

Зохион байгуулагчид:

Христмас Вайлли Цуглаан

Индогуан цуглаан

“Үл Устах Үгс” сайн дурын үйлчлэл

Зөвлөх хороо:

Марк Фийнер

Пак Сү Ён

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Орчуулагч:

Б. Шинэбаяр

Хянан засварласан:

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Э. Алтанцэцэг

Зохиогчийн эрх © Виллиям МакДоналд 1989, 1990,
1992, 1995 Америкийн Нэгдсэн Улс

Christian Missions in Many Lands, Inc. PO Box 13,
Spring Lake, NJ 07762; USA

Зохиогчийн албан ёсны зөвшөөрлөөр Монгол
хэлнээ орчуулж, 2025 онд БНСУ-д хэвлэв.

Зохиогчийн бүх эрх хадгалагдана.

Тус хэвлэлийн аль ч хэсгийг зохиогчийн
зөвшөөрөлгүйгээр цахилгаан, механик, фото
хуулбар, хальсанд хуулах гэх мэт бусад ямар ч
утга болон хэлбэрт шилжүүлэн, хуулж, хэвлэж
үл болно.

ГАЛАТЫН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

ОРШИЛ

“Ертөнцийг бүхэлд нь хамарсан бүх цаг үеийн сүнслэг эрх чөлөөний ‘Магна Карта.’”

-Чарльз Р. Эрдман

I. БИЧВЭРТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Англи хэлтэй ард түмнүүдийн нэлээдгүй хувь нь, мөн франц хүмүүс кельт (шотланд, ирланд, уэллс, брэтон) гарвальтай байдаг. Паул анхны захидлуудынхаа нэгийг өвөг дээдэст нь зориулж бичсэнийг мэдвэл энэ угсаатнууд ихэд баярлах нь дамжиггүй (“Галат”, “Галл”, “Кельт” бүгдээрээ нэг язгууртай үг юм).

МЭӨ 278 оны орчим европын галлуудын нэлээд хувь нь өнөөгийн Турк улсын нутаг дэвсгэрт нүүдэллэн очиж, хил хязгаараа тогтоож, “Галат” улс хэмээн нэрлэжээ. Олон хүн галатчуудын хувирамтгай занг кельтүүдийн төрөлх араншинтай адилтган үздэг (тухайлбал Үйл 13, Гал 3:1).

Ямартай ч галатын чуулганд бичсэн захидал нь анхан үеийн христитгэлд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Зарим хүн үүнийг ромчуудад бичсэн захидлын анхны ноорог хэмээн үздэг. Учир нь нигүүлслийн сайнмэдээ, Абрахам, хууль гэх мэт олон төстэй сэдвүүд захидалд агуулагддаг байна. Гэвч галатын чуулганд бичсэн захидал нь христитгэлийг легализмд баригдсан иудейзмын мессианик бүлэглэл болгохгүй гэсэн Паулын хатуу ширүүн боловч гал халуун хүчин чармайлт байсан юм. Галатчууд өөрсдөө үүнд хэрхэн хандсаныг бид мэдэхгүй. Гэхдээ хуулийн үйлсээс ангид нигүүлслийн сайнмэдээ ялж, христитгэл дэлхий даяар түгэн тархсан билээ.

Шашны шинэчлэлийн цаг үед Мартин Лютерын хувьд галатчуудад бичсэн захидал нэн чухалд тооцогддог байлаа. Тиймээс ч галатчуудад бичсэн захидлыг “миний Кэйт” (эхнэрээ энхрийлэн дууддаг нэр нь) хэмээн нэрлэжээ. Мартин Лютерын бичсэн *Галат номын тайлбар* нь эрдэмтэн судлаачдад төдийгүй жирийн ард иргэдэд ч нөлөөлсөн бөгөөд одоо ч гэсэн хэвлэгдэн судлагдсаар байна.

II. ЗОХИОГЧ

Галатчуудад бичсэн захидлыг Паул бичсэн гэдэгт нэг их эргэлзэх явдал гардаггүй. Поликарп, Игнатус, Юстин Мартир, Ориген, Ириней, Тертуллиан, Александрын Клемент нар галатчуудад бичсэн захидлыг Паулынх хэмээн эш татсан байдаг. Мураторын Канон мөн үүнийг Паулын бичсэн захидал гэж бүртгэсэн байдаг. Түүнчлэн, *Марконы Апостоликон* иудейжүүлэх үзлийн эсрэг өнгө аяс хүчтэй байдгийнх нь улмаас галатчуудад бичсэн уг захидлыг хамгийн түрүүнд онцлон бичсэн байж болзошгүй. Тиймээс энэ номыг Паул бичсэн байх *гадаад баримт нотолгоо* нэн хүчтэй байдаг.

Дотоод баримтын хувьд Паул 1:1 болон 5:2 эшлэл дээр өөрийнхөө талаар эш татсан байдаг. Мөн төгсгөл хэсэгт (6:11) “том үсгээр бичлээ” гэж мөн өөрийнхөө тухай тайлбарласан байдаг. Эндээс элч Паулыг нүд муутай байсан гэж дүгнэх нь ч бий. Түүнчлэн, галатчууд Паулд *нүдээ ухаад өгөхөд ч бэлэн байсан тухай дурдсан нь үүнийг батална*. Галатчуудад бичсэн захидлын олон түүхэн баримт Үйлс номын агуулгатай таардаг. Хозлолын асуудал, Паул жинхэнэ элч мөн эсэх талаарх яриа МЭ 50, 60-аад онд гол асуудал болж байгаад удалгүй мартагдсан билээ.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Захидлыг бичсэн огноог тодруулахын тулд “Галатын чуулганууд”, “галатчууд” гэсэн илэрхийллийн утгыг багтай мэдэх хэрэгтэй болно. Хэрэв энэ үг Бага Азийн Хойгийн өмнөд хэсгийн талаар ярьж байвал энэ захидлыг бичсэн хугацаа арай эрт, бүр Иерусалим дахь Зөвлөлд (Үйл 15) Паул орохоос ч өмнө бичигдсэн байх боломжтой. Хэрэв хойд хэсгийн талаар илэрхийлж байвал уг захидлыг хожуу бичсэн байх учиртай.

“Галат” гэдэг нь *газарзүйн* хувьд хойд хэсгийг, *улс төрийн* хувьд өмнөд хэсгийг буюу Ромын Галат аймгийг хэлж байжээ.

Хойд Галат гэсэн онолыг 1800-аад оныг хүртэл жишиг болгон баримталж байсныг одоо ч герман судлаачид дагадаг. Паул тэр зүгийн галатчуудад үйлчилж байсан гэх илт баримт одоогоор байхгүй боловч ийм байх боломжийг бүрэн үгүйсгэхгүй.

Өмнөд Галат гэсэн онолыг Сер Виллиям Рамсей нэлээд түгээмэл болгосноос хойш Их Британи болон Хойд Америкт үүнийг түгээмэл баримтлах болжээ. Лукын бичсэн Үйлс номыг үзвэл энэ бүс нутагт (Писидийн Антиох, Икониум, Лустр, Дерб) Паул илгээлтийн үйлчлэл хийж байсан тул уг захидлыг тэнд сайнмэдээ тарааж итгэл рүү авчирсан ах дүүстээ хандан бичсэн мэт харагддаг. Паул илгээлтийнхээ анхны аяллаар өмнөд Галатад сайнмэдээг тунхаглаж, удаах аяллаараа дахин айлчилсан тул эл захидлыг нэлээд эрт бичсэн байх боломжтой. Уг захидлыг Үйлс 15 дугаар бүлэг дээрх Иерусалим дахь Зөвлөл (МЭ 49) үүсэхээс өмнө бичсэн бол хозлолын асуудал яагаад хүчтэй яригдаж байсан нь ойлгомжтой болно. Германы нэрт консерватив эрдэмтэн Теодр Захн уг захидлыг бичсэн хугацааг Паул хоёр дахь илгээлтийн аяллынхаа үед Коринт хотоос бичсэн гэж тогтоожээ.

Тэгэхээр энэ захидал Паулын бичсэн нэлээн эртний захидал болно.

Хэрэв хойд Галат гэсэн онол зөв бол галатчуудад бичсэн захидал МЭ 50-аад он, бүр тодруулбал МЭ 53 он, магадгүй түүнээс хойш бичигдсэн байх боломжтой.

Харин бидний үзэж байгаагаар өмнөд Галат гэсэн онолыг зөв гэж үзвэл, нэн ялангуяа харь үндэстний итгэгчдэд зориулсан хозлолын асуудлыг шийдсэн Иерусалим дахь Зөвлөлд (Үйлс 15) Паул оролцохоос өмнө энэ захидал бичигдсэн гэж үзвэл МЭ 48 он болж таарна.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ЕРӨНХИЙ АГУУЛГА

Элч Паул илгээлтийн анхны аяллаараа Бага Азийн Хойгт очиж, гагцхүү Христэд итгэснээр л аврагдана гэх сүр жавхлант мэдээг дамжуулжээ. Сонсогчдоос нь олон хүн итгэж, чуулганууд ч байгуулагдав. Тэдний зарим нь Галатынх байлаа. Галатын оршин суугчид тогтворгүй, дайнч, хувирамтгай гэдгээрээ алдартай.

Паул энэ нутаг орноос явсны дараа хуурамч багш нар чуулгануудад ирж, гаж буруу сургаал номлож эхлэв. Тэд Христэд итгэхээс гадна хуулийг сахиж байж аврагдана хэмээн зааж байлаа. Тэд христитгэлийг иудейзмтэй, нигүүлслийг хуультай, Христийг Мосетэй хольж хутган сургаж байв. Мөн тэд Паулыг Эзэний жинхэнэ элч биш учраас дамжуулсан мэдээ нь ч найдваргүй хэмээн галатчуудын сэтгэлийг түүнээс хөндийрүүлэхийг зорьжээ. Тэд сайнмэдээг дамжуулсан элчид итгэх итгэлийг нь үгүй хийх замаар сайнмэдээний үнэнд эргэлзүүлэхийг оролдож байв. Олон галат христитгэгчид тэдний бузар санаархалд автсан байна.

Галатаас ийм мэдээ хүлээн авсан Паулын зүрх сэтгэл ямар их уй гашуугаар дүүрсэн бол доо! Тэр хүмүүсийн

төлөө хөдөлмөрлөсөн нь ингээд талаар өнгөрч байгаа юм гэж үү? Христитгэгчидийг иудей үзэл, легализмийг баримталсан сургаалаас ангижруулах боломжтой юу? Паул түргэн шуурхай, шийдэмгий арга хэмжээ авав. Тэрээр бийр цаасаа аваад итгэлийн хүүхдүүддээ зориулж нэн яаралтай захидал бичжээ. Энд аврал бол эхнээсээ эцэс хүртэл нигүүлслээр өгөгддөг тул хуулийг бүхэлд нь болон хэсэгчлэн сахихтай ямар ч холбоогүй гэдгийг Паул мэдэгдэв. Сайн үйлс бол авралын болзол бус, үр жимс ажээ. Христитгэгчид хуулийн хувьд үхсэн тул ариун амьдралыг өөрийн хүчээр бус, харин дотор нь орших Бурханы Ариун Сүнсний хүчээр сахидаг гэж Паул бичжээ.

ТОЙМ

I. ӨӨРИЙН ТУХАЙ: ПАУЛ ЭРХ МЭДЛЭЭ ӨМГӨӨЛСӨН НЬ (1, 2-р бүлэг)

А. Паул уг захидлыг бичсэн зорилго (1:1-10)

Б. Паул тунхагласан мэдээ ба үйлчлэлээ өмгөөлсөн
нь (1:11-2:10)

В. Паул Петрийг зэмлэсэн нь (2:11-21)

II. СУРГААЛЫН АСУУДАЛ: ПАУЛ ИТГЭЛЭЭР ЗӨВТГӨГДӨХИЙГ ӨМГӨӨЛСӨН НЬ (3:1-5:1)

А. Сайнмэдээний агуу үнэн (3:1-9)

Б. Хууль ба амлалтын ялгаа (3:10-18)

В. Хуулийн зорилго (3:19-29)

Г. Хүүхдүүд болон хөвгүүд (4:1-16)

Д. Боолчлол эсвэл эрх чөлөө (4:17-5:1)

III. БОДИТ ЗААВРУУД: ПАУЛ СҮНС ДОТОРХ ХРИСТИТГЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ӨМГӨӨЛСӨН НЬ (5:2-6:18)

А. Легализмийн аюул (5:2-15)

Б. Ариун амьдрах хүч (5:16-25)

В. Амьдралд ойр ятгалгууд (5:26-6:10)

Г. Дүгнэлт (6:11-18)

ТАЙЛБАР

I. ӨӨРИЙН ТУХАЙ: ПАУЛ ЭРХ МЭДЛЭЭ ӨМГӨӨЛСӨН НЬ (1, 2-р бүлэг)

A. Паул уг захидлыг бичсэн зорилго (1:1-10)

1:1 Юун түрүүнд, Паул өөрийгөө Бурханаар элч болон дуудагдсан гэж мэдэгдлээ. Элчийн дуудлага нь **хүмүүсээс бус** ажээ. Мөн Бурхан **хүнээр** дамжуулж түүнийг томилоогүй байна. Харин **Есүс Христээр мөн Түүнийг үхэгсдээс амилуулсан Эцэг Бурханаар** шууд дуудагдан **элч** болжээ. Гагцхүү Бурханаар дуудагдаж, зөвхөн Бурханы өмнө үүрэг хүлээсэн хүн л Бурханы мэдээг хүнээс эмээлгүй тунхаглаж чадна. Тиймээс Паул арван хоёр элч болон бусад хүнээс хараат бусаар мэдээгээ дамжуулж, үйлчлэлээ хийжээ.

Энэ эшлэлд Христийн бурхан чанарыг ил тод мэдэгдэхийн сацуу дам илэрхийлсэн байна. **Хүнээр бус, харин Есүс Христээр** гэсэн нь ил тод мэдэгдэл юм. Харин **Есүс Христ ба Эцэг Бурханыг** хамтад нь хэлсэн дам илэрхийлэл нь энэ хоёрыг нэг зиндаанд тавьсан явдал юм. Тэгээд Эцэг Бурханыг Есүсийг **үхэгсдээс амилуулсан** Нэгэн хэмээжээ. Паул зориуд үүнийг галатчуудад сануулсан шалтгаан бий. Учир нь, амилал бол бидний төлөө гүйцэлдүүлсэн Христийн үйл хэрэгт Бурхан бүрэн сэтгэл ханасны баталгаа билээ. Галатчууд Аврагчийн үйл хэргийг хангалттай гэж үзээгүй нь хуулийг сахиснаараа Христийн үйл хэрэгт дэм үзүүлэхийг оролдсоноос нь илэрхий харагддаг.

Паулыг амилсан Христ дуудсан нь бусад арван хоёр элчээс ялгаатай болгодог. Учир нь арван хоёр элчийг Эзэн Есүс газар дэлхий дээр үйлчилж байхдаа дуудсан юм.

Тэгэхээр Паулын хувьд амиллын мэдээ тунхаглалынх нь салшгүй, чухал хэсэг байжээ.

1:2 Элч Паул өөртэй нь хамт байсан бүх **ах дүүстэй** өөрийгөө хамаатуулсан. Энэ **ах дүүс** сайнмэдээний үнэнийг баримтлахыг галатчуудад ятгаж буй Паултай нэгдэн ятгасан юм. **Галатын чуулгануудад** бичсэн захидал халуун дулаан өнгө аясыг зориуд агуулаагүй байна. Паул итгэгчдийг ихэвчлэн “Бурханы чуулган,” “ариун хүмүүс,” “Христ Есүст итгэмжит хүмүүс” гэхчлэн дууддаг. Мөн христитгэгчдэд талархлаа илэрхийлж, сайн чанаруудыг нь магтах нь олонтоо. Тэр ч байтугай хүмүүсийн нэрийг цохон тэмдэглэдэг. Гэтэл энэ удаа тэгсэнгүй. Галатын чуулгануудын алдаа эндэгдэл дэндүү ноцтой байсан тул Паул тэдэнд хатуу ширүүн, хүйтэн хөндий хандахад хүргэжээ.

1:3 **Нигүүлсэл хийгээд амар амгалан** бол сайнмэдээний гайхалтай хоёр үг. **Нигүүлсэл** гэдэг нь бурханлаг бус нүгэлтнүүдэд хүртэх зохисгүй хайр ивээлийг нь үзүүлэх явдал билээ. Нигүүлсэл хүнд юу *хийхийг* нь заах бус, Бурхан юу *хийснийг* өгүүлж, үнэгүй бэлэг болох авралыг хүлээн авахад уриалдаг. Скофилд нэгэнтээ, “нигүүлсэл нь зохистой сайн хүнийг бус харин яллагдаж, буруутгагдан хэлэх үггүй болж, аргаа барсан хүмүүсийг хайж олоод аварч, ариусган, алдаршуулдаг юм” гэжээ.

Амар амгалан бол нигүүлслийн үр дүн. Нүгэлтэн Аврагчийг хүлээн авахад Бурхантай **амар амгалан** буюу энх тайван тогтдог. Нүглийнх нь шийтгэл төлөгдөж, нүглүүд нь уучлагдаж, дахин хэзээ ч яллагдахгүй гэдэг мэдлэг түүнийг амраадаг. Гэхдээ нигүүлсэл зөвхөн *авраад* зогсохгүй *сахин хамгаалдаг*. Бид *Бурхантай энх тайвныг тогтоох хэрэгтэй ч Түүний амар амгалан ч мөн хэрэгтэй*. Паул захидлынхаа оршил хэсэгт яг энэ ерөөлийг галатчуудад айлджээ. Хуулиас ийм ерөөл ирдэггүйг

галатчууд ойлгосон нь дамжиггүй. Хууль бол түүнийг зөрчигч нэгний дээр хараалыг авчирдаг. Тиймээс хуулиар нэг ч хүн амар амгаланг олохгүй.

1:4 Дараа нь Паул уншигчдадаа ямар их үнээр аврагдсан бэ гэдгийг сануулж байна. **“Бидний нүглийн учир Есүс Христ Өөрийгөө өгсөн юм”** гэсэн Паулын үгийг анхаарна уу. Нүглийн асуудлыг шийдэхийн тулд Тэр **Өөрийгөө өгсөн юм** бол Түүний төгс үйл хэрэг дээр нэмэх боломж бас шаардлага ч алга. Мөн хуулийг сахиж нүглээ цайруулах ч шаардлагагүй. Христ бол цорын ганц, бүрэн төгс Аврагч. Христ **одоогийн ёрын муу энэ үеэс биднийг гэтэлгэхийн тулд** үхсэн юм. Энэ нь энэ үеийн ёс суртахууны болон улс төрийн завхралаас гадна христитгэлийг элдвийн ёс заншил, дэг жаягтай хольж хутгадаг шашны ертөнцийг ч хамарна. Ялангуяа өөрсдийг нь гэтэлгэхээр Христ амиа өгсөн тэрхүү хуучин тогтолцоо руу галатчууд буцан явж байсан яг тэр үед тун чиг цагаа олсон үгийг Паул хэлжээ. Христийн золилт **бидний Бурхан бөгөөд Эцэгийн хүслээр** болсон юм. Энэ үг авралыг зохих байранд нь тавьж байна. Өөрөөр хэлбэл, хүмүүний ядмагхан хичээл зүтгэлээр бус Бурханы дээдийн дээд эрх мэдэлт хүслийн улмаас аврал өгөгджээ. Энэ нь Христ бол Бурханы авралын зам тул өөр аврал байхгүй гэдгийг онцлон тэмдэглэдэг.

Бурхан энэ ертөнцийг сайжруулж, энэ ертөнцөд хүнийг тав тухтай байлгахыг зорьдоггүй, харин хүмүүсийг энэ ертөнцөөс гэтэлгэхийг хүсдэг гэдгийг 4 дүгээр эшлэлээс олж харууштай. Бидний бодол санаа Бурхантай адил байх учиртай.

1:5 Нигүүлслийн сайнмэдээний дагуу хүнийг аварсан **алдар нь** бүхэлдээ Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христэд өгөгддөг. Хүн хуулийг сахиснаараа авралыг хамтран гүйцэлдүүлсэн алдрыг хуваалцахгүй.

Эхний таван эшлэлийн үг бүр нь утга учиртай, цөөн үгэнд олон үнэнийг шигтгэсэн байдаг. Паул захидлынхаа үлдсэн хэсэгт өгүүлэх *(1) Элчийн хувьд өөрт нь оногдсон эрх мэдэл (2) Өөрийнх нь дамжуулдаг Бурханы нигүүлслийн сайнмэдээ* гэсэн хоёр сэдвийн оршлыг энэ таван эшлэлд тавьжээ. Одоо тэрээр тулгараад байгаа асуудлыг галатчуудад шуудхан ярихад бэлэн болжээ.

1:6,7 Галатчууд алдаа гаргахад бэлэн байгаа явдлыг Паул буруутгав. Тэд сайнмэдээний үнэнийг ийм хурдан орхисонд гайхахын зэрэгцээ энэ үйлдлийг хуурамч сайнмэдээний төлөө Бурханаас нүүр буруулсан явдал гэж тэр тодорхойлов. Бурхан тэднийг **Христийн нигүүлсэл рүү дуудсан** атал хуулийн хараал доор өөрсдийгөө оруулжээ. Тэд жинхэнэ сайнмэдээг хүлээн авсан боловч одоо түүнийгээ орхиж өөр **сайнмэдээ** руу эргэжээ. Энэ үнэндээ огт сайнмэдээ биш байлаа. Харин нигүүлслийг хуультай хольж хутгасан гажуудсан мэдээ байв.

1:8,9 **Өөр сайнмэдээг** тунхаглагч хүний дээр Бурханы буулгах хараалыг Паул хоёронтоо тунхаглав. Мөхөл рүүгээ явж буй нүгэлтнүүдийг аврах цор ганц мэдээ Бурханд бий. Бурхан итгэлээр дамжуулан нигүүлслээр авралыг соёрхдог. Энэ нь хууль сахихтай ямар ч холбоогүй. Үүнээс өөр авралын замыг тунхаглагчид нь гарцаагүй сүйрнэ. Хүмүүсийн сүнсийг мөнхийн тамд аваачих мэдээг тунхаглах нь ямар ноцтой хэрэг вэ! Паул ийм худал сургаал заагчдад хүлцэнгүй ханддаггүй байсан. Бид ч мөн хүлцэнгүй хандах ёсгүй. Жон Стотт ингэж сануулжээ:

Чуулганд бэлэг авьяастай, багшлах дуудлагатай хүмүүсийг хараад олон хүн сэтгэл хоёрддог. Бид тийм байж болохгүй. Тэд бидэнд агуу нэр төр, эрх мэдэл, эрдэм мэдлэгтэй харагдаж болно. Магадгүй бишоп, тэргүүн бишоп, их сургуулийн профессор, пап ч байж болох юм. Гэсэн ч элч нарын тунхаглаж, Шинэ гэрээнд

бичигдсэнээс өөр сайнмэдээг тунхаглавал тэднийг няцаах хэрэгтэй. Бид тэднийг сайнмэдээгээр шүүнэ. Сайнмэдээг тэднээр шүүлгэхгүй. “Мэдээ дамжуулагчийн гадаад төрх уг мэдээг баталгаажуулахгүй, харин тэрхүү мэдээний мөн чанар л мэдээ дамжуулагчийг баталгаажуулна” гэж доктор Алан Коул хэлсэн байдаг.¹

Элч Паул, “Бурханы тэнгэрэлч” гээгүй, **тэнгэрийн зарлага элч** (тэнгэрээс тэнгэрэлч) гэж хэлснийг анзаараарай. Тэнгэрээс тэнгэрэлч ирээд худал мэдээ дамжуулж болно. Харин Бурханаас илгээсэн тэнгэрэлч хэзээ ч худал мэдээ дамжуулахгүй. Үүнээс илүүгээр сайнмэдээний хосгүй мөн чанарыг илэрхийлэх арга үгүй. Сайнмэдээ бол *цорын ганц* авралын зам. Үүнд хүний өөрийн хичээл зүтгэл, алдар гавьяа ямар ч үүрэггүй. Авралыг ямар ч үнэ хөлсгүйгээр сайнмэдээ л санал болгодог. Хуулийг *сахиж чадаагүй* хүмүүст хараал буйг хууль өөрөө өгүүлдэг бол сайнмэдээг *өөрчлөх* гэж оролдсон хүмүүст хараал буйг сайнмэдээнд өгүүлсэн байдаг.

1:10 Паулыг сонсогчдодоо нийцүүлэн Бурханы мэдээг өөрчилдөг хэмээн дайснууд нь буруутгасан бололтой. Тиймээс тэр, “Цорын ганц сайнмэдээ байгаа гэж хэлсэн минь **хүмүүст** таалагдах гэснийх үү эсвэл **Бурханд** таалагдах гэснийх үү?” хэмээн асууж байна. Паул **хүмүүсийн тааллыг** олох гэж яваагүй нь тодорхой. Учир нь тэнгэрийн улсад хүрэх цорын ганц зам байгаа гэж хэлснийх нь улмаас түүнийг хүмүүс үзэн ядсан. Паул **хүмүүст** нийцүүлж мэдээгээ өөрчилбөл **Христийн зарц биш байх** байлаа. Ингэвэл харин ч Бурханы уур хилэнг өөр дээрээ дуудсан хэрэг болно.

Б. Паул тунхагласан мэдээ ба үйлчлэлээ өмгөөлсөн нь (1:11-2:10)

1:11,12 Элч Паул тунхагладаг мэдээ болон хийдэг үйлчлэлээ өмгөөлөх зургаан асуудлыг дэвшүүлжээ. Нэгт, тэрээр сайнмэдээг хүнээс бус, шууд Бурханаас хүлээн авсан гэв. **Хүнийх биш** гэдэг нь сайнмэдээг хүн зохиогоогүй гэсэн утгатай. Хэсэг зуур тунгаан бодоод үзвэл энэ бүхэн үнэн болох нь батлагдана. Паулын тунхагласан сайнмэдээ хүний тухай бус, бүхэлдээ Бурханы тухай байдаг. Түүний өгүүлэх сайнмэдээ хүний зохиох боломжгүй авралыг тунхагладаг! Паул үүнийг хэн нэг хүнээс аваагүй. Мөн номоос заалгаагүй. **Харин Есүс Христийн шууд илчлэлээр хүлээн авчээ.**

1:13,14 Хоёрт, сайнмэдээнд иудейн хуулийг оруулаагүй нь **иудейзмын** талаар Паул мэддэггүй байсан хэрэг огт биш ээ. Гарал угсаа, эрдэм боловсролын хувьд тэрээр хуулийн мэргэжилтэн байжээ. Харин өөрөө чуулганыг хавчих замыг сонгосон юм. **Өвөг дээдсийнхээ ёс заншлыг** хамгаалах гал халуун сэтгэлээр үе тэнгийн олон иудей залуусаас тодрон товойжээ. Иймд хуулиас ангид, итгэлээр ирэх авралын тухай түүний сайнмэдээ хуулийг мэдэхгүйн улмаас болсон гэж хэлэхийн аргагүй. Тэгвэл Паул яагаад тунхаглалдаа хуулийг орхигдуулав? Түүний тунхагласан сайнмэдээ гарал угсаа, төрөлх хүмүүжил, шашин шүтлэгтэй нь үл нийцэх мэт сонсогдсон шалтгаан юунд оршино вэ? Энэ бүхэн Паулын санаанаасаа зохиосон зүйл биш харин Бурханаас шууд өгөгдсөн сургаал ажээ.

1:15-17 Гуравт, Паул эхний хэдэн жил үйлчлэлээ бусад элч нараас хараат бусаар явуулж байсан. Тиймээс одоо сайнмэдээг хэнээр ч заалгаагүй гэдгээ хэлж байна. Тэрээр Христэд итгэсэн даруйдаа хэн нэг удирдагчтай **зөвлөлдөөгүй**. Мөн элч нарын байсан **Иерусалим уруу** ч яваагүй. Оронд нь, **Арабт очоод, Дамаскт дахин нэг**

эргэж иржээ. Иерусалим руу яваагүй шалтгаан нь бусад элч нарыг үл хүндэтгэсэндээ бус амилсан Эзэнээс Өөрөөс нь харь үндэстнүүдэд үйлчлэх тусгай даалгавар авсантай нь холбоотой (2:8). Тэгэхээр Паулын сайнмэдээ болон үйлчлэлд хэн нэг хүний батламж хэрэг байсангүй. Паул хүнээс бүрэн хараат бус байжээ.

Эдгээр эшлэлийн зарим илэрхийллийг анхааралтай үзэх хэрэгтэй. Тухайлбал, 15 дугаар эшлэлд **“эхийн хэвлийд байхаас минь сонгон тусгаарласан”** гэснийг хараарай. Бурхан онцгой үйл хэргийг гүйцэтгүүлэхийн тулд төрөхөөс нь ч өмнө Паулыг сонгон тусгаарласныг тэрээр ойлгож байж. Тэгээд араас нь **“Бурхан намайг нигүүлслээрээ дуудсан”** гэжээ. Өөрөөр хэлбэл, Дамаск орох замд болсон үйл явдлыг ярьж байна. Тухайн үед Паул хүртэх ёстойгоо хүртсэн бол шууд тамд хаягдах байлаа. Гэтэл Христ гайхамшигт нигүүлслээрээ түүнийг аварч, өөрийнх нь устгах гэж оролдоод байгаа итгэлийг тунхаглуулахаар илгээжээ. 16 дугаар эшлэлд **Хүүгээ өөрийнх нь дотор илчилсэн** гэдгийг Паул харуулжээ. Бурхан биднийг дууддаг зорилгыг энд гайхалтайгаар илэрхийлсэн байна. Тэр *бидний* дотор Хүүгээ илчилснээр бид энэ ертөнцөд Эзэн Есүсийг төлөөлөх боломжтой болдог гэсэн санаа юм. Тэр биднээр дамжуулан Христийг харуулахын тулд (16-23 дугаар эшлэл) бидний зүрхэнд Христийг илчилснээр (16-р эшлэл) Тэр биднээр дамжин гэрэлтэж, улмаар Бурхан Өөрөө алдрыг хүртэх юм (24-р эшлэл). Паулын хүлээн авсан тусгай даалгавар бол харь үндэстнүүдэд Христийг тунхаглах явдал байлаа.

17 дугаар эшлэлд **“Арабт очоод”** гэж хэлжээ. Эзэний зарц нэг бүрд ганцаараа байх, тунгаан бясалгах цаг хэрэгтэй байдаг. Мосе цөлд дөчин жилийг өнгөрөөсөн. Давид Иудагийн уулархаг нутагт хонь хариулж явахдаа Бурхантай хувьчилсан цаг гаргаж байв.

1:18-20 Дөрөвт, Паул Иерусалимд ирээд зөвхөн Петр², **Иаков** хоёртой л уулзжээ. Үүнээс өөрөөр иудейн чуулганууд Паулыг төдийлөн мэддэггүй байлаа (1:21-24). Бусад элч нараас хараат бус гэдгээ нотлохын тулд Паул итгэснээсээ хойш **гурван жилийн** хугацаанд Иерусалимд очоогүй гэж хэлж байна. Паул **Петртэй** уулзаж танилцахаар тэнд очсон (Үйл 9:26-29) нь албан ёсны бус, хувийн чанартай байв. Иерусалимд байхдаа Паул **Эзэний дүү Иаковтай** мөн уулзсан байна. Тэр ердөө л **арван таван хоног** Петртэй хамт байжээ. Сургагдахад хангалттай урт хугацаа биш. Түүнчлэн Паул өөрийгөө Эзэний уг зарц нартай эн тэнцүү хэмжээнд тавьсан нь энэ эшлэлээс харагдана.

1:21-24 Түүнээс хойш Паул **Сири, Киликийн нутгуудаар** явж, тэнд ихэнх цагаа өнгөрөөсөн тул иудейн чуулганууд түүнийг сайн таньдаггүй байжээ. Христитгэгчдэд харгис хэрцгий хандаж байсан өнөөх хүн чинь одоо өөрөө христитгэгч болоод Христийг бусдад тунхаглаж байна гэдгийг л дам сонсжээ. Паулын амьдралд Бурханы гүйцэлдүүлсэн зүйлийн улмаас **тэд Бурханыг алдаршуулж байсан юм.** (Бидний амьдралд гарсан өөрчлөлтийн улмаас хүмүүс Бурханыг алдаршуулж байна уу?)

2:1 Тавд, Паулыг хожим Иерусалимд айлчлахад түүний сайнмэдээг Бурханаас гарвальтай гэдгийг элч нар хүлээн зөвшөөрсөн (2:1-10). Чуулган анх Иерусалимд эхэлж, элч нар тэнд суурин төвлөрч байсан учраас зарим итгэгч тэндхийн чуулганыг “төв чуулган” гэж үздэг байжээ. Тиймээс Иерусалимын элч нарын нэг биш гэдгээр нь Паулыг дорд үздэг буруутгалыг няцаан тэмцэх хэрэгтэй болжээ. Тэрээр Иерусалим руу хожим айлчилснаа дэлгэрэнгүй тайлбарлан, хариу өгч байна. **Арван дөрвөн жилийн дараа** гэдэг нь итгэснээсээ хойш уу, анхны айлчлалаасаа хойш уу гэдгийг бид мэдэхгүй. Ямартай ч

хамтран зүтгэгч **Барнаб** болон үйлчлэлийнх нь үр дүнд Христ рүү эргэсэн харь үндэстэн **Тит** нарын хамт Иерусалим руу явах ёстой гэсэн илчлэлийг Паул хүлээн авсан гэдгийг л мэдэж байна. Гэтэл иудейжүүлэх үзэлтнүүд Титийг бүрэн аврагдахын тулд хозлуул гэж шахаж байсан ч элч Паул үүнээс эрс татгалзжээ. Учир нь Тит хозлуулбал сайнмэдээний үнэн эрсдэлд орохыг мэдэж байжээ. (Хожим нь Паул өөрөө Тимотыг хозлох үед ноцтой асуудал хөндөгдөөгүй – Үйл 16:3).

Э. Ф. Кэван энэ талаар хэлэхдээ:

Паулын ойлголтоор зөвтгөгдөхийн тулд хозлуулах нь гэнэн нэгний бодож төсөөлдөг шиг гэмгүй жижигхэн ёслол огт биш. Хозлуулна гэдэг нь хуулийг сахихад тулгуурлаж, үүгээр зөвтгөгдөх гэсэн оролдлого бөгөөд ингэснээрээ нигүүлслийн үндэс суурийг үгүйсгэж байдаг юм.³

Паул Иерусалимд очоод **харийнхны дунд тунхагладаг сайнмэдээг тэдэнд, ялангуяа нэр хүндтэй хүмүүст хувьчлан хэлсэн. Учир нь дэмий гүйх буюу гүйсэн байх вий гэсэндээ тэгжээ.** Паул бүх чуулганд тунхаглахын оронд зөвхөн сүнслэг удирдагчдад **хувьчлан** хэлсэн нь ямар учиртай вэ? Худал сайнмэдээгээ тэднээр батлуулахыг хүссэндээ гэж үү? Мэдээж үгүй. Элч Паул ийм санаагаар хэлээгүй. Паул тунхагладаг мэдээгээ Бурханы илчилснээр авсан гэдгийг л хэлээд байгаа шүү дээ. Зааж буй сургаал нь үнэн гэдэгт Паул огтхон ч эргэлзээгүй. Тэгэхээр өөр шалтгаантай байж таарна. Ер нь бол удирдагч нартай эхэлж уулзах нь жудагтай явдал юм. Юун түрүүнд удирдагчид Паулын сайнмэдээг нягтлан шалгах нь зүйд нийцнэ. Удирдагчдад ямар нэг асуулт гарвал Паул эхлээд тэдэнд тайлагнахыг хүсжээ. Дараа нь элч нарын бүрэн дэмжлэгтэйгээр чуулганы өмнө тунхаглах боломжтой

болно. Олон хүнд нэгэн зэрэг тунхаглах үед сэтгэл хөдлөлөөр ханддаг хүмүүс үймээн үүсгэх эрсдэл үргэлж байдаг. Тиймээс Паул сайнмэдээгээ олон нийтийн туйлшралаас ангид удирдагчдад **хувьчлан** танилцуулахыг урьтал болгожээ. Паул эхлээд нийт чуулгантай харьцсан бол ноцтой маргаан дэгдэж, чуулган иудей болон харь үндэстэн гэсэн хоёр тал болж хуваагдах байлаа. Тэгснээр Паулын Иерусалим руу очсон зорилго талаар өнгөрөх байсан юм. **Би дэмий гүйх буюу гүйсэн байх вий гэсэндээ тэгсэн юм** гэсэн нь ийм учиртай.

2:3 Легализмийн асуудал **Тит** дээр нэлээд хурцадмал болов. Иерусалимын чуулган харь гаралтай энэ итгэгчийг нөхөрлөлдөө хүлээн авах уу эсвэл эхлээд **хозлуулахыг** шаардах уу?⁴ Энэ талаар нэлээдгүй маргасны эцэст аврагдахад хозлол шаардлагагүй гэдэг дүгнэлтийг элч нар гаргав. Энэ тал дээр Паул илэрхий ялалт байгуулав.⁵

2:4 Хоёрдугаар эшлэлийн эхний хэсгийг 4 дүгээр эшлэлийн эхний хэсэгтэй холбож үзвэл Паул яагаад Иерусалим руу явсан шалтгаан тодорхой болдог. “Илчлэлийн дагуу би тийшээ явсан юм... **Харин ингэсэн нь ... шургалсан хуурамч ах дүү нараас болсон юм.**” Энд өмнө нь Антиохт болсон үйл явдлыг ярьж байна (Үйл 15:1, 2). Иерусалимаас ирсэн зарим иудей багш нар христитгэгчдийн дүрээр Антиохын чуулганд шургалж, аврагдахад хозлуулах нь нэн чухал хэмээн номлож байжээ.

2:5 Паул, Барнаб хоёр тэднийг хатуу эсэргүүцэв. Тэгээд маргааныг таслахын тулд Иерусалим дахь элч нар болон ахлагчдын бодлыг сонсохоор тэд Иерусалим руу явцгаажээ.

2:6 Иерусалим дахь удирдагчид Паулын мэдээнд ч тэр, элчийн дуудлага дээр нь ч тэр өөр юуг ч нэмсэнгүй. Энэ бол үнэхээр онцгой гайхалтай хэрэг байлаа. Өмнөх бүлэгт Паул бусад элч нартай тэр бүр уулзаж байгаагүйгээ цохон тэмдэглэсэн. Гэтэл одоо бусад элч нартай уулзахад тэр тэдэнтэй ижилхэн сайнмэдээг тунхаглаж ирснийг тэд

бүрэн хүлээн зөвшөөрчээ. Энэ бол маш чухал санаа! Эдгээр иудей удирдагчид түүний сайнмэдээ ямар нэг өө сэвгүйг хүлээн зөвшөөрсөн байна. Паул тэднээс тусгаар байж, тэднээс суралцаагүй атлаа тунхагласан сайн мэдээ нь яг ижил байсан нь гайхалтай. (Паул бусад элч нарыг дорд үзэх гэсэнгүй. Гагцхүү, Эзэн Есүсийг энэ дэлхий дээр махбодоор байхад хамт явсан нь тэднийг Паулаас илүү эрх мэдэлтэй болгож, өндрөөр үнэлүүлэхэд хүргэдэггүй гэсэн санааг л хэлсэн хэрэг. Бурхан хүний гадаад ялгаатай байдлын тухайд царай харж алагчилдаггүй.)

2:7,8 **Петр** иудейчүүдэд сайнмэдээг хүргэх дуудлагатайн адил Паул **хозлуулаагүйчүүдийн** (харь үндэстнүүдийн) төлөө сайнмэдээний үйлчлэл хийх дуудлагатайг Иерусалим дахь элч нар баяртайгаар хүлээн зөвшөөрчээ. Энэ хоёр хүн нэг л сайнмэдээг тунхагласан ч өөр өөр үндэстнүүдэд хүрч ажилласан байна.

2:9,10 Түүгээр ч зогсохгүй чуулганы **багана гэгддэг Иаков, Кеф (Петр) болон Иохан нар** Паулаар дамжуулан Бурхан ажиллаж байгааг хүлээн зөвшөөрөөд, **харийнхан уруу** сайнмэдээг авч очих ажилд нь Паул **болоод Барнабт нөхөрлөлийн баруун гараа сунгажээ**. Энэ нь албан ёсны томилгоо бус Паулын ажлыг дэмжиж буйн илэрхийлэл байв. Элч нар Паул, Барнаб хоёрт **ядуусыг санаж яваарай** гэдэг ганц л зүйлийг захисан байна. Тэр ч үүнийг **хийхийг эрмэлзсээр** иржээ.

В. Паул Петрийг зэмлэсэн нь (2:11-21)

2:11 Элчийн үүрэг алба руу нь дайрч довтлох хүмүүст Паул сүүлийн буюу зургаа дахь хариу болгож элч Петрийг⁶ зэмлэхээс өөр аргагүй болсон явдлаа ярьж байна. Петрийг иудей итгэгчдийн олонх нь элч нарын тэргүүн гэж үздэг

байлаа. (Петр бол чуулганы төгс удирдагч гэдэг үзлийг энэ эшлэл шууд няцааж байна.)

2:12 Петр анх Антиохт ирснийхээ дараа христитгэлийн эрх чөлөөгөө бүрэн эдэлж, **харийнхантай хооллодог** байж л дээ. Иудейн уламжлалын дагуу тэр ингэж болохгүй. Гэтэл хэсэг хугацааны дараа **Иаковын хэдэн хүн** Иерусалимаас Антиохт айлчлав. Тэд өөрсдийгөө Иаковыг төлөөлж явна гэж хэлсэн ч дараа нь тэр үүнийг нь няцаасан байдаг (Үйл 15:24). Тэд магадгүй хуулийн тодорхой зан үйлийг баримталсаар байсан иудей итгэгчид байсан бололтой. Тэднийг ирэхэд Петр байгаа байдлыг нь Иерусалим дахь хуулийг баримталдаг хүмүүс мэдчих вий гэж эмээхдээ харь үндэстнүүдтэй нөхөрлөхөө больжээ. Энэ үйлдлээрээ Петр бүх итгэгчид Христ Есүс дотор нэг тул үндэстний ялгаа уг нөхөрлөлд нөлөөлөхгүй хэмээх сайнмэдээний агуу үнэнийг үгүйсгэж орхисон юм. Финдлейн хэлсэнчлэн, “Хозлуулаагүйчүүдтэй хооллохоос цэрвэснээрээ Петр тэднийг ‘бузар’ хэмээн үзсээр байгаагаа дам илэрхийлж, Мосегийн хуулийн дагуух ёслолуудыг итгэлийн зөвт байдлаас дээгүүр тавьжээ.”

2:13 Бусад нь ч гэсэн Петрийг даган дуурайв. Паулын хайрт хамтран зүтгэгч **Барнаб** ч бас тэдний эгнээнд нэгдэв. Энэ үйлдэл тун ноцтойг ойлгосон тул Паул Петрийг **хоёр нүүртэй** байдлыг зоригтой зэмлэсэн байна. Түүний хэрхэн зэмлэсэн нь 14-21 дүгээр эшлэлд гарна.⁷

2:14 Бурхан үндэстнүүдийн ялгааг авч үзэхээ больсон гэдгийг Петр христитгэгч хүнийхээ хувьд мэдэж байсан. Петр өөрөө харь үндэстэн шиг амьдарч, тэдний хоолыг зооглож байлаа. Гэтэл харь үндэстнүүдтэй хооллохоос татгалзсан үйлдэл нь ариун амьдрахын тулд иудейн хууль, ёс заншлыг сахих шаардлагатай бөгөөд харь үндэстний итгэгчид **иудейн маягаар амьдрах** хэрэгтэй гэж хэлснээс өөрцгүй хэрэг болжээ.

2:15 Паул энд егөөдөл ашиглаж буй мэт харагддаг. Петрийн үйлдэл **иудейчүүд** бусад үндэстнээс илүү, харь үндэстнүүд дорд гэх эртнээс нааш баримталж ирсэн үзлийг нь илчилсэн хэрэг биш гэж үү? Петр ийм зүйлд автах учиргүй байсан. Учир нь **харийнхнаас** Корнел Христ рүү эргэхийн өмнө хэнийг ч бузар гэж бүү дууд хэмээн Бурхан түүнд заасан шүү дээ (Үйл 10, 11:1-18).

2:16 **Хуулийн дотор** аврал байхгүй гэдгийг аврагдсан иудейчүүд мэдэж байсан. Хууль нь төгс сахиж чадаагүй хүнээ үхлээр ялладаг. Тэгэхээр ариун зарчмуудыг нь бүх хүн зөрчсөн учраас бүгд хараал дор орсон. Тиймээс Паул энд Аврагч Эзэн Есүсийг итгэлийн цорын ганц жинхэнэ найдвар хэмээн танилцуулжээ. “*Иудейчүүд бид хүртэл*” хуулийг сахиснаар бус **Христ Есүст итгэх итгэлээр** аврагдана хэмээн дүгнэсэн гэдгийг Паул Петрт сануулж байна. Гэтэл Петр харь үндэстнүүдийг хуулийн дор оруулж байгаа нь ямар учиртай вэ? Хууль хүн юу хийх ёстойг зааварладаг ч, хийх хүчийг өгдөггүй. Хууль нүглийг илчилдэг болохоос аврагч биш.

2:17 Паул, Петр нар бүгдээрээ **Христийн** дотроос, зөвхөн Христээс зөвтгөлийг хайсан. Гэтэл Антиохт гаргасан Петрийн үйлдэл өөрийг нь бүрэн зөвтгөгдөөгүй мэт авралаа бүрэн болгохын тулд хуулийг сахих ёстой гэсэн ойлголт төрүүлэхүйц байв. Үнэхээр тийм байсан бол Христ төгс, бүрэн төгөлдөр Аврагч байх боломжгүй. Нүглээ уучлуулахын тулд Христ рүү очихоос гадна өөр нэмэлт зүйлийг хийх шаардлагатай гэвэл Христ амлалтаа биелүүлж чадаагүй учраас **нүгэлд үйлчлэгч** болох биш үү? Зөвтгөгдөхийн тулд Христийг түшдэг гэж амаараа тунхаглах атлаа үнэн хэрэгтээ (биднийг нүгэлтэн гэж яллахаас өөр ажилгүй) хууль руугаа буцаж очвол бид яг христитгэгч мөн гэж үү? Христийг **нүгэлд үйлчлэгч** гэж харуулдаг тийм амьдралыг Христ сайшаана гэж үү? Паул үүнд бухимдангуйгаар **огт үгүй** хэмээн хариулж байна.

2:18 Петр Христэд итгэхийн төлөө хуулийн тогтолцооноос бүрэн ангижирсан билээ. Тэрбээр Бурханы тааллыг олохдоо иудей болон харь үндэстнүүдийн хоорондын ялгааг үгүй хийсэн. Гэтэл одоо харь үндэстнүүдтэй хамт хооллохоос татгалзсанаараа урьд нь **устгасан** зүйлээ **дахиж** босгож байгаагаас ялгаа юун. Ингэснээрээ тэр өөрийгөө **зөрчигч** гэдгээ нотолж байгаа хэрэг болно. Тиймээс Петр Христийн төлөө хуулийг орхисон нь буруу байсан, эс бөгөөс хуулийн төлөө одоогийнх шиг Христийг орхиж байгаа нь буруу!

2:19 Хууль зөрчсөн хүнд ногдох шийтгэл нь үхэл юм. Би нүгэлтэн учраас нэгэнт хуулийг зөрчжээ. Тиймээс хууль надад үхэх ял оноов. Харин Христ миний оронд үхэж, хууль зөрчсөн шийтгэлийг миний өмнөөс төлсөн. Христ үхэхэд би ч мөн үхсэн. Тэрээр хуулийн бүх зөв шударга шаардлагыг биелүүлсэн болохоор хуульд үхсэн буюу хуулийн хувьд үхсэн юм. Тиймээс Христ доторх би ч мөн **хуульд үхсэн** билээ.

Христитгэгч хүн **хуульд үхсэн** тул хуулиас бүрэн ангижирсан. Тэгвэл энэ нь итгэгч хүн Арван хуулийг хүссэнчлэн зөрчих эрхтэй гэсэн үг үү? Үгүй ээ. Бид хуулиас айсандаа биш, харин бидний төлөө амиа өргөсөн Нэгэнийг хайрласандаа ариун амьдралаар амьдарна гэсэн үг. Хуулийн доор байхыг хүсдэг христитгэгчид өөрсдийгөө хараалын доор оруулж байгаагаа ойлгодоггүй. Цаашилбал, хуулийн ганцхан заалтыг сахихыг оролдвол бүхэлд нь төгс сахих үүрэг хүлээнэ. **Бурханд амьд байх** цорын ганц зам бол хуулийн хувьд үхэх явдал юм. Хууль хэзээ ч ариун амьдралыг бий болгож чадахгүй. Бурхан ч анхнаасаа ингэхийг зориогүй. Ариун байдлыг бий болгодог Бурханы замыг 20 дугаар эшлэлд тайлбарлажээ.

2:20 Итгэгч хүн Христтэй хамт үхсэнд тооцогддог. Голгота дээр зөвхөн Христ цовдлогдсон юм биш. Би ч бас тэнд Түүний дотор **цовдлогдсон** юм. Тэгэхээр би одоо

Бурханы мэлмийд нүгэлтэн гэж харагдахаа больсон гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өөрийн хүчин чармайлт, алдар гавьяагаараа авралыг олж авах зам минь дууссан гэсэн үг. Одоо би хуулийн доор ялтай, хуучин, дахин төрөөгүй Адамын удмын хүн байхаа больжээ. Хуучин, бузар “Би” цовдлогджээ. Өдөр тутмын амьдралд минь энэ хуучин хүнд хэлэх үг байхгүй болсон байна. Би Бурханы өмнө яг ийм байр суурьтай болсон. Тэгвэл биеэ авч явахдаа энэхүү байр сууриндаа нийцүүлэх нь *зүйн хэрэг билээ*.

Мэдээж итгэгч хүн бие хүн, хувь хүнийхээ хувьд оршин тогтнохоо болихгүй. Гэвч Бурханы нүдэнд үхсэн гэж тооцогддог шалтгаан нь одоо амьдарч буй тэр хүн өнөөх хуучин хүн биш болсон гэсэн үг. **Амьд байгаа нь би биш, харин миний дотор амьдардаг Христ юм.** Намайг өөрийнхөө хүссэнээр амьдарсаар бай гэж Аврагч миний төлөө үхээгүй шүү дээ. Тэр одооноос эхлэн миний дотор амьдрах боломжтой байхын тулд л үхжээ. **Эдүгээ хүмүүний махбод дотор миний амьдарч байгаа нь Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч байгаа хэрэг юм.** Итгэл гэдэг нь найдаж, түшиглэхийг хэлнэ. Христитгэгчид үргэлж Христээс хараат байж, Түүнд буун өгч, Христийг өөрийнхөө дотор амьдрахыг зөвшөөрдөг хүмүүс билээ.

Тиймээс итгэгч хүний амьдралын дүрэм бол хууль биш Христ ажээ. Энэ нь хичээхэд бус итгэж найдахад оршино. Христитгэгч хүн шийтгэлээс айсандаа бус харин өөрийг нь **хайрлаж**, өөрийнх нь **төлөө** амиа **өргөсөн Бурханы Хүүг** хайрласандаа ариун амьдардаг.

Эзэн Есүс таны дотроос илчлэгдэхийн төлөө залбирч, амь амьдралаа та Түүнд өгсөн үү?

2:21 Авралыг ямар ч болзолгүй бэлэглэж байгаагаас нь **Бурханы нигүүлсэл** харагддаг. Хүн авралыг хүчин зүтгэлээрээ олж авах гэж оролдвол Бурханы нигүүлслийг хий хоосон болгоно. Авралыг ажил үйлс, хүчин зүтгэлээр олж авбал энэ нь нигүүлсэл гэгдэх боломжгүй. Петрт

хандаж хэлсэн Паулын эцсийн шүүмжлэл их оновчтой байсан юм. Петр иудейн хууль дүрмүүдийг сахих замаар Бурханы тааллыг олж болох юм бол **Христ дэмий үхсэн аж**. Тэрээр амиа огт хэрэгцээгүй үрэн таран хийжээ. Гэвч хүн өөр ямар ч арга замаар зөвт байдалд хүрч чадахгүй учраас л Христ үхсэн юм. Хуулийг сахиад ч хүн зөвт байдалд хүрэхгүй.

Клоу ингэж хэлжээ:

Чуулгануудыг ялзруулж, итгэлийн сургаалуудыг мунхаглалаар эсгэж, зүрх сэтгэлийг бардамналаар дүүргэдэг хамгийн гүнзгий гажуудал бол үйлсээр аврагдах үзэл юм. “Христийн чуулганыг өнө удаан жил хуваагдал, гажуудалтай байлгасан гол үндэс нь авралыг хүлээн авахын оронд олж авах гэж хичээснээс үүдэлтэй. Мөн номлол ихэнхдээ үр нөлөөгүй байдаг шалтгаан бол Бурхан өөрсдийнх нь төлөө ажиллахыг харах бус, Бурханы төлөө ажиллахыг хүмүүст уриалдаг болохоор тэр юм” хэмээн Жон Раскин бичсэн байдаг.⁸

II. СУРГААЛЫН АСУУДАЛ: ПАУЛ ИТГЭЛЭЭР ЗӨВТГӨГДӨХИЙГ ӨМГӨӨЛСӨН НЬ (3:1-5:1)

A. Сайнмэдээний агуу үнэн (3:1-9)

3:1 Галатчуудын үйлдэл нь учир шалтгааныг ойлгож, ухаараагүйг нь харуулж байв. Нигүүлслээс эргэж хууль руу хандана гэдэг нь **ховсдуулсантай** адил зүйл мөн. Нэг ёсондоо, шидэт шившлэгт автан өөрөө ч мэдэлгүй үнэнийг худлаар сольж байгаа хэрэг. **“Хэн та нарыг ховсдов?”** гэсэн Паулын асуултын *хэн* (гр. *тис*)⁹ гэдэг үг нь олон тоо биш ганц тоо байна. Дам утгаараа галатчуудын хүлээн авсан хуурамч сургаалын зохиогч бол диавол гэсэн санааг

илэрхийлж байна. Паул өөрөө галатчуудад **Есүс Христийг загалмайд цовдлогдсоныг** тунхагласан. Загалмай тэднийг хуулийн хараал ба боолчлолоос үүрд салгасныг хэлсэн. Гэтэл тэд яагаад загалмайг умартаад хууль руу эргэв? Үнэн тэдний амьдралд бодитоор ирээгүй гэж үү?

3:2 Зөв нь аль вэ гэдгийг тогтоохын тулд ганц л асуултыг асуухад хангалттай. Галатчууд Христ рүү эргэсэн мөч рүү очиж, Ариун Сүнс тэдний бие дотор оршин суухаар ирсэн үеийг харахад л болно. Тэд Ариун **Сүнснийг хэрхэн хүлээн авсан бэ?** Үйлсээр үү эсвэл итгэлээр үү? Мэдээж итгэлээр. Галатчууд **хуулийг** сахиснаар Ариун Сүнснийг хүлээн аваагүй.

3:3 Авралыг үйлсээр *олж авч* чадаагүй юм бол ариун байдал хийгээд христэч төлөвшил ба хуулийн дотор өсөж чадах уу? Аврагдахын тулд Ариун **Сүнсний** хүч чадал хэрэгтэй байсан юм бол авралын үйл явцыг дуусгахад махбодын хичээл зүтгэл хэрэгтэй байна гэж үү?

3:4 Галатчууд анх Христэд итгэхдээ ширүүн хавчлагатай нүүр тулсан. Хавчигчдын зарим нь нигүүлслийн сайнмэдээг үзэн ядагч иудейчүүд байсан юм. Тэгвэл тэр бүх зовлон **дэмий байсан юм гэж үү?** Хууль руу эргэснээрээ өөрсдийг нь хавчигчид зөвийг үйлдсэн гэж хэлснээс өөрцгүй. Хэрэв тэдний зөв юм бол энэ бүх зовлон **үнэхээр дэмий байжээ.** Зовон байж хүлээн авсан тэрхүү сайнмэдээ рүүгээ буцаж эргээсэй гэсэн найдлагыг Паул илэрхийлсээр байна.

3:5 Тавдугаар эшлэлийн **Тэр** (эсвэл *тэр*)¹⁰ гэх үг Бурханыг эсвэл Паулыг, аль эсхүл захидлыг бичиж байх үед галатчуудад үйлчилж байсан хэн нэгнийг хэлж байна уу гэдэг нь тодорхойгүй байна. Эцсийн эцэст, Бурхан л Ариун **Сүнсээр хангах** чадалтай тул **Тэр** гэдэг нь Бурханыг илэрхийлж байгаа нь гарцаагүй. Мөн түүнчлэн, Бурханы хүслийг биелүүлж, Бурханд зэмсэг болон ашиглагдах христитгэгч үйлчлэгчийг хэлж байх ч

боломжтой. Энэ утгаар нь бодвол христэч үйлчлэгч ямар эрхэм нэр төрийг хүртдэг юм бэ гэж харагддаг. “Жинхэнэ Христийн үйлчлэгч ямар ч ажил хийсэн Ариун Сүнсийг бусдад харуулж байдаг. Энэ нь үнэндээ Сүнсээр хангах ажил билээ” хэмээн хэн нэгэн нь хэлжээ.

Хэрэв элч Паул өөрийнхөө талаар ярьсан бол номлолынх нь үеэр, мөн галатчууд Христийг хүлээн авахад дагалдсан гайхамшгуудыг бодож бичсэн бололтой (Евр 2:4). Гэхдээ үйл үгийнх нь цаг ба хэвийг харвал өнгөрсөнд болсон үйл явдал бус, захидлыг бичиж байх агшинд болж буй үйл явдлыг хэлсэн гэж үзэхээр байна. Паул магадгүй Христэд итгэсний дараа Ариун Сүнснээс итгэгчдэд соёрхогддог гайхамшигт бэлгүүдийн тухай ярьсан байж болох юм. Энэ бэлгүүдийн талаар 1Коринт 12:8-11 дээр дурдсан.

Тэрээр үүнийг хуулийн үйлсээр үйлддэг үү эсвэл сонссондоо итгэснээр чинь үйлддэг үү? Үүний хариулт нь **сонссондоо итгэснээр үйлддэг** гэсэн нь болой. Ариун Сүнс итгэгч хүний дотор оршин суугаад ажиллах нь тухайн хүний хичээл зүтгэл хийгээд гавьяатай ямар ч холбоогүй. Энэ нь үргэлж нигүүлслийн улмаас итгэсэн хүнд нь өгөгддөг. Тэгэхээр Бурханы ивээл хуулийн үйлсээр бус, итгэлээр ирдэг гэдгийг галатчууд амьдралын туршлагаасаа ойлгох учиртай байлаа.

Паул хоёр дахь нотолгоогоо хуурамч багш нарын хозлол хийх шаардлагатай гэж харуулах зорилгоор гуйвуулан ашигладаг Бичвэрийн хэсгээс эш татжээ! Энэ тал дээр Хуучин гэрээ яг юуг өгүүлдэг вэ?

3:6 Бурхан галатчуудтай итгэлийн үндсэн дээр харилцдаг байсныг Паул харуулсан бол одоо Хуучин гэрээний цаг үед амьдарч байсан хүмүүс ч ялгаагүй итгэлээр аврагдсаныг харуулж байна. 5-р эшлэлд **“Тэрээр үүнийг хуулийн үйлсээр үйлддэг үү эсвэл сонссондоо итгэснээр чинь үйлддэг үү?”** хэмээн асуужээ. Үүний

хариулт нь **сонссондоо итгэснээр үйлддэг** гэсэн нь болой. Паул энэ хариуг бодолдоо хадгалан “**Яг үүнчлэн Абрахам Бурханд итгэсэн**” хэмээн 6-р эшлэлийг эхлүүлж байна. Абрахам яг үүнчлэн сонсонддоо итгэснээр зөвтгөгдсөн.

Иудей багш нар Абрахамыг өөрсдийн баатар, үлгэр дуурайлал болгож, хозлол хийх шаардлагатай хэмээх үзлээ бататгаж байсан биз (Эх 17:24, 26). Тэгвэл Паул яг тэр үндэслэлээр нь тэдэнд хариу барьж байна. Абрахам яаж аврагдсан бэ? **Абрахам Бурханд итгэсэн**. Үүнд хичээл зүтгэл хийгээд түүний гавьяа зүтгэл ямар ч хамаагүй. Бурханд итгэхгүй бол мунхаг хэрэг болно. Аврагдахын тулд хүний зүгээс хийж чадах цорын ганц зүйл бол итгэх явдал билээ. Ингэснээр хүн сайрхах боломжгүй болно. Итгэх нь хүний хүчин чармайлт шаарддаг “сайн үйлс” биш ээ. Мөн махбодод ч шалтаг өгдөггүй. Бүтээл нь Бүтээгчдээ, хүүхэд нь Аавдаа итгэж найдахаас илүү зөв зүйл гэж юу байх билээ?

Зөвтгөл бол Бурхан Өөрт нь итгэсэн хүмүүсийг зөв хэмээн тооцсоноор бий болдог Бурханы үйл хэрэг билээ. Христ Голготын толгод дээр нүгэлт бидний оронд загалмай дээр цовдлогдсон учир Бурхан нүгэлтнүүдтэй зохих журмын дагуу харилцах боломжтой болсон. Зөвтгөнө гэдэг нь Бурхан итгэгч хүнийг хувь хүнийх нь улмаас зөвт, нүгэлгүй болгоно гэсэн үг биш. Харин Аврагчийн гүйцэлдүүлсэн үйл хэрэгт үндэслэн зөвт тооцно гэсэн үг. Бурхан Өөрт нь итгэсэн нүгэлтнийг диваажинд орох эрхтэй болгоод гүйцэлдүүлж өгсөн сайн сайханд нь талархсандаа зөв шударгаар амьдраасай гэж хүсдэг. Гол нь зөвтгөл хуулийн үйлстэй ямар ч хамаагүй гэдгийг анхааралдаа авууштай. Энэ нь бүхэлдээ итгэл дээр тулгуурладаг.

3:7 Галатчуудад Абрахамын жинхэнэ хөвгүүд болохын тулд хозлуулах хэрэгтэй гэж иудей багш нар зааж байсан нь дамжиггүй. Харин Паул үүнийг няцааж байна.

Абрахамын жинхэнэ **хөвгүүд** нь еврей хүн, иудей болсон хүмүүс биш, харин итгэлээр аврагдсан хүмүүс юм. Абрахам хозлуулахаасаа *өмнө* зөвт тооцогдсон гэдгийг Паул Ром 4:10, 11 дээр харуулдаг. Өөрөөр хэлбэл, Абрахам *харь үндэстэн* гэсэн тодотголтой байхдаа л зөвтгөгдсөн байна.

3:8 Хуучин гэрээг эш үзүүлэгч мэтээр дүрсэлж, **Бурхан харийнхныг** төдийгүй иудейчүүдийг **итгэлийн** үндсэн дээр **зөвтгөнө** гэдгийг олон зуун дамнан **урьдчилан** харсан гэж үзжээ. **Харийнханд итгэлээр** ирэх ерөөлийг Хуучин гэрээ урьдаас зөгнөөд зогсохгүй Эхлэл 12:3 дээр Абрахамд “Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно” хэмээн тунхагласан байдаг.

Эхлэл номоос эш татсан энэ үгийг анх уншихаар Паул яаж ийм утга гаргаж ирээд байгааг харах амаргүй байдаг. Гэвч Хуучин гэрээнд энэ эшлэлийг шигтгэн бичсэн Ариун Сүнс, бүх үндэстэн итгэлээр аврагдах сайнмэдээ үүнд агуулагдаж буйг мэдэж байжээ. Паул Ариун Сүнсний онгодоор хөглөгдөн бичиж байсны хувьд тэр бидэнд далд утгыг нь тайлбарлах боломжтой болжээ. **Чамаар** гэдэг нь Абрахамтай хамт буюу Абрахамтай адил замаар гэсэн утгатай. **Бүх харийнхан** гэдэг нь еврейчүүд төдийгүй бүх үндэстэн гэсэн үг. **Ерөөгдөх болно** гэдэг нь аврагдана гэсэн утгатай. Абрахам хэрхэн аврагдсан бэ? **Итгэлээр**. Тэгвэл үндэстнүүд хэрхэн аврагдах вэ? Абрахамын нэг адил итгэлээр аврагдана. Ингэхдээ иудей болохгүйгээр яг байгаагаараа, харь үндэстнийхээ хувьд аврагдана.

3:9 Тиймээс итгэлийнхэн нь итгэгч **Абрахамын хамт ерөөгдсөн аж** хэмээн Бурханд итгэсэн бүхэн Абрахамтай хамт зөвтгөгдөнө гэдгийг иудей Бичвэр гэрчилж байна.

Б. Хууль ба амлалтын ялгаа (3:10-18)

3:10 Паул Ариун Бичвэрээс хууль нь ерөөх бус, харин ч хараал авчирдаг болохыг харуулжээ. Энэ эшлэлд “Хуулийг

зөрчигчид” гээгүй, харин **“Хуулийн үйлсийг түшигчид”** гэжээ. Үүнд хуулийг сахин биелүүлснээр Бурханы тааллыг хүртэхийг оролдож буй хэн бүхэн хамаарна. Тэд бүгдээрээ **хараал доор** байна. Өөрөөр хэлбэл, тэд үхлийн ялтай. **Учир нь “Хуулийн номд бичигдсэн бүхнийг хэрэгжүүлдэггүй, дагадаггүй хүн бүр хараагдсан” гэж бичигджээ** (Дх 27:26). Хуулийг нэг өдөр, нэг сар, нэг жил сахин биелүүлэх нь хангалтгүй. Хуулийг сахин биелүүлэгч хүн түүнийгээ ямагт баримтлах ёстой болдог. Өөрөөр хэлбэл, төгс дуулгавартай байх ёстой. Зөвхөн Арван хуулийг дагах нь хангалтгүй. Мосегийн таван номд бичигдсэн зургаан зуу гаруй хуулийг нэгийг нь ч алгасалгүй мөрдөх ёстой болно.

3:11 Паул хуурамч багш нарыг дахин Хуучин гэрээг эш татан няцааж байна. Бурхан хүмүүсийг хуулиар бус, зөвхөн **итгэлээр** зөвтгөдөг гэдгийг харуулахын тулд тэрээр Хабаккук номоос эш татав. Эш татсан өгүүлбэр нь грек эх хэл дээрээ **“Зөвт хүн итгэлээр амьдарна”** гэсэн дараалалтай бичигдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, үйлсээр бус, **итгэлээр** зөвт тооцогдсон хүмүүс мөнх амийг хүртэнэ. Итгэлээр зөвтгөгдсөн хүмүүс **амьдарна**.

3:12 Хууль хүнээс итгэхийг шаарддаггүй. Тэр ч байтугай тушаалуудыг сахих гэж *хичээхийг* ч шаарддаггүй. Харин Леви номд хэлсэнчлэн нарийн чанд, бүрэн дүүрэн, төгс дуулгавартай байхыг шаарддаг. Энэ нь итгэлийн зарчимтай зөрдөг. Хууль “Үйлдвэл амьтай” гэдэг бол итгэл “Итгэвэл амьтай” гэдэг. Тэгэхээр **зөвт хүн итгэлээр амьдардаг** гэсэн санааг Паул дэвшүүлж байна. **Хуулийн доор** буй хүн **итгэлээр** амьдардаггүй тул Бурханы өмнө зөвт биш болно. **“Тэдгээрийг үйлдэгч нь тэдгээрээр амьдарна”** гэж хэлэхдээ Паул онолын томьёолол буюу биелүүлэх боломжгүй хийсвэр зарчмыг илэрхийлжээ.

3:13 Золих гэдэг нь эргүүлэн худалдаж авах, үнийг нь төлөөд чөлөөлөхийг хэлнэ. **Хуулийн хараал** буюу

тушаалуудыг зөрчсөний шийтгэл нь үхэл. Христ хуулийн шаарддаг үхлийн шийтгэлийг үүрээд хуулийн доорх хүмүүсийг чөлөөлсөн. (Паул “бид” хэмээх төлөөний үгийг хэрэглэхдээ голчлон итгэгч иудейчүүдийг хэлсэн нь дамжиггүй ч тухайн иудейчүүд нь нийт хүн төрөлхтний төлөөлөл болсон юм)

Синддилан Жонс ийн хэлжээ:

Христ өөрсдийг нь хэсэгчлэн худалдаж авсан тул үлдсэн хэсгээ худалдаж авахын тулд хозлуулах болон иудейн бусад ёс заншлыг сахих ёстой гэж галатчууд төсөөлжээ. Тиймээс л хуурамч багш нарын үгэнд автаж, христитгэлийг иудейзмтай хольж хутгахад бэлэн байлаа. Паул үүнд хариу өгөхдөө “Христ биднийг хуулийн хараалаас бүрэн худалдаж авсан юм” хэмээжээ (Уэльсийн орчуулга).

Христ хүмүүсийн оронд үхэж, нүглийн эсрэг шатсан Бурханы аймшигт уур хилэнг үүрч хүмүүсийг **зольсон**. Бурханы **хараал** хүмүүсийг орлосон Түүн дээр буусан. Тэр Өөрөө нүгэлд автаагүй ч гэлээ хүн төрөлхтний нүглийг Түүн дээр тохжээ.

Христ дэлхий дээр амьдарч байхдаа Арван хуулийг төгс сахиснаар хүмүүсийг **хуулийн хараалаас** золиогүй. Хуулийг төгс дуулгавартай дагасан нь биднийг мөн тийнхүү үйлдсэнд тооцно гэж Библи заадаггүй. Харин Тэр хуулийн аймшигт хараалыг үүрч, амиа өргөснөөр хүмүүсийг хуулиас гэтэлгэжээ. Түүний үхлээс ангид аврал гэж үгүй. Гэмт хэрэгтнийг модон дээр өлгөх нь Бурханы хараалыг хүртэж буйн тэмдэг гэж хуульд заадаг ажээ (Дх 21:23). Энд Аврагч Эзэн бүтээлүүдийнхээ хараалыг үүрч модон дээр өлгөгдөн амиа өргөснийг Ариун Сүнс урьдчилан зөгнөсөн байна. Тэрээр тэнгэр газрын аль алинд нь үнэ цэнгүй Нэгэн болж өлгөгджээ. Ингэхдээ загалмайд

цовдлогдсон Түүнийг **модон дээр** өлгөгдсөн гэж хэлдэг (Үйл 5:30; 1Пт 2:24).

3:14 Бурхан Абрахамыг ерөөж, түүгээр дамжуулан бүх дэлхийг ерөөхөө амласан. **Абрахамын ерөөл** нь итгэлээр дамжин нигүүлслээр аврагдах аврал юм. Гэхдээ Бурханы шаарддаг үхлийн шийтгэл эхлээд төлөгдөх ёстой байв. Тиймээс Эзэн Есүс, иудей болон харь үндэстнүүдэд Бурханы ерөөлийг авчрахын тулд эхлээд хараал болох ёстой байжээ. Одоо Христ (Абрахамын удам) дотор үндэстнүүд ерөөгджээ.

Эхлэл 12:3 дээр гарч буй Абрахамд өгсөн Бурханы амлалтад Ариун **Сүнсийг** шууд дурдаагүй. Харин Паул энд Бурханы амьсгалаар бидэнд, Ариун Сүнсний бэлэг нь Бурханы Абрахамтай байгуулсан авралын болзолгүй гэрээн дотор багтаж байсан гэж хэлж байна. Ариун Сүнс тэр үед үр ирэх бэлтгэлээ базааж байсан гэсэн үг. Учир нь хууль байгаа цагт Ариун Сүнс ирэх боломжгүй. Ариун Сүнс өгөгдөхийн өмнө Христ нас барж, цог жавхланд орох ёстой байлаа (Иох 16:7).

Аврал нь хуулиар бус, итгэлээр ирдэг гэдгийг элч Паул, нэгт галатчуудын өөрсдийнх нь амьдралын туршлагаар, хоёрт Хуучин гэрээний гэрчлэлээр нотлов. Одоо харин хүний өдөр тутмын амьдралын жишээгээр тайлбарлаж байна.

Энэ хэсэгт дэвшүүлэх Паулын санааг дараах байдлаар тоймлож болно. Үүнд, Бурхан Абрамаар дамжуулан дэлхийн бүх гэр бүлийг ерөөнө гэж Эхлэл 12:3 дээр амласан. Авралын энэхүү амлалтад харь үндэстнүүд төдийгүй иудейчүүд багтдаг. Мөн Бурхан Эхлэл 22:18 дээр “Дэлхийн бүх үндэстэн чиний үрээр дамжуулан ерөөгдөнө” гэж амласан. Бурхан “үрс” (олон тоо) гээгүй “үр” (ганц тоо) гэжээ. Бурхан Нэг Хүнийг буюу Абрахамын цусан төрлийн удам болох Есүс Христийг хэлжээ (Лк 3:34). Өөрөөр хэлбэл, Бурхан харь үндэстэн төдийгүй иудейчүүдийг

оролцуулан дэлхийн бүх үндэстнийг Христээр дамжуулан ерөөнө гэж амлажээ. Энэ амлалт ямар ч нөхцөл болзолгүй бөгөөд сайн үйлс, хуулийн дуулгавартай байдал зэргийг ч шаарддаггүй. Гагцхүү итгэлээр л хүлээн авбал зохих энгийн амлалт байлаа.

Түүнээс гадна, 430 жилийн дараа Израильд өгөгдсөн хуулийн амлалт дээр ямар нэг нөхцөл нэмэх буюу өөрчлөх боломжгүй ажээ. Хүний ёсонд ч бас нэгэнт амласан амлалтаа өөрчлөх нь шударга бус явдал болно. Тэгвэл тэр тусмаа тэнгэрлэг амлалтын тухайд бодохын ч хэрэггүй. Тэгэхээр харь үндэстнүүдийг Христээр дамжуулан ерөөх Бурханы амлалт нь хуулийн үйлсээр бус, итгэлээр биелнэ гэдэг дүгнэлт хийж болохоор байна.

3:15 Гарын үсэг зурж, тамгалан баталгаажуулсан аливаа гэрээ, гэрээслэлийг өөрчлөх эсвэл түүн дээр нэмэх явдал хүний ёсонд ч байдаггүй. Хүмүүний гэрээслэлийг зөрчиж болдоггүй юм бол Бурханых бүр ч илүү хүчин төгөлдөр байх ёстой!

3:16 Иудейжүүлэх үзэлтнүүд амлалтуудыг Абрахам болон түүний удамд (Израилийн ард түмэн) анх итгэлээр өгсөн ч тэд хожим нь хуулийн дор орсон гэж маргаж байсан нь гарцаагүй. Тиймээс галатчууд анхандаа итгэлээр аврагдсан ч одоо Арван хуулийг сахих ёстой гэж номложээ. Паул үүнд **“Амлалтууд нь Абрахамд болон Үрд (ганц тоо) нь айлдагдсан юм”** хэмээн хариулж байна. “Үр” гэдэг нь заримдаа олон хүнийг илэрхийлэх тохиолдол байдаг ч яг энд бол нэг Хүнийг, тухайлбал Христийг хэлж байна. (Бид өөрсдөө Хуучин гэрээг уншихдаа үүнийг хэзээ ч анзаарахгүй өнгөрч болох ч Бурханы Сүнс бидний нүдийг нээж өгдөг)

3:17 Бурханы Абрахамд өгсөн амлалт нөхцөл болзолгүй, үйлсээс бүрэн ангид. Түүнчлэн, Бурхан Абрахамд Үрийг (Христ) өгнө гэж амласан. Хэдийгээр Абрахам үр хүүхэдгүй байсан ч Бурханд итгэжээ. Үүгээрээ

тэр ирэх Христэд итгэж, зөвтгөгдсөн юм. **Дөрвөн зуун гучин жилийн дараа ирсэн тэр хууль** авралын амлалтад **огтхон ч** нөлөөлөх боломжгүй байлаа. Энэ хууль амлалтыг цуцалдаг ч үгүй, ямар нэг нөхцөл болзол ч нэмдэггүй.

Иудейжүүлэх үзэлтнүүд магадгүй амлалтаас хойш 430 жилийн дараа ирсэн хууль амлалтыг хүчингүй болгосон гэж ятгасан байх л даа. Гэвч ердөө ч тийм биш. “Амлалт нь гэрээслэлтэй адил. Энэ нь зөвхөн үхлээр баталгааждаг (гэрээний тахил, Эх 15:7-11; мөн Евр 9:15-22-ыг үз) бөгөөд хүчингүй болдоггүй” гэсэн санааг Паул хэлж байна.

Иаков Египетэд хөл тавихаар бэлтгэж байхад Бурхан Абрахамын гэрээг түүнд баталгаажуулж өгсөн (Эх 46:1-4) цагаас эхлээд израильчууд Египетээс гарснаас хойш ойролцоогоор гурван сарын дараа хууль өгөгдөх хүртэлх хугацаа нь 430 жилийг хамарсан гэж үздэг.

3:18 Өв залгамжлал нь нэг бол итгэлээр эс бол үйлсээр ирнэ. Энэ хоёр хоёулаа байх боломжгүй. Үүнийг **Абрахамд болзолгүй амлалтаар соёрхсон** гэж Библи тодорхой хэлжээ. Авралыг ч мөн адил ямар ч нөхцөл болзолгүй, бэлэг хэлбэрээр санал болгодог.

В. Хуулийн зорилго (3:19-29)

3:19 Тэгвэл юуны тулд хууль байгаа юм бэ? Паулын хэлж байгаачлан хууль нь Абрахамд өгсөн Бурханы амлалтыг үгүйсгэдэггүй, түүн дээр ямар ч нөхцөл болзол нэмдэггүй юм бол **хуулийн зорилго** юу байсан юм бэ? Хууль нь нүглийг жинхэнэ мөн чанараар нь, алдаа зөрчил болохыг илчлэх зорилготой. Хууль ирэхээс өмнө нүгэл байсан боловч хууль ирэх хүртэл хүн нүглийг алдаа зөрчил гэж мэдээгүй. Алдаа зөрчил гэдэг нь хууль зөрчих явдал юм.

Хуулийг нүгэлт үндэстэнд өгсөн. Тэд хуулийг сахиснаараа хэзээ ч зөвт байдалд хүрч чадахгүй байлаа.

Учир нь тэдэнд дуулгавартай дагах хүч байгаагүй юм. Хүн гэгч ямар ч найдваргүй нүгэлтэн гэдгийг хүмүүст ухааруулах нь хуулийн зорилго юм. Ингэснээр хүмүүс Бурхан руу хашхирч, нигүүлслээрээ аварч өгөхийг гуйх юм. Абрахамтай байгуулсан Бурханы гэрээ нь нөхцөл болзолгүй ерөөлийн амлалт байсан. Хууль харин хараалыг л авчирдаг. Хүмүүн гэгч үнэгүй, нөхцөл болзолгүй ерөөлийг хүртэх зохисгүй гэдгийг хууль харуулдаг. Хэрэв хүн ерөөгдвөөс энэ нь Бурханы нигүүлслээр л боломжтой юм.

Үр бол Христ мөн. Тиймээс хууль нь Христийг ирэх хүртэл түр зуурын зохицуулалт болж байв. Абрахамд амласан ерөөл Түүгээр дамжин ирэх ёстой байсан. Хоёр талын гэрээнд **зууч** оролцдог буюу завсрын хүнтэй байдаг. Тэгвэл Хуульд Бурхан болон Израиль гэсэн гэрээний хоёр тал оролцсон. Мосе дунд нь зуучийн үүрэг гүйцэтгэсэн (Дх 5:5). Бурханы тэнгэрэлч нар хуулийг Мосед дамжуулах үүрэг гүйцэтгэсэн юм (Дх 33:2; Дуу 68:17; Үйл 7:53; Евр 2:2). Мосе болон тэнгэрэлч нарын оролцоо нь Бурхан ба Түүний ард түмний хооронд ангал мэт орон зай байсныг, мөн Түүний оршихуйд тэд зохисгүй ард түмэн байсныг харуулдаг.

3:20 Хэрэв зөвхөн нэг тал л гэрээнд давамгай эрхтэй байж, тэр нь нөхцөл болзолгүй амлалт өгч, нөгөө талаасаа юу ч шаардаагүй бол **зуучийн** хэрэг байхгүй. Гэтэл Хуульд зууч шаардлагатай болсон нь хүний зүгээс гэрээний үүргээ биелүүлэх шаардлага байсныг илтгэдэг. Энэ нь хуулийн сул тал юм. Хууль нь биелүүлж чадахгүй хүнээс дуулгавартай байдлыг нэхдэг. Харин Абрахамд өгсөн амлалтын тухайд Бурхан ганцаараа гэрээний Тал болсон юм. Энэ нь амлалтын давуу тал билээ. Бүх зүйл Бурханаас хамаарах тул хүнээс юу ч шалтгаалахгүй. Зуучийн шаардлага байгаагүй тул зууч оролцоогүй.¹²

3:21 Ингэхлээр хууль Бурханы амлалтуудыг хүчингүй болгож, орлосон уу? **Огт үгүй!** Нүгэлтнүүд Бурханы шаардаж буй төгс төгөлдөрт хуулиар хүрч чадах байсан бол аврал гарцаагүй хуулиар ирэх байлаа. Аврал арай бага өртгөөр ирж болох байсан бол Бурхан цорын ганц хайрт Хүүгээ илгээж, нүгэлтнүүдийн төлөө үхүүлж, ийм их золиос гаргахгүй байх байлаа. Харамсалтай нь цаг хугацааны шалгуур, нэлээдгүй олон хүний жишээ хуулиар нүгэлтнүүдийг аварч чадахгүй гэдгийг хангалттай харуулсан. Энэ утгаараа хууль “махбодоор дамжин мөхөс болсон.” (Ром 8:3) Хуулийн хийж чадах ганц зүйл хүнийг найдвар тасарч, цөхөрсөн нүгэлтэн болохыг харуулж, Бурханы үнэгүй нигүүлслээр л аврагдах боломжтой гэдгийг ойлгуулахад оршиж байв.

3:22 Хуучин гэрээ Хуулийн доор байгаа хүмүүсийг ч хамруулан бүх хүн нүгэлтэн гэдгийг харуулжээ. **Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан итгэгчид** авралын **амлалтыг** хүлээн авахын тулд хүн нүгэлтэй гэдгээ гүн гүнзгий ухаарах шаардлагатай байв. Тиймээс ч 22-р эшлэлийн түлхүүр үгс нь **итгэл, өгөх, итгэх** болой. Энд “хийх” хийгээд “хууль сахих” талаар юу ч дурдаагүй байна.

3:23 Энд ярьж буй **итгэл** бол христитгэл мөн. Энэ нь Эзэн Есүсийн үхэл, оршуулга, амилал, тэнгэр өөд одсон хийгээд Пентэкостын өдөр сайнмэдээ тунхаглагдсанаар ирсэн эрин үеийг илэрхийлдэг. Түүнээс өмнө иудейчүүд шоронд хоригдож, албадан саатуулагдсан мэт **хорионд байжээ**. Тэд хуулийн шаардлагаар хязгаарлагдсан байв. Нэгэнт уг шаардлагуудыг биелүүлж чадахгүйгээс хойш авралд хүргэх **итгэлийн** зам дээр зогсож хашигдсан байлаа. Иймээс хуулийн доор буй хүмүүс сайнмэдээгээр дамжуулан хуулийн боолчлолоос чөлөөлөх ялгуусан мэдээг тунхаглах хүртэл тийнхүү хорионд байв.

3:24 Хуулийг хүүхдийн асран хамгаалагч, **зааварлагч**¹³, багштай адилтгажээ. Энэ нь зааж

сургамжлах санааг онцолдог. Хууль нь Бурханы ариун байдал, хүмүүний нүгэлт чанар, солигдох хэрэгцээ шаардлагыг сургамжилдаг. Зааварлагч гэдэг эл үг нь насанд хүрч, төлөвшөөгүй хүүхдүүдэд зааж сургадаг, ерөнхий чиглүүлэг өгдөг хүнийг хэлдэг.

Биднийг хандуулах гэсэн үг эх бичвэр дээрээ байдаггүй. Харин энэ үгийг англи орчуулгад нэмж оруулсан байдаг. Хэрэв энэ үгийг авчихвал хууль нь Христийг ирэх хүртэл иудейчүүдийн асран хамгаалагч байсан гэх санаа гарч ирдэг. Нэг талаар Хууль нь гэрлэлт, өмч хөрөнгө, хоол унд гэх мэтэд хамаарах дүрэм журмуудаар Израиль үндэстнийг хамгаалж байсан тал бий. “Итгэл” ирэхэд, олон зуун жилийн турш гайхамшигтайгаар хамгаалагдаж байсан энэ үндэстэнд уг сайнмэдээ хамгийн түрүүнд тунхаглагдав. **Итгэлээр зөвтгөгдөх** нь золилтыг гүйцэлдүүлсэн Аврагч Христийн үйл хэрэг дээр үндэслэдэг амлалт юм.

3:25 Хууль бол **зааварчлагч**. Харин христэч **итгэлийг** хүлээн авмагц итгэгч иудейчүүд цаашид хуулийн доор **байхаа болив**. Тэгвэл анхнаасаа зааварлагчийн дор *огт* байгаагүй галатчууд шиг харийнхан бүр ч тийнхүү байх ёстой! Хүн *хуулиар зөвтгөгдөхгүй* гэдгийг 24-р эшлэлд заасан бол зөвтгөгдсөн хүн *хуулиар амьдралаа удирдуулахгүй* гэдгийг 25-р эшлэлд зааж байна.

3:26 Төлөөний үг нь “бид” байснаа **та нар** болж өөрчлөгдөж байгааг анзаараарай. Паул иудейчүүдийн тухай ярихдаа “бид” гэж нэрлэхдээ иудейчүүд Христийг ирэх хүртэл хуулийн дор хоригдсон байсан гэдгийг харуулсан. Хууль тэднийг итгэлээр зөвтгөгдөх мэдээг сонсох тусгай ард түмний ёсоор сахин хамгаалжээ. Тэд зөвтгөгдсөнөөр хуулийн доор байхаа больж, иудей гэх онцлог нь ч байхгүй болдог. Тиймээс эндээс эхлээд бүлгийн төгсгөл хүртэл ашигласан **“та нар”** гэх төлөөний үг нь аврагдсан иудейчүүд болон харь үндэстнүүдийг

хоёуланг нь хамруулан хэлж байна. Тийм хүмүүс **Христ Есүст итгэх итгэлээр Бурханы хөвгүүд** болдог.

3:27 Христэд итгэх үедээ бид Христтэй нэгдмэл болж, үүнийгээ усан баптисмаар нийтэд зарладаг. Энэхүү баптисм хүнийг христитгэгч буюу Бурханы хаанчлалын өв залгамжлагч болгодоггүй. Энэ нь Паулын хэлсэнчлэн **Христийг өмсөх** буюу Христтэй нэг болсныг олны өмнө зарлах ёслол юм. Яг л цэрэг хүн армийнхаа дүрэмт хувцсыг өмсөж нэг тал гэдгээ харуулдаг шиг христитгэгч хүн усаар **баптисм** хүртэн Христийнх гэдгээ харуулдаг. Энэ үйлдлээрээ тэр Христийн удирдлага хийгээд эрх мэдэлд захирагдаж буйгаа нийтэд илэрхийлж, Христийг Бурханы Хүү гэдгийг олны өмнө харагдахуйцаар дүрслэн үзүүлдэг ажээ.

Усан баптисм хүнийг Христтэй холбодог гэж элч Паул огт хэлээгүй нь ойлгомжтой. Тэр тэгж хэлсэн бол зөвхөн итгэлээр аврагдана гэсэн өөрийн суурь зарчмыг ил тод үгүйсгэж байгаа хэрэг болно.

Мөн элч Паул итгэгчийг Христийн биеийн эрхтэн болгодог Сүнсний баптисмыг (1Ко 12:13) хэлсэн байх магадлал ч тун бага. Ариун Сүнсний баптисм хүний нүдэнд үл харагдана. Үүнд нийтийн өмнө Христийг өмсөхтэй холбоотой илэрхийлэл ч байхгүй.

Энэ бол Христ *руу* баптисм хүртэх тухай юм. Израильчууд Мосе *руу* баптисм хүртэж, түүнийг удирдагчаа хэмээн хүлээн авсан шиг өнөөгийн итгэгчид Христ *руу* баптисм хүртэж, Түүнийг зүй ёсны Эзэн хэмээн хүлээн зөвшөөрдөг.

Баптисм хүртэхдээ итгэгч хүн махбод болон зөвт байдалд хүрэх гэсэн оролдлогуудаа бүгдийг нь булшилж буйгаа илэрхийлдэг. Энэхүү ёслолоор тэд хуучин амьдралдаа төгсгөл тавьж, шинэ амьтай болсноо илтгэдэг. Галатчууд усан баптисм хүртэхдээ Христтэй хамт үхэж, Түүнтэй хамт оршуулагдсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн

билээ. Христ хуулийн хувьд үхсэнчлэн тэд ч хуулийн хувьд үхсэн тул дүрмийн дагуу хуулийн доор байхыг хүсэх ёсгүй юм. Христ үхлээрээ дамжуулан иудей ба харь үндэстний хоорондох ялгааг нураасан тул тэд ч мөн үндэстэн ястны ялгааны хувьд үхэх учиртай. Тэд одоо Христийн амиар явдаг цоо шинэ амьдралтай болж **Христийг өмссөн** билээ.

3:28 Хууль нь иудейчүүд ба харь үндэстний хооронд зааг тогтоодог байсан. Тухайлбал, Дэд хууль 7:6; 14:1, 2 дээр израилийг бусад үндэстнээс онцгойд тавьжээ. Иудей эр өглөөний залбиралдаа өөрийг нь харь үндэстэн, боол, эмэгтэй хүн болгож төрүүлээгүйд Бурханд талархдаг байв. Тэгвэл одоо Бурханд хүлээн зөвшөөрөгдөх тал дээр **Христ Есүс дотор** энэ ялгаа арилжээ. Иудей хүн харь үндэстнээс давуу биш. Чөлөөт хүн боолоос илүү биш. Эр хүн эмэгтэй хүнээс илүү биш. Нэгэнт **Христ Есүс дотор** байгаа учир бүгд нэг зиндаанд байна.

Энэ эшлэлийн илэрхийлээгүй утгыг хүчээр тулган тайлбарлаж огт болохгүй. Өдөр тутмын амьдралын тухайд (чуулганы олон нийтийн үйлчлэлийн талаар хэлэх нь илүүц биз ээ) Бурхан эрэгтэй, эмэгтэй хүний ялгааг хүлээн зөвшөөрдөг. Шинэ гэрээнд эрэгтэй, эмэгтэй хүнд хандан тус тусад нь заавар өгсөн. Түүнээс гадна эзэн боолын харилцааг ч тус тусад нь зааварчилсан. Харин Бурханаас хүртэх ерөөлийн тал дээр энэ ялгаа хамаагүй юм. Учир нь тэд бүгдээрээ **Христ Есүс дотор** байна. (Энэ нь бидний тэнгэрлэг байр суурийг ярьж байгаа болохоос энэ дэлхий дээрх нөхцөл байдлыг хэлээгүй гэсэн үг). Бурханы өмнө итгэгч иудей хүн Христ рүү эргэсэн харь үндэстнээс дээгүүр биш! “Хуулийн бий болгосон ялгаа Бурханы өгсөн нэг оршуулгаар булшлагдан алга болдог” гэж Говетт хэлжээ. Тиймээс Христийн үгүй хийсэн ялгааг христитгэгчид дахин сэргээж, улам ариун болохоор хөөцөлдөх нь туйлын мунхаг хэрэг мөн.

3:29 Галатчууд хуулийг сахиснаараа Абрахамын үр сад болж чадна гэж бодон төөрөлджээ. Паул үүнийг эсрэгээр нь хэлж байна. Христ бол Абрахамын үр. Абрахамд амласан өв залгамжлал нь Христ дотор биелэлээ олсон. Тиймээс нүгэлт хүмүүс Христэд итгэх үед тэд Христтэй нэг болно. Тэгснээр тэд **Абрахамын үр** болж, Христ дотор Бурханы бүх ерөөлийг өв залгамжлан авдаг.

Г. Хүүхдүүд болон хөвгүүд (4:1-16)

4:1,2 Энд хүүгээ нас биед хүрэхээр бүх эд хөрөнгөө өвлүүлэхийг хүсэж буй баян чинээлэг эцэг хүний дүр зураг байна. Гэвч хүү бага балчир хэвээрээ байгаа тул өв залгамжлах эрх нь зарцынхаас **ялгагдах юмгүй**. Хүүд үргэлж л ингэж болно, тэгж болохгүй гэж зааварлана. Харин тэр насанд хүрэх хүртэл өв хөрөнгөнд нь хямгатай хандах **асрамжлагсад болоод итгэмжлэгдсэн хүмүүс байдаг**. Өв хөрөнгө нь гарцаагүй түүнийх боловч өсөж том болох хүртэл өвөө захиран зарцуулах боломжгүй.

4:3 Хуулийн доор байсан иудейчүүд яг үүнтэй адил байлаа. Тэд зарц боолын адил хуулиар бүхнээ заалгадаг хүүхэд байв. Тэд **хорвоогийн язгуур юмсын доор боолчлолд байсан**. Энэ нь иудейн шашны анхан шатны зарчмуудыг хэлж байна. Иудейзмын зан үйл хийгээд ёслолууд нь Христийн дотор Өөрийгөө илчилсэн Эцэг Бурханыг хараахан мэдээгүй хүмүүст зориулагджээ. Үүнийг хүүхдэд анхан шатны хэл бичгийн дүрмийг заах зорилгоор янз бүрийн дүрс, зураг ашиглан хичээл заадагтай адилтгаж болно. Хууль нь сүнслэг зүйлсийн утгыг ойлгуулахын тулд гадна өнгөн талын юмсаар дүрсэлдэг сүүдэр зургаар дүүрэн байдаг. Үүний нэг жишээ бол хозлол мөн. Иудейзм нь биет, өнгөн талын, түр зуурын шинжтэй байсан бол христитгэл сүнслэг, дотоод руу

чиглэсэн, үүрдийнх байдаг. Энэхүү өнгөн талын юмс хүүхдүүдэд нэг төрлийн **боолчлол** болж байлаа.

4:4 Цаг нь болоход гэдэг нь өв залгамжлагчид нас биед хүрснийг илтгэх Тэнгэрлэг Эцэгийн тогтоосон цагийг хэлдэг (2-р эшлэлийг үзнэ үү).

Энэ эшлэл Аврагчийн бурханлаг чанар хийгээд хүн гэсэн мөн чанарыг цөөн хэдхэн үгээр гайхалтай илэрхийлсэн байдаг. Тэрээр Бурханы мөнхийн Хүү мөн. Гэвч Тэр **эмэгтэй хүнээс** төрсөн. Хэрэв Есүс жирийн хүн байсан бол **эмэгтэй хүнээс** төрсөн гэж хэлэх нь илүүц болно. Хүн бүр л эмэгтэй хүнээс төрдөггүй гэж үү? Тэгвэл энэ илэрхийлэл Эзэн Есүсийг бусдаас онцгой Нэгэн болохыг, ер бусын байдлаар төрснийг илэрхийлдэг.

Тэрээр энэ дэлхийд израиль хүн болж **хуулийн доор төржээ**. Харин Бурханы Хүү болохын хувьд Эзэн Есүс хэзээ ч хуулийн доор байсан байх учиргүй. Харин ч Тэр Өөрөө хуулийг өгсөн Нэгэн. Гэвч Тэрээр маш даруу байдал дотор нигүүлслээрээ Өөрийн тогтоосон **хуулийн доор** төрж, амьдралаараа дамжуулан хуулийг агуу болгож, үхлээрээ хуулийн хараалыг үүрсэн юм.

4:5 Хууль нь өөрийг нь зөрчигчдөөс үхэх ялыг нэхдэг. Бурхан хүнийг хүүгийн байр суурин дээр тавихын тулд эхлээд энэ ялын төлөөсийг төлөх ёстой байв. Тиймээс Эзэн Есүс хүн төрөлхтний нэгэн эс болж энэ дэлхийд иудей хүн болон төрөөд хуулийн шаардсан төлөөсийг төлсөн юм. Тэр Бурхан учраас үхэл нь хязгааргүй үнэ цэнтэй. Өөрөөр хэлбэл, хэдэн ч нүгэлтний нүглийн төлөөсийг төлөхөд хүрэлцээтэй. Тэр Хүн учраас хүнийг төлөөлөн үхэх боломжтой байсан. “Христ Бурханы Хүүгийн мөн чанараар хүний Хүү болсон тул бид хүний хөвгүүдийн мөн чанараар Бурханы хөвгүүд болох боломжтой болжээ. Юутай гайхалтай солилцоо вэ!” хэмээн Говетт уулга алджээ.

Хүн боол байгаа цагт хөвгүүн нь байх боломжгүй. Христ тэднийг Бурханы хөвгүүд болгон үрчилж авахын

тулд хуулийн боолчлолоос чөлөөлжээ. *Бурханы хүүхэд* хийгээд *Бурханы хүү* гэдэг ялгаатай байгааг анзаарч хараарай (Ром 8:14, 16-тай харьцуулан үзнэ үү). Итгэгч хүн Бурханы гэр бүлд *хүүхэд* нь болж төрдөг (Иох 1:12-ыг үз). Энд тэнгэрлэг төрөлтийг онцолж байгаа болохоос хүүд өгөгдөх эрх, үүргийг онцлоогүй. Мөн итгэгч хүн Бурханы гэр бүлд *хүү* нь болж үрчлэгддэг. Христитгэгч хүн бүр итгэсэн даруйдаа *хүү* нь болж, Бурханы хүртээх өвийг залгамжлагч болдог. Тиймээс Шинэ гэрээнд ариун хүмүүсийн дунд нялх балчир *хүүхэд* байхгүй гэдэг утгаар заавар зөвлөгөө өгдөг. Шинэ гэрээ бүх итгэгчдийг насанд хүрсэн хөвгүүд гэж харьцдаг.

Ромын соёлд **үрчлэл** нь өнөөгийн биднийхээс өөр байсан. Бидний хувьд үрчлэл гэхээр өөр хүний хүүхдийг өөрийн болгохыг хэлдэг. Харин Шинэ гэрээнд **үрчлэл** гэдэг нь итгэгчдийг нас биед хүрсэн хүүгийн байр сууринд тавьж, тухайн байр сууринд хамаарах бүх эрх үүргийг бүрэн өгдөг.

4:6 Бурханы **хөвгүүдэд** энэхүү байр суурийнх нь эрхэм чанарыг ойлгоход дөхөм болгох үүднээс **Бурхан** Пентэкостын өдөр бидний дотор суурьшуулахаар Ариун **Сүнс**ийг илгээжээ. Тэр Сүнс биднийг Бурханы хөвгүүд болохыг мэдүүлж, Бурханыг “**Аав аа**” гэж дуудахад хөтөлдөг. “**Ааба, Аав аа**” гэдэг нь “аав” гэсэн арамей, грек үгнүүд юм. Ямар ч боол өрхийн тэргүүнийг ийнхүү дуудаж чадахгүй. Гагцхүү гэр бүлийнх нь гишүүд л ингэж дуудах эрхтэй бөгөөд энд хайр ба итгэл зориг илэрхийлэгдэж байна. Энэ эшлэлд **Сүнс, Хүү, Эцэг** гэсэн Гурвал ийм дараалалтай байгааг анзаараарай.

4:7 Итгэгч хүн **цаашид зарц** байхаа больжээ. Тэр цаашид хуулийн доор байхаа больсон. Одоо тэр Бурханы **хүү юм**. Христ Бурханы Хүүгийн хувьд Бурханы бүх баялгийн өв залгамжлагч болохын адил христитгэгчид ч бас **Бурханаар дамжин өв залгамжлагч нь мөн**.

Өнөөгийн Израильд буй раббиник сургуулийн сурагчид Соломоны дуун ном болон Езекиел номын 1-р бүлгийг дөчин нас хүртлээ унших хориотой. Соломоны дуун ном залуу хүмүүсийн хувьд бэлгийн амьдралыг хэтэрхий ил задгай илэрхийлсэн гэж үздэг тул үүнийг хорьдог. Езекиел 1-р бүлэгт үгээр ч илэрхийлж боломгүй ариун Бурханы алдрыг дүрсэлсэн байдаг гэж үздэг. Дөч хүрээгүй нэгэн хүн Езекиел 1-р бүлгийг уншиж эхэлтэл хуудаснаас нь гал дүрэлзэж түүнийг шатаасан хэмээн Талмудад өгүүлдэг ажээ. Энэ нь хуулийн доор буй хүн дөч хүртлээ нас биед хүрсэн гэж тооцогддоггүйг харуулж байна (Иудей хөвгүүд арван гуравтайдаа *бар мицва* буюу “хуулийн хүү” болдог бөгөөд энэ наснаас эхлэн хуулийг сахих үүрэг хүлээдэг). Харин ортодокс шашинд дөч хүрээгүй хүнийг хүүхэд хэмээн тооцдог байна.

Тэгвэл нигүүлслийн доорх итгэгчдийн тухайд ийм биш. Тэд аврагдсан даруйдаа өв залгамжлагч болдог. Улмаар тэднийг нас биед хүрсэн, том хүн гэж үздэг. Тиймээс тэд Библийг бүхэлд нь уншиж, судалж, таалан болгоож, дагаж болно.

Энэ талаар Харрисон яг голыг нь олж хэлсэн байдаг:

Бурханы хайрыг хүртсэн хүүхэд минь дээ! Бүх зүйл чинийх. Чиний төсөөлж чадахгүй тэр бүх агуу эд баялаг чинийх шүү гэдгийг ойлгуулахын тулд энэ тухай Тэр, 1Коринт 3:22, 23 дээр хэлсэн шүү дээ. Орчлон ертөнцийг бодоод үз дээ. Энэ бүхэн хэнийх вэ? Түүнийх бас чинийх. Тэгвэл хаан шиг амьдар.¹⁴

4:8 Галатчууд өмнө нь шүтээнд боолчлогдож байлаа. Христэд итгэхээсээ өмнө тэд мод, чулуугаар хийсэн хуурамч **бурхдыг** шүтэж байв. Гэтэл одоо өөр нэгэн боолчлол болох хуулийн доор оржээ.

4:9 Тэгвэл тэд ийм зан авираа хэрхэн зөвтгөх вэ? Тэд **Бурханыг таньж** мэдсэн шүү дээ. Бодитоор гүн гүнзгий таниагүй байлаа ч ядаж **Бурхан** тэднийг **таньсан**. Өөрөөр хэлбэл, тэд аврагдсан гэсэн үг. Гэтэл тэд Бурханаас өв залгамжилж авсан агуу хүч болоод баялгаас нүүр буруулж, **дорой буурай**, ядмаг юмс руу, тэр дундаа хозлол, ариун өдрүүд, хоол хүнсний дэглэм гэх мэт хуульд хамаарах зүйлс рүү эргэжээ. Ингэснээр өөрсдийг нь аварч чадахгүй, сайн сайхан руу хөтлөхгүй, зөвхөн дорой буурай болгох зүйлс рүү эргэн дахин **боолчлогджээ**.

Хууль хийгээд хуулийн ёслолуудыг Паул **дорой буурай** юмс хэмээн нэрлэдэг. Хуулиуд нь тогтоосон цаг, тухайн орчин нөхцөлдөө сайхан байсан ч Эзэн Есүсийг орлох үед саад тотгор болно. Христийг хуулиар солих нь шүтээн шүтлэг мөн.

4:10, 11 Галатчууд Амралтын өдөр, баяр ёслол, **улирал** бүхий иудейн хуанлийг баримталж байв. Өөрсдийгөө христитгэгч гэх боловч хууль сахих замаар Бурханд таалагдахыг эрмэлздэг хүмүүсээс эмээж буйгаа Паул илэрхийлсэн. Дахин төрөөгүй хүмүүс ч **өдөр, сар, улирал болоод жилүүдийг** чандлан мөрдөж чадна. Бурханы тааллыг олж авахын тулд өөрсдийн хүч чадлаар хийж чадах зүйл байгаа гэдгийг мэдрэх нь зарим хүнд асар их сэтгэл ханамж өгдөг. Гэвч энэ нь хүнд ямар нэг хүч чадал байгаа гэсэн утгыг илэрхийлж, түүнтэй зэрэгцээд Аврагч үнэндээ хэрэггүй мэт болгож харагдуулдаг.

Паул галатчуудад ийм захидал бичсэн юм бол хуулийг сахих замаар ариун байдалд хүрэх гэж оролддог христитгэгч нэртэй өнөөгийн хүмүүст тэр юу бичих байсан бол? Хүнээр томилогддог санваартнууд, санваартны тусгай өмсгөл, Амралтын өдөр, ариун газар, лаа, ариун ус гэх мэтчилэн иудейзмээс христитгэл рүү оруулж ирсэн энэ уламжлалуудыг гарцаагүй буруушаах байсан биш үү?

4:12 Анх Паул галатчуудад сайнмэдээг тунхаглах үед тэд ямар их баярлаж талархаж байснаа мартсан бололтой. Гэтэл галатчууд бүдэрч, гажуудах вий гэж эмээж байсан ч Паул тэднийг **“Ах дүү нар”** хэмээн дууджээ. Паул өмнө нь хуулийн доорх иудей байсан. Харин одоо Христ дотор хуулиас ангижирчээ. Тиймээс **“Надтай адил байцгаа** (хуулиас чөлөөлөгдөж, хуулийн дор амьдрахаа боль)” гэж хэлж байна. Харь үндэстэн галатчууд хэзээ ч хуулийн доор байгаагүй, байх ч ёсгүй. Тиймээс элч Паул, **“Би та нартай адил болсон** (иудей байсан би хуулиас чөлөөлөгдөж, харь үндэстэн та нар урьд ямар байсны адил болсон)” гэж хэлж байна.

Та нар надад ямар ч муу юм хийгээгүй. Паул яг юу бодож үүнийг хэлсэн нь тийм ч тодорхой биш байна. Магадгүй галатчууд өөрт нь хэрхэн хандсанд гомдож, шархлаагүй гэсэн утгаар хэлсэн байж болох юм. Тэд түүнээс нүүр буруулан хуурамч багш нар руу эргэсэн нь Паулын эсрэг дайсагнаж буй хэрэг биш үнэндээ Бурханы үнэнээс эргэж, өөрсдийгөө хохироосон хэрэг гэж тэр үзсэн бололтой.

4:13 Паул анх **махбодынхоо мөхөсдөлөөр** тэдэнд **сайнмэдээг тунхаглажээ.**¹⁵ Бурхан хүнд биш Өөртөө алдрыг авахын тулд сул дорой, басамжлагдаж, гадуурхагдсан ядмаг хүмүүсээр дамжуулж ажлаа гүйцэлдүүлэх нь элбэг.

4:14 Паулын өвчин өөрт нь болон үгийг нь сонссон хүмүүст **сорилт** болдог байв. Гэсэн хэдий ч галатчууд гадаад төрх байдал хийгээд үг ярианаас нь болж Паулаас нүүр буруулаагүй ажээ. **Харин ч** тэд түүнийг **Бурханы тэнгэрэлч адил**, тэр ч байтугай **Христ Есүс** Өөрөө ирсэн мэт **хүлээн авчээ.** Паул Эзэнийг төлөөлж байсан тул тэд түүнийг Эзэнийг хүлээн авахтай адил хүлээн авсан байна (Мт 10:40). Тэд Паулын мэдээг Бурханы үг хэмээн хүлээн зөвшөөрсөн. Энэ үйл явдал бүхий л христитгэгчид Эзэний

элч нарт ийнхүү хандах сургамж болох учиртай. Бид тэднийг найрсгаар хүлээн авбал Эзэнийг ч мөн тийн хүлээн авсанд тооцогдоно (Лук 10:16).

4:15 Галатчууд сайнмэдээг анх сонсоод зүрх сэтгэл нь ивээл ерөөлөөр бялхсаныг ухаарч хүлээн зөвшөөрсөн. Тэд ийнхүү баярлаж талархаж байсан тул боломжтой бол Паулд **нүдээ ухаад өгөхөд** ч бэлэн байжээ. (Эндээс дүгнэж үзвэл Паулын “махбод дахь өргөс” нь нүдний өвчин байсан байж болох юм) Гэтэл тэр их баяр талархал одоо хаачив? Харамсалтай нь өглөөний шүүдэр мэт ууршин оджээ.

4:16 Паулын талаарх тэдний хандлага юунаас болж ингэтлээ өөрчлөгдөв? Тэрээр урьдын адил нөгөө л мэдээгээ тунхаглаж, сайнмэдээний **үнэний** төлөө хичээнгүйлэн зүтгэсээр байсан шүү дээ. Хэрэв энэ нь түүнийг тэдний дайсан болгосон юм бол тэдний байр суурь үнэхээр аюултай байдалд оржээ.

Д. Боолчлол эсвэл эрх чөлөө (4:17-5:1)

4:17 Хуурач багш нарын сэдэл Паулынхаас өөр байлаа. Тэд өөрсдөдөө дагалдагчдыг хүссэн бол, Паул галатчуудын сүнсний сайн сайханд анхаарч байв (4:17-20). Хуурамч багш нар галатчуудын итгэл сэтгэлийг олж авахын төлөө хичээл зүтгэлтэй байвч сэдэл нь чин сэтгэлийнх биш байсан юм. **Тэд та нарыг биднээс холдуулахыг хүсдэг аж.** Иудейжүүлэх үзэлтнүүд галатчуудыг элч Паул ба бусад багш нараас тусгаарлахыг хүссэн байна. Тэд өөрсдөдөө дагалдагчдыг бий болгож, өөрсдийн гэсэн бүлэглэл үүсгэхийг санаархжээ. Стотт энэ талаар “Христитгэлийг хууль дүрмээр хүлж боолчилбол хохирогчид нь дундад зууны үеийнх шиг багш нарынхаа хормойноос дүүжлэгдсэн зарц барлаг болдог жамтай”¹⁶ хэмээн сэрэмжлүүлжээ.

4:18 Паулын хэлэх гэсэн санаа нь үндсэндээ “Би та нараас алс хол байхад хэн нэг нь та нарт санаа тавивал би дургүйцэхгүй. Гагцхүү тэдний сэдэл цэвэр ариун, зорилго нь зөв **сайн** байх ёстой” гэжээ.

4:19 Паул галатчуудыг “**хүүхдүүд минь**” гэж дуудсанаар Христ рүү авчирсан хүн нь өөрөө гэдгийг сануулж байна. Тэр тэдний төлөө **дахин төрөх зовлонг эдэлж** байна. Гэхдээ энэ удаа тэднийг авралд хүргэх гэсэндээ биш, харин **Христ** тэдний **дотор дүрээ** олоосой хэмээн шаналжээ. Өөрийн ард түмнийг Христтэй адил болгох нь Бурханы туйлын зорилго билээ (Еф 4:13; Кол 1:28).

4:20 Паул галатчуудын байр сууринд **эргэлзсэн** бололтой. Галатчууд үнэнээс урваж шарваж байгаа нь Паулыг эргэлзэхэд хүргэжээ. Тэрбээр **хоолойн өнгөө өөрчилж**, тэдэнд хандан баттай ярьж чадахаар байлаа. Эсхүл галатчууд захидалд нь хэрхэн хандаж байгааг ойлгож ядан эргэлзсэн байж магад. Тиймээс тэдэнтэй нүүр тулан уулзаж ярихыг илүүд үзсэн биз ээ. Тэгвэл тэдний хэрхэн хандахаас шалтгаалж **хоолойн өнгөө өөрчилж**, санаагаа илүү оновчтой илэрхийлж чадах байсан биз ээ. Хэрэв тэд зэмлэлийг нь хүлээж авбал зөөлөн ярина. Харин их зан гаргаж, тэрслүү загнавал хатуу хандана. Ямартай ч Паул галатчуудын байдалд эргэлзэж тээнэгэлзжээ. Захидлыг нь тэд хүлээн аваад хэрхэн хандахыг хэлж мэдэхгүй байлаа.

Иудей багш нар Абрахамын талаар тасралтгүй ярьж, итгэгчид түүний жишээг даган хозлуулах ёстой хэмээн ятгаж байсан тул Паул Абрахамын гэр бүлийн амьдралыг сөхөж, хууль бол боолчлол учраас нигүүлсэлтэй хольж болохгүй гэдгийг харуулахыг зорив.

Абрахам, Сара хоёр байгалийн жамаараа хүүхэдтэй болоход хэтэрхий оройтсон байсан ч Бурхан Абрахамыг хүүтэй болно хэмээн амлажээ. Абрахам Бурханд итгэснээр

зөвтгөгдсөн (Эх 15:1-6). Үүний дараа Сара амласан хүүгээ хүлээж тэсэлгүй урам хугарч, Абрахамд өөрийн зарц Хагарыг өгч, түүнээс хүүхэдтэй болохыг зөвлөв. Абрахам зөвлөгөөг нь дагаж, улмаар Ишмаел төржээ. Энэ хүү Бурханы амласан өв залгамжлагч байгаагүй. Харин Абрахамын тэвчээргүй зан, махбодын хүсэл, итгэлгүй байдлаас гарсан хүү байв (Эх 16-р бүлэг).

Дараа нь Абрахамыг зуун настай байхад амлалтын хүүхэд болох Исаак төрлөө. Мэдээж тэрээр гайхамшгаар төрсөн. Гагцхүү Бурханы гайхамшигт хүч чадлаар л энэ бүхэн боломжтой болжээ (Эх 21:1-5). Исаакийг хөхнөөс гаргах найран дээр хүүг нь Ишмаел шоглож байгааг Сара харав. Тиймээс тэр даруй Ишмаелыг ээжтэй нь хамт гэрээсээ хөөхийг Абрахамд тушааж, “Зарц бүсгүйн хүү миний хүү Исаактай хамт өв залгамжлахгүй” гэжээ (Эх 21:8-11). Энэ бол элч Паулын дэвшүүлж буй тайлбарын түүхэн үндэслэл билээ.

4:21 Энэ эшлэлд **хуулийг** хоёр өөр утгаар хэрэглэсэн байна. Эхнийх нь ариун байдалд хүрэх арга хэрэгслийг илэрхийлсэн бол удаах нь Хуучин гэрээний хуулийн номууд (Эхлэл-Дэд хууль), тэр дундаа Эхлэл номыг илэрхийлж байна. Паул, “Хууль сахих замаар Бурханы тааллыг олохыг **хүсэгч хүмүүс ээ, та нар надад хэлээч. Та нар хуулийн** ном юу хэлж байгааг **сонсохгүй байна гэж үү?**” хэмээжээ.

4:22, 23 Хоёр хүү нь Ишмаел, Исаак хоёр байлаа. **Шивэгчин** нь Хагар, **чөлөөт эмэгтэй** нь Сара байв. Абрахамын сэдэж үйлдсэн оролцооны үр дүнд Ишмаел төржээ. Эсрэгээрээ, Исаак бол Бурханы амлалтаар Абрахамд өгөгдсөн хүү байлаа.

4:24 Энэ түүх бэлгэдлийн шинж чанартай, анхлан харагдаж байгаагаасаа ч илүү гүн гүнзгий утгатай. Үйл явдлын жинхэнэ утга учир шууд хэлэгдээгүй ч дам илэрхийлэгдсэн байна. Тэгэхээр Исаак, Ишмаел хоёрын

бодит түүх цаагуураа гүн гүнзгий сүнслэг үнэнийг харуулдаг болохыг Паул одоо тайлбарлах гэж байна.

Хоёр эмэгтэй нь **хоёр гэрээг** төлөөлдөг. **Хагар** хуулийн гэрээг, Сара нигүүлслийн гэрээг төлөөлнө. Хуулийг **Синаи ууланд** өгсөн. “Хагар” гэдэг нь араб хэлээр “Хад” гэсэн утгатай бөгөөд арабууд Синаи уулыг “Хад” гэж нэрлэдэг нь гайхалтай.

4:25 Синаид байгуулсан гэрээ нь боолчлолыг бий болгосон. Иймээс шивэгчин **Хагар** хуулийн бэлгэдэлд тохирч байна. **Хагар** нь хууль сахих замаар зөвт байдалд хүрэх гэж оролдох хараахан аврагдаагүй израильчууд буюу еврей үндэстний нийслэл **Иерусалимыг** төлөөлдөг. Эдгээр нь **хүүхдүүдтэйгээ**, дагалдагч нартайгаа хамт **боолчлолд** байна. Паул үл итгэгч израильчуудыг Саратай биш Хагартай, Исаактай биш Ишмаелтай холбосон нь яах аргагүй гашуун үнэн билээ.

4:26 Итгэлээр зөвтгөгдсөн хүмүүсийн нийслэл хот бол тэнгэрлэг **Иерусалим**. Энэ нь иудей ба харь үндэстнийг хамруулсан итгэгч бүгдийн **эх мөн**.

4:27 Ингэж Исаиа 54:1 эшлэлээс иш татсан нь тэнгэрлэг хотын хүүхдүүд дэлхийн Иерусалимын хүүхдүүдээс ч илүү олон байх болно гэсэн зөгнөл юм. Сара бол удаан хугацаанд **хүүсэр** байсан эмэгтэй. Харин Хагар бол **нөхөртэй эмэгтэй**. Тэгвэл Сара буюу тэнгэрлэг Иерусалим эцсийн эцэст ялна гэдгийг бид хэрхэн ойлгох ёстой вэ? Үүний хариулт нь Иудей болон харь үндэстнүүдээс бүрдсэн, Бурхан руу итгэлээр ирдэг хүмүүс буюу амлалтын **хүүхдүүд** нь хуулийг түшдэг Хагарын хүүхдүүдээс **илүү олон болно** гэсэн нь болой.

4:28 Жинхэнэ итгэгчид хүний хүслээр бус, махан биеийн хүслээр ч бус, харин Бурханаас төрдөг. Үүнд мах цусны тасархай байх нь хамаагүй. Харин Эзэн Есүст итгэх итгэлээр бий болох гайхамшигт төрөлт л хамаатай.

4:29 Ишмаел Исаакийг шоглосон. Үүн шиг махан биеэс төрсөн нь **Сүнсээр төрснийгөө хавчдаг** нь бичигдээгүй хууль гэлтэй. Аврагдаагүй хүмүүсийн гарт бидний Эзэн Есүс болон элч Паул хэрхэн зовсныг бодож үзээрэй. Ишмаел Исаакийг шоглосон нь бидэнд ялихгүй зүйл мэт санагдаж болох ч Бичвэр үүнийг тэмдэглэн үлдээж, Паул үүнээс одоо ч хэвээр байгаа **махбод** ба **Сүнсний** хоорондох дайсгалын зарчмыг олж харжээ.

4:30 Тэгэхээр галатчууд Бичвэр рүү анхаарлаа хандуулаг. Тэгвэл тэд ийнхүү дүгнэснийг олж сонсоно. Хууль ба нигүүлсэл хэзээ ч холилдох боломжгүй. Хүний гавьяа зүтгэл, махан биеийн хүчин чармайлтаар Бурханы ерөөлийг өвлөх боломж байхгүй.

4:31 Христэд найдвараа тавьсан хүмүүс Бурханы тааллыг олохын тулд хууль руу очдоггүй. Тэд чөлөөт эмэгтэйн хүүхдүүд учраас эхийнхээ адил амьдарна.

5:1 Дөрөвдүгээр бүлгийн сүүлчийн эшлэл итгэгч хүний байр суурийг эрх чөлөөтэй хэмээн тодорхойлжээ: Харин тавдугаар бүлгийн эхний эшлэлд тэрээр эрх чөлөөтэй хүний хувиар амьдрах ёстойг өгүүлжээ. Энд Хууль ба нигүүлслийн ялгааг харуулсан маш сайн жишээг харуулжээ. Хууль, “Чи эрх чөлөөгөө олж авч чадвал эрх чөлөөтэй болно” гэж хэлдэг. Харин нигүүлсэл, “Христ амиа өгч асар их золиос гаргасны үр шимээр чи чөлөөлөгдсөн. Тиймээс Түүнд талархсан талархлынхаа улмаас одоо чи **Христийн** өгсөн эрх чөлөөнд **бат зогс**” гэж хэлдэг Хууль тушаадаг боловч үйлдэх хүчийг өгдөггүй. Гэтэл нигүүлсэл хуулийн шаардсаныг биелүүлээд Ариун Сүнсний хүчээр байр суурин дээрээ зохистой амьдрах хүчийг хүмүүнд өгч, тийн үйлдсэнийх нь төлөө шагнадаг.

“Хууль хүчгүй хүнээс хүч чадлыг шаарддаг. Улмаар шаардсаныг нь өгөхгүй бол хараадаг. Сайнмэдээ эсрэгээрээ хүчгүй хүнд хүч чадлыг өгөөд түүгээрээ амьдарсны төлөө ерөөдөг” гэж Ч. Х. Макинтош хэлжээ.¹⁷

Хөлгүй надад хөл, гаргүй надад гар хайрлахгүй атлаа
“Түйгээрэй Жон, амиа авар” гэж хууль надаас шаардах
юм

Харин сайнмэдээ надад хавьгүй агуу мэдээг авчирлаа
Даль жигүүр ургуулж, тэнгэр өөд намайг нисгэх юм

III. БОДИТ ЗААВРУУД: ПАУЛ СҮНС ДОТОРХ ХРИСТИТГЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ӨМГӨӨЛСӨН НЬ (5:2-6:18)

A. Легализмийн аюул (5:2-15)

5:2 Легализм Христийг ямар ч үнэ цэнгүй болгодог. Иудейжүүлэх үзэлтнүүд харь үндэстнүүд аврагдахын тулд **хозлуулах** шаардлагатай гэж тулгажээ. Тэгвэл Паул, хозлуулах аваас Христийг ямар ч хэрэгцээгүй болгоно шүү хэмээн элчийн эрх мэдлээр хэлж байна.

Жак Хантер энэ талаар ийнхүү өгүүлжээ:

Галатчуудын нөхцөл байдлыг авч үзвэл Паулын хувьд хозлол нь зүгээр нэг мэс ажилбар, эсвэл жирийн нэг шашны зан үйл биш байв. Харин сайн үйлсээр аврагдах тухай бүхэл бүтэн сургаал байлаа. Энэ нь Бурханы нигүүлслээс ангид, хүний хүчин чармайлтыг тунхагласан мэдээ ажээ. Энэ нь нигүүлслийг хуулиар, Христийг Мосегоор орлуулсан явдал байв. Учир нь Христ дээр нэмэх нь Христээс авахтай адил хэрэг юм. Христийг нөхөх нь Христийг зайлуулснаас ялгаагүй. Христ бол цорын ганц Аврагч мөн. Түүнээс өөр Аврагч гэж үгүй. Хозлолыг сонговол Христээс нүүр буруулсан хэрэг болно.¹⁸

5:3 Легализм **бүх хуулийг** дагахыг хүнээс шаарддаг. Амархан хуулиудыг нь дагаад бусдыг нь орхих боломжгүй. Хүн хозлолоор Бурханд таалагдахыг хүсвэл **бүх хуулийг биелүүлэх** үүрэгтэй болно. Тэгэхээр хүн нэг бол бүхэлдээ хуулийн дор байна, эс бол бүхэлдээ хуулиас ангид байна. Хэрэв бүхэлдээ хуулийн дор байвал түүнд Христ ямар ч хэрэггүй. Эзэн Есүс *бүрэн хангалттай* төдийгүй *цорын ганц* Аврагч мөн. Паул энд өмнө нь нэгэнт хозлуулчихсан хүний тухай яриагүй. Харин Бурханы өмнө тааллыг олохын тулд хуулийг сахиж, бүрэн зөвтгөлд хүрэхээр хозлуулах гэж буй хүмүүсийн тухай ярьсан.

5:4 Легализм нь Христийг зөвт байдалд хүрэх цорын ганц найдвар биш гэж үзэхтэй адил билээ. Энэ эшлэл нэлээдгүй маргаан үүсгэдэг тул олон янзаар тайлбарладаг. Гэхдээ тэр олон тайлбарыг гурав ангилж болох юм. Үүнд:

1. Хүн үнэхээр аврагдсан ч дараа нь нүгэлд унаж, улмаар нигүүлслээс салж, авралаа алдаж болох тухай Паул ярьсан гэж олон хүн үздэг. Үүнийг “авралаа алдах тухай онол сургаал” гэж нэрлэдэг. Бидний хувьд хоёр үндсэн шалтгааны улмаас энэ тайлбарыг үндэслэлгүй гэж үзэж байна. Нэгдүгээрт, энэ эшлэлд аврагдсан боловч нүгэлд унасан хүнийг хэлээгүй. Үнэндээ нүгэлд унах тухай ч дурдаагүй байна. Харин ч ёс суртахуунтай, нэр хүндтэй, зөвт амьдралаар амьдардаг, түүгээрээ аврагдана гэж найдаж буй хүний тухай өгүүлж байна. Тиймээс авралаа алдах тухай онол сургаалыг энэ эшлэлээр батлах гэж оролддог хүмүүст энэ нь эргээд асуудал болдог. Христитгэгч хүн аврагдахын тулд хуулийг сахиж, төгс төгөлдөр амьдарч, нүгэл үйлдэхээс зайлсхийх ёстой гэж тэд заадаг. Гэтэл Бичвэрийн энэ эшлэл хуулийн үйлс эсвэл өөрийн хүчин чармайлтаар зөвтгөгдөхийг эрмэлздэг бүх хүн **нигүүлслээс салан унажээ** хэмээжээ.

Хоёрдугаарт, Эзэн Есүс Христ чин сэтгэлээсээ итгэсэн хүн бүр мөнхөд аврагдсан, Христийн ямар ч хонь мөхөхгүй,

аврал нь хүний ядмагхан хичээл зүтгэл дээр бус Аврагчийн төгс үйл хэрэгт тулгуурладаг хэмээх Шинэ гэрээний сургаалтай энэ онол сургаал зөрчилдөж байна (Иох 3:16, 36; 5:24; 6:47; 10:28).

2. Энэ эшлэлийн хоёр дахь тайлбар нь анхнаасаа Эзэн Есүст итгэж аврагдсан боловч дараа нь авралаа хадгалан үлдэж, ариун байдалд хүрэхийн тулд өөрсдийгөө хуулийн доор тавьсан хүмүүсийн талаар өгүүлсэн гэж зарим нь үздэг. Өөрөөр хэлбэл, тэд нигүүлслээр аврагдсан боловч хуулиар авралаа хамгаалахыг эрмэлзэж байгаа аж. Энэ тохиолдолд нигүүлслээс салан унах гэдэг нь Филип Маурогийн тодорхойлсончлон, “Ариун Сүнсний хүчээр ариун хүмүүсээ төгс болгох Бурханы замаас эргэж, тэрхүү зорилгыг гаднах зан үйл, ёслолуудыг сахих замаар биелүүлэхээр тэмүүлэх явдал” гэжээ. Цаашилбал “Чухамдаа махбодын дагуу амьдардаг хүмүүс ч Бурханы ариун хүмүүстэй адил тэдгээрийг гүйцэлдүүлж чаддаг” гэсэн байна.

Энэ онол сургаал Библийн сургаалд үл нийцнэ. Учир нь юу юунаас илүүтэй энэ эшлэл ариун байдал ба ариусгалыг эрэлхийлэгч христитгэгчдийг биш, харин хууль сахих замаар *зөвтгөгдөх* гэсэн аврагдаагүй хүнийг илэрхийлсэн байна. Энд **хуулиар зөвтгөгдөхийг оролдож буй та нар...** гэж хэлсэн үгийг нь анзаараарай. Хоёрдугаарт, энэ эшлэлийг ийнхүү тайлбарлах нь аврагдсан хүмүүс хожим нь Христээс таслагдах боломжтой гэсэн санааг илэрхийлж байна. Харин энэ нь Бурханы нигүүлслийг зөвөөр харуулдаггүй.

3. Гурав дахь тайлбар нь өөрийгөө христитгэгч гэж хэлдэг боловч үнэн чанартаа аврагдаагүй хүмүүсийн тухай Паул ярьсан гэж үздэг. Тэд хуулиар зөвтгөгдөхийг эрмэлздэг ажээ. Элч Паул тэдэнд хоёр аврагчтай байх боломжгүй гэдгийг хэлж байна. Тэд нэг бол Христийг эсвэл хуулийг сонгох ёстой. Хэрэв хуулийг сонговол зөвт

байдалд хүргэх цорын ганц найдвар Христээс тусгаарлагдаж, **нигүүлслээс салан унана** гэсэн үг. Хогг, Ваин нар үүнийг тодорхой илэрхийлсэн байдаг:

Хүн бүрийн хувьд Христ нэг бол бүх зүйл эс бол хэн ч биш байх учиртай. Тэрээр хязгаарлагдмал итгэлийг ч, хуваагдмал зүрх сэтгэлийг ч хүлээж авахгүй. Эзэн Есүс Христийн нигүүлслээр зөвтгөгдсөн хүн л жинхэнэ христитгэгч мөн. Харин хуулийн үйлсээр зөвтгөгдөхийг эрмэлздэг хүн христитгэгч хүн яавч биш.

5:5 Жинхэнэ итгэгчийн найдвар нь легализмийг баримталдаг хүнийхээс огт өөр болохыг элч Паул харуулжээ. Христитгэгч хүн **зөвт байдлын найдварыг хүлээдэг**. Тэрээр Эзэн эргэн ирж, бидэнд алдрын биеийг өгч, дахин хэзээ ч нүгэл үйлдэхгүй болох цагийг найдан хүлээдэг. Энд христитгэгч хүн зөвт байдлыг хүлээдэг гэж хэлээгүйг анзаараарай. Учир нь Эзэн Есүс Христээр дамжуулан тэрээр Бурханы өмнө аль хэдийн зөвт хэмээн тооцогдсон (2Ко 5:21). Харин түүний хүлээдэг зүйл бол өөрийнх нь дотор зөвт байдал бүрэн хүчин төгөлдөр болох тэр цаг юм. Тэр үүнд хүрэх гэж ямар нэгэн хичээл зүтгэл гаргадаггүй. Харин **Сүнсээр дамжуулан итгэлээр** найдан харуулддаг ажээ. Ариун Сүнс энэ бүхнийг гүйцэлдүүлэх тул итгэгч хүн үүнийг биелүүлж өгнө гэж Бурханд найддаг. Тэгтэл легализмийг дагагч хүн эсрэгээрээ өөрийн үйлс, шашны зан үйл, хуулийг сахих замаар зөвт байдлыг олж авна гэж найддаг. Энэ бол хоосон найдвар. Учир нь ийм замаар зөвт байдалд хүрэх боломжгүй. Паул энэ эшлэлд жинхэнэ христитгэгчдийг **“бид”** гэсэн төлөөний үг ашиглан илэрхийлсэн бол 4-р эшлэлд хуулийн үйлсээр зөвтгөгдөхийг хүсэгчдийг **“та нар”** гэсэн төлөөний үг ашиглан илэрхийлснийг анзаарна уу.

5:6 Легализм нь ямар ч ашиггүй. **Христ Есүс** дотор буй хүн (буюу христитгэгч хүн) **хозлуулсан** ч илүү дээр болохгүй, **эс хозлуулсан** ч дор болохгүй. Бурхан итгэгчийн дотроос гагцхүү **хайраар дамжин ажиллаж буй итгэлийг** л хайдаг. **Итгэл** бол Бурханд бүрэн түшиглэх тухай юм. **Итгэл** дэмий хоосон зүйл биш, харин Бурханд болоод хүнд хоёргүй сэтгэлээр үйлчилдэг. Тэрхүү үйлчлэлийн цаад сэдэл нь хайр тул **итгэл нь хайраар дамжин ажилладаг**. Тэгэхээр **итгэл** нь хуулиар бус, **хайраар** өдөөгддөг. Энэ үнэнийг Бичвэр олонтоо өгүүлж, Бурхан аливаа зан үйл, ёс заншлыг бус, бодитоор бурханлаг амьдарч байгааг л сонирхдог гэжээ.

5:7 Легализм бол **үнэнд** дуулгаваргүй байгаа явдал мөн. Галатчууд анх христэч амьдралаар амжилттай амьдарч эхэлсэн боловч өөр хүмүүс **саад болжээ**. Тийнхүү саад бологсод нь иудейжүүлэх үзэлтнүүд, хуулийг баримтлагчид, хуурамч элч нар байв. Ариун хүмүүс тэдний гаж буруу сургаалыг хүлээн авснаараа Бурханы **үнэнд** дуулгаваргүй болов.

5:8 Легализм нь Бурханы сургаал огтхон ч биш. Энд яригдаж буй **үзэл бодол** нь итгэл үнэмшил, онол сургаалыг хэлж байна. **Та нарыг дуудсан** Нэгэн гэдэг нь Бурханыг илэрхийлж байна. Тиймээс хозлол ба хууль сахихыг христитгэл дээр нэмнэ гэдэг итгэл үнэмшил Бурханаас бус диаволоос гаралтай ажээ.

5:9 Легализм нь аажмаар улам л бузар муу руу хөтөлнө. Библи дээр **хөрөнгө** ямагт бузар мууг бэлгэддэг. Харин энэ эшлэлд иудейжүүлэх үзэлтнүүдийн бузар муу сургаалыг хөрөнгөөр илэрхийлжээ. **Хөрөнгө** буюу исгэгч нь **зуурсан гурилыг бүхэлд нь исгэх** хандлагатай байдаг тухай үнэн нь **өчүүхэн** буруу сургаал асар том бузар мууг бий болгох аюултайг илэрхийлж байна. Бузар муу зүйл хэзээ ч зүгээр байдаггүй. Энэ нь худал хуурмагт үндэслэж, цаашлах тусам улам олон худал хуурмагийг бий болгодог. Легализм

бол саримстай адилхан. Саримсанд жижиг томын ялгаа байдаггүй. Чуулганд хуурамч сургаал баримталдаг цөөн хүн байлаа ч тэдэнд хатуу арга хэмжээ авч, зохих ёсоор таслан зогсоохгүй л бол дагагчдын тоо нь улам олширсоор байх болно.

5:10 Легализм нь тэрхүү сургаалыг заадаг багш нар дээр Бурханы шийтгэлийг авчирдаг. Галатчууд хуурамч багш нарыг орхино гэдэгт Паул итгэлтэй байлаа. Түүний энэ итгэл **Эзэн дотор** байв. Учир нь Эзэн түүнд энэхүү баталгааг өгсөн байж болох юм. Аль эсвэл Агуу Хоньчин төөрөн одсон хонин сүргээ бичиж буй захидлаар нь дамжуулан эргүүлэн сэргээнэ гэдэгт бат итгэлтэй байсан байж ч болох юм.

Хуурамч багш нарын хувьд тэд Бурханаар шийтгэгдэх нь гарцаагүй билээ. Буруу сургаалыг номлож Бурханы чуулганыг нураах нь ноцтой зүйл мөн (1Ко 3:17). Жишээлбэл, архи ууж болно гэж заах нь өөрөө архичин байхаас ч илүү хөнөөлтэй. Учир нь хуурамч багш нар бусдыг өөр шигээ болгож байдаг.

5:11 Легализм **загалмайн бүдрүүлэх саадыг** арилгадаг. Хозлуулах шаардлагатай хэмээн Паул ч гэсэн тунхагладаг гэх худал үгэнд Паул хариу мэдэгдэл өгч байна. Паул иудейчүүдэд **мөшгөгдөн хавчигдсаар** байжээ. Хэрэв тэр **хозлолыг** тунхаглавал энэхүү хавчлага зогсох байлаа. Учир нь ингэвэл тэрээр **загалмайг** тунхаглахаа больсон гэсэн үг юм. Загалмай нь хүмүүнд **бүдрүүлэх саад** авчирдаг. Хүн авралыг олж авахын тулд юу ч хийж чадахгүй гэж тунхагладаг учраас загалмай нь хүнийг бүдрүүлдэг. Загалмай нь махбод хийгээд махбодын хүч чадалд ямар ч орон зай үлдээдэггүй тул хүний үйлсэд цэг тавьдаг. Паул хозлолоор дамжуулан үйлсийг тунхагласан бол загалмайн бүх утга учрыг таягдан хаясантай адил болох байв.

5:12 Галатчуудад асуудал тариад байгаа нөхөд **өөрсдийгөө агтлаасай** [тасдаж хаяасай] гэсэн Паулын үгийг шууд утгаар ойлгож болно. Паул тэднийг өөрсдийгөө хөнгөлж засаасай гэж хүсжээ. Тэд хутгаар бусдыг хозлох гэж улайран зүтгэж байсан бол тэр хутга одоо тэднийг өөрсдийг нь тайган болгоосой гэж хүсэж буйгаа Паул илэрхийлжээ. Паулын энэ үгийг мөн дүрслэлийн утгаар ойлгож болно. Өөрөөр хэлбэл, тэрхүү хуурамч багш нар галатчуудаас бүр мөсөн холдоосой гэж Паул хүссэн гэсэн үг.

Нигүүлслийн сайнмэдээг хүмүүс цаг ямагт хүссэнээрээ амьдрахыг зөвшөөрдөг хэмээн буруутгаж ирсэн. “Зөвхөн итгэлээр л аврагдах юм бол итгэснийх нь дараа хүний ёс суртахууныг хянах аргагүй болно” гэгцгээдэг ажээ. Тэгвэл элч Паул, христитгэгчийн эрх чөлөө нүгэл үйлдэх зөвшөөрөл биш гэдгийг энд маш тодорхой хэлж байна. Итгэгч хүний хэмжүүрийн жишиг нь Эзэн Есүсийн амь бөгөөд Христийг хайрлах хайр нь түүнд нүглийг жигшиж, ариун байдлыг хайрлах хүслийг өгдөг.

Магадгүй Паул уншигчдаа дураараа авирлахаас онцгойлон сэрэмжлүүлэх шаардлагатай байсан биз ээ. Хүн хуулийн доор хэсэг хугацаанд байгаад эрх чөлөөтэй болбол нөгөө тал руу туйлширч зах замбараагүй явдлын боол болох аюул бий. Харин зохих ёсны тэнцвэр нь хууль ба сул задгай явдлын дунд орших эрх чөлөө билээ. Христитгэгч хүн хуулиас чөлөөлөгдсөн ч хуульгүй бол биш юм.

5:13 Христэч эрх чөлөө нүгэл үйлдэхийг зөвшөөрдөггүй. Харин **хайраар** үйлчлэхийг урамшуулдаг. Христитгэгч хүн хайраар өдөөгдөж биеэ авч явдаг бол хууль хүнийг шийтгэгдэх айдсаар хөдөлгөдөг. “Хайрын боолууд бол жинхэнэ чөлөөт хүн мөн.” (Финдли)

Христитгэгч хүний эрх чөлөө *Христ Есүс* дотор байдаг (2:4). Тиймээс итгэгч хүн үүнийг нүгэл үйлдэх эрх чөлөө

гэж огтхон ч боддоггүй. Бид эрх чөлөөгөө **махбодыг** өөхшүүлэх завшаан болгож хэрхэвч болохгүй. Довтлогч арми ашигтай байрлалыг эзэлж аваад цаашид илүү том газрыг эзлэхэд түүнийгээ ашигладаг. Бид ч мөн энэ зарчмаар явж, махбодод газар нутгаа тэлэх боломжийг олгохгүй.

Бидний эрх чөлөөг зохих ёсоор тодорхойлбол, “Бие биеийнхээ боол болох дадал хэвшлийг бий болгох” гэжээ.

Тэгвэл А. Т. Пиерсон энэ талаар ингэж хэлжээ:

Жинхэнэ эрх чөлөө тодорхой хязгаарлалтад дуулгавартай захирагдахад оршдог. Гол мөрөн эргээ даган урсаж байж л эрх чөлөөгөө олдог. Эрэг үгүй аваас тэр их ус талаар нэг тарж, шавар шалбааг л болно. Гариг эрхэс тойрог замаасаа гарвал өөрсдийгөө сүйтгээд зогсохгүй сансар огторгуй сөнөж мөхөхөд хүрнэ. Биднийг хязгаарлаж буй тэрхүү хууль бусдыг ч мөн хязгаарладаг. Бидний эрх чөлөөг хязгаарладаг яг тэр зүйл эрх чөлөөг минь баталгаатай болгож хамгаалдаг. Хяналт шахалт бус, харин зөв хяналт хийгээд үүнд дуртайяа захирагдах дуулгавартай байдал л хүнийг жинхэнэ утгаар нь эрх чөлөөтэй болгодог.²⁰

5:14 Эхлээд энэ захидлын турш Паул итгэгчид хуулийн доор байдаггүй гэж ярьсан атлаа энд хуулийг дурдсан нь хачирхалтай санагдана. Гэхдээ Паул уншигчдыгаа хууль руу буцаж очихыг ятгаагүй байна. Харин хуулийн шаардаад байгаа зүйл христитгэлийн эрх чөлөөний үр дүнд биелэлээ олдог гэдгийг хэлж байна.

5:15 Легализм нь эцсийн эцэст хэрүүл маргааныг л авчирдаг. Галатад ч яг ийм явдал тохиожээ. Хачирхалтай байгаа биз! Хүмүүс хуулийн доор орохыг хүсжээ. Гэтэл хууль тэднээс хөршөө хайрлахыг шаарддаг. Гэтэл бодит

байдал дээр юмс яг эсрэгээрээ өрнөжээ. Тэд бие биеэ араар нь муулж, өөр хоорондоо барьж идэлцэв. Ийм авир махан биеэс гардаг тул хууль махбодод боломж олгож, үүн дээр тулгуурлан ажилладаг.

Б. Ариун амьдрах хүч (5:16-25)

5:16 Итгэгчид махбодоор бус, **Сүнсээр явах ёстой. Сүнсээр явна** гэдэг нь Өөрийнхөөрөө үйлдэх боломжийг Ариун Сүнсэнд зөвшөөрч, Түүнтэй ойр дотно нөхөрлөж, Түүний ариун байдалд тулгуурлан шийдвэр гаргаж, Христээр бодол санаагаа дүүргэнэ гэсэн үг. Ингэснээр Ариун Сүнс итгэгч хүнийг Эзэн Есүстэй холбох үйлчлэлийг гүйцэлдүүлдэг юм. Ингэж бид **Сүнсээр явбаас, махбод** буюу аминчхан үзэл маань үхмэл болно. Бид Христээр дүүрсэн бол нүгэлд автаж чаддаггүй.

Скофилд энэ талаар ингэж хэлжээ:

Христитгэгч хүн энэ дэлхийд амьдарч байгаа учраас хоёр мөн чанарын дунд оршдог нь түүнд хүндрэл учруулдаг. Хоёр мөн чанарыг хоёр модтой зүйрлэж болох юм. Нэг нь махбодын хуучин мод. Нөгөө нь дахин төрөх үед суулгагдсан тэнгэрлэг мөн чанартай шинэ мод. Гол хүндрэл нь хэрхэн хуучин модыг үр жимсгүй байлгаж, шинэ модыг үр жимстэй байлгах вэ гэдэг асуудал юм. Бид Сүнсээр алхвал энэ асуудал шийдэгдэнэ.²¹

Энэ эшлэл болон дараагийн эшлэлүүд дээр христитгэгчийн дотор **махбод** одоо ч оршсоор байгааг өгүүлдэг. Тэгэхээр бидний нүгэлт мөн чанар үгүй болсон гэх үзэл үүгээр няцаагдаж байна.

5:17 **Сүнс** болон **махбод** нь хоорондоо байнга зөрчилддөг. Бурхан биднийг Христэд итгэсэн даруйд махбодын мөн чанараас маань ангижруулж чадах л байсан. Гэвч Тэр тэгэхийг сонгосонгүй. Яагаад? Учир нь Тэр бидний сул дорой мөн чанарыг байнга сануулж, Тахилч ба Өмгөөлөгч маань болох Христээс хамааралтай байж, өт хорхой мэт биднийг аварсан Нэгэнийг цаг ямагт магтуулахыг хүсжээ. Бурхан хуучин мөн чанарыг маань зайлуулахын оронд Ариун Сүнсээ бидний дотор суулгажээ. Бурханы Сүнс хийгээд махбод маань байнга дайтдаг бөгөөд бид тэнгэрийн улсад очих хүртэл энэ дайн үргэлжилнэ. Харин итгэгч бидний хувьд Сүнсэнд бууж өгснөөр зөрчлийг намжаана.

5:18 Эдүгээ **Сүнсээр удирдуулдаг хүмүүс хуулийн доор эс байна.** Энэ эшлэлийг хоёр утгаар ойлгох боломжтой. **Сүнсээр удирдуулдаг** гэдэг нь бүх итгэгчийг тодорхойлно. Тиймээс христитгэгчид **хуулийн доор** байдаггүй. Тэд өөрсдийн хүчин чармайлтад найддаггүй. Тэдний доторх бузар мууг тэд өөрсдөө биш, **Сүнс** эсэргүүцдэг юм. Хоёрдугаарт, **Сүнсээр удирдуулдаг** гэдэг нь махбодыг огоорч, Эзэн Есүсээр бодол сэтгэлээ дүүргэсэн хүнийг хэлнэ. Ийм бодол сэтгэлтэй хүн хууль хийгээд махбодын талаар бодох сөхөөгүй явдаг. Бурханы Сүнс зөвтгөлийн төлөө хууль руу бус, харин Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөх цорын ганц үндэслэл болох үхлээс амилсан Христ рүү хүмүүсийн харааг чиглүүлдэг.

5:19-21 Хууль махбодын эрч хүчийг өдөөх хандлагатай байдаг тухай бид өмнө нь ярьсан. Тэгвэл нүгэлд унасан бидний махбодын мөн чанар ямар **үйлс** гаргадаг вэ? **Махбодын үйлсийг** таних тийм ч хэцүү биш, бүгдэд илэрхий байдаг. **Завхайрал** бол гэр бүлдээ итгэмжгүй, гэр бүлээс гадуурх ёс бус харилцаа юм. **Бузар тачаал** нь ёс бус бэлгийн харилцаа юм. **Цэвэр бус байдал** бол ёс суртахуунгүй, мэдрэмждээ автах явдал билээ. **Садарлал**

бол зах замбараагүй, ичгүүргүй, эрээ цээргүй байдал мөн. **Шүтээн шүтлэг** бол зөвхөн хиймэл шүтээнд мөргөх төдий зүйл биш ээ. Харин чөтгөрт мөргөхтэй холбоотой бузар муу бүхэн үүнд хамаарна. **Ид шид** бол далдын хар хүч, увдис болно. Грек эх хэл дээрх үг нь (*фармакэиа*) мансууруулах бодис гэсэн утгатай холбогддог. Мансууруулах бодисыг далдын хүчтэй холбогдоход ашигладаг болохоор энэ үг муу сүнстэй харилцаа холбоо тогтоож завхайрах, тарни шившлэг хийх гэсэн утгатай. Мөн “муу ёр” гэх мэт мухар сүсэг ч үүнд багтана. **Дайсагнал** бол хүнийг хохироох гэсэн ундарсан их хүсэл юм. **Маргаан** бол үл ойлголцол, хэрүүл тэмцэл юм. **Хардалт** бол үл итгэл, хардлага сэрдлэг билээ. **Уур хилэн** бол уур уцаар, биеэ барихгүй мунхаглан ундууцах явдал юм. **Харгалдаан** бол бусдыг золиослон байж өөрийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрүүлэх, өөрийгөө дөвийлгөх гэсэн хандлага юм. **Хагарал** бол зөрчилдөөний улмаас талцан хуваагдах явдал юм. **Тэрс үзэл** бол өөрийн зоргоор гаргасан итгэл үнэмшлээрээ бүлэглэл үүсгэх явдал юм. **Атаархал** бол бусдын амжилт, сайн сайханд сэтгэл дундуур байх явдал юм. **Архидалт** бол гашуун идээг хүртэн согтуурах явдал билээ. **Утга учиргүй наргиж цэнгэх** гэдэг нь зугаацаж цэнгэх зорилгоор архи согтууруулах ундаа хэрэглэн, дуулиан шуугиантай найрлан цэнгэх явдал билээ.

Паул уншигчдадаа өмнө нь хэлж байсанчлан **ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй** хэмээн одоо ч дахин сануулж байна. Энэ эшлэл архичин хүнийг аврагдах боломжгүй гэж хэлээгүй юм шүү. Харин махбодын үйлс гэж дээр жагсаасан зүйлсийг *байнга үйлдэж буй нь* аврагдаагүй хүний шинж хэмээн хэлж байгаа юм.²²

Паул христитгэгчдийн чуулганд яагаад заавал ийм зүйл бичих болов? Учир нь өөрийгөө христитгэгч гэсэн болгон

Бурханы жинхэнэ хүүхэд биш ажээ. Тийм ч учраас өөрийгөө христитгэгч хэмээн хэлдэг бүхэнд Ариун Сүнс энэ хатуу үнэнийг Шинэ гэрээнд олонтоо анхааруулсан байдаг.

5:22, 23 Элч Паул **Сүнсний үр жимсийг** махбодын *үйлсээс* хэрхэн ялгаж салгаж бичсэн нь нэн сонирхолтой. Үйлс бол хүний хүчээр хийгддэг зүйл, харин үр жимс модтойгоо залгаатай байгаа мөчрөөс ургадаг (Иох 15:5). Үйлс, үр жимс хоёр үйлдвэр цэцэрлэгт хүрээлэнгээс ялгаатай байдгийн адил билээ. **Үр жимс** олон тоон дээр бус, ганц тоон дээр байгааг анзаараарай. Ариун Сүнс Христтэй адил байдал гэсэн ганц л төрлийн **үр жимс** ургуулдаг. Одоо жагсаан бичих эрхэм чанарууд Бурханы хүүхдийн амьдралыг дүрсэлнэ. Ариун Сүнсний үр жимс гэгдсэн энэ сайхан чанарууд хүмүүний зүрх сэтгэлд харийн зүйл мэт байдаг хэмээн доктор С. И. Скофилд хэлжээ.

Хайр бол Бурханы мөн чанар тул бид ч тийм болохыг эрмэлзэх учиртай. Үүнийг 1Коринт 13-р бүлэгт уран яруу дүрсэлсэн бөгөөд Голготын толгод дээрх загалмай дээр бүрэн утгаараа илэрхийлэгдсэн. **Баяр баясгалан** гэдэг нь Бурхан болоод Бурханы арга замуудад туйлаас сэтгэл хангалуун байх явдал билээ. Иохан 4:34 эшлэл дээр Христ ийм баяр хөөрийг илэрхийлсэн юм. **Амар тайван** нь Бурханы амар тайван хийгээд христитгэгчдийн дундах эв найртай харилцааг ч багтаадаг. Эзэний амар амгаланг Лук 8:22-25-аас хараарай. **Тэвчээр** гэдэг нь зовлон бэрхшээл, төвөг саад, хавчлага дарамтад шантрахгүй байх тухай юм. Тэсвэр тэвчээрийн агуу үлгэр жишээг Лук 23:34-ээс хараарай. **Энэрэл** гэдэг нь бусдад сайхан сэтгэлээр хандах явдал билээ. Үүний тод жишээг хүүхдүүдэд гаргасан Эзэний хандлагаас харж болох юм (Мк 10:14). **Сайн сайхан** бол бусдад энэрэнгүй хандах явдал юм. Сайн сайхан үйлсийг харъя гэвэл Лук 10:30-35-ыг үзэх хэрэгтэй. **Итгэмжит байдал** бол Бурханд баттай итгэх, христитгэгч

ах дүүдээ итгэл үзүүлэх, бусдад итгэмжтэй хандах гэсэн утгуудыг илэрхийлнэ. Паулын хувьд хамгийн сүүлийн утгаар нь хэлсэн бололтой. **Дөлгөөн зан** гэдэг нь Эзэн Есүс шавь нарынхаа хөлийг угаахдаа Өөрийгөө дорд болгосны нэгэн адил тийм дорд байр суурийг авах тухай юм (Иох 13:1-17). **Өөрийгөө захирах** гэдэг нь өөрийгөө хазаарлан барих тухай, тэр дундаа бэлгийн харилцааны тал дээр биеэ барих тухай юм. Бид сахилга баттай байх ёстой. Хүсэл тэмүүлэл, шунал тачаал, хоолны дуршил, уур уцаар зэргийг бид захирч барих учиртай. Бид өөрийгөө хянаж, аливаад авталгүй зохистой хэмжээг баримталж сурах хэрэгтэй. Самуел Чадвик энэ талаар хэлэхдээ:

Сонины нийтлэлийн хэл найруулгаар үүнийг ингэж буулгаж болно. Ариун Сүнсний үр жимс гэдэг нь энэрэнгүй, хайр татам зан чанар, туяаран гэрэлтэх сэтгэл, талархалтай өөдрөг хандлага, тайван амгалан байдал, аядуу дөлгөөн хэв маяг билээ. Хүнд хэцүү нөхцөлд бэрх хүмүүстэй харьцахдаа шантаршгүй тэвчээртэй байх явдал юм. Өрөвч энэрэнгүй байж, бусдад туслахад бэлэн, уужуу тайван сэтгэлээр өгөөмөр нинжин хандах тухай юм. Ямар ч нөхцөлд үнэнч, найдвартай байж, бусдын төлөө өөрийгөө умартан, баяртайгаар тусалдаг даруу зан мөн. Бүх зүйл дээр өөрийгөө хянаж, захирдаг байх нь төлөвшилд хүрсний шинж мөн. Энэ бүгд 1Коринт 13-р бүлэгтэй ямар сайхан нийцэж байна вэ!²³

Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй хэмээх нууцлаг үгээр Паул энэ жагсаалтыг төгсгөжээ. Мэдээж тийм шүү дээ. Энэ сайхан чанарууд Бурханы таалалд нийцэхийн сацуу, бидэнд өөрсдөд маань ч, мөн бусдад ч тустай. Тэгвэл энэ үр жимс яаж ургадаг юм бол оо? Хүний хичээл зүтгэлээр үү? Огтхон ч үгүй. Христитгэгчид Эзэнтэй

нөхөрлөн амьдарч байхад аяндаа ургана. Христитгэгчид Аврагчаа бишрэн хайрлаж, өдөр тутмын амьдралдаа Түүнийг дуулгавартай дагаж явахад Ариун Сүнс Өөрөө тэдний дотроос гайхамшиг үйлдэх болно. Ариун Сүнс тэднийг Христтэй адил болгож өөрчилдөг. Тэд Түүнийг харуулдан, Түүнд харцаа төвлөрүүлэхийн хэрээр Түүнтэй адил болдог (2Ко 3:18). Мөчир нь бүхий л амь амьдрал, шим тэжээлээ модноосоо авдаг шиг Христ дотор буй итгэгч хүн хүч чадлаа жинхэнэ усан үзмийн Мод болох Түүнээс авч, Бурханд зориулан үр жимсийг ургуулан амьдрах боломжтой.

5:24 Христ Есүст хамаатай хүмүүс өөрсдийн махбодыг загалмайд цовдолсон ажээ. Үйл үгийн цаг нь өнгөрсөнд нэгэнт болчихсон зүйлийг илэрхийлж байна. Энэ нь үнэндээ биднийг Христэд итгэх тэр үед аль хэдийн болчихсон үйл явдал юм. Бид нүглээ гэмших үедээ хуучин, бузар муу, ялзарсан мөн чанараа бүхий л хүсэл тачаалтай нь хамт загалмай дээр хаджээ. Түүнээс хойш нүгэлд унасан мөн чанараа тэжээн тэтгэхгүй амьдрахаар шийдсэн гэсэн үг. Өөрөөр хэлбэл, энэ мөн чанар биднийг ноёрхохоо больсон юм. Мэдээж энэ шийдвэрийг бид ахин дахин гаргаж, махбодыг үргэлж үхмэл байлгах ёстой.

5:25 Хэрэв гэсэн нь “учраас,” гэсэн утгыг давхар илэрхийлдэг. **Бид Ариун Сүнсний** үйлсээр мөнх амьтай болсон учраас тэрхүү **Сүнсний** хүчээр цоо шинээр амьдаръя гэж Паул хэлж байна. Хууль хэзээ ч амь өгч чадахгүй бөгөөд христитгэгчийн амьдралын дүрэм байхаар зориулагдаагүй ажээ.

В. Амьдралд ойр ятгалгууд (5:26-6:10)

5:26 Энэ эшлэл зайлсхийж явах учиртай гурван хандлагыг хэлжээ.

1. Сайрхал – **Сайрхахгүй байцгаая.** Өөрөөр хэлбэл, өөрсдийнхөө талаар хий хоосон, худал бодол тээхгүй байя

гэсэн үг. Христитгэгчид өөрсдөөрөө сайрхаж, ихэрхэхийг Бурхан хүсдэггүй. Нигүүлслээр аврагдсан нүгэлтэнд ийм зан зохихгүй. Хуулийн доор амьдардаг хүмүүс өөрсдийнхөө өрөвдөлтэй ололт амжилтад бардаж, өөрсдийнх нь жишигт хүрэхгүй хүмүүсийг доромжилдог. Легализмийг баримталдаг христитгэгчид өөрсөд шиг нь хатуу дүрэм журам дагадаггүй бусад итгэгчдийг буруутгадаг.

2. Өдөөн сэргөлдөх — **Нэг нэгнээ өдөөн сөрдөг** тухай юм. Хувийн үзэл бодлын хэмжүүрт бусдыг хүргэх гэж өдөөн хатгаж, сэргөлдөх нь Сүнсээр дүүрэн амьдралыг үгүйсгэж байгаа хэрэг болно. Бид өөрсдөө туулж үзээгүй л бол тухайн хүн ямар сорилт бэрхшээлийг туулж, юун дундуур явж байгааг бид гаднаас нь хараад хэлж мэдэхгүй шүү дээ.

3. Атаархал – **өөр зуураа атаархах** тухай юм. Атаархал гэдэг нь өөрт нь байх зохисгүй зүйл бусдад байгааг хараад түүнд нь санаархах нүгэл юм. Атаархал нь өөр хүний гаргасан амжилт, авьяас чадвар, эд хөрөнгө, сайхан төрхийг хараад жигшин зэвүүцдэг. Авьяас чадвар багатай, сул дорой хүмүүс өөрөөс нь илүү хуулийг сахидаг хүмүүст атаархах нь элбэг. Энэ байдал нигүүлслийн мөн чанарт харшилна. Жинхэнэ итгэгч хүн бусдыг өөрөөсөө илүү хэмээн хүндэтгэх учиртай. Хуулийг сахигчид хуурамч нэр төрийг хүсэмжилдэг. Жинхэнэ агуу байдал бол анзаарагдахгүйгээр үйлчилж, хэн ч хараагүй байхад хөдөлмөрлөх явдал юм.

6:1 Христитгэгчид нүгэл үйлдсэн итгэгчтэй хэрхэн харьцах талаар үнэтэй зөвлөгөөг энд бичжээ. Хууль бол буруутай этгээдийг шүүж шийтгэдэг. Гэтэл энд тэс өөр хандлагыг дурдсан байна. **Гэмд автсан** хүн гэж нүгэл үйлддэг зуршилтай хүнийг бус, нэг удаа нүгэл үйлдсэн хүнийг хэлж байна. Ийм хүнийг **сүнслэг** христитгэгчид зохистойгоор авч үзэн, сэргээх ёстой. Махбодын дагуух

христитгэгч хүн магадгүй хатуурхаж, хүйтэн хөндий харьцвал тус болохоосоо илүү хор уршиг тарьж мэднэ. Мөн Эзэнтэй харилцаа муутай хүний залруулгыг буруудагч этгээд хүлээж авахгүй байх ч эрсдэлтэй.

Энэ эшлэлээс нэгэн сонирхолтой асуулт урган гардаг. Хэрэв хүн үнэхээр сүнслэг бол үүнийгээ өөрөө хүлээн зөвшөөрөх үү? Сүнслэг хүмүүс өөрсдийнхөө дутагдлыг хамгийн сайн ухамсарладаг биш бил үү? Өөрөөрөө үл сайрхах нь сүнслэг хүний шинж чанар юм бол нүгэлд унасан хүнийг сэргээх ажлыг хэн хийх юм бэ? Өөрийгөө сүнслэг гэх нь даруу байдалтай зөрчилдөхгүй гэж үү? Эдгээр асуултын хариулт нь, жинхэнэ сүнслэг хүн өөрөөрөө мэдээж хэзээ ч сайрхахгүй. Гэхдээ түүнд хоньчны дөлгөөн зан байдаг тул нүгэлд унасан нэгнийгээ дахин сэргээхийг зайлшгүй хүснэ. Тиймээс тэрээр өөрийгөө дээр тавьсан бардам зангаар бус, харин “би ч гэсэн **уруу татагдах** боломжтой” гэдгээ санан **дөлгөөн сүнсээр** хандах болно.

6:2 Ачаа гэж алдаа буруудалт, уруу татлага, сорилт, бэрхшээлүүдийг хэлнэ. Бид холоос шүүмжилж зогсолгүй, зовлон шаналалд унасан ах дүүгийнхээ дэргэд очоод чадах бүхнээрээ туслах хэрэгтэй.

Христийн хууль гэдэг нь Эзэн Есүсийн хүмүүстээ айлдсан Шинэ гэрээний бүх тушаалуудыг хэлнэ. Эзэн Есүсийн бүх тушаалыг “Бие биеэ хайрла” гэсэн хэдхэн үгээр тоймлон хэлж болно (Иох 13:34; 15:12). Бид **нэг нэгнийхээ ачаанаас үүрэлцэхдээ** энэхүү тушаалыг бүрэн биелүүлдэг. **Христийн хууль** Мосегийн хуулиас тэс өөр билээ. Мосегийн хууль дуулгавартай дагасан хүндээ амийг амладаг боловч дуулгавартай дагах хүчийг өгдөггүй, зөвхөн шийтгэлээс айх айдсыг өдөөх замаар дуулгавартай байлгадаг. Эсрэгээрээ, **Христийн хууль** бол аль хэдийнээ амьтай болсон хүмүүст өгсөн хайрын заавар юм. Итгэгчид

Ариун Сүнсний хүчээр тэрхүү зааврыг дагаж чадах агаад Христийг гэсэн хайр нь тэднийг үүнд өдөөдөг билээ.

6:3 Бид бүгдээрээ ялгаагүй тоос шороогоор бүтээгдсэн. Тиймээс нүгэл үйлдсэн ах дүүгээ харахдаа би ч бас түүн шиг байдалд орж болох байсан гэж даруугаар хандах хэрэгтэй. Христитгэгч хүн өөрийгөө бусдаас илүү гэж бодвол өөрийгөө хуурч буй хэрэг болно. Бид бусдаас илүү болохоороо бусдын ачааг үүрдэг юм биш ээ.

6:4 Энд өөрийгөө бусадтай харьцуулж, тэндээс сэтгэл ханамж авах зуршлаас сэрэмжлүүлсэн анхааруулга байна. Бид Христийн шүүх суудлын өмнө бусадтай жишигдэн шүүгдэхгүй хувьчлан шүүгдэх учраас өөрийнхөө хэрэгт л анхаарах ёстой гэдгийг Паул энд хэлсэн байна. Ингэснээр бид бусдын алдаа зөрчилд баярлаж, өөрийгөө дөвийлгөхийн оронд өөрийнхөө **үйл хэрэгт** л санаа тавьж чадна.

6:5 Бид энэ амьдралдаа нэг нэгнийхээ зовлон шаналал, асуудал бэрхшээлийг үүрэлцэх ёстой гэж Паул 2-р эшлэлд хэлсэн бол, харин энэ 5-р эшлэлд хүн бүр Христийн шүүх суудлын өмнө тус тусдаа хариуцлагаа **үүрнэ** гэж хэлж байна.

6:6 Итгэгчид христитгэгч багш, сургагч нартаа тусалж, тэднийг дэмжих үүрэгтэй. **Сайн бүхнээ хуваалцах** гэдэг нь багш нартайгаа материаллаг зүйлсээ хуваалцахаас гадна тэдний төлөө залбирч, бурханлаг анхаарал халамж тавьж, тогтмол дэмжихийг хэлнэ.

6:7 Бурханы үйлчлэгчдийг үл тоомсорлож байгааг хүмүүс анзаарахгүй байж болох ч Бурхан ажиглаж байдаг тул Тэр бидэнд юу тарьсанчлан хариуг нь барина. Бид тарьснаа хурааж авдаг. Тэгэх тусмаа тарьснаасаа ч илүүг хураан авдаг. Тариаланч улаан буудай таривал түүнийгээ гуч, жар, зуу дахин нугалж авдаг. “Энд нүгэлтнүүд нүглийнхээ үр жимсийг авах тухай бус, харин ариун

хүмүүс харамч зангийнхаа хариуг авах талаар Ариун Сүнс ярьж байна” гэж Скофилд тэмдэглэн хэлжээ.

Мэдээж энэ эшлэлийг илүү өргөн утгаар нь “Ёс бусыг газар мэт хагалж, тариалагсад зовлон зүдүүрийг ургац мэт хурааж авдаг”, (Иов 4:8) мөн “салхийг тарьдаг тэд шуурга хурааж авдаг” гэж хэлж болно (Хос 8:7). “Түүхийг эргэж харвал бидэнд нэг зүйлийг баттай давтан сургамжилдаг. Тэр юу хэмээвээс, энэ дэлхий юутай ч ёс суртахууны зарчим дээр тулгуурладаг тул урт хугацаандаа хувь тавилан сайн хүнд ээлтэй, муу хүнд эцэстээ халтай байдаг” гэж түүхч Ж. А. Фроуд нэгэнтээ өгүүлжээ.²⁴

6:8 Бид юу тарьснаа хурааж авдаг нь ерөнхийдөө үнэн боловч Паулын энд ярьж байгаа зүйл нь христитгэгч хүн өргөл өргөх хэрэгтэйг уриалж байгааг харж болно. Тэр утгаар нь харвал **махбодод** тарих гэдэг нь хөрөнгө мөнгөө өөрийнхөө төлөө, хувийн тааламж, тав тухдаа зориулахыг хэлж байна. **Сүнсэнд** тарих гэдэг нь Бурханы үйл хэргийн төлөө хөрөнгө мөнгөө зарцуулахыг хэлж байна.

Махбоддоо тарьдаг хүн энэ дэлхий дээр байхдаа урам хугарал ба алдагдлыг хурааж авна. Учир нь тэд нас явах тусам ялзарч муудан, үхэж мөхөх зүйлийн төлөө амьдарч байснаа ойлгодог. Тэгээд ирэх өдрүүдэд мөнх шагналаа бас алдах болно. **Харин Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна.** Мөнх амь гэдэг үг Библид хоёр янзын утгаар хэрэглэгддэг: (1) Мөнх амь бол итгэгч хүн бүр одоо эзэмшиж буй зүйл билээ (Иох 3:36). (2) Мөнх амь бол энэ дэлхийн амьдралаа дуусгасны дараа итгэгчдийн хүлээж авах амьдрал бас мөн (Ром 6:22). **Сүнсэнд таригч** хүмүүс энэ дэлхий дээр байхдаа бусад итгэгчдийн амсаж үзээгүй тийм гайхалтай мөнх амийг мэдэрдэг. Хоёрт, тэд тэнгэр дэх гэртээ очихоороо итгэмжит байдлын шагналыг хураан авах болно.

6:9 Тиймээс шагнал нь тэр даруй ирэхгүй байсан ч ирэх нь гарцаагүй тул **сайныг үйлдэхдээ** шантрахгүй байхыг

Паул уншигчдадаа сануулж байна. Хүн улаан буудай тарьсныхаа маргааш шууд ургацаа хураадаггүй шүү дээ. Сүнслэг зарчим ч үүнтэй нэгэн адил, итгэмжтэйгээр тарьсан хүн **цаг нь болохоор** шагналаа авах л болно.

6:10 Итгэлийн гэр бүл гэдэгт аврагдсан бүх хүн орно. Үүнд урсгал чиглэл, хуваагдал хамаагүй. Бидний сайхан сэтгэл зөвхөн итгэгч хүнээр хязгаарлагдах учиргүй ч тэдэнд бүр онцгой анхаарал тавих ёстой. Бидний зорилго яаж бага хор хөнөөл учруулах вэ гэсэн сөрөг хандлагаар бус, харин хэрхэн илүү их сайн сайхныг бүтээх вэ гэсэн эерэг хандлагаар **сайныг үйлдэх** ёстой юм. “Боломж байх л юм бол тусалж чадах бүх хүндээ, бүхий л арга замаа ашиглан, чадлынхаа хэрээр сайныг үйлд” хэмээн Жон Вэсли маш товч тодорхой хэлжээ.

Г. Дүгнэлт (6:11-18)

6:11 Би өөрийн гараар ямаршуу том үсгээр та нарт бичиж байгааг минь үз. Паул ихэвчлэн өөрөө хэлээд хүнээр захидлаа бичүүлдэг байсан ч энэ удаа өөрийн гараар бичжээ. Магадгүй легализмийг баримталдаг хүмүүсийн эсрэг дургүйцлээ илэрхийлж, иудейжүүлэх үзэл хэчнээн хор хөнөөлтэй гэж үзэж буйгаа харуулахын тулд ингэж өөрийн гараар **том үсгээр** бичсэн байж болох юм. Эсвэл Паулын хараа муу байсан учраас том үсгээр бичсэн байх л даа. Энэ эшлэл болон Библийн өөр хэсгүүдийг үзээд олон хүн Паулын хараа муу байсан гэж дүгнэдэг. Бид хоёр дахь тайлбарыг зөв гэж үздэг.

6:12 Иудейжүүлэх үзэлтнүүд олон дагалдагчтай болж, **махбодоор сайхан харагдахыг** хүссэн. Тэд хозлолыг номлох замаар үүнийгээ гүйцэлдүүлжээ. Ер нь хүмүүс дадал зуршлаа өөрчлөхгүйгээр элдвийн ёс заншил, зан үйлийг дагаж мөрдөх дуртай учраас тэд амжилт олдог. Эдүгээ ариун байдлын шалгуурыг бууруулах замаар олон

хүнтэй чуулган байгуулах нь элбэг болжээ. Паул ийм хуурамч багш нарын хоёр нүүртэй байдлыг нэвт шувт олж хараад **Христийн загалмайн төлөө хавчигдахаас** зайлсхийж байна хэмээн тэднийг буруутгав. Загалмай нь махбодыг Бурханд таалагдах гэсэн хүчин чармайлтуудынх нь хамт бүхэлд нь буруушаасныг бэлгэддэг. Загалмай нь махбодын мөн чанар хийгээд хамаг сайн хичээл зүтгэл бүрийг нь үхүүлдэг. Загалмай нь бузар муугаас салахыг илэрхийдэг билээ. Тиймээс хүмүүс загалмайн сүр жавхлант мэдээг үзэн ядаж, үүнийг тунхаглагчдыг хавчдаг.

6:13 Легализмийг баримтлагчид үнэн чанартаа **хуулийг** сахих сонирхолгүй ажээ. Тэд хялбар аргаар олон дагалдагчтай болж, дагалдагчдынхаа тоогоор сайрхах л хүсэлтэй байжээ. Бойс энэ талаар, “энэ нь өөрөө бүтэлгүйтэж дампуурсан зүйлдээ бусдыг уруу татан оруулах гэсэн оролдлого мөн. Учир нь хозлуулагсад ч хуулийг сахиж чадаагүй юм” гэжээ.

6:14 Паул хүний махбодоор бус, харин **бидний Эзэн Есүс Христийн загалмайгаар** сайрхаж байв. Загалмай дээр ертөнц Паулын хувьд, Паул ертөнцийн хувьд үхжээ. Хүн аврагдахад ертөнц түүнтэй салах ёс гүйцэтгэж, тэр ч **ертөнцөд** баяртай гэж хэлдэг. Тэр хүн ертөнцийн хоромхон зуурын зугаа цэнгэлийг сонирхохоо больсон тул **ертөнц** түүнд хамаагүй болдог. Сэтгэлийг нь дүүргэх Нэгэнийг олсон тул **ертөнц** түүний сэтгэлийг татахаа больдог. Финдли энэ талаар, “Тэр ертөнцөд дахиж хэзээ ч итгэхгүй. Түүгээр ч барахгүй ертөнцөөр бахархахгүй. Мөн түүнийг биширч, хүндлэхгүй. Ертөнцийн яруу алдар, үзэсгэлэн төгс чанар нь хүнийг соронздон татах хүчээ нэгэнт алджээ” гэсэн байна. Тиймээс загалмай нь ертөнц хийгээд Бурханы хүүхэд хоёрын дунд хана хэрэм босгож, тусгаарлах шугам татдаг.

6:15 Энэ эшлэлийг анх уншихад тийм ч ач холбогдолтой санагдахгүй байж болох ч галатчуудад

бичсэн энэ захидлын бүх агуулга дотроос христитгэлийн үнэний талаарх хамгийн жинтэй мэдэгдлүүдийн нэг мөнөөс мөн.

Хозлол бол гадна талын зан үйл, ёс заншил билээ. Иудей багш нар энэ ёслолыг дагаж мөрдөхийг туйлын чухалчилжээ. Учир нь хозлол иудейзмын үндэс байлаа. Тэгвэл Паул энэхүү үндсийг тасар татан хаяж, **“Хозлуулах нь юу ч биш”** гэжээ. Зан үйл, иудейзм, легализмийн аль нь ч чухал биш. Паул үүн дээр нэмж, **“эс хозлуулах нь юу ч биш”** гэж мэдэгдэв. Ямар нэг зан үйл, ёслолд баригддаггүйгээрээ сайрхдаг хүмүүс бас байдаг. Тэдний чуулганы үйлчлэл тэр чигтээ ёслолыг эсэргүүцдэг. Тэгвэл энэ ч бас үнэ цэнгүй.

Бурханд үнэтэй ганц зүйл бол **шинэ бүтээл** юм. Тэрээр өөрчлөгдсөн амьдралыг л хүсдэг. Финдли энэ талаар "Жинхэнэ христитгэл муу хүнийг сайн хүн, нүгэлд боолчлогдогсдыг Бурханы хөвгүүд болгон өөрчилдөг" хэмээн бичжээ. Бүх хүн хоёр бүтээлийн аль нэгэнд харьяалагддаг. Хүн анх энэ дэлхийд нүгэлтэй, сул дорой, ялтай шийтгэл хүртэх тавилантай төрдөг. Тэдний өөрсдийгөө аврах гэсэн оролдлого, сайн үйлсээрээ Бурханы авралын үйл хэрэгт нэмэр болох гэсэн зүтгэл нь ямар ч хэрэгцээгүй, юуг ч өөрчилдөггүй. Тэгвэл **шинэ бүтээл** амилсан Христээр удирдуулдаг. Христийн дотор нүглээсээ чөлөөлөгдөж, шинэ амьтай болсон бүх хүн багтана. **Шинэ бүтээл** гараанаасаа бариа хүртэл Христийг бүх зүйлээ болгодог учраас сайн үйлсээр Бурханы тааллыг олж авах гэсэн аливаа бодол санааг бүр мөсөн үгүйсгэдэг. Ариун амьдрал нь зан үйлийг сахихын оронд Христэд бууж өгөн, Христийн амиар явахыг хүлээн зөвшөөрснөөр бий болдог. Шинэ бүтээл бол хуучны сайжирсан хувилбар огт биш, тэс өөр зүйл билээ.

6:16 Паул энд **ямар жишгийг** өгүүлнэ вэ? Энэ бол шинэ бүтээлийн жишиг юм. Тэгээд “Энэ нь шинэ

бүтээлийнх мөн үү?” гэдэг асуултаар сургаал номлолыг шалгаад, шинэ бүтээлийнх биш бол түүнээс шууд татгалздаг хүмүүс дээр **амар тайван** ба **өршөөлийн** давхар ерөөлийг тунхаглаж байна.

Бурханы Израиль дээр гэсэн энэ үгийг олон хүн чуулган гэж тайлбарладаг. Гэтэл **Бурханы Израиль** гэдэг нь **Эзэн Есүсийг** Мессиа хэмээн хүлээн зөвшөөрдөг, төрөлхийн еврей гаралтай хүмүүсийг хэлдэг. Хуулийн доор байдаг хүмүүст амар тайван, өршөөлийн аль нь ч байдаггүй. Энэ хоёр ерөөл зөвхөн шинэ бүтээлүүдэд зориулагджээ.

6:17 Паул өмнө нь хуулийн боол байсан ч **Эзэн Есүсээр** тэрхүү боолчлолоос чөлөөлөгдсөн юм. Харин одоо сайн дураараа **Эзэний** боол болжээ. Боолууд эзнийхээ тэмдгийг бие дээрээ тавиулдаг шиг Паул **бие** дээрээ **Эзэн Есүсийн** тэмдэгтэй байлаа. Тэдгээр нь юу байсан бэ гэж үү? Тэр бол хавчигчдын гараар бий болсон шарх сорви юм. Паулын үгийг найруулан хэлбэл, “Намайг урьдын юмс руу эргүүлэх гэж бүү оролд. Хуулийн боолчлолыг илэрхийлдэг хозлолын тэмдгийн талаар ч надад бүү ярь. Надад цоо шинэ **Эзэн, Есүсийн Христийн** маань тэмдэг бий” гэжээ.

6:18 Ингээд элч Паул үзгээ тавьж, захидлаа өндөрлөх боллоо. Гэхдээ сүүлийн үгээ бичих ёстой. Тэр нь ямар үг байх бол? Тэр бол **НИГҮҮЛСЭЛ**. Энэ үг түүний сайнмэдээг тодорхойлдог. Хууль биш **нигүүлсэл**. Нигүүлсэл гэдэг энэ сэдвээр тэр захидлаа эхлүүлсэн юм (1:3). Мөн энэ сэдвээр төгсгөж байна. **Бидний Эзэн Есүс Христийн нигүүлсэл сүнстэй чинь хамт байх болтугай. Амен.**

ЛЕГАЛИЗМИЙН ТУХАЙ НЭМЭЛТ ТАЙЛБАР

Галат номын судлалыг дуусгасны дараа Паул легализмийг номлодог багш нарыг хэлэх үггүй болгосон тул энэ асуудал цаашид чуулганд дахин гарч ирэхгүй болсон гэж дүгнэж болох юм. Тэгвэл түүхэн туршлага үүнийг эсрэгээр нь гэрчилж байна! Христитгэгчдийн дунд легализм нэг чухал хэсэг нь болтлоо нэвт шингэсэн байдаг тул ихэнх хүн үүнийг байх ёстой зүйл гэж итгэдэг.

Тийм ээ, хуулийг баримтлагчид одоо ч бидний дунд оршиж байгаа. Аврагдахад баптисм, чуулганы гишүүнчлэл, батламж шаардлагатай хэмээн номлодог ба итгэлээр аврагддаг боловч үйлсээр итгэлээ хамгаална гэж заадаг Христэч үйлчлэгч нэртэй хүмүүсийг үүнээс өөрөөр юу гэж нэрлэх билээ? Хүнээр томилогддог санваартнууд, тусгай өмсгөл, элдэв янзын загвартай сүм дуган, тахилын ширээ, ариун ёслолууд, сүмийн баяр, тэмдэглэлт өдөр, мацаг барилтыг заасан хуанли гэх мэт нь бүгд христитгэл юм гэж үү? Энэ нь христитгэл дээр иудейзмыг оруулж ирсэн хэрэг биш гэж үү?

Эцэст нь аврагдахыг хүсвэл Амралтын өдрийг заавал сахих ёстой хэмээн итгэгчдэд ухуулж байгаа нь галатчуудад хүрсэн гаж номлолтой адил хэрэг биш гэж үү? Легализмийг номлодог орчин үеийн номлогчид Христэд итгэдэг хүмүүсийн дунд асар их зөрчил үүсгэж байгаа тул итгэгч хүн бүр тэдний номлолоос сэрэмжилж, тэдэнд хэрхэн хариулах чиглүүлгийг авах ёстой.

Амралтын өдрийг номлодог эш үзүүлэгчдийн урсгал чиглэл анхандаа Христэд итгэснээр л аврагдана гэсэн сайнмэдээг тунхаглаж эхэлжээ. Тэд бодлогогүй хүмүүсийг өөртөө татахын тулд сайнмэдээний олонд түгсэн магтуу дуунуудыг ашиглаж, Бичвэрийг ихэд анхааран судалдаг мэт дүр эсгэцгээсэн. Гэвч төд удалгүй дагалдагчдаа Мосегийн хуулийн доор оруулжээ. Нэн ялангуяа

Амралтын өдрийг сахих тушаалыг ихэд чухалд тавив. (Амралтын өдөр буюу шаббат нь долоо хоногийн долоо дахь өдөр, одоогийнхоор Бямба гараг юм.)

Христитгэгчид хуульд үхсэн гэж Паул тов тодорхой хэлсээр байтал тэд үүнийг яаж ийм зоригтой үйлдэж чадав? Галатчуудад бичсэн илэрхий үгсийг тэд хэрхэн тойрч гарав? Үүний хариулт нь тэд ёс суртахууны хууль болон зан үйл, ариун ёслолын хуулийг дотроо эрс ялгаатай гэж тайлбарласанд оршино. Ёс суртахууны хууль бол Арван хууль юм. Харин бузар хоол, уяман өвчин, Бурханд өргөх тахил гэх мэт бусад тушаалууд нь зан үйл буюу ариун ёслолтой холбоотой бусад бүх хуулийг хэлдэг.

Тэд ёс суртахууны хууль хүчингүй болоогүй гэж хэлдэг. Энэ нь Бурханы мөнхийн үнэний илэрхийлэл аж. Завхайрч, хүн алж, шүтээн шүтэх нь Бурханы хуульд цаг ямагт харшилна, харин зан үйлийн хууль Христтэй хамт хүчингүй болсон гэж тэд хэлцгээдэг. Тиймээс тэд христитгэгчдийг хуульд үхсэн гэж Паул хэлэхдээ зан үйлийн хуулийг ярьсан болохоос Арван хуулийг яриагүй хэмээн заадаг.

Тэгэхээр ёс суртахууны хууль хүчин төгөлдөр учир христитгэгчид түүнийг одоо ч дагах ёстой гэж тэд тулгадаг. Энэ нь тэд Амралтын өдрийг заавал сахиж, тэр өдөр ямар ч ажил хийж болохгүй болчхож байгаа юм. Мөн тэд Ромын католик сүмийн нэг пап лам Бямба гарагийн Амралтын өдрийг Ням гараг болгож, Бичвэрийг зөрчсөн хэмээх түүхэн үндэслэл гаргаж тавьдаг.

Тэдний дэвшүүлсэн үндэслэл үнэний ортой, авцалдаатай сонсогддог. Харамсалтай нь ингэж эрс буруутгах хэв маяг нь Бурханы үгтэй бүрэн зөрчилддөг. Тэгэхээр доорх тайлбарыг анхаарч үзнэ үү:

1. 2Коринт 3:7-11 дээр Христ итгэгчдийн хувьд Арван хууль бүрэн “цуцлагдсан” гэж тов тодорхой мэдэгдсэн байна. 7-р эшлэлд хуулийг “чулуун дээр үсгээр сийлэгдсэн

үхлийн үйлчлэл” гэж тодорхойлсон байна. Энэ нь зан үйлийн хуулийг бус, ёс суртахууны хуулийг л хэлснээс өөрцгүй. Учир нь чулуун дээр Бурхан хуруугаараа Арван хуулийг л сийлсэн шүү дээ (Гэт 31:18). Дараа нь 11-р эшлэлд үхлийн үйлчлэл тухайн үедээ алдартай байсан ч одоо “*цуцлагдсан*” гэж бичигджээ. Үүнээс илүү тодорхой мэдэгдэл гэж үгүй. Амралтын өдөр бол христитгэгчдийн заавал сахих ёстой үүрэг биш.

2. Амралтын өдрийг сахь гэж Бурхан харь үндэстнүүдэд огт тушаагаагүй. Энэ хуулийг зөвхөн иудейчүүдэд л өгсөн (Гэт 31:13). Хэдийгээр Бурхан Өөрөө долоо дахь өдөр амарсан ч израильчуудад энэ хуулийг өгөх хүртэл Амралтын өдрийг сахь гэж хэнд ч тушаагаагүй.

3. Христитгэгчид хэн нэг пап ламын зарлигаас болж Амралтын өдрийг ням гараг руу шилжүүлээгүй. Эзэн Есүс долоо хоногийн эхний өдөр буюу ням гарагт үхлээс амилж, авралын ажлыг бүрэн гүйцэлдүүлснээ харуулсан тул (Иох 20:1) уг өдөр хүндэтгэл мөргөлийн цуглаанаа хийдэг. Мөн ням гарагт анхан үеийн шавь нар нь хамтдаа цуглаад Эзэний үхлийг дурсан талх хувааж иддэг байв (Үйл 20:7). Түүнчлэн, Эзэн тэднийг элбэг хангалуунаар ивээж ерөөснийг дурсан санаж, тэр хэмжээгээр нь зориулалт гаргуулахаар Бурханы тусгайлан тогтоосон ариун өдөр юм (1Ко 16:1, 2). Эцэст нь хэлэхэд, Ариун Сүнс долоо хоногийн эхний өдөр тэнгэрээс бууж ирсэн.

Христитгэгчид Эзэний өдрийг ариун байдалд хүрэх гэж болон шийтгэлээс айсандаа “сахидаггүй.” Харин Өөрийгөө бидэнд зориулсан Нэгэнийг хайрласандаа энэ өдрийг онцгойлон авч үздэг.

4. Паул ёс суртахууны хууль, зан үйлийн хууль гэж ялгаж зааглаагүй. Харин хуулийг нэг цогц гэж хараад үүнийг сахих замаар зөвт байдалд хүрэх гэж оролдсон хүмүүс дагаж чадаагүйнхээ төлөө хараагдана гэдгийг хатуу хэлсэн.

5. Арван хуулийн ес нь Бурханы хүүхдүүдэд зориулсан ёс суртахууны заавар байдлаар Шинэ гэрээнд дахин давтагдсан байдаг. Эдгээр нь жам ёсны зөв, буруу гэдэг ухагдахуунтай холбоотой. Харин огт дурдагдаагүй орхигдсон нэг хууль нь Амралтын өдрийг сахих тухай юм. Ямар нэг өдрийг сахих эсэх нь угаасаа зөв, буруутай холбоогүй. Христитгэгчдэд Амралтын өдрийг сахих заавар өгөөгүй. Харин ч ямар нэг өдрийг сахиагүйнхээ төлөө бусдаар яллагдах ёсгүй гэж Библи тов тодорхой хэлжээ! (Кол 2:16)

6. Амралтын өдрийг зөрчсөн хүн Хуучин гэрээнд цаазлуулдаг байлаа (Гэт 35:2). Гэтэл өнөөдөр Амралтын өдрийг сахихыг шаардагсад Амралтын өдрийг сахиагүй хүнд ямар ч шийтгэл оноодоггүй шүү дээ. Ингэснээрээ тэд хуулийг гутааж байна. Мөн шаардлагыг нь бүрэн биелүүлэхийг шаардахгүй байснаараа эрх мэдэл, хүчин төгөлдөр байдлыг нь үгүйсгэж байгаа юм. Нэг ёсондоо, “Энэ бол Бурханы хууль. Чи түүнийг сахих ёстой. Гэхдээ зөрчвөл чамд юу ч тохиолдохгүй” гэж хэлснээс өөрцгүй.

7. Христитгэгч хүний амьдралын мөрдлөг нь хууль биш Христ билээ. Бид Түүний алхсанчлан алхах ёстой. Энэ нь хуулийн тогтоосноос ч өндөр шалгууртай (Мт 5:17-48). Ингэж ариун амьдрах хүчийг бид Ариун Сүнснээс авдаг. Бид Христэд хайртай учраас ариун амьдрахыг хүсдэг. Хуулийн шаарддаг зөвт байдлыг махбодоор явагсад бус, Сүнсээр алхагсад биелүүлдэг (Ром 8:4).

Тиймээс Амралтын өдрийг сахь гэж итгэгчдэд номлодог сургаал Бичвэртэй шууд зөрчилдөнө (Кол 2:16). Үнэндээ энэ бол Бурханы үгэнд хараалыг дууддаг хэмээсэн “өөр сайнмэдээ” билээ (Гал 1:7, 9).

Легализмийн ёрын муу сургаал яаж ч дүрээ хувиргасан ялгаж салгах мэргэн ухааныг Бурхан та бүгдэд соёрхох болтугай! Элдвийн зан үйл, хүний хичээл зүтгэлээр зөвтгөл хийгээд ариусгалыг эрэлхийлэлгүй, зөвхөн Эзэн

Есүс Христэд бүх хэрэгцээгээ даатгаж, Түүнд бүрэн түшиглэцгээе. Легализм бол Бурханыг доромжилж буй хэрэг гэдгийг байнга санаж явах болтугай. Учир нь энэ үзэл бодит дүрийг сүүдрээр, Христийг ёслол төдийхнөөр орлуулдаг.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

¹(1:8, 9) Жон Стотт, *Цорын ганц зам: Галатчуудад бичсэн захидал*, 27, 28-р хуудас.

²(1:18-20) Грек эх хэл дээрээ Кеф гэсэн байна. Энэ нь Петр гэдэг нэрийн арамей хувилбар.

³(2:1) Э. Ф. Кеван, өөр эш татах баримт байхгүй.

⁴(2:3) Хозлол гэдэг нь эр хүнд хийдэг жижиг мэс ажилбар юм. Бурхан үүнийг Абрахам болон түүний үр удамд тогтоож өгөхдөө тэдэнтэй байгуулах гэрээнийхээ тэмдэг болгохыг зорьсон. Уг гэрээний дагуу, Тэр тэдний Бурхан болж, тэд Түүний ард түмэн болох юм (Эх 17:1-11). Энэ нь биед хийгдэх тэмдэг төдийгүй сүнслэг бэлгэдэл байлаа. Абрахам Бурханд итгэснийхээ тэмдэг болгож хозлуулсан (Ром 4:11). Харамсалтай нь иудейчүүд хозлолын *сүнслэг* утгыг умартаж ердийн нэг ёслол болгожээ. Улмаар энэхүү ёслол нь Бурханы талаас ямар ч үнэ цэнгүй болов. Одоо Бурхан иудей ба харь үндэстнийг ялгалгүй бүгдтэй нь нигүүлслийн гэрээ байгуулсан учраас Шинэ гэрээнд хозлуулахыг тушаагаагүй. Анхан үеийн чуулганд зарим нэг иудей итгэгчид аврагдахын тулд заавал хозлуулах ёстой гэдэг байжээ. Тиймээс тэд “хозлуулагсад” гэдгээрээ алдаршжээ (Гал 2:12).

⁵(2:3) Иерусалимд болсон хурлын тухай Үйлс 15 дээр дэлгэрэнгүй бичсэн байдаг. Үүнийг анхааралтай судлах хэрэгтэй.

⁶(2:11) 2-р зүүлт тайлбарыг үз.

⁷(2:13) Грек эх хэл дээрээ цэг, таслал, зураас гэх мэт тэмдэг тэмдэглэгээ анхандаа байгаагүй. Хожим хянан тохиолдуулан эдгээрийг оруулсан. Тиймээс зарим тайлбарлагчид 15-21 дүгээр эшлэлийг Петрт хэлсэн үгээ Паул *тайлбарласан тайлбар* гэж үздэг.

⁸(2:21) У. М. Клоу, *Христигэлийн амьдралд буй загалмайн утга учир*, 114-р хуудас.

⁹(3:1) Грекээр *хэн* гэдэг асуулт ганц болон олон тоон дээр байдаг тул энэ тохиолдолд хариу нь олон тоон дээр байх боломжийг бүрэн үгүйсгэж болохгүй.

¹⁰(3:5) Хамгийн эрт цагийн гар бичмэлүүд бүгд том үсгээр бичигдсэн байдаг. (Жижиг үсгүүд хожим зохиогдсон.) Тиймээс эхний үсгийг томоор бичих явдал хожим хянан тохиолдуулах явцад бий болсон. Гэхдээ энэ эшлэлд *Тэр* гэдэг үгийн эхний үсгийг томоор бичих нь агуулгын хувьд таарч байна.

¹¹(3:13) Ж. Синддилен Жонс, *Гэгээн Иоханы бичсэн сайнмэдээг судлахуй*, 113-р хуудас.

¹²(3:20) Христийг Шинэ гэрээний Зууч гэж ярьсан байдаг (Евр 9:15). Паулын дэвшүүлсэн хэлэлцүүлэг үүнтэй зөрчилдөж буй мэт харагдаж болох ч зууч гэдэг үг энэ хоёр тохиолдолд өөр өөр утгаар хэрэглэгдсэн. Мосегийн хувьд Бурханаас хуулийг хүлээн аваад Израилийн ард түмэнд өгснөөрөө зууч болсон. Мосе хоёр талын хооронд зуучилж, ард түмнийг төлөөлсөн. Харин Христ хамаагүй агуу байдлаар Шинэ гэрээний Зууч болсон юм. Бурхан энэ гэрээний ерөөлийг зөв шударгаар соёрхохын өмнө Эзэн Есүс нас барах ёстой байлаа. Хүний эцсийн хүсэл хийгээд гэрээслэл тухайн хүний үхлээр хүчин төгөлдөр болдгийн нэгэн адил Шинэ гэрээ нь Христийн цусаар тамгалагдах ёстой байв. Тэр Өөрийгөө бүгдийн төлөө золиос болгон өгөх учиртай байлаа (1Тм 2:6). Христ ард түмэндээ уг гэрээний ерөөлийг баталгаатай болгож өгөөд зогсохгүй энэ дэлхийд хорсол заналхийлэл дунд яваа гэрээнийхээ ард түмнийг сахин хамгаалах ажлыг гүйцэлдүүлдэг. Тэрээр үүнийг Тэргүүн Тахилч ба Өмгөөлөгчийн хувиар гүйцэлдүүлдэг бөгөөд энэ нь зуучийн үүргийнх нь нэг хэсэг юм.

¹³(3:24) Грек эх хэл дээрээ энэ үг *paidagogos* (англи хэлний *pedagogy* буюу сурган хүмүүжүүлэх ухаан гэх үг үүнээс гаралтай) бөгөөд шууд үгчлэн орчуулбал “хүүхдийг

хүмүүжүүлэгч” гэсэн утгатай. Энэ нь хүүхдийг сургуульд нь хүргэж өгч, сургуулиас нь авдаг, заримдаа хичээл заадаг хүн юм. Ихэвчлэн боолууд энэ ажлыг хийдэг байж.

¹⁴(4:7) Норман Б. Харрисон, *Түүний тал, Бидний тал*, 71-р хуудас.

¹⁵(4:13) Паулын “махбодын мөхөсдөл” юу байсан талаар хэд хэдэн онол бий. Зарим нь Паулыг нүдний өвчтэй байсан гэдэг. Энэ нь Ойрх Дорнодод нэлээд түгээмэл өвчин ажээ. Тиймээс энэ онол хамгийн оновчтой байх магадлалтай. Мөн хумхаа өвчин, толгойны өвчин, унаж татах өвчин гэх мэт янз бүрийн бие махбодын зовуурь шаналлыг дэвшүүлдэг хүмүүс бий.

¹⁶(4:17) Стотт, *Галатчуудад бичсэн захидал*, 116-р хуудас.

¹⁷(5:1) Ч. Х. Макинтош, *Эхлэлээс Дэд хууль*, хуудас 232, 233.

¹⁸(5:2) Жак Хантер, *Библийн сургаал: Галат-Филемон*, 78-р хуудас.

¹⁹(5:4) Ч. Ф. Хогг болон У. Э. Вайн, *Элч Паулаас галатчуудад бичсэн захидал*, 241-р хуудас.

²⁰(5:13) Артур Т. Пиерсон, нэмэлт мэдээлэл байхгүй.

²¹(5:16) С. И. Скофилд, *Доктор С. И. Скофилдын номлолууд*, 234-р хуудас.

²²(5:19-21) 1Коринт 6:9-ийн зүүлт тайлбарыг үз.

²³(5:22, 23) Самуел Чадвик, Жэймс А. Стюарт эш татсан, *Зөөлөн зүлэгтэй бэлчээр*, 253-р бүлэг.

²⁴(6:7) Ж. А. Фроуд, нэмэлт мэдээлэл байхгүй.

НОМЗҮЙ

- Коул, Алан. *Паулаас галатчуудад бичсэн захидал*. Гранд Рапидс хот: Вилльям Б. Эрдмансын хэвлэлийн компани, 1965 он.
- Ийди, Жон. *Паулаас галатчуудад бичсэн захидлын тайлбар*. Эдинбург хот: Ти Энд Ти Кларк хэвлэлийн газар, 1884 он.
- Харрисон, Норман Б. *Түүний тал, Бидний тал*. Миннеаполис хот: Харрисоны Үйлчлэл, 1940.
- Хогг, Ч. Ф., У. Э. Вайн нар, *Галатчуудад бичсэн захидал*. Гласгов хот: Пикеринг Энд Инглис хэвлэлийн газар, 1922 он.
- Айронсайд, Харри А. *Галатчуудад бичсэн захидлын тайлбар номлолууд*. Нью Йорк хот, Лоизоу Брос хэвлэлийн газар, 1941 он.
- Келли, Вилльям. *Элч Паулаас галатчуудад бичсэн захидлын талаарх илтгэлүүд*. Лондон хот: Г. Морришийн хэвлэлийн газар, он тодорхойгүй.
- Лайтфут, Ж. Б. Гэгээн *Паулаас галатчуудад бичсэн захидал*. Гранд Рапидс хот: Зондерван хэвлэлийн газар, 1962 он.
- Макинтош, Ч. Х. *Эхлэлээс Дэд хууль*. Нэптюн хот, Нью Жерси муж: Лоизоу Брос, 1962 он.
- Стотт, Жон Р. *Цорын ганц зам: Галатчуудад бичсэн захидал*. Довнерс Гроув, Иллиноис муж: Интерварсити Пресс хэвлэлийн газар, 1968 он.

ЕВРЕЙЧҮҮДЭД БИЧСЭН ЗАХИДАЛ

ОРШИЛ

Бичээчийнх нь талаар хамгийн их маргаантай атлаа Бурханы амьсгалаар бичигдсэн нь илэрхий гэдэг нь эргэлзээгүй Бичвэрийн хэсэг үүнээс өөр Библид байхгүй.

-Конибер болон Хаусон

I. БИЧВЭРТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Еврейчүүдэд бичсэн захидал Шинэ гэрээнд онцгой байр эзэлдэг. Энэ нь олон шалтгаантай. Эхлэл нь захидал хэлбэртэй биш боловч төгсгөл нь захидал хэлбэртэй, мөн Италиас эсвэл Итали уруу (13:24), тодорхой бүлэг итгэгчдэд, тэр дундаа еврей итгэгчдэд хандан бичжээ. Анхандаа жижиг гэр чуулганд хаяглагдсан тул нэртэй том чуулганууд захидлын бичээч ба хүлээн авагчийнх нь мэдээллийг хадгалан үлдээж чадаагүй хэмээн үздэг. Энэ нь бичигдсэн хэлбэрээрээ Шинэ гэрээн дэх хамгийн уран яруу ном юм. Шүлэг найраг өргөн ашиглахаас гадна Септуагинтаас олонтоо эш татжээ. Үгсийн сан нь ч арвин. Грек хэлийг үйл үгийн цаг болон хэлзүйн бусад асуудал дээр нягт нямбай хэрэглэсэн байна.

Нэг талаар *иудей сэтгэлгээ* нэвт шингэсэн (Леви номтой харьцуулдаг) боловч Христийн үхлийг зүгээр нэг шашны зан үйл болгох аюулаас сэрэмжлүүлдэг. *Христитгэлт улс орнуудад* энэ анхааруулга туйлын хэрэгтэй байгаа билээ. Тэгэхээр энэ номын ач холбогдол тун их ажээ.

II. ЗОХИОГЧ

KJV (Жэймс Хааны Орчуулга) Библийн зарим хуучны хэвлэлүүд гарчиг дээр нь Паулын нэрийг оруулдаг ч

“Еврей” номын зохиогч үнэндээ тодорхойгүй байдаг. Эртний зүүний чуулган (Александрын Дионисус, Клемент нар) Паулыг зохиогчоор нь нэрлэсэн байдаг. Хүмүүс энэ үзэлд нэлээд эргэлздэг байснаа Атанасиусын үеэс хүлээн зөвшөөрч эхэлжээ. Эцэст нь барууны ертөнц нийтээр хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч эдүгээ зохиогч нь Паул гэх үзлийг баримталдаг хүн цөөрчээ. “Еврей” номын *утга агуулга*, зарим арга хэлбэр Паулынхтай ижил боловч бичиглэлийн хэлбэр Паулынхаас өөр гэж Ориген үзсэн байна. (Энэ нь Паул бичсэнийг үгүйсгэх *баримт болж чадахгүй*. Уран зохиолын төрлөөс хамаарч бичиглэлийн хэлбэр өөрчлөгдөж болно.)

Өнгөрсөн хугацаанд “Еврей” номын зохиогчоор хэд хэдэн хүнийг нэр дэвшүүлжээ. Тухайлбал, Лукыг нэрлэж болно. Учир нь бичиглэлийн хэлбэр нь Лукийнхтай төстэйгөөс гадна Лук, Паулын номлолыг мэддэг байсанд оршино. Лукаас гадна Барнаб, Силас, Филип, тэр ч байтугай Прискила, Акул хоёрыг зохиогчоор нь нэрлэж байв.

Лютер, Аполыг “Еврей” номын хэв маяг, утга агуулгад тохирох учраас зохиогч нь гэж үзсэн байна. Учир нь Апол Хуучин гэрээний мэдлэгтэй, хэл яриа сайтай хүн байв. (Аполын төрсөн Александр хот уран яруу илтгэлээрээ алдартай.) Гэвч Александрын уламжлалд энэ үзлийг дэмжих баримт алга гэх сөрөг шүүмж бий. Нутгийнх нь хүн “Еврей” номыг бичсэн байхад Александрын уламжлалд түүнийг дурдахгүй өнгөрөх учиргүй гэж тэд маргадаг.

Ямарваа нэгэн шалтгаанаар Эзэн “Еврей” номын зохиогчийн нэрийг мэдүүлсэнгүй. Захидлыг Паул бичсэн боловч иудейчүүд өөрийг нь хяхан хавчиж байсан тул нэрээ дурдаагүй гэх санал ч бас бий. Тийм ч байж мэднэ. Аль нь байлаа ч Оригений хэлсэн “Энэ захидлыг хэн

бичсэнийг Бурхан л баттай мэднэ” гэх эртний үг хамгийн зөв юм.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Захидлын хүмүүн *зохиогч* тодорхойгүй боловч бичигдсэн *он цагийг* тун дөхүүлэн тодорхойлох боломжтой байдаг.

Гадаад баримтуудыг үзвэл уг захидал нэгдүгээр зуунд хамаарна. Тухайлбал, Ромын Клемент “Еврей” номыг ашигласан (МЭ95 оны үе). Поликарп, Юстин Мартир нар захидлаас эш татсан боловч зохиогчийнх нь нэрийг дурдаагүй. Александрын Дионисус “Еврей” номоос эш татахдаа зохиогчийг нь Паул хэмээн нэрлэсэн. Мөн Александрын Клемент “Еврей” номыг Паул бичиж, Лук орчуулсан гэж дурджээ. (Гэхдээ “Еврей” ном орчуулга шиг уншигддаггүй.) Ириней, Хипполитус нар Паулыг зохиогч нь гэж үзэхгүй байгаагаа мэдэгдсэн агаад Тертуллианы хувьд Барнабыг зохиогч хэмээн үзсэн байна.

Дотоод баримтыг дурдвал, зохиогч нь хоёр дахь үеийн итгэгч гэмээр харагддаг (2:3; 13:7). Тэгэхээр Иаков болон 1Тесалоник номууд шиг *нэлээд* эрт бичигдсэн баймгүй (10:32-ыг үз). Иудейн дайныг (МЭ66 онд эхэлсэн) дурдаагүй, сүмд тахилууд өргөгдөж байсан (8:4; 9:6; 12:27; 13:10) зэргийг харахад *ямартай ч* Иерусалимын сүйрлээс (МЭ70 он) өмнө, магадгүй МЭ 66 оноос урьд бичигдсэн байх магадлалтай. Хавчлагын тухай дурдсан боловч (12:4) итгэгчид “цус урсгах хүртлээ эсэргүүцээгүй” байлаа. Хэрэв захидлыг Италид хаягласан бол тэнд Нерогийн цуст хавчлага болж байсан (МЭ 64 он) тул уг захидал бичигдсэн хугацааг ядаж МЭ 64 оны дунд үеэс өмнө байх учиртай болгодог. Энэ бүхнээс дүгнэхэд МЭ 63-65 он бол Еврей ном бичигдсэн байх хамгийн магадлалтай хугацаа юм.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ЕРӨНХИЙ АГУУЛГА

Тухайн үед еврейчүүд хуучин шашны тогтолцоогоо орхиж өөр итгэл үнэмшил рүү эргэх нь асар их тэмцэлтэй зүйл байлаа. Хуучин холбоо харилцаагаа гэнэтхэн, эрс шийдэмгий тасалж, бусдаас салан тусгаарлах гэсэн зөрчлөөс гадна эргэж буцахыг оролдсон аймшигтай дарамт шахалттай нүүр тулсан юм.

Гэхдээ энэхүү захидалд асуудлын гол нь хуучин шашны тогтолцоогоо орхиж, түүнтэй дүйцэх өөр нэгэн тогтолцоо руу орж байгаа хэрэг биш. Харин иудейзмаас салж, Христийг сонгох тухай юм. Бичээч үүнийг сүүдрээс бодит зүйл рүү, зан үйлээс жинхэнэ утга учир уруу, түр зуурынхаас мөнхийн зүйл рүү, сайн гэсэн бүхнээс хамгийн шилдэгт хүрч буй тухай хэмээн дүрсэлсэн.

Мөн Христийг сонгосон хүмүүс олонд таалагддаг байдлаас үл таалагдах руу, олонхоос цөөнх рүү, хавчигчдаас хавчигдагсад руу шилждэг ажээ. Үүнээс болоод олон ноцтой асуудал үүсдэг.

Энэхүү захидлыг иудей угшилтай хүмүүст хандан бичсэн. Тэрхүү иудейчүүд нь чуулганы эхэн үед элч нар болон өөр бусад хүмүүсээс сайнмэдээг сонсож, тэдний сургаалыг баталсан Ариун Сүнсний гайхамшгуудыг харсан. Тэд сайнмэдээг гурван янзаар хүлээн авч хариу үйлдэл үзүүлсэн. Үүнд:

1. Зарим нь Эзэн Есүс Христэд итгэж дахин төрсөн.

2. Зарим нь Христитгэгч боллоо хэмээн мэдэгдэж, баптисм хүртэж нутгийн чуулганд хамрагдсан боловч Бурханы Ариун Сүнснээс дахин төрөөгүй.

3. Зарим нь авралын сайнмэдээг шууд эсэргүүцсэн.

Энэхүү захидал маань эхний хоёр бүлэг хүмүүс буюу үнэхээр аврагдсан иудейчүүд болоод үнэн итгэлгүй,

гагцхүү өнгөц, гадна талдаа Христийн нэрийг барьсан иудейчүүдийн талаар бичсэн.

Иудей хүн эцэг өвгөдийнхөө итгэлийг орхих үед түүнийг урвагч, итгэлээсээ няцагч (*мэшиummэд*) хэмээн цоллож, доорх шийтгэлүүдийг оноодог байсан. Үүнд:

- Гэр бүлд нь өв өгөхгүй байх
- Израилийн чуулганаас таслагдах
- Ажлаа алдах
- Эд хөрөнгөө алдах
- Оюун санааны дарамт ба бие махбодын тамлал үзүүлэх
- Олны дунд доромжлон гутаах
- Шоронд хорих
- Амь насыг нь хөнөөх

Мэдээж үүнээс зугтах зам үргэлж байсан. Тэрээр Христийг үгүйсгэж, иудейзм рүү эргэвэл хавчлага зогсоно. Захидлыг уншихад Христэд итгэсэн еврей хүнийг иудейзм рүү буцаахын тулд хэд хэдэн хүчтэй үзэл санааг дэвшүүлдэг байсан нь харагдана. Үүнд:

- Эш үзүүлэгчдийн баялаг өв
- Бурханы эртний ард түмний түүхэн дэх тэнгэрэлч нарын үйлчлэл
- Хууль тогтоогч Мосетэй холбоотой байдал
- Агуу цэргийн жанжин Иошуатай холбоотой байдал
- Аароны тахилчийн үйлчлэлийн яруу алдар
- Ард түмнийхээ дунд оршин суухаар Бурханы сонгосон ариун асар
- Мосегоор дамжуулан Бурханы өгсөн хуулийн гэрээ
- Ариун асарт Бурханаар тогтоогдсон эд хэрэгслүүд, гоёмсог хөшиг
- Ариун асрын үйлчлэлүүд, агуу эвлэрүүллийн өдрийн ёслол (эвлэрүүллийн өдрийг еврейгээр

Ём Кишпур гэх ба энэ нь иудей хуанлийн хамгийн чухал өдөр)

Нэгдүгээр зууны иудей хүн эртний зан заншил бүхий шашныхаа энэ бүх цог жавхланг дэлгэн үзүүлээд “Христитгэгч та нарт юу байгаа юм бэ? Бидэнд энэ бүхэн байна. Та нарт дээврийн жижигхэн дээд өрөө, нэг ширээ, дээр нь тавьсан жаахан талх, дарснаас өөр юм байна уу? Ийм зүйлийн төлөө энэ бүх агуу зүйлсийг орхилоо гэж үү?” хэмээн хоржоонтойгоор асууж байх шиг.

"Та нарт юу байгаа юм бэ?" гэдэг асуултад Еврей захидал хариулт өгдөг. Хариулт нь *Христ*. Христийн дотор бидэнд:

- Эш үзүүлэгчдээс агуу Нэгэн бий
- Тэнгэрэлч нараас агуу Нэгэн бий
- Мосегоос агуу Нэгэн бий
- Иошуагаас агуу Нэгэн бий
- Аароны тахилчийн үйлчлэлээс илүү дээр тахилчийн үйлчлэлтэй Нэгэн бий
- Илүү дээр ариун газарт үйлчилдэг Нэгэн бий
- Илүү сайн гэрээг өгсөн Нэгэн бий
- Ариун газрын эд хэрэгсэл, хөшиг зэргээр дүрслэгдсэн жинхэнэ биелэл болсон Нэгэн бий
- Ахин дахин давтан өргөдөг бух, ямааны өргөлөөс илүү нүглийг нэгэнтээ, бүрмөсөн шийдсэн, дахин давтагдашгүйгээр Өөрийгөө өргөсөн төгс Тахил бий

Одод нарны хурц гэрлээс болж үзэгдэхээ больдог шиг иудейзмын бэлгэдлүүд хийгээд сүүдрүүд нь Эзэн Есүс Христийн мөн чанар ба гүйцэтгэсэн үйл хэргийн агуу цог жавхлангийн өмнө бүдгэрч бараг үнэгүйдэн орхигддог.

Гэсэн ч хавчлага байсаар байсан. Эзэн Есүсийн дагалдагч хэмээгдэгчид маш хатуу, улам ширүүссэн эсэргүүцэлтэй тулгарсан. Жинхэнэ итгэгчдийн хувьд энэ нь урмыг нь хугалж, цөхрөөж болох учраас Бурханы

амлалтаар итгэлийг нь батжуулж, урам зориг өгөх шаардлагатай байжээ. Тэд ирж буй шагналыг бодон тэвчээртэй байх шаардлагатай байв.

Харин нэр төдий хуурамч итгэгчдийн хувьд итгэлээс урвах аюул байлаа. Христийг хүлээн авсан хэмээн мэдэгдсэнийхээ дараа тэд Христийг үгүйсгэж, зан үйлд төвлөрсөн хуучин шашны тогтолцоо руугаа эргэж болзошгүй байсан. Энэхүү үйлдэл нь үнэн чанартаа Бурханы Хүүг гишгэлэн, цусыг нь гутааж, Ариун Сүнсийг доромжилсон доромжлол юм. Ийм санаатайгаар үйлдсэн нүгэлд гэмшил ч, уучлал ч байхгүй. Энэ нүглийг Еврей захидалд ахин дахин сэрэмжлүүлсэн байдаг. 2:1 дүгээр эшлэл дээр энэхүү нүглийг Христийн мэдээнээс *гулсаад өнгөрөх* хэмээн дүрсэлжээ. 3:7-19 дээр үүнийг *тэрслэл* буюу зүрхээ хатууруулах нүгэл гэж хэлсэн. 6:6 дээр үүнийг *дараа нь урвах* гэж нэрлэсэн. 10:25 дээр харин *хамтран цуглахыг умартах* гэж хэлсэн. 10:26 дээр *зоргоороо нүгэл үйлдэх* буюу санаатайгаар нүгэл үйлдэх гэж хэлдэг. 12:16 дээр үүнийг *ууган хүүгийн эрхээ хоолоор арилжих* хэмээсэн. Эцэст нь, 12:25 дээр тэнгэрээс айлдсан Нэгэнийг *үл хэрэгсэх* гэж хэлсэн. Энэ бүх сэрэмжлүүлэг нь *итгэлээс урвах* нүглийг янз бүрийн талаас нь сануулсан сануулга юм.

Еврейчүүдэд бичсэн захидал нэгдүгээр зууны чуулганд хэрэгтэй байсан шиг өнөөдөр ч бидэнд олон зүйлийг хэлж чадна. Христийн дотор бидэнд ямар их ивээл ерөөл, мөнхийн давуу эрх өгөгдсөнийг байнга санаж, эсэргүүцэл, хавчлага, зовлон дунд тэвчээртэй байх урам зориг бидэнд хэрэгтэй. Түүнээс гадна Эзэн сайн гэдгийг амсаж үзсэнийхээ дараа христитгэлийг орхиж, зан үйлд төвлөрсөн шашин руу буцах аюулыг нэр төдий итгэгчдэд ч сануулах шаардлага байдаг. Еврей номын зорилго энэ билээ.

ТОЙМ

I. ХРИСТ ХҮНИЙХЭЭ ХУВЬД БҮГДЭЭС АГУУ (1:1-4:13)

А. Христ эш үзүүлэгчдээс агуу (1:1-3)

Б. Христ тэнгэрэлч нараас агуу (1:4-2:18)

В. Христ Мосе, Иошуа хоёроос агуу (3:1-4:13)

II. ХРИСТ ТАХИЛЧИЙН ХУВЬД БҮГДЭЭС АГУУ (4:14-10:18)

А. Христийн Тэргүүн Тахилчийн үүрэг Аароны тахилчийн үүргээс агуу (4:14-7:28)

Б. Христийн үйлчлэл Аароныхаас агуу (8-р бүлэг)

В. Христийн өргөл Хуучин гэрээний тахилуудаас агуу (9:1-10:18)

III. СЭРЭМЖЛҮҮЛЭГ БА ЯТГАЛГА (10:19-13:17)

А. Христийг голж, дорд үзэхгүй байхыг сэрэмжлүүлсэн нь (10:19-39)

Б. Хуучин гэрээний жишээнүүдээр итгэлээ батжуулах ятгалга (11-р бүлэг)

В. Христийн дотор найдах ятгалга (12 дугаар бүлэг)

Г. Христитгэгч хүнд нийцэх сүнслэг, сайн чанаруудын тухай ятгалга (13:1-17)

IV. ТӨГСГӨЛИЙН ЕРӨӨЛ (13:18-25)

ТАЙЛБАР

1. ХРИСТ ХҮНИЙХЭЭ ХУВЬД БҮГДЭЭС АГУУ (1:1-4:13)

А. Христ эш үзүүлэгчдээс агуу (1:1-3)

1:1 Еврейчүүдэд бичсэн захидал шууд гол санаандаа оржээ. Шинэ гэрээнд ингэж эхэлдэг захидал өөр байхгүй. Ямар нэг оршил, мэндчилгээгүйгээр бичээч шуудхан л хэлэх гэсэн сэдэв рүүгээ оржээ. Эзэн Есүс Христийг бүхний дээр оршигч гэдгийг хэлэхийг ариун цухлаар тэсгэлгүй яарч байсан мэт харагдана.

Бичээч эхлээд **эш үзүүлэгчдээр** дамжуулан өгсөн илчлэлийг Хүүгийнхээ дотор өгсөн Бурханы илчлэлтэй харьцуулсан. **Эш үзүүлэгчид** бол Бурханаас илчлэгдсэн үгийг авч Бурханы өмнөөс ярьдаг Иеховагийн хүндэт зарц нар билээ. Тэдний үйлчлэлийн сүнслэг баялаг Хуучин гэрээнд хадгалагдан үлджээ.

Гэхдээ тэдний үйлчлэл бүрэн бүтэн биш ээ. Бурхан эш үзүүлэгч болгонд тодорхой хэмжээний илчлэл өгсөн боловч аль нь ч бүрэн бүтэн байсангүй.

Тэдэнд илчилсэн үнэн нь хэсэгчлэн, үе шаттайгаар өгөгдсөн төдийгүй хүмүүст уг үгийг хүргэхийн тулд **янз бүрийн** арга ашигласан байдаг. Тэд үнэнийг хуулиар, түүхээр, шүлгээр, эш үзүүлэгээр танилцуулсан. Заримдаа амаараа, заримдаа бичгээр, заримдаа үзэгдлээр, зүүдээр, бэлгэ тэмдгээр, мөн үйл хөдлөлөөр дамжуулан илэрхийлж байв. Гэхдээ ямар ч арга ашигласан иудей хүмүүст өгсөн Бурханы анхны илчлэлүүд дутуу, анхан шатных байсан бөгөөд бага багаар нэмэгдэж, олон янзаар өгөгдөж байсан.

1:2 Хуучин гэрээний үед өгөгдсөн, янз бүрийн, түр зуурын, хэсэгчилсэн, хоорондоо ялгаатай илчлэлүүд нь Бурханы **Хүүгийн** дотор өгөгдсөн эцсийн илчлэлээр бүрэн

бүтэн болж, утга санаа нь тодорчээ. Эш үзүүлэгчид нь Бурханы үгийг дамжуулах суваг байсан. Харин Эзэн Есүс Христ нь хүн төрөлхтөнд хандсан Бурханы эцсийн илчлэл болсон юм. “Бурханыг хэн ч, хэзээ ч хараагүй. Харин Эцгийн өвөр дэх цорын ганц Төрөгч болох Бурхан нь Түүнийг таниулсан юм.” (Иох 1:18) Эзэн Есүс Өөрийнхөө талаар “Намайг харсан нь Эцэгийг харсан” (Иох 14:9) гэж хэлсэн. Христ Бурханы *өмнөөс* яриад зогсохгүй, мөн Бурханы *хувиар* Бурхан Өөрөө ярьж буй мэт ярьсан юм.

Бурханы Хүүг эш үзүүлэгчдээс хязгааргүй агуу гэдгийг цохон тэмдэглэхийн тулд бичээч Түүнийг бүхнийг өвлөн авах **Өв залгамжлагч** хэмээсэн. **Бүхний өв залгамжлагч** гэдэг нь Бурханы томилгоогоор Тэрээр бүх ертөнцийг эзэмшдэг бөгөөд удахгүй бүх ертөнцийг захирна гэсэн үг.

Бурхан Түүгээр дамжуулан **ертөнцийг бүтээсэн**. Есүс Христ бол Бүтээгч юм. Тэрээр сансар огторгуй, од эрхэс, агаар мандал, газар дэлхий, хүн төрөлхтнийг бүтээгээд, бүх үеийнхэнд зориулсан Бурханы төлөвлөгөөг Биелүүлэгч юм. Бүтээгдсэн бүхэн, сүнслэг хийгээд материаллаг юм бүр Түүгээр бий болсон.

1:3 Тэрээр Бурханы цог **жавхлангийн гэгээ** юм. Өөрөөр хэлбэл, Бурхан Эцэгийн дотор оршдог бүхий л төгс төгөлдөр нь Түүний дотор ч мөн оршдог. Эзэн Есүс Христ бол Бурханы **цог жавхлангийн** туяа мөн. Бурханы бүх ёс суртахууны болон сүнслэг яруу алдар Есүс Христийн дотроос харагддаг.

Түүгээр ч зогсохгүй Эзэн Есүс Христ бол Бурханы **мөн чанарын бодит илрэл** мөн. Мэдээж энэ нь бие махбодын адил төсөөг хэлээгүй. Яагаад гэвэл Бурхан бол Сүнс юм. Харин Есүс Христ нь Эцэг Бурхантай бүх талаар яг адил, Түүнийг төлөөлдөг гэсэн үг. Өөрөөр хэлбэл, адил төстэйгөөс илүү Хүү Эцэгийг төгс илэрхийлдэг. Хүү нь Бурхан бөгөөд Бурханы үг ба үйлсээр хүн төрөлхтөнд Бурханыг илчилсэн.

Эзэн Есүс Христ нь Бурханы эрх мэдлийн үгээр орчлон ертөнцийг тогтоон барьж байдаг. Тэрээр үгээрээ анх ертөнцийг буй болгосон (Евр 11:3). Одоо ч мөн үгээ айлдаж, амь амьдралыг тэтгэж, түмэн бодисыг хамтад нь тогтоон барьж, орчлон ертөнцийг эмх журамд нь байлгадаг. Бүх юмс Түүгээр оршин тогтнодог (Кол 1:17). Энд шинжлэх ухааны нэгэн том асуудлын тайллыг хэлж өгчээ. Эрдэмтэд, бөөмсийг хамтад нь нэгтгэн барьж байдаг зүйлийг олох гэж хичээдэг. Гэтэл энд хэлсэнчлэн, Эзэн Есүс Христ бүгдийг хүчирхэг эрх мэдэлт **үгээрээ** тогтоон барьж байдаг гэжээ.

Гэвч Аврагч Эзэний маань удаах цог жавхлан тэдгээрийн дундаас хамгийн гайхалтай нь билээ. **Тэрээр нүглийн ариусгалыг гүйцээсэн.** Орчлон ертөнцийн Бүтээгч, Тогтоон Тохинуулагч нь нүглийг Үүрэгч болжээ. Тэрээр орчлон ертөнцийг бүтээхийн тулд зөвхөн үгээ айлдсан. Орчлон ертөнцийг тогтоон барьж удирдан залахын тулд мөн үгээ айлддаг. Яагаад гэвэл, үүнд ямар нэг ёс суртахууны асуудал байдаггүй. Харин бидний нүглийг нэг удаагийн үйлдлээр бүр мөсөн зайлуулахын тулд Голготын толгод дээрх загалмай дээр амиа өргөх ёстой байжээ. Бүхнийг захирагч Эзэн доош бууж, тахилын Хурга болжээ. Юутай агуу үйл явдал вэ! *“Ийм гайхалтай, тийм ариун хайрын өмнө би амь бие, сэтгэл сүнс бүхнээ Түүнд өргөхөөс өөр замгүй”* хэмээн Исаак Уотс магтуу дуундаа шүлэглэжээ.

Эцэст нь, Эзэн Есүс Христийг сэнтийд заларч, өргөмжлөгдсөн Эзэн гэдгээр бидэнд танилцуулж байна. Тэрээр **өндөрт байгч Сүр жавхлантын баруун гарт залрав.** Залрах гэдэг нь амарч суугаа дүрслэл юм. Гэхдээ ажлын дараах амралт биш. Харин ажлаа дуусгасандаа сэтгэл хангалуун байгаа амралт юм. Христ золилтын үйл хэргийг төгс гүйцээснийг Түүний энэ байр байдал илэрхийлдэг.

Сүр жавхлантын баруун гар нь хүндлэл, эрх дархыг илтгэдэг (Евр 1:13). Христ ялгуусан ялалтыг байгуулсан учраас Бурхан Түүнийг өндөрт өргөмжилжээ. **Баруун гар** нь эрх мэдэл (Мт 26:64), баяр хөөрийг (Дуу 16:11) илэрхийлдэг. Аврагч Эзэний хадаасны сорвитой гар орчлон ертөнцийн дээгүүр ноёрхох эрх мэдлийн очирт таягийг атгаж байна (1Пт 3:22).

Бичээч, Эзэн Есүсийн тухай өгүүлэхдээ бүтээлээс эхлэн Голгота, дараа нь цог жавхланд орсон үеийг нь дурсжээ. Ингэхдээ эш үзүүлэгчдийг орхигдуулсан харагдана. Эш үзүүлэгчид тухайн цаг үедээ чухал ач холбогдолтой байсан боловч эдүгээ сүүдэр мэт замхарчээ. Тэд ирж буй Мессиаг гэрчилсэн (Үйл 10:43). Одоо Мессиа ирчихсэн учраас эш үзүүлэгчид баяртайгаар тайзан дээрээс бууж, агуу Нэгэнд баяртайгаар зай тавьж өгч байна.

Б. Христ тэнгэрэлч нараас агуу (1:4-2:18)

1:4 Захидлын дараагийн үзэл санаа нь Христийг **тэнгэрэлч** нараас агуу гэдгийг нотлон харуулдаг. Иудейчүүд тэнгэрэлч нарын үйлчлэлийг өндрөөр үнэлдэг учраас энэ яриа тун чухал л даа. Тэнгэрэлч нар хуулийг өгсөн (Үйл 7:53; Гал 3:19). Бурханы эртний ард түмний түүхэнд тэнгэрэлч нар олонтоо үзэгдсэн байдаг. Еврей хүн иудейзмийг орхиод Христийг сонгох үедээ өөрийн үндэсний хийгээд шашны өвийн энэ чухал онцлогоос өөрийгөө тасалж байна гэж үздэг байв. Гэтэл үнэндээ Христийг олсон нэгэн тэнгэрэлч нараас агуу Нэгэнийг олсон юм. Христ хоёр талаар тэнгэрэлч нараас агуу. Тэр бол Бурханы Хүү (1:4-14), мөн Хүний Хүү (2:5-18).

Христ тэнгэрэлч нараас илүү эрхэм нэрийг өвлөсөн шигээ тэднээс илүү эрхэм дээд болсон юм. Энд эхлээд Түүний олж авсан эрхэм дээд чанарыг, дараа нь төрөлх буюу угаас байсан эрхэм дээд чанарыг ярьж байна.

Тэрээр үхлээс амилж, тэнгэр өөд одож, Эзэн ба Христийн хувьд өргөмжлөгдөн эрхэм дээд хүндэтгэлийг олж авсан. Есүс хүн болж төрөхдөө үхлийн зовлонг амсахын тулд тэнгэрэлч нараас арай дорд болгогдсон (2:9). Харин Бурхан Түүнийг өргөмжилж, хамгийн дээд яруу алдар дотор сэнтийд залсан.

Түүний төрөлх эрхэм дээд чанар, агуу байдал нь Бурханы Хүүгийн хувиар Бурхантай мөнхөд харилцаатай байсантай холбоотой. Илүү **эрхэм дээд нэр** нь Хүүгийн нэр юм.

1:5 Мессиаг Бурханы Хүү гэдгийг тодотгосон хоёр эшлэлийг Хуучин гэрээнээс энд эш татжээ. Нэг дэх нь, Дуулал 2:7-д Бурхан Түүнийг Хүү гэж **“Чи бол Миний Хүү. Өнөөдөр Би Чамайг төрүүлсэн”** хэмээн дууджээ. Нэг талаар, Христ бол мөнхийн Хүү юм. Нөгөө талаар, Тэрээр хүний биед ирж, Бурханы Хүү болж төрсөн. Гуравт, Тэрээр үхлээс амилахдаа төрсөн буюу үхэгсдээс анх төрсөн нь юм (Кол 1:18). Паул энэ эшлэлийг Писидийн Антиохт синагогт байхдаа эш татаж, Христ анх ирсэн тухай өгүүлэхдээ ашигласан (Үйл 13:33).

Гол нь энд, Бурхан хэзээ ч тэнгэрэлч нараа Өөрийн **Хүү** хэмээн дуудаж байгаагүйг хэлэхийг зорьжээ. Тэнгэрэлч нарыг бөөнд нь Бурханы хөвгүүд (Иов 1:6, Дуу 89:6) гэж нэрлэдэг ч энэ нь ердөө Бурханы бүтээл гэсэн утгатай үг юм. Харин Эзэн Есүсийг Бурханы Хүү гэж нэрлэсэн нь Бурхантай мөн чанараараа эрх тэгш гэдэг санааг илэрхийлдэг.

Хоёр дахь эшлэл нь 2Самуел 7:14 дээрх **“Би Түүний Эцэг болж, Тэр Миний Хүү болно”** гэсэн үг. Энэ үгс Соломоны тухай хэлсэн мэт харагддаг. Гэвч Ариун Сүнс энэ үгсийг Давидын агуу Хүүд хамааралтай гэж тодруулан харуулж байна. Энд гарч буй гол санаа нь мөн л Бурхан тэнгэрэлчид хэзээ ч ингэж хэлээгүй тухай юм.

1:6 Христ тэнгэрэлч нараас агуу гэгдэх гуравдах шалтгаан бол Христ мөргөл хүндэтгэлийг хүртэх зохистой Нэгэн. Харин тэнгэрэлч нар нь Түүний зараал, зарц нар билээ. Бичээч энэ санаагаа батлахын тулд Дэд хууль 32:43 (Септуагинт, Мөхсөн тэнгисийн хуйлмал ном) болон Дэд хууль 97:7 (NKJV-ийн хөлийн тайлбарыг үз)-г эш татжээ.

Дэд хууль номын эшлэлд **анх төрсөн Түүнийг дэлхийд Тэр дахин авчрах** үеийг өгүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Христийн хоёр дахь ирэлтийг ярьсан байна. Тэр үед **тэнгэрэлч нар** олны өмнө Христэд мөргөнө. Эндээс харахад Христ Бурхан мөн болж таарч байна. Жинхэнэ Бурханаас өөр зүйлд мөргөх нь шүтээн шүтлэг билээ. Гэтэл Бурхан, Эзэн Есүс Христэд мөргөхийг **тэнгэрэлч нартаа** тушаасан байна.

Анх төрсөн гэдэг нь цаг хугацааны хувьд эхэнд (Лк 2:7) эсвэл зэрэг дэв хүндлэлийн хувьд тэргүүнд (Дуу 89:27) гэсэн утгатай. Хоёр дахь утга нь энэ эшлэлээс гадна Ром 8:29, Колоссай 1:15, 18 дээр гардаг.

1:7 Бурхан эрхэм дээд Хүүтэйгээ эсрэгцүүлэн **тэнгэрэлчүүдээ салхи галын дөл болгодог** хэмээжээ. Харин Хүүгийнхээ талаар тийм зүйл огт яриагүй. Хүү бол **тэнгэрэлчүүдийн** Бүтээгч бөгөөд Захирагч мөн. Тэнгэрэлч нар нь Түүний хүслийг **салхи** мэт хурдтай, **гал** мэт халуун сэтгэлээр дуулгавартай гүйцэлдүүлдэг.

1:8 Одоо **Хүүгийн** цацарсан яруу алдар, юутай ч харьцуулшгүй цог жавхлангийн тухай өгүүлнэ. Юун түрүүнд, Бурхан Өөрөө, Хүүг **Бурхан** хэмээн тодотгосон. Дуулал 45:6 дээр Эцэг Бурхан Мессиагийн тухайд, **“Бурхан минь, Таны сэнтий мөнхийн мөнх”** хэмээжээ. Христ бол Бурхан мөн гэдгийг энд ч бас эргэлзээгүй тодорхой баталжээ. Уг баталгаа Хуучин гэрээний еврей эх бичвэрээр нотлогдож байна. (Еврей номын бүлэг тус бүр дор хаяж нэг удаа Хуучин гэрээнээс эш татсан байдаг.)

Хүү бас мөнхийн Хаан билээ. Түүний сэнтий **мөнхийн мөнхөд** тогтоно. Түүний хаанчлал далайгаас далайд хүртэл тэлнэ. Тэр цагт сар мандаж, дахин хэзээ ч жаргахгүй болтол, мөнхөд үргэлжилнэ.

Хүү бол шударга Хаан. Дуулаач Түүнийг **үнэн зөвийн очирт таягтайгаар** дүрсэлсэн нь хаанчлалынх нь шударга, зөвт байдлыг илэрхийлсэн юм.

1:9 Зөвт байдлыг үргэлж хайрласан бөгөөд ёс бусыг үзэн ядсан гэдгээс Хүүгийн зан чанар шулуун шударга болохыг тод харуулдаг. Энэ үг юун түрүүнд дэлхий дээр амьдарсан эхний гучин гурван жилийнх нь амьдралыг хэлж байна. Тэр үед Бурханы мэлмий зан чанараас нь ямар ч өө сэв, үйл хэргээс нь ямар ч алдаа мадаг олоогүй билээ. Ингэж Тэр хаанчлах бүрэн зохистой гэдгээ батлан харуулсан юм.

Хувийн тэр сайхан чанаруудынх нь улмаас Бурхан Түүнийг **нөхдийнх** нь **дээгүүр баяр баяслын тосоор тосолжээ**. Өөрөөр хэлбэл, Бурхан өөр ямар ч оршигчдоос дээгүүр бүрэн эрхт байр суурийг Христэд соёрхсон гэсэн үг. Энд дурдагдаж буй **тос** болбоос Ариун Сүнсний бэлгэдэл юм. Христ хэн хүнээс илүүгээр Ариун Сүнсээр бялхсан юм (Иох 3:34). **Нөхөд** гэж Түүнтэй холбогдсон бүх хүнийг хэлж байна. Гэхдээ Түүнтэй эн тэнцүү гэсэн үг биш. Үүнд тэнгэрэлч нарыг ч оруулан ойлгож болох байх. Гэхдээ юу юунаас илүүтэй иудей ахан дүүсийг нь хэлсэн байж таарна.

1:10 Эзэн Есүс Христ бол тэнгэр газрын Бүтээгч. Дуулал 102:25-27 энэ тухай өгүүлсэн. Тэрхүү дуулалд Мессиа, “Бурхан минь ээ, ...намайг бүү аваач” (24-р эшлэл) хэмээн залбирсан. Гетсемани болон Голгота дээр өргөсөн энэ залбирлын хариуд Эцэг Бурхан, “Эрт үед дэлхийн суурийг Та тавьсан. Тэнгэрс ч мутрын тань бүтээл юм” хэмээжээ.

Энэхүү 10 дугаар эшлэлд Бурхан Хүүгээ Эзэн гэх дээд нэрээр дуудаж буйг анзаараарай. **Эзэн** бол Иехова (ИАВЭ) юм. Дүгнэж хэлбэл, Шинэ гэрээний Есүс бол Хуучин гэрээний Иехова мөн.

1:11, 12 Энэ хоёр эшлэлд бүтээлийн зуурдын чанарыг Бүтээгчийн мөнхийн чанартай харьцуулж байна. Бурханы бүтээсэн юмс **мөхөх боловч** Бурхан Өөрөө хувиршгүйгээр оршиж **үлдэнэ**. Нар сар, од эрхэс, уул толгод, ус далай мөнхийн юм шиг харагдавч муудаж доройтон, устах тавилантай бүтээгдсэн билээ. Дуулаач тэднийг **бүтээлэгтэй** адилтгажээ. Бүтээлэг муудаж элэгдэхээр нь эвхэж хураан, эцэст нь илүү сайнаар сольдог.

Мөнх цаст уул нурууд, үдэш шингэх жавхлант наран, тэнгэрт түгсэн түмэн оддыг хараарай. Дараа нь тэдний тухай үнэнийг өчсөн яруу, сүр жавхлант хэмнэл бүхий хүчит үгсийг сонсоно уу. **Та тэднийг бүтээлэг мэт ороож, тэд хувцас адил бас өөрчлөгдөнө. Харин Та хэвээрээ. Таны он жилүүд эс төгсөнө.**

1:13 Хуучин гэрээнээс эш татсан дараагийн үг (Дуу 110:1) Хүүгийн хамгийн эрхэм дээд Нэгэн болохыг баталж өгдөг. Уг дуулалд Бурхан, “**Дайснуудыг чинь Би Чиний хөлийн гишгүүр болгох хүртэл Миний баруун талд залрагтун**” хэмээн Мессиаг дуудсан. “Тэнгэрэлч нарын алинд нь ер нь Бурхан ийм үг хэлсэн бэ?” гэсэн асуулт тавигддаг. Мэдээж алинд нь ч тэгж хэлээгүй.

Бурханы **баруун талд заларна** гэдэг бол хамгийн дээд хүндлэл, хэмжээ хязгааргүй эрх мэдлийн байр суурийг эзэлнэ гэсэн үг юм. Бүх дайснуудыг нь **хөлийн гишгүүр** болгох гэдэг нь бүх дайснууд Түүний эрхшээлд орж, бүхнийг захирах дээд эрх мэдэлтэй болно гэсэн утгатай.

1:14 Тэнгэрэлч нарын үүрэг болбоос захирах бус, үйлчлэхэд оршдог. Тэд болбоос **авралыг өвлөгчдөд** үйлчлэхээр Бурханаар бүтээгдсэн **сүнснүүд** мөн. Үүнийг хоёр утгаар ойлгож болно. Нэгт, тэнгэрэлч нар нь итгэж

аврагдаагүй хүмүүст үйлчилдэг. Хоёрт, тэнгэрэлч нар нь нүглийн хүч ба шийтгэлээс чөлөөлөгдсөн ч нүгэлт энэ дэлхийд амьдарч буй хүмүүст үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, дэлхий дээр амьдарч байгаа итгэгчдэд үйлчилдэг.

Тэгэхээр “хамгаалагч тэнгэрэлч” байдаг гэж үзэж болох нь ээ. Ийм үнэнийг сонсоод бид яагаад гайхах ёстой гэж? Учир нь муу ёрын сүнснүүд Бурханы сонгосон хүмүүсийн эсрэг тасралтгүй тэмцдэг нь үнэн шүү дээ (Еф 6:12). Гэтэл **авралд** дуудагдсан хүмүүсийг сахин хамгаалдаг тэнгэрэлч нар байдаг нь тийм гайхмаар хэрэг гэж үү?

Гэхдээ хамгаалагч тэнгэрэлч нар байдаг тухай бус, харин энэ хэсгийн гол санааг эргэн анхаарах хэрэгтэй байна. Энд дурдаж буй гол санаа нь тэнгэрэлч нар Бурханы Хүүгээс дорд гэж хэлэхийг зорьсон юм. Бүх ертөнцийн Захирагч Эзэнтэй харьцуулахад тэнгэрэлч нар бол Түүний үйлчлэгч зарц нар юм.

2:1 Христ бол Бурханы Хүү учраас тэнгэрэлч нартай харьцуулшгүй дээгүүр Нэгэн гэдэг санаагаа бичээч дуусгалаа. Цааш нь Христийг Хүний Хүү болохын хувьд дээдийн Дээд гэдгийг ярихаас өмнө тэрээр түр азнаж, захидалд бичсэн хэд хэдэн ноцтой анхааруулгын эхнийхийг хэлэх гэж байна. Эхлээд, сайнмэдээний сургаалаас **гулсаад өнгөрчихгүй** байгаарай гэж анхааруулав.

Бэлгийг Өгөгч хийгээд өгч буй бэлэг хоёулаа агуу учраас сайнмэдээг сонсогч нь сайнмэдээнд нухацтай хандах учиртай. Христ хэмээх Хүнээс холдож хуучин ёс заншил, дүрс бэлгэдлийн шашинлаг байдал руу буцаж гулсах аюул үргэлж байдаг. Энэ нь итгэлээс урвах нүгэл рүү гулсан орох аюул юм. Итгэлээс бүрмөсөн няцаж урвах нь эргэн гэмших боломжгүй, аймшигт нүгэл билээ.

2:2 Түүхэнд нь чухал үүрэг гүйцэтгэсэн тэнгэрэлч нарын үйлчлэл, үйл ажиллагаанд иудейчүүд онцгой ач холбогдол өгдөг гэдгийг бид дээр өгүүлсэн. Энэ бүхнээс

магадгүй хамгийн тод жишээ нь нь хууль өгөгдсөн явдал юм. Хуулийг өгөхөд үй түмэн тэнгэрэлч нар байлцсан юм (Дх 33:2; Дуу 68:17). Хуулийг **тэнгэрэлч нараар хэлүүлж** өгсөн нь үнэн. Ийн өгөгдсөн хууль хүчин төгөлдөр байсан нь ч үнэн. Хуулийг зөрчиж, дуулгаваргүй байсан бүхэн зохих шийтгэлээ хүртсэн нь ч үнэн. Үүнийг маргаангүй хүлээн зөвшөөрдөг.

2:3 Тэгвэл одоо санаа нь жижгээс том болж байна. Хэрэв зээ, хуулийг зөрчигсөд шийтгүүлсэн юм бол сайнмэдээг **үл хайхрагсдыг** ямар хувь тавилан хүлээж байгаа бол? Хууль нь хүний юу хийх ёстойг хэлдэг. Сайнмэдээ нь Бурхан юу гүйцэлдүүлснийг өгүүлдэг. Хуулиас нүглийн мэдлэг ирдэг. Сайнмэдээнээс **авралын** мэдлэг ирдэг.

Ийм агуу авралыг үл хайхрах нь хуулийг зөрчсөнөөс ч илүү ноцтой хэрэг мөн. Хуулийг Бурхан тэнгэрэлчээрээ дамжуулан Мосед өгч, Мосе нь израильчуудад гардуулсан. Харин сайнмэдээг Эзэн Есүс Христ Өөрөө шууд айлдсан. Түүгээр ч зогсохгүй, элч нар хийгээд Аврагч Эзэнийг биечлэн **сонссон** хүмүүс сайнмэдээг анхны итгэгчдэд **баталж** өгсөн.

2:4 Бурхан Өөрөө сайнмэдээг **тэмдэг хийгээд гайхамшгаар, янз бүрийн хүчит үйлс болон Ариун Сүнсний бэлгүүдээр гэрчилсэн.** Тэмдэг гэж сүнслэг үнэнийг батлах зорилгоор Эзэн Есүс болон элч нарын үйлдсэн гайхамшгууд юм. Жишээ нь, таван мянгыг хооллосныхоо (Иох 6:1-14) дараа амийн Талхны тухай сургаалыг айлдсан (Иох 6:25-59). **Гайхамшиг** гэж эргэн тойрныхоо хүмүүсийг тэр дор нь алмайруулах зорилготой ер бусын үйлс юм. Лазарыг үхлээс амилуулсан нь үүний нэг тод жишээ (Иох 11:1-44) мөн. **Хүчит үйлс** гэж байгалийн хуулийг давж гарсан ер бусын хүч билээ. **Ариун Сүнсний бэлэг** гэж хүний төрөлх чадвараас бүрэн давсан байдлаар ярьж, үйлдэх, дээрээс өгөгдсөн чадвар юм.

Энэ бүх гайхамшгийн зорилго нь сайнмэдээний үнэнийг батлах явдал байлаа. Ялангуяа итгэхийн тулд тэмдэг шаарддаг иудейчүүдийг итгүүлэх зорилготой байв. Шинэ гэрээ бичмэл хэлбэрт орсны дараа үнэнийг батлах зорилго бүхий гайхамшгуудын шалтаг, шаардлага нь дууссан гэж үзэх үндэслэл бий. Гэхдээ Ариун Сүнс одоо үед гайхамшиг *огт* хийхгүй гэж хэлэх ямар ч үндэслэл байхгүй.

Хүслийнхээ дагуу гэсэн нь гайхамшгуудыг Ариун Сүнс Өөрийн хүсэл таалал, сонголтоор өгдгийг илтгэж байна. Уг гайхамшгууд нь Бурханы бүрэн эрхийн дагуу өгөгддөг бэлэг юм. Хүний хүсэл, шаардлага үүнд ямар ч хамаагүй. Залбирлаа гээд өгөгдөх албагүй. Учир нь Бурхан гайхамшиг үйлдэнэ гэж амлаагүй.

2:5 Христ нь Бурханы Хүү болохын хувьд тэнгэрэлч нараас дээд Нэгэн гэдгийг эхний бүлэгт үзсэн. Тэгвэл одоо Хүний Хүү болохын хувьд дээд Нэгэн гэдгийг үзэх гэж байна. Иудей сэтгэхүйд Христ хүмүүн биеийг олж төрсөн нь санаанд багтамгүй хэрэг боловч загалмайд хадагдан үхэж дорд болгогдсон нь шившигтэй хэрэг юм. Үүнийг бодож дараах хэсгийг уншвал зохиогчийн илэрхийлэх гэсэн утга санааг ойлгоход тустай. Иудейчүүдийн хувьд Есүс ердийн нэг хүн байсан тул тэнгэрэлч нараас зиндаа доогуур байдаг. Харин дараах эшлэлүүдээс харвал Есүс *Хүн болохын хувьд ч* тэнгэрэлч нараас дээгүүр билээ.

Нэгт, ирээдүйн хүмүүс оршин суух **ертөнцийг** Бурхан **тэнгэрэлчүүдэд** захируулна гэж тунхаглаагүй. **Ирэх ертөнц** гэдэг нь эш үзүүлэгчдийн олонтоо ярьсаар ирсэн, энх амгалан, хөгжил цэцэглэлд хүрсэн алтан үеийг хэлдэг. Бид үүнийг мянган жилийн хаанчлал гэж нэрлэдэг.

2:6 Дэлхий дахиныг эцсийн эцэст тэнгэрэлчүүдэд бус, хүмүүнд захируулна гэдгийг нотлон харуулахын тулд Дуулал 8:4-6 эшлэлийг эш татжээ. Хүн сул дорой ч Бурхан

түүнд **санаа тавьдаг**. Хүн үнэ цэнгүй санагдавч Бурхан түүнийг **анхаардаг**.

2:7 Бүтээлийн зэрэг дэвийн хувьд хүмүүн **тэнгэрэлч нараас арай доохно** байр сууринд тавигдсан. Энэ нь мэдлэг, эрх мэдэл, хөдлөх орчны хувьд илүү хязгаарлагдмал гэсэн үг. Мөн хүн үхэлд тушаагдсан. Гэвч Бурханы зорилгын талаас харвал, хүн **алдар хүндийн титмийг өмсөх** хувь тавилантай. Хүмүүний бие махбод, оюун санааны хязгаарлагдмал байдлын ихэнх нь хожим арилж, хүн газар дэлхий дээр өргөмжлөгдөн, ноёрхох болно.

2:8 Хожмын тэр өдөр Бурхан бүх зүйлийг хүний удирдлага **дор** тавина. Тэнгэрэлчүүдийн түг түмд, амьтдын ертөнц, жигүүртэн шувууд, загас жараахай, гараг эрхсийн систем, бүтээгдсэн юмс бүхэлдээ хүмүүний захиргаанд орно.

Энэ нь Бурханы хүн төрөлхтөнд зориулсан анхны зорилго байв. Хүнийг бүтээхдээ Бурхан “Үржиж, олширцгоог! Газар дэлхийг дүүргэж, түүнийг эзэмшицгээг! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дээр хөлхөгч амьтан бүхнийг захирцгааг!” (Эх 1:28) гэж хэлсэн нь үүний тод илэрхийлэл юм.

Тэгвэл бүх юм хүний **эрхэнд орсныг** бид яагаад **хараахан үзээгүй** байна вэ? Учир нь нүглийн улмаас хүн захирах эрх мэдлээ алдсан юм. Адамын нүгэл бүтээлийг бүхэлд нь хараал дор оруулсан юм. Номхон дөлгөөн амьтад догшин хэрцгий болов. Газраас шарилж, халгай, хогийн ургамал ургадаг болов. Ийнхүү хүн байгалийг хянан захирч, удирдахад төвөгтэй болжээ.

2:9 Харин Хүний Хүү дэлхийг захирахаар эргэн ирэх үед хүмүүний захиргаа дахин сэргэнэ. Есүс Хүн болохын хувьд Адамын алдсан бүхнийг сэргээж, түүнээс ч илүүг авчирна. Хэдийгээр яг одоо бүх зүйл хүний эрхшээлд

бүрэн орсныг харахгүй байгаа ч бид **Есүсийг хардаг** бөгөөд хүний ирээдүйн ноёрхлын түлхүүр Есүст оршдог.

Эзэн Есүс ахархан хугацаанд, тодруулбал газар дэлхий дээр гучин гурван жил амьдарсан тэр хугацаандаа **тэнгэрэлч нараас арай дорд болгогдсон**. Тэрээр тэнгэрээс бууж, Бетлехем, Гетсемани, Габбата, Голгота хүртэл явж, эцэст нь булшинд орсон нь дорд болгогдсон алхам бүрийг нь илтгэнэ. Харин эдүгээ Тэр **цог жавхлан хийгээд хүндэтгэлийн титэм өмсжээ**. Энэ өргөмжлөл нь Түүний зовлон хийгээд үхлийнх нь үр шим юм. Загалмай Түүнийг титэм рүү хөтөлсөн.

Христ **хүн бүрийн төлөө үхлийг амсах** нь Бурханы нигүүлслийн зорилго байлаа. Аврагч маань биднийг төлөөлж, биднийг өмнөөс амиа өргөсөн. Өөрөөр хэлбэл, Тэрээр хүний хувьд, бас хүний төлөө амиа өгсөн. Тэрээр загалмай дээр, Өөрийн биедээ, нүглийн эсрэг шатсан Бурханы шүүлтийг үүрсэн тул Түүнд итгэгчид хэзээ ч шүүлтийг амсахгүй болжээ.

2:10 Аврагч дорд болгогдсоноор дамжуулан хүний захиргааг сэргээх нь Бурханы шударга зан чанартай яв цав нийцдэг. Нүгэл нь Бурханы тогтоосон эмх журмыг алдагдуулсан тул энэхүү эмх замбараагүй байдлыг цэгцэлж, жинхэнэ дэг журмыг тогтоохын тулд эхлээд нүглийн асуудлыг зөв шударгаар шийдэх ёстой байлаа. Нүглийг зайлуулахын тулд Христ зовж, цусаа урсгаж, үхэх нь Бурханы ариун чанарт нийцсэн хэрэг байлаа.

Энд гарч буй Мэргэн Төлөвлөгч нь **бүх юмс Түүний төлөө бөгөөд Түүгээр бүх юмс байдаг** хэмээн дүрсэлжээ. Нэгт, Тэр бол бүх бүтээлийн зорилго, гол цөм юм. Бүх юмс Түүний алдар ба тааллын төлөө бүтээгдсэн. Хоёрт, Тэр бол бүх бүтээлийн Эх үүсвэр буюу Үүсгэгч, Түүнээс ангид бүтээгдсэн зүйл гэж үгүй.

Түүний агуу зорилго бол **олон хөвгүүдийг цог жавхланд авчрах** явдал байв. Бид арчаагүй дорой гэдгээ

бодож үзвэл Тэр ийм үнэ цэнгүй бидэнд анхаарал тавьсан гэхээр гайхмаар санагдана. Харин үнэндээ Тэрээр бүх алдрын Бурхан учраас биднийг Өөрийнхөө мөнх цог жавхланд дуудсан билээ.

Биднийг алдаршуулах нь ямар үнэ өртөгтэй вэ? Тэгвэл **авралын** маань **Эхлүүлэгч** зовлонгоор төгс болгогдох ёстой байлаа. Түүний ёс суртахуун, зан чанарын тухайд Эзэн Есүс үргэлж нүгэлгүй төгс байв. Энэ тал дээр Түүнд төгс болох шаардлагатай зүйл гэж байгаагүй. Харин Тэр бидний Аврагч болохын хувьд Тэрээр зовлонгоор дамжуулан **төгс** болгогдох ёстой байжээ. Бидэнд зориулж мөнхийн золилтыг худалдан авч өгөхийн тулд бидний хүртвэл зохих нүглийн бүх шийтгэлийг Тэр Өөрийн биеэр амсав. Бид Түүний толбогүй амьдралаар аврагдаж чадахгүй. Тэр биднийг орлож амиа өргөсөн үхэл бол гарцаагүй шаардлага байсан юм.

Бурхан Өөрийнхөө үнэ цэнд нийцэх замаар биднийг аварчээ. Тэрээр бидний оронд үхүүлэхээр цорын ганц Хүүгээ илгээсэн билээ.

2:11 Дараагийн гурван эшлэл Есүсийг зуун хувь хүн гэдгийг онцлон харуулдаг. Хэрэв Есүс Адамын алдсан ноёрхлыг дахин олж авахаар ирсэн юм бол жинхэнэ хүн гэдгээ батлан харуулах шаардлагатай.

Эхлээд Есүс бол хүн гэдэг мэдэгдлийг хийжээ. **Учир нь Ариусгагч болон ариусгагдсан бүгд нэг гаралтай юм.** Нэг ёсондоо, тэд бүгд жинхэнэ утгаараа хүний мөн чанартай, хүн болохын хувьд нэг Эцэг Бурханаас гаралтай гэсэн үг.

Ариусгагч бол Христ. Тэр хүмүүсийг ертөнцөөс салган Бурханд зориулж тусгаарладаг. Ийнхүү Түүний тусгаарласан хүмүүс үнэхээр ерөөлтэй ээ!

Ариусгагдсан хүн ба юмс гэдэг нь жирийн өдөр тутмын хэрэглээнээс салган авч, Бурханы Өөрийн зорилго, алдар нэрийн төлөө ашиглахаар тусгаарлаж авсан зүйлийг хэлнэ.

Ариусгалын эсрэг нь бузартах буюу ариун бус болгох явдал юм.

Библид дөрвөн төрлийн ариусгал байдаг. Үүнд, Христ рүү эргэхийн өмнөх ариусгал, байр суурийн ариусгал, бодит амьдралын ариусгал, төгс ариусгал багтана. Энэ дөрвөн ариусгалын талаар 1Тесалоник 5:23 эшлэлд нарийвчлан тайлбарласан тул уншигч та нягтлан уншаарай.

Еврей номд ариусгал гэдэг үг гарах бүрд аль ариусгалын тухай ярьж буйг уншигч та зөв тодорхойлох хэрэгтэй.

Бурхан жинхэнэ Хүн болсон учраас Өөрийн дагалдагчдыг **ах дүүс гэж дуудахаас ичээгүй**. Орчлон ертөнцийн мөнхийн дээд бүрэн эрхт Нэгэн хүн болж, Өөрийгөө бүтээлүүдтэйгээ нэг зиндаанд тавьж, тэднийг ах дүүс гэж дуудна гэхээр төсөөлөгдөж байна уу?

2:12 Энэ асуултын хариу Дуулал 22:22 дээр өгөгдсөн. Тэнд Тэрээр **“Таны нэрийг Би ах дүүстээ тунхаглана”** хэмээн айлдсан байдаг. Мөн энэ эшлэлд Түүнийг хүмүүсийнхээ дунд мөргөл хүндлэл өргөж буйгаар **“Чуулган дунд Би Таныг магтах болно”** хэмээн дүрслэн харуулдаг. Тэрээр үхэлд тарчлан зовж байхдаа ч солигдон аврагдсан олон түмнийг Эцэг Бурханыг **магтах** магтаал өөд хөтлөх тэр өдрийг хүсэн хүлээж байлаа.

2:13 Христийн хүн чанарыг нотлохын тулд еврей Бичвэрээс дахин хоёр эшлэлийг эш татжээ. Исаиа 8:17 (LXX) дээр Христ **итгэлээ** Бурханд тавина гэж хэлсэн. Иеховад бүрэн итгэж найдна гэдэг бол жинхэнэ хүн чанарын тод томруун илэрхийлэл мөн. Дараа нь Исаиа 8:18 дээр Эзэн, **“Намайг болон Надад Бурханы өгсөн хүүхдүүдийг харагтун”** хэмээн хэлснийг эш татжээ. Эзэнд итгэгчдийг нэг Эцэгтэй, нэг гэр бүлийн хүүхдүүд гэсэн санаа энд яригдаж байна.

2:14 Хүний Хүүгийн дорд болгогдсон нь ичгүүртэй гэж үздэг хүмүүст одоо Түүний зовлон шаналлаас ирсэн дөрвөн ерөөлийг бодож үзэхийг сануулж байна.

Эхний ерөөл бол Сатаны сүйрэл юм. Яаж ийм зүйл болсон бэ? Бурхан хүүхдүүдээ ариусгаж, аварч, чөлөөлөхийн тулд Христэд өгсөн. Тэр хүүхдүүд нь хүний мөн чанартай учраас Эзэн Есүс ч мөн мах цусанд төрөх учиртай байжээ. Тэрээр бурханлаг сүр жавхлангаа далдлан, Гурвалын нэг болох мөн чанараа “шавар хувцсаар” далдалжээ.

Гэхдээ Тэр зөвхөн Бетлекемд хүрээд зогсоогүй. Харин надад дэндүү хайртай учраас миний төлөө Голгота хүртэл явсан.

Тэрээр **үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ хүчингүй болгосон. Хүчингүй болгох** гэдэг нь оршихуйг нь үгүй хийсэн юм биш, харин хүч нөлөөг нь үгүй хийсэн гэсэн утгатай. Сатан одоо ч энэ дэлхий дээр Бурханы төлөвлөгөөг саатуулахаар идэвхтэй хичээж байгаа ч загалмай дээр үхлийн шарх авчээ. Түүнд богинохон хугацаа үлдсэн. Түүний сүйрэл гарцаагүй. Тэр бол ялагдсан дайсан юм.

Диавол **үхлийн хүчийг** ямар утгаар нь эзэмшдэг вэ? Нэг гол зүйл нь тэр үхлийг *шаардах* эрхийг хэрэглэдэг. Дэлхийд анх Сатанаар дамжин нүгэл орж ирсэн. Харин Бурханы ариун чанар нүгэл үйлдсэн бүхнийг үхэлд тушаасан. Тиймээс яллагчийн хувьд диавол хүн бүрийн нүглийн төлөөсийг нэхэх боломжтой.

Түүнчлэн, шүтээн шүтлэгтэй газар Сатан өөрийн төлөөлөгчдөөрөө (бөө, удган, хараал жатгач г.м.) дамжуулан хүнийг харааж жам бусаар үхүүлэх чадалтай байдаг нь Сатаны нөлөөллийн нэг илрэл билээ.

Гэсэн ч Библийн хаана ч Бурханы зөвшөөрөлгүйгээр диавол итгэгчдийг үхэлд хүргэж чадна гэж гардаггүй (Иов 2:6). Тиймээс Сатан итгэгчдийн нас барах хугацааг

тогтоож чадахгүй. Харин хорон муу хүнээр дамжуулан заримдаа итгэгчдийг хөнөөх зөвшөөрөл авч чаддаг. Гэхдээ “Биеийг хөнөөж чадах хүмүүсээс бүү ай, харин бие ба сэтгэлийг тамд хаяж чадах Бурханаас ай” хэмээн Эзэн Есүс шавь нартаа сануулсан (Мт 10:28).

Хуучин гэрээнд Енох, Елиа нар үхлийг амсалгүй тэнгэр өөд явсан. Тэд итгэгч болохын хувьд Христийн ирээдүйн үхлээр дамжуулан үхсэнд тооцогдсон гэж үздэг.

Христ хүмүүсээ дээш шүүрэн авахаар дахин ирэх үед бүх итгэгчид нас барахгүйгээр тэнгэр өөд шүүрэгдэнэ. Тэд үхлийг амсахгүй байх шалтгаан нь Бурханы ариун шаардлага Христийн үхлээр хангагдаж, тэднийг үхсэнд тооцоход оршино. Амилсан Христ эдүгээ үхэл ба үхэгсдийн орны түлхүүрийг атгаж байна (Илч 1:18). Өөрөөр хэлбэл, Тэр энэ бүхний дээгүүр бүрэн эрх мэдэлтэй.

2:15 Христ дорд болгогдсоноор дамжуулан ирсэн удаах ерөөл бол **айдсаас** чөлөөлөгдсөн явдал юм. Загалмайн үхлээс өмнө **үхлийн айдас** хүмүүнийг бүх насаар нь боолчлолд байлгаж байв. Хэдийгээр Хуучин гэрээнд үхлийн дараах амьдралын талаар цухас цохон тэмдэглэсэн байдаг ч ихэнх тохиолдолд тодорхой бус, бүрхэг, аймшигтай байдаг байлаа. Тэр үед бүдэг бадаг байсан зүйл одоо тодорхой, ил тод харагдах болжээ. Учир нь Христ сайнмэдээгээр дамжуулан амь ба мөхөшгүй байдлыг гэрэлд авчирсан юм (2Тм 1:10).

2:16 Гурав дахь агуу ерөөл бол нүглийн ялаас чөлөөлөгдсөн явдал билээ. Эзэн Есүс энэ дэлхийд ирэхдээ **тэнгэрэлч нарт бус, харин Абрахамын үрд санаа тавьдаг. “Санаа тавих”** гэж орчуулагдсан энэ үг бол *эпиламбано* бөгөөд “барьж авах”, “түшиж тулах”, “татан аврах” [KJV орчуулга дээр үүнийг “Тэр тэнгэрэлч нарын мөн чанарыг Өөр дээрээ аваагүй, харин Абрахамын үр удмын дүрийг Өөртөө авсан” гэж илэрхийлсэн байдаг] гэсэн утгатай. Уг үйл үг нь өөр газарт хүчтэй барьж авах

гэсэн хүчирхийллийн өнгө аясыг агуулдаг ч энд гол нь туслах, татан аврах гэсэн санааг илэрхийлж байна.

Абрахамын үр гэж Абрахамын *махан биеийн* үр удам болох иудейчүүд эсвэл *сүнслэг* үр сад болох бүх үеийн итгэгчдийг ч хэлсэн байж болно. Гол нь энд эдгээр оршигчид бол тэнгэрэлч нар биш, хүмүүс гэдгийг илэрхийлэхийг зорьжээ.

2:17 Тэд хүн учир тэдэнд туслахын тулд Эзэн Есүс Өөрөө **бүх талаараа ах дүү нартайгаа адил болох ёстой** байлаа. Тэрээр жинхэнэ, төгс хүний мөн чанарыг Өөртөө өмссөн. Түүнд бүх хүний адил хүсэл, бодол, мэдрэмж, сэтгэл хөдлөл байсан. Харин хамгийн чухал ялгаа нь гэвэл Түүнд нүгэл огт байгаагүй. Үүгээрээ л бусдаас ялгаатай. Тэрээр төгс хүн байжээ. Харин бидний хүн чанар нүгэл хэмээх гаднын нэгэн зүйлээр халдварласан байдаг.

Тэр төгс хүн учраас **Бурханы өмнө өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч** болох зохистой. Тэрээр хүмүүнд **өршөөнгүй**, Бурханд **итгэмжит**. Тэрээр **Тэргүүн Тахилч** болохын хувьд нэн тэргүүний үүрэг нь **хүмүүсийн нүглийн улмаас эвлэрүүлэл хийх** явдал юм. Энэ үүргээ гүйцэтгэхдээ Тэрээр *Өөрийгөө* нүгэлгүй тахил болгон өргөж, өөр ямар ч тэргүүн тахилчийн хийж чадахгүй зүйлийг хийсэн билээ. Тэр сайн дураараа бидний оронд үхсэн юм.

2:18 Дөрөв дэх ерөөл нь **соригдогсдод** туслах тусламж юм. **Учир нь Тэр Өөрөө соригдон зовлон эдэлсэн тул соригдогсдод тусалж чадна.** Тэр Өөрөө бүгдийг биеэрээ үзсэн учраас зовж буй хүмүүст тусалж чадна.

Энд хэдэн үг нэмж хэлэх хэрэгтэй байх. Эзэн Есүс дотроосоо буюу нүгэлт хүний хүсэл тачаалаас болж соригдож байгаагүй. Харин гадаад хүчин зүйлээр л **соригдсон**. Цөлд соригдсоныг нь харсан ч дотоод нүглийн асуудлаар соригдоогүй байдаг. Сатан Түүн дээр хүрч ирээд гадаад хүчин зүйлсээр Түүнийг сорьсон. Учир нь Түүний

дотор нүгэлд хариу үйлдэл үзүүлэх ямар ч зүйл байгаагүй тул гэмт хүслээс болж соригдох боломжгүй юм. Тэрээр нүгэлгүй учир нүгэлт хүсэлтэй тэмцэж байгаагүй. Тэр **зовлон эдэлж соригдсон**. Бид уруу татлагыг эсэргүүцэхдээ зовдог бол Түүнд уруу татагдаж байна гэдэг нь Өөрөө зовлон байсан юм.

В. Христ Мосе, Иошуа хоёроос агуу (3:1-4:13)

3:1 Мосе бол Израилийн хамгийн агуу үндэсний баатар байсан. Тиймээс бичээчийн гурав дахь үндсэн стратеги нь Христийг Мосегээс хэмжээлшгүй агуу Нэгэн гэдгийг харуулах явдал байлаа.

Энэ захидлыг **тэнгэрлэг дуудлагыг хуваалцагч ариун ах дүү нарт** зориулж бичсэн. Жинхэнэ итгэгч хүн бүгдээрээ байр суурийн хувьд **ариун** байдаг тул ариун амьдрах учиртай. Тэд Христийн дотор ариун учраас өөрсдийнхөө дотор ариун байх ёстой.

Тэдний **тэнгэрлэг дуудлага** нь Израилийн газрын дуудлагаас эрс ялгаатай. Хуучин гэрээний ариун хүмүүс амлагдсан газар нутагт материаллаг ерөөлийг хүртэхээр дуудагдсан юм. (Мэдээж тэдэнд ч бас тэнгэрлэг найдвар байсан нь үнэн). Гэхдээ Чуулганы эрин үед амьдарч буй итгэгч бид эдүгээ тэнгэрийн сүнслэг ерөөл рүү дуудагдсан бөгөөд ирээдүйд тэнгэрлэг өвийг хүлээн авна.

Хараагаа Есүс дээр төвлөрүүлж, **ажигцаа**. Тэрээр бидний хүлээн зөвшөөрдөг **Элч ба Тэргүүн Тахилч** гэж хэлэгдэх зохистой нэгэн билээ. Түүнийг **Элч** хэмээн хүлээн зөвшөөрөх нь Тэр Бурханыг бидний өмнө төлөөлдөг гэдгийг хэлж байгаа юм. Түүнийг **Тэргүүн Тахилч** гэж хүлээн зөвшөөрөх нь Тэр биднийг Бурханы өмнө төлөөлөн зуучилдаг гэсэн утгатай.

3:2 Эзэн Есүст Мосетэй адил гэж хүлээн зөвшөөрөгдөх нэг тал бий. **Мосе** Бурханы **гэрт итгэмжит байсны адил**

Тэр Бурханд **итгэмжит байсан**. Энэ гэр гэдэг нь майхан сүмийг хэлэхээс гадна Мосе Бурханы ашиг сонирхлыг төлөөлж байсан бүхий л цар хүрээг илтгэж байгаа юм. Энэ нь эртний, газар дээрх Бурханы ард түмэн болох Израилийн **гэр** билээ.

3:3 Гэхдээ ижил тал нь энэ хүрээд дуусна. Эзэн Есүс бусад бүх талаар Мосегоос хамаагүй агуу юм. Эзэн Есүс **Мосегоос илүү их алдрыг хүртэх зохистой**. Учир нь **барилгачин барилгаасаа илүү хүндлэл хүлээдэг**. Эзэн Есүс бол Бурханы гэрийн Барилгачин, харин Мосе тэр гэрийн ердөө нэг хэсэг байсан юм.

3:4 Хоёрдугаарт, Христ Бурхан учраас илүү агуу. **Аливаа барилга** заавал барилгачинтай байдаг. **Бүх юмсыг барьсан нь Бурхан мөн**. Иохан 1:3, Колоссай 1:16, Еврей 1:2, 10 эшлэлүүдээс харахад Эзэн Есүс бол бүтээх үйлсэд идэвхтэй оролцсон Бүтээгч Нэгэн гэдгийг мэдэж болно. Иймд Есүс Христ бол Бурхан мөн гэдэг нь гарцаагүй дүгнэлт болно.

3:5 Гуравдугаарт, Христ Хүү болохын хувьд илүү агуу. **Мосе нь Бурханы бүх гэрт итгэмжит үйлчлэгч байсан** (Тоо 12:7) бөгөөд Тэрээр хүмүүсийг айсуй Христ рүү чиглүүлж байсан. Тэрээр **хожим яригдах ёстой** зүйлсийг буюу Христээс ирэх авралын сайнмэдээний талаар гэрчилсэн юм. Тиймээс Есүс нэгэнтээ, “Хэрэв та нар Мосед итгэсэн юм бол Надад итгэх байсан. Учир нь тэр Миний тухай бичсэн юм” (Иох 5:46) гэж хэлж байжээ. Эзэн Есүс хоёр шавьтайгаа Еммау тосгон руу явах замдаа “Мосегоос эхлэн бүх эш үзүүлэгчид, бүх Бичвэрт Өөрийнх нь тухай юу хэлснийг тайлбарлаж өгсөн.” (Лк 24:27)

3:6 Харин Христ, Бурханы гэр доторх зарц мэт биш, харин **Хүүгийн хувьд Бурханы гэрт итгэмжит юм**. Есүс Бурханы Хүү гэдэг нь Бурхантай эн тэнцүү гэсэн утгыг илэрхийлдэг. Бурханы гэр бол **Түүний Өөрийнх нь гэр болой**.

Бичээч энд Бурханы гэр гэж өнөөдөр ямар утгатайг тайлбарлаж байна. Бурханы гэр нь Эзэн Есүст итгэгч жинхэнэ итгэгч нэг бүрээс бүрддэг. **Бид зориг болон найдварын сайрхлаа эцэс хүртэл бат сахиваас бид Түүний гэр болой.** Өнгөц харвал бидний аврал эцэс хүртэл бат сахиваас маань хамаардаг гэж энэ эшлэл ойлгогддог. Тийм гэж үзвэл бид загалмай дээр бүрмөсөн гүйцэлдүүлсэн Христийн төгс ажлаар биш, тэвчээрээр аврагддаг гэсэн үг болно. Гэхдээ энэ эшлэлийн жинхэнэ утга нь бид итгэлээ бат сахивал Бурханы гэр гэдгээ батална гэсэн утгатай. Тэвчээр бол бидний итгэл жинхэнэ гэдгийн баталгаа юм. Христэд итгэх бат итгэлээ алдаж, шашны зан үйл, ёс жаяг руу эргэдэг хүмүүс үнэндээ шинээр төрөөгүй байсан гэдгээ илчлэн харуулж байгаа юм. Үүнийг бид итгэлээс урвах гэдэг. Дараах анхааруулга үүний эсрэг сэрэмжлүүлсэн.

3:7 Эндээс бичээч захидлынхаа хоёр дахь сэрэмжлүүлгийг өгч байна. Тэрээр зүрхээ хатууруулахгүй байхыг сануулж байна. Израильчууд цөлд байхдаа зүрхээ хатууруулсан. Энэ явдал дахин тохиолдох боломжтой. Тиймээс **Ариун Сүнс** анх “**Өнөөдөр та нар Түүний дууг сонсвол**” гэж хэлсэн тэр үеийнх шигээ өнөөдөр ч Дуулал 95:7-11-ээр дамжуулан бидэнд ярьсаар байна.

3:8 Бурхан үгээ айлдах бүрд бид Түүний үгийг дуулгавартай, даруйхан сонсох нь зүйтэй. Түүний үгэнд эргэлзэх нь Түүнийг худалч гэж хэлсэнтэй адил тул Түүний уур хилэнг хөдөлгөдөг.

Цөлд тэнүүчилсэн Израилийн түүхэнд ийм явдал болж байв. Энэ бол гомдол, шунал тачаал, шүтээн шүтлэг, үл итгэл, тэрслэлтээр дүүрэн гунигт түүх билээ. Жишээ нь, тэд усгүй болмогц Рефидимд гомдоллож, Бурханы оршихуй тэдний дунд байгаа эсэхэд эргэлзсэн юм (Гэт 17:1-17). Параны цөлд итгэлгүй туршуулууд эргэн ирэхдээ муу мэдээ авчирч, ард түмний зоригийг мохоож, эргэлзээ

төрүүлэх үед (Тоо 13:25-29) ард түмэн боолчлогдож байсан Египет рүүгээ буцахаар шийдсэн (Тоо 14:4).

3:9 Бурхан үүнд нь ихэд хилэгнэж, тэднийг цөлд дөчин жил тэнүүчилнэ хэмээн тунхаглав (Тоо 14:33-34). Египет нутгаас гарсан хорь ба түүнээс дээш насны цэргүүдээс зөвхөн Калев, Иошуа хоёр л Канаан нутагт орж чадна гэж тунхаглав (Тоо 14:28-30).

Энд анхаарал татах нэг зүйл бол Израиль **дөчин жил** цөлд тэнүүчилсэн шиг Христийн үхлээс хойш ойролцоогоор дөчин жилийн турш Бурханы Сүнс Израиль үндэстэнтэй харьцаж, тэдний асуудалд оролцсоор байсан явдал юм. Израиль үндэстэн Христийн сайнмэдээг эсэргүүцэн, зүрхээ хатууруулсан тул МЭ 70 онд Иерусалим хот сүйтгэгдэж, хүмүүс нь харь үндэстнүүдийн дунд тараагдсан.

3:10 Бурхан цөл дэх израильчуудын үйлдэлд дургүйцсэн тул ийм хатуу үгийг хэлсэн. Тэд Өөрөөс нь үргэлж холдон одож, Бурханы замуудыг зориуд үл тоомсорлох хандлага байгааг Бурхан буруутгасан.

3:11 Бурхан тэднийг Өөрийн амралт буюу Канаан нутагт оруулахгүй гэж **хилэн дотроо андгайлав**.

3:12 12-15 дугаар эшлэлд Ариун Сүнс Израилийн амссан туршлагаас бидэнд өгөх сургамжийг гаргаж ирж байна. Еврей номын бусад хэсгүүдийн нэгэн адил энд ч бас уншигчдаа **ах дүү нар** гэжээ. Гэхдээ тэглээ гээд уншигчид нь бүгдээрээ жинхэнэ итгэгч гэсэн үг биш л дээ. Тиймээс өөрийгөө итгэгч гэж нэрлэдэг бүхэн **итгэлгүй зүрхтэй байж, амьд Бурханаас салах вий хэмээн болгоомжлох хэрэгтэй**. Энэ бол байнгын аюул.

3:13 Энэ аюулаас сэрэмжлэх нэг том арга бол бие биеэ урамшуулан ятгах явдал билээ. Ялангуяа, зовлон бэрхшээлтэй үед Бурханы хүмүүс бусдыгаа **өдөр бүр** сэнхрүүлж, нүглийг шийдэж чаддаггүй шашин руу ухарч, Христийг орхиж явахаас сэрэмжлүүлэн сэргийлэх хэрэгтэй.

Ингэж ятган сэнхрүүлэх ажил зөвхөн пастор ахлагчдад оногдсон үүрэг биш гэдгийг эндээс анзаарч хараарай. Энэ бол бүх ахан дүүсийн үүрэг юм. **“Өнөөдөр”** гэгдэж л байгаа бол энэ ажлыг бид тасралтгүй хийх хэрэгтэй. Өнөөдөр гэдэг нь итгэлээр дамжуулан нигүүлслээр ирэх Бурханы аврал боломжтойг илэрхийлнэ. **“Өнөөдөр”** бол зохистой цаг үе. **“Өнөөдөр”** бол авралын өдөр.

Итгэлээс салан унах гэдэг нь **нүглийн мэхлэлээр хатуурахыг** хэлнэ. Нүгэл эхэндээ сайхан харагддаг. Нүгэл нь Христийн төлөөх доромжлол, зовлонгоос зайлсхийх замыг санал болгож, ариун байдлын шалгуурыг бууруулж, гоо зүйн хувьд сэтгэл татах ёс заншлуудыг санал болгож, дэлхийн ашиг хонжоог амладаг. Гэвч эргээд харахад нүгэл далд хорон байдаг. Эцэст нь хүн нүглийн уучлалгүй, булшнаас цааш найдваргүй, гэмших боломжгүй хоцордог.

3:14 Хэрэв бид анхны итгэлээ эцэс хүртэл бат сахиваас Христийн хуваалцагчид болсон байна гэдгийг энд ахин сануулжээ. Иймэрхүү эшлэлийг ихэвчлэн буруу ашиглаж, хүн аврагдаад дараа нь авралаа алдах боломжтой гэж номлодог. Гэвч ийм тайлбар хийх огт боломжгүй. Учир нь авралыг Бурханы нигүүлслээрээ үнэгүй өгч, Христ Өөрийн цусаар худалдан авч, хүн итгэлээр хүлээн авч, сайн үйлээрээ батлан харуулдаг гэсэн санаа Библид дэндүү олон бий. Жинхэнэ итгэлд гуйвшгүй чанар хэзээд байдаг юм. Бид авралаа хадгалж үлдэхийн тулд итгэлээ сахидаггүй. Харин итгэлээ сахиж байна гэдэг нь аврагдсаны баталгаа юм. Авралын үндэс бол итгэл, харин тэвчээр бол итгэлийн үр дүн юм. Хэн Христийн хуваалцагч вэ? “Итгэлээ сахих тэвчээрээрээ Христийнх гэдгээ батлан харуулдаг хүмүүс Христийн хуваалцагч мөн.”

3:15 Одоо бичээч Израилийн гунигт туршлагаас бидэнд өгөх сургамжийг дүгнэж, Дуулал 95:7, 8 эшлэлээс дахин эш татав. **“Өнөөдөр та нар Түүний дууг сонсвол тэрслэл дэх шиг зүрхээ бүү хатууруул.”** Нэгэн цагт энэ хүчтэй

ятгалга Израильд хандсан байсан бол эдүгээ сайнмэдээг орхиж, хууль руу эргэж болзошгүй бүхэнд хандан хэлж байна.

3:16 Гуравдугаар бүлэг Израилийн итгэлээс урвасан явдлыг түүхэн талаас нь тайлбарлаад өндөрлөж байна. Бичээч гурван асуулт, гурван хариултаар Израилийн тэрслэл, өдөөн хатгалга, залхаан цээрлүүлэлтийг авч үзэн, дүгнэжээ.

Тэрслэл. Тэрслэгчид нь **Мосегийн дор Египетээс гарсан бүгд** гэж тодорхойлогддог. Гагцхүү Калев, Иошуа хоёр л үүнд багтаагүй.

3:17 *Өдөөн хатгалга.* Яг энэ тэрслэгчид л Иеховаг **дөчин жилийн** турш өдөөн хатгаж хилэгнүүлсэн. Энд 600 мянган эрчүүд байсан бөгөөд дөчин жилийн төгсгөлд цөлд 600 мянган булш болон үлджээ.

3:18 *Залхаан цээрлүүлэлт.* Эдгээр тэрслэгчид дуулгаваргүй байдлынхаа горьг амсаж Канаан нутагт орох боломжоо алдсан.

Гаднаа сүсэгт дүртэй боловч итгэл сүсгийн хүчийг үгүйсгэдэг олонхыг даган араас нь явахад уруу татагддаг хүмүүст энэ гурван асуулт, хариултаас энгийнээр дурдах төдийд л гүн сургамж болно. Дандаа олонхын зөв байдаг гэж үү? Энэ бүлэгт авч үзсэн Израилийн түүхэнд хоёр хүний зөв, хагас сая гаруй хүний буруу байлаа.

А.Т.Пиерсон Израилийн нүгэл ямар ноцтойг цохон тэмдэглэж ийн дүгнэжээ:

Тэдний үл итгэл дөрвөн талаар Бурханы уур хилэнг төрүүлсэн. Үүнд:

1. Бурханы үнэн рүү давшилж, Бурханыг худалч гэж үзсэн.
2. Бурханы хүч чадлыг гутааж, Бурханыг хүчгүй, Канаан руу оруулах чадалгүй гэж үзсэн.
3. Бурханы хувиршгүй мөн чанарыг үгүйсгэсэн. Израильчууд үүнийг үгээрээ шууд хэлээгүй ч үйлдэл,

хандлагаараа Бурханыг байнга өөрчлөгддөг мэт аашилсан. Өмнө нь хийсэн гайхамшгаа ахин хийж чадахгүй гэж үзсэн.

4. Тэд Бурханыг хэрэгцээнд нь анхаардаггүй атлаа найдвар төрүүлдэг мэтээр үзсэн нь Түүний эцэг мэт үнэнч байдлыг гутаасан хэрэг байлаа.¹

Харин Калев, Иошуа хоёр эсрэгээрээ Бурханы үгийг туйлын үнэн, хүч чадлыг нь хязгааргүй, зан чанарыг нь хувиршгүй, итгэмжийг нь хэзээ ч хөсөрдүүлэхгүй биелүүлдэг гэж үнэлэн Бурханыг хүндэлсэн.

3:19 *Дүгнэлт.* Тэрслүү израильчууд **итгэлгүйгээсээ** болж амлагдсан нутагт ороогүй. Аль ч цаг эрин үед хүн итгэлгүйгээсээ болж Бурханы өвийг хүртэх эрхээ алддаг. Эндээс өгөгдөх сургамж бол тодорхой, **итгэлгүй** бузар зүрхнээс сэрэмжилцгээе.

Дараагийн эшлэлүүд бол энэ захидлын хамгийн төвөгтэй, ярвигтай хэсгийн нэг юм. Библи судлаач тайлбарлагч нар энэ хэсгийн хэлэлцүүлгийн утга агуулга дээр нэг их санаа нэгддэггүй ч үндсэн сургаал нь илэрхий ойлгомжтой байдаг.

Еврей 4:1-13 дугаар эшлэлийн ерөнхий санаа болбоос Бурханы амралт юм. Мөн Бурханы амралтад орохыг хичээн эрмэлзэх хэрэгтэй тухай өгүүлдэг. Эхлээд Библид хэд хэдэн өөр төрлийн амралтыг дурдсаныг анзаарах нь энэ хэсгийг илүү ойлгоход тустай.

1. Бурхан орчлон ертөнцийг бүтээгээд долоо дахь өдрөө амарсан (Эх 2:2). Гэвч ажил хийгээд ядарсандаа амраагүй. Харин хийсэн ажилдаа сэтгэл ханасандаа амарсан юм. Энэ нь бүрэн дүүрэнд сэтгэл амарсан амралт байжээ (Эх 1:31). Гэвч дэлхийд нүгэл орж ирснээр Бурханы амралт тасалдсан. Тэр цагаас хойш Бурхан тасралтгүй ажиллаж байна. “Эцэг минь одоо болтол ажиллаж байна. Би ч ажиллаж байна” (Иох 5:17) гэж Эзэн Есүс айлдсан билээ.

2. Канаан нутаг Израилийн хөвгүүдийн хувьд амралтын нутаг байхаар төлөвлөгдсөн. Тэдний ихэнх нь Канаан нутагт орж чадаагүй. Орсон хэд нь ч мөн Бурханы бэлдсэн амралтыг амсаагүй. Канаан бол Бурханы тогтоосон төгс, мөнхийн амралтын бэлгэдэл маягаар хэрэглэгдсэн. Канаан нутагт орж чадаагүй олон хүн (жишээ нь Кора, Датан, Абирам) өнөө цагийн итгэлээс урвагчдыг дүрслэн харуулдаг. Тэд үл итгэлийнхээ улмаас Бурханы амралтад орж чаддаггүй.

3. Өнөөдөр итгэгчид мөс чанартаа амралтыг эдэлж байна. Учир нь Эзэн Есүсийн бүрэн гүйцэлдүүлсэн төгс ажлаар дамжуулан нүглийнх нь шийтгэл бүрэн төлөгдсөн гэдгийг тэд бат мэддэг. Энэ бол Аврагч Эзэний амласан амралт юм. “...Над дээр ир. Би та нарыг амраая.” (Мт 11:28)

4. Итгэгч хүн мөн Эзэний үйлчлэл дотор амралтыг эдэлдэг. Эхнийх нь авралын амралт байсан бол энэ нь үйлчлэлийн амралт мөн. “Буулгыг минь өөрсөд дээрээ ав. Надаас сур... Та нар сэтгэлдээ амралтыг олох болно.” (Мт 11:29)

5. Хамгийн сүүлийнх нь мөнхийн амралт. Энэ амралт тэнгэр дэх Эцэгийн гэрт итгэгчдийг хүлээж буй мөнхийн амралт юм. Ирээдүйн энэхүү амралтыг амралтын өдрийн амралт гэж нэрлэдэг (Евр 4:9). Энэ амралт нь бусад бүх амралтын бэлгэдэл эсвэл урьдчилсан амталгаа болдог эцсийн амралт билээ. Одоо үзэх хэсэгт голчлон энэ амралтын тухай өгүүлнэ.

4:1 Амралтад орно гэсэн амлалт одоо хүчингүй болсон гэж бодох хэрэггүй. Учир нь энэ **амралтын** тухай амлалт өнгөрсөнд огтхон ч бүрэн дүүрэн утгаараа биелээгүй **учраас** одоо ч хүчин төгөлдөр хэвээр байна.

Гэхдээ өөрийгөө итгэгч гэж хэлдэг бүхэн зорилгодоо хүрэхээс хоцрохгүй гэдгээ баттай болгох хэрэгтэй. Хэрэв тэдний амнаас гарах үг зүрхэн дэх үнэн төрхөөсөө зөрж

байвал хүн Христээс нүүр буруулж, аврах чадалгүй ямар нэг шашныг сонгох аюул үргэлж байдаг.

4:2 Бидэнд сайнмэдээ тунхаглагдсан. Христэд итгэх итгэлээр дамжин мөнх амьтай болох сайнмэдээ. Израильчуудад ч гэсэн Канаан нутгийн амралтад орох сайнмэдээ тунхаглагдсан. Даан ч тэд амралтын сайнмэдээний ач тусыг үзээгүй юм.

Үүнд хоёр тайлбар бий. NKJV-хэмээх англи орчуулгаас уншвал тэдний бүтэлгүйтсэн шалтгаан нь тунхаглагдсан үг нь сонсогчдын дотор итгэлээр холбогдоогүйд оршино гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тэд итгэж, итгэлээрээ үйлдээгүй юм.

Харин өөр тайлбар дээр ‘тэд үгийг дуулгавартай дагасан хүмүүстэй итгэлээр нэгдэх ёстой байтал тэгсэнгүй’ гэсэн санаа гардаг. Өөрөөр хэлбэл, израильчуудын дийлэнх нь Калев, Иошуа хоёрын итгэлтэй нэгдээгүй гэсэн үг.

Аль ч тайлбар нь байлаа гэсэн гол санаа нь үл итгэл тэднийг Бурханы бэлтгэсэн амлалтын нутаг дахь амралтаас салгасан явдал юм.

4:3 Энэ эшлэлийн уялдаа холбоо ойлгоход их төвөгтэй байдаг. Харахаар бие биетэйгээ холбогдолгүй гурван өөр өгүүлбэр байх шиг харагддаг. Гэхдээ гурван өгүүлбэрт гурвуулд нь Бурханы амралт гэсэн ерөнхий санаа агуулагдаж байгааг харж болно.

Юуны түрүүнд, **итгэгч бид** Бурханы **амралтад орох** хүмүүс гэдгийг энд хэлж өгсөн. Хаалгыг нээх түлхүүр нь итгэл. Өмнө хэлсэнчлэн, итгэгч бид эдүгээ мөс чанартаа амралтыг эдэлдэг. Учир нь нүглээсээ болж дахиж хэзээ ч шүүгдэхгүйгээ бид мэднэ (Иох 5:24). Мөн итгэдэг хүмүүс л гагцхүү Бурханы цог жавхланд буй тэрхүү эцсийн амралтад орно гэдэг нь үнэн. Энд голчлон хэлж буй амралт нь магад тэрхүү ирээдүйн амралт бололтой.

Дараагийн өгүүлбэрт санаагаа улам бататгаж, **“Би хилэн дотроо ‘Миний амралтад тэд эс орно’ гэж**

андгайлсан” хэмээн мэдэгдэв. Үүнийг Дуулал 95:11 эшлэлээс эш татсан байна. Итгэл амралт руу оруулдаг бол үл итгэл амралтаас хөндийрүүлдэг. Христэд итгэсэн бид Бурханы амралтад орно гэдэгт бат итгэлтэй байдаг. Харин үл итгэгч израильчууд Бурханы амралтад бүрэн найдаж чадаагүй. Учир нь тэд Бурханы үгэнд итгээгүй юм.

Гурав дахь өгүүлбэрийг тайлбарлахад хамгийн төвөгтэй. Энд, **Түүний ажлууд дэлхийн сууриас дууссан хэдий ч...** гэжээ. Магадгүй энэ өгүүлбэрийг өмнөх өгүүлбэртэй нь холбож харвал хамгийн зөв тайлбар гарч ирэх биз ээ. Бурхан Өөрийнхөө амралтын тухай ярихдаа **“Миний амралтад тэд эс орно”** хэмээн ирээдүй цаг ашигласан нь зарим нэг нь дуулгаваргүй байдлаасаа болж алдсан ч гэлээ Бурханы амралт одоо ч хүчин төгөлдөр, боломж нээлттэй хэвээрээ байгааг илэрхийлдэг. **Түүний ажлууд дэлхийн сууриас дууссан** нь үнэн ч гэлээ энэ амралт одоо ч боломжтой хэвээр байна.

4:4 Энэ эшлэлд Бүтээлийн ажил дууссаны дараа **Бурхан амарсан** гэдгийг Бичвэрийн үндэслэлээр батлах зорилготой. Захидлыг бичигч уг эшлэлийг “хаа нэгтээ” гэж хэлэхдээ Бичвэрийн байршлыг тодорхой заагаагүй нь бичээч мэддэггүй байсан гэсэн үг биш. Харин тухайн үед Библийг бүлэг, эшлэлээр хуваадаггүй байсан учир бичлэгийн хэв маяг ийм байжээ. Уг эшлэлийг Эхлэл 2:2-оос “Бурхан бүх ажлаасаа долоо дахь өдөртөө амарчээ” хэмээн эш татжээ.

Энэ хэсэгт өнгөрсөн цаг ашигласан тул зарим хүнд Бурханы амралт зөвхөн өнгөрсөнд хамаатай, ирээдүйн амлалттай ямар ч холбоогүй мэт санагдаж магадгүй. Эндээс Бурханы амралт өнөөдрийн бидэнд хүртээлгүй гэж дүгнэж болох юм. Гэвч энэ бодит байдалтай огт нийцэхгүй.

4:5 Бурхан орчлон ертөнцийг бүтээснийхээ дараа амарсан гэдэг нь Бурханы амралт бүрэн хаагдсан асуудал гэсэн санаа биш гэдгийг дахин тодотгохын тулд бичээч

Дуулал 95:11 эшлэлийг бага зэрэг өөрчлөн, ирээдүй цагийг ашиглан эш татсан байна (Англиар уншвал Дуулал 95:11 дээр should not enter, Еврей 4:5 дээр shall not enter гэсэн байна. Монголоор энэ ялгаа харагдахгүй.). **“Тэд миний амралтад эс орно.”** Өөрөөр хэлбэл, бичээч, “Бурханы амралтыг Эхлэл 2-р бүлэгт болсон түүхээр хязгаарлаж болохгүй. Учир нь Бурхан хожим нь Өөрийн амралтын тухай дахин ярьсан учраас энэ амралт одоо ч нээлттэй хүлээгдэж буй боломж” гэж хэлж байгааг харуулж байна.

4:6 Бурхан орчлон ертөнцийг бүтээсэн цагаас эхлэн хүн төрөлхтөнд амралтыг санал болгосоор байгааг энэ хүртэл үзсэн хэсгээс харж болно. Амралт руу орох хаалга бүх цаг үеийн турш нээлтэй байсаар ирсэн.

Цөлд байсан израильчууд **дуулгаваргүйгээсээ болж** амралт руу **орж чадаагүй**. Гэвч тэглээ гээд уг амралт одоо хүчингүй болсон гэсэн үг биш.

4:7 Дараагийн алхам нь израильчууд Канаан руу орж чадалгүй цөлд унацгааснаас хойш 500 орчим жилийн дараа **Давидаар** дамжуулж Бурхан дахин **“өнөөдөр”** гэдэг үгийг ашиглаж, боломж байсаар байгааг харуулах явдал байлаа. Бичээч Дуулал 95:7, 8 эшлэлийг Еврей 3:7, 8, 15 дээр аль хэдийн эш татсан. Харин одоо амралтын тухай Бурханы амралт цөлд байсан израильчуудтай хамт дуусгавар болоогүй гэдгийг батлах зорилгоор дахин эш татаж байна. Давидын цаг үед ч гэсэн Бурхан хүмүүсийг Өөрт нь найдахыг уриалж, **зүрхээ бүү хатууруул** хэмээн айлдаж байв.

4:8 Зарим израильчууд **Иошуатай** хамт мэдээж Канаан руу орсон нь үнэн. Гэвч Өөрийг нь хайрладаг хүмүүст Бурханы бэлдсэн эцсийн амралтад тэд бас л орж чадаагүй юм. Канаан нутагт дайн тулаан, гэм нүгэл, өвчин зовлон, гуниг гутрал, үхэл хагацал үргэлжилсээр байсан. Хэрэв тэд Бурханы амралтын тухай амлалтад хүрчихсэн бол Бурхан

Давидын өдрүүдэд амралтыг дахин санал болгохгүй байх байсан юм.

4:9 Өмнөх эшлэлүүд эцэст нь, “**Бурханы хүмүүст Амралтын өдрийн амралт үлддэг**” гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Бичээч энд амралт гэдэг үгийг хэлэхдээ *шаббат* гэсэн үгтэй холбоотой *саббатисмос* гэх өөр грек үгийг ашиглажээ. Энэхүү амралт нь Христийн үнэт цусаар солигдсон бүхний эдлэх мөнхийн амралт юм. Энэ бол хэзээ ч сахиж дуусахгүй “шаббат” билээ.

4:10 Бурхан долоо дахь өдөр **ажлаасаа амарсны адил хэн Түүний амралтад орно, тэр нь ажлаасаа бүрэн амрах болно.**

Аврагдахаасаа өмнө бид аврагдахын тулд хичээж зүтгэдэг байсан. Харин Христ загалмай дээр авралын ажлыг гүйцэлдүүлснийг мэдсэнийхээ дараа ямар ч хэрэгцээгүй, үнэ цэнгүй хичээл зүтгэлээ орхиж, үхлээс амилсан Аврагчид найдвараа тавьсан.

Аврагдсаныхаа дараа бид, өөрсдийг маань хайрласан Нэгэний төлөө хайраар үйлчилж, Түүнд өөрсдийгөө өгсөн. Бидний сайн үйлс бол дотор минь орших Ариун Сүнсний үр жимс билээ. Түүнд үйлчилж байхдаа бид ядарч сульддаг ч гэлээ үйлчлэлээсээ хэзээ ч залхдаггүй.

Бурханы мөнхийн амралтад орвол бид дэлхий дээрх бүх ажлаасаа амрах болно. Гэхдээ тэнгэрийн улсад очоод ямар ч идэвхгүй болно гэсэн үг биш. Бид тэнд Бурханд үйлчилж, Түүнд мөргөнө. Гэхдээ тэнд ямар ч ядрал цөхрөл, дарамт шахалт, хавчлага зовлон, гай түйтгэр байхгүй болно.

4:11 Өмнөх эшлэлүүд бидэнд Бурханы амралт одоо ч бэлэн байгаа гэдгийг харууллаа. Харин энэ эшлэлд **амралтад орохын** тулд хичээх хэрэгтэй гэдгийг хэлж өгчээ. Тиймээс цорын ганц найдвар маань Христ гэдгийг тодорхой болгохын тулд бид хичээл зүтгэлтэй байх хэрэгтэй. Бид Христэд итгэдэг гэж хоосон амладаг хүмүүс

болж, хавчлага зовлонгийн халуун гал дунд Христээс урвах уруу татлагыг хичээнгүйлэн эсэргүүцэх хэрэгтэй.

Израильчууд хайнга байсан. Тэд Бурханы амлалтыг хөнгөн үзэж, боолчлолын нутаг болох Египет рүү зүрхээ хандуулсан. Тэд Бурханы амлалтыг итгэлээр хүлээн авах гэж шамдаагүй. Үр дүнд нь, тэд Канаан нутагт орж чадаагүй юм. Бид тэдний жишээнээс сургамж авах учиртай.

4:12 Үл итгэл илчлэгдэхгүй өнгөрч чадахгүй гэдгийг дараагийн хоёр эшлэлд нухацтай сануулж байна. Нэгдүгээрт, үл итгэлийг **Бурханы үг** ил болгодог. (Үг гэдгийг *логос* гэсэн грек үгээр илэрхийлжээ. Иохан сайнмэдээний номынхоо эхэнд ашигласан үгтэй ижил байна. Гэвч энэ эшлэлд амьд үг Есүсийг бус, бичигдсэн үг болох Библийг хэлж байна.) **Бурханы энэ үг** бол:

Амьд-байнгын идэвхтэй оршигч

Идэвхтэй-хүч тэнхээ хайрладаг

Хурц иртэй-хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц

Салтал нэвтрэн ордог-хүний дотоод мөн чанарын үл үзэгдэх хоёр хэсэг болох сэтгэл хийгээд сүнснийг, мөн үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог. Үе мөч хүний гадаад хөдөлгөөнд хамгийн чухал хэсэг бол нугас чөмөг нь далд байдаг ч ясны амин чухал хэсэг юм.

Шүүх чадвартай-зүрхний бодол хийгээд санааг ялгаж салгаж, шүүн тунгаадаг. Бурханы үгийг бид биш, харин Бурханы үг биднийг шүүх ёстой ажээ.

4:13 Хоёрдугаарт, үл итгэлийг амьд Эзэн илрүүлдэг. Энд төлөөний үг ерөнхий хэлбэрээс хувьчилсан хэлбэр рүү шилжиж, **Түүний хараанаас нуугдах нэг ч бүтээл үгүй** гэжээ. Эзэний анзааралгүй өнгөрөх зүйл гэж нэг ч үгүй. Тэр бүгдийг мэддэг. Орчлон ертөнцөд болж буй бүхнийг Тэр мэддэг. Гэхдээ Эзэн аль нь жинхэнэ итгэл, аль нь баримтыг хүлээн зөвшөөрөхөөс хэтрэхгүй итгэл болохыг мэддэг гэдгийг энэ эшлэл хэлэхийг зорьжээ.

II. ХРИСТ ТАХИЛЧИЙН ХУВЬД БҮГДЭЭС АГУУ (4:14-10:18)

А. Христийн Тэргүүн Тахилчийн үүрэг Аароны тахилчийн үүргээс агуу (4:14-7:28)

4:14 Энэ эшлэлүүд бичээчийн 3:1 эшлэлд танилцуулсан Христ бол ард түмнийхээ **аугаа Тэргүүн Тахилч** гэсэн санааг дахин авч танилцуулж байна. Христ сул дорой хүмүүсийнхээ агуу эх сурвалж, тэднийг алдагдахаас хамгаалж байдаг гэдгийг эдгээр эшлэл танилцуулдаг. Мөн Эзэнийг шалгаж нягтлагч гэж танилцуулсан бол эндээс эхлээд энэрэн Өрөвдөгч гэж дүрсэлж эхэлжээ. Бурханы үг дотор маань орж ирэхэд (12, 13-р эшлэл) бид өршөөл нигүүлслийг нь эрэлхийлэн Түүн рүү очих боломжтой.

Гайхамшигт Эзэний маань сайхан чанаруудыг эндээс анзаарч харна уу:

1. Тэр бол **аугаа Тэргүүн Тахилч**. Мосегийн хуулийн дагуу олон тэргүүн тахилч гарч ирсэн боловч хэн нь ч аугаа гэж дуудагдаагүй юм.

2. Тэрээр нэг дэх тэнгэр (агаар мандал) ба хоёр дахь тэнгэрийг (сансар огторгуй) өнгөрч Бурханы орших гурав дахь тэнгэрт заларсан билээ. Тэр дээш одож, Эцэгийн баруун гар дахь цог жавхланд орсон.

3. Тэр бол хүн. Түүнийг төрөхөд нь **Есүс** гэж нэрлэсэн. Энэ нэр Түүний хүмүүн чанартай шууд утгаараа холбоотой.

4. Тэр бол Бурхан. Христийг **Бурханы Хүү** гэдэг нь Бурхан Эцэгтэй эн тэнцүү гэсэн утгыг илэрхийлдэг. Тэрээр хүн гэдгээрээ бидний өнцгөөс, Бурхан гэдгээрээ Бурханы өнцгөөс шаардлага хангасан. Түүнийг **аугаа Тэргүүн Тахилч** гэж нэрлэхэд гайхах зүйлгүй.

4:15 Дараа нь бид Түүний үзэж туулсныг ч авч үзэх хэрэгтэй. Төстэй зовлон туулж үзээгүй хүн бусдын зовлонг ойлгож, үнэн сэтгэлээсээ **өрөвдөж** чадахгүй. Хүн болж

ирсэн Эзэн маань биднийхтэй адил туршлага, зовлон бэрхшээлийг бүгдийг туулсан тул бидний тэвчиж туулдаг сорилтуудыг бүрэн ойлгож чадна. (Харин бурууг хэзээ ч үйлдээгүй тул Тэр бидний буруу үйлдэлтэй нэгдэж чадахгүй.)

Зүрх зүсэм шаналал бүрийг
Зовлонгийн Хүн ойлгож чадна

Тэр нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ. Бичвэр Эзэн Есүсийг нүгэлгүй төгс гэдгийг ариун хардалтаар хамгаалдаг. Бид ч мөн тийн хамгаалах ёстой. Тэрээр нүглийг үл мэдэгч (2Ко 5:21) бөгөөд нүгэл үйлдээгүй (1Пт 2:22). Түүнд ямар ч нүгэл байхгүй (1Ио 3:5).

Түүний хувьд Бурханы хувиар ч, хүний хувиар ч нүгэл үйлдэх боломжгүй байсан юм. Төгс хүн болохын хувьд Тэрээр юуг ч Өөрийнхөө хүслээр хийх боломжгүй байсан бөгөөд Эцэгтээ бүрэн дуулгавартай байсан (Иох 5:19). Эцэг Бурхан мэдээж Түүнийг нүгэл рүү хөтлөхгүй.

Тэгвэл Тэр нүгэл үйлдэх боломжгүй юм бол Тэрээр соригдсон нь утга учиргүй гэж маргах нь алдаатай хэрэг болно. Сорилтын нэг зорилго нь Түүнийг нүгэл үйлдэх боломжгүй гэдгийг бүрэн дүүрэн харуулах явдал байсан юм.²

Алтыг тунгааж үзээд цэвэр байвал уг туршилт үнэ цэнгүй гэхгүй шүү дээ. Харин ч алт цэвэр биш байвал тэр туршилт л үүнийг илчилж харуулах байсан. Үүнтэй адил, Тэр нүгэл үйлдэх боломжгүй байсан юм бол төгс хүн байгаагүй гэж хэлж болохгүй. *Үнэндээ нүгэл нь хүнд байх ёстой зайлиггүй зүйл биш.* Харин гаднаас дайран довтолдог зүйл юм. Хүн бид нүглээр сэвтсэн бол Эзэн Есүс бол төгс, өөгүй хүн билээ.

Хэрэв Есүс Хүний хувьд дэлхий дээр байхдаа нүгэл үйлдэж чадах байсан бол тэнгэрт очоод нүгэл үйлдэхгүй гэх ямар баталгаа байгаа вэ? Тэрээр тэнгэр өөд одож, Эцэгийнхээ баруун мутарт залрахдаа ч хүн байхаа болиогүй. Тэрээр газар дээр өө сэвгүй байсан шигээ тэнгэрт ч өө сэвгүй байдаг.

4:16 Одоо энэ эшлэлд **нигүүлслийн хаан ширээнд зоримгоор очицгооё** гэсэн нигүүлсэнгүй уриалгыг өгчээ. Эзэн Есүс биднийг аврахын тулд амиа өргөж, сахин хамгаалахын тулд амьдардаг гэдэг мэдлэг дээр тулгуурлан бид зоримог байдаг. Тэр биднийг ир гэж хэлсэн тул Тэр биднийг баяртайгаар угтана гэдэгт итгэлтэй байж болно.

Хуучин гэрээний өдрүүдэд хүмүүс Түүнд ойртож чаддаггүй байсан. Зөвхөн тэргүүн тахилч жилд ганц л удаа ойртон очих боломжтой байлаа. Харин бид өдөр шөнийн аль ч цагт Түүн рүү ойртон очиж, **хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олж, өршөөлийг хүлээн авч** чадна. Түүний **өршөөл** хийх ёсгүй байсан бурууг минь халхалж, Түүний **нигүүлсэл** хийх ёстой боловч хийх хүч хүрэхгүй зүйлсийг хийх хүчийг өгдөг.

Энэ талаар Морганы бичсэн үг бидэнд их тус болно:

“Хэрэгцээтэй цагт” гэж орчуулагддаг грек хэллэгийг би “тулсан газарт” гэдэгтэй дүйнэ гэж хэлэхээс огт залхдаггүй. Өөрөөр хэлбэл, яг хэрэгтэй тэр агшинд тус болох нигүүлсэл өршөөлийг бид хүлээн авна гэсэн үг. Хэзээ, хаана хэрэг болно, тэр цагт, тэр газарт нигүүлслийг бид олно. Танд сорилт, дайралт ирлээ гэхэд дайралт ирсэн яг тэр цагт Түүн рүү хараагаа чиглүүлбэл яг тэр агшинд танд туслах нигүүлсэл тэнд байж л байна гэсэн үг. Заавал өглөөний залбирлаа хийсний дараа л Бурхан хүсэлтэд чинь хариулна гэж хойшлуулахгүй. Хотын гудамжинд гал мэт сорилттой тулгарлаа гэж бодоход шуудхан Христ рүү хашхирч

тусламж гуйвал яг тэр агшинд, тэр газарт нигүүлсэл байж л байх болно.³

Энэ хүртэл Эзэн Есүсийг эш үзүүлэгч, тэнгэрэлч, Мосе нараас илүү агуу гэдгийг цохон тэмдэглэлээ. Одоо бүгдээрээ Христийн тэргүүн тахилчийн үүрэг алба нь Аароны үүрэг албаас илүү агуу гэдгийг харахаар тахилчийн үүрэг албын тухай үзэх гэж байна. Бурхан Синаи уулан дээр Мосед хууль өгөхдөө хүмүүн тахилчдаар дамжуулан хүмүүсийг Өөртөө ойртуулах зарчмыг тогтоосон. Бурханы хуулийн дагуу тахилчид нь Леви овгоос, Аароны удмаас гарах ёстой. Энэ тогтоолыг Левийн эсвэл Аароны тахилчийн үүрэг алба гэдэг.

Бас нэгэн тэнгэрлэг тахилчийн үүрэг албыг Хуучин гэрээнд дурдсан байдаг нь өвөг эцгүүдийн үеэс улбаатай Мелхизедекийн тахилчийн үүрэг алба билээ. Энэ хүн хууль өгөгдөхөөс ч өмнө, Абрахамын цаг үед амьдарч, хаан ба тахилчийн албыг зэрэг хашиж байлаа. Бичээч бидэнд Эзэн Есүс Христийн тахилчийн албыг Мелхизедекийн хэргэмийн дагуу Аароныхаас ч илүү агуу гэж тайлбарлаж байна.

Эхний дөрвөн эшлэлд Аароны тахилчийн алба юу болохыг тодорхойлсон. Дараагийн 5-10 дугаар эшлэлд Христ тахилч байх шаардлагыг бүрэн хангасан гэдгийг харьцуулан тайлбарлажээ.

5:1 Аароны тахилчийн нэг шаардлага нь тэр тахилч **хүмүүсийн дундаас сонгогдох** явдал юм. Өөрөөр хэлбэл, тахилч нь хүн байх ёстой ажээ.

Тэрээр хүмүүсийн өмнөөс Бурхантай харилцахаар томилогддог байв. Мөн хүн, Бурхан хоёрын дунд зуучийн үйлчлэлтэй онцгой бүлэг хүмүүст хамаардаг байв. Түүний гол ажил үүрэг нь **бэлэг болоод тахилыг нүглээс болж өргөх** явдал байлаа. **Бэлэг** гэж Бурханд зориулж өргөсөн

бүх төрлийн өргөлийг хэлнэ. **Тахил** гэж нүглийн төлөө цус урсгадаг тусгай зориулалтын өргөлийг хэлдэг.

5:2 Тэрээр хүмүүний сул дорой байдалд өр нинжин сэтгэлээр хандаж, төөрөлдсөн, буруудсантай зөөлөн харьцах ёстой байв. Учир нь тахилч өөрөө бусдын адил сул дорой махан биетэй тул ард түмэн ямар бэрхшээлтэй тулгардгийг ойлгох боломж олгодог байв.

Энэ эшлэл дэх **үл мэдэгч** гэсэн үг нь Хуучин гэрээний тахилууд санаатай хийгээгүй нүглүүдийн төлөө зориулагдсаныг сануулдаг. Хууль санаатай нүгэлд зориулж тахил өргөхийг заагаагүй.

5:3 Тахилч өөрөө хүн гэдэг нь бусадтайгаа ижил байх давуу талыг олгодог ч өөрөө бас нүгэлтэй нь сул тал болдог. Тиймээс тахилч **хүмүүсийн болон өөрийнхөө төлөө тахил өргөх ёстой ажээ.**

5:4 Тахилчийн ажил үүргийг хэн дуртай нь хийдэггүй байв. Харин **Аароны нэгэн адил Бурханаар дуудагдсан нь** хийх ёстой байлаа. Бурхан зөвхөн Аарон болон Аароны үр удмыг дуудсан. Аароны гэрийнхнээс өөр хүн асар буюу сүмд үйлчлэх боломжгүй байлаа.

5:5 Эндээс бичээч яриагаа **Христ** рүү хандуулж, Христ тахилч байхад бүрэн тэнцэнэ гэдгийг батлан харуулж байна. Ингэхдээ Христийг Бурхан томилсныг, Христ Бурханы хүмүүн дүр болохыг, Христ болзлыг бүрэн хангасан гэдгийг харуулсан.

Христийн томилгооны тухайд Бурхан Өөрөө эх сурвалж нь байсан билээ. Энэ бол хүний удам угсаатай огт холбоогүй, бүрэн эрхт Нэгэний дуудлага билээ. Мөн энэ томилгоонд эртний аль ч тахилчид байхгүй онцгой харилцаа байсан. Бидний тэргүүн **Тахилч** болбоос Бурханы цор ганц **Хүү**, мөнхөөс Бурханы Хүү болсон Нэгэн. Тэрээр Хүний биед төрөхдөө Бурханы Хүү байсан, мөн үхлээс амилахдаа ч Бурханы Хүү байсан.

5:6 Цаашилбал, Христийн тахилчийн үүрэг алба нь Аароныхаас хавьгүй илүү байсан гэдгийг Дуулал 110:4 дээр Бурхан, **“Мелхизедекийн хэргэмийн дагуу Чи мөнхийн тахилч”** хэмээн тунхагласан байдаг. Энэ талаар 7-р бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. Эндээс харах ёстой гол зүйл нь Христийн тахилчийн алба Аароньхтай адилгүй нь **мөнхийнх** ажээ.

5:7 Христ Бурханы нүгэлгүй Хүү төдийгүй жинхэнэ Хүн юм. Христ **махбодынхоо өдрүүдэд** үүнийг батлахын тулд юу амссаныг бичээч хөндөж байна. Тэр дундаа, Гетсемани цэцэрлэгт болсон үйл явдлыг **“Тэрээр... чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөсөн”** хэмээн онцолжээ. Эдгээр нь бүгд Түүний Бурханд захирагдан дуулгавартай амьдардаг, Түүнд бүрэн найддаг Хүн болох үйлчлэлийнх нь талаар өгүүлдэг бөгөөд нүгэлтэй ямар ч холбоогүй хүний бүхий л мэдрэмж, сэтгэл хөдлөлийг Тэр бидэнтэй адил хуваалцсан тухай өгүүлдэг.

Христ үхлээс аварч өгөөч гэж залбираагүй. Тэр энэ ертөнцөд ирсэн ганц зорилго нь нүгэлтнүүдийн төлөө үхэх байсан шүү дээ (Иох 12:27). Харин Тэр үхсэнийхээ дараа Өөрийг нь үхлээс чөлөөлж, сүнсийг нь Үхэгсдийн оронд бүү үлдээгээч хэмээн залбирсан. Бурхан Түүнийг үхлээс амилуулахдаа энэ залбиралд хариулжээ. **Тэр эмээдэг байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ.**

5:8 Энд бид дахин Бурхан хүмүүсийн төлөө үхэхийн тулд Хүн болсон талаарх гүн гүнзгий нууцтай тулгарч байна.

Тэрээр Хүү нь байсан. Гэхдээ олон хөвгүүдээс нэг нь биш, харин Бурханы цорын ганц Хүү байсан боловч **зовсон зүйлсээсээ дуулгаварт суралцсан.** Тэр энэ дэлхийд Хүн болж ирснээр тэнгэрт хэзээ ч үзэхгүй байх байсан туршлага, зовлон бэрхшээлийг биеэрээ амсаж туулжээ. Өглөө бүр тухайн өдрийн зааварчилгааг Эцэгээсээ авах гэж Тэр чихээ нээдэг байлаа (Иса 50:4). Тэр

дуулгаврыг жинхэнэ утгаар нь, Эцэгийнхээ хүсэлд үргэлж захирагддаг байсан Хүүгийн ёсоор сурсан.

5:9 Тэгээд **Тэр төгс болгогдсон.** Мэдээж энэ нь Түүний зан чанарыг хэлээгүй. Учир нь Эзэн Есүс туйлын төгс билээ. Түүний үг, үйлдэл, арга замуудад ямар ч өө сэв байхгүй. Тэгвэл Тэр ямар утгаараа **төгс болгогдсон** бэ? Бидний Аврагч гэдэг алба үүргийнхээ хувьд төгс болгогдсон гэж хэлж болно. Хэрэв Тэр тэнгэртээ үлдсэн бол хэзээ ч бидний төгс Аврагч болохгүй байлаа. Харин Тэр хүн болж төрөөд амиа өргөөд, булшлагдаж, үхлээс амилж, тэнгэр өөд одохдоо биднийг нүглээс аврах ажлыг бүрэн гүйцээсэн тул эдүгээ ертөнцийн төгс Аврагч болоод цог жавхлан дунд заларч байна.

Тэгээд тэнгэр рүү буцан одсоны дараа **Өөрт нь дуулгавартай байдаг бүхэнд мөнх авралын эх үндэс нь болжээ.** Тэр бол бүх хүний авралын Үндэс мөн боловч Түүнд **дуулгавартай байдаг** хүмүүс л аврагдана.

Энэ эшлэлд **аврал** дуулгавартай байх гэсэн нөхцөлтэй мэт харагдаж байна. Гэтэл Библийн бусад хэсэгт авралын нөхцөл болзол бол итгэл гэж гардаг. Тэгвэл энэ хоёр яаж хоорондоо уялдах вэ? Юун түрүүнд, энд итгэлийн дуулгавартай байдлыг хэлж байна (Ром 1:5; 16:25-27). Товчхондоо, Бурхан хүнээс Өөрийнх нь үгэнд итгэж, дуулгавартай байхыг шаарддаг. Нөгөө талаар, жинхэнэ авралд хүргэх итгэл нь дуулгавартай байдлын үр дүнд зайлшгүй хүргэдэг. Шинэ гэрээний утгаар бол дуулгавартай байхгүйгээр итгэх ямар ч боломж үгүй.

5:10 Эзэн Есүс тахилчийн үйлчлэлийн суурь үндсэн ажлыг яруу алдартайгаар гүйцэтгэсэн тул Бурхан Түүнийг **Мелхизедекийн хэргэмийн дагуу Тэргүүн тахилчаар өргөмжлөв.**

Энд нэг зүйлийг тэмдэглэх хэрэгтэй. Христийн тахилчийн үүрэг алба нь Мелхизедекийн хэргэмийн дагуу боловч ажил үйлчлэл нь Аароны үйлчлэлтэй олон талаар

төстэй. Үнэндээ, иудей тахилчдын үйлчлэл Христийн гүйцэтгэх ажлын сүүдэр буюу бэлгэдэл дүр зураг нь байсан юм.

5:11 Энэ мөчөөс эхлэн бичээч сэдвээсээ бага зэрэг хазайх хэрэгтэй болно. Тэрээр Христийн Мелхизедекийн хэргэмийн дагуух тахилчийн үүрэг албын талаар үргэлжлүүлэн яримаар байвч чадсангүй. Ариун Сүнс түүнийг шахамдуулж, уншигчдынхаа төлөвшилгүй байдлыг зэмлэхийг, итгэлээс салан одох аюулыг нухацтайгаар сэрэмжлүүлэхийг ятгажээ.

Бурханы үнэнийг ухаарах хэмжээ бидний сүнслэг төлөвлөөөс хамаарч байдаг нь гашуун боловч үнэн юм. **Хатуу чих** гүнзгий үнэнүүдийг хүлээн авч чаддаггүй. Эзэн шавь нартаа олон зүйл хэлэхийг хүссэн ч тэд түүнийг нь даах чадваргүй байсан нь үүний нэг тод жишээ юм (Иох 16:12).

5:12 Захидлыг уншигч еврейчүүд урт удаан сургаал сонсож, заалгаж ирсэн тул одоо бусдад **заах** хэмжээнд хүрсэн байх ёстой байтал **Бурханы** үгийг анхан шатнаас нь өөр хүнээр заалгах хэмжээний төлөвшилгүй байгааг бичээч сануулж байна.

Энэ цагт та нар багш байх ёстой байсан. Итгэгч хүн бүр бусдад заах хэмжээнд төлөвшихийг Бурхан хүсдэг. Нэг нь нөгөөдөө заах зарчим бүх итгэгчдэд хамаатай. Зарим хүнд багшлах гэдэг тусгай бэлэг авьяас байдаг нь үнэн ч итгэгч хүн бүхэн бусдад заах ажилд өөрийн хувь нэмрийг оруулах үүрэгтэй юм. Бурханы ажил цөөн хэдэн хүний хүрээнд явах нь Бурханы санаа зорилго огт биш ээ.

Та нарт бор хоол бус, харин сүү хэрэгтэй болсон байна. Бодит амьдрал дээр сүүнээс гарч бор хоолонд ордоггүй хүүхдийн эрүүл мэнд асуудалтай болдог. Сүнслэг өсөлтийн явц ч гэсэн үүнтэй ижил юм (1Ко 3:2).

5:13 Дахин төрөөгүй боловч өөрийгөө итгэгч гэдэг хүмүүс **сүүн** хоолноос эс салах ба **зөвт байдлын үгэнд**

гаршдаггүй. Тэд үгийг зөвхөн сонсохоос биш эс үйлдэнэ. Тэд ашиглахгүй зүйлсээ алдаж, мөнхөд балчир хүүхэд хэвээр үлддэг.

Тэдэнд сүнслэг зүйлсийн цаад нарийн учир шалтгааныг шүүн тунгаах мэргэн ухаан үгүй. Тиймдээ ч “давалгаанд энд тэнд шидэгдэн, аливаа номлолын салхи, хүмүүсийн ов мэх болон зальхай хуйвалдааны башир аргад туугдсаар явдаг.” (Еф 4:14)

5:14 Сүнсний бор хоол нь төлөвшсөн, насанд хүрсэн хүмүүст зориулагдсан. **Учир нь тэдний сэрэхүй сайн мууг ялгахад дасгалжсан байдаг.** Тэд Бурханы үгээс хүлээн авсан гэрлээ дагаж явсаар сүнслэг зүйлсийг шүүн тунгаах чадварт суралцаж, ёс суртахууны болон сургаал номлолын аюулаас өөрсдийгөө хамгаалдаг.

Хам сэдвийг нь бодож үзвэл **сайн мууг ялгах** гэдэг нь христитгэл ба иудейзмийг хооронд нь ялгаж таньдаг байхыг илэрхийлж байна. Иудейзм муу гэсэн үг биш. Левийн хуулийг Бурхан Өөрөө тогтоож өгсөн. Гэвч энэ хууль Христ рүү чиглүүлж, Түүнд хүргэх зорилготой байсан. Христ бол тэрхүү зан үйл, ёслол бүхний жинхэнэ биелэл юм. Одоо Христ нэгэнт ирсэн тул Түүнийг бэлгэдсэн юмсыг Түүнээс дээгүүр тавих нь нүгэл болно. Учир нь хүний зүрх сэтгэл, үнэнч байдлын тухайд Христтэй өрсөлдөх ямар ч зүйл ёрын муу билээ. Сүнсээр төлөвшсөн итгэгчид Аароны тахилчийн үүрэг албыг Христийнхээс дор гэдгийг ялгаж салгаж ойлгож чаддаг.

6:1 Энэ бүлэгт 5:11 эшлэлээс эхэлсэн сануулга сэрэмжлүүлгийг үргэлжлүүлэн ярина. Энэ бол Шинэ гэрээний хамгийн их маргаан дагуулдаг хэсгүүдийн нэг билээ. Үнэн зөв, бурханлаг олон итгэгч энэ бүлгийн тайлбар дээр санал зөрөлддөг. Тиймээс бидний зүгээс нэг талыг хэт барьсан тайлбар хийх ёсгүй юм. Харин хам сэдэв болон Шинэ гэрээний бусад хэсэгтэй хамгийн нийцэж байгаа тайлбарыг л танилцуулах болно.

Юуны өмнө, **Христийн тухай балчир ойлголтыг орхихыг** бичээч уншигчдадаа уриалж байна. Үүнийг үгчилж орчуулбал, “Христийн тухай суурь сургаал”-аас цааш ахихыг уриалж байна. Энэ нь Хуучин гэрээнд заасан Мессиаг ирэхэд Израилийг бэлтгэх зорилготой үндсэн сургаалуудыг хэлсэн гэж бид ойлгодог. Энэ сургаалуудыг 1-р эшлэлийн сүүл болон 2-р эшлэлд жагсаасан байдаг. Жагсаалтыг харвал тэдгээр нь христигтэлийн суурь сургаалууд биш, харин хожим баригдах барилгын суурийг бүтээсэн анхан шатны мөн чанартай, Хуучин гэрээний сургаалууд болох нь харагдана. Уг сургаалууд үхлээс амилж, цог жавхланд орсон Христийг бүрэн харуулдаггүй. Бичээч ийм энгийн сургаалуудыг одоо орхи хэмээн ятгаж байна. Гэхдээ тэднийг ямар ч үнэ цэнгүй гэж орхих биш, харин түүнээс цааш ахиж, илүү насанд хүрсэн төлөвшил рүү ир гэсэн санаа юм. Дам утгаараа, иудейзмын цаг үе бол сүнслэг байдлын хувьд балчир үе ажээ. Харин христигтэл нь насанд хүрсэн үе юм.

Нэгэнт сууриа тавьсан бол цааш нь барилгаа барих ёстой. Сургаалын суурь нь Хуучин гэрээнд тавигдчихсан. Энд жагсаасан зургаан сургаал үүнд багтана. Христ, Христийн мөн чанар, Христийн ажил үйлсийн тухай Шинэ гэрээний сургаалууд нь төлөвшлийн үйлчлэлийг төлөөлдөг.

Хуучин гэрээний эхний сургаал нь **үхлийн үйлсээсээ гэмших** тухай байдаг. Үүнийг эш үзүүлэгчдээс эхлэн Мессиагийн замыг бэлтгэгч Иохан хүртэл тасралтгүй тунхагласан. Хүмүүс итгэлгүй байсан тул тэд бүгд **үхлийн үйлсээсээ** эргэхийг уриалдаг байсан юм.

Энд гарч буй **үхлийн үйлс** өмнө нь зөв гэгддэг байсан боловч эдүгээ Христ ирсэн тул утгаа алдан **үхлийн үйлс** болсныг хэлж байж болох юм. Жишээлбэл, сүмийн тахилтай холбоотой бүх дэг жаяг, ёслолууд Христийн төгс гүйцэлдүүлсэн үйл хэргийн улмаас хүчингүй болсон шүү дээ.

Бичээчийн дурдсан хоёр дахь сургаал нь **Бурханд итгэх** явдал байв. Энэ ч бас Хуучин гэрээний голлох сэдэв юм. Гэтэл Шинэ гэрээнд итгэлийн гол цөм нь үргэлж Христ Өөрөө байдаг. Энэ нь Бурханд итгэх итгэлийг үгүйсгэж байгаа юм биш, харин Христийг гадна тавиад Бурханд итгэх нь хангалтгүй болсон гэсэн санаа юм.

6:2 Баптисмын тухай заавар гэж энд хэлсэн нь христитгэлийн баптисмд хамаарахгүй. Харин тахилчид болон Израилийн ард түмний сүсэг бишрэлийн амьдралд чухал байр суурь эзлэх угаал ариутгалыг хэлсэн юм (мөн 9:10-ыг үз).⁴

Гар тавих зан үйлийн талаар Леви 1:4, 3:2, 16:21 дээр тодорхой заасан байдаг. Өргөл өргөж буй хүн эсвэл тахилч амьтны толгой дээр гараа тавьж, түүнтэй нэг болж буйгаа илэрхийлдэг байв. Ингэснээр уг амьтан тухайн нүгэлд оролцсон хүмүүсийн нүглийг үүрсэнд тооцогддог байжээ. Энэ зан үйл нь эвлэрүүллийг бэлгэддэг. Энд яригдаж буй гар тавилт нь Чуулганы эрин үед элч нар болон үйлчлэгчдийн хийж байсан гар тавих үйлчлэлийг хэлээгүй гэж бид үздэг (Үйл 8:17; 13:3; 19:6).

Үхэгсдээс амилуулагдах тухай сургаал Иов 19:25-27, Дуулал 17:15 дээр бий. Мөн Исаиа 53:10-12 дээр шууд бус утгаар илэрхийлсэн байдаг. Хуучин гэрээнд бүдэг бадаг илэрхийлсэн энэ үнэн Шинэ гэрээнд тодоос тод илчлэгджээ (2Тм 1:10).

Хуучин гэрээний хамгийн сүүлийн суурь үнэнүүдийн нэг нь **мөнхийн шийтгэл** юм (Дуу 9:17; Иса 66:24).

Эдгээр анхан шатны сургаалууд иудейзмд байдаг ба Христийг ирэхэд бэлтгэх зорилготой байв. Христитгэгч бид эдгээр үнэнд сэтгэл ханаж зогсох бус, харин Христээр дамжин ирсэн бүрэн илчлэл рүү урагшлах хэрэгтэй. Бичээч уншигчдадаа хандан, “сүүдрээс бодит зүйл рүү, бэлгэдлээс жинхэнэ биелэл рүү, өнгөн хэсгээс цөм рүү, эцэг

өвгөдийнхөө шашны үхмэл хэлбэрээс Христийн амьд үнэн рүү” ирэхийг ятгаж байна.

6:3 Бичээч, **Бурхан зөвшөөрвөл** үүнийг хийхэд нь уншигчдадаа туслах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Гэвч ахиц гарах эсэхийг хязгаарлах хүчин зүйл нь Бурханы талд бус хүний талд байдаг. Бурхан Өөрийн хүүхдүүдийг сүнсээр бүрэн төлөвших бүх боломж, нөөцөөр хангаж чадна. Харин хүүхдүүд нь жинхэнэ итгэл ба тэвчээрээр Бурханы үгийг дагаж, эерэг байх шаардлага бий.

6:4 Одоо бид итгэлээсээ санаатай урвахын эсрэг сэрэмжлүүлсэн сэрэмжлүүлгийн цөмд ирээд байна. Энэ хэсэг нэгэнт итгэлээс нүүр буруулсан хүмүүст хандан тэднийг дахин гэмших боломжгүй гэж байна. Хэдийгээр энэ хүмүүсийг Христэд итгэсэн гэж дурдагдаагүй ч нэгэн цагт гэмшсэн мэт харагдаж байна. Харин тэд дахин гэмших боломжгүй гэдгийг энд тов тодорхой мэдэгджээ.

Энэ хүмүүс хэн бэ? 4, 5-р эшлэлд өгсөн дүр зургаар тэднийг таньж болно. Тэдний амссан агуу завшааныг нягтлан үзвэл аврагдаагүй хүмүүст ч гэсэн байж болох шинж тэмдгүүд байна. Тэднийг энд дахин төрсөн гэж огт хэлээгүй. Мөн авралд хүргэх итгэлтэй, Христийн цусаар аврагдсан, мөнх амьтай болсон ч гэж хэлээгүй байдаг.

Тэд **нэгэнтээ гэгээрүүлэгдсэн**, Бурханы нигүүлслийн сайнмэдээг сонссон л гэсэн байна. Ямартай ч авралд хэрхэн хүрэхийг мэддэг болсон байна. Ийм хүмүүсийн тод жишээ бол Искаротын Иудас байлаа. Гэвч тэр гэгээрүүлэгдсэн боловч гэрлээс татгалзсан юм.

Тэд **тэнгэрлэг бэлгийг амссан**. Эзэн Есүс бол тэнгэрлэг Бэлэг юм. Тэд Түүнийг амссан боловч итгэлийн шийдмэг үйлдлээр Түүнийг хэзээ ч хүлээн авч байгаагүй. Хүн идээ ундааг идэж, уухгүйгээр амсаад өнгөрч болдог. Хүмүүс цөстэй хольсон дарсыг загалмайд хадагдсан Есүст өгөхөд Эзэн түүнээс амссан боловч уугаагүй (Мт 27:34). Христийг амтлаад өнгөрөх нь хангалтгүй. Хүний Хүүгийн

махыг идэж, цусыг уух буюу Түүнийг Эзэн ба Аврагчаа болгон хүлээн авахаас нааш бид мөнх амьтай болж чадахгүй (Иох 6:53).

Тэд **Ариун Сүнсний хуваалцагч болсон**. Үүнийг үзээд тэднийг дахин төрсөн гэж шууд дүгнэхээсээ өмнө Ариун Сүнс дахин төрөхөөс нь өмнө хүмүүсийн амьдралд ажилладаг гэдгийг санацгаая. Тэр үл итгэгчдийг ариусгадаг (1Ко 7:14). Өөрөөр хэлбэл, авралын тухай мэдэж болох боломжийг Тэр өгдөг гэсэн үг. Ариун Сүнс үл итгэгчдийн нүглийг ухааруулж, зөвт бус явдлыг нь харуулж, айсуй шүүлтийн талаар мэдүүлдэг (Иох 16:8). Ариун Сүнс хүмүүсийг гэмшилд хөтөлж, цорын ганц найдвар болох Христ рүү чиглүүлдэг. Иймээс хүмүүс Түүнийг дотроо хүлээж аваагүй ч гэсэн Түүний ашиг тусыг хүртэж болох юм.

6:5 Тэд Бурханы сайн үгийг амссан. Сайнмэдээг тунхаглахад тэдний сэтгэл хөдөлж, түүнд татагдсан. Тэд яг л чулуулаг хөрсөнд унасан үртэй адил, үгийг сонсоод тэр даруй баяр хөөртэйгөөр хүлээн авах боловч үндэсгүй тул хэсэг хугацааны дараа зовлон бэрхшээлт тулгарахад замаасаа эргэнэ (Мт 13:20, 21).

Тэд **ирэх үеийн хүчийг амссан**. Энд **хүч** гэдэг нь “гайхамшиг” гэсэн утгаар орж байна. **Ирэх үе** гэж Христ дэлхий дээр мянган жил хаанчилж, бүгдийг энх амгалан, хөгжил цэцэглэлтэй болгох мянган жилийн хаанчлалыг илэрхийлж байна. Чуулганы эрин үеийн эхэнд сайнмэдээний тунхгийг дагалдсан гайхамшгууд нь (Евр 2:4) ирээдүйд Христийн хаанчлалд илрэх тэмдэг хийгээд гайхамшгуудын зах зухаас амсуулсан хэрэг юм. Энэ хүмүүс нэгдүгээр зуунд тохиосон уг гайхамшгуудыг нүдээр үзэж, магад түүнд нь оролцсон ч байх боломжтой. Жишээлбэл, таван талх, хоёр загасаар таван мянгыг хооллосон гайхамшгийг авч үзье. Есүс таван мянган хүнийг хооллосны дараа хүмүүс Түүнийг нуурын нөгөө

эрэг хүртэл дагасан. Аврагч тэднийг хараад тэд гайхамшигийг амталсан боловч Өөрт нь үнэндээ итгэж, хүлээж аваагүй гэдгийг мэдэж байсан. Тиймээс Тэр тэдэнд, “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Та нар тэмдгүүдийг үзсэндээ Намайг хайгаагүй, харин талх идэж цадсан учраас хайж байна” гэж айлдсан (Иох 6:26).

6:6 Тэд дээр дурдсан боломж завшааныг хүртсэнийхээ дараа **завхайрвал дахин шинээр гэмших боломжгүй**. Тэд итгэлээс урвах нүглийг үйлдсэн байна. Там руу явж байсан зам дээр нь гэрэл тусаж, үнэнийг харуулсан боловч одоо унтарсан гэсэн үг.

Итгэлээс урвах нь ямар ноцтой нүгэл болохыг дараах үг тодорхой илэрхийлэн харуулдаг! **Тэд өөрсдөдөө Бурханы Хүүг дахиад цовдолж, илэрхий гутамшиг болгодог**. Тэр хүмүүс Христийг ойлгож мэдэхгүйдээ биш, харин санаатай зориуд, доромжлон үгүйсгэдэг гэсэн үг. Цаашилбал, тэд Христээс илт урваж, Христийн дайснуудтай нэгдэж, Христийг Өөрийг нь болон үйл хэргийг нь гутаан доромжилдог.

ИТГЭЛЭЭС УРВАХ ТАЛААР НЭМЭЛТ ТАЙЛБАР

Сайнмэдээг сонсож, итгэгч болсноо зарлаж, Христийн чуулганд нэгдсэнийхээ дараа итгэсэн гэдгээ эцэст нь үгүйсгэж, Христийг зориудаар няцааж, итгэгчдийн нөхөрлөлөөс гарч, Эзэн Есүс Христийн дайснуудтай нэгдэхийг итгэлээс урвах гэдэг. Итгэлээс урвах нүглийг зөвхөн үл итгэгчид л үйлдэж чадна. Зөвхөн хууртсан хүмүүс ч биш, мэдсээр байж, санаатайгаар, сайн дураараа, зориудаар Эзэнийг үгүйсгэдэг нүгэл юм.

Сайнмэдээг сонссон боловч сайнмэдээний талаар ямар нэг хариу илэрхийлээгүй жирийн үл итгэгчдийн нүгэлтэй үүнийг андуурч болохгүй. Жишээлбэл, хүн Ариун Сүнсний урилгыг олон дахин авсан ч Христийг хүлээн

аваагүй байж болно. Тэгвэл тэр хүн итгэлээс урвасан юм биш. Тэр хүн хожим нь Аврагчийг магад хүлээн авч аврагдах боломжтой. Мэдээж тэр хүн итгэхгүйгээр нас барвал түүнд аврал байхгүй. Гэхдээ амьд сэрүүн байх хугацаандаа Эзэнд итгэх боломж түүнд хэзээд байна.

Итгэлээс урвасан хүнийг буруудаж алдсан итгэгчтэй андуурч болохгүй. Жинхэнэ итгэгч хүн Христээс маш хол тэнэж одох боломжтой. Нүглийн улмаас түүний Бурхантай харилцах харилцаа хөндийрч болно. Тэр хүн итгэгч гэж танигдахын аргагүй болтлоо хол явж ч болох юм. Гэвч нүглээ улайж, гэмшиж, нүглээсээ эргэх л юм бол Бурхантай эргээд яг өмнөх шигээ нөхөрлөх боломжтой (1Ио 1:9).

Итгэлээс урвах нь сайнмэдээний номуудад дурдагдсан уучлагдашгүй нүгэлтэй адилгүй. Эзэн Есүсийн үйлдсэн гайхамшгийг чөтгөрүүдийн жононд хамаатуулсан нь тэдний нүгэл байсан юм. Эзэн Есүсийн гайхамшгууд Ариун Сүнсний хүчээр хийгдсэн. Үүнийг чөтгөрийнх гэж хэлэх нь Ариун Сүнсийг доромжилсон хэрэг билээ. Энэ нь Ариун Сүнсийг чөтгөр гэснээс ялгаагүй. Ийм нүгэл энэ үед ч, ирэх үед ч уучлагдахгүй гэж Эзэн Есүс айлдсан (Мк 3:22-30). Итгэлээс урвах явдал нь мөнхийн нүгэл гэдэг утгаараа Ариун Сүнсийг доромжлохтой адил, хоёулаа мөнхийн үр дагавартай. Гэхдээ төстэй байдал нь зөвхөн энэ хүрээнд л хамаарна.

Би итгэлээс урвах нүглийг 1Иохан 5:16 дээр гардаг үхэлд хүргэх нүгэлтэй адил гэж үздэг. Иохан тухайн үед итгэгч гэж нэрлэгдэн, нутгийн чуулганд хамрагдаж байсан хүмүүсийн тухай бичсэн байдаг. Харин тэд дараа нь гностикуудын хуурамч сургаалыг дагаж, итгэгчдийн нөхөрлөлөөс санаатайгаар гарч явсан байдаг. Христитгэлт хамт олны дундаас зориуд гарч явсан нь тэднийг үнэхээр дахин төрөөгүйг харуулдаг (1Ио 2:19). Есүс бол Христ гэдгийг ил тод үгүйсгэсэн нь (1Ио 2:22) тэднийг үхэлд

хүргэх нүгэлд унагажээ. Тэдний гэмшлийн төлөө залбирах нь үр дүнгүй ажил ажээ.

Зарим чин сүсэгтэй итгэгчид Еврей 6-р бүлэг болон ижил төстэй эшлэлүүдийг уншаад түгшдэг. Сатан энэ эшлэлүүдийг урвуулан ашиглаж, бие махбод, бодол санаа, сэтгэлийн зовлонтой сул дорой итгэгчдийг зовоох гэж оролддог. Тэд өөрсдийгөө Христээс салан одох вий хэмээн эмээж, дахин Бурхан уруу эргэж сэргээгдэх найдваргүй болчихлоо гэж эмээдэг. Авралын хил хязгаарыг давчихсан мэт санаж санаа зовнидог. Ийн эмээж, санаа зовж байгаа нь тэднийг итгэлээс урвагч биш гэдгийг баталдаг. Учир нь итгэлээс урвасан хүнд ийм төрлийн айдас байдаггүй. Харин ч Христийг гутаахдаа бардам, ширэн нүүртэй байдаг.

Итгэлээс урвах нүгэл итгэгчдэд хамаагүй юм бол өнөөдөр хэнд хамаатай вэ? Тийм хүмүүсийн нэг жишээ хэлье. Өөрийгөө Христэд итгэсэн хэмээдэг нэгэн залуу хэсэг хугацаанд гал цогтой явжээ. Гэтэл удалгүй амьдралд нь ямар нэг зүйл тохиолдоно. Магадгүй бусдаас ширүүн хавчлага ирж л дээ. Өнөөх залуу ёс бус байдалд автаж болох юм. Аль эсвэл их сургуульд ороод шашингүй үзэлтэй багш нарын дэвшүүлсэн Христийн эсрэг үзэл санааг хүлээн авч л дээ. Ийнхүү үнэнийг сайн ойлгосон атал сайн дураараа үнэнээс ухарч, эргэнэ. Тэгээд Христийг бүрмөсөн няцааж, христитгэлийн тулгуур ариун сургаалуудыг заналтайгаар дэвсэлж эхэлнэ. Ийм хүнд дахин гэмших боломж байхгүй гэж библи хэлдэг. Түүхэн баримт ч үүнийг баталдаг. Бидний мэдэх олон хүн ийм байдлаар Христээс нүүр буруулахыг бид харж, тэднээс хэн нь ч эргэж ирээгүй билээ.

Энэ үеийн төгсгөл ойртох тусам итгэлээс урвах явдал гаарна гэдгийг бид мэдэж байх хэрэгтэй (2Тс 2:3; 1Тм 4:1). Тиймээс тэр өдөр ойртох тусам, итгэлээс урвах талаар сэрэмжлүүлсэн үгс улам үнэ цэнтэй сануулга болж байна.

6:7 Одоо бичээч байгаль дэлхийн жишээг ашиглан жинхэнэ итгэгч (7-р эшлэл) болон итгэлээс урвасан хүн (8-р эшлэл) хоёрыг дүрслэн харуулж байна. Энэ хоёр хүнийг хоёуланг нь газартай зүйрлэжээ. 4 болон 5 дугаар эшлэлд дурдагдсан боломж завшааныг тэнгэрээс тэтгэх хур **бороотой** зүйрлэжээ. Харин газраас ургах ургац нь тухайн хүн боломж завшааныг хэрхэн хүлээн авч, ямар хариу үйлдэл үзүүлэх үр дүн юм. Ямар ургамал гарахаас шалтгаалаад ерөөгдөх үү, хараагдах уу гэдэг нь шийдэгдэнэ.

Жинхэнэ итгэгч **бороог** уудаг, **өөрийг нь** эдлэгсдэд **ашигтай ургамал гаргадаг** газартай адил, **Бурханаар** ерөөгдөнө.

6:8 Харин итгэлээс урвагч нь сайн услагдсан ч **хогийн ургамал ба халгайг** буюу нүглийн үр дагаврыг **ургуулдаг** газартай адил билээ. Ийм газар хүлээн авдаг боловч ашигтай ургамал нэгийг ч ургуулдаггүй. Ийм газар хэнд ч хэрэггүй. Энэ хүн аль хэдийнээ яллагджээ. **Шатаагдаж төгсөх** тавилан л түүнийг хүлээж байна.

6:9 Өмнөх эшлэлд өгүүлсэн итгэлээс урвагчид нь үл итгэгч гэдгийг нотлох хоёр хүчтэй нотолгоо 9, 10-р эшлэлд бий. Эхнийх нь төлөөний үг гэнэтхэн өөрчлөгдсөн явдал юм. Итгэлээс урвагчдыг ярьж байхдаа бичээч “тэд” гэж ярьсан бол жинхэнэ итгэгчдэд хандахдаа “та нар” гэдэг төлөөний үгийг ашиглажээ.

Хоёр дахь нотолгоо нь бүр тодорхой байна. Итгэгчдийн тухай бичээч **“Хайртууд минь, хэдийгээр бид ийнхүү ярьж байгаа боловч та нарын тухай илүү сайн зүйлс буюу авралд хамаатай зүйлсийн тухайд итгэлтэй байна”** гэжээ. Тэгэхээр 4 – 6, 8 дугаар эшлэлд тайлбарласан зүйлс бол авралтай холбоогүй гэж дүгнэж болохоор байна.

6:10 Ариун хүмүүсийн амьдралд авралын үр дүнд ил тод харагддаг хоёр зүйл бол **үйлчлэл ба хайр** юм. Ариун хүмүүсийн итгэл нь сайн үйлсээр илэрдэг. Мөн итгэлийн

гэр бүлийг хайрлах **хайраар** харагддаг. Энэ л жинхэнэ христитгэлийн мөн чанар билээ. Тэд Эзэний төлөө Эзэний хүмүүст байнга үйлчилдэг.

6:11 Дараагийн хоёр эшлэлийг арай өөр төрлийн хүмүүст хандаж бичсэн бололтой. Тодруулбал, бичээчийн зүгээс шууд тодорхойлох аргагүй, иудейзм рүү халтирах магадлалтай хүмүүст ханджээ.

Юуны өмнө, бичээч тэднийг **найдварын бүрэн баталгааны төлөө эцсээ хүртэл** жинхэнэ итгэгчидтэй **адилхан хүчин чармайлт** гаргаасай гэж хүссэн байна. Өөрөөр хэлбэл, христитгэлийн эцсийн найдварыг тэнгэрт үзэх хүртлээ Христийн төлөө тууштай байхыг захиж байна. Энэ бол үнэн итгэлтэй байсны баталгаа юм.

6:12 Тэд хойргошиж, алхам нь удааширч, зориг нь мохож унтрахаас болгоомжлох ёстой. Мөн **итгэл ба тэвчээрээр амлалтыг** өвлөн авдаг бүх жинхэнэ итгэгчдийн үлгэр жишээг дуурайн, шантралгүй урагш тэмүүлэх хэрэгтэй.

6:13 Зургаадугаар бүлгийн төгсгөл хэсэг нь 12-р эшлэлд гардаг итгэл, тэвчээрээр урагшлах ятгалгатай холбогддог. **Абрахамыг** жишээг урам зориг болгож өгөөд итгэгчдийн найдвар баттай, хөдөлшгүй гэдгийг бататгадаг.

Нэг талаар, итгэгч хүн бүхнээ Христийн төлөө орхиж, бусдад үзүүлэх юу ч үгүй болох нь өрөвдөлтэй харагдаж болох юм. Түүний бүх амлалт ирээдүйд хамаарна. Тэгвэл Христийн амлаад байгаа найдвар хоосон биш гэдгийг яаж мэдэх вэ?

Хариулт нь **Абрахамд** өгсөн Бурханы **амлалтаас** олдоно. Энэ амлалт нь хожим Христээр дамжуулан биелэлээ олох Бурханы амлалтын эх үндсийг өөртөө агуулж байсан. **Бурхан амлалт өгөхдөө Өөрөөсөө агуу хэнээр ч андгайлах боломжгүйгээс хойш Өөрөөрөө тангарагласан.**

6:14 Бурхан Эхлэл 22:16, 17 эшлэлд “Би Өөрөөрөө тангараглаж байна. Би үнэхээр чамайг ерөөж, үр удмыг чинь... асар олон болгоно” хэмээн амласныг харж болно. Бурхан амлалтаа биелүүлэхийн тулд Өөрийнхөө нэрээр тангарагласан учраас биелэл нь баталгаатай болсон юм.

6:15 **Абрахам** Бурханд итгэж, **тэвчээртэй хүлээснээрээ** биеллийг нь харжээ. Үнэндээ, Абрахам Бурханд итгэсэн нь ямар ч гарз, эрсдэлгүй байсан. Бурханы үг бол орчлон ертөнцийн хамгийн баталгаатай зүйл мөн. Бурханы аливаа **амлалт** бол аль хэдийнээ биелсэн мэт баттай зүйл билээ.

6:16 Хүний ёсонд **хүмүүс өөрсдөөсөө агуу нэгнээр андгайлдаг**. Жишээ нь, шүүх хурал дээр хүмүүс үнэнийг хэлнэ гэж амлаад араас нь “Бурханаар андгайлдаг.”

Хүн амлалтаа баталж **андгай** өргөвөл **зөрчлийг** эцэслэж, амлалтаа сахина гэсэн ойлголтыг бусдад өгдөг.

6:17 Өөрийнх нь амлалт гарцаагүй биелнэ гэдэгт бүү эргэлзээсэй гэж **Бурхан** Өөрт нь итгэгч хүмүүсээс хүсдэг. Үнэндээ, Түүний амлалт дангаараа хангалттай боловч Бурхан амлалтаа баталгаажуулж амлалт дээрээ нэмж **андгай өгчээ**.

Амлалтыг өвлөгчид гэдэг нь итгэлээрээ итгэмжит Абрахамын үр удам болсон бүх хүнийг хэлнэ. Энд яригдаж буй **амлалт** нь Түүнд итгэсэн бүгдэд өгөгдөх мөнхийн авралын амлалт юм. Бурхан Абрахамын үрд амлалт өгсөн ба уг амлалтын бүрэн дүүрэн биелэл Христийн дотор оршдог. Христтэй нэгдэх үед ирдэг бүх ерөөл тэр амлалтад *багтсан*.

6:18 Тэгэхээр итгэгч хүн Бурханы үг ба андгай гэсэн хэзээ ч хувирахгүй **хоёр зүйлд** түшиглэх боломжтой болжээ. Энэ хоёроос илүү найдвартай, баталгаатай зүйл байх боломжгүй. Бурхан Христэд итгэсэн бүгдийг аварна гэж амлаад амлалтаа андгайгаар баталгаажуулав. Эндээс

гарах гарцаагүй дүгнэлт бол итгэгч хүний аврал мөнхөд баталгаатай юм.

Зургаадугаар бүлгийн үлдсэн хэсэгт бичээч итгэгчдийн найдварыг хөдөлшгүй бат гэдгийг дөрвөн зүйрлэлээр дүрслэн харуулжээ. Үүнд, (1) хоргодох газар, (2) зангуу, (3) урд маань гүйгч, (4) Тэргүүн Тахилч гэх мэт хамаарна.

Нэн тэргүүнд, жинхэнэ итгэгчдийг сүйрч буй энэ ертөнцөөс тэнгэрлэг **хоргодох газар** руу зугтааж буй хүмүүстэй жишин зүйрлэв. Зугтах замналд нь зоригжуулахын тулд Бурхан тэдэнд Өөрийн үг ба андгайгаар хэзээ ч үл хувирах **найджарыг** соёрхсон гэжээ.

6:19 Амьдралын салхи шуурга, сорилт бэрхшээл дунд энэ **найджар** нь **сэтгэлийн зангуу** болдог. Хожим цог жавхланд орох маань аль хэдийнээ биелсэн мэт баттайг мэдэх нь эргэлзээ, цөхрөлийн догшин давалгаанд туугдахаас хамгаална.

Энэ **зангуу** ертөнцийн тогтворгүй, нүүдэг элсэнд бус, тэнгэр дэх ариун асарт бат бэхлэгдсэн байдаг. Бидний **найджар** зангуу юм бол энэ зангуу **хөшигний цаана** байх Бурханы оршихуйд баттай тогтсон гэсэн үг. Зангуу маань тэнд баттай байгаа юм бол бид ч бас тэнд очих нь зайлшгүй ажээ.

6:20 **Есүс** тэнгэрийн ариун газар руу **бидний төлөө урд маань гүйгч адил орсон билээ**. Есүс тийш орсон нь Түүнтэй нэгдсэн бүгд орно гэдгийг ч мөн баталгаажуулдаг. Энэ дэлхий дээрх хамгийн дорд итгэгч хүн хүртэл тэнд орсон ариун хүмүүсийн адил тийш орно. Үүнд эргэлзэх ямар ч шалтгаан үгүй.

Д. Андерсон-Берри энэ талаар ийн бичжээ:

“Урд маань гүйгч” гэж орчуулагдсан энэ үг Шинэ гэрээнд өөр газар гардаггүй. Энэ бол Левийн тахилчийн тогтолцоонд огт байдаггүй ухагдахуун юм. Учир нь Хуучин гэрээнд тэргүүн тахилч ариунаас ариун газарт

бусдыгаа төлөөлж ганцаараа ордог байсан, түүнийг дагаж араас нь орох ямар ч хүн байгаагүй. Харин бидний төлөө урд маань гүйгч эсрэгээрээ, Тэр тэнд байгаа учраас бид ч удахгүй Түүний араас дагаж орно гэдгийг батлан харуулдаг амлалт болдог. Урд маань гүйгч болохын хувьд Тэр (1) биднийг тэнгэрт очно гэдгийг урьдчилан тунхаглаж, (2) бидний өмнөөс тэнгэрийн цог жавхланд орж, (3) Өөрийн хүмүүсийг тэнгэрт очих бүх бололцоогоор ханган, тэнгэрийн Сүр жавхлантын өмнө биднийг төлөөлж байдаг.⁵

Дөрөв дэх зураглал нь **Тэргүүн Тахилчийн** тухай юм. Бидний **Эзэн, Мелхизедекийн хэргэмийн дагуу үүрд Тэргүүн тахилч болсон.** Бидэнд мөнхийн тахилч байгаа тул аврал маань ч мөнхөд баталгаатай. Хэрэв бид Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрсэн юм бол тэр тусмаа Бурханы баруун талд залрагч Тахилч болох Түүний амиар аврагдах нь үүнээс дутахааргүй үнэн юм. (Ром 5:10)

Тиймээс Есүсийг **Мелхизедекийн хэргэмийн дагуу Тэргүүн Тахилч** гэж мэдэгдэн биднийг 5:10 дээрх гол сэдэв рүү буцаан аваачиж байна. Бичээч түр энэ сэдвийг орхиж, итгэлээс урвах явдлын аюулаас сэрэмжлүүлсэн юм. Харин одоо хэлэлцүүлгээ урьдын адил чадварлаг гэгч нь үргэлжлүүлж, Христийн тэргүүн тахилчийн алба нь Аароныхтай харьцуулшгүй агуу гэдгийг нотолж эхэлж байна.

7:1 Мелхизедек бол хүн төрөлхтний түүхийн тавцанд халтихан үзэгдээд алга болсон нууцлаг дүр билээ (Эх 14:18-20). Хэдэн зуун жилийн дараа түүний нэрийг Давид ахин нэг удаа дурдсан (Дуу 110:4). Тэгээд ахиад хэдэн зууны эцэст Еврей номд ахин нэр нь үзэгдэв. Энд нэг зүйл тодорхой байгаа нь Бурхан түүний амьдралыг чиглүүлээд эцэст нь Эзэн Есүс Христийн бэлгэдэл болгохыг зорьжээ.

Долоодугаар бүлгийн эхний гурван эшлэлд түүний амьдралтай холбоотой түүхэн баримтуудыг өгүүлдэг. Тэрээр **хаан, тахилч** гэсэн хоёр албыг нэгэн зэрэг хашиж байжээ. Тэр бол **Салем** (хожмын Иерусалим)-ын **хаан, Хамгийн Дээд Бурханы тахилч** юм. Нэг ёсондоо, ард түмнийхээ улс төрийн болон итгэл бишрэлийн удирдагч нь байв. Яг л Бурханы төгс дүр зураг мэт байв. Бурхан захирч байгаа цагт энгийн хийгээд, ариун засаглал нь тусдаа байх учиргүй. Харин нүгэлт хүн захирч байгаа үед чуулган, төр хоёрыг салгах зайлшгүй шаардлагатай. Хожим Христ зөв шударгаар дэлхийг хаанчлах цаг дор энэ хоёр нэгдэн нийлэх боломжтой болно (Иса 32:1, 17).

Мезхизедек ялалт байгуулаад **буцаж яваа Абрахамтай уулзаж, түүнийг ерөөсөн**. Энэ үйл явдлын ач холбогдлыг 7-р эшлэлд дэлгэрүүлэн тайлбарлана. Хэрэв бидэнд гагцхүү Хуучин гэрээ л байсан бол нэг их ач холбогдолгүй мэт хэсгүүд үнэндээ ямар чухал ач холбогдолтойг ойлгохгүй өнгөрөх байжээ.

7:2 Абрахам дайны олзныхоо **аравны нэгийг** энэхүү нууцлаг хаант тахилчид **өгсөн**. Абрахамын өргөсөн аравны нэг ямар учиртай байсныг ойлгохын тулд 4, 6, 8-10 дугаар эшлэлийг харах хэрэгтэй болж байна.

Библид хүний нэр тухайн хүний ямар хүн болохыг илэрхийлж байдаг. Тиймээс Мелхизедекийн нэр ба албан тушаалыг нэр нь тайлбарласан байна. Түүний нэр нь **“Зөвт байдлын хаан”** гэсэн утгатай. Албан тушаал (**Салемын хаан**) нь **“Амар тайвны хаан”** гэсэн утгатай.

Эхлээд **зөвт байдлыг**, дараа нь **амар тайвныг** дурдсан нь утга учиртай. Зөвт байдал бий болоогүй цагт амар тайван хэзээ ч тогтдоггүй.

Христийн үйл хэрэг яг энэ замаар хэрэгжсэн. Загалмайд дээр “энэрэл хайр ба үнэн хамтдаа уулзжээ. Зөвт байдал ба амар тайван бие биеэ үнсжээ” (Дуу 85:10). Нүглийн эсрэг Бурханы бүх зөв шударга шаардлагыг Аврагч хангасан тул

бид одоо Бурхантай энх тайван харилцаатай болох боломжтой болсон.

7:3 Мелхизедек **эцэггүй, эхгүй, ураг удамгүй**, төрсөн **өдөр ч үгүй, үхэл ч үгүй** гэснийг унших үед түүний тухай нууц улам бүр гүнзгийрдэг. Энэ үгсийг хам сэдвээс нь салгавал Мелхизедек гэж хүн тэнгэрээс эсвэл өөр гарагаас бууж ирсэн, Бурханы нэг тусгай бүтээл юм байна гэж дүгнэхэд хүрнэ.

Гэвч энэ үгсийг хам сэдэвтэй нь уялдуулж харвал зөв ойлгоно. Энд тахилчийн тухай ярьж байна. Бичээч Мелхизедекийн тахилчийн албыг Аароныхтай харьцуулан ялгаж байна. Аароны тахилчийн үүрэг албанд тэнцэхийн тулд аливаа хүн Леви овгоос, Аароны гэр бүлээс гаралтай байх ёстой. Үүнд удам судар хамгийн чухал байв. Мөн, түүний тахилч болох эрх нь төрөхөд нь эхэлж, үхэхэд нь дуусдаг байв.

Мелхизедекийн тахилчийн алба үүнээс тэс өөр байлаа. Мелхизедек тахилчийн гэр бүлд төрсөн учраас тахилч болоогүй. Харин Бурхан түүнийг сонгон авч тахилч болгон томилжээ. *Түүний тахилчийн үүрэг албыг нь авч үзвэл түүнд ямар ч эцэг, эх, ураг удам байсангүй. Түүний хувьд энэ нь чухал ач холбогдолтой байсангүй. Түүний төрсөн, үхсэн талаар огт тэмдэглэн үлдээсэнгүй.* Тиймээс Мелхизедекийн тахилчийн алба мөнхөд үргэлжилдэг.

Бид Мелхизедект эцэг, эх байгаагүй, хэзээ ч төрөөгүй, бас нас бараагүй гэж ойлгож болохгүй. Энд өгүүлэх гол санаа нь энэ биш. Гол санаа нь *тахилчийн алба үүрэгтэй* нь холбогдуулан авч үзэх эдгээр амин чухал мэдээлэл огт бүртгэгдэж үлдээгүй гэсэн үг. Учир нь түүний тахилчийн үйлчлэлд эдгээр нь ямар ч хамаагүй ажээ.

Зарим хүн эндүүрдэг шиг Мелхизедек Бурханы Хүү биш ээ. Харин тахилчийн алба үүрэг нь юугаар ч тасалдалгүй үргэлжилдэг гэдгээрээ **Бурханы Хүүтэй адил болгогдсон.**

Одоо бичээч Мелхизедекийн тахилчийн үүрэг албыг Аароныхаас илүү агуу гэдгийг нотлох гэж байна. Үүний тулд гурван үндэслэлийг гаргаж тавьжээ. Үүнд, (1) Аравны нэг ба ерөөлтэй холбоотой үндэслэл, (2) Аароны тахилчийн албанд хүмүүс нь байнга солигдож байдаг тухай үндэслэл, (3) Мелхизедекийн тахилчийн алба үүрд үргэлжилдэг тухай үндэслэл хамаарна.

7:4 Эхний үндэслэлийг бид 4-10 дугаар эшлэлээс харна. Энэ хэсэг Мелхизедекийн агууг **харагтун** гэж уулга алдан эхэлдэг. **Өвөг Абрахам** хүртэл дайны **олзноосоо аравны нэгийг түүнд өгсөн** байна шүү дээ. Абрахам еврейчүүдийн тэнгэрт гялалздаг хамгийн тод од байсан гэвэл Мелхизедек түүнээс ч илүү том од байсан нь тодорхой байна.

7:5 Леви овгийн тахилчийн хувьд тэд бусад еврей ахан дүүсээсээ **аравны нэгийг** авах эрхийг **хуулиар** хүртсэн. Тахилчид ч, жирийн еврейчүүд ч бүгдээрээ итгэгч хүмүүсийн эцэг **Абрахамаас** гаралтай хүмүүс билээ.

7:6 Гэтэл Мелхизедек **Абрахамаас аравны нэгийг** хүлээн авсан үйл явдал ер бусын, энгийн бус хэрэг байв. Мессиа төрөн гарах үндэстний эцэг гэж дуудагдсан Абрахам, сонгогдсон ард түмэнтэй огт холбоогүй нэгэнд хүндлэл үзүүлж аравны нэгийг өргөж байна. Ийнхүү Мелхизедекийн тахилчийн үүрэг алба нь угсаа гарал, үндэстний хил хязгаарыг даван гарсан юм. Өөр нэг чухал баримт бол Мелхизедек Абрахамыг ерөөсөн явдал юм. Тэрээр, “Тэнгэр газрын Эзэн, Хамгийн Дээд Бурхан, Абрахамыг ерөөх болтугай!” гэсэн байна (Эх 14:19, 20).

7:7 Нэг хүн нөгөөгөө ерөөхдөө илүү агуу байр суурьтай нь дорд байр суурьтайгаа ерөөх нь ойлгомжтой. Мэдээж, хувь хүний үнэ цэн, ёс суртахууны хувьд дорд гэдгийг илэрхийлж байгаа бус, харин байр суурийн хувьд илүү гэсэн утгыг илэрхийлнэ.

Хуучин гэрээнд тулгуурласан эдгээр үндэслэлүүдийг уншихдаа бид тухайн үеийн еврей уншигчид үүнийг

хэрхэн хүлээн авсныг төсөөлж үзэх хэрэгтэй. Тэд Абрахамыг үндэстнийхээ хамгийн агуу баатар гэж үргэлж хүндэтгэлтэй хандаж ирсэн. Тэр нь ч зөв. Гэтэл одоо “иудей биш” тахилч Абрахамаас илүү агуу байсныг тэд мэдэж авлаа. Бодоод үз дээ! Энэ бүх зүйл тэдний Библид байсаар байтал тэд ер анзаараагүй ажээ.

7:8 Аароны тахилчийн албанд **аравны нэгийг** хурааж авдаг хүмүүс хэзээ нэгэн цагт нас барцгаадаг. Араас нь өөр нэг нь түүний албыг залгамжилдаг. Тахилч бүр өөрийн цаг үедээ үйлчлээд жамаараа нас барцгаана. Мелхизедекийн хувьд нас барсан тухай огтхон ч дурдаагүй. Иймээс түүний тахилчийн алба хэзээ ч үл дуусах тусгай тахилчийн албаны бэлгэдэл болж чадна.

7:9 Мелхизедек **Абрахамаас** аравны нэгийг авснаараа **Левигээс** ч мөн авсанд тооцогдоно. Учир нь Леви бол тахилчийн овгийн тэргүүн учраас Аароны тахилчийн алба Мелхизедект **аравны нэгийг өгсөн гэж хэлж болох юм.** Энэ нь цаашлаад Мелхизедекийн алба Аароныхаас илүү агуу гэдгийг илэрхийлнэ.

7:10 Ямар үндэслэлээр Леви Мелхизедект аравны нэгийг өгсөн гэж хэлж болох вэ? Бодит байдал дээр аравны нэгийг өгсөн хүн нь Абрахам өөрөө шүү дээ. Абрахам бол Левийн өвөг эцэг байсан. Леви хэдийгээр төрөөгүй байсан ч Абрахамын **ууцанд байсан** буюу Абрахамаас гарах үр удам болохоор товлогдсон байсан. Тэгэхээр Абрахам бүх үр удмынхаа нэрийн өмнөөс Мелхизедект аравны нэгийг өгсөн юм. Иймд Леви хийгээд Левигээс гаралтай тахилчийн алба Мелхизедек хийгээд Мелхизедекийн тахилчийн албатай харьцуулахад хоёрдугаар зэрэглэлд хамаарч байна.

7:11 Мелхизедекийн тахилчийн алба Аароныхаас илүү агуу гэдгийг нотлох хоёр дахь үндэслэл 11-20 дугаар эшлэлд гарна. Энэ үндэслэл нь тахилчийн жишгийг өөрчилсөн учраас гарч ирсэн. Христийн тахилчийн алба

Левийн тахилчийн албыг хүчингүй болгосон. Левийн тахилчийн жишиг бүрэн, эцсийн зорилгоо биелүүлсэн байсан бол ийнхүү өөрчлөгдөх хэрэггүй байлаа.

Үнэндээ **төгс төгөлдөр байдал нь Левийнхний тахилчийн үүргээр** ирэх боломжгүй байсан юм. Нүгэл хэзээ ч шийдэгдсэнгүй, мөргөлчид ч мөс чанартаа амралтыг олсонгүй. Мосегийн хуулиар тогтоогдсон тахилчийн алба нь эцсийн, туйлын үр дүн биш байв.

Одоо өөр төрлийн тахилчийн алба гарч иржээ. Төгс Тахилч иржээ. Түүний тахилчийн алба нь **Аароны хэргэмийн дагуу** бус, **Мелхизедекийн хэргэмийн дагуу** юм.

7:12 Тахилчийн алба өөрчлөгдвөл тахилчийн албаны тулгуурлаж байсан хууль ч мөн өөрчлөгдөх зайлшгүй шаардлагатай болдог. Энэ бол үндсээр нь өөрчлөх тунхаглал мөн! Хонх цохиж буй мэт энэ нь хуучин юмсыг халж, шинэ зарчим тогтоож буйг зарлаж байна. Бид цаашид хуулийн дор байхаа нэгэнт больжээ.

7:13 Эзэн Есүс Левийн хуулиар тахилчийн үүргийг гүйцэтгэдэг **овогт харьяалагддаггүй**. Үүнээс харахад хуульд өөрчлөлт орсон нь илэрхий байна.

7:14 Бидний Эзэн, Иуда овгоос гаралтай. Мосегийн хуульд Иуда овгоос гаралтай хүнийг тахилч байхыг зөвшөөрдөггүй. Гэтэл Есүс Тахилч болсон байна. Яаж ийм юм байх вэ? Учир нь хууль өөрчлөгджээ.

7:15 Бичээч тахилчийн хуульд өөрчлөлт орсныг батлах өөр нэг баталгааг энд гаргаж тавьж байна. **Мелхизедектэй адил өөр тахилч гарч иржээ**. Энэ тахилчийн албанд тавигдах шаардлага нь Аароны тахилчийн албанахаас эрс өөр гэжээ.

7:16 Левийн тахилч нар махан биеийн дагуу тахилч болохын тулд удам судрын шаардлагад тэнцэх ёстой гэж хуулиар тогтоосон. Тэд Леви овгоос, Аароны гэр бүлээс гаралтай байх ёстой.

Харин Эзэн Есүс Мелхизедекийн хэргэмийн дагуу Тахилч болохдоо мөнх **амиараа** шаардлагыг хангасан. Энэ амийг Тэр хэн нэгнээс өвлөж аваагүй. Харин Өөрөө мөнх амийг эзэмшдэг билээ. Эзэн Есүс мөнхөд амьдардаг.

7:17 Энэ тухай Давид Дуулал 110:4 эшлэлд Мессиагийн тахилчийн үүрэг албаны талаар, “**Мелхизедекийн хэргэмийн дагуу Чи мөнхийн тахилч юм**” гэж хэлж баталж өгдөг. Энд бичээч **мөнхийн** гэсэн үгийг цохон тэмдэглэсэн байна. Христ мөнх амьдардаг учраас үйлчлэл нь хэзээ ч дуусахгүй.

7:18 Аароны тахилчийн албыг тогтоож байсан хууль **дорой ба ашиггүйгээсээ болж хүчингүй** болов. Христ ирж хуулийг цуцлав.

Хууль ямар утгаар дорой, ашиггүй байсан бэ? Хуулийг Бурхан өгөөгүй гэж үү? Бурхан дорой, ашиггүй зүйл өгнө гэж үү? Бурхан анхнаасаа хуулийг тахилчийн мөнхийн тогтолцоо болгохыг зориогүй. Харин Өөрийнхөө *төгс* Тахилчийг ирэх хүртэл урьдач бэлтгэл болгож өгсөн. Хууль нь эцсийн төгс төгөлдөр юмсын түр зуурын дүрслэл, сүүдэр байсан юм.

7:19 Түүнээс гадна, хууль **юуг ч төгс болгосонгүй**. Энэ утгаараа хууль нь бас дорой, ашиггүй юм. Хүмүүс хуулийн цаг үед ариунаас ариун газарт Бурханы оршихуй руу орж чадаагүй. Бурхан, хүн хоёрын дунд ангал байна гэдэг бол нүглийн асуудал бүрмөсөн шийдэгдээгүй байгааг харуулдаг.

Тэгтэл **илүү сайн найдвар өгөгдөж, үүгээр бид Бурханд ойртдог. Илүү сайн найдвар** гэдэг нь Эзэн Есүс Өөрөө юм. Эзэн Есүсийг цорын ганц төгс найдвар болгон хүлээн авсан хүмүүс хэзээд **Бурханд ойртох** төгс замтай болжээ.

7:20 Эдүгээ тахилчийн алба үүрэг хийгээд тахилчийн хууль өөрчлөгдөөд зогсохгүй, тахилчийн албанд томилогдох арга хэлбэр ч өөрчлөгдсөн байна. Энд Бурханы

андгайг Христийн тахилчийн үүрэг албатай холбожээ. Хэзээ ч хувирахгүй, мөнхийн тахилчийн албанд томилогдоход Бурханы андгай чухал ач холбогдолтой. “Бидний ерөөлт Эзэн Есүсийн тахилчийн албыг мөнхийн мөнхөд хүчин төгөлдөр болгож баталгаажуулдаг ганц зүйл бол Төгс Хүчит Бурханы андгай билээ.” (Рэйнсбюри)⁶

7:21 Аароны удмын тахилчид **андгайгүйгээр** томилогддог байв. Үүний цаад утга нь Аароны удмын тахилчид мөнхийнх биш, түр зуурынх гэдгийг илэрхийлдэг.

Харин Бурхан **тангаргаар** Христийг тахилчийн үйлчлэлд томилсон. “**Эзэн андгайлсан бөгөөд санаагаа өөрчлөхгүй. Чи бол мөнхийн тахилч**” гэсэн уг тангараг Дуулал 110:4 дээр бий. Хэндерсон ингэж бичжээ:

Бурхан Христийн үйлчлэлийн ард хаан ширээнийх нь мөнхийн мөхөшгүй үнэнийг, мөн чанарынх нь хувирахгүй шинжүүдийг тавьжээ. Энэ бүхэн өөрчлөгдөх боломжтой бол шинэ тахилчийн алба ч өөрчлөгдөх боломжтой. Гэвч эдгээр нь хэзээ ч өөрчлөгдөхгүй тул шинэ тэргүүн тахилчийн эрхэм чанар мөнхөд оршин тогтноно.⁷

7:22 Тийнхүү Есүс илүү сайн гэрээний батлан даагч болов. Аароны тахилчийн алба Хуучин гэрээний нэг хэсэг байсан. Христийн тэргүүн тахилчийн алба шинэ **гэрээтэй** холбоотой. Гэрээ болон тахилчийн тогтолцоо хоёр хамтдаа байдаг тул нэг нь үгүй болоход хамтдаа хүчингүй болдог.

Шинэ гэрээ гэдэг нь Эзэн Есүс энэ дэлхий дээр хаанчлалаа байгуулах үед Израилийн гэр ба Иудагийн гэртэй байгуулах ямар ч нөхцөл болзолгүй, нигүүлслийн гэрээ юм (Иер 31:33, 34). Өнөөгийн итгэгчид энэхүү шинэ гэрээний ерөөлөөс заримыг нь эдэлдэг боловч Израиль бүрэн сэргээгдэж, улс үндэстнээрээ аврагдах хүртэл энэ гэрээ бүрэн утгаараа биелэхгүй.

Есүс шинэ гэрээний батлан даагч буюу баталгаа гэдэг нь Тэр Өөрөө уг гэрээний биеллийн гарцаагүй баталгаа гэсэн утгатай. Есүс үхэл, оршуулга, амиллаараа уг гэрээний болзлыг биелүүлэх шударга үндэслэлийг Бурханд хангаж өгсөн. Түүний дуусашгүй тахилчийн алба ч мөн уг гэрээний нөхцөл болзол алдаа мадаггүй биелэхтэй салшгүй холбоотой.

7:23 Одоо бид Мелхизедекийн хэргэмийн дагуух тахилчийн албын агууг баталсан гурав дахь буюу сүүлийн үндэслэл рүү орж ирлээ.

Израильд **олон** тахилч байсан. Израилийн түүхэнд наян дөрвөн тэргүүн **тахилч** байсан гэж үздэг. Мэдээж жирийн тахилчид түүнээс ч олон байсан нь тодорхой. Тэдний үйлчлэл зайлшгүй ирдэг **үхлээс** болж тасалддаг байлаа.

7:24 Христийн тахилчийн албын хувьд тийм сул тал огт байхгүй. Учир нь Есүс **мөнх** амьдардаг. Христийн тахилчийн алба өөр хүнд шилждэггүй, тасалддаггүй, хүчингүй болдоггүй. Энэ нь **үл өөрчлөгдөх**, үл шилжих, мөнхөд үргэлжилдэг алба юм.

7:25 Эзэн Есүс Христ мөнхөд **амьд байдаг** учраас **Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрмөсөн аварч чадна**. Бид энэ үгийг ихэвчлэн Христийн нүгэлтнүүдийг нүглийн шийтгэлээс аврах ажлыг хэлж байна гэж бид ойлгодог. Гэвч бичээч Христийн ажил ариун хүмүүсийг нүглийн хүчнээс авардаг гэдгийг хэлэхийг зорьжээ. Учир нь энд Эзэн Есүсийг Аврагчийн үүднээс бус, Тэргүүн Тахилчийнх нь хувьд авч үзэж байна. Итгэгчид авралаа алдана гэх аюул байхгүй. Эзэн Есүс **тэдний төлөө зуучлан залбирдаг** учраас авралын баталгаа нь мөнхийнх билээ. Есүс Бурханы баруун гарт залраад, үхлээр хэзээ ч тасрахгүй үйлчлэлийг бидний төлөө хийж байна.

7:26 Христийн тахилчийн алба Аароныхаас илүү агуу байх шалтгаан бол Түүний хувийн төгс чанарын улмаас ажээ. Есүс Бурханы өмнө **ариун** зогсдог. Хүмүүстэй

харилцахдаа **гэмгүй**. Есүсийн хувийн зан чанар **бузартаагүй**. Тэрээр Бурханы баруун мутарт залрах амиараа **нүгэлтнүүдээс тусгаарлагдсан** билээ. Христийн өдгөөгөөс өнө мөнхөд орших цог жавхлан **тэнгэрээс өндөр** билээ. Ийм Тэргүүн Тахилчтай байх нь бидний хувьд зохистой.

7:27 Левийн тахилчдаас ялгаатай нь бидний Тэргүүн Тахилч **өдөр бүр тахил өргөх шаардлагагүй. Учир нь Тэрээр үүнийг нэгмөсөн хийжээ**. Тэр Өөрийнхөө төлөө тахил өргөх шаардлагагүй. Учир нь Түүнд ямар ч нүгэл байхгүй. Бусад тахилчдаас ялгарах гайхамшигтай ялгаа бол **Тэрээр Өөрийгөө** хүмүүсийн нүглийн төлөө тахил болгон өргөсөн явдал билээ. Тахилч маань Өөрийгөө тахил болгожээ. Есүсийн энэхүү гайхамшигт нигүүлсэл юутай ч зүйрлүүлшгүй сүр жавхлантай!

7:28 **Хууль нь** төгс бус, алдаа дутагдалтай, мөхөс хүмүүсийг **тахилчаар томилдог**. Тэд гагцхүү ёслолын хувьд л ариун гэж тооцогддог.

Хуулийн дараа ирсэн Бурханы тангаргийн үг нь харин мөнхөд төгс болсон Хүүг Тахилчаар томилдог билээ. Энэ тангаргийг Дуулал 110:4-өөс эш татан 21-р эшлэлд оруулжээ.

Бидний сая авч үзсэн хэсгээс дараах дүгнэлт гарч ирж байна. Хүний тахилчийн үүрэг албын тогтолцоо бүрэн халагдаж, оронд нь Бурханы тогтоосон, мөнх орших Тахилчийн үйлчлэл иржээ. Тэгвэл Хуучин гэрээний загвараар тахилчийн тогтолцоог бий болгож, агуу Тэргүүн Тахилчийн ажил үүргийг булаацалдах нь юутай мунхаг хэрэг вэ!

Б. Христийн үйлчлэл Аароныхаас агуу (8-р бүлэг)

8:1 Одоо үзэх эшлэлүүдэд Христийн үйлчлэлийг Аароныхаас илүү агуу гэдгийг харуулдаг. Учир нь Христ

илүү дээр ариун газарт үйлчилдэг (1-5-р эшлэл) бөгөөд илүү сайн гэрээн дор (7-13-р эшлэл) Аароныхаас агуу тахилчийн үүргийг гүйцэтгэдэг.

Бичээч үндэслэлийнхээ **гол** санааг тайлбарлахад бэлэн болжээ. Тэрээр өмнөхөө дүгнэж бичээгүй, харин энэ хүртэл юу ярихыг зорьсон **гол** санаагаа бичиж байна.

Тийм Тэргүүн тахилч бидэнд байна. Бидэнд бий гэх энэ үг ялалтын өнгө аястай байгааг тэмдэглэх нь зүйтэй. “Бидэнд сүм, асар, тахилчид, өргөлүүд, ёслолууд тахилчийн үзэмжит өмсгөл” байгаа гэх үгээрээ нэгдүгээр зууны итгэгчдийг зовоож байсан иудейчүүдэд бичээч энэ хариуг өгч байна. Итгэгч хүний хувиар тэдэнд итгэлтэйгээр, “Тийм ээ, та нарт сүүдэр нь байдаг. Харин бидэнд биелэл нь байдаг. Та нарт ёслолууд байдаг. Харин бидэнд Христ байдаг. Та нарт дүрслэл нь байдаг. Харин бидэнд Хүн нь байдаг” гэж хэлж чадна. Бидний Тэргүүн Тахилч тэнгэр дэх **Сүр Жавхлантын сэнтийн баруун гарт заларч** байна. Тэргүүн тахилчдын хэн нь ч төгс ажлыг гүйцэлдүүлээд ийм их хүндлэл, эрх мэдэл, хүчийг атгаж байгаагүй.

8:2 Бидний Тэргүүн Тахилч тэнгэрийн **ариун газарт** хүмүүст үйлчилдэг. Энэ бол **жинхэнэ асар** юм. Харин газар дээрх асар бол түүний хуулбар буюу бэлгэдэл ажээ. **Жинхэнэ асар нь** газар дээрх асар шиг **хүний** гараар бус **Эзэний** гараар босжээ.

8:3 Тэргүүн тахилч бүр бэлэг хийгээд тахил өргөхийн тулд томилогдсон байдаг тул бидний Тэргүүн тахилч ч мөн өргөх ямар нэгэн юмтай байх хэрэгтэй.

Бэлэг гэдэг нь Бурханд өргөдөг бүх төрлийн өргөлийн ерөнхий нэршил юм. **Тахил** гэдэг нь амьтны цусыг гарган нядалж өргөдөг өргөл билээ. Тэгвэл Христ юу өргөдөг вэ? Энэ асуултад 9-р бүлэг хүртэл шууд хариу өгөөгүй.

8:4 Энэ эшлэл Христ юу өргөдөг тухай сэдвийг алгасаж, **Тэр газар дээр байсан бол** хууль ёсны дагуу майхан юмуу

асарт бэлгүүдийг өргөх тахилч болох эрхгүй **байх байсан** гэдгийг сануулж байна. Бидний Эзэн, Иуда овгоос гаралтай. Леви овог, Аароны удмаас гаралгүй учраас Тэр газар дээрх ариун газарт үйлчлэх шаардлагыг хангаж чадахгүй. Сайнмэдээнд Есүсийг сүмд орсон гэж хэлсэн нь ердөө сүмийн ойр орчмын газраар явснаас бус (Лк 19:45), ариун газар юмуу ариунаас ариун газар руу орж байгаагүй гэдгийг бид ойлгох ёстой. Эндээс Христ тэргүүн тахилчийн ажлыг газар дээр байхдаа хийж байсан уу эсвэл тэнгэрт очсоныхоо дараа л хийж эхэлсэн үү гэдэг асуулт гарч ирнэ. *Христ дэлхий дээр Левийн тахилчийн албанд эс тэнцэх ба Иерусалим дахь сүмд үйлчлэх боломжгүй байсан* гэдгийг 4-р эшлэлд хэлэхийг гол нь зорьсон. Гэсэн ч Христ *Мелхизедекийн хэргэмийн дагуух тахилчийн* ажлыг хийх боломжгүй байсан гэсэн үг биш. Үнэндээ, Иохан 17-р бүлэг дэх залбирал нь тэргүүн тахилчийн залбирал мөн. Голгота дээр Өөрийгөө төгс тахил болгож өргөсөн нь ч бас тахилчийн үйл хэрэг билээ (2:17-г үз).

8:5 Газар дээрх асар нь **тэнгэрлэг** ариун газрын хуулбар байлаа. Асрын байр байдал нь Бурханы гэрээний ард түмэн Бурханд мөргөл хүндлэлээр ойртон очих загвартай байв. Эхлээд гадна хашааны хаалга байна. Тэгээд шатаалт тахилын ширээ таарна. Түүний араас угаал байна. Түүний араас тахилчид ариун газарт орж, тэргүүн тахилчид ариунаас ариун газар руу орно. Ариунаас ариун газарт Бурхан Өөрийгөө илчилдэг.

Асар нь анхнаасаа жинхэнэ ариун газар байх зорилгоор хийгдээгүй. Энэ нь ердөө л **сүүдэр** буюу хуулбар байлаа. Бурхан Мосег Синаи уулан дээр дуудаад асрыг барихдаа яг ямар загвар ашиглахыг нэгд нэггүй тодорхой хэлж өгчээ. Энэ **загвар** нь дээр орших, тэнгэрлэг, сүнслэг ариун газрын бэлгэдэл байв.

Бичээч энэ санааг яагаад ийм хүчтэй онцолно вэ? Учир нь иудейзм рүү эргэх сорилтод орсон хүмүүсийн бодол

санааг үнэнийг орхин сүүдэр рүү буцаж байна гэдгийг ятгах зорилгын улмаас юм. Уг нь тэд сүүдрийг орхиж, биеийг сонгох ёстой байлаа.

Хуучин гэрээний тогтоолууд тэнгэрлэг үнэний бэлгэдэл байсан гэдгийг 5-р эшлэл маш тодорхой заадаг. Тиймээс бэлгэдлийн сургаалыг Бичвэртэй нийцүүлэн зөв тайлбарлаж хэрэглэвэл зөв үндэслэл гарч ирнэ.

8:6 Энэ эшлэл илүү ариун газар гэсэн сэдвээс илүү сайн амлалтууд гэсэн сэдэв рүү яриаг шилжүүлж байна.

Эхлээд энд харьцуулалт хийж байна. Христийн зуучилдаг **гэрээ** нь хуучнаас илүү учраас Христийн үйлчлэл Аароныхаас илүү гэжээ.

Хоёрт, үндэслэлийг нь тайлбарлав. Шинэ **гэрээ** нь **илүү сайн амлалтууд** дээр суурилдаг учраас **илүү сайн** юм.

Христийн **үйлчлэл** илүү гэдэг нь хэмжээлшгүй илүү гэсэн үг. Тэрээр амьтныг бус, Өөрийгөө өргөсөн. Тэрээр бух, ямааны цусыг биш, Өөрийнхөө цусны үнэ цэнээр өргөл өргөсөн. Тэрээр нүглүүдийг түр халхлаагүй, харин бүрэн зайлуулжээ. Тэрээр Бурханы оршихуйн гадна талд, алсад зогсдоггүй, харин тийш орох замыг нээжээ.

Тэрээр **илүү сайн амлалтууд дээр тогтоосон илүү сайн гэрээний зууч мөн. Зууч** учраас Бурхан, хүн хоёрын хооронд зогсож, алсарсан зайг гэтэлгэх гүүр болжээ. Гриффит Томас, хоёр гэрээг харьцуулж товчоор ийн бичсэн байна:

Шинэ гэрээ нь туйлынх бөгөөд болзолгүй, махбодынх бус сүнслэг, нэг ард түмнийх бус бүх ертөнцийнх, түр зуурынх бус мөнхийнх, хувь хүнийх бус улс үндэстнийх, гаднаас тулгаагүй дотроосоо бичсэн учраас хуучнаас “илүү сайн” билээ.⁸

Энэ нь **илүү сайн амлалтууд дээр** суурилсан учраас **илүү сайн гэрээ** юм. Хуулийн гэрээ дуулгавартай байвал

ерөөлийг амлаж, дуулгаваргүй байвал үхлээр айлгадаг. Хууль нь зөвт байдлыг шаарддаг боловч түүнийг бий болгох хүчийг өгдөггүй.

Харин Шинэ гэрээ бол болзолгүй, нигүүлслийн гэрээ юм. Энэ гэрээ зөвт байдал байхгүй байхад зөвт байдлыг тогтоож, хүмүүст зөвөөр амьдрахыг зааж, зөвийн замаар алхах хүчийг өгч, зөвт байгаа нь илчлэгдвэл шагнадаг.

8:7 Анхны гэрээ төгс бус байсан. Өөрөөр хэлбэл, хүн, Бурхан хоёрын дунд жинхэнэ харилцааг бий болгож чадаагүй. Энэ гэрээ анхнаасаа эцсийн гэрээ байх зорилго агуулаагүй юм. Харин Христийг ирэхэд бэлтгэх зорилготой байжээ. Хожим **хоёр дахь** гэрээний талаар дурдсан нь **анхны** гэрээ төгс, туйлынх биш байсныг батлан харуулдаг юм.

8:8 Үнэндээ асуудал нь анхны гэрээнд байгаа юм биш. “Хууль бол ариун бөгөөд тушаал ч ариун, зөв бөгөөд сайн юм.” (Ром 7:12) Асуудал нь хуулийг хүлээн авсан хүмүүст бий. Хууль энэ асуудлыг шийдэх чадалгүй. Үүнийгээ энд ингэж тунхаглаж байна. “**Тэр тэднээс дутагдал олсон**”. Бурхан гэрээнээс алдаа дутагдал олсонгүй, харин гэрээний ард түмнээсээ алдаа дутагдал олжээ. Эхний гэрээ нь дуулгавартай дагана гэсэн хүний амлалтад тулгуурласан (Гэт 19:8; 24:7) тул удаан наслаагүй. Харин Шинэ гэрээ эхнээсээ төгсгөл хүртлээ Бурханы амлалтад үндэслэдэг. Энэ нь уг гэрээний хүч, төгс байдлын үндэс юм.

Бичээч одоо Иеремиа 31:31-34 эшлэлээс эш татан, Бурхан шинэ гэрээг амласныг иудейчүүдийн Бичвэрээс харуулж байна. Бүх үндэслэл **шинэ** гэдэг үгэн дээр төвлөрч буйг анзаараарай. Хэрэв хуучин нь хангалттай юм бол шинийг гаргаж ирэх ямар хэрэгтэй гэж?

Гэтэл Бурхан, **Израилийн гэр ба Иудагийн гэртэй шинэ гэрээ байгуулах** тусгай амлалт өгчээ. Өмнө нь хэлсэнчлэн, энэ **шинэ гэрээ** юун түрүүнд Чуулганд биш, **Израильд** хамаатай. Тиймдээ ч гэмшиж, бүрэн аврагдсан

Израилийг Христ захирахаар дахин ирэх үеийг хүртэл бүрэн утгаараа биелэхгүй. Тэр болтол уг гэрээний зарим хэсгийг өнөөгийн бүх итгэгчид эдэлдэг. Тиймээс Аврагч маань шавь нартаа аягатай дарс дамжуулахдаа “Энэ аяга нь Миний цусаар тогтоогдох шинэ гэрээ юм. Үүнээс та нар уух болгондоо Намайг дурсаж үүнийг үйлд” гэсэн (1Ко 11:25).

Хэндерсон ийнхүү сийрүүлжээ:

Иймээс бид Шинэ гэрээний анхны тайлбар нь Израильд шууд хамаатай, харин Сүнсний хүчээр хэрэгждэг удаах буюу сүнслэг хэрэглээ нь Чуулганд хамаарна гэдгийг ялгаж салгаж ойлгох хэрэгтэй. Бид өнөөдөр шинэ гэрээний ерөөлийг Ариун Сүнсний хүчээр эдэлж байгаа ч Бурханы амлалтад дурдсанчлан Израильд ирээдүйд бүрэн дүүрэн биелэх өдрийг хүлээж байна.⁹

8:9 Израильчуудыг Египет нутгаас гаргахын тулд эцэг өвгөдийнх нь гараас хөтөлсөн тэр өдөр тэдэнтэй байгуулсан гэрээтэй нь шинэ гэрээ адилгүй байна гэж Бурхан амлажээ. Тэгвэл энэ юугаараа өөр байх вэ? Юу нь өөр байх талаар шууд хэлээгүй боловч эшлэлийн үлдсэн хэсэгт хэлж байгаа үгээс дам утгаар ойлгож болох юм. Учир нь тэд Миний гэрээн дотор байгаагүй Би ч тэднийг хайхраагүй. Хуулийн гэрээ нөхцөл болзолтой учраас бүтэлгүйтсэн. Хуулийн гэрээ нь дуулгавартай байж чадахгүй хүмүүсээс дуулгаврыг шаарддаг. Бурхан ямар ч нөхцөл болзолгүй, нигүүлслийн шинэ гэрээг тогтоохдоо биелэл нь бүтэлгүйтэх бүх боломжийг хааж, уг гэрээг хэзээ ч алдаж энддэггүй Өөр дээрээ тулгуурлан тогтоосон юм.

Иеремиагаас эш татсан хэсэгт маш том, чухал өөрчлөлт бий. Иеремиа 31:32 эшлэлийн еврей эх бичвэр дээр “хэдийгээр Би тэдний хань нөхөр нь атал” гэсэн байдаг. Иеремиагийн эртний зарим орчуулга дээр “Би ч тэднийг

хайхраагүй” гэдэг. Иеремиагийн үгсийг өгч, библийг хадгалан авч үлдэх ажлыг удирдан чиглүүлсэн Ариун Сүнс, Еврей захидлын бичээчийг энэ хувилбарыг зориуд сонгоход чиглүүлсэн байна.

8:10 Бурхан “Би хийх болно” гэсэн санааг хэд хэдэн удаа давтсаныг анзаараарай. Хуучин гэрээ хүнээс үйлдэл хийхийг шаарддаг бол Шинэ гэрээнд Бурхан юу хийхийг тунхагладаг. Израилийн дуулгаваргүй байдал өнгөрөн одсон **өдрүүдийн дараа Бурхан хуулиудаа тэдний санаанд оруулж, зүрхэнд нь бичнэ.** Тэгээд тэд Бурханы хуулийг хайрлана. Тэд шийтгэлээс айсандаа биш Бурханыг хайрласандаа хуулийг нь дагана.

Би тэдний Бурхан болж, тэд Миний ард түмэн болно. Энд ойр дотно харилцааг илэрхийлж байна. Хуучин гэрээнд хүн Бурханаас алс хол байсан бол нигүүлсэл ойртон ирэхийг урьдаг. Энд мөн хэзээ ч тасрахгүй харилцаа, нөхцөл болзолгүй авралыг ярьж байна. Энэхүү цусаар худалдаж авсан холбоог юу ч тасалж чадахгүй.

8:11 Шинэ гэрээнд бүх дэлхий Эзэнийг мэдэх ерөөл багтдаг. Христийн цог жавхлант хаанчлалын үед хүн **хөршдөө, ах дүүдээ “Эзэнийг мэд” гэж заахгүй. Учир нь өчүүхнээсээ агуу нь хүртэл бүгд Түүнийг зөнгөөрөө мэддэг болно.** “Далай усаар бялхдаг шиг дэлхий ЭЗЭНий мэдлэгээр дүүрнэ.” (Иса 11:9)

8:12 Хамгийн гайхалтай зүйл бол шинэ гэрээ нь зөвт бус хүнд өршөөлийг амлаж, **нүглийг нь үүрд мартана** гэж хэлдэг. Гэтэл хуульд ямар ч уян хатан чанар байдаггүй. “Аливаа тэрслэлт ба дуулгаваргүй байдал нь шударга хариугаа хүртсэн.” (Евр 2:2)

Түүнээс гадна, хууль нүглийг бүрэн шийдвэрлэх бодит хүчтэй байгаагүй. Хууль нүглийн эвлэрүүллийг зааж өгсөн ч нүглийг зайлуулдаггүй. (Еврейгээр эвлэрүүлэл гэдэг нь “хучих, далдлах” гэсэн үгээс гаралтай.) Хуульд заасан тахилууд хүнийг шашны зан үйлийн хувьд цэвэр болгодог.

Өөрөөр хэлбэл, тухайн хүн хуулийн дагуух тахилыг өргөснөөр үндэстнийхээ сүсэг бишрэлийн амьдралд оролцох шаардлагыг хангана. Гэвч зан үйлийн цэвэр байдал ердөө гадна талынх юм. Энэ нь хүний дотоод амьдрал руу ордоггүй тул хүмүүнд ёс суртахууны цэвэр мөс чанарыг өгдөггүй.

8:13 Бурхан **шинэ** гэрээг тогтоохдоо **анхныхыг хуучин болгов**. Тиймээс дахин хуулийн дор буцаж орох тухай бодох ч ёсгүй. Харамсалтай нь зарим нэг нэр төдий итгэгчид яг тийм зүйл рүү татагдах аюулд өртжээ. Бичээч тэдэнд хуулийн гэрээ хуучирч үеэ өнгөрөөсөн, харин одоо илүү сайн гэрээ тогтоогдсон гэдгийг сануулж байна. Тэд Бурханы алхаатай хөлөө нийлүүлэх хэрэгтэй.

В. Христийн өргөл Хуучин гэрээний тахилуудаас агуу (9:1-10:18)

9:1 Тэргүүн тахилч бүхэн өргөх юмтай байх ёстой гэдгийг бичээч 8:3 дугаар эшлэлд товч дурдсан. Харин одоо бидний Тэргүүн Тахилчийн өргөлийн тухай авч үзэн, Хуучин гэрээний тахилуудтай харьцуулан тайлбарлахад бэлэн болсон байна. Энэ сэдвийг дэлгэрүүлэхийн өмнө тэрээр асрын бүтэц зохион байгуулалт болон мөргөлийн зан үйлийг тоймлон тайлбарлав.

9:2 Асар нь Синаи ууланд израильчууд буудалласнаас эхлээд Иерусалимын сүм баригдах хүртэл Бурхан израильчуудын дунд байхдаа оршин суусан майхан маягийн байгууламж байжээ. Асрын эргэн тойрон дахь хэсгийг асрын гаднах талбай гэнэ. Энэ нь хүрэл шонгуудад тулгуурлан, тэдгээр шонгийн хооронд маалинган даавуугаар хашаалан хүрээлжээ. Израиль хүн асрын хашааны зүүн хаалгаар ороход шатаалт тахилын ширээ тааралдана. Энэ ширээн дээр нядалсан амьтныг шатааж

тахина. Дараа нь том хүрэл суурьтай, дотроо устай угаагуурт хүрч очно. Тэнд тахилчид гар хөлөө угаана.

Асар нь ойролцоогоор 14 метр урт, 4.5 метр өргөн, 4.5 метр өндөр хэмжээтэй. Асар хоёр хэсгээс бүрдэнэ. Эхнийхийг нь ариун газар гэж нэрлэнэ. Урт нь 9 метр байна. Хоёр дахь хэсгийг ариунаас ариун газар гэдэг ба 4.5 метр урттай.

Асрын хүрээ нь мод, ар, хажуу, дээд талаасаа ямааны хялгасаар хийсэн хөшиг маягийн ус үл нэвтрэх амьтны арьсан хучлагатай байв. Харин нүүрэн тал нь хээ угалз бүхий хөшигтэй.

Ариун газарт гурван төрлийн тавилга байв. Үүнд:

1. **Тавиг талхны ширээ.** Үүн дээр Израилийн арван хоёр овгийг бэлгэдсэн арван хоёр талх байна. Талхыг “оршихуйн талх” гэж нэрлэнэ. Учир нь тэднийг Бурханы өмнө буюу Бурханы оршихуйд тавьдаг байжээ.

2. **Дэнлүүний алтан суурь.** Сууриас салаалсан долоон мөчир дээш гарч, тосон дэнлүүг тогтоож асаадаг байжээ.

3. **Утлагын алтан ширээ.** Үүн дээр өглөө, оройд ариун утлага уугиулдаг байжээ.

9:3 Асрын хоёр дахь хөшигний ард **ариунаас ариун газар** буюу ариун газрын ариун хэсэг байрлана. Энд Бурхан Өөрийгөө тод гялалзсан үүлэн дунд илчилдэг байв. Энэ дэлхий дээрх бүх газраас ялгаатай нь эвлэрүүллийн цусаар Бурханд ойртон очих боломжтой байжээ.

9:4 Асрын энэхүү хоёр дахь хэсэгт **алтаар битүү бүрсэн гэрээний авдар** байршина. **Гэрээний авдар** нь том модон сав юм. **Авдар дотор манна агуулсан алтан сав, Аароны навчилсан таяг болон хуулийн хоёр хавтан байлаа.** (Хожим нь Иерусалимд сүм баригдах үед түүний дотор хуулийн хавтангаас бусад нь байсангүй – 1Ха 8:9)

Дөрөвдүгээр эшлэлд ариунаас ариун газарт **утлага тахилын алтан ширээ** байсан гэжээ. **Утлага тахилын ширээ**¹⁰ (Гэт 30:6-д хэлснээр энэ ширээ ариун газарт

байдаг) гэж орчуулагдсан грек үг нь нэг талаар утлага тахилын ширээ гэж орчуулагдаж болох ч нөгөө талаар тэргүүн тахилчийн утлага уугиулдаг бойпор гэж бас орчуулагдах боломжтой. Үүнийг утлагын бойпор гэж үзэх нь зөв. Тэргүүн тахилч эвлэрүүллийн өдөр үүнийг утлагын тахилын ширээнээс авч ариунаас ариун газар руу авч ордог тул бичээч ариунаас ариун газрын эдлэлд багтаасан байна.

9:5 Гэрээний авдрын алтан тагийг “**эвлэрүүллийн таг**” гэнэ. Түүний дээр алтаар урласан хоёр херубын дүрс байрлана. **Херубууд** өөд өөдөөсөө харж, толгойгоо авдрын таг руу гудайлгаж, далавчаа дэлгэсэн байна.

Бичээч энд хүрээд товч танилцуулгаа дуусгав. Түүний зорилго асрын бүтцийг нэгд нэггүй дэлгэрэнгүй тайлбарлахад биш, асрын байр байдлыг товч тайлбарлаад Бурхан руу хэрхэн ойртон очдог байсныг ерөнхийд нь тоймлон харуулахад оршиж байлаа.

9:6 Бичээч Христийн өргөлийг иудейзмын өргөлтэй харьцуулах гэж байгаа тул эхлээд хуулийн шаарддаг тахилуудыг тайлбарлах шаардлагатай байв. Тэрээр олон өргөлөөс сонгон ярьж болох байсан ч хуульд хамгийн чухалд тооцогддог тахил буюу эвлэрүүллийн өдөр өргөдөг тахилыг (Лев 16-р бүлэг) онцлон авч үзжээ. Хэрэв Израилийн хамгийн чухал өдөр тэргүүн тахилчийн өргөдөг өргөлөөс Христийн үйлчлэл илүү гэдгийг баталж чадвал түүний үндэслэл батлагдана.

Тахилчид гадаад өрөө буюу ариун газар руу нэвтрэх эрхтэй байсан. Тэд зан үйлээ гүйцэтгэхээр тэнд байнга орж гардаг байв. Харин жирийн иргэд тийш орохыг зөвшөөрдөггүй тул гадна нь үлдэх ёстой байлаа.

9:7 Харин ариунаас ариун газар руу дэлхий дээр ганц л хүн орох эрхтэй байсан нь Израилийн **тэргүүн тахилч** байлаа. Дэлхийн ганц л үндэстнээс нэг овгийн нэг л айлын ганц хүн жилд нэг удаа буюу зөвхөн эвлэрүүллийн өдөр ариунаас ариун газар руу орно. Орохдоо **өөрийн болон**

хүмүүсийн мэдэлгүйгээр үйлдсэн нүглийн учир өргөх ёстой цустай сав авч орно.

9:8 Энэ зан үйлтэй холбоотой маш гүнзгий сүнслэг үнэн бий. Нүгэл нь хүн, Бурхан хоёрын дунд зааг үүсгэж, хүн заавал зуучаар дамжуулан Бурханд ойртох ёстойг, мөн тэр зууч тахилын цусгүйгээр Бурханд ойртож чадахгүй гэдгийг **Ариун Сүнс** бидэнд зааж сургаж байсан юм. Энэ нь Бурханы оршихуйд хүрэх **зам** хараахан нээгдээгүй байгааг хүндлэл мөргөл үйлдэж буй хүмүүст ойлгуулах бодит сургамж байлаа.

Эхний асар байгаа цагт Бурханд хүрэх зам бүрэн нээгдээгүй хэвээр байв. Энд Дарбигийн орчуулга үүнийг илүү оновчтой тайлбарласан байж магадгүй. Тэрээр Соломоны хаанчлалын үед асар нь сүмээр солигдсон хэдий ч Христийн үхэл, оршуулга, амилал хүртэл энэхүү асрын тогтолцоо хүчин төгөлдөр хэвээр байсаар байв. Бурхан руу ойртох талаар заадаг асрын зарчмууд нь сүмийн хөшиг дээрээс доош цуу урагдах хүртэл хүчин төгөлдөр байсан юм.

9:9 Асрын тогтолцоо **өнөө үеийн төлөөх бэлгэдэл юм.** Энэ нь илүү сайн зүйлийн дүр зураг болохын хувьд Христийн төгс үйл хэргийн төгс бус дүрслэл байсан юм.

Бэлэг ба тахил нь мөргөж буй хүнийг **мөс чанарынх нь хувьд** хэзээ ч **төгс болгож чадахгүй.** Хэрэв нүгэл бүрэн уучлагдсан байсан бол өргөл өргөгчийн **мөс чанар** нүглийн буруутгалаас чөлөөлөгдөх ёстой байлаа. Гэвч тийм зүйл огт болоогүй.

9:10 Үнэндээ Левийн тахилчдын өргөдөг өргөлүүд **зөвхөн** зан үйлийн бузар байдлыг л арилгадаг байлаа. Тэдгээр өргөл нь гадаад байдлыг л цэвэр болгох бузар **хоол, унд,** дэг жаягийн **угаалтай** холбоотой асуудлыг **шийддэг** байв. Харин ёс суртахууны бузар байдал буюу нүглийн асуудлыг огт арилгаж чаддаггүй байв.

Мөн эдгээр өргөл нь Бурхантай гэрээний харилцаа тогтоосон ард түмэнд хамаатай байв. Тэднийг зан үйлийн хувьд ариун байлгаж, мөргөл үйлдэх боломжоор хангах зорилготой байсан юм. Тэдэнд аврал өгөх хүч, нүглээс цэвэрлэх чадал байгаагүй. Тухайн үеийн хүмүүс ирээдүйд Христийн хийх төгс ажлын үндсэн дээр Эзэнд итгэснээр аврагдаж байсан юм.

Эцэст нь хэлэхэд, тэдгээр тахил бол түр зуурын шинжтэй байв. Тэд **бүх юмсыг байранд нь тавих цаг хүртэл** тогтоогдсон юм. Тэдгээр нь ирж буй Христ рүү, Түүний төгс өргөл рүү чиглүүлж байлаа. **Бүх юмсыг байранд нь тавих цаг** гэдэг нь өнөөгийн христитгэлийн эрин үеийг хэлж байгаа юм.

9:11 Христ, ирэх сайн юмсын Тэргүүн тахилчаар гарч ирсэн. **Христ** Өөрийг нь хүлээн авсан хүмүүст тэрхүү сайн юмсын ерөөлийг соёрхдог.

Түүний ариун газар, **илүү агуу бөгөөд илүү төгс асар** билээ. Үүнийг энэ ертөнцийн барилгын материал ашиглан хүний **гараар** бариагүй. Энэ бол тэнгэрийн ариун газар, Бурханы орших газар билээ.

Христийн үйлчилдэг ариун газар
Хүний гараар баригдаагүй сүм
Тэнгэрлэг тахилчийн үүргээ
Тэнгэрт Тэр ёсчлон биелүүлдэг
Хуульд дүрслэгдсэн бүх бэлгэдлүүд
Христийн дотор бүрэн гүйцэлдсэн

-Томас Келли

9:12 Бидний Эзэн ариунаас ариун газарт нэгмөсөн бүгдийн төлөө орсон. Тэнгэрт өргөгдөхдөө Христ Голгота дээр **золилтын** ажлыг бүрмөсөн дуусгаад Бурханы оршихуйд орсон билээ. **Нэгмөсөн бүгдийн төлөө** гэдэг үг

бол баярлаж бахдаад дуусамгүй сайхан үг билээ! Авралын ажил гүйцэлдсэн тул Эзэнийг магтагтун!

Тэрээр бух ямааны цусыг биш, **Өөрийнхөө цусыг** өргөсөн. Амьтдын цусанд нүглийг зайлуулах хүч байхгүй. Амьтны цус сүсэг бишрэлийн зан үйлийг сэвтээсэн махбодын бузрыг л шийддэг байсан. Харин Христийн цус мөнхийн үнэ цэнтэй. Энэ цус өнгөрсөн, одоо, ирээдүйд амьдарч байсан бүх хүний нүглийг цэвэрлэх хангалттай хүчтэй. Мэдээж итгэлээр Христ рүү ирсэн хүмүүс л тэрхүү хүч чадлын үр нөлөөг амсана. Гэхдээ нүглийг цэвэрлэх боломж нь хязгааргүй.

Христ Өөрийгөө тахил болгоод **мөнхийн золилтыг** боломжтой болгожээ. Харин хуучны тахилчдын өргөл нэг жилийн хугацаанд л эвлэрүүллийг гүйцэлдүүлдэг байлаа. Энэ хоёр өргөлд асар том ялгаа байна.

9:13 Христийн тахил хуулийн өргөлөөс ямар их ялгаатайг харуулахын тулд бичээч улаан **охин бярууны** зан үйл рүү анхаарал хандуулжээ. Хуульд заасанчлан, израиль хүн нас барсан хүний цогцост хүрвэл шашны зан үйлийн хувьд долоо хоногийн турш бузартсанд тооцогддог байв. Үүнээс ангижрахын тулд улаан **охин бярууны үнсийг** булгийн цэвэр устай хольж, гурав болон долоо дахь өдөртөө бузартсан хүн рүү цацдаг байжээ. Ингэж тэр хүн цэвэршдэг байсан юм.

Мантель энэ тухай ийнхүү тайлбарласан байдаг. Үүнд:

Улаан охин бярууны үнсийг нүглийн тахилын үндсэн эдийн нийлбэр гэж үздэг ба цаг алдалгүй, төвөггүй ашиглах боломжтой байжээ. Ганц улаан охин бярууны үнсийг хэдэн зуун жил хэрэглэсэн ч хүрэлцдэг байв. Израилийн түүхийн бүх цаг үеийн турш ердөө зургаан охин бяруу л хэрэгтэй байсан гэж ярьдаг. Учир нь маш бага хэмжээтэй үнс байхад л цэвэр булгийн усанд бузрыг арилгах хангалттай хүчтэй байжээ (Тоо 19:17).¹¹

9:14 Хэрэв улаан охины бярууны үнс гадна талын хамгийн ноцтой бузарталтын нэгийг цэвэрлэх хүч чадалтай байсан юм бол **тэгэх тусмаа Христийн цус** нь хамгийн гүн дэх, дотоод нүглийг цэвэрлэх хүч чадалтай биш гэж **үү!**

Түүний өргөл **мөнхийн Сүнсээр** өргөгдсөн. Энэ хэллэгийн талаар хүмүүс олон янзаар тайлбарладаг. Зарим нь үүнийг “мөнхийн сүнсээр” гэж орчуулах хэрэгтэй гэдэг. Өөрөөр хэлбэл, мал амьтныг хүчээр өргөдөг шиг албадмал бус, харин сайн дураараа (“хүслэнт сүнсээр”) Христ Өөрийгөө өргөсөн гэж тайлбарладаг. Харин зарим нь үүнийг “Христ Өөрийнхөө мөнхийн сүнсээр” гэж тайлбарладаг. Бидний зүгээс үүнийг Ариун Сүнс гэж үзэх нь зөв гэж хардаг. Учир нь Христ Ариун **Сүнсний** хүчээр Өөрийгөө тахил болгон өргөсөн юм.

Энэ өргөлийг **Бурханд өргөсөн**. Тэрээр ёс суртахууны хувьд ямар ч толбогүй, нүгэлгүй, Бурханы Хурга бөгөөд энэхүү төгс ариун байдал нь Түүнийг нүглийг Үүрэгч болоход бүрэн тохирохоор болгосон юм. Амьтдын тахилууд бие махбодын хувьд ямар ч өө сэвгүй, толбогүй, согоггүй байх ёстой байсан бол Христ ёс суртахууны хувьд төгс өөгүй байсан юм.

Түүний **цус мөс чанарыг маань үхлийн үйлсээс цэвэрлэн, амьд Бурханд үйлчлүүлдэг**. Энэ нь зүгээр нэг бие махбодын цэвэрлэгээ, зан үйлийн ариусгал биш, харин мөс чанарыг ариусган шинэчилдэг ёс суртахууны гүн өөрчлөлт юм. Энэ бол үл итгэгч хүмүүс өөрсдийнхөө мөс чанарыг цэвэрлэхийн тулд хийдэг амьгүй, үхмэл үйлсээс цэвэрлэж, амьгүй үйлсээс чөлөөлж, **амьд Бурханд үйлчлүүлдэг**.

9:15 Өмнөх эшлэлүүд Шинэ гэрээний цусыг хуучин гэрээний цуснаас хавьгүй илүү гэдгийг цохон тэмдэглэсэн. Үүнээс үүдэн 15-р эшлэлийн дүгнэлт гарч ирж байна. Өөрөөр хэлбэл, Христ **шинэ гэрээний зууч мөн** гэдгийг тунхаглаж байна. Вэст үүнийг ингэж тайлбарлажээ:

“Зууч” гэдэг үг нь *мэситэс* гэдэг грек үгийн орчуулга бөгөөд энх тайван, нөхөрлөлийг бий болгох, сэргээх, нягт харилцааг үүсгэх, гэрээг бататгах зорилгоор хоёр хүний хооронд хөндлөнгөөс оролцогч этгээдийг хэлдэг. Энд Мессиа нь ариун Бурхан ба нүгэлт хүмүүний хооронд зууч болж, загалмай дээр амиа өргөснөөрөө хүн, Бурхан хоёрын харилцааг салгасан саад тотгорыг (нүглийг) зайлуулсан юм. Нүгэлт хүн Мессиагийн тахилын ач гавьяаг итгэлээр хүлээн авбал түүний нүглийн буруутгал хийгээд шийтгэл үгүй болж, амьдралд нь буй нүглийн хүч тасарч, Бурханы мөн чанарын хуваалцагч болж, Бурхантай харилцах харилцаанд нь байсан хуулийн болон хувийн зөрчил ор мөргүй алга болно.¹²

Дуудагдсан хүмүүс одоо амлагдсан **мөнхийн өвийг** хүлээн авах боломжтой болжээ. Христийн үйл хэргийн ачаар Хуучин болон Шинэ гэрээний ариун хүмүүс **мөнх** аврал ба **мөнх** золилтыг эдэлж байна.

Христээс өмнөх үеийн итгэгчид энэхүү өвийг хүлээн авах болзлыг хангах шалтгаан нь Христийн үхэл юм. Түүний үхэл тэднийг хуулийн **дор үйлдсэн** алдаа зөрчлөөс нь зольдог.

Нэг ёсондоо, Бурхан Хуучин гэрээний хүмүүсийг “зээлийн зарчмаар” авардаг байлаа. Тэд бидний нэгэн адил итгэлээр зөвтгөгдсөн. Гэвч тухайн үед Христ хараахан амиа өргөөгүй байв. Тэгвэл Бурхан тэднийг хэрхэн авардаг байсан юм бэ? Хариулт нь, Христ үхнэ гэдгийг Бурхан мэдэж байсан учраас үүн дээр үндэслэн тэднийг авардаг байсан ажээ. Хуучин гэрээний хүмүүс Голгота дээр юу болох талаар бараг л мэддэггүй байсан. Зарим нь энэ талаар огт мэдээгүй юм. Гэвч Бурхан ирээдүйд юу болохыг мэдэж байсан учир Өөрийнхөө талаар илчилсэн зүйлд нь

итгэвэл Христийн ирээдүйд үйлдэх үйл хэргийн үнэ цэнийг тэдний хувьд тооцон аварч байлаа.

Нэг ёсондоо, Хуучин гэрээний үед нүглийн их өр хуримтлагджээ. Харин Христ үхлээрээ дамжуулан өмнөх үеийн итгэгчдийг алдаа зөрчлөөс нь аварчээ.

Бурхан Христийн ирээдүйд үйлдэх үйл хэргээр дамжуулан хүмүүсийг аварсан энэхүү үйл явдлыг Ром 3:25, 26 дээр “урьд үйлдэгдсэн нүглүүдийг тэвчин өнгөрүүлэх” гэж маш тодорхой тайлбарлан өгүүлсэн байдаг.

9:16 Бичээч 15-р эшлэлд дурдсан өв гэх ойлголт нь нас барсан хүний эцсийн гэрээслэлийг санагдуулж байна. Гэрээслэл хэрэгжихийн тулд эхлээд **гэрээслэгч** нас барсныг нотлох баримт зайлшгүй шаардлагатай. Ихэнхдээ нас барсны гэрчилгээ байхад хангалттай баримт болдог.

9:17 Гэрээслэгч нас барахаасаа олон жилийн өмнө гэрээслэл үйлдээд аюулгүй газар хадгалсан байж болох ч **гэрээслэгч** нас барах хүртэл гэрээслэл хүчин төгөлдөр болдоггүй. **Гэрээслэгч** амьд байгаа цагт гэрээслэлд нэр дурдсан хүмүүст эд хөрөнгийг нь өвлүүлэх боломжгүй.

9:18 Энд ярианы сэдэв хувь хүний эцсийн гэрээслэлээс хальж Мосегоор дамжуулан Бурханы өгсөн Хуучин **гэрээ** рүү шилжиж байна. (“Гэрээ” эсвэл “гэрээслэл” гэдэг үг грек хэлээр *διατέке* гэх ганц үгээр илэрхийлэгддэг.) Энд ч мөн адил үхэл зайлшгүй шаардлагатай байлаа. Энэ гэрээ **цус** урсгах замаар баталгаажсан.

Эрт цагт аливаа гэрээг батлахын тулд амьтныг тахил болгон өргөдөг байв. Урсгасан цус нь гэрээний нөхцөл биелнэ гэдэг баталгаа байжээ.

9:19 Мосе Израильд хуулийг уншиж өгснийхөө дараа тугал болон ямааны цусыг ус, час улаан ноос, балууны мөчрийн хамт авч, хуулийн ном дээр болон бүх хүн дээр цацсан. Ийнхүү Мосе гэрээг ёслол төгөлдөр батлах зан үйлийг үйлдсэн юм.

Гэтлэл 24:1-11 эшлэлийг уншвал Мосе тахилын ширээ болон **бүх хүн дээр цус цацсан** тухай өгүүлэх боловч **ном, ус, час улаан ноос, балууны** тухай дурдаагүй байна. Тэгэхээр энэ хоёр тэмдэглэлийг хоорондоо зөрчилдөх бус харилцан бие биеэ нөхсөн гэж харвал хамгийн зөв болно.

Тахилын ширээгээр Бурхан ба израилийн ард түмэн гэсэн гэрээний хоёр талыг төлөөлүүлэв. Харин **ном** өөрөө гэрээ байв. **Цацсан цус** нь гэрээний нөхцөлийг биелүүлэх үүргийг хоёр талд хоёуланд нь өгсөн юм. Израилийн ард түмэн дуулгавартай байна гэж амласан бол Эзэн тэднийг дуулгавартай дагавал ерөөнө гэж амласан.

9:20 Мосе цусыг цацахдаа “**Энэ бол Бурханы та нарт тушаасан гэрээний цус мөн**” гэж хэлжээ. Энэ үйлдэл нь израильчуудын амийг дэнчин тавьсан явдал байлаа. Тэд хуулийг эс сахивал амиараа төлнө гэдгийг үүгээр илэрхийлж байна.

9:21 Үүний нэгэн адил Мосе **асар ба үйлчлэлийн бүх сав суулга дээр мөн цус цацсан**. Мосегийн энэ үйлдлийг Хуучин гэрээнд шууд тэмдэглэн үлдээгээгүй. Гэтлэл 40-р бүлэгт асрыг ариусгахдаа цус цацсан гэж дурддаггүй. Гэхдээ бэлгэдлийн чанартай утга нь тодорхой байна. Нүгэлт хүний хүрсэн юм бүр бузартдаг тул ариусгах шаардлагатай байдаг.

9:22 **Хуулийн дагуу бараг бүх юм цусаар цэвэршигддэг**. Гэхдээ үүнд эс хамаарах хэдэн тохиолдол бий. Жишээ нь, хүн Израилийн хөвгүүдийн дунд тоологдвол цусан өргөл авчрахын оронд “эвлэрүүллийн мөнгө” болгож хагас шекел мөнгө өгч болно (Гэт 30:11-16). Уг зоос тухайн хүний сүнсний эвлэрлийг бэлгэдсэн тэмдэг байсан ба Бурханы ард түмний нэг гэж тооцогддог бэлгэдэл байжээ. Өөр нэг тохиолдол Леви 5:11 дээр гардаг. Энд хэлсэнчлэн зан үйлийн зарим бузрыг сайн чанарын гурил өргөснөөр шийдэж болдог байжээ.

Эдгээр онцгой тохиолдол нүглийн эвлэрүүлэл буюу нүглийг *халхлахтай* холбоотой байжээ. Гэвч ерөнхийдөө эвлэрүүлэлд цусан өргөл шаардлагатай хэвээр байв. Харин нүглийн **уучлалын** тухайд ямар ч онцгой зүйл байхгүй заавал **цус урсах** ёстой юм.

9:23 Есдүгээр бүлгийн үлдсэн хэсэгт хоёр гэрээг хооронд нь харьцуулан ялгаж тайлбарлажээ.

Юуны түрүүнд, газар дээрх асрыг бух болон ямааны цусаар цэвэршүүлэх ёстой байв. Өмнө хэлсэнчлэн, энэ нь зан үйлийн шинжтэй ариусгал байв. Өөрөөр хэлбэл, бэлгэдлийн чанартай ариусгал нь бэлгэдлийн ариун газарт үйлдэгдсэн гэсэн үг.

Харин **тэнгэр дэх** ариун газар нь газар дээрх асрын жинхэнэ бодит байдал бөгөөд газар дээрх асар түүний хуулбар нь байлаа. Тэгэхээр **тэнгэр дэх** ариун газар **илүү дээр тахилуудаар** буюу Христийн **тахилуудаар цэвэршигдэх шаардлагатай байв**. Христийн ганц өргөлийг **тахилууд** гэж олон тоон дээр ярьсан учир нь уран сайхны хэллэг болох эрхэм дээдийн олон тооны нэршил юм.

Тэнгэр дэх ариун газар ариусгагдах шаардлагатай гэдгийг сонсоод та гайхаж болох юм. Үүний тайлал нь Иов 15:15 дээр өгөгдсөн байдаг. “Тэнгэрс ч хүртэл Түүний мэлмийд цэвэр биш байдаг.” Энэ нь магадгүй Сатан анхны нүглийг тэнгэрт үйлдсэнтэй холбоотой буй за (Иса 14:12-14). Түүгээр ч зогсохгүй, Сатан одоо ч ах дүүсийг буруутгахаар Бурханы өмнө оршихуйд очих боломжтой (Илч 12:10) байдагтай холбоотой байж болно.

9:24 Христ жинхэнийнх нь хуулбар, хүний гараар хийгдсэн ариун газарт ороогүй. Харин тэнгэрт өөрт нь орсон билээ. Тэнд Тэр бидний төлөө Бурханы оршихуйд үзэгддэг.

Хүн бид жинхэнэ нь байсаар байтал хуулбар руу нь буцмаар байдаг нь ойлгомжгүй. Яагаад тэнгэрийн ариун

газарт үйлчилдэг агуу Тэргүүн Тахилчийг орхиж, бэлгэдлийн чанартай асарт үйлчилдэг Израилийн тахилчид руу очих гэдэг юм бэ?

9:25 Эзэн Есүс Аароны удмын **тэргүүн тахилч шиг, дахин дахин** давтдаг өргөл өргөөгүй. Аароны удмын тэргүүн тахилчид жилд нэг удаа, эвлэрүүллийн өдрөөр ариунаас **ариун газарт** ганц удаа ордог байлаа. Тэд тийш орохдоо өөрийнхөө цусыг бус, амьтны **цусыг** тахилд өргөдөг байжээ.

9:26 Христ ахин дахин өргөл өргөсөн бол ахин дахин зовох ёстой болох байлаа. Учир нь Түүний өргөл бол Өөрийнх нь амь байсан юм. **Тэр ертөнцийн сууриас хойш** Голготын шаналал зовлонг үе үе дахин эдлэх ёстой байсан бол бодохоос ч зүрх өвдмөөр юм. Гэвч ингэх хэрэг огт байхгүй.

Шинэ гэрээнд дараах бодит үнэнүүд бий.

1. Бүрмөсөн шийдэгдсэн – **Тэр бүгдийн төлөө ганц удаа үзэгдсэн.** Одоо тэр ажлыг ахин дахин давтаж хийх шаардлагагүй.

2. Тааламжтай цаг – **Тэр үеийн төгсгөлд** үзэгдсэн. Өөрөөр хэлбэл, Хуучин гэрээ хүний алдаа, хүчгүй дорой байдлыг бүрэн харуулсны дараа гарч ирсэн гэдэг.

3. Төгс үйлс – **Тэр нүглийг зайлуулахын** тулд үзэгдсэн. Энд **нүглийг зайлуулах** гэдэг үг онцгой ач холбогдолтой. Нүгэл нэгэнтээ зайлуулагдсан юм бол жил бүрийн эвлэрүүлэл хэрэггүй болж, мөнхийн уучлал ирсэн юм.

4. Өөрийгөө тахил болгосон – **Тэр нүглийг зайлуулахын** тулд **Өөрийгөө тахил болгон** өргөсөн. Тэрээр бидний үүрэх ёстой шийтгэлийг Өөрийн бие дээр үүрчээ.

Ичгүүр гутамшиг, доромжлолыг үүрэн
Энэ биеийн минь оронд Тэр шийтгүүлжээ
Цусаараа уучлалыг тамгалсан
Эгэлгүй аугаа Аврагч минь, халлелуяа!

-Филип II. Блисс

9:27 Есдүгээр бүлгийн 27, 28 дугаар эшлэл Хуучин ба Шинэ гэрээг арай өөр талаас нь харьцуулж байгаа мэт харагддаг. Хууль нь нүгэлтнүүдийг **ганц удаа** үхүүлэхээр тогтоож, **харин дараа нь** шүүлт ирдэг байв. Хуулийг төрөлхийн нүгэлтэй, төгс сахиж чадахгүй нь тодорхой хүмүүст өгсөн. Тиймээс хууль нь өөрийнх нь доор байдаг хүмүүсийг яллагч болж хувирав.

9:28 Шинэ гэрээ нь **Христийн** хязгааргүй тахилыг танилцуулдаг. **Христ олны нүглийг үүрэхийн тулд ганц удаа өргөгдсөн.** Шинэ гэрээ нь мөн Христийн эргэн ирэх ерөөлт найдварыг соёрхдог. Тэрээр **хоёр дахиа үзэгдэхдээ Өөрийг нь тэсэн ядан хүлээгсдийг аврахын тулд ирнэ.** Гэхдээ эргэж ирэхдээ Тэр **нүглийн** асуудлыг шийдэхээр ирэхгүй. Учир нь энэ үйл хэргийг Тэр загалмай дээр бүрэн дуусгасан юм. Харин Христ Өөрийн хүмүүсийг тэнгэр дэх гэр рүү нь авч явахаар ирнэ. Энэ нь тэдний авралын оргил үе байх болно. Тэд цог жавхлант биеийг хүлээн аваад үүрд нүглээс ангид байх болно.

Өөрийг нь тэсэн ядан хүлээгсэд гэсэн илэрхийлэл нь жинхэнэ итгэгчдийг хэлж байна. Эзэнийг эргэн ирэхтэй холбоотой үйл явдлын дараалал дээр бүгд санаа нийлэхгүй байж болох ч Эзэний хүмүүс Түүнийг эргэн ирэхийг харуулдан хүлээдэг.

Шүүрэлт болох үеэр зөвхөн онцгой сүнслэг итгэгчид л тэнгэрт гарна гэж Библи заадаггүй. Харин тухайн үед “Христ дотор үхэгсэд” хийгээд “амьд үлдсэн бид” тэнгэр өөд дээш одно гэж Библи хэлдэг (1Тс 4:16, 17). Нэг ёсондоо, үхсэн амьд бүх жинхэнэ итгэгч хүнийг хэлж байна. 1Коринт 15:23 эшлэлд тэднийг “Христийнхэн” гэжээ.

Анзаарч харсан бол 24-28 эшлэлд Христ үзэгдэх тухай гурвантаа онцолсон байдаг. Эдгээрийг дараах байдлаар тоймлон авч үзэж болно.

26-р эшлэл: Тэрээр үеийн төгсгөлд үзэгдсэн. Энэ нь Христ нүглийн шийтгэлээс аврахаар газар дэлхий дээр хамгийн энх ирсэн үеийг хэлж байгаа (авралын *өнгөрсөн* цаг).

24-р эшлэл: Тэрээр Бурханы оршихуйд үзэгддэг. Энэ нь биднийг нүглийн хүчнээс аврахын тулд Бурханы өмнө хийдэг Христийн одоогийн үйлчлэлийг хэлж байна (авралын *одоо* цаг).

28-р эшлэл: Тэр хоёр дахиа үзэгдэнэ. Энэ нь биднийг нүглээс бүрмөсөн аврахаар Христ эргэн ирэхийг хэлж байна (авралын *ирээдүй* цаг).

10:1 Хууль ердөө л **ирэх сайн юмсын сүүдэр** байв. Энэ нь Христийн мөн чанар ба үйл хэргийг заадаг боловч бодит юмсыг орлуулж байгаа өчүүхэн орлогч байв. Хуулийг Христээс дээр тавих нь хүнийг нь мартаад зургийг нь илүүд үзэж буйтай адил юм. Энэ бол Түүний сүр жавхланд *доромжлол* болно.

Хуулийн тогтолцооны сул тал нь өргөдөг тахилууд нь байнга давтагддаг байсанд оршино. Ахин дахин ийн давтдаг байсан нь уг тахилууд ариун Бурханы шаардлагыг хангах чадваргүйг нотолж байна. Үүнийг илтгэхийн тулд **жил бүр байнга өргөдөг өнөөх л тахилууд** гэсэн үг хэллэгийг ашиглажээ..

Энэ тахилууд нь хүндэлж мөргөдөг хүмүүсийг төгс болгох ямар ч чадваргүй байв. Өөрөөр хэлбэл, нүглээс хүний мөс чанарыг **төгс** чөлөөлж чаддаггүй байсан юм. Израильчууд нүглийн буруутгалаас үүрд ангижирсан мэдрэмжийг хэзээ ч амсаагүй гэсэн үг. Тэд мөс чанартаа бүрэн амралтыг олоогүй юм.

10:2 Хэрэв тахилууд нь тэднийг нүглээс бүрэн чөлөөлж чадсан бол тэд жил бүр асар майхан руу очихоо **больсон байх байсан биш үү?** Гэтэл тахилуудыг байнга давтдаг байсан нь үр дүнгүй байсныг нь нотолж байна. Амьд

явахын тулд байнга эм уух шаардлагатай хүнийг эдгэрсэн гэж хэлэх аргагүйтэй адил юм.

10:3 Левийн хууль нь мөс чанарыг тайвшруулахын оронд жил бүр сэдрээж, сануулдаг байв. Эвлэрүүллийн өдрийн сайхан зан үйлийн цаана үнэндээ нүгэл түр зуур халхлагдсан хэвээр байгааг жил бүр дахин сануулж байсан юм.

10:4 Бух, ямааны цус нүглийг авч хаях ямар ч хүчгүй байлаа. Өмнө нь хэлсэнчлэн, энэ тахилууд нь зөвхөн зан үйлийн алдаа зөрчлийг л шийддэг байсан юм. Тэд ёс заншлын дэг жаягтай холбоотой ариусгалыг тодорхой хэмжээнд хийх боловч хүний нүгэлт чанар хийгээд хорон муу үйлийнх нь асуудлыг хангалттай шийдэж өгөлгүй, бүтэлгүйтсэн юм.

10:5 Левийн тахилуудыг сул дорой гэж харьцуулан харсан бид одоо Христийн хэмжээлшгүй агуу тахилын хүч чадлыг харж байна. Христ хүн болж энэ дэлхийд ирэх үед доторх бодлыг нь сонсох боломж бидэнд олддог. Тэрээр Дуулал 40-р бүлгээс эш татан, Хуучин гэрээний тахилуудад Бурхан сэтгэл ханадаггүйг цохон тэмдэглэв. Энэ тахилуудыг Бурхан Өөрөө тогтоосон нь үнэн ч тэдгээр нь Бурханы туйлын зорилго байсангүй. Учир нь энэ нь нүглийг бүрмөсөн арилгахын тулд биш, харин ертөнцийн нүглийг үүрэх Бурханы Хурга руу чиглүүлэхийн төлөө байлаа. Бурхан амьтдын цусаар урсах гол, цогцсоор дүүрсэн овоог таална гэж үү?

Бурхан сэтгэл хангалуун биш байсан бас нэг шалтгаан нь хүмүүсийн доторх нь ялзрал, гэм нүглээр дүүрчихсэн атлаа зан үйл үйлдээд Бурханд таалагдана гэж эндүүрч байсан явдал юм. Олон хүн өөрсдийн гэм нүглээ гэмшихгүйгээр өнөөх л уйтгартай тахилыг давтан өргөхөд найдвараа тавьж байлаа. Тэд амьтнаар тахил өргөж Бурханыг аргадна гэж бодсон ч Бурхан эмтэрсэн сэтгэлийн тахилыг хүсэж байсныг ойлгосонгүй. Тэгвэл Бурхан зан

үйлд ач холбогдол өгч, баригддаг Нэгэн биш гэдгийг тэд ухаараагүй юм.

Бурхан урьдын тахилуудад сэтгэл ханаагүй учир Өөрийн Хүүд хүний **бие бэлдсэн**. Энэ нь Түүний хүний мөн чанар, амь амьдралын салшгүй хэсэг байв. Энэ нь мөнх Үг махбод болж, Хүний хувиар хүмүүсийн төлөө үхэхийн тулд хүн болсон Нэгэний талаар ухаарч ойлгохын аргагүй гайхамшгийг илэрхийлдэг.

“Та Надад бие бэлдсэн” гэдгийг эш татсан Дуулал 40:6 хоёр утга илэрхийлдэг нь нэн сонирхолтой. Уг Дуулалд “Та чихийг минь нээсэн” гэж бичигджээ. Энэ өгүүлбэрийг өөрөөр бас “Та чихийг минь цоолсон” гэж орчуулж болно. Чих нь нээлттэй гэдэг нь Бурханы зааврыг хүлээн авч, дуулгавартай дагахад Мессиа бэлэн байсныг илэрхийлдэг. Харин цоолуулсан чих еврей боолын дүрслэл юм (Гэт 21:1-6). Еврей боол сайн дураараа үүрд эзэндээ үнэнч үлдэхээр шийдвэл хаалган дээр чихийг нь тавьж байгаад шөвгөөр цоолдог байжээ. Бидний Эзэн энэ дэлхийд Хүн болж ирэхдээ “Би Эзэндээ... хайртай. Би чөлөөлөгдөж явахгүй” гэж хэлжээ.

10:6 Дуулал 40 дүгээр бүлгээс үргэлжлүүлэн эш татаад Мессиа, Бурхан **шатаалт ба нүглийн тахилыг** таалаагүй гэдгийг давтан хэлэв. Эдгээр амьтан өөрсдийн хүслээр бус, албадлагаар золиос болдог тул цус нь цэвэршүүлэх чадалгүй. Тэгээд ч амьтнаар өргөсөн тахил Бурханы туйлын хүсэл байгаагүй. Харин тэдгээр нь Христийн тахил руу чиглүүлдэг бэлгэдэл ба сүүдэр төдий зүйл байлаа. Үнэн чанартаа ямар ч үнэ цэнгүй билээ.

10:7 Харин Мессиа ямар ч үнээр хамаагүй Бурханы **хүслийг** биелүүлэх эрмэлзэлтэй байсан нь Бурханы таалалд нийцсэн юм. Тэрээр Өөрийгөө тахилын ширээн дээр өргөж, дуулгавартай байдлаа батлан харуулсан юм. Бидний Эзэн энэ үгсийг хэлж байгаа нь Хуучин гэрээ эхнээсээ төгсгөл хүртэл Өөрийг нь гэрчилдгийг сануулж,

Бурханы хүслийг чин сэтгэлээсээ, баяртайгаар хэрэгжүүлдэг болохоо харуулж байна.

10:8 Аравдугаар бүлгийн 8-10-р эшлэлд бичээч, Эзэний дотроо ярьсан үгсийн сүнслэг ач холбогдлыг дурдаж байна. Бичээч Эзэний үгсийг хуучин тахилын тогтоолцоо нурж, Есүс Христийн төгс, бүрэн дүүрэн, эцсийн ганц тахил шинээр тогтоогдсоны нотолгоо гэж үзжээ.

Бичээч Дуулал 40 дүгээр бүлгээс товчхон эш татаж, Бурхан **хуулийн дагуу өргөгддөг** тахилуудыг **хүсээгүй** гэдгийг цохон тэмдэглэв.

10:9 Дараа нь бичээч Бурхан хуучин тахилуудыг таашаадаггүй гэдгийг илэрхийлснийхээ яг араас нь Мессиа Өөрөө Эцэгийнхээ сэтгэлд таалагдах зүйлийг үйлдэхээр гарч ирж байгаа нь маш чухал ач холбогдолтой гэж үзжээ.

Үүнээс, **Тэр хоёр дахийг нь тогтоохын тулд анхныхыг нь зайлуулдаг** гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, Тэр хуулийн шаарддаг тахилын хуучин тогтолцоог хүчингүй болгож, нүглийн төлөө өргөгдсөн Өөрийнхөө агуу тахилыг оронд нь тогтоов. Хуулийн гэрээний үүрэг дуусаж, тайзны ард үлдэж, шинэ гэрээ гол дүрд тоглохоор тайзан дээр гарч ирэв.

10:10 Есүс Бурханы тэрхүү хүслийг бүрэн дуулгавартай биелүүлсний үр дүнд **бид Есүс Христийн, бүгдийн төлөө нэгмөсөн биеэ өргөсөн өргөлөөр ариусгагдсан юм.** Жорж Ландис үүнийг доор ийнхүү тайлбарлан бичсэн байдаг.

Еврей 12:14 эшлэлийг эс тооцвол Еврей ном тэр чигтээ байр суурийн ариусгалыг ярьдаг. Энэ нь бүх итгэгчдэд хамаатай (1Ко 6:11). Итгэлээр өссөн цөөн хэдэн итгэгчид ч биш харин бүх итгэгч хүн Бурханы өмнө ариунд тооцогддог. Энэ ариусгал Бурханы хүсэл ба Христийн тахилаар биеллээ олжээ. Бид Бурханаар, Бурханд зориулан, Бурханы төлөө тусгаарлагджээ.

Үгээр дамжуулан Бурханы Сүнс итгэгч хүний дотор ажилладаг үйл явцтай үүнийг андуурч болохгүй (Иох 17:17-19; 1Тс 5:23).¹³

10:11 Одоо Аароны удмын **тахилчийг** Христтэй харьцуулж байна. Тэд **өдөр бүр үйлчлэн зогсдог** байлаа. Асар болон сүмд ямар ч амсхийх суудал байгаагүй. Ажил нь хэзээ ч дуусдаггүй учир тэдэнд амрах боломж гараагүй. Тэд **өнөөх л тахилуудаа дахин дахин өргөсөөр** байлаа. Дуусахгүй ажлыг хийсээр байвч нүгэл шийдэгдэхгүй, мөс чанарт ч амралт эс ирэв.

Энэ тахилууд нүглийг хэзээ ч зайлуулж чадаагүй. “Левийн тогтолцоонд Аароны үүрэг алба чухал үүрэгтэй ч тахил өргөх ажил нь дууссангүй. Түүний үйлддэг ёслол, дэг жаяг, зан үйлүүдэд жинхэнэ үнэ цэн байсангүй.”¹⁴ (А. Б. Брюс)

10:12 Харин бидний ерөөлт Эзэн **нүглийн төлөө ганц тахил** өргөсөн. Нэмж өөр тахил өргөх шаардлага одоо байхгүй.

Тахилын ширээ, амьтны цус ахин хэрэггүй
Тахилыг одоо нэмж өргөх шаардлагагүй
Халуун гал, анхилуун утлага гэж байхгүй
Хурга нядалж Бурханд өргөх албагүй
Ял бурууг сэтгэлээс минь зайлуулахаар
Яруу алдарт Бурханы цус урсжээ
Хилэнц нүглийг минь арчиж цэвэрлэхээр
Христ Эзэний эрхэм цус асгарчээ
-Хоратиус Бонар

Христ золилтын үйл хэргээ бүрэн гүйцээсний дараа “**Бурханы баруун гарт үүрд заларч** байна.” Энэ эшлэлийг цэг таслалаас нь хамаарч хоёр янзаар хөрвүүлэх боломжтой. Нэгдүгээрт, “Тэр нүглийн төлөөх ганц тахил

үүрд өргөсөн”, эсвэл “Бурханы баруун гарт үүрд заларсан” гэж хөрвүүлж болно. Аль аль нь зөв боловч хоёр дахь хувилбарыг зөв гэж үзэх нь бий. Учир нь нүглийн их өр нэг мөр төлөгдсөн тул Христ үүрд сэнтийдээ заларсан байх учиртай. Тэрээр **Бурханы баруун гарт** буюу хүндлэл, хүч чадал, эрх мэдэл, тааллыг хүртсэн байр сууринд заларч байна.

Зарим хүн Христ шүүхээр босох тул үүрд заларсан байх боломжгүй гэж маргаж магадгүй. Энд ямар нэг зөрчил байхгүй. Нүглийн төлөө өргөл өргөхийн тухайд Тэр үүрд заларч байна. Харин шүүлтийн тухайд Тэр үүрд залрахгүй.

10:13 Христ дайснуудыг нь хөлийнх нь гишгүүр болгох хүртэл хүлээж байна. Тэр цагт өвдөг бүхэн Түүний өмнө сөхөрч, хэл бүхэн Түүнийг Эзэн хэмээн хүлээн зөвшөөрч, Эцэг Бурханыг алдаршуулна (Флп 2:10, 11). Энэ бол бүх дэлхий Түүний үнэн зөвийг олны өмнө ил тод батлах өдөр байх болно.

10:14 Тэр ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд (буюу мөнхөд) **төгс болгожээ.** Эндээс харвал Христийн **тахил** илт давуу, үнэ цэнтэй гэдэг нь ойлгомжтой байна. **Ариун болгогдогсод** гэж энэ ертөнцөөс Бурханд тусгаарлагдсан хүмүүс буюу жинхэнэ итгэгчдийг хэлж байна. Тэд хоёр талаар **төгс болгогдсон.** Нэгдүгээрт, тэд Бурханы өмнө төгс байр суурьтай болсон гэсэн үг. Тэд хайрт Хүүгийнх нь үнэ цэнээр Эцэгийн өмнө зогсдог. Бурхан Христийг хэрхэн хүлээн авдгийн адил тэднийг хүлээн авдаг. Хоёрдугаарт, тэд нүглийн буруутгал, шийтгэлийн хувьд төгс мөс чанартай болсон гэсэн үг. Учир нь нүглийн өр бүрэн төлөгдсөн тул Бурхан шийтгэлийг хоёр дахь удаагаа нэхэхгүй гэдгийг тэд мэддэг болсон.

10:15 Шинэ гэрээн дор нүгэл нэгмөсөн, бүрэн шийдэгдэнэ гэдгийг **Ариун Сүнс мөн гэрчилдэг.** Ариун Сүнс үүнийг Хуучин гэрээний бичвэрээр дамжуулан **гэрчилдэг.**

10:16 Иеремиа 31:31 дээр **Эзэн** Өөрийн сонгож авсан, дэлхийн ард түмэнтэй шинэ **гэрээ** байгуулна гэж амласан.

10:17 Иеремиагийн үгэнд цааш нь **Эзэн**, “**Би цаашид тэдний нүглийг, тэдний ёс бус явдлыг эс санана**” гэжээ. Нүглийг нэгмөсөн, бүрэн уучлах тухай Бурханы амлалтыг Иеремиа бичиж үлдээсэн байтал уг амлалт эхнээсээ биелж буй цаг үед амьдарч байсан зарим хүн иудейзмын хэзээ ч дуусдаггүй тахилууд руу эргэж буцахыг оролдож байсныг гайхаад барамгүй!

10:18 Шинэ гэрээн дор нүглийн уучлал ирнэ гэж амласан нь **цаашид нүглийн төлөөх тахил үгүй болно** гэсэн утгатай. *Цаашид нүглийн тахил үгүй болно* гэдэг үгээр бичээч захидлынхаа онол сургаалыг дуусгаж байна. Бичээч энэ үгсийг зүрх сэтгэл, бодол санаандаа байнга хадаатай байлгаж, амьдралдаа тогтмол хэрэгжүүлэхийг биднээс хүсэж байна.

III. СЭРЭМЖЛҮҮЛЭГ БА ЯТГАЛГА (10:19-13:17)

А. Христийг голж, дорд үзэхгүй байхыг сэрэмжлүүлсэн нь **(10:19-39)**

10:19 Хуучин гэрээний үед хүмүүс Бурханаас алс хол байсан. Харин одоо бид Христ дотор Түүний загалмайн **цусаар** ойр болжээ. Тиймээс биднийг Бурханд ойртон очихыг уриалан зоригжуулж байна.

Энэ уриалга бүх итгэгчийг тахилч болсон гэдгийг харуулдаг. Учир нь бидэнд **Есүсийн цусаар ариун газарт нэвтрэн орох итгэл** байгаа гэж байна. Иудейзмын цаг үед жирийн хүмүүс ариунаас ариун газар байтугай ариун газарт ч нэвтрэх эрхгүй байлаа. Асрын эхний өрөө рүү тахилчид, хоёр дахь өрөө рүү тэргүүн тахилч л гагцхүү орж болдог байв. Тэгвэл одоо бүх зүйл өөрчлөгдсөн байна. Бурхантай уулзах гэж тусгай өрөө рүү, тусгай хүмүүс

ордог үе ард хоцорчээ. Харин бүх итгэгч дэлхийн хаанаас ч, хэзээ ч итгэлээр Бурханы оршихуй руу орох боломжтой болсон байна.

Айж бэргэж эмээлгүй нэвтэр гэж дууджээ
Агуу Бурханы үгийг зоригтой дагана би
Амьд бөгөөд шинэ замаар ор гэж айлджээ
Аврагчийн бие, хөшгөөр дамжин орно би

Христтэй хамт Бурхантай тэнд уулзах юм
Хэлтрүүлгийн таган дээр Бурхан заларч суугаа юм
Христийн цусны үнэ цэнээр тэнд зогсох юм
Хэзээ ч хөөгдөхгүй гэх баталгаа надад байгаа юм

Хүндлэл, дээдлэл, бишрэлээ илэрхийлэхдээ би
Ургацын түрүү Христийг өргөн барина
Хүлээн зөвшөөрөгдөж тааллыг хүртэх гэж би
Бурханы баясал болох Христийг өмнөө барина
-Зохиогч нь тодорхойгүй

10:20 Бид одоо **шинэ, амьд замаар** Бурханд ойртох боломжтой болсон. **Шинэ** гэдэг нь “шинээр нээгдсэн” буюу “цоо шинээр нядалсан” гэсэн утгатай. Харин **амьд** гэдэг нь амилсан Есүс буюу **амьд** Аврагчийг хэлж байна. Энэ зам Христийн **махбод болох хөшгөөр дамжуулан** нээгдсэн. Асрын хоёр өрөөний дундах хөшиг нь бидний Эзэний биеийг илэрхийлж байсныг энд тодорхой хэлжээ. Бид Бурханы оршихуй руу нэвтрэхийн тулд хөшиг урагдах ёстой байсан юм. Өөрөөр хэлбэл, Түүний бие махбод үхлээр бяцрах ёстой байжээ. Тэгэхээр бид Христийн нүгэлгүй амьдралаар дамжин Бурханд ойртох боломжгүй, харин үхлээр нь дамжин ойртох боломжтой байсан гэдгийг сануулдаг. Зөвхөн Хурганы үхлийн шархаар дамжин бид дотогш нэвтрэн орж болно. Тиймээс залбирал хийгээд

мөргөлөөр Бурханы оршихуйд орох бүрдээ энэ агуу эрх ямба бидэнд асар их үнээр ирснийг санах хэрэгтэй.

10:21 Бидэнд Бурханы оршихуй руу орох итгэл зоригоос гадна **Бурханы гэр дэх аугаа Тахилч** байдаг. Бид хэдийгээр тахилч (1Пт 2:9; Илч 1:6) боловч өөр нэг Тахилч хэрэгтэй. Тэгвэл Христ бидний агуу Тэргүүн **Тахилч** билээ. Тэр одоо тэнгэрт үйлчилдэг учраас Бурхан биднийг ямагт таалан хүлээн авах баталгаа болдог.

10:22 Бурханд **ойртон очицгооё**. Энэ бол итгэгчдэд цусны үнээр олдсон онцгой эрх юм. Энэ бол дэлхийн алдартнуудтай биш орчлон ертөнцийн Аврагчтай уулзахаар дуудагдсан үгээр илэрхийлэхийн аргагүй, агуу гайхалтай завшаан юм! Бид энэ урилгыг хэр их үнэлж байгаагаа ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаараа харуулдаг. Бид сэнтийн өмнө очихдоо сэтгэл сүнсээ бэлтгэх дөрвөн шаардлагыг энэ эшлэлд тодорхойлсон байна.

1. **Үнэн зүрхээр.** Израилийн ард түмэн амаараа Бурханд ойртож, Түүнийг уруулаараа хүндэтгэдэг байсан ч зүрх сэтгэл нь Түүнээс хол байлаа (Мт 15:8). Харин бидний хандлага чин сэтгэлийнх байх ёстой.

2. **Итгэлийн дүүрэн баталгаатай.** Бид Түүний оршихуйг нигүүлслээр хүлээн авна гэдэгтээ эргэлзэхгүй байж, Бурханы амлалтад бат итгэж, зоригтойгоор ойртох хэрэгтэй.

3. **Хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулж.** Энэ нь гагцхүү шинээр төрөх замаар л биелэх боломжтой. Бид Христэд итгэх үед Түүний цусны үнэ цэн биднийх болдог. *Зүйрлэвэл*, израильчууд Алгасал баярын хурганы цусыг хаалганы тотгондоо түрхсэнтэй адил бид зүрх сэтгэлдээ Христийн цусыг цацуулдаг. Энэ нь биднийг хилэнцэт мөс чанараас чөлөөлдөг. Улмаар бид ийнхүү гэрчилдэг.

Хэмжээлшгүй үнэтэй Өөрийнхөө цусаар Тэр
Хилэнцийг минь угааж бүрмөсөн цэвэрлэжээ
Бурханы нүдэнд биднийг гэмгүй болтол ариусгажээ
Буруутгал одоо мөс чанараас минь нэгэнт зайлан
оджээ

-Фрэнсис Беван

4. Биеэ ариун усаар угаалган. Ахин хэлэхэд энэ ч бас зүйрлэл юм. Энд **бие** гэдэг нь бидний амьдралыг төлөөлдөг. **Ариун ус** гэдэг нь зарим хүний хувьд Бурханы үгийг (Еф 5:25, 26), заримынх нь хувьд Ариун Сүнснийг (Иох 7:37-39), эс бөгөөс Ариун Сүнс үгийг ашиглан биднийг өдөр тутмын бузраас цэвэрлэх үйл явцыг илэрхийлж байж болно. Бид Христийн үхлээр нүглийн буруутгалаас нэг удаа бүрмөсөн цэвэрлэгдсэн боловч нүглийн бузарталтаас Бурханы үгээр дамжуулан Ариун Сүнсний хүчээр өдөр бүр ахин дахин цэвэрлэгдэх шаардлагатай (Иох 13:10-г үз).

Тиймээс Бурханы оршихуйд ойртоход шаардагдах дөрвөн үндсэн шаардлагыг чин сэтгэл, итгэл зориг, аврал, ариусгал хэмээн дүгнэн хэлж болно.

10:23 Хоёр дахь уриалга нь **найдвараа хүлээн зөвшөөрснөө гуйвалгүй бат баримтлах** явдал юм. Бидний цорын ганц **найдвар** Христ гэдгийг **хүлээн зөвшөөрсөн** бол ямар ч үед түүнээсээ няцаж болохгүй.

Христитгэлийн ирээдүйн, нүдэнд үл үзэгдэх ерөөлүүдээс няцаж, иудейзмын өнөөгийн харагдах зүйлсээр солиход уруу татагдаж буй хүнд **Амлагч нь итгэмжит** гэдгийг сануулж байна. Түүний амлалт хэзээ ч бүтэлгүйтэхгүй. Түүнд итгэдэг хүн хэзээ ч урам хугарахгүй. Аврагч амласанчлан ирнэ. Мөн Түүний хүмүүс Түүнтэй хамт байж, Тэд үүрд Түүнтэй адил болж, мөнх оршино.

10:24 Бид **хайр болон сайн үйлсээр** дүүрэн байхад нь итгэл нэгт ах дүүсээ урамшуулж зоригжуулахыг эрмэлзэх хэрэгтэй. Шинэ гэрээний утгаар **хайр** бол сэтгэл хөдлөл биш, харин хүслээрээ зориуд хийдэг үйлдэл юм. Бидэнд хайрлахыг тушаасан тул **хайрлах** нь бидний хийж чадах, бас хийх ёстой зүйл ажээ. **Хайр** бол үндэс, **сайн үйлс** бол үр жимс юм. Бид үлгэр дуурайл ба сургаалаараа бусад итгэгчдийг **бадрааж**, ийм амьдралаар амьдрах хүслийг нь өдөөх хэрэгтэй.

Хайрладаг зүрх бол цэцэрлэг

Хайрладаг бодол бол үндэс

Хайрладаг үгс бол цэцэгс

Сайн үйлс бол тэдний үр жимс мөн

-Өөрчлөн найруулсан хувилбар

10:25 Тиймээс бид үргэлж **хамтран цуглаж, зарим** хүмүүсийн үйлддэг шиг нутгийн чуулганы итгэгчдийн нөхөрлөлөөс өөрсдийгөө тусгаарлахгүй байхыг бидэнд уриалж байна. Үүнийг бүх итгэгчдэд хандсан, чуулгандаа тогтмол хамрагдахыг уриалсан ерөнхий уриалга гэж үзэж болно. Хамтдаа цуглан Бурханд хүндлэл мөргөл өргөж, үйлчлэх үед хүч тэнхээ, тайтгарал тайвшрал, сүнслэг хоол тэжээл, баяр баяслыг олдог нь гарцаагүй үнэн.

Мөн үүнийг хавчлагад өртсөн итгэгчдэд зориулсан онцгой уриалга гэж харж ч болно. Хавчлага дунд байгаа итгэгчид баривчилгаа, буруутгал, элдвийн зовлонгоос зайлсхийхийн тулд өөрийгөө тусгаарлаж, Христийг нууцаар дагах сонголтыг хийх нь бий.

Гэвч энэ эшлэлийн гол санаа нь үндсэндээ итгэлээс урвахын эсрэг сэрэмжлүүлэг юм. Энэ эшлэлд нутгийн чуулганыг орхих гэсэн нь христитгэлээс эргэж, иудейзм руу эргэж буцахыг хэлж байна. Еврей захидлыг бичиж байхад олон хүн ийм замыг сонгож байсан ажээ. Тиймээс

тэдэнд бие биеэ урамшуулж ятгах хэрэгцээ их байлаа. Ялангуяа Христ эргэж ирэхэд ойрхон байна гэдгийг байнга хэлж байх хэрэгтэй байв. Христ эргэн ирэх тэр үед хавчигдаж, дарлагдаж, үзэн ядагдсан итгэгчид ялагчийн талд байсныг бүгд харах болно. Тэр үеийг хүртэл бидэнд тууштай байдал зайлшгүй хэрэгтэй.

10:26 Одоо бичээч дөрөв дэх гашуун сануулгаа өгч байна. Өмнөх тохиолдлуудын нэгэн адил энд ч бас итгэлээс урвах явдлын эсрэг сэрэмжлүүлжээ. Энд үүнийг санаатай нүгэл хэмээн тодорхойлжээ.

Христитгэгчид энэхүү **нүглийн** жинхэнэ мөн чанарын талаар нэлээд санал зөрөлддөг талаар өмнө нь дурдсан. Товчхондоо, энэ бүхнийг дараах тохиолдлын аль нь вэ гэсэн асуулт гарч ирнэ. Үүнд:

1. Жинхэнэ итгэгчид байгаад хожим Христээс холдож авралаа алддаг хүмүүс

2. Жинхэнэ итгэгчид хэдий ч буруу замаар орсон, гэсэн ч авралаа хадгалж үлддэг хүмүүс

3. Хэсэг хугацаанд Христэд итгэгч гэж өөрийгөө нэрлэж, нутгийн чуулганд хамрагддаг ч эцэст нь Христийг санаатайгаар орхисон хүмүүс. Тэд анхнаасаа дахин төрөөгүй бөгөөд хэзээ ч дахин төрөх боломжгүй болсон хүмүүс.

Аль ч байр суурийг баримталсан бай тайлбарлахад хэцүү асуудлууд бүгдэд нь байдаг. Харин бидний хувьд гурав дахь тайлбарыг зөв гэж харж байна. Учир нь энэ нь Еврей ном болон Шинэ гэрээний үндсэн онол сургаалтай хамгийн сайн нийцдэг.

Энд, 26-р эшлэлд итгэлээс урвах явдлыг **үнэний мэдлэгийг хүлээн авсныхаа дараа** санаатайгаар **нүгэл үйлддэг** хүн гэж тодорхойлжээ. Тийм хүн Иудас шиг сайнмэдээг сонсож, авралын замыг мэдэж, хүлээн авсан мэт дүр үзүүлдэг ч дараа нь түүнийгээ санаатайгаар няцаадаг.

Тийм хүнд **нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй**. Тэрээр нэг удаа бүгдийн төлөө нэгмөсөн өргөсөн Христийн тахилаас санаатай, эрс шийдэмгий татгалзжээ. Тиймээс Бурхан түүнд санал болгох өөр аврал байхгүй.

Нэг талаар, бүх нүгэл санаатай үйлдэгддэг гэж хэлж болох ч бичээч энд итгэлээс урвахыг онц ноцтой, санаатай нүгэл гэж дүрсэлжээ.

Энэ хэсэгт бичээч **“бид”** гэсэн төлөөний үг ашигласан нь өөрийгөө заавал хамаатуулж байна гэсэн үг биш. 39-р эшлэлд тэрээр өөрийгөө болон итгэлийн ахан дүүсээ мөхөл рүү ухрах хүмүүсээс *ямар ч эргэлзээгүй* ялгаж салган ярьсан байна.

10:27 Итгэлээс урвагчийн хувьд **шүүлтийг айн чичирч хүлээхээс** өөр юу ч үлдэхгүй. Түүнд зугтах ямар ч найдвар байхгүй. Итгэлээс урвасан хүнийг дахин гэмшилд хүргэх боломжгүй (6:4). Тэрээр Христ доторх Бурханы нигүүлслээс өөрийгөө санаатайгаар бүрмөсөн таслав. Түүний хувь тавилан нь **эсэргүүцэгчдийг шатаах галын хилэн** билээ. Үүнийг шууд утгаар нь гал мөн эсэх дээр маргах нь ямар ч утгагүй. Ямартай ч энд хэрэглэсэн хэллэгийн дагуу тэд маш хүнд шийтгэл амсах нь тодорхой байна.

Бурхан итгэлээс урвагчдыг **эсэргүүцэгчид** гэдэг ангилалд оруулсныг анзаараарай. Тэд зүгээр төвийг сахидар бус, харин санаатайгаар Христийг эрс эсэргүүцдэг ажээ.

10:28 Одоо Хуучин гэрээнд дурдсан хууль зөрчигчийн мөхлөөр жишээ татаж, итгэлээс урвасан хүмүүст ногдох илүү хүнд шийтгэлийг ярих гэж байна. Шүтээн шүтэгч болж, **Мосегийн хуулийг** зөрчсөн хүний гэм буруу нь **хоёр буюу гурван гэрчтэйгээр** нотлогдвол **өршөөлгүй** цаазлуулдаг (Дх 17:2-6).

10:29 Итгэлээс урвагч хүн тэднээс **илүү хүнд шийтгэл эдэлбэл зохилтойд** тооцогдоно. Учир нь түүний хүртсэн боломж асар их байсан юм. Түүний нүглийн ноцтой байдал нь түүнд тулгасан дараах гурван ялаас тодорхой харагдана. Үүнд:

1. **Бурханы Хүүг уландаа гишгэсэн.** Тэрээр Есүсийн дагалдагч болно хэмээн зарлаж байсан атал дараа нь Христээс ил цагаан нүүр буруулж, Түүнтэй ямар ч хамаагүй гэдгээ мэдэгдэж байна. Тэрээр өөрт нь Аврагч хэрэггүй хэмээн үгүйсгэж, Есүс бол Эзэн гэдгийг бүрмөсөн няцааж байна.

Японд хавчлагын үеэр засгийн газраас ашиглаж байсан загалмай байдаг ажээ. Загалмайг газар тавихад хүн бүр цовдлогдсон Есүсийн нүүрэн дээр гишгэхийг шаарддаг байжээ. Үл итгэгчид Есүсийн нүүрэн дээр эргэлзэх зүйлгүй гишгээд гардаг байсан бол жинхэнэ итгэгчид энэ үйлдлийг хийхээс татгалзаж амь насаа алдсан гэдэг. Түүхэнд өгүүлсэнчлэн, Есүсийн царай хүмүүсийн хөлд талхлагдсаар авах юмгүй болсон гэдэг.

2. **Өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн тооцсон.** Тэрээр шинэ гэрээг баталсан Христийн **цусыг** хэрэггүй бузар юм мэт тооцжээ. Энэ **цус** түүнийг тусгаарлаж, аврагдах боломжийг нээж өгсөн. Христитгэгчидтэй нөхөрлөж, тэдний дунд байсан тул тэрээр ариусгагдсан мэт, үл итгэгч нөхөр нь итгэгч эхнэрээрээ ариусгагддагтай яг адил (1Ко 7:14) байсан юм. Гэвч тэр хүн аврагдсан гэсэн үг биш.

3. **Нигүүлслийн Сүнсийг доромжилсон.** Бурханы Сүнс түүнд сайнмэдээг ойлгуулж, нүглийнх нь талаар зэмлэж, цорын ганц хоргодох газар бол Христ гэдгийг зааж өгчээ. Гэтэл тэр нигүүлслийн **Сүнсийг доромжилж**, мөн Христийн санал болгосон авралыг бүхэлд нь үл тоомсорлож, дорд үзжээ.

10:30 Бурханы хайрт Хүүг санаатайгаар няцаах нь онц ноцтой нүгэл юм. Бурхан үүнд буруутай бүх хүнийг шүүх болно. Тэр **“Өшөө авалт нь Минийх. Хариуг нь Би өгнө”** гэж айлдсан (Дх 32:35-ийг үз). **Өшөө авалт** гэдэг энэ үг “өс санах”, хариугаа авах гэсэн утга илэрхийлдэггүй. Харин бүрэн төгс шударга ёсыг тогтоох гэсэн утгатай. Бурханд энэ үгийг хамаатуулах үед аливаа хүнд зохих ёсны хариуг нь өгөх гэсэн утгыг илэрхийлдэг. Бурханы зан чанарыг мэддэгийн хувьд Христ Өөрөө хэлсэнчлэн, итгэлээс урвагчдад шударгаар хариуг нь өгнө гэдэгт бид итгэлтэй байж болно.

Цааш нь, **“Эзэн Өөрийн хүмүүсийг шүүнэ”** гэжээ. Бурхан Өөрт нь хамаарах хүмүүсийг зайлшгүй өмгөөлж, зөвтгөнө. Харин энэ 30-р эшлэлд гарч буй илэрхий утга бол хорон муу хүмүүсийг шүүх тухай байна.

Хэрэв итгэлээс урвагчдыг Бурханы хүмүүс гэж хэлсэн нь таныг будилуулж байгаа бол итгэлээс урвагчид нь нэгт Бурханы бүтээл болохын хувьд, хоёрт хэсэг хугацаанд ч гэсэн хүлээн зөвшөөрснийхөө улмаас Бурханы хүмүүс гэж нэрлэгддэгийг санаарай. Бурхан тэдний Аврагч биш байж болох ч Бүтээгч нь мөн. Түүнчлэн, тэд нэгэн цагт Бурханыг хувьчлан таньж мэддэг мэт өөрсдийгөө Түүний ард түмэн хэмээн зарлаж байсан ч гэлээ Түүнийг хэзээ ч жинхэнэ утгаар нь таньж мэдээгүй хүмүүс билээ.

10:31 Бүх хүнд хамаарах мөнхийн сургамж бол Бурханы шийтгэлийг амсах хүмүүсийн тоонд орохгүй байх явдал билээ. Учир нь **амьд Бурханы гарт орох нь аймшигтай хэрэг.**

Бичвэрийн энэ хэсэг Христэд үнэхээр харьяалагддаг болсон хүмүүсийн сэтгэлийг чилээж, тогтворгүй болгох гэсэн зорилгогүй ээ. Харин Христийн нэрийг зөвхөн амаараа хүлээн зөвшөөрдөг хүмүүст Түүнээс нүүр буруулахын аймшигт үр дагаврыг сануулахын тулд ийм хурц өнгө аястай бичсэн билээ.

10:32 Аравдугаар бүлгийн үлдсэн эшлэлүүдэд бичээч, Христээс зуурсаар байх ёстой гурван чухал шалтгааныг эртний иудей гаралтай итгэгчдэд өгсөн байна. Үүнд:

1. **Урьдын** туршлага нь тэднийг өдөөх ёстой.
2. Шагнал ойрхон байгаа тул үүгээр урамших ёстой.
3. Бурханы дургүйцлээс эмээх нь тэднийг ухрахаас сэргийлнэ.

Юуны өмнө, өнгөрсөн туршлага нь тэднийг өдөөх ёстой. Тэд Христэд итгэснийхээ дараа ширүүн хавчлагын бай болцгоосон. Гэр бүл нь тэднээс нүүр буруулж, найз нөхөд нь орхиж, дайснууд нь мөрдөн мөшгөсөн. Гэвч энэ **зовлон** зүдүүр тэднийг мохоохын оронд итгэлийг нь улам батжуулсан. Тэд Түүний нэрийн төлөө гутаан доромжлогдож зовлон амсах нь зохистой гэж үзэх хэмжээний баяр хөөрийг мэдэрсэн нь лавтай (Үйл 5:41).

10:33 Заримдаа тэд ганц нэгээрээ зовлонтой нүүр тулна. Тэднийг ганцаар нь олны өмнө гарган доромжилж, тамлан зовоодог байв. Харин заримдаа тэд бусад итгэгчтэй хамт зовлон амсдаг байжээ.

10:34 Тэд Христийн төлөө хоригдсон хоригдлуудыг эргэж очихоос айгаагүй. Тэдний нэг гэж үзэгдэх нь аюултай байсан ч дагжин чичрээгүй юм.

Эрх мэдэлтнүүд эд **хөрөнгийг** нь дээрэмдэн тоноход ч нөхцөл байдлыг **баяр хөөртэйгөөр** хүлээн авч байв. Учир нь материаллаг эд баялгаа хадгалж үлдсэнээс Есүст үнэнч байх нь дээр гэж үзжээ. Тэд “мөхөшгүй, бузартаагүй, алга болчихгүй өв” байгааг мэдэж байлаа (1Пт 1:4). Дэлхийн баялгийг үл тоож чадах хүчийг өгсөн нь Бурханы нигүүлслийн гайхамшиг яах аргагүй мөн.

10:35 Хоёр дахь чухал шалтгаан бол **шагнал** ойрхон байгааг харж урамших явдал билээ. Өнгөрсөн хугацаанд ихийг тэвчсэн атлаа одоо бууж өгч болохгүй. Бичээчийн дүгнэж хэлэх гэсэн санаа нь, “Нулимс дуслуулан байж тарьсан ургацаа заавал хурааж аваарай” (Ф. Б. Мэйер)

гэсэн нь болно. Одоо тэд урьд урьдынхаас илүү Бурханы амлалтын биелэлд ойртон очжээ. Одоо ухрах цаг биш.

“Одоо итгэлээ бүү хаягтун. Энэ итгэл чинь ирэх ертөнцөд асар их шагналтай.”

10:36 Тэдэнд **хэрэгтэй** байсан зүйл бол **тэвчээр** юм. Өөрөөр хэлбэл, Христийг үгүйсгэн зугтаахын оронд хавчлага дунд зовлонгоос зугталгүй итгэлээ сахиж үлдэх шийдэмгий чанар билээ. Ийнхүү **Бурханы хүслийг биелүүлснээр амлагдсан** шагналыг хүлээн авах болно.

10:37 Ирээдүйн тэр шагнал Эзэн Есүс Христийн эргэн ирэхтэй салшгүй холбоотой. Тиймээс Хабаккук 2:3 эшлэлээс эш татан, **“Учир нь айсуй Нэгэн тун удалгүй ирнэ. Эс саатна”** гэжээ. Хабаккук номд энэ эшлэлийг арай өөрөөр, “Үзэгдэл нь тогтоогдсон цагийн төлөө юм. Төгсгөл уруугаа энэ нь яарах агаад эс хөсөрдөнө. Хоцорч байгаа боловч үүнийг хүлээгтүн. Хойшлолгүй заавал биелэгдэх болно” гэдэг.

Энэ өөрчлөлтийн талаар Винсент дараах тайлбарыг хийсэн байдаг:

Еврей эх дээрээ өгүүлбэрийн утга санаа нь халдеичуудын мөхлийг харуулсан үзэгдэл заавал биелэх тухай байдаг... Хожим Септуагинтад хөрвүүлэхдээ Иехова эсвэл Мессиагаас өөр аргагүй болж тийнхүү илэрхийлсэн байдаг. Энэ эшлэлийг хожуу үеийн иудей теологичид Мессиаатай холбон тайлбарлажээ. Манай бичээч ч мөн адил ийнхүү тайлбарлан хэрэглэжээ.¹⁵

А. Ж. Поллок харин ингэж тайлбарлажээ:

Хуучин гэрээний хэсэг болон түүнийг Шинэ гэрээнд өөрчлөн эш татсан хэлбэр нь хоёулаа Ариун Сүнсний амьсгалаар бичигдсэн үгс бөгөөд адилхан л Бурханы үг

мөн. ТЭР (саармаг хүйс) гэж Хабаккукийн хэрэглэсэн төлөөний үг үзэгдлийг зааж, Христ хаанчлахаар ирнэ гэдгийг илэрхийлдэг. Харин энэ төлөөний үг Еврей номд ТЭР (эр хүйс) болж, дээш өргөгдөх буюу Шүүрэлтийг зааж байна.

Бичээч цааш нь илүү ерөнхий утгаар ингэж хэлсэн байдаг.

Бурханы амьсгалаар бичсэн бичээч, Хуучин гэрээнээс эш татахдаа тухайн эшлэлийг хам сэдвээс нь гажуулахгүйгээр, Ариун Сүнсний бодол санаанд нийцүүлэн хэрэглэжээ. Гэхдээ хэзээ ч эх утгатай нь зөрчилддөггүй. Харин ихэнхдээ Шинэ гэрээг бүрэн дүүрэн илэрхийлэх утгыг дамжуулахын тулд Хуучин гэрээний утгыг яг адилхан давталгүй гүн утгыг нь гаргадаг... Бурханаас өөр хэн ч Библийн үгэнд ингэж хандах эрхгүй. Библийн үгийг ингэж ашигласан тохиолдол нэлээдгүй байгаа нь тухайн ном Бурханы амьсгалаар бичигдсэнийг харуулах нэг нотолгоо юм. Бурхан бол Библийн жинхэнэ Зохиогч. Тэр Өөрийнхөө үгээс эш татахдаа Өөрийнхөө зорилгод нийцүүлэн өөрчлөн найруулах эрхтэй. Харин хүн бид Библиэс эш татахаар бол үг нэмж хасах вий хэмээн болгоомжлох нь зөв. Библийн үгийг өчүүхэн төдий ч өөрчлөх эрх бидэнд байхгүй. Библийн Зохиогчид бол тийм эрх бий. Мосе, Исаиа, Паул, Матай, Иохан гэх мэт, хэнийг Тэр ашиглан үгээ бичүүлэх нь тийм ч чухал биш. Харин Библийн бүх хэсэг Бурханы бичвэр гэдэг нь л чухал.¹⁶

10:38 Тэвчээртэйгээр замаа дуусгахыг ятгасан сүүлийн ятгалга бол Бурханы дургүйцлээс эмээх эмээхүй билээ. Бичээч маань Хабаккукийн номоос үргэлжлүүлэн эш татахдаа Бурханы таалдаг амьдрал нь итгэлийн амьдрал юм шүү гэдгийг харуулж байна. **“Зөвт хүн итгэлээр амьдарна.”** Итгэлийн амьдрал гэдэг нь Бурханы амлалтыг

барин, үл үзэгдэх зүйлсийг итгэлээр харж, эцэс хүртэл тэвчдэг амьдрал билээ.

Нөгөөтээгүүр, Бурхан таалдаггүй амьдрал бол Мессиаг няцааж, сүмийн үр ашиггүй хуучин тахилын тогтолцоо руу эргэдэг хүний амьдрал юм. **“Хэрэв тэр ухрах аваас сэтгэл минь түүнийг эс таална.”**

10:39 Бичээч өөрийгөө болон бусад итгэгчдийг **сүйрэл уруу ухрагсдаас** шуудхан зааглаж байна. Нэг ёсондоо, итгэлээс урвагчдыг жинхэнэ итгэгчдээс ялгаж өгч байгаа хэрэг. Итгэлээс урвагчид буцаж **ухардаг**, харин жинхэнэ итгэгчид **итгэж**, үл итгэгчдийн хувь тавилангаас гэтэлгэж, **амийг хадгалдаг**.

Бичээч итгэлийг дурдсанаар Бурханы таалалд нийцдэг амьдралын талаар илүү дэлгэрэнгүй ярих суурийг бэлтгэлээ. Тиймээс олон сайхан жишээ бүхий арван нэгдүгээр бүлэг итгэлийн амьдралын талаар үргэлжлүүлэн өгүүлсэн нь зүйн хэрэг аж.

Б. Хуучин гэрээний жишээнүүдээр итгэлээ батжуулах ятгалга (11-р бүлэг)

11:1 Энэ бүлэг итгэлийн алсын хараа ба тэсвэр хатуужлын талаар өгүүлдэг. Тэнд бид зуун хувь сүнслэг хараатай, итгэлээ үгүйсгэлгүй асар их гутамшиг, зовлонг тэвчсэн Хуучин гэрээний хүмүүсийн жишээг ярина.

Нэгдүгээр эшлэл бол үнэндээ итгэлийн албан ёсны тодорхойлолт гэхээс илүүтэй **итгэл** бидэнд юу *хийж* өгдөг тухай тайлбарласан дүрслэл юм. Итгэл нь найддаг зүйлсийг нэгэнт болоод өнгөрсөн мэт **бодит** болгож, үл үзэгдэх сүнслэг ерөөлийг гарцаагүй үнэн гэдгийг харуулах **баталгааг** өгдөг. Өөрөөр хэлбэл, итгэл нь ирээдүйг одоо руу авчирч, үл үзэгдэхийг үзэгдэх зүйл болгодог.

Итгэл гэдэг нь Бурханы итгэмжит чанарт найддаг. Энэ нь Бурханы хэлсэн бүхнийг үнэн гэж хүлээн зөвшөөрч, амласан амлалт нь заавал биелнэ гэж итгэх итгэл билээ.

Итгэл нь заавал Бурханаас ирсэн ямар нэг илчлэл, амлалт дээр суурилах ёстой. Итгэл гэхээр харанхуйд тэмтчин явахыг хэлэхгүй. Харин орчлон ертөнц дээрх хамгийн баттай нотолгоог шаардаж, түүнийгээ Бурханы үгээс олдог. Итгэл нь гагцхүү боломжоор хязгаарлагддаггүй. Харин боломжгүй мэт санагдах тэрхүү орон зайг эзлэн авдаг. Хэн нэгэн нь ингэж хэлжээ. “Боломж дууссан газраас итгэл эхэлдэг. Хэрэв боломж байвал тэнд Бурхан алдаршдаггүй.”

Бат итгэл амлалтыг барьж
Бурханыг л зөвхөн түшдэг
Жинхэнэ итгэл боломжгүйн өөдөөс инээж
Заавал биелнэ гэж тунхагладаг

-Зохиогч нь тодорхойгүй

Итгэлийн амьдралд асуудал бэрхшээл тохиолдоно. Учир нь үнэхээр жинхэнэ эсэхийг шалгахад Бурхан бидний итгэлийг цэвэршүүлэх зууханд хайлуулж шалгадаг (1Пт 1:7). Гэвч Жорж Мюллерийн хэлсэнчлэн, “Бэрхшээлүүд бол жинхэнэ итгэлийн хоол тэжээл билээ”.

11:2 Итгэлээр алхаж, харагдах зүйлд бус Бурханд найдсан учраас Хуучин гэрээний эрхэм хүмүүс Бурханаас сайшаалыг хүртсэн юм. Энэ бүлгийн үлдсэн хэсэгт Бурхан тэдний талаар хэрхэн гэрчилснийг жишээ болгон өгүүлнэ.

11:3 Бүтээлийн тухай хөдөлшгүй баримтыг итгэлээр л харах боломжтой. Эхэнд Бурхан ганцаараа байсан. Тэгэхэд юу болсныг Бурхан бидэнд хэлж өгдөг. Бид Түүний үгэнд итгэснээр баттай ойлголттой болдог. Макги, “Материас өмнө оршин байсан Бурхан материйг үгээрээ биет оршигч болгосон нь бидний оюун ухаан, нотолж чадах цар

хүрээнээс давсан зүйл юм. Үүнийг зөвхөн итгэлээр л хүлээн авах боломжтой” гэж өгүүлсэн байдаг.

Бид итгэлээр ойлгодог. Энэ ертөнц, “Харвал итгэнэ” гэдэг. Харин Бурхан, “Итгэвэл харна” гэдэг. Есүс нэгэн удаа Мартад, “Хэрэв чи итгэвэл Бурханы алдрыг харна” гэж айлдсан шүү дээ (Иох 11:40). Элч Иохан, “Та нар... мэдээсэй гэсэндээ би... итгэдэг та нарт үүнийг бичлээ” гэж бичжээ (1Ио 5:13). Сүнслэг асуудлыг ойлгохын тулд эхлээд итгэл хэрэгтэй.

Бурханы үгээр ертөнц бүтээгдсэн. Бурхан үгээ айлдахад матери бодитоор орших болжээ. Матери үндсэндээ энерги гэдгийг сүүлийн үеийн шинжлэх ухааны судалгаа нээн илрүүлж байгаа нь үүнтэй нийцэж байна. Бурхан үгээ айлдахад дууны долгион хэлбэрээр энерги ялгарч, матери болж хувирснаар дэлхий ертөнц оршин тогтнож эхэлжээ.

Харагдах зүйлс нь үзэгдэх зүйлсээс бий болгогдоогүй. Энерги харагддаггүй. Атом, молекул, хий ч хүний нүдэнд үл үзэгдэнэ. Харин тэдгээр нь нийлэхээрээ бидний нүдэнд харагдах бодит ертөнц болдог.

Еврей 11:3 эшлэлд бүтээлийн тухай энэхүү баримт нь няцааж боломгүй үнэн юм. Үүнээс илүү тайлбар өөр хаана ч байхгүй, цаашид ч гарахгүй биз ээ.

11:4 Итгэлийн баатруудын жагсаалтаас Адам, Ева хоёрыг хасжээ. Учир нь Бурхан ба Сатан хоёрын хэн нь үнэн хэлж байгааг сонгох мөчид Ева Сатаныг сонгосон юм. Гэхдээ хожим нь тэд итгэлээр аврагдаагүй гэсэн үг биш. Тэдэнд амьтны арьсаар дээл хийж өмсгөсөн нь авралын бэлгэдэл байлаа.

Нүгэлт хүн зөвхөн цус урсгасны үндсэн дээр Бурханд ойртох боломжтой гэдгийг **Абел** олж мэдсэн нь харагддаг. Магадгүй эцэг эх нь амьтны арьсан дээл өмссөний дараа л Бурхантай харилцах харилцаагаа сэргээснийг хараад энэ үнэнийг тэр мэдсэн байж болох юм (Эх 3:21). Ямартай ч

тэр тахилын цустай Бурханы өмнө очсон нь итгэлийг нь харуулдаг. Харин Каины өргөл цусгүй үр тариа байсан юм. Абел итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдах үнэнийг төлөөлдөг бол Каин өөрийн сайн үйлсээр аврагдах гэсэн хоосон оролдлогыг төлөөлдөг.

“Бурхан Абелыг сайн учраас зөвд тооцсон бус, харин итгэлээр авчирсан тахил нь түүнийг зөвд тооцуулах шалтгаан болжээ” гэж Жорж Катинг онцолсон байдаг. Энэ зарчим бидэнд ч мөн адил үйлчилнэ. Бид өөрсдийн гавьяа зүтгэл, сайн үйлсээр бус, зөвхөн Христийн тахилын үнэ цэнийг хүлээн авснаараа зөвтгөгддөг.

Абелын амийг Каин хөнөөсөн нь хууль нигүүлслийг үзэн яддаг гэдгийг харуулдаг. Өөрийгөө зөвтгөдөг хүн өөрийгөө аврах чадалгүй, харин Бурханы өршөөл хайрд өөрийгөө даатгах ёстой гэсэн үнэнийг жигшдэг.

Гэхдээ Абелын гэрчлэл үүгээр дууссангүй. Абел итгэлээр ярьсаар байна. Итгэл нь тухайн хүний бие булшинд орсон ч дуу хоолойгоо сонсгосоор байдаг. Итгэл үүнийг боломжтой болгодог.

11:5 Енох амьдралынхаа аль нэг цаг үед үхэхгүйгээр тэнгэр рүү явна гэсэн амлалтыг Бурханаас авчээ. Енохоос өмнө хүн бүр эрт орой хэзээ нэгэн цагт нас барсаар байлаа. Енохоос өмнө үхлийг үзэлгүй дээш аваачигдсан өөр хүний тухай тэмдэглэл байгаагүй. Гэвч Бурхан амласан, харин Енох итгэсэн. Итгэх нь Енохын хийж чадах хамгийн ухаалаг, зөв үйлдэл байлаа. Учир нь бүтээл нь Бүтээгчдээ итгэхээс илүү эрүүл ухаан гэж юу байх билээ?

Итгэсэнчлэн яг тийнхүү бүтжээ. Енох үл үзэгдэх Бурхантай хамт гурван зуун жилийн турш алхаад (Эх 5:21-24) өнө мөнх рүү орсон. **Тэр аваачигдахынхаа өмнө Бурханд таалагдсан гэсэн гэрчлэл хүлээн авчээ.** Итгэлийн амьдрал Бурханд үргэлж таалагддаг. Бурхан Өөрт нь итгэл найдвараа тавихад дуртай байдаг.

11:6 Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Ямар ч сайн үйлс **итгэлгүй** байдлыг орлож чадахгүй. Хүн бүгдийг хэлж, бүхнийг хийлээ ч эцэст нь Бурханд итгэхээс татгалзвал Түүнийг худалч хэмээн зарлаж буй хэрэг юм. “Бурханд итгэдэггүй нь Түүнийг худалч болгож байна.” (1Ио 5:10) Өөрийг нь худалч гэж байгаа хүмүүсийг Бурхан яаж таалах билээ?

Итгэл л Бурханд зохих хүндлэлийг өгч, хүнийг байх ёстой байранд нь тавьдаг цорын ганц зүйл юм. Ч. Х. Макинтош, “Итгэл нь Бурханыг дэндүү ихээр алдаршуулдаг. Учир нь бид өөрсдийнхөө нүдэнд бус, Бурханы мэлмийд итгэж буйгаа үүгээр харуулдаг” хэмээн бичжээ.

Итгэл нь Бурхан байдаг гэдэгт итгээд зогсохгүй **Өөрийг нь хайгчдад Тэр Шагнагч нь болдог гэдэгт ч итгэдэг.** Хүн итгэх аргагүй зүйл гэж Бурханд үгүй. Харин асуудал нь хүний хүсэл зоригт л оршдог.

11:7 Ноагийн итгэл нь Бурхан дэлхийг үерээр устгана гэсэн Бурханы сануулга дээр тулгуурлаж байв (Эх 6:17). Тухайн үед хүн төрөлхтний түүхэнд үер болсон тохиолдол байгаагүй. Үнэндээ бороо ч орж байгаагүй гэж үзэх үндэслэл бий (Эх 2:5, 6). Гэвч Ноа Бурханд итгэж, их уснаас алс хол байсан ч **бүхээг** барьжээ. Ноа олон хүний элэг доог болсон нь дамжиггүй. Гэвч Ноагийн итгэл шагналаа авсан юм. Ноагийн **гэр бүл** аврагдаж, түүний амьдрал ба гэрчлэл **дэлхийг яллаж**, Ноа өөрөө **итгэлийн** үндсэн дээр **зөвт байдлыг өвлөгч болжээ.**

Энэ захидлыг хүлээн авч уншсан, эрт цагийн иудей итгэгчдийн олонх нь зөв замаар явж байгаа юм бол яагаад христитгэгчид цөөнх байгаа юм бэ гэж боддог байсан биз ээ. Тэгвэл Хуучин гэрээний хуудаснууд дотроос Ноа ба гэрийнхэн нь нийлээд наймхан хүний л зөв байсан, үлдсэн дэлхийн бүх хүн ард мөхсөн гэдгийг сануулж байна.

11:8 **Абрахам** Бурханд дуудагдахаасаа өмнө халдеичуудын нутгийн Ур хотод амьдарч, шүтээн шүтдэг байсан бололтой. Бурхан түүнд үзэгдэн, нүүхийг тушаахад **итгэлийн дуулгавартай** байдлаар орон гэр, эх нутгаа орхин гарч, өөрийг нь ямар хувь тавилан хүлээж буйг ч **мэдэлгүй** явсан. Абрахамыг мунхаг алхам хийж байна хэмээн анд нөхөд нь зэмлэж байсан нь дамжиггүй. Гэвч түүний хандлага дараах шүлгийн үг шиг байлаа:

Мэдэхгүй ч гэсэн би явна
Мэдэх боломжтой ч би мэдье гэж эс бодно
Гэрэлд ганцаар алхсанаас
Харанхуйд Бурхантай явсан нь дээр
Ил харагдаж буйд ганцаар алхсанаас
Итгэл дотор Бурхантай явсан нь дээр
-Хэлен Эннис Кастерлайн

Итгэлийн алхам ихэнхдээ бусдад мунхаг харалган явдал шиг харагддаг. Гэвч Бурханыг жинхэнэ утгаар нь мэддэг хүн ирээдүйд юу хүлээж буйг мэдэхгүй ч нүдээ боолгосон мэт Бурханы удирдамжид итгэн тайван алхахад бэлэн байдаг.

11:9 Бурхан Канаан **нутгийг** Абрахамд амласан. Канаан нутаг үнэндээ түүний өмч байлаа. Гэвч тэр өөрийгөө оршуулах жижиг газрыг л тэндээс худалдан авчээ. Тэрээр барилга байшинд бус, **майханд** амьдрахдаа сэтгэл хангалуун байсан юм. Майхан нь түр суугч хүний шинж тэмдэг юм. Амьд ахуйдаа Абрахам **харийн нутагт буй мэт** Канаанд амьдарчээ.

Харийн нутагт түр суусан амьдралыг нь түүний хүү, ач хоёр нь дагажээ. Абрахамын бурханлаг амьдралын үлгэр жишээ тэдэнд ч гэсэн ул мөрөө үлдээжээ. Тиймдээ ч тэд **адилхан амлалтыг хамтран өвлөгчид** болов.

11:10 Абрахам үл хөдлөх хөрөнгөнд яагаад ингэж ач холбогдол өгөөгүй вэ? Учир нь, **Абрахам суурь бүхий хотыг хүлээж байсан юм. Түүнийг бүтээгч ба барилгачин нь Бурхан мөн.** Абрахам өнөөгийн материаллаг зүйлс дээр бус, мөнхийн юманд хараагаа тавьсан. Эх бичвэртээ **хот, суурь** гэсэн үгийн өмнө ялгац гишүүн (the) байдаг. Нэг ёсондоо, итгэлээ тавин байж хүлээх ганцхан **хот**, найдаж болох ганцхан **суурь** байдгийг үүгээр илтгэж байна.

Тэрхүү тэнгэрлэг хотын зохион бүтээгч ба **барилгачин нь Бурхан мөн.** Энэ хотод агаар усны бохирдол, ядуурал гуйланчлал зэрэг дэлхийн хотуудын өнгө төрхийг гутаадаг элдэв асуудлын аль нь ч байхгүй, жишиг хот билээ.

11:11 Итгэлээр Сара ер орчим насандаа гайхамшгаар **үртэй болох хүчийг авсан байна. Сара** хүүхэд төрүүлэх **нас бие хэтэрсэн** байсныг энд тодорхой хэлжээ. Гэсэн ч Бурхан түүнийг хүүхэдтэй болно гэж амласныг, Бурхан үгнээсээ буцдаггүйг тэр мэдэж байлаа. Бурхан амласнаа биелүүлдэг гэдэгт Сара бат итгэсэн.

11:12 Исаакийг төрөхөд Абрахам ерэн есөн настай байв. Хүний талаас нь харвал, Абрахам эцэг болох ямар ч боломжгүй байсан ч Бурхан түүнд тоо томшгүй үр хүүхэд амласан тул тэр нь ёсоор болох ёстой байв.

Исаакаар дамжуулан Абрахам махан биеийн тоо томшгүй олон үр удамтай болсон. Тэрээр еврей үндэстний эцэг болсон юм. Христээр дамжиж тэрээр бүх цаг үеийн жинхэнэ итгэгчдээс бүрдэх үй олон итгэлийн (сүнслэг) хүүхдүүдтэй болсон. **Тэнгисийн эргээрх элс** нь *газрын* үр удмыг нь, **тэнгэр дэх одод** нь *тэнгэрлэг* ард түмнийг төлөөлж байж магадгүй.

11:13 Эдгээр өвөг дээдэс **бүгд итгэл дотроо нас барсан билээ.** Тэд Бурханы **амлалтуудын** биеллийг амьд ахуйдаа хараагүй. Жишээ нь, Абрахам тоо томшгүй олон үр удмаа харж амжаагүй. Еврей үндэстэн ч мөн амлагдсан газрыг

бүхэлд нь эзэмшиж үзээгүй. Хуучин гэрээний ариун хүмүүс Мессиагийн амлалт биелэхийг нүдээрээ үзээгүй. Гэвч огторгуйн дуран мэт алсын хараа нь **амлалтуудыг** маш ойр байгаа мэт ойртуулан харж, биелсэн мэт сэтгэл догдлон угтсан мэтээр дүрслэгддэг.

Энэ дэлхий эцсийн гэр орон нь биш гэдгийг тэд ойлгосон тул газар дээр тав тух хайлгүй, **гаднынхан ба түр суурьшигчид** мэт амьдрахдаа сэтгэл хангалуун байлаа. Тэд газар дэлхийгээр дамжин өнгөрөхдөө дэлхийн жишгээр явахгүйг хичээцгээсэн. Зүрх нь Бурханы уулыг зорьсон тул тэд энэ дэлхийг түр суугчийн хувиар туулжээ (Дуу 84:5).

11:14 Ингэж тэд **эх нутаг хайж буйгаа** амьдралаараа **тодорхой** харуулсан. Итгэлийн далд ухамсар нь тэднийг эх нутаг руугаа тэмүүлэх зөн совинг суулгажээ. Энэ сэтгэлзүйг Канааны баяр баясгалан дүүргэж чадаагүй. Тэдний зүрх сэтгэлийг илүү сайхан нутаг байгаа гэх дуудлага үргэлж урагш хөтөлж байв.

11:15 Бичээч итгэлийн хүмүүсийг эх нутаг хайж байсан гэж хэлэхдээ төрсөн газраа эрэлхийлсэн гэдэг утгаар хэлээгүй. Хэрэв Абрахам төрөлх Месопотами нутгаа үгүйлсэн бол аль хэдийнээ очих боломж байлаа. Гэвч Месопотами нэгэнтээ түүний эх нутаг байхаа больжээ.

11:16 Тэдний хайсан эх нутаг бол тэнгэрлэг орон гэр юм. Израилийн ард түмэнд өгөгдсөн ихэнх амлалт энэ дэлхийн материаллаг ерөөлтэй холбоотой байсныг бодвол энэ үнэхээр сонирхолтой байдаг. Гэсэн ч тэдэнд тэнгэрлэг найдвар байсан агаад энэ найдварын улмаас тэд энэ ертөнцийг харийн орон гэж үзэж байлаа.

Ийнхүү түр суугчийн сэтэлгээтэй байх нь Бурханы таалалд онцгой нийцдэг. “Зүрх сэтгэл хийгээд хүртэх хувь нь тэнгэрт байдаг хүмүүсийн Бурхан гэж дуудагдахаас Бурхан ичээгүй юм” гэж Дарби бичсэн байдаг. **Тэр тэдэнд**

хот бэлджээ. Тэд ч тэндээс амралт, сэтгэл ханамж, төгс амгаланг олдог.

11:17 Одоо бүгдээрээ Абрахамын **итгэлийн** хамгийн том сорилтын талаар үзэж байна. Бурхан Абрахамд, цорын **ганц хүү Исаакаа** тахилын ширээн дээр өргөхийг тушаасан. Абрахам огтхон ч эргэлзэлгүй Бурханыг дуулгавартай дагаж, сэтгэлийнхээ хамгийн нандин эрдэнийг Бурханд өргөхөөр хөдөлсөн юм. Түүний хувьд асар их зөрчил тэмцэл дагуулсан үнэхээр хүнд шийдвэр байсан нь мэдээж шүү дээ, тийм үү? Бурхан түүнд тоо томшгүй ур удам амласан. Гэтэл Исаак түүний цорын **ганц хүү**, төрсөн хүү нь байлаа. Тэр үед Абрахам 117, Сара 108 настай байлаа.

11:18 Үй олон үр удамтай болох амлалт заавал **Исаакаар** дамжин биелэх ёстой. Гол асуудал нь Абрахам Исаакийн амийг хөнөөвөл Бурханы амлалт яаж биелэх вэ? Тэр үед Исаак дөнгөж арван долоон настай, гэрлээгүй байлаа.

11:19 Абрахам Бурханы амласныг мэдэж байсан. Энэ л хангалттай байлаа. Бурхан хүүгээ тахил болгон өргөхийг Абрахамаас шаардсан бол амлалтаа биелүүлэхийн тулд хүүг нь **үхэгсдээс хүртэл амилуулах чадалтай хэмээн Абрахам үзсэн.**

Абрахамын цаг үеийг хүртэл хэн нэг хүн үхлээс амилсан тохиолдол огт байгаагүй. Хүн төрөлхтний туршлага, баримт нотолгоо огт байсангүй. Энэ утгаараа үхлээс амилах гэдэг санааг анх Абрахам бодож олсон гэлтэй. Бурханы амлалтад итгэх итгэл нь Исаак үхлээс амилна гэдэг дүгнэлтэд түүнийг хүргэжээ.

Дүрслэлээр Абрахам Исаакийг **үхэгсдээс буцаан авсан юм.** Абрахам Исаакийг тахил болгон өргөнө гэдэгтээ огтхон ч эргэлзээгүй учраас Бурхан энэ шийдвэрийг нь үйлдсэнд тооцсон. Тийнхүү Абрахамын хүүг амьд үлдээжээ. Грант үүнийг маш оновчтой ийнхүү

илэрхийлжээ. “Тэр Өөрийнхөө Хүүг хэлтрүүлээгүй юм. Тэр Исаакийн оронд тахил болгох хуцыг бэлдэж өгөхөд Абрахамын ганц хүү нь эцгийнхээ зүрх сэтгэлд эргэн ирж, гэртээ харьсан билээ”.

Итгэлийн энэхүү гайхамшигт жишээг дуусгахын өмнө хоёр зүйлийг зайлшгүй дурдах хэрэгтэй. Нэгдүгээрт, Абрахам хүүгээ тахил болгохыг Бурхан хүсээгүй. Бурхан хүнээр тахил өргөхийг Өөрийн хүмүүст хэзээ ч заагаагүй. Тэрээр зөвхөн Абрахамын итгэлийг шалгаад жинхэнэ итгэл гэдгийг нь баталгаажуулж, тушаалаа цуцалсан.

Хоёрдугаарт, Абрахамд өгөгдсөн тоо томшгүй олон үр удамтай болно гэсэн амлалт зуун жилийн турш шалгагдсан юм. Абрахам далан таван настай байхдаа хүүтэй болно амлалтыг анх сонссон. Исаакийг төрөх хүртэл тэр хорин таван жил хүлээжээ. Абрахам Исаакийг Бурханд өргөхөөр Мориа ууланд аваачих үед Исаак арван долоон настай байсан. Исаак дөчин настайдаа гэрлэж, түүнээс хорин жилийн дараа хоёр ихэр хүүтэй болжээ. Абрахам 175 настайдаа нас барсан. Тэр үед түүний үр удам гэвэл далан таван настай нэг хүү, арван таван настай хоёр ач хүү л байлаа. Гэсэн ч Абрахам амьдралынхаа туршид “Бурханы амлалтын талаар үл итгэн тээнэгэлзэх бус, харин ч итгэлээр хүчирхэгжихдээ Бурханд алдрыг нь өргөж, амласнаа биелүүлэх чадвартайд нь бүрэн итгэж байлаа” (Ром 4:20, 21).

11:20 Дараагийн гурван эшлэлд бичигдсэн **Исаак, Иаков, Иосеф** нарын итгэл юугаараа тийм онцгой байсан гэдгийг барууны сэтгэхүйгээр ойлгох амаргүй. Жишээлбэл, **Исаак ирэх зүйлсийнх нь талаар Иаков, Есав нарыг ерөөснөөрөө итгэлийн баатруудын жагсаалтад оржээ. Үүнд онцгой зүйл юу байгаа юм бэ?**

Хүүхдүүдийг төрөхөөс өмнө Эзэн Ребекад, “Хөвгүүд чинь хоёр үндэстний өвөг дээдэс болж, том нь (Есав) багадаа (Иаков) үйлчилнэ” гэж айлдсан. Есав бол

Исаакийн хайртай хүү байсан бөгөөд ууган хүүгийн хувьд ааваасаа илүү хувийг авах нь зүй ёсны хэрэг байлаа. Гэтэл Ребека, Иаков нар хараа муутай Исаакийг мэхэлж, хамгийн сайн ерөөлийг Иаковт соёрхуулжээ. Исаак хуйвалдааныг мэдээд ихэд хилэгнэсэн ч том нь багадаа үйлчилнэ гэсэн Бурханы үгийг санаж, Есавт элэгтэй байсан ч Бурханы сонголтыг хүндлэхээр шийджээ. Иаковын сул дорой зан чанарыг Бурхан Өөрийн төлөвлөгөөндөө ашиглана гэдгийг тэр ухаарчээ.

11:21 Иаковын амьдралд гутамшигт хуудаснууд олон байсан ч тэр итгэлийн баатар цолыг хүртжээ. Нас явахын хэрээр түүний зан чанар төлөвшиж, төгсгөлөө яруу сайхнаар дуусгасан. **Иаков нь Иосефын хөвгүүд болох** Ефраим, Манассе хоёрыг **ерөөхдөө** гараа зөрүүлж тавьсан юм. Тийнхүү ууган хүүгийн ерөөлийг бага хүү Ефраим дээр нь буулгав. Иосеф үүнийг болиулах гэсэн ч ингэх нь Эзэний хүслийн дагуу гэдгийг Иаков хэлжээ. Иаковын махан биеийн хараа доройтсон ч сүнслэг хараа нь хурц байлаа. Иаков амьдралаа төгсгөхдөө **таягаа тулж Бурханд мөргөжээ**. Ч. Х. Макинтош түүний амьдралыг ийнхүү дүгнэн бичжээ.

Иаковын амьдралын сүүлчийн мөч нь урт адармаатай амьдралтай нь харьцуулахад тэс өөр, шуургатай үдийн дараах тогтуун тайван орой мэт амгалан тайван байжээ. Үүл манан, салхи шуурганаас болж халхлагдсан нар оройн тогтуунд тэнгэрийн баруун хаяанаас туяагаа тусган, гэрэлт маргаашийг илтгэх мэт байв. Нас өндөр болсон Иаковт ийн санагдаж байсан буй заа. Хууран мэхлэх, наймаацах, зохицуулах, төлөвлөх, амласнаасаа няцах, эргэж холбирсон зан, үл итгэлээс улбаатай айдас хүйдэс гэх мэт хүмүүний төрөлх чанарын хар бараан үүл замхран арилж, итгэлийн тогтуун тайван амьдрал эхлэв. Иаков тийнхүү гагцхүү Бурханы өгч чадах өндөр

байр суурь, ивээл ерөөл, Бурхантай нөхөрлөх нөхөрлөлийг эдлэх болов.¹⁷

11:22 Иосефийн итгэл ч мөн нас барж байхдаа хүчтэй байлаа. Израилийн хөвгүүдийг Египетээс чөлөөлнө гэсэн Бурханы амлалтад тэр итгэж, Египетээс гарах тэр үйл явдлыг аль хэдийнээ итгэлээрээ харжээ. Ингэж бат итгэсэн учраас **ясыг** нь Египетээс авч яваад Канаанд нутаглуулах зааврыг хөвгүүддээ үлдээсэн юм. “Иосеф биеэрээ Египетийн суу жавхлан дунд амьдарсан ч сэтгэлээрээ тэнд байсангүй. Харин ард түмнийхээ ирээдүйн яруу алдар, ивээл ерөөлтэй сэтгэлээ холбожээ” гэж Виллиям Линкольн бичсэн байдаг.¹⁸

11:23 Энэ эшлэлд Мосегийн биш, Мосегийн эцэг эхийн итгэлийг өгүүлж байна. Тэд хүүгийнхээ сайхныг харахдаа биеийнх нь сайхныг бус хувь тавиланг нь, тэр дундаа Бурханы онцгой ажлыг хийх нэгнийг харжээ. Тэд Бурханы зорилго төлөвлөгөөнд итгэсэн тул хааны зарлигаас ч айсангүй. Тиймээс хүүхдээ гурван сарын турш нуусан.

11:24 Итгэлээр Мосе агуу зүйлсээс татгалзав. Тэрээр Египетийн ордны тансаглалд умбаж, хүний хүсэж болох бүхнийг эзэмшиж байсан ч “олж авснаараа биш, хаяж орхисноороо амар амгаланг олдгийг” ухаарчээ (Ж. Грегорий Мантель).

Юуны өмнө, Мосе Египетийн алдар нэрээс татгалзсан. Тэрээр **Фараоны охины** өргөмөл хүү байсан тул Египетийн сурвалжит хүмүүсийн дунд баттай байр суурьтай, бүр цаашилбал Фараоны өв залгамжлагч болох ч боломжтой байлаа. Гэвч Бурханы сонгосон ард түмний нэг, илүү дээр удам угсаанаас гаралтай учраас Египетийн хааны удмын сурвалжит гаралтай хэвээр үлдэж чадаагүй юм. Мосе нас биед хүрээд сонголтоо хийжээ. Газар дэлхий дээр цөөн хэдэн жил алдар нэртэй явахын төлөө жинхэнэ

удам угсаагаа нуусангүй. Үүний үр дүнд юу болов? Египетийн хаадын булш бунхан дунд Мосегийн хөшөө дурсгал баригдаж үлдэхийн оронд Бурханы мөнхийн номд дурсгал нь үүрд бичигдэн үлджээ. Египетийн занданшуулсан шарил болж музейн үзмэр болохын оронд Бурханы хүн хэмээн алдаршжээ.

11:25 Хоёрдугаарт, тэр Египетийн **зугаанаас** татгалзсан. Биеийн тааламжаа хөөж амьдарснаас **Бурханы** зүдэрсэн ард түмний **хамт** даруухан байх нь түүний хувьд илүү байв. Фараоны ордонд жаргаж цэнгэн сууснаас өөрийнхөө ард түмний зовлонгоос хуваалцах нь түүний хувьд хавьгүй илүү үнэ цэнтэй байв.

11:26 Гуравдугаарт, Мосе **Египетийн эрдэнэсээс** татгалзсан. Итгэл түүнд Египетийн эрдэнэсийн санд хураагдсан их баялгийг өнө мөнхөөс харвал хэрэгцээгүй хог гэдгийг ухаарах ухаарлыг соёрхжээ. Хожим нь Мессиа **буруутгагдсаны** адил зовлонг нэгэн адил туулах замыг Мосе сонгосон. Түүний хувьд Бурханд үнэнч байх хийгээд Бурханы ард түмнийг хайрлах нь Фараоны бүх хөрөнгийг нийлүүлснээс ч илүү үнэ цэнтэй байлаа. Учир нь энэ эд баялаг хүнийг нь үхсэний дараа хэнд ч хэрэггүй болохыг тэр ойлгож байв.

11:27 Ингээд Мосе Египетийн хааны эрх мэдлээс татгалзав. Тэрээр **итгэлээр** зоригжиж, **хааны уур хилэнгээс айлгүй**, боолчлолын нутаг **Египетийг орхисон**. Нэг ёсондоо, энэ ертөнцийн улс төрийг таягдан хаясан эрс шулуун шийдвэр байлаа. Тэрээр Бурханаас асар их эмээсэн тул Фараоноос өчүүхэн ч эмээсэнгүй. Мосегийн нүдний өмнө “Ерөөлт бөгөөд цор ганц хэмжээлшгүй Эрхт, хаадын Хаан, эздийн Эзэн, ганцаараа үхэшгүй мөнхийг эзэмшигч, хүршгүй гэрэл дотор оршигч, ямар ч хүний хараагүй мөн харж чадахгүй Нэгэн, хүндэтгэл ба мөнх ноёрхлын эзэн” байлаа (1Тм 6:15, 16).

11:28 Эцэст нь, Мосе Египетийн *шашин шүтлэгээс* татгалзав. **Итгэлээр тэр, Алгаслыг сахиад цус цацахдаа** Египетийн шүтээн шүтлэгээс өөрийгөө бүрмөсөн тусгаарлаж, шашны тогтолцооны эсрэг зоригтой зогссон юм. Түүний хувьд аврал нь Нил мөрний уснаас бус, хурганы цусаар ирдэг ажээ. Энэ сонголтын үр дүнд, Израилийн **ууган хүүхдүүдийн** амь хэлтэрч, Египетийн ууган хүүхдүүд устгагчаар хөнөөгдөв.

11:29 Эхлээд **Улаан тэнгис** нь еврей дүрвэгсдэд сүйрэл мэт санагдаж байв. Дайсан араас нь мөшгөн хөөж, тэд гарцгүй урхинд орсон мэт байв. Гэвч тэд Бурханы үгийг дуулгавартай дагаж, урагш алхахад ус хуваагдаж, “ЭЗЭН шөнийн турш дорнын хүчит салхиар далайн усыг ухраасанд ус хуваагдаж, хуурай газар гарав.” (Гэт 14:21). **Египетчүүд** еврейчүүдийн араас ортол тэрэгний дугуй нь гацаж, ус буцаж ердийн хэвэндээ орж, Фараоны арми **живэв**. Ийнхүү Улаан тэнгис нь израилийн хувьд аврал, египетчүүдийн мөхөл болжээ.

11:30 Хана хэрмэн бэхлэлттэй **Иерихо** хот нь Канааныг эзлэн авах ажиллагааны эхний алхам байлаа. Ийм бат бэх цайзыг зөвхөн хүчирхэг армиар л эзлэн авах боломжтой. Гэхдээ итгэлийн арга барил өөр байдаг. Бурхан зорилгоо хэрэгжүүлэхдээ хүмүүст мунхаг харагддаг стратегийг ашигладаг. Тэрээр хотыг **долоон өдрийн турш** тойрохыг израильчуудад тушаав. Долоо дахь өдөр нь хотыг долоон удаа тойрон алхах ёстой байлаа. Тахилчид бүрээгээ чангаар үлээж, хүмүүс хашхирахад хэрэм нуран унах байв. Цэргийн мэргэжилтнүүд үүнийг бүтэшгүй арга гэх байсан биз ээ. Гэхдээ энэ арга үр дүнгээ өгсөн юм. “Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм” (2Ко 10:4).

11:31 Янхан эм Рахаб хэзээ Иеховад хүндлэн мөргөдөг болсныг бид мэдэхгүй. Ямартай ч тэр Иеховад итгэдэг болсон нь энд тодорхой байна. Тэр Канааны хуурамч

шашнаас татгалзаж, еврейчүүдийн Бурханыг сонгожээ. Туршуулууд гэрт нь ирэх үед түүний итгэл жинхэнэ утгаараа шалгагдсан байна. Эх нутаг, элгэн садандаа үнэнч байх уу эсвэл Эзэнд үнэнч байх уу гэдэг сонголт өмнө нь тулж иржээ. Хэдийгээр эх орноосоо урвах ёстой болсон ч тэрээр Эзэний талд зогсов. Рахаб **туршуулуудыг** гэртээ орогнуулснаараа гэр бүлийнхэнтэйгээ хамт аврагдсан бол дуулгаваргүй хөршүүд нь амиа алдацгаав.

11:32 Яг энэ мөчид бичээч нэгэн эргэцүүлэх асуулт асууж байна. **Би өөр юу ярих вэ?** Тэрээр Хуучин гэрээний цаг үед итгэл хийгээд тэвчээрийг харуулсан хүмүүсийн нэрсийг дарааллаар нь дурдан, хэлэх гэсэн санаагаа ойлгуулахын тулд дахиад хэдэн хүний тухай ярих ёстой вэ гэж асууж байна.

Жишээнүүд нь дууссан болохоор ингэсэн юм биш, харин цаг хугацаанд баригджээ. Хүн бүхний тухай дэлгэрэнгүй ярихад хэтэрхий их хугацаа шаардагдах тул бичээч нэмээд цөөн хэдэн хүний нэрийг дурдаад өнгөрөх нь хангалттай гэж үзсэн байна.

Эхлээд 32 мянган цэргээ 300 болтол нь цөөрүүлсэн **Гидеоныг** нэрлэв. Эхлээд айж хулчийсан цэргүүдийг гэрт нь буцааж, дараа нь хувийн тав тухаа тэргүүнд тавигсдыг явуулжээ. Эцэст нь эрс шийдсэн эрчүүд Гидеонтой хамт мидианы армийг бут цохисон юм.

Дараагийн жишээ бол **Барак** юм. Канаанчуудын эсрэг тулалдаанд Израилийг удирдахаар дуудагдахдаа Дебораг хамт явбал явна гэдэг нөхцөлийг тэр тавьсан юм. Зан чанарын хувьд аймхай хулчгар байсан ч Бурхан түүний дотроос жинхэнэ итгэлийг олж хараад түүнийг итгэлийн хүмүүсийн дунд нэрлэв.

Самсон сул дорой байдлын бас нэгэн тод жишээ билээ. Гэсэн хэдий ч залуу арсланг улаан гараараа алах, Ашкелон дахь гучин филистийг устгах, мянган филистийг илжигний эрүүний ясаар хөнөөх, Газагийн дааман хаалгыг өргөх,

Дагоны сүмийг нурааж, амьд ахуйдаа хөнөөснөөс ч илүү олон дайсныг үхэхдээ устгах итгэлийг Бурхан түүний дотроос олж харжээ.

Иефта хэдийгээр бутач хүүхэд байсан ч ард түмнээ аммончуудын савраас чөлөөлсөн билээ. Хүн итгэлтэй байж чадвал гарал үүсэл, орчин нөхцөлөөсөө үл хамаарч амьдралаа өөрчилж, Бурханы төлөө түүх бүтээх боломжтой гэдгийг Иефтагийн жишээ харуулдаг.

Давид итгэлээрээ Голиаттай тэмцэлдэж, Саулд хүнлэг ёсоор хандаж, Сионыг эзлэн авч, өөр олон ялгуусан үйлсийг бүтээсэн юм. Зохиосон дууллуудаас нь бид түүний залбирал, магтаал, эш үзүүллэгүүд тод илрэхийг хардаг.

Самуел бол Израилийн сүүлчийн шүүгч, эш үзүүлэгчдийн үеийн анхдагч билээ. Тэрбээр тахилчдын сүнслэг завхралын үед улс үндэстнийхээ төлөө зогссон Бурханы хүн байлаа. Тэрээр Израилийн түүхэн дэх хамгийн агуу удирдагчдын нэг байсан юм.

Энд Бурханы нэрийн өмнөөс яригчид, цэвэр мөс чанартай эрчүүд, худал ярьснаас үхсэн нь дээр гэж үзэгсэд, энэ дэлхий дээр хүн муутай явснаас тэнгэрийн улс руу сайн мөс чанартай очихыг сонгогсод гэх мэт нэр нь дурдагдаагүй боловч өөр олон эш үзүүлэгчид жагсаалтад зүй ёсоор бичигдэнэ.

11:33 Бичээч итгэлийн хүмүүсийг нэрлэж байснаа одоо тэдний үйл хэргийг ярьж эхэллээ.

Тэд **хаанчлалуудыг эзэлсэн**. Ийм үйлстэй хүмүүс гэвэл Иошуа, шүүгчид (тэд жинхэнэ цэргийн жанжид байлаа), Давид тэргүүтэн юм.

Тэд **зөвийг үйлдсэн**. Хэдий төгс биш ч Соломон, Аса, Иехошафат, Иоаш, Хезекиа, Иосиа гэх мэт хаад үнэн зөвөөр төр барьцгаасан.

Тэд **амлалтуудад хүрсэн**. Үүнийг нэг талаар, Бурхан тэдэнтэй гэрээ байгуулсан гэж ойлгож болно. Тухайлбал, Абрахам, Мосе, Давид, Соломон нартай Бурхан гэрээ

байгуулсан. Нөгөө талаар, үүнийг амлалтуудын биеллийг хүлээн авсан гэж ойлгож болно. Түүгээрээ Бурханы үг үнэн болохыг тэд харуулсан юм.

Тэд **арслангуудын амыг хаасан**. Үүний хамгийн тод жишээ бол Даниел (Дан 6:22) боловч Самсон (Шүү 14:5, 6), Давид (1См 17:34, 35) нарыг ч мартаж болохгүй.

11:34 Тэд галын хүчийг унтраасан. Догшин ширүүн галд хаягдсан гурван еврей залуу хиншүү хярвасны ч үнэргүй галаас гарч ирж байлаа (Дан 3:25). Тийнхүү тэд Бурханы үнэнч дагалдагч болохоо баталсан юм.

Тэд **илдний ирээс зайлсан**. Саулын мунхаг мугуйд дайралтаас Давид (1См 19:9, 10), Иезебелийн хорсол заналаас Елиа (1Ха 19:1-3), Сирийн хаанаас Елиша зугтсан (2Ха 6:15-19) юм.

Тэд **буурайгаас хүчирхэг болгогдсон**. Сул дорой шинж тэмдэг итгэлийн хүмүүсээс нэлээдгүй илэрдэг. Жишээлбэл, Ехүд солгой гартай байсан ч Моабын хааныг хөнөөсөн (Шүү 3:12-22). Иаел нь эмэгтэй хүн боловч Сисераг майхны гадсаар хороосон (Шүү 4:21). Гидеон мидианчуудыг буулгаж авахдаа хагархай шавар ваар ашигласан (Шүү 7:20). Самсон илжигний эрүүний ясаар 1000 филистийг алсан (Шүү 15:15). Бурхан хүчтэйг ичээхийн тулд ертөнцийн мөхсийг сонгодог (1Ко 1:27). Тэд энэ үнэнийг батлан харуулсан юм.

Тэд **дайн тулалдаанд зоригжсон**. Итгэлтэй хүн өөрт байхгүй хүчийг олж, өөрөөс нь хүчирхэг нэгнийг ч ялах зоригийг олдог.

Тэд **харийн дайчдыг буулган авсан**. Израилийн арми ихэнх тохиолдолд зэвсэглэл, хүн хүчээр дутуу хэр нь ялалт байгуулж, өстөн дайснаа самгардуулж, өрөөл бусдыг гайхшируулдаг байлаа.

11:35 Эмэгтэйчүүд өөрсдийн үхэгсдийг амилалаар буцаан авч байв. Зарефатын бэлэвсэн эхнэр (1Ха 17:22), шунем эмэгтэй (2Ха 4:34) бол үүний тод жишээ билээ.

Гэхдээ итгэл дандаа ийм ялгуусан байгаагүй. Итгэлд өөр нэг тал бий. Итгэлийн амьдралаар ийм ялгуусан үр дүнг амссан хүмүүсээс гадна маш их зовлон бэрхшээлийг туулсан хүмүүс ч байна. Бурхан хоёр дахь төрлийн хүмүүсийг өмнөх хүмүүсийн нэгэн адил өндрөөр үнэлдэг.

Эзэнд итгэснийхээ улмаас зарим нь хэрцгийгээр тамлуулж байв. Тэд Иеховаг үгүйсгэвэл чөлөөлөгдөх байсан. Гэвч энэ дэлхий дээр Бурханаас урвахын оронд үхэж, хожим нь тэнгэрийн яруу жавхланд амилсан нь дээр гэж тэд үзжээ. Маккабичуудын өдрүүдэд Антиохус Епифанес долоон хөвгүүнийг эхийнх нь хамт өөрсдийнх нь нүдний өмнө нэг нэгээр нь хороожээ. Тэд **илүү дээр амилалд хүрэхийн тулд чөлөөлөлтийг хүлээж авахаас** татгалзсан юм. Учир нь энэ бол зүгээр л газар дэлхий дээр үргэлжлүүлэн амьдарсаар байхаас ч илүү дээр зүйл билээ. Моррисон энэ тал дээр дараах тайлбарыг хийсэн байдаг. Үүнд:

Тэгэхээр энэ ч бас итгэлийн нэг үр дүн юм. Итгэл нь хүнийг заавал чөлөөлөгдөхөд хүргэнэ гэсэн үг биш, заримдаа чөлөөлөгдөх боломжийг санал болгох үед татгалзах эр зоригийг ч өгөх нь бий. Итгэлээр заримдаа хүлээн авах цаг мөч гэж байхад татгалзах байдлаар гэрчлэгдэх цаг үе ч бас байна. Итгэлээр хүлээж аваад чөлөөлөгдөх нь ч бий. Итгэлээр татгалзаж чөлөөлөгдөх нь ч байна. Тэд тарчилж, зовж зүдэрсэн ч чөлөөлөлтийг хүлээж авалгүй татгалзсан нь итгэмжит гэдгийнх нь баталгаа, тэмдэг байлаа . Заримдаа итгэлийн хамгийн хүчтэй нотолгоо нь илүү амар, хялбар замаас эрс шулуухан татгалзах явдал байдаг.¹⁹

11:36 Зарим нь доромжлогдон ташуурдуулж шоронд хоригдсон. Иеремиа гэхэд Бурханд итгэмжит байсныхаа төлөө зүсэн зүйлийн шийтгэл амссан (Иер 20:1-6, 37:15).

Иосеф ч нүгэл үйлдсэнээс зовлон эдлэх нь дээр гэж үзэн шоронд хоригдсон юм (Эх 39:20).

11:37 Тэд **чулуугаар шидүүлсэн**. Есүс нэгэн удаа хуулийн багш нар болон фарисайчуудад, “Танай өвөг дээдэс Зехариаг ариун газар ба тахилын ширээний хооронд чулуугаар чулуудаж алсан” гэж сануулсан байдаг (Мт 23:35).

Тэд **тас хөрөөдөгдсөн**. Хууч яриагаар Манассе хаан Исаиаг хөрөөдөж алсан гэдэг.

Тэд мөн **соригдсон**. Эзэнд итгэгчдийг шантраах, мохоох, нүгэлд унагаах, Эзэнийг үгүйсгэхэд хүргэх оролдлогыг энд хэлж байх шиг байна.

Тэд **илдэнд хөнөөгдсөн**. Эш үзүүлэгч Уриа Бурханы мэдээг Иехонаким хаанд итгэмжтэй тунхагласныхаа төлөө илдээр хороогдсон (Иер. 26:23). Гэхдээ энэ эшлэл ганц хүний үхлээс илүүтэй, хоморголон устгах явдлыг ярьж байна. Тухайлбал, маккабичуудын цаг үед итгэмжит иудейчүүдийг үй олноор нь хороосон түүх бий.

Тэд **хонь, ямааны арьс нөмрөн явж, хоосон тарчиг байн, зовж, ад үзэгджээ**. Мүүрхээд энэ талаар дараах тайлбарыг хийсэн байдаг. Үүнд:

Тэд Бурханыг үгүйсгэж, ертөнцийн худал хуурмагт итгэсэн бол торгонд хөлбөрч, тосонд умбаж, хаад ноёд мэт тансаг амьдрах боломжтой байлаа. Гэвч тэд энэ замыг сонгохын оронд хонь, ямааны арьс нөмрөн явжээ. Нэг ёсондоо, нядлуулах тавилантай хонь, ямааны хэмжээнд өөрсдийгөө оруулжээ.²⁰

Тэд ядуурал, гачигдал, хавчлага, зовлонг амссан.

11:38 Дэлхий тэднийг амьд явах эрхгүй хүмүүс мэт үзжээ. Гэвч Бурханы Сүнс үүнийг арай өөр талаас нь, **тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ** хэмээн өгүүлжээ.

Тэд цөл, уул, агуу болоод газрын гаваар тэнүүчлэн байлаа. Орон гэрээсээ хөөгдөж, гэр бүлээсээ хагацаж, мал амьтан шиг туугдаж, нийгмээс тусгаарлагдаж, халуун хүйтэнд гандаж, зовлон бэрхшээлийг туулсан ч тэд Эзэнээ үгүйсгээгүй.

11:39 Хуучин гэрээний эдгээр итгэлийн баатрууд Бурханаас гэрчлэлийг хүлээн авсан боловч **амлалтын** биеллийг хүлээн авахаасаа өмнө нас барцгаасан. Тэд өнө удаан хүлээсэн Мессиа ирэхийг харах хүртлээ амьдарч, үйлчлэлийнх нь ивээл ерөөлийг амсаж чадаагүй юм.

11:40 Учир нь Бурхан бидний төлөө илүү сайныг хадгалсан байжээ. **Тэд бидэнгүйгээр төгс болгогдох ёсгүй** байхаар Бурхан бүгдийг зохион байгуулжээ. Учир нь тэд нүглийн хувьд төгс тайвшралыг олоогүй. Мөн тэд биднийг Эзэнтэй уулзахаар агаар мандалд дээш өргөгдөх хүртэл тэнгэрт бүрэн төгс алдрын биетэй болох боломжгүй (1Тс 4:13-18). Хуучин гэрээний ариун хүмүүсийн сүнс Эзэний оршихуйд аль хэдийнээ төгс болсон (Евр 12:23) ч Эзэн хүмүүсийнхээ төлөө эргэн ирэх хүртэл тэдний бие үхэгсдээс амилахгүй. Тэр үед л тэд амиллын цог жавхлангийн төгс төгөлдрийг хүртэх болно.

Үүнийг арай өөр талаас нь илэрхийлбэл, Хуучин гэрээний итгэгчид бидэн шиг их аз завшааныг хүртээгүй гэсэн үг. Тэгсэн атал ямар ялгуусан амьдралаар амьдарсныг нь бодоод үзээрэй! Тэд ямар их зүйлийг тэвчиж туулсныг санаарай! Тэд загалмайн үхлээс өмнө амьдарч байсан. Харин бид загалмайн цог жавхлан дотор бүрэн дүүрэн амьдардаг. Гэтэл бидний амьдрал тэднийхтэй харьцуулахад ямар байна вэ? Энэ асуулт бол Еврей 11 дүгээр бүлгийн онцлон авч үзэх халуун сэдэв билээ.

В. Христийн дотор найдах ятгалга (12 дугаар бүлэг)

12:1 Еврей номыг хавчигдаж буй хүмүүст хандан бичсэн гэдгийг бид мэдэж байх хэрэгтэй. Тэд иудейзмыг

Христээр сольсныхоо төлөө хатуу эсэргүүцэлтэй тулгарсан. Тэд энэхүү зовлонгоо Бурханы шийтгэл хэмээн буруугаар ойлгосон байх аюул байв. Улмаар урам хугарч, бууж өгсөн байж магадгүй. Хамгийн ноцтой нь тэд иудейзмын зан үйл, сүмийн дэг жаяг руу буцаж эргэх уруу татлагад орох аюултай байлаа.

Тэдний амсаж буй зовлон дэндүү хэцүү гэж тэд бодох ёсгүй байлаа. Арван нэгдүгээр бүлэгт өгүүлсэн итгэлийн баатруудын ихэнх нь Эзэнд үнэнч байсныхаа төлөө яг ийм тэвчишгүй хүнд зовлонг амсаж байсан ч тэвчсэн тухай олон гэрчлэл бий. Тэд биднээс бага боломж завшааныг хүртсэн атал тийм их тэвчээр хатуужлыг гаргасан юм бол христитгэлээр дамжин ирсэн илүү сайн, агуу ерөөлүүдийг хүртсэн бид бүр ч илүү тэвчээртэй байх ёстой биш үү?

Хуучин гэрээний итгэлийн баатрууд биднийг **хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нар** билээ. Гэхдээ тэд дэлхий дээр болж байгаа үйл явдлыг дээрээс ажиглан харж байдаг гэсэн үг *биш*. Харин тэд итгэл ба тэвчээр дүүрэн амьдралаараа бидэнд гэрчилж, даган дуурайн дагах үлгэр жишээг үлдээсэн гэсэн утгатай.

Энэ эшлэл нэг асуултыг өөрийн эрхгүй төрүүлдэг. “Тэнгэрт буй ариун хүмүүс дэлхий дээр болж байгаа үйл явдлыг хардаг гэж үү?” Үүнийг баттай хэлж мэдэхгүй ч баттай хэлж чадах ганц зүйл бол нүгэлт хүн аврагдсаныг тэд мэддэг ажээ. “Би та нарт хэлье. Мөн үүний адил гэмших шаардлагагүй ерэн есөн зөвтөөс гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.” (Лк 15:7)

Христитгэлийн амьдрал бол сахилга бат, тэсвэр тэвчээр шаарддаг уралдаан юм. Тиймээс биднийг хойш татдаг ачаа дарамтаасаа салах хэрэгтэй. Ачаанууд гэм хортой зүйл биш боловч урагшлахад саад учруулж болно. Үүнд эд хөрөнгө, ойр дотнын харилцаа холбоо, тав тухыг хайрлах хайр, уян хатан бус байдал гэх мэт олон зүйлийг дурдаж болно.

Олимпын тэмцээнд тамирчин хүн идэж уух юм авч орж болохгүй гэсэн дүрэм байдаггүй ч гүйлтийн тамирчин олон юм барьж явбал уралдаандаа түрүүлэхгүй шүү дээ.

Бид мөн **амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавих** хэрэгтэй. Үүнд бүх төрлийн нүглийг хамруулан ойлгох хэрэгтэй. Тэр дундаа үл итгэлийн нүглийг авч үзэж болно. Бид Бурханы амлалтад бүрэн найдаж, итгэлийн амьдралд гарцаагүй ялна гэдэгтээ эргэлзэхгүйгээр итгэх ёстой.

Уралдаан маань амархан мэт, христитгэлийн амьдрал хялбар гэж санах хэрэггүй. Зүсэн бүрийн уруу татлага, сорилт бэрхшээлтэй тулгарахад тэвчээртэйгээр даван туулахад сэтгэлээ бэлтгэх хэрэгтэй.

12:2 Уралдаж байхдаа өмнө маань гүйгч Есүсээс харааг минь салгах бүхнийг таягдан хаяж, Есүс өөд хараагаа чиглүүлэх учиртай. А. Б. Бриус энэ талаар дараах тайлбарыг өгчээ:

Бусдаас тод ялгарч, онцгойрч харагдах Нэгэн бий. Тэр бол итгэлээр амьдрахын утга учрыг анх удаа төгс харуулсан Хүн юм. Тэрээр итгэлээр хожмын баяр баясгалан, яруу алдрыг тодоос тод харахдаа загалмайн гашуун зовлон ба айдсаа умартан тэвчиж, гутаамшгийг үл тоон, ичгүүрийг нүдээ анин өнгөрүүлсэн юм.²¹

Есүс итгэлийн амьдрал ямар байх ёстойг төгс харуулсан цорын ганц Хүн гэдэг утгаараа **итгэлийг Эхлүүлэгч** билээ. Өөрөөр хэлбэл, анхдагч, зам гаргагч юм.

Тэр бас **итгэлийг Төгсгөгч**. Есүс уралдааныг эхлүүлээд зогсохгүй, ялгууснаар дуусгажээ. Есүсийн хувьд уралдааны зам нь тэнгэрээс гараагаа эхэлж Бетлехем, тэгээд дараа нь Гетсемани, Голготыг дайран булшаар дамжиж, буцаад тэнгэрт барианд орсон юм. Тэр хэзээ ч эргэж няцаагүй. Харин аврагдсан хүмүүс бүгдээрээ Өөртэй

нь хамт мөнхийн жаргалд хамтдаа цуглах тэр яруу алдарт өдрийг ширтэн харж байсан юм. Энэхүү найдвар нь **гутамшгийг** үл тоон, зовлон хийгээд үхлийг давах хүчийг Түүнд өгчээ. Өнөөдөр тэр **Бурханы сэнтийн баруун гарт** заларч байна.

12:3 Одоо уралдааны дүрслэл нүглийн эсрэг тэмцэл болон өөрчлөгдлөө. Бидний зоригт Жанжин бол Эзэн Есүс билээ. **Нүгэлтнүүд** Эзэн Есүсийг эсэргүүцсэн шиг **тийм** их **эсэргүүцлийг тэвчсэн** хүн энэ дэлхийд өөр байхгүй. Хэрэв бид **сэтгэлээр унавал** Тэр юуг даван туулсныг бодох хэрэгтэй. Энэ үед бидний амсах зовлон Түүнийхтэй харьцуулшгүй өчүүхэн санагдах болно.

12:4 Бид **нүглийн эсрэг** тасралтгүй тэмцэх тулаан дунд байна. Гэхдээ бид **цус урсгах хүртлээ** (амиа алдталаа) **хараахан эсэргүүцээгүй байгаа**. *Харин Эзэн Есүс амиа алдсан.*

12:5 Одоо христитгэлийн хувьд зовлон гэж юу болохыг танилцуулж байна. Итгэгч хүний амьдралд хавчлага, уруу таталга, сорилт бэрхшээл, өвчин зовлон, уй гашуу яагаад ирдэг вэ? Эдгээр нь Бурханы уур хилэн, дургүйцлийн тэмдэг үү? Эсвэл санаандгүй тохиолддог хэрэг үү? Тэр бүхэнд бид яаж хандах ёстой вэ?

Бурхан хүүхдүүдээ илүү төлөвшүүлэхийн тулд заримдаа зовлон бэрхшээлийг ашигладаг гэж энэ эшлэлүүд сургаж байна. Хэдийгээр зовлон Бурханаас ирдэггүй ч Бурханы зөвшөөрлөөр тохиолддог. Бурхан тэдгээрийг Өөрийнхөө алдар суу, бидний сайн сайхан, бусдын ивээл ерөөлийн төлөө ашигладаг.

Христитгэгч хүнд аливаа зүйл тохиолдлын чанартай байдаггүй. Зовлон бэрхшээл нь үнэн хэрэгтээ далдлагдсан ивээл ерөөл байдаг. Мөн урам хугалам асуудлууд нь Бурханы тогтоосон цагт байдаг. Бурхан амьдралын сөрөг нөхцөл байдлаар дамжуулан биднийг Христийн дүр төрхтэй улам адил болгодог.

Тийм учраас анхан үеийн еврей итгэгчдэд Сургаалт үгс 3:11, 12-ыг сануулан ятгаж байна. Тэнд Бурхан тэднийг хөвгүүд хэмээн дууджээ. Мөн Өөрийнх нь сахилгажуулалтыг дорд үзэхгүй байхыг, зэмлэхэд нь шантрахгүй байхыг анхааруулсан байна. Хэрэв тэд тэрсэлж, бууж өгөх аваас Бурхан тэдний төлөө үйлдсэн бүхэн үр ашиггүй болж, сургамжийг нь олж авч чадахгүйд хүрнэ.

12:6 Сахилгажуулалт гэдгийг бид суран тэлээгээр ороолгох гэж ойлгодог. Гэвч энд хүүхдийг сургаж хүмүүжүүлэх тухай ярьж байна. Үүнд зааварлах, дасгалжуулах, залруулах, анхааруулан сэрэмжлүүлэх зэрэг нь багтдаг. Эд бүгдээрээ христитгэгч хүний дотроос муу муухайг зайлуулж, итгэлийн сайн чанарыг хөгжүүлэх зорилготой. Энэ эшлэлд сахилгажуулах гэдэг нь бурууг шийтгэх гэсэн үг биш, харин хавчлага зовлонгоор дамжуулан сургах гэсэн утгатай.

Сургаалт үгс номоос эш татсан хэсэгт Бурханы сахилгажуулалтыг хайрынх нь илэрхийлэл гэж мэдэгджээ. Бурханы хөвгүүд сахилгажуулалтаас нь зугтах боломжгүй гэжээ.

12:7 **Бурханы сахилгажуулалтад** дуулгавартай хандаж, тэвчсэнээр бид улам бүр Христтэй адил дүр төрхтэй болж хэлбэржинэ. Харин Бурханы сахилгажуулалтаас зайлсхийж, дөтлөх замыг хайвал Бурхан илүү урт хугацааны, илүү сургамжтай, улам хэцүү аргаар биднийг сургах хэрэгтэй болно. Бурханы сурган хүмүүжүүлэх ухаанд ч мөн анги дэвших үйл явц байдаг. Бид сурах ёстой хичээлээ гүйцэд сурахаас нааш дараагийн ангид дэвшдэггүй.

Тэгэхээр амьдралд сорилт бэрхшээл тулгарвал Бурхан бидэнд **хөвгүүд шигээ** хандаж байгааг ойлгох хэрэгтэй. Ердийн эцэг хүүгийн харилцаанд ч бас эцэг нь хүүгээ сургадаг. Учир нь эцэг нь хүүгээ хайрлаж, хамгийн сайн сайхныг хүсдэг учраас ингэдэг шүү дээ. Бурхан бидэнд

үнэхээр хайртай учраас биднийг өсөж хөгжөөсэй гэж хүссэндээ сахилгажуулдаг.

12:8 Сүнслэг талаас нь харвал Бурханы сахилгажуулалтыг хүртээгүй хүн бол Түүний жинхэнэ хүү биш, **бутагч** хүүхэд ажээ. Эцсийн эцэст, цэцэрлэгч хүн талбайнхаа хогийн ургамлыг арчилдаггүй, харин усан үзмийн модоо арчилдаг. Ердийн амьдралын энэ зарчим сүнслэг талбарт ч мөн адил хэрэгжинэ.

12:9 Бидний ихэнх нь **махбодын эцгүүдээсээ** сахилгажуулалтыг хүртсэн байдаг шүү дээ. Тэглээ гээд тэд биднийг үзэн ядаж байгаагийн илрэл гэж бид хүлээж авдаггүй шүү дээ. Харин ч тэд бидний сайн сайхны төлөө санаа тавьсандаа хийсэн гэж ухааран **тэднийг хүндэлдэг**.

Тэгвэл **сүнсний Эцэгийн** сурган хүмүүжүүлэх ухааныг бүр ч илүү хүндлэх ёстой бус уу? Бурхан бол сүнс хийгээд сүнслэг бүхний **Эцэг** (буюу Эх сурвалж) мөн. Хүн бол бие дотор нь сүнс оршдог бодгаль юм. Бурханд захирагдсанаараа бид амьдралыг жинхэнэ утгаар нь амталдаг.

12:10 Махан биеийн эцэг эхийн сахилгажуулалт төгс биш байдаг. Энэ нь **хэсэг зуур** буюу хүүхэд нас, өсвөр үед л үргэлжилдэг. Нэгэнт энэ үе өнгөрчихвөл хүүхдийг дахиж хүмүүжүүлэх аргагүй болдог. Эцэг эх маань зөв гэж бодсоноороо **бидний сайн сайхны төлөө сахилгажуулдаг**. Гэвч заримдаа тэдний буруу байх нь бий.

Тэгвэл Бурханы сахилгажуулалт үргэлж төгс байдаг. Бурханы хайр дуусашгүй, мэргэн ухаан нь яндашгүй. Бурхан хэзээ ч дур зоргоороо сахилгажуулдаггүй, үргэлж бидний ашиг тусын төлөө байдаг. Түүний зорилго бол **бид Түүний ариун чанарыг хуваалцагч** болох явдал билээ. Бурханы сурган хүмүүжүүлэх ухаанаас гадуур жинхэнэ бурханлаг зан чанарыг эзэмших боломжгүй. Жовет энэ талаар дараах тайлбарыг хэлсэн байдаг:

Бурханы сахилгажуулалт нь шийтгэх бус, босгон байгуулах зорилготой. Тэр биднийг Өөрийнхөө ариун чанарыг хуваалцагч болгохын тулд сахилгажуулдаг. Нэг ёсондоо, биднийг илүү ариун, зөв, сайхан амьдралаар амьдруулахыг зорьдог ажээ. Бурханы гал нь хяналтгүй дүрэлзэн эргэн тойрныхоо үнэт зүйлсийг шатааж устгадаг гал түймэр бус, харин цэвэршүүлэгчийн гал юм. Тэрээр галаа манаж, тэвчээртэй тайвнаар сул доройгоос хүчирхгийг, бузраас ариуныг тунгаан ялгадаг. Бурхан нигүүлслийн харанхуй хэрэгслийг ашигласан ч үргэлж босгон байгуулж, Ариун Сүнсний үр жимс, цэцэг навчийг ургуулж байдаг. Түүний хайр үргэлж гоо сайхныг эрэлхийлж байдаг.²²

12:11 Бүх сахилгажуулалт нь тухайн үедээ баяр хөөр бус, уй гашуу мэт санагдавч дараа нь түүгээр дасгалжсанд нь зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг гаргаж өгдөг. Тийм ч учраас зовлон үзсэн хүнээс хүчирхэг гэрчлэлүүд гарч ирдэг. Үүний нэгэн жишээ бол Лэсли Вээдэрхээд юм.

Хүн бүр эрүүл саруул, энх тунх, аз жаргалтай, амжилт дүүрэн, сайхан амьдрахыг хүсдэг. Би ч бас тэдний нэг л дээ. Гэхдээ айдас хүйдэс, алдаа дутагдал, зовлон бэрхшээл дунд би Бурханы тухай, амьдралын тухай, өөрийнхөө тухай илүү ихээр ухаарч ойлгосон. Нартай өдрүүдээс илүү харанхуй шөнө бидэнд ихийг сургадаг. Харанхуйд эрдэнэс нуугдсан байдаг. Гэхдээ Бурханд талархууштай нь харанхуй шөнө дуусдаг. Харин харанхуй шөнө сурч мэдсэн зүйлс хүнтэй үүрд хамт үлддэг. Бишоп Фенелоны хэлсэнчлэн Бурхантай харилцах харилцаанд саад болж байгаа мэт зовлон бэрхшээлийг даруугаар тэвчиж чадвал Бурхантай илүү

дотносох хэрэгсэл болдог. Биднийг дарангуйлж, бардам занг минь хугалж, мунхаглалаас ангижруулдаг зүйлс үнэн хэрэгтээ, биднийг зоригжуулдаг тааламжтай зүйлсээс илүү бидний амьдралд сайн сайхныг өгдөг ажээ.²³

Ч. Х. Спержоны гэрчлэлийг мөн авч үзье:

Тав тухтай, амар хялбар, аз жаргалтай үеүдэд олж авсан ивээл нигүүлсэл сохор зоосны ч үнэ цэнгүй гэж би айж байна. Гэтэл зовлон шаналлаасаа хүлээн авсан сайн сайхан юутай ч харьцуулшгүй үнэ цэнтэй байдаг. Намайг зовоосон алх хадаас, гал ус, салхи шуурганд би өртэй. Зовлон бол орон гэрийн минь хамгийн сайхан тавилга мөн.²⁴

12:12 Итгэгчид амьдралын хүнд хэцүү нөхцөл байдалд шантарч болохгүй. Учир нь итгэл нь суларвал бусдад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Тиймээс **сульдсан гараа тэнхрүүлж**, амьд Христэд үйлчилцгээе. **Салгалсан өвдгөө тэнхрүүлж** тууштай залбирцгаая.

12:13 **Доголон нь** Христийн дагалдагчийн шулуун **жимээр** алхахын тулд өөрсдийгөө дасгалжуулцгаая. Виллиямс ингэж бичжээ:

Эзэнийг бүрэн дуулгавартай дагагсад сул дорой ах дүүсийнхээ итгэлийн жимийг тэгшилж өгдөг бол бүрэн дуулгаваргүй хүмүүс бусдынхаа алхах жимийг бартаатай болгож, сүнслэг доголон хүмүүсийг бий болгодог.²⁵

Г. Х. Ланг энэ тухай маш сайхан дүрслэн харуулжээ:

Ядарч туйлдан, урт зам, шуурганд балбуулж цөхөрсөн аялагч гутранги байдалтай зогсоно. Толгой нь гудайж, гар нь унжиж, өвдөг нь салгалаад бууж өгч газар хөсөр унахад бэлэн болсон мэт санагдана. Манай бичээчийн дүрсэлснээр Бурханы замаар явж буй мөргөлчинд ч ийм зүйл тохиолдож болно.

Гэтэл итгэл дүүрэн ах дүүсийн нэг нь ирээд, нүүр дүүрэн инээмсэглэж, зоригтойгоор түүнд “Бос, дүү минь! Хүчтэй бай! Өвдгөө чангал! Зүрхээ зоригжуул! Чи урт замыг туулсан. Өнгөрсөн хөдөлмөрөө бүү үгүй хий. Сайхан гэр орон чинь замын төгсгөлд хүлээж байна. Замаасаа бүү хазай! Чигч шулуун алх! Доголон хөлөө Эмч Эзэнээсээ гуйж, эдгээлгэ. Урд минь Гүйгч энэ хатуу ширүүн замаар Бурханы өргөө рүү явж очсон. Өөр бусад нь ч бас энэ замаар алхаад зорьсондоо хүрсэн. Одоо ч гэсэн олон хүн энэ замаар алхаж байгаа. Чи ганцаараа биш. Зөвхөн тууштай бөгөөд зоригтой бай! Тэгвэл чи зорьсондоо хүрч шагналаа авах болно” гэж хэлбэл хэчнээн их итгэл төрж, зоригжих бол доо.

Эцэж ядарсан хүнд үгээр туслахыг мэддэг хүн ерөөлтэй еэ! (Иса 50:4) Сургамжийн үгийг хүлээж авдаг хүн ерөөлтэй еэ! (Евр 13:22) Эзэний сахилгажуулалт хатуу үед Эзэнээс болж бүдэрдэггүй, эгэл даруу, хүчтэй итгэлтэй хүн ерөөлтэй еэ!²⁶

12:14 Христитгэгчид **бүх хүнтэй** үргэлж **эвтэй** байхыг эрмэлзэх хэрэгтэй. Энэ ятгалгыг хавчлага ширүүссэн үед бүр ч илүү санах нь зүйтэй. Учир нь тийм үед олон хүний итгэл алдарч, хамгийн ойр дотнын хайртай хүмүүс рүүгээ муу муухай зан гаргахад бэлэн болдог.

Мөн бид **ариуслыг мөшгөх ёстой**. **Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй**. Энд ямар ариуслын тухай ярьж байна вэ? Энэ асуултад хариулахын тулд эхлээд Шинэ гэрээнд гурван төрлийн *ариуслын* тухай ярьдгийг санах нь зүйтэй.

Нэн тэргүүнд, итгэгч хүн дахин төрсөн өдрөөсөө эхлээд *байр суурийн* хувьд ариусаж, ариун болдог. Бурхан түүнийг өөрийн болгож энэ ертөнцөөс тусгаарладаг (1Ко 1:2; 6:11). Христтэй нэгдсэний улмаас тэр хүн үүрд ариуссанд тооцогддог. “Ариун байдал минь тэнгэрт бий” гэж хэлсэн Мартин Лютерийн үг ийм учиртай. Христ бол бидний ариун байдал юм. Өөрөөр хэлбэл, Бурханы өмнөх бидний байр суурь Христ дотор байгаа цагт ариун гэж тооцогддог.

Удаах нь *бодит* ариусал (1Тс 4:3; 5:23) юм. Бид өдөр бүр ариун байх хэрэгтэй. Бид өдөр тутмын амьдралдаа элдвийн ёр муугаас өөрсдийгөө тусгаарлаж явах учиртай. Энэхүү ариун байдал тасралтгүй өсөн нэмэгддэг байх ёстой. Өөрөөр хэлбэл, бид цаг ямагт Эзэн Есүстэй адил болж төлөвших учиртай.

Эцэст нь *бүрэн төгс* ариусгал гэж бий. Энэ ариусгал тэнгэрт очсоны дараа биелнэ. Тэр үед бид нүглээс үүрд чөлөөлөгдөнө. Нүгэлт мөн чанар маань үүрд арилж, жинхэнэ утгаараа байр сууриндаа нийцсэн байдалд очно.

Тэгвэл энэ эшлэлд ямар **ариуслыг** ярьж байна вэ? Бид аль ариусгалыг нь **мөшгөх** ёстой юм бэ? Бодит ариусгал гэдэг нь тодорхой байна. Байр суурийн ариусгалыг мөшгөх шаардлага байхгүй. Учир нь бид дахин төрөх үедээ энэ ариуслыг шууд хүлээн авсан. Мөн төгс ариусгалыг бид мөшгөдөггүй. Үүнийг бид Түүнийг нүүр нүүрээрээ харах үедээ хүлээн авна. Харин байнга өсөн нэмэгдэж байдаг бодит ариусгалд дуулгавартай байдал, хамтын ажиллагаа хэрэгтэй болдог. Бид энэ ариусгалыг цаг үргэлж мөшгөсөөр байх ёстой. Мөшгөсөөр байх ёстой гэдгээс нь харахад л бид энэ амьдралдаа бүрэн төгс ариусгалд хүрдэггүй нь илэрхий байна. (Ариусгалын төрлүүдийн талаар 2:11-т дэлгэрэнгүй өгүүлснийг үзээрэй).

Вэст ингэж бичжээ:

Ариун амьдралыг баримталж, шинээр олсон итгэлдээ зохистой алхах энэхүү уриалгыг Иерусалимын сүмийг орхисон, дахин төрсөн иудейчүүдэд хандаж хэлсэн. Тэгснээр гадна талдаа Шинэ гэрээний сургаалыг хүлээн авсан мэт харагдаж буй аврагдаагүй иудейчүүд Левийн тогтолцооны хүчингүй болсон тахилууд руу буцаж очилгүй, Тэргүүн Тахилч болох Мессиад итгэх итгэлээ улам лавшруулах урам зоригийг авах юм. Христитгэлийн амьдралаар дутуу дулимаг алхвал аврагдаагүй иудейчүүд хуучин руугаа эргэж буцах сэдэлтэй болно шүү гэдгийг эргэлт буцалтгүй дахин төрсөн иудейчүүдэд сэрэмжлүүлжээ.²⁷

Гэсэн ч ойлгоход төвөгтэй асуудал байсаар л байна! Бодит ариусгал байхгүй бол бид Эзэнийг харж чадахгүй юм гэж үү? Тийм ээ, зарим талаараа энэ үг үнэн. Гэхдээ ариун амьдарснаараа л Бурханыг харах эрхтэй болно гэж бүү буруу ойлгоорой. Тэнгэрт орох цорын ганц тасалбар бол Есүс Христ Өөрөө билээ. Энэ эшлэлийн хэлэх гэсэн санаа нь мөнх амьтай болсны баталгаа нь бодит ариусал хэлбэрээр илэрнэ гэжээ. Хүн улам бүр ариун болж өсөхгүй бол аврагдаагүй гэсэн үг юм. Ариун Сүнс хүний дотор оршин суувал Түүний оршихуй муу муухайгаас тухайн хүнийг тусгаарлах байдлаар илэрдэг. Христийг хүлээн авсан л бол амийн ус урсаж гарах нь гарцаагүй гэсэн учир шалтгааны зүй тогтол бий.

12:15 Дараагийн хоёр эшлэлд зайлсхийж явах ёстой дөрвөн нүглийг танилцуулж байгаа мэт байдаг. Гэвч хам сэдвээс нь ажиглавал итгэлээс урвах гэдэг ганц нүглийг сэрэмжлүүлсэн мэт харагдахаас гадна энд дурдсан дөрвөн нүгэл бүгдээрээ итгэлээс урвахтай холбоотой байдаг.

Нэгт, итгэлээс урвах нь **Бурханы нигүүлслийг** олж аваагүйн илрэл билээ. Тийм хүн христитгэгч мэт харагдаж, христитгэгч хүн мэт ярьж, христитгэгч гэж өөрийгөө хэлж

болно. Гэвч хэзээ ч дахин төрөөгүй байдаг. Тэрээр Аврагчид нэлээн ойртож ирсэн боловч Түүнийг хэзээ ч хүлээж аваагүй байдаг. Маш ойртсон ч дэндүү хол байдаг.

Итгэлээс урвах нь **гашуун үндэс** юм. Тийм хүн Эзэнд хорсож, христитгэлийг үгүйсгэдэг. Ийнхүү урвах нь халдварладаг шинж чанартай. Түүний гомдол, эргэлзээ, үгүйсгэлээс болж бусад хүн ч бас **бузарлагддаг**.

12:16 Итгэлээс урвах нь ёс бус байдалтай салшгүй холбоотой байдаг. Өөрийгөө итгэгч гэж хэлдэг хүн ёс суртахууны хувьд гүн гүнзгий нүгэлд автаж болзошгүй. Харамсалтай нь буруугаа хүлээн зөвшөөрөхийн оронд Эзэнийг үгүйсгэж, итгэлээ хаядаг. Итгэлээс урвахыг 2Петр 2:10, 14, 18, Иуда 8, 16, 18 дээр садар самууны нүгэлтэй холбосон байдаг.

Эцэст нь хэлэхэд, итгэлээс урвахыг **Есавын** жишээгээр тайлбарладаг бөгөөд нэгэн төрлийн сүсэггүй явдал ажээ. **Есав ууган хүүгийн эрхээ** үнэн сэтгэлээсээ хайрлаж, талархалтай хандаагүй. Тиймдээ ч хоромхон зуурын хоолны дуршлаар түүнийгээ дуртайяа арилжжээ.

12:17 Хожим нь Есав, хоёр дахин илүү хувь авах ууган хүүгийн эрхээ алдсандаа харамссан. Гэвч аав нь ерөөлийг буцаах боломжгүй болж, хэтэрхий оройтсон байлаа.

Итгэлээс урвагч хүн ч бас үүнээс ялгаагүй. Тэр сүнслэг зүйлсийг үнэн сэтгэлээсээ эрхэмлэдэггүй. Тиймдээ ч буруутгал, зовлон, үхлээс зайлсхийхийн тулд сайн дураараа Христийг үгүйсгэдэг. Түүнд шинэчлэгдэж, гэмших боломж байхгүй. Харуусаж болох ч бурханлаг гэмшил хэзээ ч байдаггүй.

12:18 Хууль руу эргэхээр санаархаж буй хүмүүс хууль өгөгдөх үеийн тэр аймшигт нөхцөл байдлыг санаж, түүнээс сүнслэг сургамж авах хэрэгтэй. Тэрхүү үйл явдал бодит, гар хүрч болох Синаи уулд өрнөсөн бөгөөд уул тэр чигтээ **галд** автсан байлаа. Уулыг бүхэлд нь үүл манан бүрхэж,

харанхуй нөмөрч бүрхэг бүүдгэр байлаа. Эргэн тойронд нь хүчит **салхи** хуйларч байжээ.

12:19 Байгалийн гамшигт үзэгдлээс гадна ер бусын аймшигт зүйлс ч болж байв. Чанга **бүрээ** дуугарч, аянгын нүргээн мэт **дуу** хадаж, үнэхээр сүрдмээр байсан тул ард түмэн уг үйл явдлыг болиулахыг хүссэн юм.

12:20 Тэгсэн атал тэд **“амьтан ч гэсэн ууланд хүрэх аваас түүн уруу үхтэл нь чулуу шидэгтүн”** гэсэн тэнгэрийн зарлигийг үл тоов. Ухаангүй мал амьтан хүртэл ууланд хүрвэл үхэх ялтай байсан юм бол сэрэмжлүүлгийг ойлгох чадвартай ухаант хүнд энэ зарлиг бүр ч илүү хүчин төгөлдөр байх бус уу?

12:21 Энэ бүх үзэгдэл үнэхээр **аймшигтай байсан тул Мосе** өөрөө ч **айдаст автжээ**. Энэ бүхэн хуулийн мөн чанар хийгээд үйл хэргийн талаар тод томруун өгүүлдэг. Хууль нь Бурханы зөвт шаардлага, нүглийн эсрэг Түүний уур хилэнг илэрхийлдэг. Хууль нь авралын мэдлэг өгөхөд бус, нүглийн мэдлэгийг өгөх зорилготой. Нүглийн улмаас Бурхан, хүн хоёрын дунд ямар том ангал үүссэнийг хууль тунхагладаг. Энэ нь буруутгал, ял зэм, харанхуй, үүл манангийн үйлчлэл билээ.

12:22 Харин итгэгчид Синаи уулын аймшигт нөхцөл байдал руу ирээгүй. Тэд нигүүлслийн урилга руу ирсэн юм:

Асаж дүрэлзсэн уул, бэлгэдлийн хөшиг
Айдас хүйдэс, буруутгалтай хамт арилав
Сэтгэлд минь амар амгаланг үлдээсэн
Сэв толбогүй Хурга, өндөр сэнтийд залрав
-Жэймс Г. Дэк

Цусаар солигдсон Бурханы хүүхэд бүхэн эдүгээ энэ үгийг хэлж чадна:

Бурханы хуулийн шийтгэлийн айдас
Бүрмөсөн миний хэрэг биш болжээ.

Аврагчийн минь дуулгавар ба цус
Ар нуруундаа бүх нүглийг минь хаяжээ.

-А. М. Топлади

“Эдүгээ бид үүрд мөнх бүрэн дүүрэн эдлэх зүйлдээ аль хэдийн хүрчээ. Ирээдүй аль хэдийнээ биелжээ. Өнөөдөр бид маргаашийг эзэмшиж байна. Газар дээр бид тэнгэрийн зүйлсийг эзэмшиж байна.” (эш татсан)

Бид газар дээрх бодит уул руу ирээгүй. Харин тэнгэр дэх ариун газар руу нэвтрэх эрхтэй болсон. Итгэлээр бид Бурханд ойртож, нүглээ улайж, магтаал залбирлаар Түүнд ханддаг. Бид жилд нэг удаа биш, харин хүссэн үедээ ариунаас ариун газарт нэвтрэх боломжтой. Учир нь Бурхан биднийг үргэлж хүлээн авна гэдэг мэдлэг бидэнд бий. Бурхан одоо “хол зогс” гэж хэлэхгүй. Харин “Зоригтойгоор ойртон ир” гэж дууддаг.

Хуульд Синаи уул байдаг бол итгэлд **Сион уул** бий. Энэхүү тэнгэрлэг уул нь нигүүлслийн бүх ерөөлийг бэлгэддэг. Уг ерөөлүүд нь Есүс Христийн золилтын ажлаар дамжуулан бидэнд өгөгдсөн бүхнийг илтгэдэг.

Хуульд газар дээрх Иерусалим байдаг бол итгэлд **тэнгэрлэг хот** байдаг. Энэ бол **Амьд Бурханы** хот бөгөөд тэнгэрт байх бат суурьтай. Уг хотын Барилгачин нь Бурхан мөн.

Биднийг Бурханы оршихуй руу орох үед сүр жавхлант үй түмнээр хүрээлүүлдэг. Юун түрүүнд, биднийг **үй түмэн тэнгэрэлч нар** хүрээлнэ. Тэд нүглийг мэдэхгүй боловч авралын баяр баяслыг туулж үзээгүй тул “авралын баяр хөөрийн” дууг хамт дуулж чадахгүй.

12:23 Мөн бид **тэнгэрт бүртгэгдсэн анх төрөгсдийн чуулганаар** хүрээлүүлдэг. Тэд бол Пентэкостын өдрөөс хойш Эзэн дотор нас барж, одоо Эзэний оршихуйд амар амгаланд орсон Христийн бие болох **Чуулганы** эрхтнүүд билээ. Тэд булшин дахь бие нь амилуулагдаж, сүнстэйгээ нэгдэн алдаршуулагдах өдрийг хүлээж байна.

Мөн бид **бүгдийн Шүүгч Бурхан** руу ойртон ирдэг. Одоо цаашид харанхуй ба үүл манан Түүнийг халхлахгүй. Түүний яруу алдар нь итгэлийн мэлмийд тодоос тод харагдана.

Түүнчлэн тэнд Хуучин гэрээний ариун хүмүүс буюу **төгс болгогдсон зөвт хүмүүсийн сүнс** байна. Итгэлээр зөвтгөгдсөн тэдний хувьд Христийн үйл хэрэг тооцогдсон учир одоо өө сэв, толбогүйгээр зогсож байна. Тэд ч бас эртний булш бунхнаас бие нь гарч ирж амилж, алдрын биеийг өмсөх цагийг хүлээж байна.

12:24 Тэнд мөн **шинэ гэрээний Зууч Есүс** байгаа. Хуучин гэрээний зууч Мосе, **шинэ гэрээний Зууч Есүс** нарын хооронд асар их ялгаа бий. Мосе бол Бурханаас хуулийг хүлээн авч, Израилийн ард түмэнд дамжуулж өгснөөрөө зуучлагчийн үүрэг гүйцэтгэсэн. Тэрээр ард түмнийг төлөөлж гэрээг баталгаажуулахын төлөө тахил өргөдөг байсан.

Тэгвэл Христ түүнээс агуу шалтгаанаар **шинэ гэрээний Зууч** болжээ. Бурхан энэхүү гэрээг зөвт шударгаар байгуулахын тулд Эзэн Есүс үхэх ёстой байлаа. Есүс цусаараа уг гэрээг тамгалж, олны төлөө Өөрийгөө өгчээ (1Тм 2:6).

Эзэн Есүс шинэ гэрээний ерөөлүүдийг Өөрийнхөө үхлээр дамжуулан хүмүүст баталгаажуулж өгсөн юм. Мөн мөнх амиараа дамжуулан энэ ерөөлүүдийг хадгалж өгдөг. Түүнчлэн, Бурханы баруун гарт залран үйлчилж буй үйлчлэлээрээ дамжуулан дайсагнагч энэ ертөнцөд уг ерөөлийг хүртэх боломжийг хүмүүстээ олгож, тэднийг хамгаалж байна. Энэ бүхэн Түүний зуучлалын үйлчлэлд хамаарна.

Эзэн Есүс Голготын толгод дээрх шарх сорвитойгоо Бурханы баруун гарт Эзэн ба Аврагчийн хувиар заларч байна.

Түүний сонгосон, нядлагдсан Хурга
Тэнгэрт заларсныг харах дуртай бид
Түүний ариун хүмүүс алдрыг нь хуваалцаж
Тэргүүн ба Эзэнтэйгээ үүрд хаанчилна.

-Жэймс Г. Дэк

Эцэст нь, **Абелынхаас илүү дээр, ярьдаг, цацагдсан цус** байгаа. Христ тэнгэрт өргөгдөхдөө загалмай дээр урсгасан цусныхаа үнэ цэнийг бүхэлд нь Бурханд өргөжээ. Тэрээр тэнгэр рүү цусаа бодитоор барьж орсон гэсэн үг биш. Харин цусных нь үнэ цэн, ач гавьяа нь тэнгэрийн ариун газарт тунхаглагдсан гэсэн санаа юм. Энэ үнэнийг Ж. Г. Дэк ийнхүү шүлэглэн илэрхийлсэн байна:

Христийн нандин цус цацагдсан
Хилэнц нүглийн асуудал дууссан
Бие дэх шарх нь тэнгэрт зарласан
Биднийг аврах ажил бүрэн төгссөн

Христийн үнэт **цусыг Абелын** цустай харьцуулав. Абелын цус гэхээр өргөсөн тахилынх нь цусыг хэлж байна уу, Каинд алдагдах үедээ урсгасан өөрийнх нь цусыг хэлж байна уу? Аль ч утгаар нь ойлгох боломжтой. Аль ч тохиолдолд Христийн цус илүү их нигүүлслийг өгүүлдэг нь үнэн. Абелын тахилын цус “Түр зуур халхаллаа” гэдэг бол Христийн цус “Үүрд уучиллаа” гэж тунхагладаг. Абелын цус “Өшөө авалт” гэж хашхирдаг бол Христийн цус “Өршөөл, уучлал, энх тайван” гэж хашхирдаг.

12:25 Арван хоёрдугаар бүлгийн төгсгөлийн хэсэгт Синаи уулан дээр илэрхийлэгдсэн Бурханы илчлэлийг Христийн дотор өгөгдсөн илчлэлтэй харьцуулжээ. Христитгэлээр дамжин ирдэг эрх мэдэл, алдар сууг үл ойшоож, хөнгөн хандаж болохгүй. Бурхан өнөөдөр ч үгээ

айлдаж, биднийг урин дуудаж байна. Түүнийг **үл хэрэгсэх** нь мөхөлд хүргэнэ.

Хуулийн дотор цуурайтсан Бурханы дуу хоолойг үл ойшоосон хүмүүс зохих шийтгэлээ хүртсэн. Мөн илүү их эрх мэдэл, боломж өгөгдөх тусам үүрэг хариуцлага ч нэмэгддэг. Христ дотор Бурхан хамгийн агуу, эцсийн илчлэлээ өгсөн юм. Эдүгээ сайнмэдээгээр дамжуулан **тэнгэрээс** ярьж буй Бурханы дуу хоолойг үл ойшоосон хүмүүс хуулийг зөрчигчдөөс ч илүү хүнд хариуцлага хүлээнэ. Авралын энэ замаас зугтах ямар ч боломж байхгүй.

12:26 Синаи ууланд Бурханы дуу хоолой газар хөдлөлт үүсгэсэн. Харин ирээдүйд энэ дуу хоолой “тэнгэрийг ч бас донсолгоно.” Үүнийг эш үзүүлэгч Хаггаи (2:6) зөгнөж хэлсэн байдаг. “Тун удахгүй Би дахин нэг удаа тэнгэр ба газар, далай ба хуурай газрыг сэгсэрнэ.”

Энэхүү сэгсрэлт нь Шүүрэлтийн үеэс эхэлж Христийн хаанчлалын төгсгөл хүртэл бүрэн утгаараа биелнэ. Христ хаанчлалаа байгуулахаар ирэхээс өмнө газар, тэнгэрт байгалийн гамшигт үзэгдлүүд тохиолдоно. Гараг эрхсүүд тойрог замаасаа гарч, далай тэнгист асар хүчтэй давллагаанууд үүснэ. Тэгээд дараа нь Христийн хаанчлалын төгсгөлд дэлхий хийгээд сансар огторгуй тэр чигтээ халуун галаар устгагдана (2Пт 3:10-12).

12:27 Бурхан “**дахиж нэг удаа**” гэж айлдахдаа тэнгэр газрыг бүрмөсөн, эцсийн байдлаар **зайлуулахыг** зөгнөсөн. Энэ нь бидний харж, барьж, мэдэрдэг зүйлс л бодит, харин үл үзэгдэх зүйлс бодит биш гэсэн хуурамч төсөөллийг үндсээр нь няцаана. Бурхан сэгсрэх, зайлуулах үйл явдлыг дуусгах үед жинхэнэ бодит зүйлс л **үлдэх** болно.

12:28 Гарт баригдаж нүдэнд харагддаг иудейзмын зан үйлээс зуурдаг хүмүүс ганхах зүйлсэд түшиглэж байна. Харин жинхэнэ итгэгчдэд **үл ганхах хаанчлал** бий. Үүнийг ойлговол бидний мөргөл хүндлэл гал халуун болно.

Бид Түүнд **хүндлэл, айдас бүхий** магтаалыг тасралтгүй өргөх учиртай.

12:29 Бурханыг сонсохоос татгалзагч бүхэнд **Бурхан шатаах гал мөн.** Бурханы хүмүүст ч мөн адил Бурханы ариун байдал, зөв шударга чанар нь туйлаас эмээн хүндлэх шалтгаан байх учиртай.

Г. Христитгэгч хүнд нийцэх сүнслэг, сайн чанаруудын тухай ятгалга (13:1-17)

13:1 Одоо Еврей номын амьдралд ойр сургамжийн хэсэг нь бидний хөгжүүлэх ёстой зургаан зан чанарын тухай уриалгаар үргэлжилнэ. Нэн тэргүүнд, **ах дүүсийн хайрыг** уриалж байна. Жинхэнэ итгэгчид хоорондоо гэр бүлийн харилцаатай байж, хайрын үг ба үйлсээрээ энэ дотно холбоогоо харуулж байх ёстой (1Ио 3:18).

13:2 Хоёрдугаарт, **гаднынханд зочломтгой хандах** талаар уриалж байна. Гаднынхан гэж хавчлагаас зугтаж, хоол хүнс, толгой хоргодох газар олохгүй яваа итгэгчдийг нэн түрүүнд хэлсэн байж болох юм. Тэднийг хүлээн авч, хэрэгцээг нь хангаж өгсөн хүн өөрсдөө аюулд өртөж болзошгүй байсан ч тэднийг хүлээн авахыг уриалж байна. Энэ нь ерөнхийдөө тусламж хэрэгтэй байгаа итгэгчдэд зочломтгой хандахыг хэлж байна.

Ингэж зочломтгой хандах үедээ бид **тэнгэрэлчүүдэд мэдэлгүйгээр** үйлчлэхийг үгүйсгэх аргагүй! Үүнийг бодохоор гурван танихгүй хүнийг зочилсон Абрахамын түүх өөрийн эрхгүй санагддаг (Эх 18:1-15). Үнэндээ тэр гурван хүн Эзэний тэнгэрэлч нар байжээ.²⁸ Үнэндээ тэнгэрэлчүүдэд биш байлаа ч Бурханы хүмүүст үйлчилснээрээ бид мөнхийн мөнхөд үр дүнгээ өгөх ивээл ерөөл, бурханлаг нөлөөг тэднээс авч болох юм.

13:3 Гурав дахь уриалга бол шоронд хоригдсон итгэгчдийг анхаарах тухай юм. Энэ нь бараг л Христийг

гэрчилснийхээ төлөө хоригдсон хүмүүсийг хэлж байна. Тэдэнд хоол хүнс, дулаан хувцас, унших ном, урам зориг хэрэгтэй байв. Харин бусад итгэгчид **хоригдогсдоос** зайгаа барьснаар хамсаатан болох буруутгалаас зайлсхийхийг бодож байсан байж болох юм. Гэвч тэд хоригдсон нэгнийг эргэхдээ Христийг Өөрийг нь эргэсэнтэй адил гэдгийг **санах** хэрэгтэй.

Мөн **ад үзэгдэгсдийг** энэрч өрөвдөх хэрэгтэй. Дахин хэлэхэд, энд ч бас хавчигдсан итгэгчдийг хэлж байна. Тэдэнд тусалснаараа өөрсдийгөө аюулд оруулж магадгүй ч үүнээс болгоомжлон биеэ оторлох ёсгүй. Мэдээж энэ эшлэлийн утгыг ерөнхийд нь авч үзвэл зовлонд унасан бүх ариун хүмүүст хайр энэрлийг үзүүлэх ёстой гэж бодох хэрэгтэй. Бид **ч гэсэн бие дотор байгаа тул** хэзээ нэгэн цагт ижилхэн зовлонд унахыг үгүйсгэх аргагүй шүү дээ.

13:4 Одоо **гэрлэлтийг бүгд хүндлэх** тухай уриалж байна. Гэрлэлтийг дэлхийд нүгэл орж ирэхээс өмнө Бурхан тогтоосон юм. Тиймээс гэрлэлт бол хүн төрөлхтөнд зориулсан Бурханы ариун хүслийн илэрхийлэл мөн. Гэрлэлтийг бузар гэж үзэж цээрлэх, зарим итгэгчид шиг тоглоом шоглоом болгох нь Бичээст хориглосон.

Гэрлэсэн хүмүүс ам тангарагтаа үнэнч байж, гэрлэлтийн **ор дэрээ** бузарлахгүй байх ёстой. Орчин үеийн хүмүүс энэ талбарт хэт хайнга ханддаг ч гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа нүгэл гэдэг үнэн хэвээрээ л байгаа. Завхайрал бол өвчин биш нүгэл юм. Мөн энэ нүгэл Бурханы шийтгэлийг заавал амсдаг. Бурхан садар самууныг энэ амьдралд нь шийтгэх нь бий. Тухайлбал, өвчин тусах, гэр бүлийн харилцаа муудах, сэтгэл санааны зовлонд унах, хувь хүний зан чанар доголдох гэх мэт асуудлууд гарч ирэх зэргээр илэрдэг. Энэ нүглийг Христийн цусаар уучлуулахгүй л бол эцэст нь Бурхан мөнх галаар шийтгэх болно.

Шашны шинэчлэлийн үеийн бишоп Латимер ёс бус амьдралд автсан VIII Хэнри хаанд үүнийг зоригтойгоор эл шулуухан сануулсан байдаг. Тэрээр хааны өмнө нямбайлан баринтагласан Библи гаргаж ирэв. Баринтаг дээр нь “Янхан эрчүүдийг болон завхайрагчдыг Бурхан шүүнэ” гэж бичсэн байлаа.

13:5 Хөгжүүлэх ёстой зургаа дахь сайн чанар бол сэтгэл хангалуун байх явдал юм. Иудейзмын сүсэгтнүүд “Бидэнд асар байна. Тахилчид байна. Тахилууд байна. Гайхалтай сайхан ёслолууд байна. Та нарт юу байгаа юм бэ?” гэж байнга хэлж байсныг санаарай. Тэгвэл бичээч христитгэгчдэд хандан **“Байгаа юмандаа сэтгэл хангалуун бай”** хэмээн намуухнаар захиж байна. Тэгэх нь ч зүйтэй! Учир нь христитгэгчдэд байгаа зүйл иудейзмын хамгийн сайн зүйлсээс ч хязгааргүй илүү агуу билээ. Яагаад бид сэтгэлээр унах ёстой юм бэ? Бидэнд Христ байна. Үүнээс илүү юу хэрэгтэй гэж?

Мөнгийг хайрлах хайр итгэгчдэд маш том саад учруулдаг. Жижигхэн мөнгөн зоосыг нүднийхээ өмнө баривал нарыг халхалж чаддаг шиг шунал нь Бурхантай харилцах харилцаанд тээг болж, сүнслэг өсөлтийг удаашруулдаг.

Хүнд байж болох хамгийн агуу баялаг бол **“Би чамайг хэзээ ч орхихгүй мөн чамайг хаяхгүй”** гэж амласан Нэгэнийг олж авах явдал юм. Грек хэлэнд баттай үгүйсгэлийг илэрхийлэхийн тулд хоёр ба түүнээс олон сөрөг үг хэрэглэдэг. (Энэ нь англи хэлний бүтэцтэй зөрдөг. Англи хэлэнд давхар үгүйсгэл эерэг утгатай болдог). Энэ эшлэлд таван удаа үгүйсгэл хэрэглэснийг харвал Христ биднийг хэзээ ч, ямар ч тохиолдолд орхихгүй гэдгийг онцлон баталж байна.

13:6 Христийг өөрийн болгосон хүн итгэлтэйгээр юу гэж хэлдгийг Дуулал 118:6-д дурджээ. **“Эзэн миний туслагч. Би айхгүй. Хэн надад юу хийж чадах юм бэ?”**

Христийн дотор бидэнд төгс хамгаалалт, төгс аюулгүй байдал, төгс амар амгалан бий.

13:7 Бурханы үгийг ярьсан багш нарыг буюу удирдагчдаа сана гэж бичээч уншигчдадаа уриалж байна. **Тэдний амьдралын хэв байдлын үр дүн** юу байсан бэ? Тэд Левийн тогтолцоо руу эргэлгүй, итгэлээ эцэс хүртэл бат сахисан. Зарим нь Христийн төлөө амиа алдсан ч байж магадгүй. Христээс зуурдаг, Христийн сургаалыг бат баримталдаг, Бурханыг амьдралынхаа бүх талбарт оруулж ирдэг, даган дуурайхуйц **итгэл** гэж бий. Бид бүгдээрээ ижил үйлчлэл хийхээр дуудагдаагүй ч бүгдээрээ итгэлийн амьдрал руу дуудагджээ.

13:8 Энэ эшлэл өмнөхтэйгөө хэрхэн холбогдож байгаа нь тодорхойгүй байж болох ч сая дурдагдсан удирдагчдын сургаал, зорилго, итгэлийг дүгнэн хэлсэн гэж үзэх нь хамгийн зөв бололтой. Тэд **Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ** гэж тунхаглаж байлаа. Тэдний амьдралын зорилго **өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ Есүс Христ** байв. Тэдний итгэлийн суурь **Есүс бол өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ Христ** мөн гэдэгт тулгуурлаж байсан юм.

13:9 Дараа нь хуулийг баримталсан хуурамч сургаалын эсрэг сэрэмжлүүлэв. Иудейзмыг дэмжигчид ёслол бүхий мөргөл, цэвэр хоол гэх мэт гадаад зүйлсээр ариун байдлыг олж авах сургаалыг тулгадаг байв. Гэтэл үнэндээ ариун байдал нь хуулиар бус, нигүүлслээр бий болдог ажээ. Хуулийн шаардаад байгаа цэвэр, бузар хоолны асуудал нь *зан үйлийн* хувьд цэвэр байдлыг бий болгох зорилготой. Гэтэл энэ нь дотоод ариун байдалтай ямар ч холбоогүй. Хүн зан үйлийн хувьд цэвэр байж болох ч дотроо хорсол, хоёр нүүртэй байхыг үгүйсгэх аргагүй. Гагцхүү Бурханы нигүүлсэл л итгэгчдийг ариун амьдрахад уриалж, хүч өгч чадна. “Сүсэг бишрэлгүйг болон ертөнцийн шуналыг үгүйсгэхийг, мөн эдүгээ үед биеэ цэнэдэг ба сүсэг

бишрэлтэй амьдрахыг” (Тит 2:12) өдөөдөг цорын ганц зүйл бол бидний нүглийн улмаас болж үхсэн Аврагчийг хайрлах хайр билээ. Эцэст нь хэлэхэд, хоол унд, уух зүйлтэй холбоотой эцэс төгсгөлгүй дүрэм журам нь ариун амьдрахад хэзээ ч ашиг тусаа өгч байгаагүй юм.

13:10 Бидэнд тахилын ширээ бий гэсэн энэ ялгуусан үгийг бүү үл тоогоорой. Энэ бол иудейзмыг баримтлагчдын ахин дахин асуусан асуултад итгэгч бидний хариулах бат итгэлтэй мэдэгдэл юм. Бидний **тахилын ширээ** бол Христ Өөрөө юм. Христийн дотор бүх ерөөл оршдог. Левийн тогтолцоонд хамааралтай хүмүүс христитгэлийн илүү сайн зүйлсийн хуваалцагч болох **эрхгүй**. Тэд эхлээд нүглээ улайж, Есүс Христийг цорын ганц Эзэн ба Аврагч гэж итгэх ёстой.

13:11 Тахилын хуулийн дагуу, мал **амьтан** нядлаад **цусыг нь тэргүүн тахилч нүглийн** тахил болгож ариунаас ариун газар руу авч ордог байв. Харин **биенийг** нь хуарангийн гадна талд гарган шатаадаг байлаа. **Хуарангийн гадна** гэж асрыг тойрон хүрээлсэн хашааны гадна талыг хэлж байна.

13:12 Хуарангийн гадна шатаагддаг амьтад бол Эзэн **Есүсийн** бэлгэдэл байсан юм. Тэрээр Иерусалим хотын хэрмийн **гадна** цовдлогдсон. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн байгуулсан иудейзмын хуарангийн гадна Тэрээр **Өөрийнхөө цусаар хүмүүсийг ариусгажээ**.

13:13 Захидлыг анх уншиж байсан итгэгчдэд өгч буй сургамж нь тодорхой байлаа. Тэд иудейзмаас эрс шийдэмгий салах ёстой байв. Тэд сүмийн тахилуудыг орхиж, Христийн төгс үйл хэргийг өөрсдийн цорын ганц аврал гэж үзэх ёстой байжээ.

Эдүгээ бидэнд ч мөн адил утга нь тодорхой. Өнөөдрийн хувьд хуаран гэдэг бол хүний үйлс, сайн чанар, зан үйл, ёслолоор дамжуулан аврагдахыг номлодог шашны бүх тогтолцоо юм. Тэд хүний гараар тахилчдыг томилж,

материаллаг зүйлсийн тусламжтайгаар мөргөл үйлдэж, ёслол зан үйлд дэндүү их төвлөрдөг. Тэд бол Христгүй христийнхэн билээ. Эзэн Есүс тэдгээрийн гадна байна. **Иймээс Түүнийг доромжилсныг нь үүрэн, хуарангийн гадна гарч Түүн уруу очигцооё.**

13:14 Сүмд үйлчилдэг хүмүүсийн зүрхэнд Иерусалим хот асар эрхэм хүндтэй байжээ. Энэ хот тэдний “хуарангийн” төв байсан юм. Харин христитгэгч хүнд энэ дэлхий дээр ийм **хот** байхгүй. Итгэгч хүний зүрх сэтгэл тэнгэрлэг хот, шинэ Иерусалим руу чиглэсэн байдаг. Тэнд Хурга Өөрөө бүх яруу алдар нь болдог.

13:15 Шинэ гэрээний үед итгэгч бүхэн тахилч билээ. Тэд бол мөргөл үйлдэхээр Бурханы ариун газар руу ордог ариун тахилчид (1Пт 2:5) юм. Мөн тэд Бурханыг гэрчлэхээр энэ дэлхий рүү илгээгдсэн хаант тахилчид (1Пт 2:9) билээ. Тахилчийн хувиар итгэгч бидний өргөдөг гурван янзын тахил бий. Нэгдүгээрт, бид өөрийн биеийг тахил болгон өргөдөг (Ром 12:1). Хоёрдугаарт, энэ эшлэлд гарч байгаа **магтаалын тахил** юм. Үүнийг бид Эзэн Есүсээр дамжуулан **Бурханд** өргөдөг. Бидний бүх магтаал, залбирал Эцэг Бурханд хүрэхээсээ өмнө Эзэн Есүсээр дамждаг. Тэргүүн Тахилч маань тэр бүгдээс хамаг өө сэв, дутуу дулимаг, бохир бузрыг арилгаж, зайлуулаад Өөрийнхөө төгс үйл хэргийг нэмж өгдөг.

Магтаал залбирал бүхэнд минь
Машид тансаг Христийн үнэр шингэнэ
Утлагын бойпроос хайр суунаглана
Уугьж дээшээ Бурханы өмнө очно

-Мэри Б. Питрс

Магтаалын тахил бол Түүний нэрд талархах уруулын үр жимс юм. Бурхан аврагдсан хүмүүсийн уруулаас гарах мөргөлийг л хүлээж авдаг.

13:16 Гурав дахь тахил бол эд хөрөнгөө өргөх явдал билээ. Бид өөрт байгаа материаллаг эд юмсаа **сайныг үйлдэхэд** ашиглаж, хэрэгцээ бүхий хүмүүст **хуваалцахад** зориулах ёстой. **Тахил** мэт золиос гаргадаг ийм амьдралыг **Бурхан** таалдаг. Энэ нь өөртөө эд агуурс хураадаг амьдралын яг эсрэг байдаг.

Бурханы тосолсон тахилчдын удам
Хэзээ ч үл тасрах нандин хэлхээ
Түүний яруу жавхлангийн өмнө тэд
Өдөр шөнөгүй үйлчлэн зогсоно
Хүний цэцэрхэл, үл итгэл
Хүчит давлагаа мэт нөмрөн ававч
Бурханы нууцалсан тахилчид
Эцэс хүртэл оршсоор байх болно
Бурханы сонгосон ариун хүмүүс
Ариун галд биеэ өргөнө
Тахил болгосон тэрхүү өргөл нь
Бурханы зүрхэнд тааллыг олно
Мөргөл хүндлэлийн утлага нь
Ариунаас ариун газрыг дүүргэж,
Магтаал талархлынх нь дуу хуур
Тэнгэрийн сүмд халгиж цалгина

-Герхард Тэрстигэн

13:17 7,8-р эшлэлд өмнө үеийн удирдагчдаа сана гэж зааварласан бол энэ эшлэлд одоогийн **удирдагчдаа дага** гэж захиж байна. Энэ нь нэн ялангуяа нутгийн чуулганы ахлагчдыг (өөрөөр хэлбэл, пасторуудыг) хэлж байгаа юм. Тэд чуулганд Бурханыг төлөөлөн үйлчилдэг. Тэдэнд эрх мэдэл өгөгдсөн тул итгэгчид тэдэнд **захирагдах** хэрэгтэй. Ахлах Хоньчны доор дэд хоньчин хийж байгаа хүмүүсийн хувиар ахлагчид нь хонин сүргийнхээ **сэтгэлийг сэрэмжилдэг**. Тэд хариуцсан хүмүүсийнхээ өмнөөс

хожмын нэг өдөр Бурханд тайлагнах учиртай. Тэд үүнийг баяртайгаар хийх үү, гунигтайгаар хийх үү гэдэг нь итгэгчдийн сүнслэг өсөлтөөс шалтгаална. Хэрэв тэд гунигтайгаар хийвэл ариун хүмүүсийн төлөөх шагналаа алдана. Тиймээс хүн бүрийн ашиг тусын төлөө Бурханы тогтоосон эрх мэдлийг хүндлэх нь зүйтэй.

IV. ТӨГСГӨЛИЙН ЕРӨӨЛ (13:18-25)

13:18 Бичээч захидлынхаа төгсгөлд залбирч өгөхийг нэмж хүсэж байна. Үлдсэн өгүүлбэрээс харахад тэрээр шүүмжлэгчдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан бололтой. Эдгээр шүүмжлэгчид нь итгэгчдийг Хуучин гэрээний мөргөл рүү эргүүлэхийг оролдож байсан хүмүүс байж магад хэмээн таамаглаж байна. Гэвч тэрээр өөрт нь ямар ч буруутгал ирсэн бай, мөс чанар минь сэвгүй, хүсэл минь цэвэр гэдгийг батлан хэлж өөрийгөө өмгөөлжээ.

13:19 Мөн бичээч удахгүй уншигчидтайгаа уулзахын төлөө залбирч өгөхийг хүсжээ. Магадгүй бичээч маань шоронгоос суллагдан гарах тухай ярьсан байж болох юм. Гэвч үүнээс цааш таамаглах боломж бидэнд байхгүй.

13:20 Дараа нь Тооллого 6:24-26, 2Коринт 13:14, Иуда 24,25-тай эн зэрэгцэх, Библийн хамгийн сайхан ерөөлүүдийн нэгийг бичиж үлдээжээ. Энэ нь амар тайвны Бурханд хандан хэлсэн үг юм. Хуучин гэрээний ариун хүмүүс мөс чанартаа төгс амар тайвныг авч байгаагүй гэдгийг өмнө нь хэлсэн. Тэгвэл Шинэ гэрээний дотор бид Бурхантай эвлэрч (Ром 5:1), Түүний амар амгаланг (Флп 4:7) эдэлдэг. Энэхүү амар амгалан нь Христийн гүйцэлдүүлсэн үйл хэргийн үр дүн юм. Бурхан бидний Эзэн Есүсийг үхлээс амилуулснаараа загалмай дээрх Христийн үйл хэрэг нүглийн асуудлыг бүхэлд нь нэг мөр шийдсэнийг баталсан.

Христ сайн **Хоньчны** хувьд хоньдынхоо төлөө амиа өгсөн (Иох 10:11). Агуу **Хоньчны** хувьд үхлээс амилж, авралын үйл хэргийг гүйцэлдүүлэв (Евр 13:20). Тэргүүн **Хоньчны** хувьд зарц нараа шагнахаар эргэн ирэх болно (1Пт 5:4). Бид Түүнийг Дуулал 22 дээр сайн Хоньчин, Дуулал 23 дээр агуу Хоньчин, Дуулал 24 дээр Тэргүүн Хоньчин гэдгээр нь хардаг.

Түүнийг **мөнх гэрээний** дагуу **үхэгсдээс амилуулжээ**. Энэ талаар Вэст дараах тайлбарыг өгсөн байдаг. Үүнд:

Түр зуурын чанартай анхны гэрээнээс ялгаатай нь Шинэ гэрээ мөнхийн гэж нэрлэгддэг. Мессиа нүгэлт хүний төлөө амиа зориулж, үхэгсдээс амилуулагдсан нь мөнхийн гэрээний хүрээнд байв. Тэрээр үхэгсдээс амилуулагдаагүй бол Мелхизедекийн хэргэмийн дагуу Тэргүүн Тахилч болж чадахгүй байлаа. Нүгэлт хүний нүглийг нь төлөөд л дуусах үхдэг тахилч бус, итгэсэн нүгэлтэнд амь өгөх чадалтай амьд Тахилч хэрэгтэй. Тиймээс Шинэ гэрээнд Өөрийгөө тахил болгон өргөсөн тахилч үхэгсдээс амилах ёстой гэдэг.²⁹

13:21 Хорьдугаар эшлэлээс эхэлсэн ерөөлийн залбирал нь Бурханы **хүслийг гүйцэтгэх аливаа сайн хэрэгт** ариун хүмүүс бүрэн **бэлэн** болох болтугай гэсэн хүсэлт билээ. Энд Бурхан, хүн хоёрын хамтын ажиллагааг харж болно. Бурхан биднийг **сайн** бүхнээр зэвсэглэж, **Өөрийнхөө мэлмийд тааламжтай зүйлийг бидний дотор бүтээлгэхээр Есүс Христээр дамжин ажилладаг**. Дараа нь бид Түүний хүслийг гүйцэлдүүлдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан бидний дотор хүслийг өгч, үйлдэх хүчийг соёрхдог. Тэгээд бид Бурханы хүслийг үйлддэг. Үүний төлөө Тэр биднийг шагнадаг.

Эцэст нь уг залбирал Есүс Христ **үеийн үед алдар** сууг хүртэх зохистой хэмээн хүлээн зөвшөөрснөөр төгсдөг.

Эзэн Есүс Та минь
Магтаал талархлыг авах зохистой
Бишрэл хүндлэлийг хүртэх учиртай
Тэнгэрийн жавхланг үүрд амсах эрхтэй
-Ф. Т. Виграм

13:22 Бичээч одоо захидлынх нь **сургамжийн үгийг** буюу зан үйлд төвлөрсөн шашныг орхиж, үнэн сэтгэлээсээ Христээс зуурах тухай бичсэн ятгалгыг нь анхааран хүлээж авахыг уншигчдадаа уриалж байна.

Тэрээр захидлаа **товчхон бичлээ** гэжээ. Энэ нь Христ дотор Левийн тогтолцоо хэрхэн биеллээ олсныг дэлгэрэнгүй тайлбарлаж болох байсан ч товчлон бичсэнийг илтгэнэ.

13:23 **Тимот суллагдсан** гэснийг хараад олон хүн энэ захидлыг Паул бичсэн гэж үздэг. Мөн Тимоттой хамт очно гэсэн үг нь захидлыг Паул бичсэн байж болохыг бас илтгэдэг. Гэхдээ үүнийг бүрэн батлах боломжгүй тул энэ асуудлыг нээлттэй орхих нь зүйтэй.

13:24 Христийн чуулганы **бүх удирдагч** болон **бүх ариун хүмүүст** мэнд хүргэж байна. Захидалд итгэгч хүний эелдэг найрсаг зан олонтоо илэрхийлэгддэгийг бид анзааралгүй өнгөрч болохгүй. Харин ч өнөө үед тэдгээрээс үлгэр дуурайлал авах хэрэгтэй.

Италиас ирсэн зарим итгэгч бичээчтэй хамт байсан тул тэд ч бас мэндчилгээгээ уламжлахыг хүсэж байв. Эндээс дүгнэвэл, уг захидлыг Италиас бичсэн эсвэл Итали руу илгээсэн байж болохыг илтгэнэ.

13:25 Шинэ гэрээний энэхүү захидал **“Нигүүлсэл та бүгдтэй хамт байх болтугай”** гэсэн нигүүлслийн ерөөлөөр төгсөж буй нь зүйн хэрэг билээ. Шинэ гэрээ нь Эзэн Есүс Христийн тахилаар дамжуулан зохисгүй нүгэлтнүүдэд илэрхийлэгдсэн Бурханы таалал, хязгааргүй нигүүлслийг тунхагладаг нөхцөл болзолгүй гэрээ юм. **Амен.**

ЕВРЕЙЧҮҮДЭД БИЧСЭН ЗАХИДЛЫН ӨНӨӨ ЦАГИЙН УНШИГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАМЖИЙН ТАЛААР НЭМЭЛТ ТАЙЛБАР

Еврейчүүдэд бичсэн захидал номоос хорьдугаар зууны итгэгч бидэнд авах сургамж байгаа юу? Өнөөдөр христитгэл анх үүсэж байсан үеийнх шиг иудейзм нь олонхыг хамарсан шашин биш ч гэлээ хуульчлагдсан сэтгэлгээ Христийн гэсэн тодотголтой хүрээлэлд нэгэнт тархжээ. “*Үнэний үгийг зөв хуваах нь*” (*Rightly Dividing the Word of Truth*) хэмээх алдарт товхимолдоо С. И. Скофилд ингэж бичжээ:

Чуулганыг иудейжүүлэх оролдлого Чуулганы өсөлт дэвшлийг хазаарлаж, эрхэм зорилгыг нь гажуудуулж, сүнслэг байдлыг нь мөхөөх түмэн янзын шалтгааны эх үүсвэр гэдгийг би баттай хэлье. Энэ ертөнцөөс тусгаар байж, тэнгэрлэг дуудлагынхаа дагуу Эзэнийгээ дагахын оронд Чуулган өөрийгөө зөвтгөхийн тулд иудейн судруудыг ашиглаж, энэ ертөнцийг соён гэгээрүүлэх нэрийн дор эд хөрөнгө хурааж хуримтлуулах, тансаг сүмийн барилга барих, элдвийн ёслолуудыг сахих, тэр ч байтугай эрх тэгш ахан дүүсийг дунд нь хагарлыг тарааж, “санваартан” ба “жирийн хүн” хэмээн хуваагдлыг үүсгэжээ.³⁰

Христийг цор ганц Эзэн ба Аврагч гэж хүндэлдэггүй, гүйцэлдүүлсэн үйл хэргийг нь нүглийн төлөөх бүрэн төгс тахил гэж итгэдэггүй шашны бүх тогтолцооноос өөрсдийгөө тусгаарла гэж Еврейчүүдэд бичсэн захидал биднийг уриалж байна.

Хуучин гэрээний тогтолцооны сүүдэр, бэлгэдлүүд нь Христ дотор бүрэн гүйцэлдсэн гэж Еврейчүүдэд бичсэн захидал сургаж байна. Тэр бол бидний Тэргүүн Тахилч,

Тахил, Тахилын ширээ билээ. Тэрээр тэнгэрлэг ариун газарт үйлчилдэг бөгөөд Түүний тахилчийн үйлчлэлд төгсгөл гэж үгүй.

Мөн энэ ном бүх итгэгчдийг тахилч гэж тунхаглаж байна. Итгэгчид ямар ч үед итгэлээр Бурханы оршихуй руу тэр даруй нэвтэрч чадна гэж сургаж байна. Тэд Бурханд өөрсдийн бие хүн, магтаал талархал, эд хөрөнгөө тахил болгон өргөдөг.

Давид Бэрон энэ талаар ингэж бичжээ:

Левийн тахилчийн загварыг Христийн Чуулганд нэвтрүүлнэ гэдэг бол эвлэрлийг тогтоосон Бурхан Өөрийн гараар хоёр хуваасан хөшгийг бузар гараараа дахин нийлүүлж зүйхтэй адил бөгөөд Христийн цусаар Бурханд ойртсон хүмүүст хандаж “Бурханд бүү ойрт, хол зогс” гэж хэлснээс ялгаагүй хэрэг юм.³¹

Еврей ном бидэнд *илүү сайн* гэрээ, *илүү сайн* Зууч, *илүү сайн* найдвар, *илүү сайн* нутаг орон, *илүү сайн* тахилчийн үйлчлэл, *илүү сайн* эд хөрөнгө буюу иудейзмийн шилдэг бүхнээс *илүү сайн* зүйлс байгаа гэж сургадаг. Энэ нь бидэнд мөнхийн золилт, мөнхийн аврал, мөнхийн гэрээ, мөнхийн өв байгаа гэдгийг баталгаажуулдаг.

Цаашилбал, энэ ном итгэлээс урвах нүглээс хатуу сэрэмжлүүлдэг. Хүн өөрийгөө итгэгч гэж нэрлээд, Христийн чуулгантай холбогдсон ч дараа нь Христээс нүүр буруулж, Эзэний дайснуудтай нэгдвэл түүнд дахин шинэчлэгдэж, гэмших боломж үлдэхгүй.

Еврейчүүдэд бичсэн захидал нь жинхэнэ итгэгчдийг харснаараа бус, итгэлээр алхахыг уриалдаг. Учир нь ийм амьдрал л Христийн тааллыг олдог. Мөн амлагдсан шагналыг хүлээн авахын төлөө аливаа зовлон, сорилт, хавчлага дор зоригтой тэвчээртэй байхыг урамшуулдаг.

Итгэгчид олон онцгой эрх, ивээлийг хүртсэн тул тэдэнд онцгой хариуцлага ноогддог гэж Еврей ном сургадаг. Христийн бүхнээс агуу байдал нь итгэгчдийг энэ дэлхийн хамгийн их тааллыг хүртсэн хүмүүс болгодог. Энэхүү онцгой эрхээ үл тоомсорловол Христийн шүүх суудлын өмнө үйлсийнхээ дагуу алдагдал хүлээх болно. Хуулийн доор амьдарч байсан хүмүүсээс илүү ихийг итгэгчдээс хүлээдэг тул хожим биднээс илүүг шаардах болно.

“Иймээс Түүнийг доромжилсныг нь бид үүрэн, хуарангийн гадна гарч Түүн рүү очицгооё.” (Евр 13:13)

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

¹(3:18) Артур Т. Пиерсон, нэмэлт мэдээлэл байхгүй.

²(4:15) Христ нүгэл үйлдэж чадах байсан эсэхийг теологичид хоёр латин хэлцээр илэрхийлдэг. “non posse peccare” буюу “нүгэл үйлдэх боломжгүй”, “posse non peccare” буюу “нүгэл үйлдэхгүй байх боломжтой.” Тэгвэл зөв сургаал нь “non posse peccare” буюу Христ нүгэл үйлдэж чадахгүй байсан гэдэг нь юм.

³(4:16) Г. Кэмпэл Морган, “Шилмэл сургамжийн хуанли”

⁴(6:2) Баптисмыг грек эх хэл дээрээ ялгаатай үг ашиглан илэрхийлсэн байдаг. Баптисмыг *баптисма* гэж ихэвчлэн хэлдэг бол энд *баптисмои* гэдэг үг хэрэглэсэн нь ёслолын угаал үйлдэхийг хэлж байна.

⁵(6:20) Д. Андерсон-Берри, нэмэлт мэдээлэл байхгүй.

⁶(7:20) А. В. Рэйнсбюри, “Бүрэн төгс аврах чадалтай,” *Кесвикийн долоо хоног*, 1958, 78-р хуудас.

⁷(7:21) Жорж Хэндерсон, *Еврейчүүдэд бичсэн захидал номын судлал*, 86-р хуудас.

⁸(8:6) У. Х. Гриффит Томас, *Еврей ном: Чимээгүй цагийн тайлбар*, 103-р хуудас.

⁹(8:8) Жорж Хэндерсон, *Еврейчүүдэд бичсэн захидлын судлал*, 92-р хуудас.

¹⁰(9:4) Грекээр *тумиатэрион* гэдэг үг нь утлага уугиулдаг эд юм эсвэл газар орон юм.

¹¹(9:13) Ж. Грегорий Мантель, *Илүү сайн зүйлс*, 109-р хуудас.

¹²(9:15) Кэннет С. Вэст, *Грек Шинэ гэрээн дэх Еврей ном*, 162, 163-р хуудас.

¹³(10:10) Жорж М. Ландис, *Еврейчүүдэд бичсэн захидал: Төлөвшил өөд*, 116-р хуудас.

¹⁴(10:11) Александр Балмэйн Брюс, *Еврейчүүдэд бичсэн захидал: Христгэлийн анхны өмгөөлөл*, 34-р хуудас.

- ¹⁵(10:37) Марвин Винсент, *Шинэ гэрээний үг судлал*, II:1150.
- ¹⁶(10:37) А. Ж. Поллок, *Библи ба модернизм*, 19-р хуудас.
- ¹⁷(11:21) Ч. Х. Макинтош, *Эхлэлээс Дэд хууль ном: Пентатухын сургамж*, 133-р хуудас.
- ¹⁸(11:22) Виллиям Ликольн, *Еврейчүүдэд бичсэн захидлын талаар илтгэл, номлолууд*, 106-р хуудас.
- ¹⁹(11:35) Г. Х. Моррисон, *Лукийн сайнмэдээ – Моррисоны тайлбар, Гласговын цуврал номлол*, I:42.
- ²⁰(11:37) Виллиям Г. Мүүрхээд, *Шинэ гэрээг тоймлон судлахуй: Филиппой номоос Еврей ном хүртэл*, 248-р хуудас.
- ²¹(12:2) А. Б. Брюс, *Еврейчүүдэд бичсэн захидал*, хуудас 415, 416.
- ²²(12:10) Ж. Х. Жовет, *Дээд зэрэглэлийн амьдрал*, хуудас 247, 248.
- ²³(12:11) Лэсли Вээдэрхээд, *Шаналал зовлонг эдгээх жор*, 32-р хуудас.
- ²⁴(12:11) Ч. Х. Спержон, “Шилмэл сургамжийн хуанли”
- ²⁵(12:13) Жорж Виллиямс, *Ариун Библийг судалдаг судлаачийн тайлбар*, 989-р хуудас.
- ²⁶(12:13) Г. Х. Ланг, *Еврейчүүдэд бичсэн захидал*, хуудас 240, 241.
- ²⁷(12:14) Вэст, *Еврей ном*, 222-р хуудас.
- ²⁸(13:2) Энэ гурвын нэг нь Эзэний Тэнгэрэлч буюу Христийн махан биеэр ирэхээс өмнөх дүр байсан гэж үздэг.
- ²⁹(13:20) Вэст, *Еврей ном*, 242-р хуудас.
- ³⁰(Тайлбар хүүрнэл) С. И. Скофилд, *Үнэний үгийг зөв хуваах нь*, 17-р хуудас.
- ³¹(Тайлбар хүүрнэл) Давид Бэрон, *Тахилчийн үйлчлэлд тавигдах шинэ тушаал*, хуудас 39, 40.

НОМЗҮЙ

- Брюс, Александр Балмэйн. *Еврейчүүдэд бичсэн захидал: Христгэлийн анхны өмгөөлөл*. Эдинбург хот: Ти Энд Ти Кларк хэвлэлийн газар, 1908 он.
- Говет, Роберт. *Тэнгэрэлч, Мосе, Аарон нараас аугаа Христ*. Лондон хот: Жэй Нисбет хэвлэлийн газар, 1884 он.
- Хэндerson, Ж. Д. *Еврейчүүдэд бичсэн захидлын судлал*. Баркингсайд, Англи: Жи Эф Валлэйнс хэвлэлийн газар, хэвлэгдсэн он тодорхойгүй.
- Хэвит, Томас. *Еврейчүүдэд бичсэн захидал, Гурвал Баптист Чуулган*. Гранд Рапидс хот: Ээрдмансын хэвлэлийн газар, 1960 он.
- Айронсайд, Х. А. *Еврей болон Тит ном*. Нэптюнь хот, Нью Жерси муж: Лойзюкс Бродерс хэвлэлийн газар, 1932 он.
- Келли, Виллиям. *Еврейчүүдэд бичсэн захидал болон Филемон номын удиртгал илтгэлүүд*. Оак Парк хот, Иллинойс муж. “Библийн үнэний хэвлэл” хэвлэлийн газар, хэвлэгдсэн он тодорхойгүй.
- Ландис, Ж. М. *Еврейчүүдэд бичсэн захидал: Төлөвшил өөд*. Оак Парк хот: Еммау Библийн Сургууль, 1964 он.
- Ланг, Г. Х. *Еврейчүүдэд бичсэн захидал*. Лондон хот: Патерностер Прэсс хэвлэлийн газар, 1951 он.
- Ликольн, Виллиям. *Еврейчүүдэд бичсэн захидлын талаар илтгэлүүд*. Бостон хот: “Итгэгчдийн номын өрөө” хэвлэлийн газар, хэвлэгдсэн он тодорхойгүй.
- Мантель, Ж. Грегорий. *“Илүү сайн зүйлс”: Еврейчүүдэд бичсэн захидлаар цуврал Библийн уншлага*. Нью Йорк хот: Христитгэгчдийн Нэгдэл Пабблишинг ХХК, 1921 он.
- Мэйер, Ф. Б. *Ариунаас ариун газар орох Зам*. Гранд Рапидс хот: Зондерван хэвлэлийн газар, 1950 он.

- Моффат, Жэймс. *Еврейчүүдэд бичсэн захидлын шүүмж тайлбар*, Олон улсын конференцийн төв. Эдинбург хот: Ти Энд Ти Кларк хэвлэлийн газар, 1924 он.
- Мюле, Х. К. Г. *Еврей номын судлал*. Гранд Рапидс хот: Крегел Пабликэшн хэвлэлийн газар, 1977 он.
- Ньювел, У. Р. *Еврей номыг эшлэл эшлэлээр*. Чикаго хот: Мүүди хэвлэлийн газар, 1947 он.
- Пфэйфер, Чарльз Ф. *Еврейчүүдэд бичсэн захидал*. Чикаго хот: Мүүди хэвлэлийн газар, 1962 он.
- Рэйнсбюри, А. В. “Бүрэн төгс аврах чадалтай,” *Кесвикийн долоо хоног*. Лондон хот: Маршал, Морган, Скот ХХК, 1958 он.
- Томас, У. Х. Гриффит. *Еврей ном: Чимээгүй цагийн тайлбар*. Гранд Рапидс хот: Виллиям Б. Эрдмансын хэвлэлийн газар, 1961 он.
- Вайн, У. Э. *Еврейчүүдэд бичсэн захидал*. Лондон хот: Олифантс ХХК, 1952 он.
- Вэсткот, Б. Ф. *Еврейчүүдэд бичсэн захидал*. Лондон хот: Макмиллан хэвлэлийн газар, 1889.
- Вэст, К. С. *Грек Шинэ гэрээн дэх Еврей ном*. Гранд Рапидс: Эрдманс Пабблишинг ХХК, 1947 он.

ИАКОВЫН ЗАХИДАЛ

ОРШИЛ

“[Иаков бол] эш үзүүлэгчтэй адил ярьдаг номлогч...Есүсийн айлдваруудыг эс тооцвол христитгэлийн эртний утга зохиолд түүнийхтэй эн тэнцэх бичвэр байхгүй.”

– Теодор Захн

I. БИЧВЭРТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Мартин Лютер Иаковын захидлыг “яг л сүрэл шиг хэрэггүй захидал” гэж дорд үзсэн нь туйлын буруу байсан юм! Аврагдахын тулд итгэлээс гадна үйлс шаардлагатай гэж заадаг хүмүүстэй ширүүн тэмцэж байх үедээ шашны шинэчлэгч Лютер сайн үйлсийн талаарх Иаковын сургаалыг буруугаар ойлгосон нь түүнийг ийнхүү эндүүрэхэд хүргэжээ. Христитгэлийн хамгийн эртний энэ захидлыг буруугаар ойлгосон нь ганц Лютер биш байлаа. Зарим хүн эл захидлыг “хэлхсэн сувд” шиг гэж нэрлэсэн нь хоорондоо уялдаа холбоогүй ч сайтар найруулан бичсэн догол мөрүүдийг холбож, хэлхсэн мэт байдаг гэсэн санааг илэрхийлдэг.

Үнэндээ энэ бяцхан ном сургаал маягийн бичвэрийн сонгодог бүтээл юм. Захидалд иудей сэтгэхүйн хэв маяг хүчтэй агуулагдаж байгааг христитгэгчдийн цуглааныг 'синагог' гэж нэрлэснээс нь харж болно (2:2). Синагог гэж энгийнээр “цуглаан” гэсэн грек үг байсан ч удалгүй зөвхөн *иудейчүүдийн* цугларалтыг нэрлэх болсон нь эдүгээ ч тэр хэвээрээ байна.

Иаков богинохон таван бүлэгтэй захидалдаа сүнслэг үнэнийг харуулахын тулд байгалийн үзэгдлийг гучин удаа ашиглажээ. Энэ нь бидэнд Эзэний заасан сургаалыг сануулна.

Иаковын энэхүү захидал нь амьдралд тун ойр. Тухайлбал хэл амаа захирах, баячуудад бялдуучлахын аюул, итгэлээ амьдралаараа батлан харуулах зэрэг хүмүүс тэр бүр сонирхдоггүй сэдвүүдийг хөндсөн байдаг.

II. ЗОХИОГЧ

Библийн олон нэр нэршил еврей хэлнээс грек, латин, франц хэлээр дамжин англи хэл рүү орчуулагдахдаа аялга дуудлага нь тодорхой хэмжээнд өөрчлөгдсөн байдаг. Гэхдээ Иаковаас (James) бусад нь анхны дуудлагаасаа нэг их хол зөрдөггүй. Иаковын нэр ганцаараа танигдахын аргагүй өөрчлөгджээ. Еврей хэл дээр Яаков (“Иаков”) гэсэн нэр грек дуудлагаар “Иакобос” болсон байна. *Иаков* (James) гэдэг нэр иудейчүүдийн дунд түгээмэл байсан ба Шинэ гэрээнд ийм нэртэй дөрвөн хүн гардаг. Иаковын захидлыг эдгээр дөрвөн хүний хэн нь бичсэн байж болох талаар янз бүрийн таамаг дэвшүүлсэн байдаг ч магадлал болон эрдэмтдийн дэмжлэгийн хувьд ялгаатай байдаг.

1. *Зебедеен хүү*, Иоханы ах (Мт 4:21), *элч* Иаков. Элч Иаков зохиогч нь байсан бол энэхүү захидлыг хүлээн зөвшөөрөх гэж ийм урт хугацаа өнгөрөхгүй байсан биз ээ (доорхыг үз). Мөн Иаков МЭ 44 онд хороогдсон нь энэ ном бичигдэхээс өмнө болсон үйл явдал байх магадлал өндөр байдаг.

2. *Алфайн хүү* Иаков (Мт 10:3). Түүний тухай элч нарын жагсаалтад дурдагдсанаас өөрөөр *бараг мэдэх зүйл үгүй*. Гэтэл зохиогч өөрийгөө зүгээр л "Иаков" гэж бусдаас ялгах цол гуншингүй нэрлэснээс нь харвал тухайн үед хүмүүс түүнийг сайн таньдаг байсныг илтгэж байна.

3. *Иудасын эцэг* Иаков (Искарот биш, Лк 6:16). Энэ хүний мэдээлэл бүр ч бүрхэг учир зохиогч байх боломжийг шууд үгүйсгэж болно.

4. *Эзэний маань дүү* Иаков (Мт 13:55; Гал 1:19). Энэ хүн захидлын зохиогч байх магадлал хамгийн өндөр. Тэрээр олонд танигдсан атлаа даруу нэгэн байжээ. Учир нь тэр Христтэй цусан төрлийн холбоотойгоо дурдсангүй (Иуда номын оршлыг үзнэ үү). Тэрээр Иерусалим дахь Зөвлөлийг удирдаж, насан эцэс болтлоо уг хотдоо амьдарчээ. Мөн иудей хэв маягийг баримталдаг христитгэгч, зарчимч гэдгээрээ нэр хүндтэй байлаа. Товчхондоо, түүхэн эх сурвалж (Иосефус) төдийгүй чуулганы уламжлалд түүнийг л ийм төрлийн захидал бичих хүн хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг.

Гадаад баримт

Иаковын захидал гадаад эх сурвалж дээр үндэслэсэн баримт хамгийн багатай номын нэг билээ. Анхан үеийн чуулганы эцгүүд энэ номоос эш таталгүй, үл ялиг л дурдсан байдаг. Мөн Мураторийн Канонд ч бас багтаагүй. Энэ бүхэн Иаковын захидал Иерусалимаас гаралтай, дорнын иудейчүүдэд хаяглагдсан, мөн итгэлээр зөвтгөгдөх тухай Паулын номлолтой зөрчилдөж байна гэж олон хүн үздэг байсантай холбоотой байж ч болох юм.

Гэхдээ Иаков номоос Иерусалимын Кирил, Назианын Грегори, Афанасий, Иером нар эш татсан байдаг. Евсевий ч энэ захидлыг зарим итгэгчид антилемоген буюу маргаантай номуудын нэг хэмээн үздэг байсан тухай тэмдэглэн үлдээсэн боловч өөрөө энэ захидлыг ариун Бичвэр хэмээн эш татсан байдаг.

Дотоод баримт

Иаковын захидал *дотоод* эх сурвалж дээр үндэслэсэн *баримт* нэлээд ихтэй. Түүний бичвэрийн хэв маяг Үйлс болон Галат номд гарч буй Иаковын хэв маягтай нийцдэг.

Мөн бусад эх сурвалжаас олж авсан иудейчүүдийн харьд тархсан түүхтэй ч тохирдог. Ийм номыг хуурамчаар зохиох шалтгаан байхгүй. Иаковын захидал шинэ онол сургаал гаргаж тавиагүй. (2-р зууны хуурамч зохиолууд үргэлж шинэ сургаал нэмдэг байсан). Иаков хуулийг чандлан сахидгаараа иудейчүүдийн дунд нэр хүндтэй байсан боловч Мессиагийн тухай гэрчлэх нь хориотой байсан цаг үед гэрчилснээрээ хороогдсон гэж түүхч Иосефус бичжээ. Энэхүү иудей түүхч Иаковыг тэргүүн тахилч Ананиагийн тушаалаар чулуудуулж алуулсан гэжээ. Харин Евсевийн тэмдэглэлд Иаковыг сүмийн орой дээрээс түлхэж унагаад модоор балбаж амийг нь бүрэлгэсэн гэжээ. Хегесиппус энэ хоёр түүхийг хоёуланг нь нэгтгэн бичжээ.

Иаковын захидлын грек хэлний найруулга Палестин гаралтай еврей хүн бичсэн гэхэд "хэтэрхий сайн" байна гэж маргах нь Бурханы сонгосон ард түмний оюуны гайхамшигт чадварыг үл тоомсорлосон, мэдлэг дутмаг хандлага болно.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Иаков МЭ 62 онд алуулсан тул захидал нь үүнээс өмнө бичигдсэн байх учиртай гэж түүхч Иосефус үздэг. Түүнчлэн уг захидалд Иаковын удирдсан Иерусалим дахь Зөвлөлийн (Үйл 15, МЭ 48 эсвэл 49 он) цуглаанаас гаргасан хуулийн шийдвэрийн талаар огт дурдаагүйгээс үзэхэд захидлыг МЭ 45-48 оны хооронд бичсэн гэж олонх нь хүлээн зөвшөөрдөг.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ЕРӨНХИЙ АГУУЛГА

Хэдийгээр Иаковын захидал Шинэ гэрээний хамгийн эхэнд бичигдсэн ном агаад тэр ч утгаараа иудей өнгө аяс

хүчтэй мэдрэгддэг ч доторх сургаалуудыг нь хоцрогдсон хэмээн орхигдуулж болохгүй. Энд гарч буй сургаалууд нь эдүгээ ч ач холбогдолтой, нэн хэрэгцээтэй хэвээрээ байгаа.

Иаков зорилгодоо нийцүүлэн Эзэн Есүсийн уулан дээрх сургаал дээр чамгүй их түшиглэн бичжээ. Үүнийг дараах харьцуулалтуудаас тодорхой харах боломжтой:

Сэдэв	Иаков
Матай	
Зовлон	1:2, 12; 5:10
5:10-12	
Залбирал	1:5; 4:3; 5:13-18
6:6-13; 7:7-12	
Хоёргүй сэтгэл	1:8; 4:8
6:22, 23	
Эд баялаг	1:10, 11; 2:6, 7
6:19-21, 24-34	
Уур хилэн	1:19, 20; 4:1
5:22	
Хууль	1:25; 2:1, 12, 13
5:17-44	
Энгийн ажил	1:26, 27
6:1-18	
Хаан хууль	2:8
7:12	
Өршөөл энэрэл	2:13
5:7	
Итгэл ба үйлс	2:14-16
7:15-27	
Үндэс ба үр жимс	3:11, 12
7:16-20	
Жинхэнэ мэргэн ухаан	3:13
7:24	

Амар тайвныг тогтоогч	3:17, 18
5:9	
Бусдыг шүүх	4:11, 12
7:1-5	
Зэвэрсэн эрдэнэс	5:2
6:19	
Тангараг	5:12
5:33-37	

Энэхүү захидалд хуулийг олон удаа дурдсан байдаг. Тухайлбал “төгс хууль” (1:25), “хаан хууль” (2:8), “эрх чөлөөний хууль” (2:12) гэх мэт нэрлэжээ. Иаков уншигчдадаа хандан аврагдахын тулд хуулийн доор байх ёстой, хуулийг дагаж мөрдөх ёстой гэж заагаагүй. Харин нигүүлсэл доор байгаа хүмүүст зөвт байдлын заавар болгож хуулийн зарим хэсгээс эш татсан.

Иаковын захидал Сургаалт үгс номтой олон талаараа төстэй байдаг. Сургаалт үгс номтой адил Иаков номын хэв маяг эрс шулуухан, амьд дүрслэлүүдтэй, тоймлоход амаргүй байдаг. *Мэргэн ухаан* гэдэг үг олонтоо дурдагдана.

Мөн Иаковын захидал *ах дүүс* гэсэн түлхүүр үгтэй. Энэ үг 15 удаа давтагдах бөгөөд Иаков захидлаа итгэгчдэд хандаж бичсэн гэдгийг сануулдаг. Мэдээж зарим хэсэгт нь хараахан Эзэн рүү эргээгүй байгаа хүмүүст хандсан мэт санагдах зүйлс ч бас бий л дээ. Иаковын захидлыг зарим талаар Шинэ гэрээн дэх хамгийн тушаан захирсан өнгө аястай ном гэж хэлж болно. Энэ нь Иаков бусад бичээчдээс илүү олон зааварчилгааг өгсөнтэй холбоотой. Ердөө 108 эшлэл бүхий товч агуулга дотор нийт 54 тушаал (захиран тушаах хэлбэрийн үг) агуулагддаг.

ТОЙМ

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1)

II. СОРИЛТ БА УРУУ ТАТЛАГА (1:2-17)

III. БУРХАНЫ ҮГ (1:18-27)

IV. ЯЛГАВАРЛАХЫГ БУРУУШААСАН НЬ (2:1-13)

V. ИТГЭЛ БА ҮЙЛС (2:14-26)

VI. ХЭЛЭЭ ХАЗААРЛАХУЙ (3:1-12)

VII. МЭРГЭН УХААН: ҮНЭН БА ХУДАЛ (3:13-18)

VIII. ШУНАХАЙРАЛ: ШАЛТГААН БА ЭДГЭРЭЛ (4-р
бүлэг)

IX. БАЯЧУУД БА ТЭДЭНД ИРЭХ ШАНАЛАЛ (5:1-6)

X. ТЭСВЭР ТЭВЧЭЭРТ СУРГАМЖИЛСАН НЬ (5:7-12)

XI. ЗАЛБИРАЛ БА ӨВЧТЭЙ НЭГНИЙ ЭДГЭРЭЛ (5:13-
20)

ТАЙЛБАР

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1)

Зохиогч өөрийгөө **Бурханы ба Эзэн Есүс Христийн зарц Иаков** гэж танилцуулжээ. Бидний үзэж байгаачлан зохиогч Эзэний дүү мөн бол түүний амьдралд гайхалтай өөрчлөлт гарчээ. Нэгэн цагт тэрээр Эзэн Есүст итгээгүй явсан (Иох 7:5). Тэрээр Есүсийг ухаан мэдрэлээ алджээ гэж (Мк 3:21) ярьж байсан удаатай. Гэвч бидний Эзэн тэвчээртэйгээр үгийн үрийг түүний дотор тарьжээ. Талархахгүй байсан ч Тэрээр Бурханы хаанчлалын агуу зарчмуудыг заасаар байв. Хожим тэр үр Иаковын амьдралд үндэслэж, агуу өөрчлөлт гарсан байна. Үл итгэгч байсан Иаков одоо зарц болсон бөгөөд ингэж хэлэхдээ ч ичсэнгүй!

Өөрийгөө **Бурханы ба Эзэн Есүс Христийн зарц** гэж дуудахдаа Иаков **Бурхан ба Эзэн Есүсийг** эрх тэгш, адил зиндаанд зөв байршуулан харуулсан байна. Тэрээр Эцэгийг хүндэтгэдгийн адил Хүүг ч мөн хүндэтгэжээ (Иох 5:23). “Хэн ч хоёр эзэнд үйлчилж чадахгүй” (Мт 6:24) гэдгийг Иаков мэдэж байсан атлаа өөрийгөө Бурханы ба Эзэн Есүсийн зарц гэжээ. Үүнд зөрчилдөх зүйл байхгүй. Учир нь Бурхан Эцэг ба Бурхан Хүү эрх тэгш билээ.

Захидлыг **харьд тархсан** (гр. *диаспора*) **арван хоёр овогт** хаяглажээ. Эд бол еврей гаралтай, Израилийн арван хоёр овгийнхон юм. Израилийн гэм нүглийн улмаас ард түмэн нь төрөлх нутгаасаа цөлөгдөж, Газар дундын тэнгисийг хүрээлсэн улс орнуудад тархан суурьшив. Анх МЭӨ 721 онд ассиричууд арван овгийг цөллөгт авч явах үед харьд тархан суурьшиж эхэлжээ. Тэднээс зарим нь буюу үлдэгсэд нь Езра, Нехемиагийн өдрүүдэд нутагтаа эргэн ирсэн юм. Пентэкостын өдөр тухайн үеийн дэлхийн бараг бүх үндэстнээс сүсэгт иудейчүүд Иерусалимд ирсэн байлаа (Үйл 2:4). Тэднийг харьд тархсан иудейчүүд гэж

хэлж болохоор байв. Хожим нь *христитгэлт* иудейчүүд харьд тархаж эхэлсэн юм. Үйлс 8:1-д бичсэнчлэн Саулын хавчлагын улмаас анхан үеийн христитгэгчид (ихэнх нь иудей гаралтай) Иудей болон Самари даяар харьд тархсан гэжээ. Ийнхүү итгэгчид харьд тархсан тухай дараа нь Фоиник, Кипр Антиох хүртэл тархсан гэж дахин дурдагджээ. Тиймээс Иаковын захидалд гарч буй хүмүүс бол энэ хямралын аль нэг үед харьд тархсан иудейчүүд байх боломжтой.

Бүх үнэн итгэгчид энэ ертөнцөд ирмэл агаад түр суурьшигчид байдаг тул (Флп 3:20; 1Пт 2:11) уг захидлыг шууд бидэнд хаяглаагүй ч өөрсөд дээрээ тусган хэрэгжүүлж болно.

Иаковын захидал Христэд итгэдэггүй иудейчүүдэд, Христ рүү эргэсэн иудейчүүдэд эсвэл итгэгч ба итгэгч бус иудейчүүдийн аль алинд нь хандсан эсэхийг баттай хэлэх хэцүү. Иаков ерөнхийдөө жинхэнэ, дахин төрсөн итгэгчдэд хандан бичсэн харагддаг (1:18). Гэхдээ зарим тохиолдолд нэр төдий христитгэгч, тэр ч байтугай итгэж амжаагүй хүмүүст хандсан гэмээр санагддаг. Энэ нь захидал нэн эрт бичигдсэн гэдгийг батлах нэг баримт юм. Учир нь тухайн үед иудей христитгэгчид ба үл итгэгч иудейчүүдийн хоорондын зөрчил хараахан ил болоогүй байжээ.

II. СОРИЛТ БА УРУУ ТАТЛАГА (1:2-17)

1:2 Энэ хэсэгт Иаков сорилтын тухай сэдвийг хөнджээ. Иаков энэ үгийг хоёр өөр утгаар ашиглажээ. 2-12-р эшлэлд Бурханаас илгээсэн *ариун сорилт, бэрхшээл* гэж хэлж болох бидний итгэлийн мөн чанарыг шалгаж, Христэй адил болгох шалгуурын талаар өгүүлжээ. Эсрэгээрээ, 13-17-р эшлэлд бидний дотроос гардаг, гэм нүгэлд хүргэдэг *ариун бус уруу татлагын* талаар өгүүлсэн байна. Христитгэлийн амьдрал бэрхшээлээр дүүрэн. Асуудлууд

урилгагүй, гэнэт хийсэн ирнэ. Заримдаа ганц нэгээрээ, заримдаа бөөн бөөнөөрөө ирнэ. Энэ бүхэн тохиолдох нь зайлшгүй. Иаков “**хэрэв элдвийн сорилтод орвол**” гээгүй харин “**орохдоо**” гэжээ. Бид асуудлаас хэзээ ч зугтан зайлж чадахгүй. Зугтах талаар бодохын оронд, “Бид эдгээрийг хэрхэн шийдвэрлэх вэ?” гэж асуух хэрэгтэй.

Амьдралын шалгуур, **сорилт** ирэхэд бид хэд хэдэн янзын хандлага гаргаж болно. Бид тэдгээрийг эсэргүүцэж, өөрсдийн хүчээр тэмцэн ялалт байгуулна гэж бардамнан, сорилтын өдөөс тэрсэлж тэмцэж болно (Евр 12:5). Эсвэл дарамтад орж, зүрх алдаж, бууж өгч болно (Евр 12:5). Энэ нь гутранги байдалд оруулж, Эзэн анхааран халамжилдаг гэдэгт хүртэл эргэлзэхэд хүргэдэг. Мөн асуудлынхаа талаар гомдоллож гонгинож болно. 1Коринт 10:10-т Паул үүнээс биднийг сэрэмжлүүлсэн. Бас нэг хувилбар нь өөрийгөө өрөвдөж, өөрөөсөө өөр хэнийг ч бодохгүй, бусдаар өрөвдүүлэхийг хичээж болох юм. Энэ бүгдээс арай дээр хандлага бол амьдралын ээдрээ, хүнд хэцүүг хүлээн зөвшөөрч, үүгээр дасгалжиж, төлөвших явдал билээ (Евр 12:11). Үр дүнд нь бид, “Бурхан энэ сорилтыг надад зөвшөөрсөн. Түүнд миний төлөө гэсэн сайн зорилго бий. Тэр зорилго нь юу болохыг би мэдэхгүй ч олж мэдэхийн тулд хичээх болно. Түүний зорилго миний амьдралд биелээсэй гэж би хүсэж байна” хэмээн бид хэлэх чадалтай болно. Иаков яг энэ хандлагыг хөхүүлэн дэмжиж, “**Ах дүү нар минь, элдвийн сорилтод орохдоо үүнийг бүрэн баяр хөөр гэж үз. Бүү тэрсэл! Сэтгэлээр бүү уна! Баярлан хөөр! Асуудал зовлон таныг устгах зорилготой дайсан биш. Харин Христэч зан чанартай болгоход туслах зорилготой анд нөхөр чинь шүү**” гэж байна.

Бурхан хүүхэд бүрийнхээ дотор Христтэй адил байдлыг бий болгохыг зорьдог. Ингэхийн тулд зовлон, цөхрөл, ээдрээг заавал туулах хэрэг гарна. Нар гийх мэт бүх зүйл асуудалгүй үед Ариун Сүнсний үр жимс боловсрох

боломжгүй. Заавал хар үүл хурж, бороо орох шаардлагатай байдаг. Сорилт шалгуур хэзээ ч таатай байдаггүй. Хүнд хэцүү, таагүй санагддаг. Гэвч үүнийг давсны дараа зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг ургуулдаг. (Евр 12:11). Христитгэгчид хүнд бэрхийг туулсныхаа дараа, “Үүнийг давахад амаргүй байлаа. Гэхдээ энэ туршлагыг би өөр юугаар ч солихгүй” гэж хэлэхийг бид олонтоо сонсдог шүү дээ.

1:3 Иаков итгэлийн шалгуурын тухай ярьж байна. Тэрээр итгэлийг галд тунгаагддаг үнэт металлтай зүйрлэжээ. Ийнхүү Бурхан шалгахад үнэхээр жинхэнэ эсэхээ харуулна. Уг металл мэт итгэл хавчлага, өвчин зовлон, уй гашуу гэх мэт галаар соригдоно. Амьдралд асуудал байхгүй байсан бол бид хэзээ ч тэсвэр тэвчээртэй болохгүй. Энэ дэлхийн үл итгэгч хүмүүс хүртэл асуудал бэрхшээл зан чанарыг хүчирхэгжүүлдэг гэж хэлдэг. Аж үйлдвэрийн нэрт зүтгэлтэн Чарльз Кэттеринг нэгэнтээ, “Асуудал бол өсөн дэвшихийн тулд төлдөг төлөөс юм. Надад асуудлаас өөр юу ч битгий авчир. Сайхан мэдээ намайг доройтуулдаг” гэж хэлж байжээ.

1:4 “Хатуужил нь төгс үйл байг” хэмээн Иаков хэлжээ. Заримдаа асуудал бэрхшээл тулгарах үед бид цөхрөнгөө барахдаа ямар ч аргаар хамаагүй сорилтыг товчлохыг оролддог. Тухайлбал, сорилтыг богиносгохын тулд Эзэний зорилгыг асуулгүй юу юугүй эмч рүү яаран очиж, эм их хэмжээгээр хэрэглэдэг. Ингэснээрээ амьдралд маань тусгайлан төлөвлөсөн Бурханы зорилтот үйл ажиллагаанд саад болж байж болох юм. Тэгээд Бурханы зорилго бидний дотор хэрэгжих хүртэл Тэрээр сорилтыг улам урт болгож ч мэднэ. Тиймээс амьдралд тэсвэр тэвчээртэй больё гэвэл товчлох гэсний хэрэггүй. Харин Бурхантай хамтран ажилласнаар бид төлөвшсөн, сайн христитгэгч болж, Сүнсний нигүүлслийг бүрэн хүртэж, **юугаар ч дутахгүй байна.**

Сорилт дундуур туулан гарахдаа хэзээ ч урам хугарч болохгүй. Бидний Бурхан Эцэгт дэндүү том асуудал гэж байхгүй. Амьдралын зарим асуудлыг тойрон гарах аргагүй байдаг. Тиймээс тэдгээрийг хүлээн зөвшөөрөхөд суралцаж, Түүний нигүүлсэл хангалттай гэдгийг батлах хэрэгтэй. Паул бие махбодынх нь сул дорой байдлыг зайлуулж өгөхийг Эзэнээс гурван удаа гуйсан байдаг. Гэтэл Эзэн түүнийг нь зайлуулаагүй, харин Паулд тэсвэрлэн давах нигүүлслийг өгсөн (2Ко12:8-10).

Бурхан зайлуулж өгөхгүй нь тодорхой асуудлууд амьдралд тулгарвал бид Түүний хүсэлд захирагдах хэрэгтэй. Гоц авьяастай ч хараагүй төрсөн магтан дууны зохиогч охин найман настайдаа эдгээр мөргийг бичжээ:

*Харж чадахгүй ч гэлээ
Ямар азтай хүүхэд вэ би!
Хараагүй болсон ч гэлээ
Сэтгэл амгалан байюу би!
Бусдын мэдэрч чадамгүй
Олон ивээлийг хүртнэм би
Хараагүйдээ гашиудан уйлж
Энэлэн шаналж үл чаднам би
- Фанни Кросби -*

Бурханы хүсэлд захирагдах үед амар тайван ирдэг.

Амьдралын зарим асуудал сурах ёстой сургамжаа авсны дараа арилдаг. Цэвэршүүлэгч нэгэн хайлсан металл дээр Өөрийнх нь дүр тодорч эхлэхийг хараад тунгаан цэвэршүүлэх галын илчийг багасгадаг. Бидний ихэнх нь амьдралын дарамтыг Бурханы өнцгөөс харах мэргэн ухаанаар дутдаг. Бид юмсыг богино ухаанаар бодож, шууд л сэтгэлээр унадаг. Ингэснээр Бурхан биднийг дарамтаар дамжуулан төлөвшүүлэн тэлэх зорилгоо алгуурхан хэрэгжүүлж байгааг умартдаг (Дуу 4:1).

1:5 Амьдралын асуудлуудтай бид өөрсдийн мэргэн ухаанаар тулах албагүй. Соригдож байхдаа сүнслэг мэргэн ухаанаар дутвал Бурхан руу очиж, өөрсдийн эргэлзээ тээнэгэлзээ, ойлгож мэдэхгүй байгаа бүхнээ Түүнд илэн далангүй хэлэх хэрэгтэй. Соригдож байхдаа Бурханы зорилгыг мэдэх гэж тийнхүү хичээдэг хүн бүхэн өгөөмрөөр шагнуулах болно. Мөн Бурхан зэмлэнэ гэж санаа зовох хэрэггүй. Сурах эрмэлзэлтэй, дуулгавартай байдал маань Түүнд таалагдана. Бид бүгд **мэргэн ухаанаар** дутдаг. Библи амьдралд тулгардаг тоо томшгүй олон асуудал бүрд *тусгайлан* зориулсан хариулт өгдөггүй. Гэхдээ нарийн тодорхой үг хэллэгээр асуудлыг шийдэж өгдөггүй ч Бурханы үг бидэнд ерөнхий зарчмуудыг зааж өгдөг. Тэр зарчмуудыг бид өдөр тутмын амьдралын нөхцөл байдалдаа тохируулан хэрэглэж сурах хэрэгтэй. Тиймээс л бидэнд мэргэн ухаан хэрэгтэй болдог. Сүнслэг мэргэн ухаан гэдэг нь Эзэний сургаалуудыг өдөр бүрийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх ухаан юм.

1:6-8 Бурхан руу бид **ямар ч эргэлзээгүйгээр** очих хэрэгтэй. Тэрээр хайрлан халамжлахаас гадна Түүнд боломжгүй зүйл гэж үгүй гэдэгт бид итгэх ёстой. Бид Түүний сайн сайхан, хүч чадалд эргэлзвэл хүнд хэцүү цаг ирэхэд гуйвахгүй тогтвортой байж чадахгүй. Өөрөөр хэлбэл, Түүний амлалтад хэсэгхэн хором итгэж, амар тайван байснаа удалгүй Бурхан намайг мартжээ гэж түгшинэ гэсэн үг. Бид яг л салхиар туугдан давлагаалах **тэнгисийн долгио** мэт дээш өндөрт хөөрч, гэнэтхэн айн түгшиж, доош унан савлана. Нэг бол өөдрөгөөр болж эс бол гутарч гуньхардаг тогтворгүй итгэл Бурханд хүндэтгэл авчирдаггүй. Ийм гуйвж дайвсан, тогтворгүй хүнд Бурхан сүнслэг ойлголтыг өгдөггүй (7, 8-р эшлэл). Мэргэн ухааны эх үүсвэр бол Бурхан гэдгийг 5-8 дугаар эшлэлд хэлж байна. Мөн энэ мэргэн ухааныг залбирлаар, хүн бүр чөлөөтэй авах боломжтой, өгөөмрөөр буруушаалгүйгээр

өгөгддөг. Гол болзол нь **ямар ч эргэлзээгүйгээр итгэлээрээ гуйх** явдал юм.

1:9 9-11 дүгээр эшлэлийг өнгөцхөн харвал цоо шинэ сэдвийг танилцуулсан мэт санагдана. Гэвч Иаков тодорхой зураглалууд ашиглан ариун сорилтын тухай сэдвийг үргэлжлүүлэн хөндөж байна. Хүн ядуу ч бай, баян ч бай амьдралд тулгарах зовлон бэрхшээл, хямралаас сүнслэг ашиг тусыг хүртэх боломжтой. Жишээлбэл, **эгэл дорд ах дүү** нь сэтгэл дундуур болж, урам хугарвал Бурханы өв залгамжлагч, Есүс Христийн хамтран өв залгамжлагч гэдгээ санахдаа баярлан хөөрч болно. Тийм хүн бүх зүйл түүнийх, тэр өөрөө Христийнх, Христ Бурханых гэсэн үнэнээс тайтгарлыг авах боломжтой. **Эгэл дорд ах дүү** нь дорой нөхцөл байдлаа өөрчилж чадахгүй ч байж мэднэ. Түүнийг залхуу, хайнга гэж үзэх үндэслэл байхгүй. Бурхан түүнийг бага орлоготой амьдрах нь зохистой гэж үзсэн тул ийм байсаар ирсэн ч юм бил үү. Тэр баян байсан бол Христийг хэзээ ч хүлээн авахгүй байсан байж мэднэ. Одоо тэр Христ дотор байгаа тул тэнгэр дэх бүх сүнслэг ерөөлөөр ерөөгджээ. Тэгвэл тэр юу хийх хэрэгтэй вэ? Амьдралынхаа нөхцөл байдалд тэрсэлж, эсэргүүцэл гаргах ёстой юу? Атаархаж жөтөөрхөх ёстой юу? Үгүй ээ. Харин өөрөөс нь үл шалтгаалж Бурханы өгсөн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч, сүнслэг ерөөлүүддээ баярлах ёстой.

Дэндүү олон христитгэгч хүн нас хүйс, биеийн өндөр, тэр ч байтугай өгөгдсөн амьдралдаа дургүйцэн тэрсэлдэг. Сагсан бөмбөгт эвсэлтэй охид өөрсдийгөө хөвгүүн байсан ч болоосой гэж хүсдэг. Залуу хүмүүс настай болохыг хүсэж, настай хүмүүс нь залуу болохыг хүсдэг. Намхан хүмүүс өндөр хүмүүст атаархаж, өндөр хүмүүс нь бусдаас содон өндөр байхыг хүсдэггүй. Зарим хүн “Би үхсэн ч болоосой!” гэж хэлэх нь бий. Энэ бүхэн бүгдээрээ утга учиргүй мунхаглал юм. Христитгэгчид өөрчилж чадахгүй зүйлийнхээ төлөө Бурханд бууж өгөх хандлагатай байх

ёстой. Тэдгээр нь Бурханаас бидэнд өгөгдсөн хувь тавилан тул үүгээрээ Бурханыг алдаршуулж, бусдыг ерөөхийн тулд хамаг чадлаараа хичээх хэрэгтэй. Бид элч Паултай адил “Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон” (1Ко 15:10) гэж хэлэх хэрэгтэй. Бид өөрсдийн сул дорой байдлаа умартан бусдад үйлчлэхэд гол анхаарлаа хандуулбал сүнслэг хүмүүс биднийг гадаад дүр төрхөөр маань бус хэн гэдэг мөн чанараар маань хайрлаж буйг анзаарч эхэлнэ.

1:10, 11 Дараа нь Иаков баян хүний тухай ярьж эхлэв. Хачирхалтай нь, “Баян хүн эд баялагтаа баярлан хөөр” гэж тэр хэлсэнгүй. Харин **“Баян хүн дордохуйдаа сайрхаг”** гэжээ. Иаков, Иеремиа 9:23,24-тэй санал нэгджээ:

Мэргэн хүн мэргэн ухаанаараа, хүч чадалтай хүн хүч чадлаараа, баян хүн нь эд баялгаараа бүү сайрхаг. Харин сайрхагч нэгэн нь Намайг ЭЗЭН гэж мэдэж ойлгодгоороо гагцхүү сайрхаг. Хайр энэрэл, шударга ёс, зөв шударгыг дэлхий дээр хэрэгжүүлдэг Би ЭЗЭН. Учир нь Би үүнийг таалдаг гэж ЭЗЭН тунхаглаж байна.

Баян хүн материаллаг эд хөрөнгөө алдсан тохиолдолд баярлах жинхэнэ шалтгааныг олж мэднэ. Магадгүй бизнесийн бүтэлгүйтэл нь түүнийг Эзэн рүү хөтөлж болох юм. Харин тэр аль хэдийн итгэгч болсон бол тэнгэрт илүү сайн, мөнхийн хөрөнгөтэй гэдгээ мэдэн баярлан хөөрч чадна (Евр 10:34). Энэ ертөнцийн эд баялаг **өвс ногооны цэцэг мэт** өнгөрөн одох тавилантай (Иса 40:6, 7). Хүн материаллаг эд баялгаас өөр юу ч үгүй бол түүний төлөвлөгөө өөртэй нь хамт булшлагдана. Иаков баян хүний амьдралын хэврэг байдал, эд баялгийн зуурдын үнэ цэнийг харуулахын тулд **өвс ногооны** хоромхон зуур хагдран алга болдог шинж чанарыг иш татан дүрсэлжээ. Тэрээр **замдаа** тийнхүү **үрэгдэх болно**. Мэдээжийн хэрэг, сүнслэг үнэт

зүйлийг нар, салхи муутгаж чадахгүй гэдгийг голчлон хэлэх гэсэн биз ээ. Биднийг өнгөрөн одох зүйлсийг хайрлах хайраас салгаж, дээгүүрх зүйлс рүү хандуулдаг сорилтууд нь ерөөл билээ. Ийнхүү доордсыг өргөмжилдөг тэрхүү нигүүлсэл баяныг даруу болгодог ажээ. Аль аль нь баярлах шалтгаан мөн.

1:12 Иаков ариун сорилтын талаарх яриагаа сорилтыг тэсвэрлэдэг хүний дээр ерөөлийг тунхаглан төгсгөв. Тийм хүн шалгуураа даваад **амийн титмийг хүлээн авна**. Энд гарч буй **титэм** нь хааны титэм биш, харин Христийн шүүх суудлын өмнө шагнуулах ялагчийн цэцгэн хэлхээ юм. Мэдээжийн хэрэг, сорилтыг тэвчсэний шагналд мөнхийн амийг авна гэсэн санаа энд байхгүй. Харин сорилтыг зоригтой тэсвэрлэсэн хүн мөнх аминд хүндэтгэлийг хүртэж, тэнгэрт уг амийг дээд зэргийн талархалтайгаар эдлэх юм. Тэнгэрийн улсад хүн бүрийн аяга дүүрэн байх боловч хэмжээ нь өөр өөр байна. Тэнгэрийн алдар сууг эдлэх чадамж нь харилцан адилгүй байна гэсэн үг. **Амийн титэм** гэдэг илэрхийлэл чухам үүнийг илэрхийлж байгаа бололтой. Амийн титэм авсан хүн тэнгэрийн цог жавхланг бүрэн дүүрэн, гүн гүнзгий эдлэх тухай аж.

Одоо бүгдээрээ ариун сорилтын тухай энэхүү хэсгийг өөрсдийн амьдралд ойр, бодитой болгоцгооё. Амьдралд маань янз бүрийн сорилт ирэхэд бид хэрхэн хариу үйлддэг вэ? Амьдралын зовлон зүдүүрийн эсрэг гашуунаар эсэргүүцэн гомдолдог уу? Эсвэл тэдгээрийн төлөө Эзэнд талархаж, баярлан хөөрдөг үү? Соригдож байгаагаа сурталчилдаг уу? Эсвэл чимээгүйхэн шүд зуун тэвчдэг үү? Нөхцөл байдал сайжирна хэмээн болоогүй ирээдүйг хүсэн хүлээж амьдардаг уу? Эсвэл бидэнд тохиож буй бүгдэд Бурханы мутар хүрэхийг хүлээн одоо цагтаа амьдардаг уу? Бид өөрсдийгөө өрөвдөж, бусдаар өрөвдүүлэхийг боддог уу? Эсвэл бусдын төлөө үйлчлэхэд гол анхаарлаа хандуулдаг уу?

1:13 Сэдэв маань одоо ариун бус уруу татлага руу шилжиж байна (13-17 дугаар эшлэл). Ариун сорилтууд нь бидний дотроос сайныг гаргах зорилготой байсан бол ариун бус уруу татлага нь бидний дотроос мууг гаргадаг. Энд нэг зүйлийг тодорхой ойлгох хэрэгтэй. Бид гэм нүгэлд **уруу татагдах** үедээ тэрхүү уруу татлага **Бурханаас** ирдэггүй гэдгийг санах хэрэгтэй. Бурхан хүний итгэлийг шалгаж сорьж болох ч хүнийг бузар мууг үйлдүүлэхэд хэзээ ч уруу татдаггүй. **Тэр Өөрөө** бузар муу зүйлтэй огт холбоогүй бөгөөд хүнийг нүгэлд өдөөдөггүй.

1:14 Хүн нүглийнхээ хариуцлагыг үргэлж бусдад тохох хандлагатай байдаг. Хэрэв Бурханыг буруутгах шалтаггүй болбол, нүгэл бол өвчин гэх орчин үеийн сэтгэлзүйн үзэл санааг ашиглана. Ингэж шүүлтээс мултрах найдлага тээнэ. Гэвч нүгэл бол өвчин биш. Харин хүний заавал хариуцлага хүлээх учиртай ёс суртахууны доройтол юм. Тэр ч байтугай, зарим нь нүглийнхээ төлөө амьгүй зүйлсийг буруутгах гэж хичээдэг. Гэвч материаллаг “зүйлс” өөртөө нүглийг агуулдаггүй. Нүгэл тэндээс үүсдэггүй. **“Харин тачаалдаа автаж, татагдахдаа хүн бүр уруу татагддаг”** гэж хэлснээрээ Иаков арслангийн үүрийг зааж өгч байна. Нүгэл бидний дотроос, өвөг дээдсээс өвлөж авсан хуучин хүнээс, дахин төрөөгүй мөн чанараас гарч ирдэг. Есүс, “Зүрхнээс ёрын бодол, аллага, завхайрал, садарлал, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг гардаг” гэж хэлсэн (Мт 15:19).

14-р эшлэлд Иаковын хэрэглэсэн **хүсэл**¹ гэх үг нь сайн, муу хүслийн аль алийг илэрхийлдэг. Энэ нь ёс суртахууны хувьд саармаг утгатай үг. Гэхдээ цөөн хэдэн тохиолдлыг эс тооцвол ШГ-д ихэвчлэн муу муухай хүслийг илэрхийлсэн байдаг бөгөөд энд ч ялгаагүй. Хүсэл тачаалыг энд бузар муу эмэгтэйтэй адилтгажээ. Тэр эмэгтэй гоо үзэсгэлэнгээрээ хохирогчдоо уруу татдаг. Бид бүгд түүнд уруу татагддаг. Бидэнд нүгэл үйлдэхийг хүсдэг бузар шунал хүсэл, ариун бус хүсэл тачаал байдаг. Тэгвэл бид

хүсэл **татаалдаа автаж, татагдахдаа** юу ч хийж чадахгүй хохирогчид гэж үү? Үгүй. Бид нүгэлт бодлуудыг оюун санаанаасаа хөөн зайлуулж, цэвэр бас ариун зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлж чадна (Флп 4:8). Мөн уруу татлагад хүчтэй орох мөчдөө Эзэнийг дуудаж, “ЭЗЭНий нэр бат цамхаг. Зөвт нь гүйн ороод аюулгүй” (Сур 18:10) гэдгийг санах хэрэгтэй.

1:15 Уруу татлагыг даван дийлэх боломжтой юм бол бид яагаад нүгэл үйлддэг вэ? Хариулт нь энд байна: **Тэгээд тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг.** Нүгэлт бодлуудыг бид оюун санаанаасаа хөөн зайлуулахын оронд тэжээн тэтгэж, өөхшүүлдэг. Үүнийг бэлгийн харьцаатай адилтган зүйрлэжээ. Тачаал нь үр тогтоож, НҮГЭЛ гэдэг хүүхдийг төрүүлдэг. Бид хориглосон зүйлийг бодол сэтгэлдээ удаан тээвэл эцэстээ үйлдэл болох нь зайлшгүй. Тачаал нь үр тогтоон нүглийг төрүүлдэг үйл явцыг Давид, Батшеба хоёрын түүхээс тодорхой харж болно (2См 11:1-27).

Нүгэл нь гүйцэд болохоороо үхлийг гаргадаг аж гэж Иаков хэлжээ. Нүгэл нь хүүсэр, үр тогтоох чадваргүй биш ээ. Харин өөрийнхөө үр удмыг үлдээдэг ажээ. **Нүгэл үхлийг гаргадаг** гэсэн өгүүлбэрийг хэд хэдэн утгаар ойлгож болно. Юун түрүүнд, Адам нүгэл үйлдсэнээрээ өөртөө болон бүх үр удамдаа бие махбодын үхлийг авчирсан (Эх 2:17). Цаашилбал, нүгэл нь мөнхийн, сүнслэг үхэлд хүргэдэг. Сүнсний үхэл гэж Бурханаас болон ерөөлөөс салдаг эцсийн шийтгэл юм (Ром 6:23а). Нүгэл нь итгэгч хүнийг үхэлд хүргэдэг гэсэн утга бас бий. Жишээлбэл, зугацан амьдрагч бэлэвсэн эмэгтэй амьд боловч үхсэн байна гэж 1Тимот 5:6 дээр бичигдсэн байдаг. Тэрээр амьдралаа дэмий хоосон үрж, өөрийг нь аварсан Бурханы зорилгыг гүйцэлдүүлэхгүй байна гэсэн үг. Бурхантай нөхөрлөхгүй байна гэдэг нь христитгэгчийн хувьд үхмэл амьдарч байгаа хэрэг.

1:16, 17 Хүн нүгэл үйлдчихээд өөрийгөө буруутгахын оронд Бурханыг буруутгах нь хэвийн үзэгдэл. Тэд Бүтээгчдээ хандан, “Та яагаад намайг ингэж бүтээсэн юм бэ?” гэдэг. Гэвч энэ бол өөрийгөө хуурч байгаа хэрэг юм. Бурханаас зөвхөн сайн бэлгүүд л ирдэг. Үнэндээ Бурхан л **аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлгийн** эх сурвалж шүү дээ.

Иаков Бурханыг **гэрлүүдийн Эцэг** гэж дүрсэлсэн байдаг. Библид *Эцэг* гэдэг үг заримдаа Бүтээгч эсвэл Эх сурвалж (Иов 38:28) гэсэн утгыг илтгэдэг. Тиймээс Бурхан бол **гэрлүүдийн** Бүтээгч ба Эх сурвалж мөн. Гэхдээ **гэрлүүд** гэдгээр юуг илэрхийлж байна вэ? Мэдээж тэнгэрийн эрхсүүдийг буюу нар, сар, оддыг хэлж байгаа (Эх 1:14-18; Дуу 136:7). Түүгээр ч зогсохгүй Бурхан бас бүхий л сүнслэг гэрлийн Эх сурвалж гэдгийг илтгэж байна. Тиймээс орчлон ертөнц дэх бүхий л гэрлийн Эх сурвалж бол Тэр мөн гэж бид бодох учиртай. **Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй.** Бурхан Өөрийнхөө бүтээсэн тэнгэрийн эрхсүүдтэй адилгүй. Тэнгэрийн эрхсүүд байнга хувьсан өөрчлөгддөг. Гэтэл Бурхан хэзээ ч өөрчлөгддөггүй. Иаков нар сар, оддын гэрэл гэгээ буурч байгаагаас гадна манай гарагийн эргэлтийн улмаас тэдний гэрлийн тусгал хэрхэн өөрчлөгдөж байдгийг бодож ярьсан болов уу. Хувьсал өөрчлөлт нь нар, сар, оддын нэг шинж чанар. **Өөрчлөгдөх сүүдэр** гэж дэлхийн эргэлтийн улмаас үүсдэг сүүдрийг хэлсэн байж болох юм. Эсвэл нар сарны хиртэлтийг хэлж байж болно. Жишээлбэл, сарны сүүдэр дэлхий дээр тусахад нар хиртдэг. Харин Бурхан үүнээс огт өөр. Түүнд ямар ч өөрчлөлт үгүй. Түүнд өөрчлөгдөх **сүүдэр** ч гэж байхгүй. Мөн Түүний бэлгүүд нь Өөртэй нь адил **төгс** билээ. Тиймээс Бурхан хүнийг нүгэл үйлдэхэд уруу татсан гэж хэзээ ч бодож боломгүй. Хүн өөрийнхөө бузар мөн чанараас болж уруу татагддаг.

Ариун бус уруу татлагын тухай сэдэв дээр өөрсдийн итгэлийг шалгацгаая. Бид ёрын муу бодолд автаж байна уу эсвэл хурдан хөөн зайлуулж байна уу? Бид нүгэл үйлдчихээд зайлж чадсангүй гэж хэлж байна уу? Нүгэлд уруу татагдчихаад Бурханыг буруутгаж байна уу?

III. БУРХАНЫ ҮГ (1:18-27)

Иаков Бурханыг гэрлүүдийн Эцэг гэж хэлсээр байлаа. Харин одоо Бурханыг бас бидний Эцэг гэдгийг сануулж байна. Мөн Тэр бидэнд Өөрийн агуу бүтээлийн дотроос онцгой үүрэг оноосон гэж байна. Бид үнэний үгэнд дуулгавартай байснаар тэрхүү үүргийг биелүүлж чадна (19-27 дугаар эшлэл).

1:18 Энэ хэсэгт Ариун Сүнсээр дамжуулан үйлчилдэг Бурханы үг биднийг шинээр төрөхөд ямар үүрэг гүйцэтгэдгийг тоймлон харуулж байна. Энэ үйл явцыг энэ эшлэлд **“Тэр хүслээрээ биднийг үнэний үгээр төрүүлэв. Ингэснээр бид Түүний бүтээлүүдийн анхны үр жимс нь болох юм”** гэжээ. Тэр хүслээрээ гэдэг үг Тэр юунаас болж биднийг аврахад хүрснийг өгүүлж байна. Бид гавьяа зүтгэлтэй учраас Тэр аврахаас өөр аргагүй болсон юм биш. Харин Бурхан сайн дураараа, хүслийнхээ улмаас биднийг аварчээ. Түүний хайр бидний хүсэл зориг, гавьяа зүтгэл, үнэ цэн дээр суурилаагүй, бүрэн дүүрэн Түүний хүсэл зоригийн улмаас байсан юм. Үүний төлөө бид Бурханыг хүндэлж мөргөх учиртай! **Тэр биднийг төрүүлсэн** гэдэг үг шинэ төрөлтийг илэрхийлж байна. Энэхүү сүнслэг төрөлтөөр дамжуулан бид Бурханы хүүхэд болдог. Нэгэнт төрсөн бол буцааж болдоггүй учраас Бурхантай тогтоосон энэ шинэ харилцаа хэзээ ч хувирахгүй. **Үнэний үгээр** гэдэг нь Библи шинэ төрөлтийг бий болгох зэмсэг гэсэн утгатай. Хүн Христэд жинхэнээсээ итгэсэн тохиолдол бүрд Бичвэр аман хэлбэрээр ч бай, бичмэл хэлбэрээр ч бай зайлшгүй нэг үүрэг гүйцэтгэсэн

байдаг. Библи байхгүй бол бид авралын замыг мэдэж чадахгүй байх байсан. Үнэндээ, аврал байдаг тухай ч мэдэж чадахгүй байсан!

Ингэснээр бид Түүний бүтээлүүдийн анхны үр жимс нь болох юм. Энд яригдаж буй **анхны үр жимс** гэдэг үгтэй холбоотой гурван чухал санаа бий. Нэгдүгээрт, хураасан буудайны анхны багц юүж. Иаков харьд тархсан христитгэгчдийн дундаас анхан үеийн итгэгчдэд хандан бичиж байлаа. Мэдээж, итгэгч бүхэн Түүний **бүтээлүүдийн анхны үр жимс** мөн боловч Иаков юун түрүүнд иудей христитгэгчдэд хандан бичжээ. Хоёрдугаарт, Бурханы ивээл ерөөлд талархлаа илэрхийлэн бүх зүйл Түүнээс ирдэг, Түүнийх гэдгийг хүлээн зөвшөөрч **анхны үр жимсийг** өргөдөг байлаа. Тиймээс бүх итгэгчид өөрсдийгөө амьд тахил болгон Бурханд өргөх ёстой (Ром 12:1, 2). Гуравдугаарт, **анхны үр жимс** нь цааш цаашдын арвин их ургацын баталгаа болдог байв. Иаков уншигчдаа Христийн ургацын анхны юүжилсэн багцтай зүйрлэж байна. Тэдний араас зуун зууны турш олон хүн даган ирэх боловч тэд өөрсдөө шинэ бүтээлийн үр жимсийг харуулах ариун хүмүүсийн загвар болон тодорчээ. Эзэн яваандаа газар дэлхийг тэдэн шиг хүмүүсээр дүүргэнэ (Ром 8:19-23). Эзэн Есүс дэлхийг захирахаар эргэн ирээд ургацаа бүрэн хураана. Харин тэр мөчийг хүртэл мянган жилийн хаанчлалд бүх дэлхий Христэд хэрхэн захирагдахтай адил тэд ч тийнхүү дуулгавартай захирагдах хэрэгтэй. Хэдийгээр энэхүү эшлэл нэгдүгээр зууны христитгэгчдэд хандсан ч Христийн нэрийг хүндэтгэдэг хүн бүрд хамаатай.

1:19а Энэ бүлгийн үлдсэн хэсэгт Түүний бүтээлийн анхны үр жимс ямар байх ёстой талаар амьдралд ойр зааварчилгааг өгчээ. Үнэний үгээр дахин төрсөн хүмүүс зөвт байдлыг амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэхийг энд зааж өгчээ. Бид Бурханы үнэнийг илчлэн харуулахын

тулд бид үгээр төрсөн билээ. **Тиймээс**² одоо бүгдээрээ үүрэг хариуцлагаа биелүүлцгээе.

Бид **сонсохдоо түргэн** байх хэрэгтэй. Энэхүү этгээд гэмээр тушаал, хошигнол ч юм шиг сонсогддог. “Яараарай бас сонсоорой!” гэж хэлж байгаа гэлтэй. Энэ тушаалын утга нь Бурханы үгийг болон бурханлаг зөвлөгөө, сэрэмжлүүлгийг сонсоход бэлэн байх хэрэгтэй гэсэн үг. Бид Ариун Сүнсээр сургагддаг байх хэрэгтэй. Бид **ярихдаа удаан** байх хэрэгтэй. Иаков бидний хэл ярианы талаар үнэхээр ихийг өгүүлсэн нь гайхалтай! Тэрээр биднийг бусадтай харилцан ярилцахдаа хянуур байхыг анхааруулж байна. Төрөлх байдал ч үүнийг зааж өгдөг. Эртний грекийн философич Эпиктет, “Байгаль эх хүнийг их сонсож бага ярь гэж хоёр чих, нэг ам заяажээ” хэмээсэн байдаг. Соломон хүртэл Иаковтой бүрэн дүүрэн санал нийлэх байлаа. Соломон нэгэнтээ, “Амаа захирах нь амийн хамгаалалт. Уруулаа ангалзуулах нь сүйрэл” (Сур 13:3) гэж хэлсэн юм. Мөн “Үг олшроход нүгэл зайлшгүй. Харин амаа захирдаг хүн мэргэн нэгэн юм” (Сур 10:19 АБ2004) гэжээ. Хяналтгүй, хэт их ярьдаг хүмүүс эцэстээ нүгэлд унадаг.

1:19б, 20 Бид уур хилэндээ хойрго байх хэрэгтэй. Түргэн ууртай хүн **Бурханы** хүүхдүүдээсээ хүсэн хүлээдэг **зөвт байдлыг** хэрэгжүүлдэггүй. Уураа барьдаггүй хүн бусдад христитгэлийн талаар буруу ойлголтыг өгдөг. “Уурлахдаа удаан хүн хатан зоригтноос дээр. Сүнсээ захирдаг хүн хотыг эзлэгчээс дээр” гэж бичигдсэн нь өнөөдөр ч үнэн хэвээр байгаа (Сур 16:32).

1:21 Бурханы бүтээлийн анхны үр жимс гэдгээ илчлэн харуулах өөр нэг арга бол **бүх бузар байдал, хорон санааныхаа бүх л үлдэгдлийг хаях** явдал мөн. Эдгээр гэм нүглийг нэг мөсөн тайлж хаях ёстой бохирдсон хувцастай зүйрлэдэг. **Бузар байдал** гэдэг нь сүнсний, оюун санааны, бие махбодын хувьд ариун бус байх бүхий л хэлбэрийг

хэлнэ. **Хорон санааны үлдэгдэл** гэдэг нь итгэхээс өмнөх бузар муугийн үлдэгдлийг хэлж байгаа бололтой. Мөн бидний амьдралд ул мөр нь үлдсэн, бусдын амьдралд нөлөөлж болзошгүй нүглийн үлдэгдлийг хэлсэн байж ч болох юм. Эсвэл хаа сайгүй дэлгэрсэн ёс бус явдлыг хэлж байж болох юм. Энэ тохиолдолд ёс бусын хэр хэмжээг бус, харин муу ёрын шинж чанар нь хэр гүн гүнзгий болохыг онцолж байгаа хэрэг. Ямартай ч гол санаа нь тодорхой байна. Бурханы үгийн үнэнийг хүлээн авахын тулд бид цэвэр ёс суртахуунтай байх ёстой.

Тэнгэрлэг үнэнийг хүлээн авах дараагийн нэг шаардлага нь **дөлгөөн** байдал юм. Библийн санааг хүлээн авахгүй мөртлөө зүгээр л уншдаг хүмүүс байна. Нөлөөг нь авалгүй боловсрол авах хэмжээнд судалдаг хүмүүс ч байна. Бардам зан, хатуу сэтгэл, гэм нүглээс минь болоод Библийн үг зүрх сэтгэлд минь ордоггүй. Улмаар Библийн үгэнд хариу үйлдэл гаргах ч үгүй байх нь бий. Гагцхүү даруу, дуулгавартай сэтгэлтэй хүн л Бичвэрийн ашиг тусыг бүрэн дүүрэн хүртэнэ. “Тэрээр даруу хүнийг шударгаар удирдаж, тэдэнд замаа сургадаг” (Дуу 25:9). “Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй, үгэнд минь чичирдэг нэгнийг л Би анхаарна” (Иса 66:2).

Иаков **Бичвэрийг дотор чинь суулгагдсан, сэтгэлийг чинь аврах чадалтай үг** хэмээжээ. Эндээс харвал хүн дахин төрөх үед Бурханы үг дотор нь ариун барьцаа болон суулгагддаг ажээ. Библийн RV орчуулгын тайлбар дээр энэ үгийг “төрөхөөс чинь байсан үг” гэж бичжээ. Бурханы үг **сэтгэлийг аврах чадалтай**. Бурхан хүнийг шинээр төрүүлэхэд Библийг зэмсэг болгон ашигладаг. Бурхан Библийг ашиглан хүнийг нүглийн шийтгэлээс авраад зогсохгүй нүглийн хүчээс ч бас авардаг. Бурхан Библийг ашиглан хүнийг мөнхийн хараалаас авраад зогсохгүй **энэ амьдралд**³ хохирол амсахаас авардаг. Иаков 21-р эшлэлд

авралын энэхүү өнөөгийн тасралтгүй үргэлжлэх шинж чанарыг онцлон хэлж байгаа нь дамжиггүй байна.

1:22 Суулгагдсан үгийг хүлээж авах нь дангаараа хангалтгүй. Бид үүнийг дуулгавартай дагаж мөрдөх ёстой. Библийг олж аваад зүгээр нэг уран зохиолын ном мэт унших нь ямар ч үр ашиггүй. Харин Бурханы айлдаж буйг сонсож, юу ч айлдсан бай дуулгавартай дагах чин хүсэл байх нь чухал. Бид Библийг үйлдэл болгон амилуулах хэрэгтэй. Үг нь бидний амьдралд махбод болон илрэх ёстой. Бид Бичвэрийг уншсанахаа дараа амьдралыг маань илүү дээр болгож өөрчлөх нөлөөг авалгүй өнгөрч болохгүй. Бурханы үгийг таньж мэдэх тусам зан чанар маань Эзэн Есүстэй адил болж өөрчлөгдөхгүй л бол Бурханы үгийг хайрладаг, Библийн судлаач байхын ашиг тус гэж үгүй. Энэ нь өөрийгөө мэхэлж буй хэрэг болно. Үгийг нь дуулгавартай дагалгүй Библийн тухай мэдлэгээр тархиа цэнэглэх нь ерөөл гэхээс илүүтэй занга болж болно. Бид хийх ёстой зүйлээ мэдсээр байж үйлдэхгүй бол сэтгэлээр унан цөхөрч, хөндий хүйтэн болдог. “Хэрэгжүүлдэггүй их ухаарал эцэст нь сэтгэл гутралд хүргэдэг.” Ихийг мэдэх тусам Бурханы өмнө илүү хариуцлага үүрэх хэрэгтэй болно. Үгийг уншаад хэрэгжүүлдэг байх нь л хамгийн төгс хослол мөн.

1:23, 24 Үгийг сонсоод зан чанараа өөрчилдөггүй нэгэн өглөө бүр толинд өөрийгөө хурдхан шиг харчхаад **ямар байснаа бүрэн мартдаг хүнтэй адил юм.** Тэрээр толинд харахын ашиг тусыг гаргадаггүй нэгэн аж. Мэдээж бидэнд өөрчлөхийн аргагүй гадаад үзэмж гэж бий. Гэхдээ бид толинд царайгаа харахдаа ядаж л даруу зангаар хандах учиртай! Толь “нүүрээ угаа,” “сахлаа ав,” “үсээ самна,” “шүдээ угаа” гэж хэлбэл бид дагах хэрэгтэй шүү дээ. Тэгэхгүй бол толь бидэнд бодитоор ашиг тусаа өгөхгүй.

Библийг юу ч бодолгүй, уншиж байгаагаа хэрэгжүүлэх санаагүй, унших ёстой гэсэн хандлагаар унших амархан л

даа. Бид ямар байх ёстойгоо Библиэс хардаг ч тун удахгүй уншсанаа мартаж, аль хэдийнээ төгс болчихсон мэт амьдарна. Өөртөө ийнхүү сэтгэл хангалуун байх нь сүнслэг өсөлтийг хязгаарладаг.

1:25 Эсрэгээрээ, Бурханы үгийг **үзэн**, сурснаа дадал болгон хэрэгжүүлдэг хүн бий. Түүний тунгаан бодож, эргэцүүлэх үйлдэл нь амьдралд нь бодит үр дүн авчирдаг. Библи түүний хувьд **эрх чөлөөний төгс хууль** юм. Библийн зарчмууд түүнд ачаа дарамт болдоггүй. Учир нь шинэ хүнийх нь хийх дуртай зүйлийг Библи хэлж өгнө. Тэрээр Библийн үгийг дагаж байхдаа хүний ёс заншил, махбодын цэцэрхлээс ангижирч, жинхэнэ эрх чөлөөг олдог. Үнэн түүнийг чөлөөлдөг. Ийм хүн Библийн ашиг тусыг хүртдэг. Тэрээр уншсанаа мартдаггүй. Харин өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээдэг. Түүний хүүхэд шиг энгийн дуулгавартай байдал сэтгэл зүрхэнд нь асар их ивээл ерөөлийг авчирдаг. **Түүгээр байдаг нь үйлсдээ ерөөгдөх болно.**

1:26, 27 Ашиггүй сүсэглэлийг цэвэр бөгөөд бузартаагүй сүсэглэлтэй харьцуулжээ. Энд сүсэглэл гэдгээр итгэл үнэмшилтэй холбоотой биеэ хэрхэн авч явах байдлыг хэлжээ. Дотоод сэтгэлийг бус, гадаад хэлбэрийг хэлж байна. Баримталдаг онол сургаалыг бус хүндлэл мөргөл ба үйлчлэл гэх мэтээр илэрдэг итгэлийн гадаад илэрхийллийг хэлж байна гэсэн үг.

Хэн нэгэн нь өөрийгөө сүсэгтэй хэмээн боддог хэдий ч хэл амаа захирч чаддаггүй бол сүсэглэл нь ашиггүй ажээ. Өөрийг нь маш шүтлэгтэй харагдуулах олон янзын шашинлаг ёслолуудад оролцдог байж болох ч тийм хүн өөрийгөө л хуурч байгаа аж. Бурхан зан үйлд сэтгэл ханадаггүй. Харин бурханлаг амьдралыг л сонирхдог.

Хазаарлаагүй хэл нь хоосон **сүсэглэлийн** нэг жишээ юм. Христитгэлд үл нийцэх амьдралын аливаа хэв маяг ямар ч үнэ цэнгүй. Сүсэгт хүний дүртэй хүнсний

дэлгүүрийн эзний тухай түүх байдаг. Тэрээр дэлгүүрийнхээ дээд давхарт амьдардаг байж л дээ. Тэрээр өглөө бүр туслахаа дээрээс “Жон!” гэж дуудна.

-За, ноёнтоон!

-Чи сүүн дээр ус хийсэн үү?

-Тийм ээ, ноёнтоон.

-Цөцгийн тосыг өнгө оруулсан уу?

-Тийм ээ, ноёнтоон.”

-Кофенд орлуулагч хольсон уу?”

-Тийм ээ, ноёнтоон.”

-Маш сайн байна. Дээшээ гараад ир. Өглөөний чимээгүй цагаа хийе.

Иаков ийм сүсэглэлийг ямар ч ашиггүй гэж хэлж байна.

Бусдыг энэрч, өөрийн амьдралыг цэврээр сахидаг бодит сүсэглэлийг Бурхан эрэн хайдаг. **Цэвэр бөгөөд бузартаагүй сүсэглэлийн** жишээ болгон тусламж хэрэгтэй **өнчин хүмүүс, бэлэвсэн эмэгтэйчүүдийг** эргэж тойрон, өөрийгөө **ертөнцөөс бохирдуулахгүй** байдаг хүнийг Иаков магтжээ.

Өөрөөр хэлбэл, үнэхээр дахин төрсөн хүн “бусдыг энэрч, энэ ертөнцөөс өөрийгөө тусгаарладаг” ажээ. Гаи Кинг эдгээрийг амьдралд ойр, бодит хайр, ариун байдал хэмээн нэрлэсэн байдаг.

Бид дараах асуултуудыг өөрөөсөө асууж итгэлээ шалгах хэрэгтэй. Бурхан намайг зэмлэж, надад зааж, залруулаасай гэсэн даруу хүсэл сэтгэлээр би Библийг уншдаг уу? Би хэлээ хазаарлаагүй байх вий гэж санаа зовдог уу? Би уур хилэнгээ зөвтгөдөг үү эсвэл ялан дийлэхийг хүсдэг үү? Хэн нэгэн надад зохисгүй онигоо ярьж эхэлбэл би ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ? Надад эргүүлэн төлж чадахгүй хүмүүст өгөөмөр хандаж итгэлээ харуулж байгаа уу?

IV. ЯЛГАВАРЛАХЫГ БУРУУШААСАН НЬ (2:1-13)

Хоёрдугаар бүлгийн эхний хагаст хүмүүсийн ялгавартай хандах байдлыг буруутгасан байдаг. Ялгаварлах нь Эзэний үлгэрлэл, Шинэ гэрээний сургаал огт биш. Христитгэлд бусдыг дорд үзэх, ялгаварлан гадуурхах орон зай байхгүй.

2:1 Юун түрүүнд, энэ зуршлыг маш тодорхой хориглосон байна. Энэ сэрэмжлүүлгийг хамгийн эхлээд итгэгчдэд өгснийг анхаараарай. **“Ахан дүүс минь”** гэсэн үгнээс үүнийг баттай мэдэж болно. **Эзэн Есүс Христэд итгэх итгэл** гэдэг нь христитгэлийг хэлж байна. Энд бидэнд өгсөн итгэл, найдварт асуудал байгаа юм биш, харин Түүний бидэнд даалгаж өгсөн үнэнд оршиж байна. Тэгэхээр энэ бүх санааг нэгтгэн харвал Иаков, **“Ахан дүүс минь, христитгэлийг сахихдаа бусдыг бүү ялгаварлан, алагчил”** гэж хэлж байна гэсэн үг. Дээгүүр зиндааны хүнд тал засах, давхаргын ялгаа гаргах нь жинхэнэ христитгэлийн мөн чанарт нийцэхгүй. Алдрын Эзэний оршихуйн өмнө хүний агуу байдалд бялдуучлах нь байж боломгүй зүйл мөн. Хүнийг гарал үүсэл, арьс өнгө, нас хүйс, ядуу дорд байдлынх нь улмаас басамжлан доромжлох нь итгэлээ үгүйсгэснээс өөрцгүй хэрэг болно. Энэ тушаал нь итгэгчдийг эрх мэдэл бүхий хүмүүсийг буюу захирагч, эзэн, ахлагчид болон эцэг эхээ зохих ёсоор хүндэтгэхийг заадаг Шинэ гэрээний бусад хэсгүүдтэй зөрчилддөггүй. Бурханаас тогтоосон эрх мэдэл, байр суурийг хүндлэх нь зүйтэй (Ром 13:7). Харин энэ хэсэгт хээнцэр ганган хувцастай, бусдаас ялгарах дэгжин чамин байдлаар нь хүмүүст бялдуучлан хүндлэх асуудлыг хөндөж байна.

2:2-4 Үүнийг 2-4 дүгээр эшлэлд өгсөн нүдэнд харагдахуйц дүрслэл баталж байна. Гаи Кинг энэ хэсгийг “Харалган угтагч” гэж голыг нь олж нэрлэжээ. Үйл явдал

Христийн нэгэн **цуглаанд**⁴ болж байна. Загварлаг хувцастай, үнэтэй **алтан бөгжтэй**, бусдаас содон нэгэн эрхэм цуглаанд орж иржээ. Угтагч түүнд мэхийн ёслоод бусдаас содон өнөөх зочныг урд талын эгнээний хүндэт суудал руу дагуулан явав. Өнөөх угтагч төд удалгүй хаалга руу буцаж очтол өөр нэгэн зочин орж ирэв. Энэ удаад эгэл жирийн хувцастай **ядуу хүн** байв. (**Хиртэй хувцастай** гэсэн илэрхийлэмж нь тухайн хүний хувцас угааж цэвэрлэхгүй л бол болохгүй, бохир гэсэн санаа байх албагүй. Тухайн хүн борог ядуу амьдралаасаа болоод ядруухан хувцаслажээ.) Энэ удаад угтагч чуулганыг ичгүүртэй байдалд оруулахгүйн тулд зочныг танхимын арын хэсэгт зогсох эсвэл өөрийнхөө суудлын өмнөх шалан дээр суухыг урьж байна. Хэн нэгэн ийм үйлдэл гаргах нь итгэмээргүй санагдаж болох л юм. Энэ жишээ арай хэтрүүлэгтэй мэт санагдаж болох ч бид зүрх сэтгэл рүүгээ өнгийн харвал яг ийм ялгаварлал гаргадаг гэдгээ олж харна. Бид **ёрын бодолтой шүүгчид** ажээ.

Өнөөгийн чуулганаас хамгийн тод харагддаг ялгаварлан гадуурхлын нэг жишээ бол хүмүүсийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал мөн. Олон тохиолдолд өнгөт арьстай итгэгчдийг цуглаанд оруулдаггүй. Орууллаа ч дуртай дургүй хүлээж авна. Христэд итгэсэн иудейчүүдийг ер нь л таатай хүлээн авдаггүй. Дорнын христитгэгчид төрөл бүрийн ялгаварлал амссан байдаг. Арьс өнгөний асуудал нийгэмд нийтлэг бэрхшээл учруулж байгааг үгүйсгэх аргагүй. Гэвч христитгэгчид Бурханы зарчмыг үнэнчээр баримтлах ёстой. Христитгэгч хүний үүрэг бол итгэгч хүн бүгдээрээ Христ Есүс дотор нэг гэдэг үнэнийг амьдралаараа батлан харуулахад оршдог.

2:5, 6а Алагчлах хандлага христитгэлтэй яавч нийцэхгүй. Иаков үүнийг 5-13-р эшлэлд харуулсан байна. Итгэгчид баячуудад тал засаад ядуусыг дорд үзэх нь яагаад

буруу болохыг нотлох дөрвөн баттай шалтгааныг энд дурджээ.

Юун түрүүнд, ядуусыг ялгаварлах нь **Бурханы** хүндэлдэг хүнийг хүндэтгэхгүй байна гэсэн үг. **Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайрлагсдад амласан хаанчлалын өвлөгчид болгож, тэднийг итгэлдээ баян байлгахаар сонгосон.** Ядуус бол Бурханаар сонгогдсон, Бурханы хаант угсаа, Бурханы өв залгамжлагч, Бурханыг хайрлагсад билээ. Библийг харвал баян хүн биш, харин ядуу хүн Христийн тугийг өргөдөг гэж олон удаа бичигдсэн байдаг. Бидний Их Эзэн Өөрөө, “ядууст сайнмэдээ тунхаглагдаж байна” (Мт 11:5) гэж айлдсан. Учир нь хөрөнгө мөнгөтэй, сурвалжит язгууртнууд биш, харин энгийн иргэд Түүнийг баяртайгаар сонссон юм (Мк 12:37). Дуудагдсан хүмүүс дотор нэр алдартай язгууртнууд цөөн, харин мунхаг, мөхөс, дорд, гологдсон, өчүүхэн хүмүүс олон байдаг (1Ко 1:26-29). Баячууд Эзэнд найдахын оронд эд хөрөнгөндөө найддаг тул ихэнх тохиолдолд итгэлээр ядуу байдаг. Эсрэгээрээ, ядуу дорд хүмүүс итгэлээр баян байхаар Бурханаар сонгогдсон байдаг. Бурханы хаанчлалын иргэдийн дунд судалгаа явуулбал тэдний ихэнх нь ядуу байсныг харж болох биз ээ. Тэд тэнгэрийн хаанчлалд эд хөрөнгө, алдар хүндтэй байр сууринд очих болно. Тэгвэл нэг л өдөр Аврагч Эзэний хаанчлалд өргөмжлөгдөх хүмүүсийг дорд үзэх нь ямар мунхаг бас эрсдэлтэй хэрэг вэ!

2:66 Баян хүнд бялдуучлах нь мунхаглал гэдгийг харуулах хоёр дахь шалтгаан бол баячууд Бурханы хүмүүсийг хавчин дарладаг давхарга байсанд оршино. Энэ тайлбар жаахан төвөгтэй, зарим хэсэгтээ бүр будилаантай ч санагдаж болох юм. Эхний хэсэгт дурдсан баян хүн эргэлзээгүй итгэгч байсан. Энэ нь 6-р эшлэлд дурдсан баячууд итгэгч гэсэн үг биш. Иаков ердөө л “Хүнийг баян байсных нь төлөө түүнд яагаад таатай хандах ёстой гэж?

Баян байдлынх нь улмаас хүнийг хүндэлж байгаа бол таныг хамгийн түрүүнд дээрэлхдэг, **шүүхэд аваачдаг** хүмүүсийг хүндэтгэж байгаа хэрэг болно” гэж хэлж байна. “Цаазын ял тулгасан хүнээ яагаад хүндэтгэнэ гэж?” хэмээн Калвины хэлсэн үг Иаковын энэ санааг товч, тодорхой тайлбарлажээ.

2:7 Баян хүнд тал засах хандлага мунхаглал гэдгийг батлах гурав дахь шалтгаан бол баячууд Христийн нэрийг доромж, ёрын хэллэг болгон ашиглах зуршилтай байдагт оршино. Итгэгчид Христийн энэхүү **эрхэм нэрээр** христитгэгч, Христийн дагалдагч хэмээн дуудуулдаг. Эзэнийг гутаан доромжлох нь зөвхөн баячуудын үйлддэг нүгэл биш ч гэлээ ядуу итгэгчдийг хавчдаг хүмүүс ихэвчлэн энэ хавчлагатай хамт Аврагчийн эсрэг доромж хэллэг байнга хэрэглэдэг нь үнэн юм. Тэгвэл итгэгчид баян гэдгээс нь болж хүнд яагаад тал засах ёстой гэж? Баян байдалтай хамт илэрдэг нийтлэг зан чанар ерөнхийдөө Эзэн Есүсийг хүндэтгэдэггүй. **Та нарыг дууддаг эрхэм нэр** гэсэн хэллэгийг “та нарын дээр дуудсан тэр эрхэм нэр” гэж бас хөврүүлж болох юм. Зарим нь үүнийг христитгэлийн баптисмтай холбон үздэг. Итгэгчид Эзэн Есүсийн нэр дээр баптисм хүртдэг. Харин баян хүн яг энэ эрхэм **нэрийг** байнга доромжилдог.

2:8 Баян хүнд тал засах тал дээр Иаковын өгүүлсэн дөрөв дэх шалтгаан бол **“Хөршөө өөрийн адил хайрла”** гэсэн хуулийг тэд зөрчдөгт оршино. Энэ хууль Хааны хууль бөгөөд бүх хуулийн хаан нь учраас **хаан хууль** гэж нэрлэдэг. Баян хүнд тал зассан үйлдлээ угтагч магадгүй хөршөө өөрийн адил хайрлаж байна гэж өөрийгөө хаацайлж болох юм. Гэвч ядуу хүнд гаргасан хандлагыг нь энэ үгээр цайруулах боломжгүй. Бид үнэхээр хөршдөө өөрийн адил хайртай бол өөрсдөд маань хэрхэн хандаасай гэж хүсдэг шигээ бүгдэд нь адил хандах байсан. Ядуугийн улмаас гадуурхагдахыг бид хүсэхгүй нь ойлгомжтой.

Тэгвэл бусдыг ч гэсэн ядуугийнх нь улмаас басамжлан доромжилж болохгүй.

Библийн сургаалуудаас **“Хөршөө өөрийн адил хайрла”** гэсэн үг онцгой хүчтэй. Тэгвэл энэ үгийн утгыг бодоод үзээрэй! Энэ нь бид өөрсдийгөө халамжилдаг шигээ бусдыг халамжилна гэсэн үг. Бидэн шиг боломж хүртээгүй хүмүүст эд хөрөнгөөсөө хуваалцахад ч бэлэн байх хэрэгтэй гэсэн үг. Юу юунаас илүүтэй ерөөлт Аврагчаа тэдэнд таниулахын төлөө хамаг хүчээ дайчилна гэсэн үг. Харамсалтай нь бидний шийдвэрүүд ихэнхдээ өөрсдөд маань хэрхэн нөлөөлөхөөс хамаардаг. Бид өөрсдийгөө л боддог. Нийгмийн байр суурь, эд материаллаг ашиг хонжоо горьдсондоо бид баячуудад тал засдаг. Гэтэл ядуус ийм ашиг өгөх найдлага бага учраас бид тэднийг үл тоомсорлодог. Гэтэл хаан хууль иймэрхүү амин хувиа хичээсэн зорилгоор бусдыг мөлжихийг хориглодог. Харин **хөршөө өөрийн адил хайрлахыг** бидэнд заадаг. Тэгвэл “Миний хөрш гэж хэн бэ?” гэж асуувал сайн самари хүний түүхээс (Лк 10:29-37) бидний тусалж хүчрэх тусламж хэрэгтэй хүн бүр бидний хөрш мөн гэдгийг ойлгоно.

2:9 Алаг үзэх нь хаан хуулийг зөрчсөн хэрэг болно. Энэ бол **нүгэл** төдийгүй гэмт үйлдэл мөн. Бурханы хүсэлд нийцэхгүй, тавьсан шалгуурт нь хүрч чадахгүй байхыг **нүгэл** гэдэг. Харин гэмт үйлдэл гэдэг нь хуулийг мэддэг атлаа санаатай зөрчихийг хэлнэ. Зарим үйлдлийн мөн чанар нь үндсэндээ буруу байдаг тул **нүгэл** болдог. Гэтэл тэрхүү үйлдлийг хориглосон хууль байсаар атал зөрчвөл гэмт үйлдэл болно. **Алаг үзэх, ялгаварлах** нь үндсэндээ, мөн чанараараа буруу учраас **нүгэл** мөн. Түүнээс гадна үүний эсрэг хууль байгаа тул үйлдвэл бас гэмт үйлдэл болно.

2:10 Хуулиас нэг хэсгийг нь л зөрчвөл **бүгдийг нь зөрчсөн болно**. Хууль нь арван хэсэг хэлхээтэй гинжтэй

адил юм. Нэг холбоосыг таслахад л гинж бүхэлдээ тасрах болно. Бурхан биднийг дуртай хуулиа сахиад бусдыг нь зөрчихийг зөвшөөрдөггүй.

2:11 Завхайрлыг хориглодог Бурхан бас хүн алахыг хориглосон. Хүн завхайрал үйлддэггүй ч **аллага үйлдсэн** байж болно. Тэгвэл тэр **хуулийн гэмт хэрэгтэн** мөн үү? Мэдээж тийм! Хуулийн мөн чанар нь хөршөө өөрийн адил хайрлахыг биднээс шаарддаг. Завхайрал энэ мөн чанарыг зөрчдөг шиг аллага ч мөн адил зөрчинө. Бусдыг дорд үзэх хийгээд ялгаварлан гадуурхах нь ч бас энэ мөн чанарыг зөрчдөг. Бид эдгээр нүглийн аль нэгийг үйлдвэл хуулийн тушаасныг зөрчсөн хэрэг болно.

АРВАН ХУУЛИЙН ТАЛААРХ НЭМЭЛТ ТАЙЛБАР

Одоо бүгдээрээ Иаковын үндэслэлд гарч ирсэн нэг асуудлыг ярилцахаар түр саатах хэрэгтэй болж байна. Юу гэвэл, “Христитгэгчид хуулийн дор байдаг уу үгүй юу?” гэдэг асуудал гарч ирж байна. Иаков христитгэгчдээс арван хуулийг дагаж мөрдөхийг шаардаж байгаа нь тодорхой мэт харагдаж байна. Ялангуяа хүн алах болон завхайрахыг хориглосон 6, 7-р хуулийг тэр өгүүлжээ. Мөн сүүлийн таван хуулийг “Хөршөө өөрийн адил хайрла” гэсэн үгээр нэгтгэн дүгнэсэн байна. Гэтэл хуулийг амьдралын дүрэм болгож христитгэгчийг хуулийн дор оруулах нь Шинэ гэрээний бусад хэсэгтэй зөрчилдөнө. Тухайлбал:

Ром 6:14 – “Та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа.”

Ром 7:6 – “Бид хүлүүлж асан хуульдаа үхэж түүнээс чөлөөлөгдсөн.”

Ром 7:4 – “Та нар Христийн биеэр дамжин хуульд үхсэн.”

(Мөн Гал 2:19; 3:13, 24, 25; 1Тм.1:8, 9; Евр 7:19-ийг үз.)

Христитгэгчид Арван хуулийн дор байдаггүй гэсэн баримтыг 2Коринт 3:7-11 дээр тов тодорхой дурдсан байна.

Тэгвэл нигүүлслийн эрин үед Иаков итгэгчдэд хандан хуулийн асуудлыг яагаад чухалчлан хөндсөн юм бол? Юуны өмнө, христитгэгчид амьдралын дүрэм болгож хуулийн дор байдаггүй. Итгэгч хүний амьдралд хууль биш Христ жишиг болдог. Хууль байгаа газар шийтгэл бас дагалдах хэрэгтэй болно. Хуулийг зөрчсөний шийтгэл нь үхэл. Христ хууль зөрчигчдийн ял шийтгэлийг үүрэхийн тулд амиа өргөсөн. Тиймээс Христ дотор байгаа хүмүүс хуулиас болон хуулийн шийтгэлээс чөлөөлөгдсөн. Гэсэн ч хуулийн зарим зарчим байнга хүчин төгөлдөр хэвээрээ байдаг. Эдгээр тушаал бүх цаг үеийн, бүх хүнд хамаарна. Шүтээн шүтэх, хүн алах, хулгай хийх, завхайрах нь үндсээрээ буруу. Эдгээр нь итгэгч төдийгүй итгэгч бус хүмүүсийн хувьд ч буруу зүйл мөн. Цаашилбал, Арван хуулийн ес нь Шинэ гэрээний захидлууд дээр дахин дурдагдсан байдаг. Харин дахин дурдагдаагүй цорын ганц тушаал бол амралтын өдрийг сахих тухай. Шаббат буюу Амралтын долоо дахь өдрийг сахь гэж христитгэгчдэд огт хэлээгүй. Учир нь энэ бол ёс суртахууны гэхээс илүүтэй сүсэг бишрэлийн зан үйл юм. Иудей хүн долоо дахь өдөр ажиллах нь төрөлх ёс суртахууны хувьд буруу биш байсан. Гагцхүү Бурхан энэ өдрийг тусгаарласан учраас л тэр өдөр ажиллах нь буруу байсан юм.

Эцэст нь, Шинэ гэрээний захидлуудад дахин дурдагдсан есөн тушаалыг хууль болгож өгөөгүй, харин Бурханы хүмүүст зөвт амьдрах зааварчилгаа болгож өгсөн. Өөрөөр хэлбэл, “Чи хулгай хийвэл үхэх ялтай”, “Чи ёс бус үйлдэл хийвэл авралаа алдана” гэж Бурхан христитгэгчдэд хэлдэггүй. Харин “Би чамайг нигүүлслээрээ аварсан. Тиймээс Намайг хайрлах хайрынхаа улмаас ариун

амьдраасай гэж Би чамаас хүсэж байна. Би чамаас юу хүсдэгийг Шинэ гэрээнээс олж мэдэж болно. Тэндээс чи Арван хуулийн ес нь давтагдсаныг олж мэднэ. Түүгээр ч зогсохгүй *хуулийн шаарддагаас илүү өндөр ёс суртахууны шаарддаг* Эзэн Есүсийн сургаалуудыг ч бас чи тэндээс олно” гэж Тэр айлддаг. Тиймээс Иаков итгэгчдийг хуулийн дор оруулж, ял шийтгэлээр унагаж байгаа юм биш. “Хэрэв чи хүнийг хүндэлбэл хуулийг зөрчсөн хэрэг болж үхэх ялтай болно” гэж Иаков хэлээгүй.

2:12 Харин Иаков, “Итгэгч болсныхоо хувьд чи “хуулийн хүлээс” дор байхаа больсон. **Харин эрх чөлөөний хууль** буюу зөвийг үйлдэх эрх чөлөөн **дор байдаг болсон**. Мосегийн хууль чамайг хөршөө хайрлахыг шаарддаг байсан ч хөршөө хайрлах хүчийг өгдөггүй байсан. Гэсэн атлаа хөршөө эс хайрлавал ялладаг байсан. Нигүүлслийн дор чамд хөршөө хайрлах хүч өгөгдөхөөс гадна хөршөө хайрлавал шагнуулдаг болсон. Чи аврагдахын тулд бус аврагдсан болохоор хөршөө хайрладаг юм. Шийтгүүлэхээс айсандаа биш чиний төлөө үхээд амилсан Нэгэнийг хайрласандаа үүнийг үйлддэг болсон. Чи Христийн шүүх суудлын өмнө зогсохдоо энэ хэмжүүрээр шагнуулах эсвэл шагналаа алдана. Энэ нь аврагдах тухай биш, харин шагнал авах тухай асуудал юм” гэж хэлж байна. **"Тийнхүү ярь, тийнхүү үйлд"** гэдэг нь үг ба үйлсийг хэлж байна. Ам ажил хоёр нэг байх ёстой гэсэн үг. Итгэгч хүний хэлэх үг хийх үйлдэл нь зөрөх ёсгүй. Эрх чөлөөний хуулийг ийнхүү зөрчвөөс Христийн шүүх суудлын өмнө шүүгдэнэ.

2:13 Энэхүү 13 дугаар эшлэлийг хам сэдэвтэй нь хамаатуулж ойлгох учиртай. Иаков итгэгчдэд хандан ярьж байна. Энд мөнх шийтгэлийн тухай яриагүй. Тэрхүү шийтгэлийг Эзэн Есүс Голготын толгод дээрх загалмай дээр нэг удаа бүрмөсөн төлсөн. Харин газар дэлхий дээр

Бурхан бидэнтэй Өөрийн хүүхдүүдийн хувиар харьцаж байгаа талаар энд өгүүлж байна. Бид бусдад **өршөөл** үзүүлэхгүй бол Бурхантай нөхөрлөх нөхөрлөл дотор явж чадахгүй бөгөөд түүнийхээ үр дагаврыг амсана гэдгээ мэдэх хэрэгтэй.

Өршөөл шүүлтийг дийлдэг гэдэг нь Бурхан биднийг сахилгажуулахын оронд өршөөхийг илүүд үздэг гэсэн утгатай байж болох юм (Мик 7:18). Шүүлт бол Бурханы "өвөрмөц үйл". Бид бусдад өршөөл үзүүлбэл шүүлтийн өмнө баяр хөөртэй байж чадна. Шударга шийтгэлээ амсвал зохих хүмүүст хүртэл өршөөл үзүүлээгүй бол бид ч өөрсдөө өршөөгдөхгүй гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, өршөөл шүүлтийг дийлдэг гэдэг нь өршөөл энэрэл шүүлтээс ч илүү агуу гэсэн утгыг илэрхийлж байж болно. Ерөнхийдөө, бусдад өршөөл үзүүлэх аваас бидэнд оногдох шүүлт өршөөлөөр солигдоно гэж ойлгож болно.

Тэгвэл бүгдээрээ ялгаварлалын талаарх энэхүү чухал сэдэв дээр өөрсдийгөө шалгаж үзье. Бид харь хүнээс илүү нутаг нэгтэндээ өршөөнгүй хандаж байна уу? Настай хүнээс илүү залуучуудад элэгтэй хандаж байна уу? Гундуу хүнээс илүү өнгө зүстэй хүнд эелдэг хандаж байна уу? Хэний ч танихгүй хүнээс илүү нэр төртэй хүмүүстэй нөхөрлөх гэж оролдож байна уу? Хөгжлийн бэрхшээлтэй хүнээс дөлж, эрүүл чийрэг хүнтэй нөхөрлөх гэж хичээдэг үү? Ядуусыг алагчилж баячуудад бялдуучилдаг уу? Төрөлх хэлээр минь хазгай ярьдаг харь хүмүүст хүйтэн хөндий ханддаг уу?

Эдгээр асуултад хариулж байхдаа сул дорой итгэгчид яаж хандана Эзэнд яг тийн хандсантай адил гэдгийг санах хэрэгтэй (Мт 25:40).

V. ИТГЭЛ БА ҮЙЛС (2:14-26)

Эдгээр эшлэл Иаковын захидлаас хамгийн маргаан үүсгэдэг. Чуулганы түүхэнд агуу удирдагчдын нэг Лютер

272

хүртэл итгэлээр бус үйлсээр зөвтгөгдөх тухай Иаковын сургаалыг итгэлээр зөвтгөгдөх тухай Паулын сургаалтай яаж уялдуулж ойлгохоо мэдэхгүй байсан гэж үздэг. Аврагдахын тулд итгэлээс гадна үйлс хэрэгтэй гэж заадаг "синергизм" хэмээх гаж сургаалыг баримтлагчид эдгээр эшлэлийг ашиглаж өөрсдийн сургаал номлолыг батлах гэж оролддог. Өөрөөр хэлбэл, бидний хувьд аврагдахын тулд зөвхөн Эзэн Есүст итгэхэд хангалттай байхад тэдний хувьд энэ нь дангаараа хангалтгүй. Бид Түүний авралын ажил дээр сайн үйлс, хичээл зүтгэлийг нэмэх хэрэгтэй гэж тэд үздэг.

Энэ хэсгийг бид "үйлсээр зөвтгөгдөх" гэж нэрлэж болох юм. Учир нь тодорхой тохиолдолд бид үйлсээр зөвтгөгддөг. Үнэндээ зөвтгөлийн тухай үнэнийг бүрэн ойлгохын тулд зөвтгөлийн зургаан талыг сайтар мэдэх хэрэгтэй болно. (1) Бид *нигүүлслээр* зөвтгөгддөг (Ром 3:24). Нэг үгээр хэлбэл, бид зөвтгөгдөх зохисгүй, харин ч шийтгэл авбал таарсан хүмүүс гэсэн утгатай. (2) Бид *итгэлээр* зөвтгөгддөг (Ром 5:1). Итгэл бол Бурханы нигүүлсэлд хүний зүгээс үзүүлэх хариу хандлага юм. Итгэлээр бид үнэгүй бэлгийг хүлээн авдаг. Бидний төлөө гүйцэлдүүлж өгсөн Бурханы үйл хэргийг бид итгэлээр өөрийн болгодог. (3) Бид *цусаар* зөвтгөгддөг (Ром 5:9). Энд яригдаж буй цус бол зөвтгөгдөхөд шаардагдах үнийг цусаар төлсөн гэдгийг илэрхийлж байна. Нүглийн төлөөсийг Христийн үнэт цус барагдуулсан тул эдүгээ Бурхан бурханлаг бус нүгэлтнүүдийг зөвтгөх боломжтой болов. Учир нь зөвт байдлын шударга шаардлага хангагдсан юм. (4) Бид *Бурханаар* зөвтгөгддөг (Ром 8:33). Энд Бурхан бол зөвтгөгч Нэгэн гэдэг үнэнийг илэрхийлж байна. (5) Бид *хүч чадлаар* зөвтгөгддөг (Ром 4:25). Бидний зөвтгөл Христийг үхлээс амилуулсан хүч чадалтай холбоотой. Христ үхлээс амилснаараа Бурханы шаардлага хангагдсаныг батлан харуулдаг. (6) Түүнчлэн, бид *үйлсээр*

зөвтгөгддөг (Иак 2:24). Үйлс нь итгэлийг үнэн бодит гэдгийг харуулах гадна талын баталгаа юм. Үйлс нь үл үзэгдэх итгэлийн гадаад илэрхийлэл болдог. Тэгэхээр хүн нигүүлсэл, итгэл, цус, Бурхан, хүч чадал, үйлсээр зөвтгөгддөгийг бид эндээс харж байна. Энэ бүхэн хоорондоо огт зөрчилдөхгүй байна шүү дээ. Эдгээр тодорхойлолт нэг цогц үнэний ялгаатай тал юм. Нигүүлсэл бол Бурханы зөвтгөлийн зарчим. Итгэл бол хүн нигүүлслийг хүлээн авах суваг. Цус бол Аврагчийн маань төлөх шаардлагатай байсан төлөөс. Бурхан бол зөвтгөлийг идэвхийлэн Гүйцэлдүүлэгч. Хүч чадал бол тэрхүү зөвтгөлийн баталгаа. Үйлс бол үүний үр дүн.

2:14 Сайн үйлс хийхэд хүргэдэггүй итгэл хүнийг аврахгүй гэж Иаков онцлон хэлж байна. Энэ эшлэлийг ойлгоход тус болох хоёр үндсэн түлхүүр бий. Юуны өмнө, "Хүн итгэлтэй байлаа гээд ямар ашигтай юм бэ?" гэж Иаков хэлээгүй. Харин **"Хүн 'Надад итгэл бий' гэсэн атлаа үйлсгүй бол ямар ашигтай юм бэ?"** гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл, энд үнэхээр итгэлтэй атлаа аврагдаагүй хүний тухай биш, харин итгэлтэй гэж хэлэхээс цаашгүй хүний тухай Иаков дүрслэн харуулж байна. Тэр өөрийгөө итгэлтэй гэж хэлдэг ч үүнийг нь илэрхийлэх зүйл амьдралд нь огт байдаггүй. Хоёр дахь түлхүүрийг бид Библийн NASB орчуулгаас харж болно. Уг эшлэл **"Энэ⁵ итгэл нь түүнийг аварч чадна гэж үү?"** гэсэн асуултаар төгсөж байна. Өөрөөр хэлбэл, *ийм төрлийн итгэл* аварч чадах уу гэж байна. Иаков ямар төрлийн итгэлийн талаар ярьж байгааг асуувал хариулт нь энэ эшлэлийн эхний хэсэгт бий. Иаков сайн үйлсээр батлагддаггүй, *ярихаас цаашгүй* итгэлийн тухай өгүүлж байна. Ийм итгэл ямар ч үнэ цэнгүй, хоосон ярихаас цаашгүй.

2:15, 16 Үйлсгүй хий хоосон үгс ямар ч хэрэгцээгүй гэдгийг одоо дүрслэн харуулж байна. Энд хоёр төрлийн хүнийг танилцуулжээ. Эхнийх нь **өдөр тутмын хоол хүнс,**

өмсөх хувцас ч үгүй хүн. Удаах нь идэх хоол, өмсөх хувцастай боловч хуваалцах хүсэлгүй хүн. Удаах хүн өгөөмөр зангийн талаар ярьж байгаа ч ядуу ах дүүдээ "Яваад сайхан хувцаслаад, сайн хоол идээрэй" гэж хэлсэн ч туслахаар хуруугаа ч хөдөлгөсөнгүй. Ийм хоосон үг ямар ашигтай гэж? Ямар ч ашиг тусгүй шүү дээ. Ийм хоосон үгс өлсгөлөн ходоодыг цатгаж, даарсан **биеийг** дулаацуулж чадахгүй.

2:17 Иймээс ч итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм. Үйлсгүй итгэл нь үнэндээ жинхэнэ итгэл биш. Энэ нь ердөө л хоосон үгс болно. Тэгэхээр Иаков аврагдахын тулд итгэлээс гадна үйлс хэрэгтэй гэж огт хэлээгүй байна. Ийм үзлийг баримталбал Эзэн Есүс Христийн гүйцэлдүүлсэн бүрэн төгс үйлсийг гутаасан хэрэг болно. Аврагдахын тулд итгэлээс гадна үйлс хэрэгтэй гэвэл Есүс болон би гэсэн хоёр аврагчтай болно гэсэн үг. Гэтэл Христ бол цорын ганц Аврагч гэж Шинэ гэрээ тодорхой хэлсэн. Тэгэхээр Иаков амаараа ярьдаг итгэлээр бус сайн үйлс хийхэд хүргэдэг итгэлээр бид аврагддаг гэдгийг онцлон тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, үйлс нь авралын үндэс биш үр жимс юм. Үйлс бол учир шалтгаан биш үр дүн ажээ. Калвин энэ тухай "Бид гагцхүү итгэлээр л аврагддаг. Гэхдээ тэр итгэл хоосон байдаггүй" хэмээн голыг нь олж хэлсэн байдаг.

2:18 Сайн үйлсийг жинхэнэ итгэлээс салгах аргагүй. Иаков үүнийг ойлгуулахын тулд хоёр хүний мэтгэлцээнээс жишээ татан харуулдаг. Эхнийх нь жинхэнээсээ аврагдсан, энэ бүхнийг хүүрнэж буй хүн. Хоёр дахь нь “Надад итгэл байна” гэж хэлдэг боловч итгэлээ үйлсээрээ харуулдаггүй хүн. Эхний хүн нөгөөдөө хариулж чадамгүй асуулт асууж сорьж байна. Тэдний яриаг илүү ойлгомжтой болгох үүднээс өөр үгээр илэрхийлье: “Тийм ээ. Надад **итгэл байна** гэж **чи** хэлсэн. Гэхдээ итгэлээ үйлсээрээ харуулсангүй. Итгэлийг амьдралын үйлсээр харуулах

ёстой гэж би үздэг. Сайн **үйлсгүйгээр итгэлтэй** гэдгээ чи надад батлан харуул гэвэл чи чадахгүй. Итгэл харагддаггүй зүйл. Итгэлтэйг чинь бусад хүн мэдэх цорын ганц арга бол амьдралаараа харуулах явдал шүү дээ. **Би чамд итгэлээ үйлсээрээ харуулья”** гэжээ. *Харуулах* гэдэг үг энэ эшлэлийн гол түлхүүр. Учир нь үйлсгүйгээр итгэлийг харуулах ямар ч боломжгүй.

2:19, 20 Мэтгэлцээн цааш үргэлжилж байна. Эхний хүн хүүрнэсэн хэвээрээ байна. Амаараа итгэдэг гэж хэлэх нь гарцаагүй үнэнийг хүлээн зөвшөөрсөн хоосон тунхаг төдий байж болно. Бодолдоо хүлээн зөвшөөрөх нь ямар нэг зориулалт шаарддаггүй учраас амьдралыг өөрчлөн шинэчилдэггүй. **Бурхан** оршин байдагт итгэх нь хангалтгүй. Мэдээж итгэх нь чухал ч хангалттай биш. Бурхан оршин байдаг гэдэгт **чөтгөрүүд ч итгэдэг** бөгөөд Бурханы шийтгэлийг эцэст нь хүртэнэ гэдгийг бодохдоо дагжин чичирцгээдэг юм. **Чөтгөрүүд** хөдөлшгүй баримтад **итгэдэг** ч Бурханд Өөрт нь бууж өгдөггүй. Тиймээс энэ нь авралд хүргэх итгэл биш. Хүн Эзэнд үнэхээр итгэвэл сүнс, сэтгэл, биеэ бүрэн зориулдаг. Энэ зориулалтын үр дүнд амьдрал өөрчлөгддөг. **Үйлсээс** ангид **итгэл** нь тархинд эргэлдэх бодол төдий итгэл учраас **үхмэл** юм.

2:21 Энд итгэлээ үйлсээрээ харуулсан хоёр жишээг Хуучин гэрээнээс эш татаж байна. Тэд бол иудей хүн **Абрахам**, харь үндэстэн Рахаб нар юм. Абрахам **тахилын ширээн дээр хүү Исаакаа өргөхдөө үйлсээрээ зөвтгөгдсөн**. Энэ үнэнийг зөв өнцгөөс харахын тулд Эхлэл 15:6-г харцгаая. Абрахам Эзэнд итгэсэнд Эзэн түүнийг зөвд тооцжээ гэж бичигдсэн байна. Абрахам итгэсэн учраас зөвтгөгдсөнийг эндээс харж болно. Өөрөөр хэлбэл, Абрахам итгэлээр зөвтгөгдсөн. Дараа нь Эхлэл 22 дугаар бүлгийг үзвэл Абрахам хүүгээ өргөл болгон өргөж байна. **Энэ үедээ тэр үйлсээр зөвтгөгдсөн**. Абрахам Эзэнд итгэх мөчид Бурханы нүдэнд зөвтгөгдсөн. Долоон бүлэг хойш нь

уншвал Бурхан Абрахамын итгэлийг шалгасан тухай гарна. Тэр Исаакийг өргөл болгон өгөхөд бэлэн байснаараа итгэлээ жинхэнэ гэдгийг харуулсан юм. Түүний дуулгавартай байдал зүгээр ч нэг бодолдоо итгээд байдаггүй зүрх сэтгэлийн зориулалт гаргаж итгэдэг гэдгийг нь баталсан юм.

Ингэж хэлэхээр зарим нь Абрахам Исаакийг өргөж байхад дэргэд нь хэн ч байгаагүй тул итгэлээ жинхэнэ гэж батлах хүн байгаагүй гэж маргадаг. Гэхдээ Абрахамыг дагаж явсан залуу Абрахам, Исаак хоёрыг уулнаас буун ирэхийг хүлээгээд холгүйхэн байж байсан. Түүнээс гадна Исаак тэнд байсан. Мөн Бурханы тушаалд дуулгавартай хандаж хүүгээ өргөхөд бэлэн байсан Абрахамын хандлага Библид тэмдэглэгдэн үлдсэнээр түүний итгэл жинхэнэ байсныг бүх үеийн итгэгчдэд харуулж байна.

2:22, 23 Тэгэхээр Абрахамын үйлс итгэлээс нь гарсан нь тодорхой байна. Түүний **итгэл үйлсээр нь гүйцэд болсон**. Жинхэнэ итгэлийг үйлсээс салгах аргагүй. Эхнийх нь удаахыг бий болгодог. Удаах нь эхнийхийгээ баталдаг. Исаакийг өргөснөөр Абрахамын итгэл бодитой харагддаг. Ингэснээр **Абрахам** итгэлээр зөвтгөгдсөн гэдэг **Бичвэр** бодит амьдрал дээр биелэлээ олсон юм. Абрахамын сайн үйлс түүнийг **Бурханы анд нөхөр** мөн гэдгийг тодорхойлсон.

2:24 Энэ бүхнээс дүгнэн үзвэл **хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг бид харж байна**. Дахин хэлэхэд, итгэлээс гадна үйлс байж гэмээнэ зөвтгөгдөнө гэсэн утгыг энд огт яриагүй шүү. Хүн Бурханы нүдэнд итгэлээр зөвтгөгдөж, хүний өмнө үйлсээр зөвтгөгддөг. Бурхан хүнийг итгэсэн тэр мөчид нь шууд зөвтгөдөг. Харин хүн, "итгэлээ бодитой гэдгийг надад харуул" гэж хэлдэг. Үүнийг харуулах цорын ганц зам бол сайн үйлс билээ.

2:25 Хуучин гэрээний хоёр дахь жишээ бол **янхан эм Рахаб** юм. Энэ эмэгтэй сайн үйлсээр аврагдаагүй нь

илэрхий (Учир нь тэр биеэ үнэлэгч байсан!). Гэхдээ тэр үйлсээр зөвтгөгдсөн. Учир юу хэмээвэл **тэрээр элч нарыг** (туршуулуудыг) **хүлээн авч тэд нарыг ондоо замаар явуулсан**. Рахаб бол Иерихо хотод амьдардаг канаан эмэгтэй байсан юм. Тэрээр ялгуулсан арми хотыг чиглэн ирж явааг болон уг армийн эсрэг юу ч хийгээд нэмэргүй гэдгийг сонсжээ. Тиймээс тэр еврейчүүдийн Бурхан бол жинхэнэ Бурхан мөн гэж үзээд тэрхүү Бурханыг ямар ч үнээр хамаагүй дагахаар шийджээ. Туршуулууд хотод орж ирэхэд Рахаб тэднийг найрсгаар угтан авав. Энэ үйлдлээрээ тэр жинхэнэ, цорын ганц, амьд Бурханд итгэх итгэлээ бодитой гэдгийг нотолсон юм. Тэр туршуулуудыг нууснаараа аврагдаагүй, харин зочломтгой байдал нь жинхэнэ итгэгч гэдгийг нь баталсан юм.

Зарим хүн энэ хэсгийг буруу тайлбарлан, аврагдахын тулд сайн үйлс шаардлагатай гэж заадаг. Тэдний ярьж буй сайн үйлс нь өргөл өргөх, өрөө төлөх, үнэнийг хэлэх, чуулганд явах зэргийг хэлдэг. Гэтэл Абрахам, Рахаб нар ийм сайн үйлс хийсэн үү? Мэдээж үгүй! Абрахамын хувьд энэ нь хүүгээ алахад бэлэн байдал байсан. Рахабын хувьд энэ нь ард түмнээсээ урвах явдал байлаа! Тэдний энэхүү үйлдлээс итгэлийг аваад хаячихвал сайн биш ёрын муу үйлс болно. "Тэдний үйлдлээс итгэлийг салгавал ёс бус, сэтгэл зүрхгүй үйлдлээр зогсохгүй гэм нүгэл болох байлаа." Энэ тал дээр Макинтошийн тайлбар голыг нь олж хэлсэн байдаг. "Энэ хэсэгт хуулийн үйлсийг биш амийн үйлсийг ярьж байна. Та Абрахам болон Рахабын үйлсээс итгэлийг салгавал муу үйл болно. Харин тэдний үйлдлийг итгэлийн үр жимс хэмээн хараад үзээрэй. Тэгвэл амийн үйлс болох нь харагдана" хэмээжээ.

Тэгэхээр энэ хэсгийг ашиглаж сайн үйлсээр аврагдана гэж номлох боломжгүй. Тэгэх аваас аллага хийгээд урвах үйлсээр дамжуулан авралд хүрч болно гэдэг маш буруу үзэл санаа гарч ирнэ.

2:26 Иаков энэ хэсгийг **"сүнсгүй бие үхмэл байдгийн адил түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл болой"** гэх мэдэгдлээр төгсгөж байна. Энд гол сэдвээ маш сайхан дүгнэн хэлжээ. Иаков **итгэлийг** хүний **биетэй** адилтгаж, **үйлсийг сүнстэй** зүйрлэсэн байна. Сүнсгүй бие амьгүй учраас ямар ч хөдөлгөөн хийж чадахгүй, ашиг тус, үнэ цэн байхгүй. **Түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл** учраас үр нөлөө, үнэ цэнгүй. Ийм итгэл илт худал хуурмаг, жинхэнэ авралд хүргэхгүй. Дараах асуултаар бүгдээрээ өөрсдийн итгэлийг жинхэнэ эсэхийг шалгацгаая. Би амьдралынхаа хамгийн үнэ цэнтэй зүйлийг Абрахам шиг Бурханд өргөхөд бэлэн байна уу? Христэд үнэнч байхын тулд энэ ертөнцөөс нүүр буруулж, Рахаб шиг урвагч болоход бэлэн байна уу?

VI ХЭЛЭЭ ХАЗААРЛАХУЙ (3:1-12)

Гуравдугаар бүлгийн эхний 12 эшлэл хэл ярианы тухай өгүүлнэ (Мөн 1:19, 26 2:12, 4:11 5:12 хэлний тухай дурдсан). Хуучны эмч нар өвчтөнийхөө биеийн байдлыг оношлохын тулд хэлийг нь үздэг байсан шиг Иаков бидний хэл яриагаар сүнсний эрүүл мэндийг маань шалгаж байна. Өөрийгөө оношлох асуудал хэл яриагаа шалгахаас эхэлнэ. "Хэл амаа болгоомжил. Нойтон газар байдаг тул амархан халтирдаг юм шүү" гэх орчин үгтэй Иаков санаа нийлэх байсан биз ээ.

3:1 Бурханы үгийн багш болох гэж бүү яар гэдэг анхааруулгаар хэл ярианы тухай сэдвийг танилцуулжээ. Энд тусгайлан хэл яриаг дурдаагүй ч Бурханы үгийг заадаг хүн хэл яриагаа ашигладаг учраас Бурханы болон хүмүүсийн өмнө нэмэлт хариуцлага хүлээнэ гэсэн санааг далд утгаар илэрхийлж байна. **"Та нараас олноороо багш бүү бол"** гэсэн үгийг арай өөр үгээр илэрхийлье: "Багш болох гэж хэтэрхий их тэмүүлэх хэрэггүй." Багшлахаар

Бурханаар үнэхээр дуудагдсан хүнийг багшийн бэлэг авьяасаа ашиглахыг нь хориглоход энэ эшлэлийг ашиглаж болохгүй. Энэ нь энгийнээр бусдад заах үйлчлэлийг хөнгөн үзэж болохгүй л гэсэн сануулга юм. Үнэний үгийг заадаг хүмүүс зааж байгаагаа амьдралд хэрэгжүүлэхгүй бол илүү **хүнд шүүлтэд орно.**

Библийг заана гэдэг маш том хариуцлага. Багш хүн Бурханы үгээс олж харснаа өөрөө дуулгавартай биелүүлэх сэтгэлзүйн бэлтгэлтэй байх ёстой. Өөрөө хэрэгжүүлдэггүй зүйлээ бусдад зааж сургана гэж бодох ч хэрэггүй. Хүний бусдад нөлөөлөх нөлөөлөл өөрөө хэр их өсөж төлөвшсөнөөр тодорхойлогддог. Багш хүн бусдыг өөр шигээ дүртэй болгодог. Багш хүн өөртэйгөө адил хүмүүсийг бүтээдэг. Тэрээр Библид тодорхой хэлсэн утгыг мушгин гуйвуулж, дураараа тайлбарлаваас суралцагчдынхаа өсөлтийг хязгаарладаг. Алив нүглийг хүлээн зөвшөөрвөл ариун бус амьдралыг өөгшүүлнэ. Бусад ямар ч ном Шинэ гэрээ шиг уншигчдадаа ийм шаардлага тавьдаггүй. Шинэ гэрээ Есүс Христэд хоёргүй сэтгэлээр зориулагдахыг уриалдаг. Есүсийг амьдралынхаа талбар бүрд Эзэн байлгахыг энэ ном итгэгчдээс шаарддаг. Тиймээс ийм номоос зааж сургана гэдэг тун хариуцлагатай хандах асуудал мөн!

3:2 Иаков одоо багшлах үйлчлэлээс жирийн харилцан яриа руу шилжиж байна. **Бид цөмөөрөө олон юман дээр бүдэрдэг.** Гэхдээ хүн хэлээ захирч, хэл ярианы алив нүгэлд унахаас өөрийгөө сэргийлж чаддаг бол маш сахилга баттай, төлөвшсөн хүн байна. Хэл яриагаа захирч чаддаг хүн амьдралын бусад талбар дээр ч мөн адил төвөггүй биеэ хянан захирч чадна. Мэдээж үүнийг Эзэн Есүс Христ л бүрэн төгс гүйцэлдүүлж чадсан Нэгэн. Гэхдээ бид ч бас энэ тал дээр **төгс** болох боломжтой. Төгс гэдэг нь төлөвшсөн, бүрэн дүүрэн, сахилга баттай болохыг хэлж байгаа юм.

3:3 Хэлийг таван янзаар зүйрлэн дүрсэлжээ. Эхнийх нь хазаартай зүйрлэсэн байна. Хазаар бол морины толгойд угладаг тоног хэрэгсэл бөгөөд хазаарын **амгайвчийг морьдын аманд** зуулгана. Жолоо амгайвчтай холбогдоно. Жижигхэн төмөр боловч **амгайвчийг** удирдаж чадвал морио залж чадна. Үүн шиг хүний хэл амьдралыг сайн руу ч, муу руу ч чиглүүлж чаддаг.

3:4 Дараа нь хэлийг усан онгоцны **залууртай** зүйрлэжээ. Усан онгоцтойгоо харьцуулахад **залуур** маш **жижигхэн** хэрэгсэл юм. Усан онгоцны жингийн өчүүхэн хувийг эзэлнэ. Тухайлбал, “Хатан хаан Елизабет” хөлөг онгоц 83,673 тонн жинтэй байв. Гэтэл залуур нь ердөө 140 тонн буюу усан онгоцны нийт жингийн нэг хувийг арав хуваасны хоёрт ч хүрэхгүй. Тэгсэн атал тэрхүү залуур эргэхэд л усан онгоцыг бүхэлд нь залдаг. Хүн тэр том хөлөг онгоцыг ийм жижигхэн төхөөрөмжөөр зална гэдэг итгэмээргүй санагдаж болох ч яг л ийм зүйл болдог. Тэгэхээр бид хэлний хүчийг харагдах хэмжээгээр нь үнэлж болохгүй. Хэдийгээр хэл биеийн жижиг эрхтэн бөгөөд харьцангуй далд байрладаг ч сайн муу аль нь ч бай агуу зүйлсээр сайрхдаг.

3:5, 6 Гуравт, хэлийг галтай зүйрлэсэн байна. Зурсан чүдэнзийг болгоомжгүй хаявал түймэр гарах аюултай. Энэ өчүүхэн гал бүхэл бүтэн **ой модыг** түймэрдэж асар их хэмжээний гарз хохирол учруулж чадна. Тэгвэл жижигхэн тэр чүдэнз ямар их сүйрэл гамшгийг дотроо агуулж байдгийг бодоод үз дээ! Түүхэнд гарсан томоохон гамшгуудын нэг нь 1871 онд болсон Чикагогийн түймэр. Албан бус эх сурвалжид дурдсанаар Олери гэгч эмэгтэйн үнээ дэнлүүг нь түлхэж унагаснаас энэ гал гарсан гэдэг. Энэ үнэн ч бай худал ч бай тэрхүү түймэр гурван өдөр, гурван шөнө үргэлжилж, хотын 1.5 бээр хавтгай дөрвөлжин талбайг түймэрджээ. Үүний улмаас 250 хүн амиа алдаж, 100,000 хүн орон гэргүй болж, 175 сая

ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгө сүйдсэн юм. Хэл бол өчүүхэн чүдэнзний гал, түлхэж унагаасан дэнлүүтэй адил. Хэлнээс гарч болох бузар мууд хэмжээ хязгаар гэж үгүй. Иаков хэлийг **бидний эрхтнүүдийн дунд байдаг зүй бусын ертөнц** гэж нэрлэсэн байдаг. Энд ашигласан *ертөнц* гэдэг үг нь асар өргөн уудам гэсэн санааг илэрхийлдэг. Бид ч бас заримдаа энэ үгийг ийм утгаар хэрэглэдэг шүү дээ. Жишээлбэл, асуудлаар дүүрэн ертөнц гэвэл асар их хэмжээний асуудал гэсэн утгатай. Хэл хэдийгээр жижигхэн боловч асар их хэмжээний зүй бусыг үйлдэх чадвартай.

Бузар муу яриа гал мэт тархдагийг Брүүклиний хоёр эмэгтэйн яриагаар дүрсэлсэн байдаг:

-Тиллигийн талаар ярьсныг минь чи Тиллид хэлсэн байна лээ. Тиллигээс би сонслоо. Би чамайг түүнд битгий хэлээрэй гэж хэлсэн шүү дээ.

-Хэлснийг минь чамд битгий хэлээрэй гээд би Тиллид хэлсэн юм даа. Тэр ч өөдгүй эмэгтэй юм аа.

-За яахав. Надад хэлснийг нь чамд хэлэхгүй гэж би Тиллид хэлсэн юм. Чамд ярьсныг минь Тиллид битгий хэлээрэй.

Хэл бүх биеийг бузарлаж чаддаг. Хүн хэлээ доромжлол, гүтгэлэг, худал хуурмагт ашиглавал мөн чанараа бүхэлд нь гутаадаг.

Чаппел ийнхүү бичжээ:

"Бусдыг өөлж муулдаг хүн өөрийгөө хохироодог... Бусад руу шавар шиддэг хүн хүссэнээ хийхээр эргэхдээ гартаа болон зүрх сэтгэлдээ наасан шавраасаа зайлж чадахгүй. Ингэж муу муухайтай хутгалдсаны дараа ихэвчлэн өөрөө бохирдсон мэдрэмжтэй үлддэг шүү дээ! Уг нь бид анхнаасаа ийм зорилго агуулдаггүй. Бусад руу шавар шидчихвэл өөрсдийгөө илүү цэвэрхэн харагдуулна гэсэн хоосон горьдлогод автаад л ийм зүйл болчихдог. Бид бусдыг доош нь хийвэл өөрөө өндрөөр

үнэлэгдэнэ хэмээн мунхаглан боддог. Хөршийнхөө байшин доор тэсрэх бөмбөг тавьчхаад өөрсдийнхөө байшингийн суурийг бат бөх болгоно гэж харалган зан гаргадаг. Гэвч энэ бүхэн хэзээ ч бүтэхгүй. Бусдыг хохироох гэсэн оролдлого амжилт олж болох ч бид өөрсдөө илүү ихээр хохирдог нь бичигдээгүй хууль юм шүү."⁶

Хэл бидний амьдралын хүрдийг галдан шатаадаг. Хүний “амьдралын хүрд” төрсөн цагаас нь эргэж эхэлдэг. Өөрөөр хэлбэл, хүрд гэдэг нь хүн амьдралынхаа турш үйлдэх бүхий л үйлийг илэрхийлж байна. Бузар муу хэл хувь хүний амьдралыг бохирдуулаад зогсохгүй үйл хэргийг нь тэр чигт нь хордуулдаг ажээ. Тэгэхээр бузар муу хэл нь хүний бүх амьдралын турш бүх талбарт нь ёрын муугаар нөлөөлдөг байна. Бузар муу хэл **тамаар асаж байдаг.** Бүх бузар ярианд эх сурвалж гэж бий. Тэрхүү мөн чанарт тамын шинж агуулагддаг. Энд тамыг илэрхийлсэн үгний эх хувилбар нь гехенна. Энэ тохиолдлоос гадна гагцхүү Эзэн Есүс л Шинэ гэрээнд гехенна гэдэг үгийг ашигласан байдаг.

3:7 Дөрөвт, хэлийг үл номхруулагдах зэрлэг амьтадтай жишин зүйрлэжээ. Бүх төрлийн араатан амьтан, шувуу, могой, далайн амьтдыг сургаж болдог. Сургуультай заан, арслан, бар, махчин шувууд, могой, далайн гахай, загас хүртэл байдаг. Плини өөрийнх нь цаг үед хүмүүсийн номхруулж, гаршуулсан амьтдыг жагсаан бичсэн байдаг. Үүнд, заан, арслан, бар, бүргэд, могой, матар олон төрөл бүрийн загас багтана. Хүний сургаж номхруулаагүй олон төрлийн амьтад бий гэж маргавал Иаковын хэлэх гээд байгаа санааг олж харж чадахгүйд хүрнэ. Хангалттай цаг хугацаа, тэсвэр тэвчээр байвал хүний гаршуулж сургаж чадахгүй амьтан гэж үгүй буй за.

Роберт Г. Ли энэ тухай уран яруу илэрхийлжээ:

"Хүн аварга том заануудыг яаж орхилоо? Тэд заануудын орон гэр болсон ширэнгийг эзлэн түрэмгийлж, тэднийг барьж аваад гуалин зөөлгөх, хүнд ачаа чирүүлэх зэрэг хамаг л хүнд хүчир ажилд сургасан. Хүн ногоон нүдэт Бенгалийн баруудыг яасан бэ? Тэднийг барьж аваад сургаж, үзүүлбэр үзүүлэх хамтрагчаа болгосон. Хүн Африкийн хүчирхэг догшин арсланг яасан бэ? Олон тооны арсланг барьж аваад сургаж, галт цагариган дундуур үсрүүлж, морины нуруун дээр зогсоож, өндөр тавцан дээр суулгаж, өлссөн ч салаандаа хавчуулсан махаа идэлгүй сууж, хүний хэлсэн үгийг дуулгавартай дагаж, ташуурын хөдөлгөөнөөр гүйж, харайхад сургаж, номхруулж чадсан. Хэдэн жилийн өмнө циркийн нэгэн арслан амаа томоо гэгч нь ангайж байхад сургагч эзэн нь толгойгоо нэг минут хэртэй байлгахад арслан эзэндээ ямар ч хор учруулаагүйг би нүдээрээ харж байв. Хүн аварга том могойг яасан бэ? Цирк рүү очоод үз. Жижигхэн биетэй, цэцэг цэврүү шиг эмзэг туяхан эмэгтэйчүүд тэдгээр аймшигт араатныг бие дээгүүрээ цагариглуулан эрхлүүлэх авч могой ямар ч гэм хор учруулахгүй байгааг харна. Хүн цусанд дуртай цоохор ирвэсийг өөрийнхөө өмнө ямар ч гэм хоргүй болгож чаддагийг харъя гэвэл амьтдын шоуг очиж үзээрэй. Тэндээс та сургуультай нохой бөөсийг ч олж харна. Өлсгөлөн цөөвөр чоно хургатай хамт хэвтэж, тагтаа бүргэд хоёр нэг торонд сууж, чоно туулай хоёр хамтдаа үзүүлбэр үзүүлэхийг та харна."⁷

3:8 Хүн төрөлхтөн зэрлэг амьтдыг ийнхүү сургаж номхруулж чаддаг атлаа өөрийнхөө **хэлийг** номхруулж чаддаггүй. Шударгаар хариулбал энэ үг үнэн болохыг бид хүлээн зөвшөөрнө. Хүн нүгэлд унасан учраас хэл гэдэг энэ

жижиг эрхтнийг захирч чадахаа больжээ. Хэлээ захирах хүч тэнхээ, ур чадвар хүний мөн чанарт нэгэнт байхаа больсон байна. Гагцхүү Бурхан л энэ хэлийг номхруулж чадна.

Иаков дараа нь хэлийг **амралтгүй муухай эд мөн** гэж тодорхойлжээ. Энэ үгийг **“үхлийн хороор дүүрсэн”** гэдэг үгтэй холбосныг харвал Иаков дотроо, хэзээ ч зүгээр суудаггүй хорт могойг төсөөлж байсан бололтой. Түүний ганц хоёрхон дусал хор шууд үхэлд хүргэнэ. Үүн шиг хэл ч бас бодол санааг хордуулж, зан чанарыг эвддэг. Бусдын талаар хов жив ярих ямар амархан болохыг бид бүгдээрээ мэднэ. Бид ямар ч шалтгаангүйгээр бусдыг араар нь муулж, шүүмжилж, доромжилдог. Ямар ч утга учиргүйгээр бусдыг гутаадаг. Гэвч энэ бүхэн ямар их хор хохирол учруулдгийг хэн ч хэмжиж чадахгүй. Ямар их нулимс урсаж, хэчнээн хүний зүрх шархалж, нэр төр нь үгүй болсон бол? Би өөртөө болон гэр бүлдээ ямар их гай түйтгэр авчирсан бол? Муу муухай хэл ярианаас болж хүмүүс дотроо хорсол тээж, уучлал гуйхаас өөр аргагүй ичгүүртэй байдалд унаж, эрүүл мэндээ доройтуулдаг. Эцэг эх нь бусад итгэгчдийг байнга муулж буйг харж өссөн хүүхдүүд мөн адил бусдыг шүүмжлэх хандлагатай болж, христэч нөхөрлөлөөс холдон оддог. Хэл амаа захирч сураагүйн улмаас төлөх төлөөс хэмжээлшгүй.

Хэл яриагаа хэрхэн эдгээх вэ? Өдөр бүр залбирч, хэл яриаг минь хов жив, хэрүүл маргаан, гомдол гонгиноогоос хамгаалж өгөөч гэж Эзэнээс байнга гуй. Бусдыг хэзээ ч бүү муул. Хайр үй түмэн нүглийг далдалдаг (1Пт 4:8). Хэн нэг хүнтэй асуудал үүсвэл шууд очиж уулзаад хайр дотор ярилцаж, хамтдаа залбир (Мт 18:15; Лк 17:3). Ах дүүсийнхээ жижиг сажиг алдаа дутагдлыг хэтрүүлэн сүржигнэлгүй тэдний дотроос Христийг олж хараарай. Ямар нэг таагүй, ашиг тусгүй зүйл ярихыг завдвал яриагаа тасалж, цааш үргэлжлүүлэх нь босгон байгуулахгүй

гэдгийг тайлбарлаарай. Зарим зүйлийг хэлэлгүй үлдээх нь дээр байдаг.

3:9, 10 Хэлийг сайн муугийн аль алинд ашиглах нь хоорондоо зохицохгүй. Энэ нь жам ёсны, төрөлх зүйл биш ээ. Хүн эхлээд хэлээрээ **Бурханыг** магтаж байснаа дараа нь **Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн** хүнийг хараадаг. Нэг эх ундаргаас эсрэг тэсрэг үр дагавар гарах нь зүйд нийцэхгүй. Ийм юм ер байж болохгүй. Бурханыг магтдаг хэл хүнийг шархдуулалгүй босгон байгуулах ёстой. Бүгдээрээ хэлж байгаа бүхнээ дараах гурван асуултаар шалгаж байх хэрэгтэй. Энэ үнэн үү? Энэ эелдэг үг мөн үү? Энэ үгийг хэлэх шаардлагатай юу? Уруул дээр минь манаач тавихыг Эзэнээс цаг ямагт гуйж (Дуу 141:3), бидний хүч чадал хийгээд Аврагч болсон (Дуу 19:14) Түүний нүдэнд тааламжтай зүйлсийг л зүрхэндээ тунгааж, амаараа гаргаж байхын төлөө залбирах хэрэгтэй. Ром 12:1-т хэлсэн бидний биеийн нэг хэсэг яах аргагүй хэл мөн.

3:11 Булгийн нэг эхээс цэвэр цэнгэг ба гашуун ус зэрэг гардаггүй. Хэл ч бас хоёр өөр зүйл өгүүлэх учиргүй. Зөвхөн сайныг л өгүүлэх хэрэгтэй.

3:12 Булгийн ус хүний амны цангааг тайлж сэрүүцүүлдэг шиг инжрийн мод хүнийг тэжээн тэтгэдэг. Инжрийн мод чидун жимсийг, усан үзмийн мод инжрийг гаргаж чадахгүй. Байгаль дээр мод өөрийнхөө төрөл зүйлийн жимсийг л ургуулдаг. Тэгвэл хэл хэрхэн сайн муу гэсэн хоёр өөр төрлийн жимсийг ургуулж чаддаг юм бол? Энэ эшлэлийг Матай 7:16-20 дээр хэлэгдсэн төстэй үгтэй хольж хутгаж болохгүй. Матай дээр муу модноос сайн үр жимс гарахыг бүү хүлээ гэж сануулсан. Бузар муу хүнээс зөвхөн бузар муу үйлс л гардаг. Харин энэ эшлэлд хоорондоо төсгүй, хоёр өөр үр жимсийг хэлээрээ гаргаж болохгүй гэдгийг сануулж байна.

Нэг эх ундаргаас нэгэн зэрэг **давстай ус** ба цэвэр **цэнгэг ус** гардаггүй. Байгаль дээр илэрхий байдаг эдгээр

жишээ нь бид хэлээ зөвхөн сайн сайхныг өгүүлэхэд хэрэглэх учиртай гэсэн сургамжийг сануулж байна.

Тэгэхээр Иаков бидний хэл яриаг шалгаж байна. Энэ хэсгийг өндөрлөхийн өмнө дараах асуултуудаар өөрсдийгөө шалгацгаая. Би өөрийнхөө дагаж мөрддөггүй зүйлийг бусдад заадаг уу? Би бусдыг араар нь муулдаг уу? Миний хэл яриа үргэлж нигүүлсэнгүй, цэвэр, босгон байгуулах мөн чанартай байдаг уу? Би уулга алдахдаа хараалын үг хэлдэг үү? Нухацтай ярилцлагын дараа би шалдар булдар, хэрэгтэй хэрэггүй юм ярьдаг уу? Би Бичвэрийг тунгаан боддог уу? Би бусдад сэтгэгдэл төрүүлэхийн төлөө юмсыг дэгсдүүлж ярьдаг уу? Би найз нөхөд, танил талаа алдаж, санхүүгийн алдагдал хүлээх байсан ч үнэнийг ярьдаг хэвшилтэй юу?

VII. МЭРГЭН УХААН: ҮНЭН БА ХУДАЛ (3:13-18)

Иаков одоо жинхэнэ мэргэн ухаан ба хуурамч мэргэн ухааны ялгааг ярьж байна. Тэрээр мэргэн ухааны талаар өгүүлэхдээ хүний хэр их *мэдлэгтэйг* биш, харин өдөр тутамдаа хэрхэн *амьдарч* байгааг хэлж байна. Мэдлэг хуримтлуулахдаа бус хэрэгжүүлэх нь л чухал. Энд жинхэнэ мэргэн ухаантай хүний хөрөг дүрийг харуулж байна. Энэ хүн бол үндсэндээ Эзэн Есүс Христ юм. Тэр бол мэргэн ухааны махбод дотор амилсан дүр (Мт 11:19; 1Ко 1:30). Түүнчлэн, мэргэн хүн Христийн амийг харуулж, Сүнсний үр жимсийг гаргадаг (Гал 5:22, 23).

Мөн үүнчлэн энэ ертөнцийн мэргэн хүний хөрөг дүрийг дүрслэн харуулжээ. Тэрээр энэ ертөнцийн зарчмуудын дагуу амьдардаг. Хүний сайрхан бардамнадаг бүхнийг хэрэгжүүлдэг. Түүний дотор тэнгэрлэг амийн хэлтэрхий ч харагддаггүй.

3:13 Хэрэв хүн **мэргэн агаад ухаалаг бол биеэ зөв авч яван, тэрхүү мэргэн ухааны** дөлгөөн сүнстэй байдаг.

Жинхэнэ мэргэн ухааны амьд дүр болсон Эзэн Есүс онгироо сагсуу, ихэрхүү бардам байгаагүй. Тэрээр дөлгөөн, зүрхэндээ даруу Нэгэн байсан (Мт 11:29). Тийм ч учраас жинхэнэ мэргэн хүн даруу дөлгөөн зантай байдаг.

3:14 Энэ ертөнцийн мэргэн хүн **гашуун атаархал ба хувиа хичээсэн** хүсэл эрмэлзлийг зүрхэндээ агуулж байдаг. Түүний амьдралын ганц зорилго нь хувийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх явдал байдаг. Тэрээр өрсөлдөгчдөдөө атаархаж, тэдэнд өршөөл нигүүлсэл үзүүлдэггүй. Тэрээр амжилтад хүргэсэн мэргэн ухаанаараа сайрхдаг. Иаков үүнийг мэргэн ухаан огтхон ч биш гэж хэлжээ. Ийм сайрхал хоосон юм. Үнэхээр мэргэн хүн даруу дөлгөөн байдаг гэсэн **үнэнийг** ертөнцийн хүн үйлдлээрээ үгүйсгэдэг.

3:15 Христэч үйлчлэлд хүртэл бусдад гашуунаар атаархаж, өөрийгөө тэргүүнд тавих гэсэн хандлага гарах нь бий. Энэ ертөнцийн мэргэн хүнийг чуулганы удирдлагад тавих аюул ч бас бий. Сүнслэг асуудалд энэ ертөнцийн зарчмуудыг удирдамж болгохоос байнга сэрэмжлэх хэрэгтэй. Иаков энэхүү хуурамч мэргэн ухааныг **газрынх, төрөлхийнх** бөгөөд **чөтгөрийнх** гэж нэрлэсэн. Энэ гурван тэмдэг нэр дээрхийг зориуд уруудах дарааллаар бичжээ. **Газрынх** гэдэг нь уг мэргэн ухаан тэнгэрээс биш газраас гаралтайг хэлж байна. **Төрөлхийнх** гэдэг нь уг мэргэн ухаан Ариун Сүнснийх биш, хүний төрөлх зан чанараас гардаг гэдгийг илтгэдэг. **Чөтгөрийнх** гэдэг нь уг мэргэн ухаан хүнийх гэхээс илүүтэй чөтгөрийн үйлдэл шиг харагддагийг хэлж байна.

3:16 Учир нь хаана атаархал ба хувиа хичээсэн зорилго оршиж байна, тэнд замбараагүй байдал болоод аливаа муу муухай юмс байдаг. Энэ юутай үнэн үг вэ! Өнөөгийн дэлхий ертөнц амар амгалангүй, зөрчил тэмцэл, будилаанаар дүүрэн байна. Учир нь хүн төрөлхтөн

жинхэнэ Мэргэн Ухаанаас татгалзаж, өөрсдийн ухаанаар явцгааж байгаад оршино.

3:17 Бурханаас ирдэг **мэргэн ухаан нь нэгт ариун** байдаг. Бодол санаа, үг хэл, үйл хэрэг нь цэвэр байдаг. Сүнс хийгээд бие махбод, онол сургаал хийгээд хэрэгжүүлэлт, итгэл хийгээд ёс суртахуун нь бузартаагүй байдаг. Мөн Бурханаас ирдэг мэргэн ухаан нь **амар тайван** байдаг. Өөрөөр хэлбэл, мэргэн хүн амар тайвныг хайрлаж, ариун байдлаа золиослохгүйгээр амар амгаланг хадгалахын төлөө чадах бүхнээ хийдэг гэсэн үг. Энэ санааг Лютер гүнзгий устай гол дээгүүр тавьсан нарийхан гүүрээр зөрж яваа хоёр ямааны түүхээр дамжуулан дүрсэлсэн байдаг. Гүүр нарийн тул буцаж явах ч аргагүй, урагш зүтгэсээр байх ч боломжгүй байв. Хэсэг гайхан зогссоны эцэст нэг нь доош бөхийж нөгөөгөө дээгүүрээ давуулав. Хэн хэнд нь ямар ч хохирол учирсангүй. Лютер энэ хоёр ямааны түүхээс дараах сургамжийг өгүүлэв: "Амар амгаланг тогтоохын төлөө бие дээгүүрээ гишгүүлэх шаардлагатай бол дуртайяа гишгүүл. Гэвч би мөс чанараа биш биеэ гэж хэлсэн шүү". Жинхэнэ мэргэн ухаан **ээлдэг** байдаг. Жинхэнэ мэргэн ухаан бусдыг хүчилдэггүй хүлцэнгүй ханддаг. Бүдүүлэг зан гаргадаггүй, бусдыг хүндэлдэг. Мэргэн хүн бусдын сэтгэл мэдрэмжид хүндэтгэлтэй ханддаг. "Бүдүүлэг, дээрэнгүй хандлага, уур уцаар, хахир хатуу үгс – энэ бүхэн Туслагчийн дөлгөөн сургаалтай огтхон ч нийцэхгүй" гэж А. Б. Симпсон хэлжээ.

Мэргэн ухааны дараагийн шинж чанар бол **ул суурьтай** байдал. Ул суурьтай гэдэг нь зөвшилцөхөд бэлэн, юмыг наана цаанатай боддог, үнэнд бууж өгдөг, харилцан ойлголцдог зан юм. Энэ нь гэжүүд, хөшүүн хүзүүтэй, уян хатан биш байдлын эсрэг зан. Дээрээс ирдэг мэргэн ухаан нь **өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн**. Ийм хүн буруутайд **өршөөлөөр дүүрэн** хандаж, зөв замаа олоход нь туслахыг хүсдэг. Бусдад уян зөөлөн, энэрэнгүй хандана. Өс

хонзонгийн сэдэл агуулалгүй, өөдгүй муу хандлагад сайн сайхнаар хариу барьдаг. Дээрээс ирдэг мэргэн ухаан нь **ялгаварладаггүй**. Өөрөөр хэлбэл, сул доройг дээрэлхэж, хүчтэйд тал засдаггүй. Бүх хүнд нэг янзаар ханддаг. Эцэст нь, жинхэнэ мэргэн ухаан хоёр **нүүр гаргадаггүй**. Бүх зүйл нь үнэн байдаг. Жинхэнэ төрхөө нууж дүр эсгэдэггүй.

Одоо бүгдээрээ энэ бүх санааг нэгтгэн үнэхээр мэргэн хүн болон хуурамч мэргэн хүн гэсэн хоёр хүний дүрийг гаргаж ирье. Жинхэнэ мэргэн хүн даруу дөлгөөн зантай, бусдыг өөрөөсөө дээр гэж үздэг, өөрийгөө дөвийлгөдөггүй эргэн тойрныхоо хүмүүст амар амгаланг мэдрүүлдэг аж. Зан чанар нь хүрээлэн буй орчныхноосоо эрс ялгаатай, өөр ертөнцийнх гэмээр. Тэрээр махбодын төлөө биш сүнснийхээ төлөө амьдардаг. Үг үйлдэл хоёр нь Есүс Христийг санагдуулна. Амьдрал нь цэвэр ариун. Ёс суртахууны болон сүнслэг байдлын хувьд цэвэр. Мөн амар амгалан. Гүтгэлэг доромжлол ирэхэд тэвчээртэй хандаж, хариуг нь өгөх гэж тэмцдэггүй, өөрийгөө ч өмөөрдөггүй. Тэрээр дөлгөөн, тайван, уужуу зантай. Бусадтай эрүүл саруулаар ярилцаж, бусдын санаа бодлыг сонсож чаддаг. Өс саналгүй харин ч өөрт нь буруу зүйл хийсэн хүнийг уучлахад хэзээд бэлэн байдаг. Түүгээр ч зогсохгүй сайныг хүртэх зохисгүй хүмүүсийг хүртэл энэрдэг. Тэрээр бүгдэд нэг янзаараа, хэнийг ч алагчилж, ялгаварладаггүй. Ядууст хэрхэн ханддагийн адил баячуудад ч бас тийнхүү хандана. Эрх мэдэлтэй нэгнийг жирийн ард иргэдээс дээгүүрт тавьдаггүй. Үндсэндээ, хоёр нүүр гаргадаггүй. Хэлсэн үгэнд нь далд санаа байхгүй. Бусад бялдуучилж байна гэсэн мэдээ дуулдахгүй. Тэрээр үргэлж үнэнийг өгүүлж, баг өмсдөггүй.

Энэ ертөнцийн мэргэн хүн харин тийм биш. Түүний зүрх атаархал, хэрүүл тэмцлээр дүүрэн. Тэрээр өөрийгөө баяжуулах хүсэл сонирхлынхоо улмаас өрсөлдөгч, дайсан гэж үзсэн хүнээ тэвчиж чаддаггүй. Түүний зан чанарт

эрхэмсэг зүйл юу ч үгүй. Энэ ертөнцөөс ялгарах юм нэг ч үгүй. Яг л мал адгуус мэт дур хүслээ л өөхшүүлж амьдарна. Түүний арга барил зэрлэг балмад, урвагч, чөтгөр мэт байдаг. Сайхан хувцасных нь цаана бохир заваан амьдрал нуугдаж байдаг. Бодол санаа нь хордож, ёс суртахуун нь доройтож, хэл яриа нь шалиг завхай болсон байдаг. Өөртэй нь санал нийлээгүй, ямар нэг байдлаар замд нь саад болсон хүнийг үзэж чаддаггүй. Гэртээ ч, ажил дээрээ ч, олон нийтийн дунд ч байнгын хэрүүл маргаан хийж явдаг. Тэрээр хатуу хахир, тэвчээргүй, бүдүүлэг, харгис догшин. Хүмүүс түүнд тийм ч амар ойртож чадахгүй, хүмүүсээс зайгаа барина. Түүнтэй эвтэйхэн зөвшилцөж ярилцах ямар ч боломжгүй. Бүхнийг өөрийн зөв гэж бодох тул бодол санаа нь өөрчлөгдөнө гэж үгүй. Тэрээр хүнийг уучилдаггүй, өс хонзон санадаг. Бусдын алдаа зөрчлийг олж харвал ямар ч өршөөл үзүүлэхгүй. Харин ч доромжилж, хатуурхаж, муухай авирлана. Өөрт нь ашигтай гэж үзсэн хүмүүсийг л үнэлдэг. Ашиг тус нь дуусахаар харилцах сонирхол нь буурна. Эцэст нь, тэр бол хоёр нүүртэй, чин сэтгэлээсээ ханддаггүй. Түүний үг үйлдэл хоёрт итгэх арга байхгүй.

3:18 Иаков энэ бүлгийг **"Зөвт байдлын үр жимст тэдний үр болбоос амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм"** хэмээн төгсгөжээ. Энэ эшлэл бидний ярилцсан зүйлийг одоо ярих гэж буй сэдэвтэй холбодог. Саяхан бүгдээрээ жинхэнэ мэргэн ухаан амар тайванд дуртай гэдгийг үзсэн. Тэгвэл дараагийн бүлэгт Бурханы хүмүүсийн дунд гардаг зөрчилдөөний талаар үзнэ. Энэ эшлэлд амьдралыг тариалалтын үйл явцтай зүйрлэжээ. Тариаланч (амар тайвныг тогтоогч мэргэн хүн), цаг уур (**амар тайван**), ургац (**зөвт байдал**) гэсэн дүрслэлүүд энд гарч байна. Уг тариаланч зөвт байдлын ургац хураахыг хүсэж байна. Энэ ургац хэрүүл маргаан, тэмцэл зөрчилдөөний уур амьсгалд ургах уу? Мэдээж үгүй. Амар тайван нөхцөлд үрээ тарих ёстой. Амар амгалан зан

чанартай хүмүүс үрийг тарих хэрэгтэй. Тэгснээр зөвт байдлын ургац өөрсдийнх нь болон үйлчилж байгаа хүмүүсийнх нь амьдралд боловсорно.

Иаков дахин бидний итгэлийг шалгаж байна. Энэ удаа өдөр тутамдаа ямар мэргэн ухааныг харуулдаг вэ гэдгийг маань шалгаж байна. Дараах асуултуудыг өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Би Эзэн Есүст итгэдэг даруу итгэгчээс илүү энэ ертөнцийн бардам хүнийг хүндэлдэг үү? Би ямар ч ашиг харахгүйгээр Эзэнд үйлчилдэг үү? Сайн үр дүнд хүрэхийн төлөө заримдаа муу арга хэрэглэдэг үү? Хүмүүст нөлөөлөхийн тулд бялдуучлан долигонодог уу? Зүрх сэтгэлд минь атаархал хорсол байдаг уу? Ааш авир минь дөлгөөн даруу юу? Бодол санаа, үг хэл, ёс суртахуун минь цэвэр үү?

VIII. ШУНАХАЙРАЛ: ШАЛТГААН БА ЭДГЭРЭЛ (4-р бүлэг)

Мэргэн хүн амар тайвныг эрхэмлэдэг гэдгийг Иаков онцлон хэлжээ. Харин одоо Бурханы хүмүүсийн дунд байнга гардаг эмгэнэлт маргаан, зөрчлийг сануулж байна. Үүний шалтгаан юу вэ? Олон гэр бүл аз жаргалгүй, олон чуулган хагарч хуваагдахын учир юу вэ? Орон нутгийн христэд үйлчлэгчид ч тэр, харь оронд үйлчилдэг илгээлтийн эзэд ч тэр хатуу ширүүн зөрчил тэмцэлтэй байдаг шалтгаан юу юм бол оо? Энэ бүхний шалтгаан нь хүн бид өөрсдийн тааламж, эрх ашгийг хангах гэсэн хүсэл тачаалдаа автаж, бусдаас илүү гарах гэж үргэлж тэмцдэгт оршино.

4:1, 2а Харамсалтай хэдий ч үнэн зүйл бол христитгэгчдийн дунд **хэрүүл болон зөрчил** байдаг. Энэ хэсгийг итгэгчдийн тухай хэлээгүй гэвэл бодит үнэнд нийцэхгүй ба энэ эшлэлийн үнэт сургамжийг үнэгүйдүүлнэ. Тэгвэл энэ бүх тэмцлийн учир шалтгаан нь юунд оршино

вэ? Бидний дотор **хүслүүд** булгилж, тэрхүү **хүслүүдээ** биелүүлэхийн төлөө улайрч байдаг. Бидэнд эд материал цуглуулах гэсэн шунал хүсэл бий. Алдар нэр хөөцөлдөнө. Биеийн тааламжийг эрэлхийлж, өөгшүүлдэг хандлага байдаг. Эдгээр хүчирхэг нөлөө бидний дотор ажилладаг. Тиймээс бид хэзээ ч сэтгэл ханадаггүй. Үргэлж л улам илүүг хүснэ. Гэвч хүссэнээ авах гэсэн оролдлого маань байнга бүтэлгүйтэж байдаг мэт санагдана. Тиймээс уг биелээгүй хүсэл улам хүчтэй болж, замд саад болж байгаа мэт харагдах хүмүүсийг хүртэл хайр найргүй гишгэлэхэд хүрдэг. **"Та нар хүн алдаг"** гэсэн үгийг Иаков шууд утгаар хэлээгүй. Бид мэдээж хүн алдаггүй. Гэхдээ уур хилэн, атаа хорсол, харгис хэрцгий байдал маань хүн алах сэдлийг үүсгэдэг.

4:26, 3 Бид атаархдаг бөгөөд олж авч чаддаггүй. Бид бусдаас илүү дээр, сайн юмтай байхыг хүсдэг. Үүнийхээ улмаас өөр зуураа хэрэлдэж маргалдана.

Жон, Жейн хоёр гэр бүл болжээ. Жон дундаж цалинтай боломжийн ажилтай. Жейн чуулганы бусад гэр бүлүүдтэй адил сайхан байртай болохыг хүснэ. Харин Жон сүүлийн үеийн загварын авто машинтай болохыг мөрөөднө. Жейн гэртээ гоё тавилга, хэрэгсэл авмаар байгаа. Тэгэхээр заримыг нь лизингээр авах шаардлагатай. Гэхдээ Жоны цалин санхүүгийн энэ ачааллыг даахад бараг хүрэлцэхгүй. Удалгүй тэд хүүхэдтэй болов. Улмаар зардал ч нэмэгдэж, орлого ч хүрэлцэхээ болив. Жейний шаарддаг зүйлс ч нэмэгдэж, Жон улам уур уцаартай боллоо. Жейн гомдоллож, уурлаж, уйлж, удалгүй гэр оронд нь хэрүүл маргаан тасрахаа больжээ. Материализм энэ айлыг сүйрүүлж байна. Нөгөөтээгүүр, Жейний дотор атаархал байх ч магадлалтай. Боб, Сью хоёр чуулганд өөрсдөөс нь илүү нэр хүндтэй гэж тэр бодно. Удалгүй тэр Сьюд хорон үг чулуудаж эхэлнэ. Сью, Жейн хоёрын тэмцэл хурцдахад Жон, Боб хоёр ч хоорондоо таарч тохирохоо болив.

Цаашид чуулганы итгэгчид талцаж, ганц хүний шунал хүслээс болж хуваагдав.

Тэгвэл энд итгэгчдийн дунд гардаг хэрүүл маргаан, зөрчил тэмцлийн эх сурвалжийг харуулж байна. Илүү ихийг хүсэх шунал, бусдад атаархах сэдлээс энэ бүхэн эхэлдэг. Энэ хандлагыг боловсноор “айлын хоол амттай” гэж хэлж болох ч шуудхан хэлбэл, шунал, хүсэл тачаал, атаархал гэж болно. Бид шунал хүсэлдээ автдаг учраас хүсэл тачаалаа хангахын тулд юу ч хийхээс буцахгүй болдог. Гэхдээ жинхэнэ тааламжийг ийм аргаар олж авдаггүй харин идэх хоол, өмсөх хувцастайдаа сэтгэл хангалуун байвал жинхэнэ жаргалыг олно (1Тм 6:8).

Энэ асуудлын хамгийн зөв гаргалгаа бол залбирал. **"Бүү марга, бүү тэмц, харин залбир. Та нар гуйдаггүй учраас та нарт байдаггүй"** гэж Иаков хэлж байна. Эдгээр юмсыг бид Эзэнээс залбиран гуйхын оронд өөрсдийн хүчээр олж авах гэж оролддог. Байхгүй зүйлээ авахын тулд Бурханаас гуйх хэрэгтэй. Гуйсан ч залбирлын хариу ирэхгүй бол яах вэ? Тэгвэл бидний сэдэл цэвэр биш байжээ гэсэн үг. Бид Бурханы алдрын төлөө, эсвэл хөршүүдийнхээ сайн сайхны төлөө эдгээрийг эзэмшихийг зориогүй гэсэн үг. Харин амин хувийн зорилгоо биелүүлэхийг л зорьжээ гэсэн үг. Бид төрөлх дур хүслээ хангахыг боджээ л гэсэн үг. Бурхан ийм залбиралд хариулна гэж амлаагүй.

Эхний гурван эшлэл бидэнд ямар гүн сургамжийг өгч байна вэ! Хүн Бурханы өгсөн зүйлд сэтгэл хангалуун байдагсан бол ямар их хэрүүл маргаан зөрчилдөөнөөс зайлсхийж болох байсан бол оо! Бид хөршүүдээ өөрийн адил хайрлаж, авахын оронд өгөхийг урьтал болгодогсон бол амар тайван ноёрхох байлаа. Хураахын оронд бүхнийг орхиж, газар дээр бус тэнгэрт баялгийг хураа гэсэн Аврагч Эзэний тушаалыг дагасансан бол зөрчил тэмцэл төгсгөл болох байлаа.

4:4 Иаков материаллаг зүйлсийг хайрлах хайрыг сүнслэг завхайралтай зүйрлэн буруутгасан. Бурхан Өөрийг нь нэн тэргүүнд тавьж, үнэнчээр хайрлахыг биднээс хүсдэг. Бид энэ ертөнцийн өнгөрөн одож буй зүйлсийг хайрлавал Бурханд үнэнч байж чадахгүй.

Шунал бол шүтээн шүтлэгийн нэгэн хэлбэр. Бурхан бидэнд өгөхийг хүсээгүй зүйлийг авах гэж улайрч байна гэсэн үг. Энэ нь зүрхэндээ шүтээн залсантай адил. Бид Бурханы хүслээс илүү материаллаг зүйлсийг эрхэмлэж байна гэсэн үг. Тиймээс шунал бол шүтээн шүтлэг бөгөөд шүтээн шүтлэг нь Эзэнд итгэмжгүй байгаа сүнслэг завхайрал юм.

Ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал. Ертөнц гэж бидний амьдарч буй энэ гариг, байгаль дэлхийг хэлээгүй. Харин нүдний хүсэл, махан биеийн хүсэл тачаал, амьдралын бардам бахдалыг хангахын төлөө хүн өөртөө зориулж байгуулсан тогтолцоог хэлж байгаа юм. Энэ тогтолцоонд Бурхан болон Түүний Хүүг багтаах орон зай байдаггүй. Энэ нь урлагийн ертөнц, соёл, боловсрол, шинжлэх ухаан, шашин шүтлэг ч байж болно. Энэ хүрээлэлд Христийн нэрийг таатай хүлээн авдаггүй, заримдаа бүр тас хориглоно. Христийг хоосон шашны ёс жаяг төдийхнөөр л хүлээн авна. Товчхондоо, жинхэнэ чуулганы хүрээллээс гадуурх хүн төрөлхтний бүтээсэн ертөнц юм. Энэ тогтолцоонд уусвал Бурханы дайсан болдог. Энэ ертөнц л үнэндээ амь ба алдрын Эзэнийг цовдолсон шүү дээ. Түүнийг үхэлд хүргэхэд *шашны* ертөнц гол үүргийг гүйцэтгэсэн. Тийм атал Аврагчийг нь хөнөөсөн ертөнцтэй мөр зэрэгцэн алхахыг хүснэ гэдэг итгэгч хүний хувьд байж болшгүй зүйл!

4:5 5 дугаар эшлэл уг захидлын хамгийн хэцүү хэсэг нь: "Эсвэл Бичвэр дэмий хоосноор "Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг" хэмээсэн гэж та нар бодож байна уу?"

Эхний бэрхшээл гэвэл Иаков Хуучин гэрээнээс эш татсан мэт харагдаж байгаа ч Хуучин гэрээнд яг ийм үг байдаггүй. Библид албан ёсоор багтаагүй номуудад ч энэ үг байхгүй. Тэгэхээр уг эшлэлд хоёр боломжит тайлбар бий: (1) Хэдийгээр энэ үг Хуучин гэрээнд ийнхүү үгчлэн бичигдээгүй ч Иаков Бичвэрийн ерөнхий санааг эш татсан байж болно. (2) Энэ асуудлын хоёр дахь тайлбарыг RV орчуулгын хувилбараас харж болно. Уг орчуулга энэ эшлэлийг хоёр асуулт болгон ийнхүү салгасан байдаг: "Эсвэл Бичвэр дэмий хоосон хэлсэн гэж та нар бодож байна уу? Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс атаархан хүсдэг гэж үү?" Энэ орчуулгаас харвал өрсөлдөх сэтгэл, ертөнцтэй найзалдаг сүнсийг буруутгасан Библийн үг дэмий хоосон биш шүү гэсэн утга санаа байна.

Тавдугаар эшлэлийн хоёр дахь бэрхшээл бол эшлэлийн удаах хэсгийн утга санаа юм. Энд *Ариун* Сүнсийг (NKJV орчуулгад бичсэн шиг⁸) хэлж байна уу эсвэл *атаархан хүсдэг* сэтгэлийг (сүнсийг) хэлж байна уу гэдэг нь тодорхойгүй байна. Сүнс гэдэг нь Ариун Сүнсийг илэрхийлсэн бол хэрүүл маргааныг үүсгэдэг хүсэл тачаал, атаархлыг бидний дотор Бурханы суулгасан Ариун Сүнс бий болгодоггүй харин ч Тэр Сүнс биднийг Христэд бүрэн зориулагдаасай гэж атаархан **хүсдэг** гэсэн утгатай болно. Эсвэл сүнс гэдэг нь атаархах сэтгэлийг хэлж байгаа бол бидний дотор оршдог хүсэл тачаал, атаархлын сүнс Бурханд итгэмжгүй байдлыг бий болгодог гэсэн утгатай болно.

4:6 Гэвч Тэр илүү их нигүүлсэл өгдөг. Эхний таван эшлэлд итгэгч хүний хуучин мөн чанар ямар бузар муу болохыг харуулжээ. Харин одоо энэхүү махан биеийн хүсэл тачаалтай өөрийн хүч чадлаар тэмцэхгүй гэдгийг бид сурч байна. Хэрэгцээтэй цагт **нигүүлслийг** буюу хүчийг **өгдөг** Бурханд талархъя (Евр 4:16). Амьдрах өдрийн чинь уртад хүч чадал оршино" гэж Тэр амласан (Дх 33:25).

Ачаа минь хүндэрвэл Тэр надад илүү их хүчийг хайрладаг

Ажил минь арвидвал Тэр нигүүлслийн булгаа бялхаадаг
Зовлон минь нэмэгдвэл Тэр өршөөлийнхөө голыг цутгадаг

Замд минь сорилт оволзвол Тэр амар амгалангаараа хучдаг

- Энни Жонсон Флинт

Хэрэгцээтэй цагт Бурхан нигүүлслийг өгдөг гэдгийг батлахын тулд Иаков Сургаалт үгс 3:34-ийг эш татсан боловч энэхүү **нигүүлслийг** бардам хүнд биш **даруу** нэгэнд амлажээ. **Бурхан бардмыг эсэргүүцдэг** боловч эмтэрсэн сүнстэй хүнийг эсэргүүцдэггүй.

4:7 Жинхэнэ гэмшил байгаа үед дагах ёстой зургаан алхмыг 7-10 дугаар эшлэлд дурджээ. Иаков ариун хүмүүс нүгэл үйлдэхийн эсрэг дуу хоолойгоо өргөж байна. Түүний үгс гэмшлийн сумыг зүрхэнд минь харвадаг бөгөөд Бурханы сэнтийгээс гарах аянга мэт биднийг ниргэдэг. Улмаар Бурхан бидэнд үгээ хэлж байгааг бид ухамсарлаж зүрх сэтгэл маань Түүний үгийн нөлөөн дор сөгддөг. Гэхдээ бид юу хийх ёстой вэ гэсэн асуулт урган гарна.

Тэгвэл **Бурханд захирагдах** нь хамгийн эхний алхам болно. Өөрөөр хэлбэл, Бурханд бууж өгч, Түүнийг сонсож, үгийг нь дуулгавартай дагана гэсэн үг. Бардамнаж, гөжүүдлэхгүй даруу эмтэрсэн сэтгэлтэй байх хэрэгтэй гэсэн үг. Дараа нь **диаволыг эсэргүүцэх** ёстой. Үүний тулд диаволын уруу татлага, заль мэхэнд чихэн дүлий байж, тэдгээрээс зүрхээ хамгаална гэсэн үг. Сүнсний сэлэм болох Бичвэрийг ашиглан диаволыг эсэргүүцнэ. Бид түүнийг эсэргүүцвэл **тэр** биднээс **зайлна**.

4:8 Дараа нь бид **Бурханд ойртох** хэрэгтэй. Залбирлаар л Түүнд ойртоно. Бид зүрхэндээ байгаагаа Түүнд өчиж, итгэлтэй, хүсэмжилсэн залбирлаар Бурханы өмнө очих хэрэгтэй. Ингэж бид Бурханд ойртвол Тэр ч бас бидэнд **ойртоно**. Махан биеэ өөхшүүлж, дэлхийн зарчмаар амьдарч байгаа учраас Бурхан биднээс хол байгаа гэж бид боддог ч Түүнд ойртох үед Тэр биднийг уучилж, сэргээн шинэчилдэг. Дөрөв дэх алхам нь **нүгэлт гараа цэвэрлэж, хоёр санаат зүрхээ ариусгах** явдал билээ. Гар нь үйлдлийг, **зүрх** нь хүсэл, сэдлийг төлөөлдөг. Бид гаднаасаа ч тэр сэтгэлийн гүнээсээ ч тэр нүглээ улайж, таягдан хаяснаар **гараа цэвэрлэж, зүрхээ ариусгана**. Бид **нүгэлтэй** учраас бузар үйлсээ улайх хэрэгтэй. **Хоёр санаат** хүмүүсийн хувьд бид бүгдээрээ урваж шарвадаг байдлаа улайх хэрэгтэй.

4:9 Нүглээ улайх нь гүн харууслыг дагуулах ёстой. **Шанал, гашууд, уйл. Инээд чинь гашуудал болог, баяр хөөр чинь уйтгар гуниг болог.** Бурхан нүглийг минь ухааруулахаар айлчлах нь баярлан хөөрөх цаг биш. Харин Бурханы өмнө нүүрээрээ хөсөр унаж, нүгэл, сул дорой байдал, хүйтэн цэвдэг сэтгэл, дөжирсөн байдалдаа гашуудах цаг билээ. Бид материаллаг зүйлст татагдаж, дэлхийн юмсыг бодож, хэлбэр хөөсөндөө уйлж, даруу болох ёстой. Гаднаа ч, дотроо ч жинхэнэ гэмшлийн үр жимсийг харуулах хэрэгтэй.

4:10 Сүүлчийн алхам бол **Эзэний өмнө өөрсдийгөө даруу болгох** явдал. Бид Эзэний хөлд байх ёстой байрандаа тоос шороон дээр хэвтвэл цаг нь ирэхээр **Тэр** биднийг **өргөмжилнө**.

Эзэн бидэнд үнэн байдлыг минь харуулах үед биднээс яг ийм хариу үйлдэл гарах учиртай. Харамсалтай нь энэ хандлага тун цөөн ажиглагддаг. Жишээлбэл, нэгэн цуглаан дээр Бурхан сэтгэлд минь чангаар ярьжээ гэж бодъё. Бид тухайн мөчид сэтгэл хөдөлж, шийдвэр гаргадаг. Гэтэл

цуглаан дуусмагц хүмүүстэй нийлэн аахар шаахар юм ярьж эхэлдэг. Ингээд цуглааны уур амьсгал өөрчлөгдөж, үгийн нөлөө арилж, Бурханы Сүнс бөхдөг.

4:11, 12 Иаков **ах дүүгээ гүжирддэг эсвэл шүүдэг** нүглийг цааш нь өгүүлж байна. Бусдыг шүүмжлэхээсээ өмнө гурван асуултыг өөрөөсөө асуух хэрэгтэй гэж хэн нэгэн хэлсэн байдаг. Энэ нь ах дүүд чинь ямар ашиг тустай вэ? Өөрт чинь ямар ашиг тустай вэ? Ингэснээр Бурханыг алдаршуулах уу?

Хаан **хуульд** хөршөө өөрийн адил хайрла гэж заадаг. Тэгэхээр ах дүүгээ гүжирдэн, сэдлийг нь шүүх нь энэ хуулийн эсрэг ярьж, үнэ цэнийг нь үгүйсгэсэнтэй адил хэрэг билээ. Хуулийг санаатайгаар зөрчинө гэдэг хуулийг доромжилж, үл хүндэлж байгаа хэрэг юм. Нэг үгээр хэлбэл, "Дуулгавартай байхыг эсэргүүцэгч нь хууль сайн биш, дагах шаардлагагүй" гэж хэлж байгаатай агаар нэг. Үнэндээ ах дүүгээ гүжирдэгч нь өөрийгөө шүүгчийн байр сууринд тавьдаг. Уг нь бол тэрээр **шүүгчийн** биш **шүүгдэгчийн** байр сууринд байх ёстой. Тэрээр өөрийгөө хуулийг биелүүлэгч биш хуулийн дээгүүр эрх мэдэлтэн болгож байна. Гэвч Бурхан л хуулийн дээгүүр эрх мэдэлтэй. Хуулийг тогтоож, хуулиар шүүдэг нэгэн бол Бурхан. Тэгвэл **хэн гээч** нь Бурханы *байр суурийг түрэмгийлэн* эзэлж, **бусдыг шүүхээр** зүрхэлж чадах вэ?

4:13 Иаков цааш нь Бурханд түшиглэхгүйгээр өөртөө найдан төлөвлөдөг нүглийг зэмлэж байна (13-16-р эшлэл). Иаков ирээдүйнхээ төлөвлөгөөг бүрэн гаргасан хүнийг дүрсэлжээ. Тэр хүн юу хэлж байгааг анзаараарай. Тэрээр цаг хугацаа (**өнөөдөр эсвэл маргааш**), хүний нөөц (**бид**), газар орон (**тийм тийм хотод**), үргэлжлэх хугацаа (**нэг жил**), ажил хэрэг (**худалдаа хийж**), зорьж буй үр дүнгийнхээ (**ашиг олно**) талаар бүгдийг бодож төлөвлөжээ. Энд юу дутаж байна вэ? Тэр эл үйл хэрэгтээ Бурханыг огт дурдсангүй. Амьдралд ирээдүйгээ төлөвлөх нь чухал л даа.

Гэхдээ Бурханаас ангид төлөвлөх нь цаанаа нүгэл юм. "Би", "Бид" гэдэг хандлага нүглийн мөн чанар юм. Тухайлбал, Исаиа 14:13, 14 дээр Люсифер ямар олон удаа би гэж хэлснийг анзаараарай: "Би тэнгэрт гарна. Би Бурханы оддын дээр сэнтийгээ босгоно. Би умардын хамгийн чанадад чуулганы уулан дээр заларна. Би үүлсийн орой дээр гарна. Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн лугаа адил болгоно."

4:14 Маргаашийг баттай мэддэг юм шиг төлөвлөх нь буруу. "...Маргааш... гэж бүү хэл!" (Сур 3:28) Учир нь бид **хэсэг зуур үзэгдээд дараа нь арилах уур манан шүү дээ.**

4:15 Юу ч төлөвлөсөн Бурхантай зөвлөлдөж, Бурханы хүслийн дагуу хийх хэрэгтэй. Бидний хувь тавилан Бурханы мэдэлд байдгийг ухаарсан ухаарлаараа ярьж, амьдрах учиртай. **"Эзэн хүсвэл, бид амьд байж, үүнийг болон түүнийг хийнэ"** гэж яривал зөв болно. Тийм ч учраас Үйлс номд элч Паул "Хэрэв Бурхан хүсвэл би та нар дээр эргэж ирнэ" (18:21) гэж хэлжээ. Мөн 1Коринт 4:19 дээр "Хэрэв Эзэн хүсвэл Тит та нар дээр удахгүй очно" гэж бичсэн байна. Заримдаа итгэгчид захидалдаа "D.V." гэж тэмдэглэн Бурханаас хамааралтай гэдгээ илэрхийлдэг. *Deo Volente* гэх энэ латин үгийн товчлол *Бурхан хүсвэл* гэсэн утгатай.

4:16 Та нар ихэмсэг зандаа сайрхдаг хэмээн Иаков бичжээ. Христитгэгчид ирээдүйгээ сайрхлаар төлөвлөж бардамнадаг байжээ. Юу ч төлөвлөгөөнд нь саад учруулахгүй хэмээн мунхаглан бодож, ихэрхдэг байж. Тэд өөрсдийнхөө хувь тавилангийн эзэд юм мэт аашилж байлаа. **Иймэрхүү сайрхал нь ёрын муу юм.** Учир нь ийм сайрхал Бурханыг орхигдуулдаг.

4:17 Тийнхүү зөвийг үйлддэг хэрнээ эс үйлдэгсдэд энэ нь нүгэл болой. Энэ хам сэдвийн хүрээнд зөвийг үйлдэх гэдэг нь амьдралынхаа бүх талбарт Бурханыг оруулж, хором мөч тутам Бурханд түшиглэж амьдрахыг

хэлж байгаа юм. Үүнийг хийх ёстойгоо мэдсээр байж хийхгүй бол бид гарцаагүй нүгэл үйлдэж байна. Мэдээж энэ зарчим илүү өргөн хүрээг хамарна. Амьдралын ямар ч талбарт **зөвийг үйлдэх** боломж нь заавал зөвийг үйлдэх үүрэг хариуцлагыг дагуулдаг. Бид юу нь зөв болохыг мэдэж байвал тэрхүү ухаарлынхаа дагуу амьдрах үүрэг хүлээдэг. Эс үйлдэх нь Бурханы эсрэг, хөршийнхөө эсрэг, өөрсдийнхөө эсрэг үйлдэж буй **нүгэл** мөн.

Дөрөвдүгээр бүлэгт шунал тачаал ба зөрчил тэмцэл, ах дүүгээ гүжирдэх, Эзэнтэй зөвлөлгүйгээр төлөвлөх зэрэг асуудлаар Иаков биднийг шалгаж байна. Тиймээс дараах асуултуудыг өөрсдөөсөө асууцгаая. Би илүү их юмтай болох гэж улайрдаг уу эсвэл байгаадаа сэтгэл хангалуун байдаг уу? Өөрөөс маань илүү юмтай хүнд би атаархдаг уу? Худалдан авалт хийхээсээ өмнө би залбирдаг уу? Бурхан надад үгээ хэлэхэд би дуулгавартай дагадаг уу эсвэл эсэргүүцдэг үү? Би ах дүүсээ гүжирддэг үү? Би Эзэнтэй зөвлөлгүйгээр төлөвлөдөг үү?

IX. БАЯЧУУД БА ТЭДЭНД ИРЭХ ШАНАЛАЛ (5:1-6)

Иаков захидлынхаа хамгийн гүн гүнзгий, сэтгэл цочроом хэсгүүдийн нэг болох энэ хэсэгт баян хүний нүглийг буруушаан зэмлэжээ. Түүний үгс яг л хүнд алхаар цохиод авах мэт хүчтэй, энэрэлгүй байдаг. Үнэн хэрэгтээ, энэхүү зэмлэл тун хатуу учраас эдгээр эшлэлээс ховорхон номлодог.

Энд Иаков нийгмийн шударга ёсны төлөө дуугардаг эш үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж, хүмүүний хэрэгцээг харсан ч хараагүй мэт мөнгөө харамладаг баячуудын нүглийн эсрэг дуугаа өндөрсгөж байна. Мөн ажилчдаа мөлжиж баян болсон хүмүүсийг буруутгажээ. Эд баялгаа амин хувийн жаргал цэнгэл, тансаг амьдралд зориулж

байгааг нь зэмлэжээ. Эцэст нь, баячуудыг зөвтийг хавчин бардамнадаг байдлаар дүрсэлсэн байна.

5:1 Юуны өмнө баячуудыг **уйл орил** хэмээн Иаков уриалж байна. Учир нь тэднийг **зовлон** хүлээж байна. Тэд удахгүй Бурхантай уулзаж ичгүүр, гутамшиг, харамслаар дүүрнэ. Тэд ямар итгэмжгүй нярав байснаа мэдээд ямар их боломжуудыг алдсанаа ухаарч, хувиа хичээсэн шуналт зан гаргаж байсандаа гашуудан уйлна. Тэд хүний хөдөлмөрийг шударга бусаар мөлжиж байсан буруугаа ойлгож, Эзэнд найдахаас илүү материаллаг зүйлсээс амьдралын баталгаа хайж байсан нүглээ олж харна. Амин хувийн жаргал цэнгэлдээ ташуурч байснаа хараад гашуудан уйлцгаана. Иаков баян хүний үйлддэг дөрвөн гол нүглийг дурджээ. Эхнийх нь эд баялаг хураах нүгэл юм.

5:2 “Эд баялаг чинь ялзарч, дээлийг чинь хивэн хорхой иджээ” хэмээн Иаков хэлжээ. “Алт, мөнгө чинь зэвэрч, зэв нь та нарын эсрэг гэрч болж, махбодыг чинь гал мэт залгина. Та нар эрдэнэсээ эцсийн өдрүүдэд хураажээ”.

Баян байх нь нүгэл гэж Библи хэзээ ч хэлээгүй. Жишээ нь, хүн нэг шөнийн дотор их хэмжээний эд хөрөнгө өвлөж авлаа гэхэд тийнхүү баян болсноороо нүгэл үйлдэж байгаа хэрэг биш. Харин эд хөрөнгө хураах нь буруу гэж Библи заадаг. Хөрөнгө мөнгө хураахыг Эзэн Есүс тов тодорхой буруутгасан байна. Тэрээр, "Газар дээр өөрсдөдөө эд баялаг бүү хураа. Тэнд хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэг, хулгайч эвдэж ороод, хулгайлдаг аж. Харин өөрсдөдөө эд баялгийг тэнгэрт хураа. Учир нь тэнд хивэн хорхой ба зэв идэж сүйтгэдэггүй, хулгайч ч эвдэж ордоггүй, хулгайлдаггүй. Эд баялаг чинь хаана байна, зүрх сэтгэл чинь бас тэнд байх болно" гэжээ (Мт 6:19-21).

Иаков баялгийг эд **баялаг, дээл, алт, мөнгө** гэх дөрвөн хэлбэрээр авч үзжээ. Библийн цаг үед эд баялаг ерөнхийдөө үр тариа, тос, хувцас, алт, мөнгө хэлбэрээр оршиж байв. "**Эд баялаг чинь ялзарчээ**" гэж байгаа нь үр

тариа хөгцөрч муудах, тос хуршиж гашлах тухай ярьсан бололтой. Гол санаа нь эдгээрийг өлссөн хүмүүсийг хооллоход ашиглаж болох байсан ч ялзарч муудтал нь хадгалсныг хэлж байна. Гэвч одоо ямар ч хэрэггүй болжээ. Мөн **"Дээлийг чинь хивэн хорхой иджээ"** гэж Иаков хэлж байна. Хувцсыг тогтмол хэрэглэхэд хивэн хорхой иддэггүй. Харин их хэмжээгээр шүүгээндээ хурааж, удаан хугацаанд хэрэглэхгүй байх үед хивэн хорхой иддэг. Энэ дэлхий дээр дэндүү олон хүн хувцас хунар, олон зүйлээр дутагдаж гачигдаж байхад дээл хувцсаа ингэтэл нь цааш хураах нь ёс зүйн хувьд буруу гэж Иаков үзжээ.

5:3 Алт, мөнгө чинь зэвэрч, зэв нь та нарын эсрэг гэрч болж, махбодыг чинь гал мэт залгина. Та нар эрдэнэсээ эцсийн өдрүүдэд хураажээ. Алт мөнгө зэвэрдэггүй боловч өнгө нь хувирч, өнгөр тогтох тохиолдол бий. Муу нөхцөлд удаан хадгалбал уг өнгөр нь зэврэх боломжтой. Өлсгөлөн нэгнийг хооллож, нүцгэн хүнийг хувцаслаж, өвчтөнд эм авч өгч, сайнмэдээг түгээхийн оронд баячууд мөнгөө хэцүү цагийн төлөө хадгалдаг. Гэтэл энэ нь хэнд ч ашиг тусаа өгөхгүй, эцэст нь хэрэггүй хог болдог.

Удаан хугацаанд хэрэглээгүйн улмаас элэгдэж муудах үйл явцыг зэв идэх гэжээ. Энэ нь баячуудыг буруутгах гэрч болно. Иаковын үед амьдарч байсан баячуудын тухайд энэ үг үнэн байсан бол өнөөгийн итгэгчдэд бүр ч илүү үнэн байх бус уу? Сайнмэдээг тараах нөөц бололцоотой атлаа түүнийгээ ашиглаагүй бол бидэнд ямар буруутгал ирэх бол? Сүнснүүдийн авралын төлөө ашиглаж болох их хэмжээний эд материал цуглуулчхаад түүнийгээ зориулахгүй бол яах вэ? **Зэв нь махбодыг чинь гал мэт залгина** гэдэг нь эд баялгаа бусдын сайн сайхны төлөө ашиглаагүй бол эцэст нь асар их шаналж, харамсана гэсэн утгатай. Эцсийн эцэст хувиа хичээсэн зан, шунал (үнэт эдлэл, дэгжин хувцас, орд

харш мэт гэр орон, үнэтэй машин) гэдэг ямар харгис болохыг олж хараад зовж, зүрх нь зүсэгдэнэ.

5:4 Иаковын буруутгасан хоёр дахь нүгэл бол ажилчдаа шулж мөлжих замаар эд хөрөнгө олж авах явдал юм. **Тариалангийн** талбайд ажилласан **ажилчид хөлсөө** авч чадахгүй хохирцгоожээ. Тэд эсэргүүцэл гаргасан ч хүчин мөхөстөж байлаа. Шударга ёсыг тэдний өмнөөс хамгаалан тэмцэх нэг ч хүн байсангүй. Гэвч тэдний **хашхираан түг түмдийн** Эзэнд хүрчээ. Тэнгэрийн цэргүүдийг захирдаг Нэгэн газар дэлхий дээр дарлагдсан олны төлөө зогсдог. Бүхнийг чадагч Эзэн Бурхан тэдэнд тусалж, өшөөг нь авч өгнө. Тэгэхээр Библи эд хөрөнгө хурааж цуглуулахыг буруутгахаас гадна шударга бус замаар эд хөрөнгө олохыг зэмлэдэг. Хүний хөлсийг зохих ёсоор төлөхгүй байх нүглээс гадна орлогын албан татварын тайлангаа хуурамчаар мэдүүлэх, жин хэмжүүрээр хуурах, төрийн албан хаагчдыг хахуульдах, хуурамч зар сурталчилгаа явуулах, зардлын дансаа хуурамчаар үйлдэх зэргийг ч Иаков дурдсан байж болох юм.

Иаков дараа нь баячуудын хэтэрхий тансаг амьдардаг нүглийг буруутгажээ. Түмэн олон туйлын гачлантай амьдарч байхад баячууд үнэт эдлэл, дэгжин хувцас, орд харш мэт гэр орон, хэтэрхий үрэлгэн хоол хүнс гэх мэтийг өөрсдөдөө зарцуулан тансаглах нь зүйд нийцэх үү? Үүнийг өнөөгийн нийгэмд нийцүүлэн хэлбэл Христийн чуулган ба итгэгчид дэндүү их тансаглалаа хэрхэн зөвтгөж чадах вэ? Мянга мянган хүн өлсөж үхдэг дэлхийд бид амьдарч байна. Дэлхийн хүн амын талаас илүү хувь нь Эзэн Есүс Христийн сайнмэдээг амьдралдаа огт сонсож үзээгүй байгаа. Ийм байхад спорт машин, лимузин, уралдааны завиа бид юугаар зөвтгөх юм бэ? Эзэний мөнгийг үнэтэй зочид буудал, дээд зэрэглэлийн ресторан гэх мэт өөрийгөө зугаацуулах зүйлст хэрхэн зарцуулж зүрхэлнэ вэ? Бичвэрийн тов тодорхой сургаал, энэ ертөнцийн туйлын их

хэрэгцээ, Аврагчийн үлгэр дуурайлал, энэрч нигүүлсдэг мөс чанар маань сайнмэдээ сонсоогүй ганц хүн үлдсэн л бол тохь тухтай, тансаглалд амар жимэр амьдрах нь буруу гэдгийг хэлээд өгдөг.

Баян тансаг, эрх дураараа амьдардаг хүмүүсийг нядлах гэж байгаа малыг эхлээд сайтар борддогтой адил **нядалгааны өдөрт зүрхээ бордсон** хэмээн хэлжээ. Ийм хүмүүсийг дайны үед олон хүн тулаанд үхэж байхад хулгай хийж, амиа хоохойлж буй цэрэгтэй адилтгаж бас болно.

5:6 Зөвт нэгнийг яллаж алсан ба тэр тэднийг эсэргүүцдэггүй хэмээн Иаков баячуудыг эцсийн удаа буруутгажээ. Зарим хүн энэхүү зөвт нэгнийг Эзэн Есүс гэж үздэг. Гэвч Эзэн Есүсийг баячууд гэхээсээ илүү шашны удирдагчид алсан. Зөвт нэгэн гэдгийг ерөнхийдөө эгэл жирийн, гэм зэмгүй хүмүүсийг хэлж байна гэж үзэх нь хамгийн тохиромжтой. Иаков баячууд доод тушаалын хүмүүстэй бүдүүлэг, харгис, ёс зүйгүй ханддаг нийтлэг байдлыг бодож ийнхүү хэлжээ. Тэд гэм зэмгүй эгэл жирийн хүмүүсийг гүтгэж, хатуу үгээр **яллаж**, ширүүн харьцдаг байжээ. Баячууд тэднийг шууд утгаараа биш ч хөдөлмөрийг нь шулж мөлжих замаар амь амьдралыг нь сүйрүүлж, алдаг байжээ. Тэдгээр гэм зэмгүй хүмүүс баячуудыг эсэргүүцдэггүй. Эсэргүүцэл үзүүлбэл баячууд улам хэрцгий харьцаж, гэм зэмгүй хүмүүс ажлаасаа халагдахад хүрч болзошгүй байжээ.

Х. ТЭСВЭР ТЭВЧЭЭРТ СУРГАМЖИЛСАН НЬ (5:7-12)

5:7 Иаков одоо дарлагдсан итгэгчдэд хандаж тэдэнд **тэвчээртэй** байхыг уриалж байна. **Тэвчээртэй** байх шалтгаан бол **Эзэн ирэх явдал** юм. Эзэн ирнэ гэдэг нь чуулганыг шүүрэх шүүрэлт аль эсхүл Христ газар дэлхий дээр хаанчлахаар залран ирэхийг хэлж байж болно. Аль

依ийг нь Шинэ гэрээнд тэвчээртэй байх урам зориг болгон ашиглажээ. Тариачны жишээ тэвчээртэй байх хэрэгтэйг дүрслэн харуулдаг. Тариачин тариа тарьсан өдөртөө ургацаа хурааж авдаггүй. Харин удаан хугацаанд хүлээх шаардлагатай болдог. Эхлээд **эрт бороо** орж, үр соёолох ёстой. Дараа нь улирлын төгсгөлд **оройтсон бороо** орж үр тариаг боловсруулна. **Эрт ба оройтсон бороо** гэж энд гарсан үгийг зарим хүн чуулган анх бий болоход тохиолдсон Пентэкостын ерөөл Эзэн дахин ирэхээс өмнө тохиох амлалт гэж үздэг. Гэвч Шинэ гэрээний бүхэл агуулга тийм хүлээлтийг төдийлөн дэмждэггүй. Гэсэн ч итгэмжит үлдэгсэд Бурханы төлөө зүрх сэтгэл нь шатаж, бүх дэлхийд сайнмэдээг хүргэхийн төлөө явна гэсэн горьдлогыг хориглох зүйлгүй. Аврагч Эзэн айлчлан ирэхэд ийнхүү бэлдэхээс илүү сайн зам байгаа гэж үү?

5:8 Эзэн ирээд энэ дэлхийн бурууг зөв голдиролд нь оруулна. Тиймээс Түүний хүмүүс тариачин шиг **тэвчээртэй** байх хэрэгтэй. **Эзэн ирэх** нь гарцаагүй гэдэгт бат итгэн **зүрхээ чангалах** хэрэгтэй.

Хавчлага дарамттай үед хохирсон хүмүүс бие биеийнхээ эсрэг болох нь элбэг тохиолддог. Хүний нүгэлд унасан мөн чанар дарамт шахалтад орохоороо хамгийн их хайрладаг хүмүүс рүүгээ хамаг уур хилэнгээ гаргадаг. Тиймээс дараах сэрэмжлүүлгийг өгч байна. **Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн [буруутгагдахгүйн]**⁹ тулд **бие биеийнхээ эсрэг бүү гомдолло**. Хүнд нөхцөлд хамтдаа үйлчилж буй Эзэний зарц нарт энэ эшлэлийг зориулжээ. Бид бие биеийнхээ эсрэг гомдол тээх ёсгүй. Учир нь **Шүүгч үүдэн дээр зогсож байна!** Тэр бидний бодлыг мэднэ. Бид удахгүй Христийн шүүх суудлын өмнө зогсоод тайлагнах болно. Шүүгдэхгүйн тулд шүүхгүй байх хэрэгтэй.

5:10 Хуучин гэрээний эш үзүүлэгчдийг зовлон ба тэвчээрийн жишээ болгон өгчээ. Тэвчихийн тулд эхлээд

зовлон тохиолдож байгааг анзаараарай. "Зовлон нь тэвчээрийг төрүүлдэг" (Ром 5:3). Өмнө нь тайлбарлаж хэлсэнчлэн тэвчээр гэдэг нь Шинэ гэрээнд хатуужил, тууштай байдлыг илэрхийлдэг. Эзэний үгийг итгэмжтэй тунхаглаж байсныхаа төлөө тэдгээр эш үзүүлэгчид өршөөлгүйгээр хавчигдан, дарлагдсан. Гэсэн ч "тэд үл үзэгдэх Түүнийг харж байгаа мэт тэвчсэн ажээ" (Евр 11:27)

5:11 Бид Исаиа, Иеремиа, Даниел зэрэг эш үзүүлэгчдийг харахдаа туйлын хүндэтгэлтэй ханддаг шүү дээ. Тэдний халуун сэтгэл, тууштай байдлыг нь бид хүндэлдэг. Тэр ч утгаараа бид тэднийг **ерөөлтэй** гэж үздэг. Харин одоо бид энэ ертөнц буруу байсныг, харин тэдний зөв байсныг харж байна. Харин тухайн цаг үедээ тэд асар их сорилт бэрхшээл, зовлон зүдүүрийг туулж, тэвчсэнийг мартаж болохгүй. Хэрэв бид **ерөөлтэй** гэж дуудагдахыг хүсэж байвал тэдний адил тэвчээртэй байх ёстой гэж дүгнэх нь зөв.

Тэвчээр буюу тэсвэр хатуужлын нэг тод жишээ бол **Иов** мөн. Богинохон хугацаанд Иов шиг хамаг юмаа алдсан хүн түүхэнд тийм ч олон биш ээ. Гэсэн ч **Иов** Бурханыг харааж, Түүнээс нүүр буруулаагүй. Эцэст нь, Бурхан түүний тэвчээрийг шагнаж, Өөрийгөө илчилсэн. Тэрээр **энэрлээр дүүрэн, өршөөнгүй** хандахын төлөө цаг ямагт ийнхүү Өөрийгөө илчилдэг.

Хэрэв бид Иаковын хэлсэнчлэн **Эзэний хийсэн төгсгөлийг** (Эзэний авчрах эцсийн үр дүн) мэддэггүй байсан бол хорон муу хүмүүст атаархах байлаа. Асаф хорон муу хүний амжилтыг хараад атаархсан. (Дуу 73:3-17) Асаф энэ тухай бодох тусам улам тайван бус болж байв. Харин дараа нь Бурханы ариун газарт ороод тэр тэдний хожмын төгсгөлийг ойлгожээ. Энэ ойлголт атаархлыг нь үлдэн хөөжээ. Давид ч мөн адил зүйлийг амссан байдаг. Дуулал 17:15 дээр Давид хожмын ирээдүйд итгэгч хүний хүртэх хувь ноогдлыг дүрсэлжээ. Энэ өнцгөөс бодвол

итгэгч хүн тууштай байх ёстой болж байна. Харин Иовын хувьд **Эзэний хийсэн төгсгөл** нь урьдынхаасаа хоёр дахин ихийг хүртсэн явдал байлаа (Иов 42:10-15).

5:12 Сорилтод орсон үедээ хүн тэвчээр алдарч байгаа нь ам тангараг өргөх байдлаар илэрч болно. Энэ нь хараал хэлэх, бусдыг доромжлох тухай асуудал биш. Мөн хууль шүүхийн өмнө тангараг тавих тухай ч биш. Энд хориглосон нэг зуршил бол өөрийнхөө хэлсэн үгийг батлахын тулд Эзэний болоод бусад аливаа нэрийг бодлогогүй ашиглах шаардлагагүй тухай юм. Христитгэгч хүн хэнээр ч, юугаар ч **тангараглаж** болохгүй. **Тэнгэрээр ч, газраар ч** болохгүй. Тухайн хүнийг мэддэг хүмүүс нь түүний **"за нь за", "үгүй нь үгүй"** байдаг итгэмжтэй занд нь л найдахад болно.

Энэ эшлэл мөн "Тэнгэрийн нэрийг барьж тангараглая", "Бурхан миний Шүүгч", "Бурхан гэрчилнэ" гэх мэт шаардлагагүй үгсийг хэрэглэхгүй байхыг ятгасан бололтой.

"Ингэсэнээр та нар шүүлт (хоёр нүүр¹⁰ /NKJV хажуугийн тайлбар/) дор унахгүй юм" гэж Иаков хэлэхдээ гурав дахь тушаалыг дотроо бодож байсан болов уу: "Чи Бурхан ЭЗЭНийхээ нэрийг хуурмаг хоосонд бүү дурд. Учир нь нэрийг нь хуурмаг хоосон дурдагчийг ЭЗЭН шийтгэлгүй эс орхино." (Гэт 20:7)

XI. ЗАЛБИРАЛ БА ӨВЧТЭЙ НЭГНИЙ ЭДГЭРЭЛ (5:13-20)

Захидлын сүүлийн эшлэлүүд залбирлын тухай өгүүлнэ. Залбирал гэдэг үг нэр үг болон үйл үг хэлбэрээр нийт долоон удаа дурдагджээ.

5:13 Амьдралд юу ч тохиолдсон бид Эзэнд хандан залбирах хэрэгтэй. Зовлон бэрхшээл дунд бид чин сэтгэлээсээ гуйлт хүсэлтээ Бурханд мэдүүлэх учиртай.

Баяр хөөртэй үедээ Бурханыг магтах хэрэгтэй. Амьдралын ямар ч нөхцөл байдалд Өөрт нь хандахыг Бурхан хүсдэг.

Амьдралд тохиож буй бүхний учир шалтгаан нь нэн тэргүүнд Бурхан Өөрөө гэж бид харах хэрэгтэй. Рутерфорд хэмээх нэгэн эрхэм “амьдралд тохиож буй бүхэн хоёрдогч хүчин зүйлийн улмаас бий болдог ээдрээтэй асуудал” гэж хэлсэн зүйлд анхаарал хандуулах хэрэггүй. Амьдралын нөхцөл байдлын хохирогч болж тоглох эсвэл нөхцөл байдал өөрчлөгдөхийг хүлээвэл ялагдал хүлээнэ. Бид өөр арга замыг хайх бус Түүнд л найдах учиртай.

Иаковын захидлын энэ хэсэг хамгийн их маргаан дагуулдаг. Магадгүй Шинэ гэрээний хамгийн маргаантай хэсэг ч байж мэднэ. Энэ хэсэг өнөөгийн итгэгчдийн амьдралд эдгэрэл ямар ач холбогдолтойг зааж өгдөг.

Эшлэлүүдийг нарийвчлан авч үзэхийн өмнө өвчин болон эдгэрлийн талаар Библи юу гэж сургадгийг тоймлон үзвэл тустай байх болно.

ТЭНГЭРЛЭГ ЭДГЭРЛИЙН ТАЛААР НЭМЭЛТ ТАЙЛБАР

1. Бүх өвчин ерөнхийдөө дэлхий дээрх нүглийн үр дагавар гэдгийг христитгэгчид хүлээн зөвшөөрдөг. Дэлхийд нүгэл орж ирээгүй бол өвчин гэж байхгүй байсан.

2. Заримдаа өвчин тухайн хүний амьдралд буй нүглийн шууд үр дагавар байдаг. 1Коринт 11:30 дээр нүглээ шүүн тунгаагаагүй буюу нүглээ улайж, эргэлгүй Эзэний зоог барьсан зарим коринтчууд өвчтэй болсон гэж бичигдсэн байдаг.

3. Өвчин бүр хүний амьдралын нүглийн шууд үр дагавар байдаггүй. Иов газрын хөрсөн дээрх хамгийн шударга хүн байсан боловч өвчин туссан (Иов 1:8). Төрөлхийн сохор хүн нүгэл үйлдсэн учраас сохроогүй гэж

Эзэн Есүс хэлсэн (Иох 9:2, 3). Епафродит Эзэний үйл хэрэгт эцэж цуцалгүй зүтгэсний улмаас өвчин туссан (Фил 2:30). Гаи сүнсээр эрүүл байсан ч бие махбодын хувьд сайнгүй байсан (3Ио 2).

4. Заримд тохиолдолд Сатаны үйл ажиллагааны үр дагаварт өвчлөх нь бий. Сатан Иовын биеийг яр шарханд бариулсан (Иов 2:7). Лук 13:10-17-д дурдагдсан эмэгтэйг Сатан бөгтөр болгосон: "...энэ эмэгтэйг сатан арван найман жилийн турш хүлээтэй байлгажээ" (Лк 13:16). Сатан Паулын биеийг сул дорой болгосон. Паул энэ тухайгаа "Махбодод минь өргөс өгөгдөж... намайг Сатаны зарлага элч дэлссэн" (2Ко 12:7) гэж хэлсэн байдаг.

5. Бурхан эдгээж чаддаг. Бурхан одоо ч эдгээдэг. Үнэндээ эдгэрэл бүхэн Бурханаас эхтэй. Хуучин гэрээнд Бурханы нэг нэрийг Иехова Рофека буюу "Та нарыг эдгээч ЭЗЭН" (Гэт 15:26) гэдэг. Эдгэрсэн тохиолдол бүрдээ бид Бурханд талархах хэрэгтэй.

Бурхан янз бүрийн аргаар эдгээдэг нь Библид тодорхой байна. Тэрээр заримдаа бие махбодын өөрийгөө нөхөн сэргээх чадварыг ашиглан хүнийг эдгээдэг. Бурхан хүний биед нөхөн сэргэх агуу нөөц бололцоог өгчээ. Эмч нар хүний ихэнх зовуурь өглөө намддаг гэдгийг мэддэг. Заримдаа Бурхан анагаах ухааныг ашиглан хүнийг эдгээдэг. Жишээ нь, Паул, "Ходоодныхоо байнгын өвчний улмаас бага зэрэг дарс хэрэглэ" (1Тм 5:23) гэж Тимотод зөвлөсөн байна. Заримдаа Тэр буруутгал, айдас, гутрал зэрэг өвчин үүсгэгч сэтгэлийн дарамтаас чөлөөлөн эдгээдэг. Заримдаа эмч, мэс засалчаар дамжуулан эдгээдэг. Өвчтөнд эмч хэрэгтэй гэж Есүс тодорхой хэлсэн (Мт 9:12). Паул Лукуыг "хайрт эмч" (Кол 4:14) гэж хэлсэн нь христитгэгчдийн дунд эмч хүн хэрэгтэйг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл юм. Бурхан эмч нарыг эдгэрлийн үйлчлэлд ашигладаг. Францын нэрт мэс засалч Парэ, "Мэс засалч шархыг оёдог. Бурхан харин эдгээдэг" гэж хэлжээ.

6. Түүнчлэн, Бурхан гайхамшгаар ч бас эдгээдэг. Сайнмэдээний номуудад үүний талаар олон жишээ бий. Бурхан үргэлж гайхамшгаар эдгээдэг гэж хэлэх нь буруу ч бас гайхамшиг огт үйлддэггүй гэж хэлэх нь бас буруу. Бурхан өнөөдөр ч гайхамшиг үйлдэж эдгээдэг гэдэгт итгэхийг хориглох ямар ч үндэслэл Библид байхгүй.

7. Гэхдээ Бурхан үргэлж эдгээхийг хүсдэггүй гэдгийг ч бид мэдэж байх ёстой. Паул Трофимыг өвдсөн учир Милетэд үлдээжээ (2Тм 4:20). Эзэн Паулын бие дэх өргөсийг эдгээж өгөөгүй (2Ко 2:7-10). Бурхан үргэлж эдгээдэг бол зарим хүн хэзээ ч хөгширч үхэхгүй байсан.

8. Бурхан бүх өвчнийг эдгээнэ гэж амлаагүй. Тиймээс бид эдгэрлийг Түүнээс шаарддаг зүйл биш. Филиппой 2:27 дээр эдгэрлийг өршөөл хэмээснээс бус гарцаагүй болох ёстой, бидний хүртэх эрхтэй зүйл гэж хэлээгүй.

9. Христийн эвлэрүүллийн үйл хэрэг эдгэрлийг багтаадаг нь үнэн. Гэхдээ эвлэрүүллийн үйл хэргийн үр дүнд ирдэг бүх ерөөлийг бид хараахан аваагүй байна. Жишээлбэл, бидний төлөө хийсэн Христийн үйл хэрэгт биеийн аврал багтдаг боловч Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх хүртэл энэ авралыг бид хүртэхгүй (Ром 8:23). Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх тэр цагт бид бас бүх өвчнөөс бүрэн эдгэрнэ.

10. Өвчнөөсөө эдгэрэхгүй байх нь итгэл багатайн шинж биш. Итгэлтэй хүн бүр эдгэрдэг бол зарим нэг нь хэзээ ч үхэхгүй байсан. Гэвч хүн бүр үхдэг. Паул, Трофим, Гаи нар эдгэрээгүй боловч итгэл нь гал халуун, хүчтэй байсан шүү дээ.

5:14, 15 Одоо Иаков 5 дугаар бүлгээ дахин уншвал 5 дугаар бүлэгт яригдаж буй эдгэрэл Библийн бусад хэсэгтэй хэрхэн уялдаж байгааг харна.

Та нар дунд хэн нэг нь өвчтэй байна уу? Тэр нь чуулганы ахлагчдыг дуудаг. Тэд Эзэний нэрээр түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбираг. Итгэлийн залбирал нь өвчтэй нэгнийг эдгээж, Эзэн түүнийг босгоно. Тэр нүгэл үйлдсэн болбоос тэрээр уучлагдах болно.

Энэ нь эдгэрлийн тухай хэлсэн Библийн цорын ганц эшлэл байсан бол энд жагсаасан болзлыг хангачихвал христитгэгч хүн ямар ч өвчнөөс эдгэрэх боломжтой гэж бид таамаглахад хүрэх байлаа. Гэтэл Бурхан бүх өвчнийг эдгээдэггүй гэдгийг Библийн бусад хэсгээс бид аль хэдийн үзсэн шүү дээ. Тиймээс Иаков бүх өвчний тухай яриагүй, тодорхой төрлийн өвчний талаар ярьж байна гэж дүгнэхэд хүрч байна. Тодруулж хэлбэл, тодорхой нөхцөл байдлаас улбаатай өвчний талаар ярьж байна. Энэ эшлэлийг зөв ойлгох түлхүүр нь: **"Тэр нүгэл үйлдсэн болбоос тэрээр уучлагдах болно"** гэсэн үгэнд оршиж байна. Энэ хэсэгт дурдсан эдгэрлийг **нүглийн** уучлалтай холбосон байна.

Энд нэг хүн нутгийн чуулганы гэрчлэлтэй холбоотой байж магадгүй нүгэл үйлджээ. Төд удалгүй тэр хүн өвчин тусав. Тэрээр өвчин нь нүглийнх нь шууд үр дагавар гэдгийг ойлгов. Бурхан түүнийг нөхөрлөл рүү буцааж авчрахын тулд сахилгажуулж байгаа нь энэ байлаа. Тэрээр нүглээ гэмшиж Бурханд улайв. Гэхдээ түүний нүгэл чуулганы гэрчлэлтэй холбоотой учраас чуулганы **ахлагчдыг дуудаж**, тэдэнд ч бас нүглээ улайжээ. Тэд **Эзэний нэрээр түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбирав**. Энэхүү итгэлийн залбирал нь өвчтэй нэгнийг эдгээж, Эзэн түүнийг босголоо. Тухайн өвчин нүглийн шууд үр дагавар бол нүглээ улайж, дээр дурдсан байдлаар нүглээсээ эргэвээс Эзэн өвчнийг нь эдгээнэ гэсэн Эзэний тодорхой амлалт энд байна.

"Тэр хүн нүгэл үйлдсэнийг яаж мэдэх юм бэ? Мөн чин сэтгэлээсээ гэмшиж нүглээ улайсныг нь яаж мэдэх вэ?" гэж зарим нь хэлж магадгүй. Үүний хариу нь 15 дугаар эшлэлийн төгсгөлд **тэр нүгэл үйлдсэн болбоос тэрээр уучлагдах болно** хэмээн бичигджээ. Түүнээс гадна нүглийн уучлал гэмшиж улайх үед ирдгийг бид мэднэ (1Ио 1:9).

"Энэ эшлэлд тухайн хүнийг нүгэл *үйлдсэн* гэж хэлээгүй. Хэрэв **тэр нүгэл үйлдсэн болбоос** гэж хэлсэн" хэмээн өөр нэгэн нь маргаж магад. Тийм ээ. Гэхдээ хам сэдвийг нь бүхэлд нь харвал замаасаа эргэсэн хүн нүглээ улайж, сэргээгдэж байгаа тухай өгүүлжээ. Дараагийнх нь эшлэлд "Тийм учраас бие биеийнхээ өмнө нүглээ улайж, бие биеийнхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой" гэснийг бас анзаараарай. 17, 18 дугаар эшлэлд дурдсан ган гачиг нь нүглээс болж Израилийн дээр буулгасан Бурханы шүүлт байсан юм. Изриалчууд Эзэн рүү эргэж, Түүнийг жинхэнэ Бурхан гэж хүлээн зөвшөөрөх үед ган гачиг арилсан (1Ха 18:39). 19, 20 дугаар эшлэлд замаасаа гажсан хүнийг эргүүлэн авчрах тухай байгаа нь тодорхой байна.

Иаков 5:13-20 дугаар эшлэлийн бүхэл утга нь нүглээс болж өвчин туссан хүн тухайн нүглээ ахлагчдад улайваас Бурхан эдгээнэ гэсэн амлалтыг илэрхийлж байна. **Ахлагчид түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбирах** үүрэгтэй аж. Иаков үүнийг бичиж байх тэр цаг үед тосыг эмийн зорилгоор ашигладаг (Лк 10:34) байсан учраас энэ эшлэлд дурдсан **тосыг эмийн зорилгоор** ашигласан гэж зарим хүн тайлбарладаг. Харин зарим нь тосыг *бэлгэдлийн утгаар* ашигласан гэж үздэг. **Эзэний нэрээр** гэсэн үг энэ үзлийг бататгадаг. Өөрөөр хэлбэл, Эзэний эрх мэдлээр үйлдэж, Эзэний үгийг дуулгавартай дагасны илэрхийлэл болгож тосоор тосолдог байжээ. Элч нар зарим тохиолдолд эдгэрлийн гайхамшиг үйлдэхдээ тос

ашигладаг байв (Мк 6:13). Тосонд эдгээх хүч байхгүй ч эдгэрлийн үйлчлэлд Ариун Сүнснийг бэлгэддэг байжээ (1Ко 12:9).

Тосыг бэлгэдэл, зан үйлийн утгаар ашиглах нь нигүүлслийн эрин үед нийцэхгүй гэж зарим хүн эсэргүүцэж зан үйл, ёслол чухал биш гэцгээдэг. Гэхдээ бид талх, дарсыг Христийн бие ба цусны бэлгэдэл болгож, усыг баптисм хийхэд ашигласаар л байдаг шүү дээ. Мөн эмэгтэйчүүд чуулганд эр хүнд захирагддаг гэдгээ бэлгэдэж толгойгоо алчуураар бүтээдэг. Тэгвэл тосыг бэлгэдэл, зан үйлийн утгаар ашиглах нь яагаад буруу гэж?

Итгэлийн залбирлын хариуд Бурхан тухайн хүнийг эдгээнэ. Энэ нь Бурханы үгийн амлалтад суурилсан учраас **итгэлийн залбирал** мөн. Ахлагчид болон өвчтэй хүн хэр их итгэлтэй байх нь энд гол асуудал биш байна. Энд дурдсан нөхцөл бүрэн хангагдсан л бол Бурхан өвчтэй нэгнийг босгоно гэж амласан учраас ахлагчид үүнд бат итгэлтэйгээр залбирч болно.

Товч дүгнэвэл, 14, 15 дугаар эшлэл хүний өвчин ямар нэг нүглийн шууд үр дагавраас үүдэлтэй тохиолдолд хамаарна. Тухайн хүн үүнийгээ ухаараад гэмшвэл чуулганы **ахлагчдыг дуудаж**, нүглээ бүрэн улайх хэрэгтэй. Тэгээд ахлагчид **Эзэний нэрээр түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбирах** ёстой. Бурхан тэр хүнийг эдгээнэ гэж амласан учраас ахлагчид эдгэрлийнх нь төлөө итгэл дотор залбирах боломжтой.

5:16а Тийм учраас бие биеийнхээ өмнө нүглээ улайж, бие биеийнхээ төлөө залбир. Энэ үгийг өнгөцхөн уншвал бид нуугдмал нүглүүдээ бусдад бүгдийг нь дэлгэх ёстой гэсэн сэтгэгдэл төрж магадгүй. Гэвч үүнд тийм санаа огт агуулагдаагүй! Иаков яг үнэндээ, бид хэн нэгний эсрэг нүгэл үйлдсэн бол тэр даруй нүглээ улайх хэрэгтэй л гэж хэлсэн.

Түүнчлэн, бид **бие биеийнхээ төлөө залбирах** ёстой. Хорсол, дургүйцэл тээхийн оронд нүглээ улайж, залбирснаар бусадтай нөхөрлөх нөхөрлөлөө хадгалах хэрэгтэй.

Энд биеийн эдгэрлийг сүнслэг сэргэлттэй холбожээ. Иаков нүглээ улайх, залбирах, эдгэрэхийг хэрхэн холбосныг анзаараарай. Бие махбод болон сүнс салшгүй холбоотой гэдгийг энд тодорхой харуулж байна. Хүн бол сүнс, сэтгэл, бие махбод гэсэн гурван хэсгээс бүрдсэн оршихуй юм (1Тс 5:23). Энэ гурвын нэг нь гэмтэхэд нөгөө хоёртоо нөлөөдөг. Хуучин гэрээнд тахилч хүн эмчийн үүргийг давхар гүйцэтгэдэг байсан. Жишээлбэл, уяман өвчнийг оношилж, эдгэрсэн бол зарлах үүрэгтэй байжээ. Ингэж тахилч болон эмчийн албыг нэг хүнд хослуулан оноосноор сүнс, бие махбод хоёр салшгүй холбоотой гэдгийг Эзэн харуулжээ.

Психосоматик анагаах ухаан уг салшгүй холбоог хүлээн зөвшөөрч, хүний сүнс хийгээд сэтгэл санаа бие махбодод хэрхэн нөлөөлдгийг судалдаг. Гэвч орчин үеийн анагаах ухаанд нүглийг эдгээх эмчилгээ байхгүй. Нүглийн буруутгал, бузар, хүч, ял шийтгэлээс зөвхөн Христийн цус л чөлөөлж чадах тул хүн нүглээ Бурханд болон хүнд улайж байж л чөлөөлөгдөх боломжтой. Харамсалтай нь ховдоглох, санаа зовнил, уур хилэн, үл уучлал, биеэ барьдаггүй зан, атаархал, хувиа хичээсэн байдал, бардамнал зэрэг бидний бодож байснаас ч их өвчин нүглээс үүдэлтэй байдаг. Нүгэл өвчлүүлж, заримдаа үхэлд хүргэдэг (1Ко 11:30). Амьдралд минь нүгэл орж ирснийг мэдсэн даруйдаа улайж, орхих хэрэгтэй. Бүх нүглийг Бурханд улайх хэрэгтэй. Дээрээс нь, хүмүүсийн эсрэг үйлдсэн нүглээ тухайн хүнд нь улайх ёстой. Энэ нь сүнсний хийгээд бие махбодын эрүүл мэндэд нэн чухал.

5:166-18 “Сайн хүний чин сэтгэлийн залбирал асар их үр нөлөөтэй. Та нар Елиаг санаж байна уу? Тэр бидэн шиг

хүн байсан ч бороо оруулахгүй хэмээн шаргуу залбирсан. Тэгтэл гурван жил хагас газарт нэг ч дусал бороо ороогүй. Дараа нь тэр дахин залбирахад тэнгэр хур бороогоо хайрлаж, газарт урьдынх шигээ өвс ногоо ургасан.” (Ж.Б.Филлипсын орчуулга)

Энэ үйл явдлыг 1Ха 17:1-19:10 дээр тэмдэглэн үлдээжээ. Тухайн үед Ахаб Израилийн хаан байлаа. Ахаб эхнэр Иезебелийнхээ нөлөөгөөр Баалыг шүтдэг болж, израилчуудыг шүтээн шүтлэг рүү урвуулсан. "Ахаб өөрийн өмнөх Израилийн бүх хаадаас ч илүүгээр Израилийн Бурхан ЭЗЭНийг хилэгнүүлэх зүйл хийв." (1Ха 16:33) Израилийн нутагт гурван жил хагас ган гачиг тохиолдсон нь нүглийн шууд үр дагавар байлаа.

Дараа нь Елиа Кармел уулан дээр Баалын тахилчидтай алдарт тулаанаа хийв. Эзэнээс гал бууж тахилын ширээ, шатаалт тахил, усыг юу ч үгүй шатаахад ард түмэн буруугаа ухаарч Эзэн рүү эргэсэн юм. Елиа **дахин залбирахад** ган гачиг арилжээ. Нүгэл үйлдэж, Бурханаас холдон одсон хүмүүсийн төлөө залбирахыг урамшуулах зорилгоор **Елиагийн** жишээг өгчээ. **Зөвтийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна.** Энэ үгийг арай өөрөөр илэрхийлбэл зүрх сэтгэл нь Бурхантай зөв харилцаатай байгаа хүний залбирал гайхамшгийг бүтээдэг гэж болно. Бид Елиаг биднээс өөр онцгой хүн байсан хэмээн бодох вий гэсэндээ **Елиа бидэнтэй адил жирийн хүн байсан** гэдгийг Иаков сануулсан байна. Елиа бусад хүний л нэгэн адил өвчинд өртөмтгий, сул дорой, махбодоос бүтсэн жирийн хүн байсан.

5:19, 20 Өмнөх эшлэлүүдэд нүгэл үйлдсэн ариун хүнийг сэргээхэд чуулганы ахлагчид хэрхэн оролцож байсан тухай үзлээ. Мөн замаасаа гажсан Израиль үндэстнийг сэргээхэд (түр зуурын, хэсэгхэн сэргэлт) Елиа хэрхэн ашиглагдсаныг ч харлаа. Тэгвэл одоо энэхүү өргөн

цар хүрээтэй үйлчлэлд өөрсдийгөө зориулахад биднийг уриалсан байна.

19 дүгээр эшлэлд онол сургаалын хувьд эсвэл амьдралын хэв маягаараа **үнэнээс** холдон одсон христитгэлт ах дүүгийн талаар дүрслэн өгүүлжээ. Өөр нэг ах дүү нь түүнд санаа тавьж, гал халуунаар залбирч, Бурхантай нөхөрлөх нөхөрлөл болон Христ доторх ах, эгч дүүсийнх нь дунд хайраар **эргүүлэн авчирч** байна. Энэ үйлчлэлийн ач холбогдол ямар их гээч! Нэгт, **тэр хүн** төөрсөн ах дүүгээ Бурханы сахилгажуулалтыг амсаж цагаасаа өмнө үхэхээс **авардаг**. Хоёрт, тэр хүн **тоо томшгүй олон нүглийг халхлах болно**. Улмаар Бурхан түүний нүглүүдийг уучилж мартдаг. Ах дүү нар нь ч түүнийг уучилж, энэ ертөнцийн хараанаас халхалдаг. Өдгөө бидэнд яг энэ үйлчлэл хэрэгтэй байна. Бид төөрсөн нэгнийг аврахаар идэвхтэй хүчин зүтгэж байхдаа сүргээсээ төөрсөн Христийн хонин сүрэгт хангалттай анхаарал тавьдаггүй байж ч болох юм.

Иаков христитгэлт амьдралын янз бүрийн талбарт мөс чанараа сайтар нягтлан үзэхийг дахин анхааруулж байна. Тухайлбал, Иаков биднээс ийнхүү асууж байна. Чи энэ дэлхий дээр эд хөрөнгө хурааж байна уу? Чиний бизнесийн зарчим үнэнч шударга байна уу? Жишээлбэл, орлогын албан татвараа чи шударгаар төлдөг үү? Чи тансаглан амьдарч байна уу эсвэл бусдад Аврагч Эзэнийг мэдүүлэхийн төлөө золиос гарган амьдарч байна уу? Бусдын эсрэг нүгэл үйлдвэл очиж уучлалт гуйхад бэлэн байна уу? Өвчин тусвал хэн дээр түрүүлж очдог вэ? Эмч дээр үү, Эзэн дээр үү? Ах дүү чинь нүгэлд унахыг хараад шүүмжилж байна уу, эргүүлэн авчрахыг оролдож байна уу?

Ингээд бүгдээрээ товч боловч амьдралд ойр захидлыг судалж дууслаа. Энэ захидлаас бүгдээрээ итгэлийн сорилт, шалгуурыг үзсэн. Итгэл нь амьдралын асуудал, ариун бус уруу татлага, Бурханд дуулгавартай байх шалгуур зэргээр

соригдохыг харлаа. Өөрийгөө итгэлтэй гэдэг хүн бусдыг ялгаварлан гадуурхахгүй, алагчлахгүй байж, сайн үйлсээрээ үүнийгээ батлан харуулах ёстойг мэдэж авлаа. Итгэлийн бодит байдал хэл ярианаас нь илэрдэг ажээ. Итгэгч хүн хэл яриагаа Христийн захиргаанд өгөх ёстойг сурлаа. Жинхэнэ итгэлийг жинхэнэ мэргэн ухаан дагалддаг. Атаархаж хорсон, өрсөлдөж тэмцэлдэж амьдарсан хүнийг жинхэнэ итгэл сүсэг өөрчилдөг гэдгийг ойлголоо.

Итгэл нь энэ ертөнцийн хүсэл тачаал, шунахайрлаас урган гардаг хэрүүл, маргаан, атаа хорслоос зайлсхийдэг. Мөн хатуу ширүүн шүүмжилдэггүй. Ийм итгэл өөртөө хэт бардаж, амьдралын төлөвлөгөөндөө Бурханыг оруулахгүй байхаас сэрэмжилдэг. Жинхэнэ итгэл мөнгө олж, зарцуулах тал дээр сорилтыг тэсвэрлэдэг. Дарамт хавчлага дор ч Эзэн дахин ирэхийг санаж тэсвэр тэвчээр гаргадаг. Хэл яриа нь ч бүх талаар үнэнийг өчдөг тул өөрийгөө батлах гэж ам тангараг өргөдөггүй. Итгэл амьдралын аливаа өөрчлөлт тохиох бүрд Бурханд ханддаг. Өвчин зовлон нүүрлэвэл сүнслэг учир шалтгаан байгаа эсэхийг нэн тэргүүнд нягталдаг. Улмаар Бурхан болон гомдоосон хүмүүсийнхээ өмнө нүглээ улайж, магадлалт шалтгаануудыг арилгадаг. Эцэст нь, жинхэнэ итгэл замаасаа төөрсөн хүмүүсийг хайрлаж, энэрэл өршөөлөөр ханддаг.

Та бидний итгэл өдөр бүр соригдож байдаг. Харин Шүүгч бидний итгэлийг хэрхэн үнэлэх бол?

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

¹(1:14) Грекээр *эпитуμία* гэсэн үг бол зүгээр л “хүсэл” гэдэг үгэнд хүч нэмсэн хэлбэр. “Lust” гэсэн англи үг ч бас (1611 оны KJV орчуулгыг үз) анхандаа “асар их хүсэл” гэсэн утгатай байснаа хожим бэлгийн хүсэл тачаалыг илэрхийлдэг болжээ.

²(1:19) “Тиймээс” (гр. *хостэ*) гэх үг зарим гар бичмэл, мөн Александрын бичвэрийг баримталдаг орчин үеийн ихэнх орчуулгад “мэдэгтүн” (гр. *истэ*) гэж солигдсон байдаг. Гэхдээ “Тиймээс” гэсэн уламжлалт хувилбар нь хам сэдэвтэйгээ илүү нийцэж байна. 1-18 дугаар эшлэлд ярьсныг одоо хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгийг өгүүлэх гэж байгаа учраас энэ нь илүү тохирч байна.

³(1:21) Грекээр “психэ” гэсэн нэг л үг “амьдрал”, “сэтгэл” гэсэн хоёр утгыг давхар илэрхийлж байна. Гэхдээ аль утга нь тухайн хам сэдэвтэйгээ нийцэж байгааг шууд хэлэх аргагүй тохиолдол олон гардаг. Түүнээс гадна аврах гэдэг үг (грекээр ч, англиар ч) заавал мөнхийн авралыг илэрхийлэх албагүй. Энэ нь эдгэрэл, чөлөөлөлт, амь аврагдах гэх мэт олон утгыг илэрхийлдэг. Тэгэхээр “сэтгэлийг чинь аврах” гэсэн үг зарим хам сэдэвт (Христийн төлөө) “амжилттай амьдрах” гэсэн утгыг ч илэрхийлж байж болно.

⁴(2:2-4) Энд “*синагогэ*” (цуглаан) гэх грек үгийг ашиглажээ. Энэ үг хожим нь зөвхөн иудейчүүдийн цуглааныг (синагог) хэлэхэд л ашиглагдах болсон тул Иаков захидлаа нэн эрт бичсэнийг илтгэж байна. “Congregation” (Tyndale), “church” (KJV), “assembly” (JND) гэсэн үгс бол бүгдээрээ *эклэсиа* буюу “дуудагдсан чуулган” гэсэн үгийн орчуулга юм. Энэ үг анхандаа улс төрийн хэллэг байлаа (НҮБ-ийн Ерөнхий Ассембли гэдэг шиг).

⁵(2:14) Энэ эшлэлд грек эх хэл дээрээ “энэ” гэсэн үг байхгүй ч, ялгац гишүүн (the) байгаа. Ялгац гишүүн нь

тухайлан тодруулах утга илэрхийлж ч болно. Аль эсвэл хийсвэр нэр үгийг дагадаг зүгээр нэг ялгац гишүүн ч байж болно. Энэ нь тайлалтай холбоотой асуудал учраас NKJV хувилбар эхний хэвлэл дээрээ “энэ итгэл” гэж буулгасан байснаа дараа дараагийн хэвлэл дээрээ KJV-ийн хувилбараар сольсон байдаг.

⁶(3:5, 6) Кловис Г. Чаппел, *Дуулал номын сургаалууд*, хуудас 132.

⁷(3:7) Роберт Г. Ли, *Эзээн, би итгэж байна*, хуудас 166-168.

⁸(4:5) Хамгийн эртний гар бичмэлүүдэд том, жижиг үсэг гэж байсангүй. Шинэ гэрээнд Ариун Сүнс болон хүний сүнсийг ялгахын тулд эхний үсгийг нь томоор бичих явдал эртний гар бичмэлүүдэд байгаагүй. Тиймээс орчуулагч, редакторууд хам сэдвийг нь харж байгаад аль утга нь болохыг тогтоох хэрэгтэй болдог. Энэ эшлэл болон бас бус эшлэл дээр Библийн эрдэмтдийн санал зөрдөг.

⁹(5:9) NU болон М бичвэр хоёулаа “шүүгдэх” гэж бичсэн боловч хам сэдэв нь сөрөг утгатай байгаа учраас “буруутгагдах” гэдэг үг ч мөн тохирч байна.

¹⁰(5:12) Нэг ижил байдлаар бичигдэж, хадгалагдсан мажорити текст гэгддэг гар бичмэлүүдийг уншиж үзвэл нэн сонирхолтой, ялгаатай хувилбар гарч ирнэ. KJV болон NU хувилбарыг уншвал *хипо крисин* буюу “шүүлт доор” гэсэн утгыг илэрхийлдэг. Гэтэл мажорити текст *эис хипокрисин* буюу “хоёр нүүртэнд” гэж уншигддаг. *Эис* гэх жижигхэн утгвар хуулбарлах явцад алга болсон гэж үзвэл утгвар үг байх зайлшгүй шаардлагатай учраас *хипо крисин* (шүүлт доор) гэж салгаж бичих нь зүй ёсны хэрэг. Гэхдээ энэ хоёрын аль аль нь тухайн хэсгийн хам сэдэв, Иаковын захидлын бүхэл утгатай таарч байна. Тэгэхээр захидлынхаа төгсгөлд Иаков шашинлаг *хоёр нүүртэн* болохоос сэрэмжлүүлсэн гэж үзэж болно.

НОМЗҮЙ

Адамсон, Жэймс. *Иаковын захидал*. Гранд Рапидс: Вилльям Б. Эердмансын хэвлэлийн компани, 1976 он.

Браун, Чарльз. *Иаковын үндсэн захидал: Чимээгүй цагийн тайлбар ном*. Филадельфи: Юнион Пресс хэвлэлийн газар, 1907 он.

Гэйблэйн, Фрэнк. *Иаковын практик захидал*. Грэйт Нэк, Нью Йорк: Донигер энд Рафли ХХК, 1955 он.

Жонстон, Роберт. *Иаковын захидлын тайлбар ба практик хэрэгжүүлэлтийн лекц*. Миннеаполис: Клок & Клок Христитгэлт Паблিশнг (1871 оны дахин хэвлэл).

Кэлли, Вилльям. *Иаковын захидал*. Лондон: Ф. Э. Рэйс, 1913 он.

Кинг, Гаи Х. Үйлдэл хийдэг итгэл. Лондон: Маршал, Морган, Скот ХХК, 1954 он.

Зодиатс, Спирос. *Итгэлийн зан авир*. Гранд Рапидс: Вилльям Б. Эердмансын хэвлэлийн компани, 1959 он.